МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2020 он

ГАРЧИГ

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

1.1 Гүйцэтгэлийн зорилт №1.1. Юнеско-ийн соёлын биет бус өвийг хамгаалах конвенцын 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх **4**
1.2 Гүйцэтгэлийн зорилт №1.2. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөг хэрэгжүүлэх **35**
1.3 Гүйцэтгэлийн зорилт №1.3 “Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр”-2020 төлөвлөгөөг хэрэгжүүлэх **216**

ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2.1 Иргэнд чиглэсэн ажил үйлчилгээ **240**
2.2 Аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн ажил үйлчилгээ **242**

ГУРАВ.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

3.1.1 Гүйцэтгэлийн зорилт №3.1.1 Соёлын биет өвийг сэргээн засварлах **271**
3.1.2 Гүйцэтгэлийн зорилт №3.1.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийг төгөлдөржүүлэх **456**
3.1.3 Гүйцэтгэлийн зорилт №3.1.3. Соёлын өвийн үзлэг, тооллого зохион байгуулах **596**
3.1.4 Гүйцэтгэлийн зорилт №3.1.4. Соёлын өвийн сурталчилах **613**
3.2 Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг **697**
Хавсралт

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН

№1.1. ЮНЕСКО-ИЙН ЯАРАЛТАЙ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ-ЛИМБЭНИЙ БИТҮҮ АМЬСГААГ ХАМГААЛАХ

Гүйцэтгэлийн зорилт №1.1. ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах конвенцын 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх

Төлөвлөлтийн уялдаа:

- ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах конвенц 11 дүгээр зүйл Оролцогч улсуудын үүрэг,13 дугаар зүйл Хамгаалалтын бусад арга хэмжээ, 14 дүгээр зүйл Боловсрол, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх болон чадавхыг бэхжүүлэх,15 дугаар зүйл Хамт олон, бүлэг хүмүүсийн оролцоо
- Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр баталсан “Соёлын өвийн үндэсний төвийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2015-2050” бичиг баримтын Тэргүүлэх чиглэл 4. СОЁЛЫН ӨВИЙГ АВРАН ХАМГААЛАХ ЧИГЛЭЭР. Стратегийн зорилт 4.1. Соёлын биет болон биет бус өвийг авран хамгаалах тогтолцоо, талуудын хамтын ажиллагааны эхлэлийг тавих;

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1-р арга хэмжээ

“МОНГОЛ УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГААГ ӨВЛҮҮЛЭН УЛАМЖЛУУЛАХ, ТОГТВОРЖУУЛАХ НЬ” ТӨСЛИЙН II ҮЕ ШАТНЫ ТАЙЛАН

“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн ерөнхий мэдээлэл.

ЮНЕСКО болон Соёлын өвийн үндэсний төв хооронд 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан № 4500386779 тоот гэрээ, Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын дагуу Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ хамтран “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь” төслийн II үе шатыг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн сангийн дэмжлэгтэйгээр 2020 онд II үе шатыг нийт 7 багц ажлын хүрээнд төлөвлөсны дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тус төсөл нь 2019-2021 оны хугацаанд 3 үе шаттай хэрэгжинэ.

Төслийн гол зорилго нь ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 2011 онд бүртгэгдсэн “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” өвийг хамгаалахад Монгол Улсын Засгийн Газар, БСШУСЯ, Соёлын өвийн үндэсний төв болон шат шатны төрийн болон төрийн бус байгууллагуудын гаргасан хүчин чармайлтыг бэхжүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулах, залуу хойч үед өвлүүлэн уламжлуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх замаар энэхүү өвийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Төслийн II шатны хүрээнд Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийн шавь сургалт зохион байгуулах, Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байран Лимбэний танхим байгуулах, "Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD, лимбэчдийн намтар, танилцуулга бүхий ном эх бэлтгэх, Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа өвийн уламжлал, шавь сургалтын явцыг харуулсан баримтат киноны бэлтгэл ажлыг хангах, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төсөл хэрэгжснээр “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийг өвлөн суралцагчийн тоо 40 хүнээр нэмэгдэж, энэхүү өвийн оршин тогтнох чадвар бэхжих юм. Мөн “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдэх болно.

1.“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтын II шатны үйл ажиллагааг зохион байгуулах, залуу хойч үед шавь сургалт явуулсан 10 өвлөн уламжлагчийг урамшуулах:

Төслийн хүрээнд “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаа” өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг баруун, зүүн, төвийн бүсэд 11 өвлөн уламжлагчид тулгуурлан зохион байгуулж байгаа бөгөөд сургалтад 40 орчим өвлөн суралцагч хамрагдаж байна. Өвлөн уламжлагчид шавь сургалтыг төслийн хүрээнд боловсруулан гаргасан гарын авлага болон өөрсдийн дадлага, туршлагад тулгуурлан зохион байгуулж байна.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Зүүн бүс буюу Өмнөговь, Дорноговь аймгуудад МУГЖ, лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч Ө.Батжаргал, Б.Отгондүү нарын зохион явуулж буй шавь сургалтын үйл ажиллагаатай танилцах, мониторинг хийх, зөвлөмж өгөх ажлыг 2020 оны 5 дугаар сарын 28-аас 6 дугаар 4-ны өдрүүд, 2020 оны 6 дугаар сарын 25-аас 7 дугаар сарын 3-ны өдрүүдэд Баруун бүс буюу Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан аймгуудад зохион байгуулав.

Шавь сургалтын үйл явцтай танилцах, хяналт хийх багийн ахлагчаар Ц.Цэвэгсүрэн (төслийн зохицуулагч, “Монголын лимбэчдийн холбоо” ТББ-ын тэргүүн), Ж.Насанжаргал (Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээллийн санч), Ц.Цолмон (Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн өвийн дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч) Д.Мөнхбаатар (Мэдээлэл, технологийн газрын зураглаач) нар ажиллав.

Өмнөговь аймаг: Сургагч багш Ө.Батжаргал, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн 1-р сургуулийн “Хүүхэд хөгжлийн төв”-д лимбэний шавь сургалтын танхимыг байгуулсан ба II шатны шавь сургалтад 4 (гэрээтэй), албан бусаар 2 нийт 6 өвлөн суралцагч суралцаж байна.

1. Одбаярын Одхүү -10 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
2. Батбаярын Энхжин -16 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
3. Отгонбаатарын Энхзул -14 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
4. Батжаргалын Одонгоо -39 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
5. Ш.Энхзаяа (шинээр суралцаж эхэлж байгаа)
6. Я.Өлзийжаргал – 12 настай (шинээр суралцаж эхэлж байгаа)

Биднийг ажиллах үеэр өвлөн уламжлагч Ө.Батжаргал өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэгбүрчилэн тайлбарлаж, жишээ болгон зарим уртын дууг тоглуулсан юм. Жишээлбэл:



О.Одхүү: Энэ жил 5-р анги төгссөн. 2019 оноос лимбэ суралцаж эхэлсэн. Лимбийг ардын арга барилаар барьж сурсан. Дээд, доод чалхад эгшгүүдээ гүйцэд дуугаргадаг болсон. Маамуу нааш ир, Тэгвэл хоёулаа гэх мэт хүүхдийн дууг тоглох чадвартай болж байгаа. Хэд хэдэн ардын дуун дээр лимбэдэх арга барилаа дээшлүүлэх, эгшгийг тогтворжуулахаар ажиллаж байгаа. Ай нанаа, Жийжүү хот мэтийн 10-аад уран бүтээл дээр ажилласан. Одоогоор битүү амьсгааны анхны барилуудыг эзэмшиж байгаа. Мөн усыг тасралтгүй битүү амьсгаагаар үлээх арга барилыг сурч байгаа. Хөөрхөн халиун гэх ардын бэсрэг дууг эхний байдлаар тоглон суралцаж байна.



Б.Энхжин: 5-р ангиасаа хойш 5 жил суралцаж байгаа. Лимбийг ардын арга барилаар сурсан. Дээд, доод чалхад эгшгүүдийг чөлөөтэй лимбэдэж чаддаг болсон. Дуу болон жижиг хэлбэрийн зохиолуудыг тоглох чадварыг эзэмшсэн. Өөрийн оролдлогоор битүү амьсгааны арга барилыг сайн суралцаж байгаа. Төслийн сургалт эхэлснээс хойш битүү амьсгааг цэвэрхэн болгох, амьсгаа авах арга барилыг цэвэрхэн дуу шуугүй болгох тал дээр ажилласан. Монгол ардын уртын дуу Дөрвөн цаг, Говь шанхын гурван дуун дээр ажиллаж, уралдаан тэмцээнүүдэд оролцож байсан. Төслийн хүрээнд сурах ёстой бэсрэг болоод айзам уртын дуунуудаас суралцаж

байгаа. Уяхан замбуу тивийн наран дуу, богино хэмжээний ардын дуунуудыг суралцаж байгаа.

О.Энхзул: Лимбэний битүү амьсгаа өвийг лимбэ барихаас эхлэн шинээр суралцаж байгаа бөгөөд ардын хэлбэрээр гарын барилыг суралцсан. Бүх чалхнуудын эгшгүүдийг тоглодог болсон. Одоогоор дасгал, дуунууд дээр ажиллаж байгаа. 43 дасгал, 10-аад дуун дээр ажилласан.



Б.Одонгоо: “Битүү амьсгаа, түүнд суралцах аргачлал” гарын авлагын дуунуудаас суралцаж байгаа.



Ш.Энхзаяа: Энэ жил 7-р анги төгссөн. Суралцаад хоёр долоо хоног болсон ба дуу тоглох хэмжээнд хүрсэн. Лимбэ барих арга барилаа ерөнхийдөө суралцсан. Доод чалхын эгшгүүдийг дуугаргаж байгаа. Одоогоор Сайхан хангайн буга гэх дуун дээр ажиллаж байгаа. 9-р ангиа төгсөөд театрт орох хүсэлтэй суралцагч.

Я.Өлзийжаргал: Энэ жил 6-р анги төгссөн. Суралцаад 5 хонож байгаа. Одоогийн байдлаар лимбэ барих, доод болон дунд чалхын эгшгүүдээ дуугаргаж сурах тал дээр ажиллаж байгаа.

Сургагч багш Ө.Батжаргалын удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 17.8 GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч





нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Дорноговь аймаг: Сургагч багш Б.Отгондүү, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Шавь сургалтыг Дорноговь аймгийн “Саран хөхөө” театрын хөгжмийн өрөөнд явуулж байгаа бөгөөд II шатны шавь сургалтад 4 (гэрээтэй), албан бусаар 1 нийт 5 өвлөн суралцагч суралцаж байна.

1. Ариунцэцэгийн Уранжаргал - 28 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
2. Чулуунбаатарын Эрдэнэбаатар - 31 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
3. Мөнхжаргалын Батзориг - 30 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
4. Төмөрбаатарын Тогтохбаяр - 46 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
5. О.Баярсүрэн – 16 настай (шинээр суралцаж эхэлж байгаа)

Биднийг ажиллах үеэр өвлөн уламжлагч Б.Отгондүү өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэг бүрчлэн тайлбарлаж, жишээ болгон зарим уртын дуу тоглуулсан юм. Жишээлбэл:



А.Уранжаргал: “Торой банди” уртын дуу тоглож, лимбэний битүү амьсгааг сурахад шаардлагатай анхан шатны дасгал болох ус үлээх, амьсгал авах гаргах үйлдлийг зэрэг хийх дасгалыг хийж, цаашид улам сайжруулахаар зорилт тавин ажиллаж байгаа талаар танилцуулав. Лимбэ хөгжмийг ардын арга барилаар сонсголоороо сурсан учир энэ төсөлд хамрагдсанаар нот сурч, эгшиг дуугаргалтыг илүү сайжруулж, битүү амьсгааг уртаар авч сурахаар ажиллаж байна. Мөн ардын болон уртын дуу даган тоглодог.



М.Батзориг: “Хөөрхөн халиун” бэсрэг уртын дуу тоглож мөн лимбэний битүү амьсгааг сурахад шаардлагатай анхан шатны дасгал болох ус үлээх, амьсгал авах гаргах үйлдлийг зэрэг хийх дасгалыг хийж, цаашид улам сайжруулахаар зорилт тавин ажиллаж байгаа талаар танилцуулав. Дуу хөгжмийн багш мэргэжилтэй, ЕБ-ын сургуульд багшилдаг бөгөөд нотоор тоглодог. Цаашид уртын дуу тоглож сурах, битүү амьсгаагаар тоглож сурахаар дасгалаа хийн ажиллаж байна.



Ч.Эрдэнэбаатар: Морин хуур хөгжмийг тоглодог бөгөөд лимбэ хөгжмийг уг төсөлд хамрагдсанаар шинээр суралцаж байна. Үзлэгийн явцад “Говийн өндөр” уртын дуу тоглож мөн лимбэний битүү амьсгааг сурахад шаардлагатай анхан шатны дасгал болох амьсгал зөв авах, гаргах дасгалыг хийж цаашид улам сайжруулахаар зорилт тавин ажиллаж байгаа талаар танилцуулав. Төсөлд хамрагдсанаар мөн нотоор тоглох, ардын болон уртын дуу сурахаар ажиллаж байна.



Төслийн дөрөв дэх суралцагч Б.Баттайван нь сургалтын явцад ирээгүй бөгөөд төслөөс хасах саналтай гэв. Тиймээс төслийн хүрээнд хамрагдах дөрөв дэх суралцагчаар Т.Тогтохбаяр /46 настай/ шинээр суралцаж эхэлсэн бөгөөд “Үлэмжийн чанар” дуу битүү амьсгаагаар тоглож үзүүлэв. Нотоор тоглодог, битүү амьсгааг өөрөө сурсан бөгөөд цаашид амьсгааг цэвэр авах, зөв техниктэй болох зорилт тавин ажиллаж байгаа талаар танилцуулав.

Шинэ суралцагч О.Баярсүрэн нь ЕБС-ын 10-р ангийн сурагч бөгөөд лимбэ хөгжмөөр 1 жил орчим хичээллэж байна. Өнгө цэвэр гаргах, дээд доод өнгүүдийг гаргах



тал дээр дасгал сургуулилт хийж байна.

Сургагч багш Б.Отгондүүгийн удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 9.67 GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Өвөрхангай аймаг: Сургагч багш Н.Баярцэнгэл, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.


Өвөрхангай аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч, сургагч багш Н.Баярцэнгэл 2 дахь жилдээ 4 өвлөн суралцагчид шавь сургалтыг удирдан зохион байгуулж байна.

Төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын төвд байх “Хүүхдийн ордон”-д лимбэний шавь сургалтын танхимыг байгуулсан ба II шатны шавь сургалтад 4 өвлөн суралцагч суралцаж байна.

1. Болормаа
2. Мөнхтулга

Биднийг ажиллах үеэр өвлөн уламжлагч Н.Баярцэнгэл өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэгбүрчилэн тайлбарлаж, жишээ болгон зарим дасгал, дууны хэсгээс тоглуулж үзүүлсэн юм. Жишээлбэл:

Болормаа: 2020 оны 1-р сараас суралцаж эхэлсэн. Анх лимбэ хөгжмийн тухай өнгөц ойлголттой ирсэн. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Хөгжимдөө сонирхолтой. (Гамм уншив)





Мөнхтулга: 2019 оны 10-р сараас суралцаж эхэлсэн. 11-р ангид суралцдаг. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Хөгжимдөө сонирхолтой. Дунд шатанд суралцахад бэлэн болж байгаа. (Гамм уншиж, El Condor Pasa тоглов)

Сургагч багш Н.Баярцэнгэлийн удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 5.78GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Говь-Алтай аймаг: Сургагч багш Л.Жамбалдорж, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хөгжмийн багш, лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч, сургагч багш Л.Жамбалдорж 2 дахь жилдээ 4 өвлөн суралцагчид лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг удирдан зохион байгуулж байна.

Шавь сургалтыг Говь-Алтай аймгийн Алтай чуулгын хөгжмийн өрөөнд явуулж байгаа бөгөөд II шатны шавь сургалтад 4 (гэрээтэй), албан бусаар 1 нийт 5 өвлөн суралцагч суралцаж байна.

1. Вангүр (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
2. Жанчивдорж (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
3. Тэмүүлэн (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
4. Дүүрэнбаяр (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
5. Ганзориг (шинээр суралцаж эхэлж байгаа)

Биднийг ажиллах үеэр өвлөн уламжлагч Л.Жамбалдорж өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэг бүрчлэн тайлбарлаж, жишээ болгон зарим уртын дууг тоглуулсан юм. Жишээлбэл:



Жанчивдорж: Алтай чуулгын эвэр бүрээч хөгжимчин. Завхан ХБК-д лимбийг Энхтайван багш дээр суралцаж байсан. Анхан шатны бүрэн мэдлэг боловсролыг авсан. Нотны мэдлэгтэй. Битүү амьсгааг анхан шатанд суралцаж байгаа (“Хан уул”, “Эртний баахан шарга” уртын дууг битүү амьсгаагаар тоглов).



Вангүр: 16-н настай. Завхан ХБК-д суралцаж байгаад гарсан. Чуулгын лимбэчин болох дадлага сургуулилт хийж байгаа суралцагч. Анхан шатны бүрэн мэдлэг боловсролыг авсан. Нотны мэдлэгтэй. Битүү амьсгааг анхан шатанд суралцаж байгаа (“Идэр Жинчин”, “Шалзат баахан шарга”, “Цомбон туурайт” уртын дууг битүү амьсгаагаар тоглов).

Дэлхий нийтийг хамарсан цар тахал Коронавирусын нөлөө, мөн сургуулийн амралт таарсан зэрэг шалтгаанаар н.Тэмүүлэн, н.Дүүрэнбаяр, н.Ганзориг нартай уулзаж баримтжуулалт хийгээгүй болно. Өвлөн уламжлагч Л.Жамбалдорж 9 дүгээр сараас шавь сургалтыг үргэлжлүүлэхээр төлөвлөж буйгаа бидэнд танилцуулж, дээрхи 3 өвлөн суралцагчдын лимбэний битүү амьсгаа өвийг суралцаж, дадлага хийж буй явцыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж СӨҮТ-д ирүүлэхээр болов.

Сургагч багш Л.Жамбалдоржийн удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын



явцтай танилцаж, нийт 8.55GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Ховд аймаг: Сургагч багш Ч.Ваша, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Ховд аймгийн лимбэний битүү амьсгаа өвийн өвлөн уламжлагч, сургагч багш Ч.Ваша 2 дахь жилдээ төслийн гэрээт 4, албан бусаар 2 нийт 6 өвлөн суралцагчид лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг удирдан зохион байгуулж байна.

Сургалтыг Ховд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын номын сан буюу лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтын танхим болгон тохижуулсан өрөөнд явуулж байна.

1. Батхишиг - (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
2. Мөнхжаргал - (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
3. Алтангэрэл - (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
4. Х. Мөнгөнхүү - (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
5. Батнасан - (шинээр суралцаж эхэлж байгаа)
6. Х.Баярсайхан - (шинээр суралцаж эхэлж байгаа)

Биднийг ажиллах үеэр өвлөн уламжлагч Ч.Ваша өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэг бүрчлэн тайлбарлаж, жишээ болгон зарим уртын дууг тоглуулсан юм. Жишээлбэл:



Х.Мөнгөнхүү – 1990 оноос өөрийн сонирхлоор лимбэ хөгжмийг сурсан. Өөрийн 2 охин, 1 банди болон төрсөн дүү, дүү охинд лимбийг зааж сургасан. 2020 оны 1-р сараас эхлэн Ваша багшийн сургалтад элссэн. Бичлэг DVD, гарын авлагаас өөрөө бие даан суралцаж байгаа.



Батхишиг – 1-р сургуулийн 11-р ангид суралцдаг. Хөгжимдөө сонирхолтой. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Битүү амьсгааг анхан шатанд суралцаж байгаа. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа.

Мөнхжаргал – 1-р сургуулийн 11-р ангид суралцдаг. Хөгжимдөө сонирхолтой. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан.









Алтангэрэл – Ховд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын соёл хариуцсан мэргэжилтэн. Төслийн үндсэн суралцагч. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан.

Батнасан – Ховд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын статистик хариуцсан мэргэжилтэн. Нэмэлтээр суралцаж байгаа. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан

Х.Баярсайхан -Дуут сумын Соёлын төвийн эрхлэгч Нэмэлтээр суралцаж байгаа. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан.

Ховд аймагт шавь сургалтын II шат сургагч багш Ч.Вашагийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалж түр зогссон байдалтай байна. Цаашид шавь сургалтыг үргэлжлүүлэн явуулах эсэх нь сургагч багшийн биеийн байдлаас шууд хамааралтай болоод байгаа тул үүсээд байгаа энэхүү нөхцөл байдлыг төслийн ерөнхий зохицуулагч, зохион байгуулах багийн гишүүдтэй зөвшилцөж шийдвэрлэхээр болов.

Ч.Вашагийн удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 6.89 GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Завхан аймаг: Сургагч багш Р.Эрдэнэлхагва, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Соёл, урлагийн их сургуулийн салбар Завхан аймаг дахь Х.Билэгжаргалын нэрэмжит Хөгжим бүжгийн коллеж дээр байгуулагдсан лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтын танхимд тус сургуулийн захирал, өвлөн уламжлагч, сургагч багш Р.Эрдэнэлхагва 2 дахь жилдээ 4 өвлөн суралцагчид лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг удирдан зохион байгуулж байна.

1. Э.Соронзонболд - 14 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
2. Т.Дашмаа - 15 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
3. Г.Нандин-Эрдэнэ - 20 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)
4. Ц.Нямгэрэл – 20 настай (Төслийн хүрээнд өвлөн суралцагч)

Биднийг ажиллах үеэр сургагч багш Р.Эрдэнэлхагва өөрийн шавь нарын лимбэний битүү амьсгаа өвийг сурах явц, сурсан арга барилыг нэг бүрчлэн тайлбарлаж, жишээ болгон зарим уртын дууг тоглуулсан юм.

Жишээлбэл:



Т.Дашмаа – 8-р ангид суралцдаг. Барилт, тавилт, үлээлт, зогсолт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа. (Гамм уншиж, Сайхан хангайн буга дууг тоглов)

Э.Соронзонболд – Барилт, тавилт,



үлээлт, зогсолт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа. (Гам уншиж, Сайхан хангайн буга дууг тоглов)

Дэлхий нийтийг хамарсан цар тахал Коронавирусын нөлөө, мөн их дээд сургууль амарсан зэрэг шалтгаанаар Г.Нандин-Эрдэнэ, Ц.Нямгэрэл нартай уулзаж баримтжуулалт хийгээгүй болно. Өвлөн уламжлагч Р.Эрдэнэлхагва 9 дүгээр сард сургууль эхлэмэгц шавь сургалтыг үргэлжлүүлэхээр төлөвлөж буйгаа бидэнд танилцуулж, дээрхи 2 өвлөн суралцагчдын лимбэний битүү амьсгаа өвийг суралцаж, дадлага хийж буй явцыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж СӨҮТ-д тайлангийн хамт ирүүлэхээр болов.

Р.Эрдэнэлхагвын удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 9.32GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв.

Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Биднийг Завхан аймагт шавь сургалтын үйл ажиллагаатай танилцах явцад сургагч багш Р.Эрдэнэлхагва шавь сургалт талаар өөрийн саналыг уламжилсан болно.

Санал:. Лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэхэд тогтмол дасгал, сургуулилалт их чухал үүрэгтэй. Лимбэ хөгжимтэй харьцах, хэлний цохилго, авиа зүй, амьсгаа зөв авч сурах, өнгөө тогтвортой сурах, гамм үлээх, диатоник, ардын дуу, уртын дуу тоглох гэсэд маш олон үе шаттайгаар суралцдаг. Төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй шавь сургалтын хугацаа их богино байна. Аль болох урт хугацаанд энэхүү сургалтыг зохион явуулах нь зүйтэй юм.

Улаанбаатар хот, Монголын хүүхдийн ордон: Сургагч багш Ч.Даваажав, шавь сургалтын үйл ажиллагааны тухай.

Монголын хүүхдийн ордны үлээвэр хөгжмийн багш Ч.Даваажав тус ордныг түшиглэн 2 дахь жилдээ 4 өвлөн суралцагчид лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтыг удирдан зохион байгуулж байна.

Эхлэн суралчагчдад лимбэ хөгжмийн тухай ойлголт, барил тавил суулт, зогсолт, толгой гар хөлний булчингийн ерөнхий зохицол хурууны байрлал, уруулын тавил, амьсгааны үйл ажиллагааны тухай сургалт явуулж си бемоль мажорын гамм үлээлгэж

№	Овог нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Оршин суугаа хаяг	Утасны дугаар
1	Цэрэнпүрэв Жамуха	УК08250897	12	эр	БЗД 25-р хороо 74в 80тоот	99093125
2	Мөнхбаатар Бишрэлт	УЖ08301534	12	эр	ХУД 15-р хороо 66-15тоот	99114998
3	Гантөмөр Төмөржин	УК03241735	18	эр	БЗД 3-р хороо Дунд гол 30в-4-50тоот	88610543
4	Баатарцог Батхүү	ЙЮ08252112	12	эр	БГД 11-р хороо Хувьсгалчдын б-00	95114870

ноот цээжлүүлэх энгийн дасгал хийлгүүллээ. Ер нь 14 хоногын сургалт нь хугацаа богино маш шаргуу хичээллэж гамм үлээлгэж сургаад дуусаж байна. Мөн хүүхдийн идэвхи оролцоо сургалт их нөлөөлж байна.

Ч. Даваажав багшийн удирдан, зохион байгуулж буй шавь сургалтын явцтай танилцаж, нийт 5.87GB-ийн цахим (гэрэл зураг, дуу дүрс бичлэг) материалыг Соёлын өвийн Улсын Нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэн өгөв. Мөн 2020 оны 10 дугаар сард II шатны шавь сургалтын тайланг өвлөн уламжлагч нар СӨҮТ-д гаргаж өгөхтэй холбогдуулан тайлан авах маягтыг танилцуулж, тайлбарлан, хүлээлгэж өгөв.

Тайлбар:

Төвийн бүсд хамаарах Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт шавь сургалт явулж байгаа Сургагч багш, Болд (сэлэнгэ аймаг), Б.Мягмарцэрэн, Б.Цогтмагнай (Монгол улсын консерватори), М.Цэнгэлсайхан (СУИС) нарын зохион байгуулж буй шавь сургалтын явцыг Дэлхий даяар тархаад буй цар цахалын дэгдэлттэй, өвлөн суралцагч нар оролцох боломжгүй байсан тул цахимаар холбогдож үйл ажиллагааны мэдээллийг 2020 оны II шатны шавь сургалтын тайланд бичиж ирүүлэхийг мэдэгдсэн болно.

2. Лимбэ урлалыг дэмжих, сургалтыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан онлайн буюу цахим хэлбэрээр зохион байгуулах:

Лимбэ урлалыг дэмжих, сургалтыг олон нийтийг хамарсан цар цахал, хөл хорио зэрэг нийгмийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан зорилтын хүрээнд танхимын сургалтаар хийгээгүй ч нөхцөл байдалтай уялдуулан цахимаар зохион байгуулж өвлөн уламжлагч нарт байгууллагын болон олон нийтийн цахим сувгийг ашиглаж түгээсэн байна. Тус контентийг 4 минут 58 секундын хугцаатай “The Hu” хамтлагийн гишүүн, Лимбэч, Лимбэ урлаач Г.Нямжанцантай хамтран лимбэ хөгжмийн хэмжээ, материал хэрхэн сонгох, хөглөгөө зэрэг мэдээллийг хамруулан бүтээсэн.



3.Лимбэний битүү амьсгааны уламжлал, сургалтыг харуулсан бариматат кино бүтээх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах:

ЮНЕСКО болон Соёлын өвийн үндэсний төвийн хооронд 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан № 4500386779 тоот гэрээ, Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтын 3,

3.1-т заасны дагуу Лимбэний битүү амьсгааны уламжлал, сургалтыг харуулсан баримтат кино бүтээх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд “Үндэсний соёл уламжлал бичиг үсгийн өвийг хамгаалах хүрээлэн” ТББ-тай гэрээ байгуулан Баримтат киноны II шатны үйл ажиллагааны дуу, дүрс бичлэгийг цуглуулах, эвлүүлэх, баримтат киноны эхний хувилбарыг хийлгэж хүлээн авсан.

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтын 3, 3.1-т заасан Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизээр цуврал баримтат нэвтрүүлэг хийх ажлын хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр “Соён гэгээрүүлэгч” телевизтэй гэрээ байгуулан “Нүүдэлчдийн лимбэдэх соёлын өвийн гайхамшиг”-2 сэдэвт 30 минутын баримтат нэвтрүүлгийг хийж, орон даяар 10 удаа эфирээр цацаж сурталчилсан.



Тус нэвтрүүлэгт Авран хамгаалах газрын Дэлхийн өв хариуцсан мэргэжилтэн М.Цэцэнбилэг Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн Конвенц, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын БМСанч Ж.Насанжаргал тус төслийн II шатны төслийн үйл ажиллагаа, төслийн хүрээнд хэрэгжиж байгаа шавь сургалтын явц, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэсэн.


4.Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байранд лимбэний сургалтын танхим байгуулах:

ЮНЕСКО болон Соёлын өвийн үндэсний төвийн хооронд 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан № 4500386779 тоот гэрээ, Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтын 2-т заасны дагуу “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь” төслийн хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байранд 2020 оны 11 дүгээр сард багтаан “Лимбэний сургалтын танхим”-ыг байгуулсан.


Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байранд Лимбэний битүү амьсгаа өвийн сургалтын танхим байгуулах зорилгоор төслийн хүрээнд төлөвлөсний дагуу 86.4м2 дуу шингээгч хавтан, 1ш зөөврийн компьютер, 10ш нотны тавиурыг холбогдох хууль журмын дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Тус танхимын дуу тусгаарлах хавтанг нааж суурилуулсан, нэмэлт санхүүжилтээр 6м2 дрож, 10 сандал, 3 ширээ зэрэг шаардлагатай эд хэрэгсэлээр тохижуулж нээлтийн үйл ажиллагааг төлөвлөсөн боловч ч дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 халдварт өвчнөөс

үүдэн Улс, орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан танхимын нээлтийн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна.



Эд хэрэгсэл, тоног тохоорөмжийн жагсаалт:

№	Нэр	Тоо	Санхүүжилт	Зураг
1	Дуу шингээгч хавтан /акустик/ Дуу чимээг 80% хүртэл өөртөө шингээх. Хүний биед хортой формальдегид бодисын ялгарлын хэмжээ E1 стандартад нийцсэн Хэмжээ (1м22 х 2м42, Зузаан 9мм) нийт 86.4м^2	30	Төслийн санхүүжилтээр	

2	Зөөврийн компьптер /Notebook/ CPU төрөл - Core i7 CPU давтамж - 2.5 GHz Хатуу диский багтаамж – 1024G Санах ойн багтаамж - Core i7, 8GB+128GB, 4-8th generation Дэлгэцийн хэмжээ – 15 inch Өнгөний нягтаршил: Бүрэн HD /1902x1080/	1	Төслийн санхүүжилтээр	
3	Нотны тавиур Хэмжээ: тавиур - 50 x 35 Өндөр: 1м 20 хүртэл /сундаг/ Өнгө: Хар	10	Төслийн санхүүжилтээр	
4	Дрож	6м^2	СӨҮТ-ийн санхүүжилтээр	
5	ширээ Хэмжээ: 120см x 60см x 70 см	3	СӨҮТ-ийн санхүүжилтээр	
6	Сандал Сандал: эвхэгддэг Өнгө: хар	10	СӨҮТ-ийн санхүүжилтээр	

5.“Соёлын биет бус өвийн талаархи мэдлэг, ойлголтыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад нэвтрүүлэх боломж, шийдэл” уулзалтын тайлан

“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, “Монголын Лимбэчдийн холбоо” ТББ хамтран “Соёлын биет бус өвийн талаарх мэдлэг, ойлголтыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад нэвтрүүлэх боломж, шийдэл” (Лимбэний битүү амьсгаа өвийн жишээн дээр) зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Уулзалтын зорилго нь энэхүү өвийг залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад СББӨ, тэр дундаа Лимбэний битүү амьсгаа өвийг тусгах талаар холбогдох төрийн байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулиудын төлөөллүүдтэй хэлэлцэн санал солилцож цаашид энэ талаар хамтран судлахад оршино.

Уулзалтыг Сүхбаатарын нэрэмжит ерөнхий боловсролын 2 дугаар дунд сургууль дээр зохион байгуулсан бөгөөд уулзалтад Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, “Монголын Лимбэчдийн холбоо” ТББ, Монголын үндэсний музей, Боловсролын хүрээлэн, Нийслэлийн боловсролын газар, Монгол улсын консерватори, Монгени цогцолбор сургууль, 2, 6, 24, 31, 45 дугаар сургуулийн төлөөллүүд оролцож санал солилцов. Уулзалтын үр дүнгээр



холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх саналын төслийг боловсруулав.

Соёлын биет бус өвийн талаархи мэдлэг, ойлголтыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад нэвтрүүлэх боломж, шийдэл: (Лимбэний битүү амьсгаа өвийн жишээн дээр).

ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцид манай улс 2005 онд нэгдэн орсон. Тус Конвенцид “Соёлын биет бус өв гэдэг нь хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий зэмсэг, эд зүйлс, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ. Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын олон төрөл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг” гэж тодорхойлсон байдаг.

Тус конвенцийн 2.3 дугаар зүйлд “Хамгаалах гэдэгт соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг хангах зорилгоор түүнийг таньж тогтоох, баримтжуулах, судлах, хадгалах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, сайжруулах, түгээх, ингэхдээ албан болон албан бус боловсролыг ашиглах, түүнчлэн тухайн өвийг сэргээх арга хэмжээг хэлнэ” гэж заасан.

Ерөнхий боловсролын сургуулийн “Дуу хөгжим”-ийн хичээл, ном, сурах бичиг, багшийн сургалтын төлөвлөгөөтэй анхан шатны байдлаар танилцахад соёлын биет бус өв, тэр дундаа үндэсний язгуур урлагийн талаарх мэдлэг ойлголт өгөх мэдээлэл, сургалтын материал дутмаг байгаа нь ажиглагдсан бөгөөд энэхүү зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах нэгэн суурь шалтгаан болсон юм.

“Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” өв 2011 онд ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн. Өвлөн уламжлагчдын тоо цөөн, устаж, мартагдахын



ирмэгт байсан энэхүү өвийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, өвлөн уламжлагчдыг алдаршуулан сурталчлах, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, “Монголын Лимбэчдийн холбоо” ТББ хамтран “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийг 2019-2021 онд ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд зохион байгуулагдах энэхүү зөвлөлдөх уулзалтын зорилго нь “Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгаа” өвийг ерөнхий боловсролын сургуульд албан болон албан бус сургалтаар дамжуулан заах боломж, тус өвийн талаарх мэдлэг ойлголтыг хүүхэд залууст түгээн дэлгэрүүлэхэд оролцогч талууд хэрхэн хамтран ажиллаж болох талаар санал солилцох, цаашлаад шийдвэр гаргагчдад зөвлөмж хүргүүлэх болно.

Зөвлөлдөх уулзалтаас гаргасан санал, зөвлөмж:

Оролцогч талууд: Соёлын яам, БШУЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Соёлын өвийн үндэсний төв, Нийслэлийн боловсролын газар, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ.

1. “Соёлын биет бус өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийн 2019-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.2 дахь заалтын хүрээнд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусган арга хэмжээг үе шаттай нэвтрүүлэх.

- Тандалт судалгаа хийх
- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулах;
- Багш нарын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, Лимбэний сургагч багш бэлтгэх
- Музей болон холбогдох байгууллагуудтай хамтран албан ба албан бус сургалтыг зохион байгуулах;
- ЕБС-ийн сурагчдад зориулсан аудио, видео контент боловсруулах;

2. Монгол Лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил-битүү амьсгааны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өвлүүлэн сургах чиглэлээр албан ба албан бус боловсрол олгох туршилтын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

- Музей болон холбогдох байгууллагуудтай хамтран албан ба албан бус “Лимбэ хөгжим” төслийг хэрэгжүүлэх;

3. Туршилтын сургалтын үр дүнгээс хамаарч цаашдын авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг тэлэх.

6.“Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD хэвлүүлэх бэлтгэл ажлыг хангах:

ЮНЕСКО болон Соёлын өвийн үндэсний төвийн хооронд 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан № 4500386779 тоот гэрээний дагуу Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, “Монголын Лимбэчдийн Холбоо” ТББ хамтран “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь” төслийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн сангийн дэмжлэгтэйгээр 2019-2021 оны хооронд хэрэгжүүлж байгаа билээ.

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтын 4, 4.1-т заасны дагуу “Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD хэвлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Лимбэний бүтүү амьсгааг өвлөн уламжилж буй өвлөгчдөөс “Монголын лимбэчдийн холбоо” ТББ-ийн саналаар уран бүтээлчдийг сонгон мэргэжлийн дуу бичлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Плэй энтертаймент” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан.

Гэрээний дагуу 10 уртын дууны хөгжмийн Лимбэний аудио бичлэг хийх, боловсруулах (миксинг мастеринг) ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авсан. Үүнд:

№	Тоглосон хөгжим, дууны нэр	Өвлөгчийн нэр
1	Ар хөвчийн унага	Батцэнгэл
2	Уртхан хонгор салхи	
3	Бор тормийн бялзуухай	Эрдэнэлхагва
4	Жаахан шарга	
5	Оройн чимэг	
6	Энх мэндийн баяр	Мягмарцэрэн
7	Жавхлант сүрэг	
8	Асарийн өндөр	Г.Нямжанцан
9	Жороо баахан улаан	
10	Дуртмал сайхан	Ж.Цэвэгсүрэн

2021 оны төслийн III шатны үйл ажиллагааны хүрээнд “Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” CD-г хэвлүүлж орны хүртээл болгох ажлыг төлөвлөсөн болно.

7.Лимбэчдийн намтар танилцуулга бүхий ном хэвлэх бэлтгэл ажлыг хангах:

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтын 5.1-т заасны дагуу Ном боловсруулах, эх бэлтгэх ажлыг “Монгол Лимбэчдийн холбоо” ТББ-ын тэргүүн, лимбэч, доктор Ц.Цэвэгсүрэнтэй “төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудтай байгуулах хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулан тус номыг боловсруулсан.

“Монгол Лимбэний урлаг” нэртэй номыг 2021 онд буюу тус төслийн III шатны хүрээнд хэвлэн олны хүртээл болгох бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд 107 нүүр /word/ бүхий бичвэрийг бэлтгэн хүлээлгэн өгсөн байна.

Хавсралт 1. “Монгол лимбэний урлаг” номын агуулга.

Хавсралт 1

МОНГОЛ ЛИМБЭНИЙ УРЛАГ
/1921-2021/

ГАРЧИГ
ӨМНӨХ ҮГ.....
I. УДИРТГАЛ
II. МОНГОЛ ЛИМБЭНИЙ ҮҮСЛИЙН ТУХАЙ ДОМОГ, ХУУЧ
III. МОНГОЛЫН ЛИМБЭДЭХ УРЛАГИЙН ТҮҮХЭН ОН ЦАГИЙН ТОВЧООН / зэмсгийн судалгаа, лимбэний сургалт, лимбэнд зориулсан гоцлол бүтээлүүд, лимбэний сургалтад зориулсан ном, гарын авлага, уралдаан тэмцээн, бусад үйл ажиллагаа гэх мэт/
IV. МОНГОЛЫН ЛИМБЭЧДИЙН НАМТАР, УРАН БҮТЭЭЛ

Намтарын агуулга:
- Төрсөн газар, он сар өдөр
- Ажилласан туршлага
- Лимбэдэх урлагт оруулсан хувь нэмэр
- Амжилт, шагнал

ДҮГНЭЛТ

Шавь сургалтын үйл явцтай танилцах, хяналт хийх баг лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах баруун бүсийн шавь сургалтын үйл ажиллагаатай танилцсаны үндсэнд дараах санал дүгнэлтийг (Хавсралт 4) сургагч багш болон өвлөн суралцагч нэг бүрт гаргав. Шавь сургалтын явцад санал дүгнэлт өгөх ажлыг хяналтын багийн ахлагч Ц.Цэвэгсүрэн (төслийн зохицуулагч, “Монголын лимбэчдийн холбоо” ТББ-ын тэргүүн) гүйцэтгэв.

Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан аймгуудад зохион байгуулагдаж буй лимбэний битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах сургалтад 4 сургагч багш 16 өвлөн суралцагч сургаж буйгаас шавь сургалтын явцтай танилцах үеэр 4 багшийн 9 өвлөн суралцагчтай уулзаж, тэдний лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн суралцсан байдалтай танилцаж, 108GB-ийн дуу, дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав. Сургалтын явцад дараах ололттой болон сул талууд ажиглагдав.

Ололттой тал

- Суралцагчдад өвийг уламжлан суралцах хүсэл эрмэлзэл, идэвх чармайлт байсаар байна,
- Хичээлийн танхим, гарын авлага, хөгжмийн зэмсэг хүрэлцээтэй байна,
- Сургалтад зөвхөн төслөөр хамрагдаж байгаа суралцагчдаас гадна сонирхол,

хүсэлтээрээ хамрагдаж суралцаж байгаа суралцагчид цөөнгүй байна.

Сул тал

- Ковид 19 үүссэн нөхцөл байдал сургалтыг хэвийн зохион байгуулахад хүндрэл учруулсан,
- Суралцагчдын сургалт, ажил төрлийн байдлаас шалтгаалан хичээл сургалт тасрах, цаг хугацаа алдах зүйл гарч байна,
- Зарим багш нарын хариуцлага, идэвх сул, хандлага буруу байна,
- Багш нар сургалтын бусад хэлбэрүүдийг сонгож хичээллэхгүй байна /цахим болон холимог гэх мэт/,
- Суралцагчид тууштай биш солигдох байдал зарим тохиолдол гарч байгаа ба үүнээс шалтгаалан үр дүн, ахиц дэвшил тодорхой түвшинд хүрэхгүй байх тохиолдол гарч байна.
- Суралцагчдын нас, хүйс, идэвхи чармайлт, сургалтын үр дүнгээс шалтгаалан сургалтын явц, түвшин харилцан адилгүй байна.
- Суралцагчдын 70% -ийн түвшин ерөнхийдөө анхан шатны байдалтай байна.

Тиймээс дараах зөвлөмжийг (Хавсралт 4) баруун бүсийн Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан аймгуудад шавь сургалт зохион байгуулж буй сургагч багш нар хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.

ХАВСРАЛТ 1. Шавь сургалтын ажилтай танилцах, хяналт хийх тухай удирдамж.

ХАВСРАЛТ 2. Тайлангийн маягт.

ХАВСРАЛТ 3. Шавь сургалтын явц, сургагч багш, өвлөн суралцагчдад өгсөн санал дүгнэлт.

ХАВСРАЛТ 4. Зөвлөмж.

ХАВСРАЛТ 5. Цахим мэдээллийн товъёог.

ХАВСРАЛТ 6. Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгаа өвийг өвлөн уламжлагчдын анхдугаар уралдааны удирдамж.

Тайлан бичсэн: Ж.Насанжаргал /Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын СББӨ хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/

Ц.Цолмон /Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн өвийн дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч/

Д.Мөнхбаатар /Мэдээлэл, технологийн газрын зураглаач/

Танилцсан: Ц.Цэвэгсүрэн /Төслийн зохицуулагч, багийн ахлагч/

Хянасан: Т.Энхтунгалаг /Захиргаа, удирдлагын дарга/

---o0o---

БАТЛАВ: Г.ЭНХБАТ
/СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ/

2020 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот

МОНГОЛ УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА БИТҮҮ АМЬСГАА" ТӨСЛИЙН II ШАТНЫ ШАВЬ СУРГАЛТЫН ҮЙЛ ЯВЦТАЙ ТАНИЛЦАХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ, БАРИМТЖУУЛАХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн сангийн дэмжлэгтэйгээр Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, "Монголын Лимбэчдийн Холбоо" ТББ хамтран хэрэгжүүлж буй "Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь" төслийн хүрээнд баруун бүс (Өвөрхангай,Говь-Алтай, Завхан, Ховд)-д зохион байгуулагдаж буй II шатны шавь сургалтын явцтай танилцах, зөвлөмж өгөх, холбогдох баримтжуулалт хийх болно.

ХОЁР: ЗОРИЛТ

Шавь сургалтын явцтай танилцах, зөвлөмж өгөх, баримтжуулах ажлын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Өвлөн уламжлагчдын шавь сургалтыг зохион байгуулахад ашиглаж буй мэдлэг, туршлага, хэрэглэгдэхүүний талаар ярилцлага, мэдээлэл авах, сургалтын явцыг баримтжуулах,
- Өвлөн суралцагчдын уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэх явцыг баримтжуулах, суралцах явцын талаарх сэтгэгдлийг баримтжуулах,
- Баримтат кинонд ашиглагдах шавь сургалтын холбогдолтой дүрс, хэрэглэгдэхүүн цуглуулах.

ГУРАВ. АРГА ЗҮЙ

1. Өвлөн уламжлагчдийн лимбэний битүү амьсгаа өвийг өвлөн суралцагчидад зааж, сургаж буй арга техникийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах.
2. Төслийн хүрээнд хэвлэгдсэн "Лимбэдэх уламжлалт арга битүү амьсгаанд суралцах нь" гарын авлагын үндсэн хичээлүүд, заавал сурах дууны жагсаалтын дагуу өвлөн суралцагчдын битүү амьсгаа тоглох явцыг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах.
3. Шавь сургалтын талаарх өвлөн суралцагчдын сэтгэгдлийг баримтжуулах, ярилцлага хийх.

4. Гэрэл зураг видео бичлэгийн баримтжуулалтыг хийхдээ өвлөн уламжлагч болон өвлөн суралцагчийн үйл хөдлөлийг бүхэлд нь оруулан дуу дүрс бичлэг, 2 буюу түүнээс дээш тооны гэрэл зургаар үйл явц бүрээр дэс дарааллан тооны хязгааргүй баримтжуулах.

Дүрс бичлэгийн баримтжуулалтыг хийхдээ:

- Өвийн зүйлийг тухайн орчин нөхцөлд нь уламжлалт ёс жаяг, арга барилаар үйлдэж байгааг баримтжуулах,
- Тухайн өвийг өвлүүлэн уламжлуулах уламжлалт арга барил, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээллийг оруулах,
- Дүрс бичлэгийг HD Форматаар хийнэ (High definition -өндөр нягтшилтай).

Гэрэл зургийн баримтжуулалтыг хийхдээ:

- Гэрэл зураг, дуу, дүрс бичлэг болон бусад судалгааны материалыг Соёлын өвийн УНБМС-гийн Үйл ажиллагааны Дотоод журмын дагуу товьёогжуулан боловсруулах,
- Гэрэл зургийг JPEG форматаар авах ба 4288x2848-аас 5616x3744 pixel-ээс багагүй авна.

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Шавь сургалтын үйл явцтай танилцах, зөвлөмж өгөх, баримтжуулах, боловсруулах, тайлан бичих зэрэг ажлыг 2020 оны 6 дугаар сарын 25-аас эхлэн 90 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа		Хугацаа	Байршил
1. Баруун бүс:			
Өвөрхангай	Арвайхээр хот	VI/25-VII/3 /8 хоног/	
Говь-Алтай аймаг	Алтай хот		
Ховд аймаг	Ховд хот		
Завхан аймаг	Улиастай хот		

ТАВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

1. Шавь сургалтын явцтай танилцаж, зөвлөмж өгснөөр шавь сургалтын чанар сайжирч, төслийн хэрэгжилтийн үр дүнд бодит хувь нэмэр оруулна.
2. Баруун бүс буюу Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Ховд аймгуудад зохион байгуулагдаж буй лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах

шавь сургалтын II шатны баримтжуулалт (өвлөн уламжлагчдын заах арга техник, өвлөн суралцагчдын битүү амьсгаагаар лимбэдэх чадвар) хийгдэнэ.

3. Соёлын өвийн УНБМС-гийн СББӨ-ийн Хадгаламжийн нэгж лимбэний битүү амьсгаа өвийн шавь сургалтын холбогдолтой гэрэл зураг, дуу, дүрс бичлэг зэрэг цахим баримтжуулалтаар баяжигдана.
4. Шавь сургалтын баримтжуулалтын дүнд цуглагдсан баримтжуулалтын материал нь баримтат кино болон лимбэчдийн намтар, танилцуулга бүхий ном бүтээхэд ашиглагдана,

ЗУРГАА. БАРУУН БҮСЭД АЖИЛЛАХТАЙ ХОЛБОГДОЛТОЙ НЭМЭЛТ ЧИГ ҮҮРЭГ:

- Соёлын өвийн үндэсний төвөөс боловсруулж байгаа соёлын биет болон биет бус өвийн оны статистикийн мэдээний санал асуулгыг Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Ховд аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтнүүдээс холбогдох маягт болон нөхөх зааврын дагуу авах.
- Санал асуулга авах явцыг баримтжуулах.

ДОЛОО. СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:	Ц.Цэвэгсүрэн СУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газрын дарга, лимбэчин, "Монголын Лимбэчдийн Холбоо" ТББ-ын тэргүүн,
Багийн гишүүн:	Ж. Насанжаргал СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч
	Ц.Цолмон (Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газар, Дэлхийн өвийн дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч)
	Д.Мөнхбаатар (СӨҮТ-ийн Мэдээллийн технологийн газрын зураглаач)
	Д.Шижирбат (Жолооч)
Удирдамж боловсруулсан:	Ц.Цолмон (Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газар, Дэлхийн өвийн дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч)
	Ж. Насанжаргал СӨҮТ-ийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын соёлын биет бус өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч

---xXx---

ХАВСРАЛТ 2

МОНГОЛ ЛИМБЭЧДИЙН УРТЫН ДУУ ХӨГЖИМДӨХ УЛАМЖЛАЛТ АРГА БАРИЛ- БИТҮҮ АМЬСГАА ӨВИЙН ШАВЬ СУРГАЛТЫН ТАЙЛАН

(хөтлөх маягт)

1. Сургагч багшийн мэдээлэл

№	Овог нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Оршин суугаа хаяг	Утасны дугаар
1	Ө.Батжаргал	БА44552222	41	эр	Өмнөговь аймаг Даланзадгал хот, 5-34 тоот	88552220

2. **Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил- битүү амьсгаа өвийг өвлөн суралцагчдын мэдээлэл** /төселд хамрагдаж байгаа болон бусад/

№	Овог нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Оршин суугаа хаяг	Утасны дугаар
1						
2						
3						
4						
5						

3. **Шавь сургалтын үргэлжилсэн хугацаа** *(сургалт эхэлснээс тухайн жилийн тайлан өгөх хүртэлх хугацааг хамруулна)*

Агуулга	Он	Сар	Өдөр
Эхэлсэн	2020	4	15
Дууссан	2020	11	10

4. **Шавь сургалтын хуваарь** *(дэлгэрэнгүй байдлаар бичнэ үү)*

№	Сар, өдөр	Хичээлийн үргэлжилсэн цаг	Хичээлийн сэдэв, агуулга
1	4 сарын 18	2	Ардын богино дууны дадлага, Ус үлээх, нотоор тоглох гэх мэт
2			
3			
14			

5. Шавь сургалт явуулахад хуримтлуулсан туршлага болон ололттой тал *(Шавь сургалтын явцад хуримтлуулсан шинэлэг туршлага, ололттой тал, гарсан үр дүнг тодорхойлж бичнэ. Үүнд: заах арга зүй, зохион байгуулалтын хэлбэр, суралцагчдийн идэвхи оролцоо гэх мэт, 300 үгнээс доошгүй бичнэ)*

6. **Шавь сургалт явуулахад гарсан хүндрэл** *(Шавь сургалтын зохион байгуулах явцад гарсан хүндрэл, бэрхшээл, дутагдалтай талыг бичнэ. Үүнд: зохион байгуулалт, санхүү төсөв, байр танхим, хөгжмийн зэмсгийн хүрэлцээ, суралцагчдийн оролцоо, сонирхол, бусад...)*

7. **Гэрэл зураг** *(Өвлөн суралцагч болон шавь сургалтын үйл явцыг харуулсан 300 dpi нягтаршил бүхий 8 -аас доошгүй гэрэл зургийг тайлбарын хамт хавсаргах)*

8. **Шавь сургалтын шалгуур үзүүлэлт, хэрэгжилт, үнэлгээ**

№	Шалгуур үзүүлэлт (заавал сурах онол, арга техникийг суралцагч тус бүрийн онцлогт тохируулж тодорхойлж оруулна)		Үнэлгээ /0-10 оноогоор үнэлнэ, шалгуур тус бүрт оноог хуваож өгнө/	Тайлбар (шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг 50-аас доошгүй үгээр тайлбарлаж бичнэ)
1	А.Уранжаргал	Онол арга зүй, ирц	3	
		Ур чадвар	4	
		Битүү амьсгаа	3	
2				
3				
4				
5				
6				

9. **Тайлангийн ерөнхий үр дүн** *(тухайн жилийн сургалтын үйл ажиллагааны ерөнхий үр дүнг дүгнэн 500-аас доошгүй үгэнд бичнэ)*

Тайлан бичсэн: ..... /гарын үсэг/

..... /гарын үсгийн тайлал/

20....оны.....сар... өдөр

ХАВСРАЛТ 3

Шавь сургалтын явц, сургагч багш, өвлөн суралцагчдад өгсөн санал дүгнэлт.

д/д	Аймгийн нэр / сургагч багшийн нэр	Өвлөн суралцагчийн нэр	Шавь сургалтын явцтай танилцах үеийн байдал	Дүгнэлт
1	Өвөрхангай аймаг - Н.Баярцэнгэл	Болормаа	2020 оны 1-р сараас суралцаж эхэлсэн. Анх лимбэ хөгжмийн тухай өнгөц ойлголттой ирсэн. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Хөгжимдөө сонирхолтой. (Гамм уншив)	Болормаагийн хувьд сургалт оройтож эхэлсэн байна. Хагас жилийн хугацаа алдсан байдалтай. Алдсан хугацааг нөхөх, шахах байдлаар хичээллэх шаардлагтай.
		Мөнхтулга	2019 оны 10-р сараас сралцаж эхэлсэн. 11-р ангид суралцдаг. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Хөгжимдөө сонирхолтой. Дунд шатанд суралцахад бэлэн болж байгаа. (Гамм уншиж, Перу аялгуу "El Condor Pasa"-г тоглов)	Мөнхтулга анхан шатны сургалтыг сайн авсан. Барил тавил, эгшиглээ/тембр/, амьсгааны зохицуулалт жигдэрсэн, тогтсон байна. Одоо битүү амьсгаанд суралцах, дасгал хийх, бэсрэг уртын дуу лимбэдэх арга барилд суралцаж эхлэх.
2	Говь-Алтай аймаг шавь сургалт – Жамбалдорж багш	Жанчивдорж	Алтай чуулгын эвэр бүрээч хөгжимчин. Завхан ХБК-д лимбийг Энхтайван багш дээр суралцаж байсан. Анхан шатны бүрэн мэдлэг боловсролыг авсан. Ноотны мэдлэгтэй. Битүү амьсгааг анхан шатанд суралцаж байгаа. (Эрдэнэ засгийн унага-г битүү амьсгаагаар тоглов)	Жанчивдорж лимбэдэх анхан шатны суурь мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Битүү амьсгаа авах арга техникийг сурсан. Битүү амьсгаа авах явцад амны хөндий, хоолойд дуу чимээ, цуурай үүсэж, сонсогдож байна. Дасгал сургуулалтыг тогтмолжуулах, ур чадвараа сайжруулах. Бэсрэг уртын дуу лимбэдэж эхэлсэн. Багшаас нутгийн уртын дуу өвлөн авах.

		Вангүр	16-н настай. Завхан ХБК-д суралцаж байгаад гарсан. Чуулгын лимбэчин болох дадлага сургуулилт хийж байгаа суралцагч. Анхан шатны бүрэн мэдлэг боловсролыг авсан. Ноотны мэдлэгтэй.	Вангүр лимбэдэх анхан шатны суурь мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Битүү амьсгааны арга техникийг сурч эхлэж байна. Бэсрэг уртын дуу лимбэдэж эхэлсэн. Битүү амьсгаа авах явцад амны хөндий, хоолойд дуу чимээ, цуурай үүсэж, сонсогдож байна. Дасгал сургуулалтыг тогтмолжуулах, ур чадвараа сайжруулах.
3	Ховд аймаг – Ваша багш	Х.Мөнгөнхүү	1990 оноос өөрийн сонирхлоор лимбэ хөгжмийг сурсан. Өөрийн 2 охин, 1 банди болон төрсөн дүү, базынхаа охинд лимбийг зааж сургасан. 2020 оны 1-р сараас эхлэн Ваша багшийн сургалтад элссэн. Бичлэг DVD, гарын авлагаас өөрөө бие даан суралцаж байгаа.	Х. Мөнгөнхүү олон жил өөрийн авьяас чадвараар лимбэдэж байгаа. Битүү амьсгааны арга техникт суралцаж эхэлж байна. Битүү амьсгааны арга техникийг хурдан эзэмших, бэсрэг уртын дуунд суралцах, багшийн үүрэг оролцоог сайжруулах шаардлагатай байна.
		Батхишиг	1-р сургуулийн 11-р ангид суралцдаг. Хөгжимдөө сонирхолтой. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Битүү амьсгааг анхан шатанд суралцаж байгаа. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа.	Батхишиг лимбэдэх анхан шатны мэдлэг, ур чавдарт суралцаж байна. Сургалтын явцыг эрчимжүүлэх, нөхөх, шахах байдлаар хичээллэх шаардлагатай.
		Мөнхжаргал	1-р сургуулийн 11-р ангид суралцдаг. Хөгжимдөө сонирхолтой. Барилт, тавилт, үлээлт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан.	Мөнхжаргал лимбэдэх анхан шатны мэдлэг, ур чадварт суралцаж байна. Сургалтын явцыг эрчимжүүлэх, нөхөх, шахах

				байдлаар хичээллэх шаардлагатай.
4	Завхан аймаг – Р.Эрдэнэлхагва багш	Т.Дашмаа	8-р ангид суралцдаг. Барилт, тавилт, үлээлт, зогсолт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа. (Гамм уншиж, Сайхан хангайн буга дууг тоглов)	Т.Дашмаа лимбэдэх анхан шатны мэдлэг, ур чадварт суралцаж байна. Сургалтын явцыг эрчимжүүлэх, нөхөх, шахах байдлаар хичээллэх шаардлагтай.
		Э.Соронзонболд	Барилт, тавилт, үлээлт, зогсолт гээд ерөнхий анхан шатны мэдэгдэхүүнээ авсан. Усыг тасралтгүй үлээх дасгалыг сурч байгаа. (Гамм уншиж, Сайхан хангайн буга дууг тоглов)	Соронзонболд лимбэдэх анхан шатны мэдлэг, ур чадварт суралцаж байна. Сургалтын явцыг эрчимжүүлэх, нөхөх, шахах байдлаар хичээллэх шаардлагтай

ХАВСРАЛТ 4

ЗӨВЛӨМЖ

ЮНЕСКО, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, "Монголын Лимбэчдийн Холбоо" ТББ хамтран 2019-2021 оны хооронд хэрэгжүүлж буй "Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь" төслийн хүрээнд баруун бүс буюу Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан аймгуудад лимбэний битүү амьсгаа өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалт зохион байгуулж буй сургагч багш нарт шавь сургалтын үр дүнг сайжруулахад дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Багш нар цахим болон танхимын сургалтын холимог тогтолцоог хэрэглэх,
2. Суралцагчдын насны байдал, сонирхол зэргийг хүндэтгэн үзэж сургалт явуулах, хандах,
3. Сургалтыг сонирхолтой байдлаар зохион байгуулах,
4. Авьяас, сонсголд тохируулан дагуулан хөгжимдөх гэх мэт уламжлалт арга зүйг ашиглах,
5. Туршилтад суурилсан туршлага суулгах, жишээнд тулгуурласан арга зүйг түлхүү ашиглах,
6. Суралцагчдын бие даалт, сургалтаас бусад цаг хугацааг оновчтой ашиглах үүднээс гарын авлага, DVD хичээлийг ашиглах арга зүйг эзэмшүүлэх,
7. Багш нар суралцагчдад мэргэжлийн сургалтын суурь баримжаа олгож байгаа нь оновчтой хэдий ч энэ байдлыг удаан үргэлжлүүлэх нь цаг хугацаа алдах нөхцөл үүсэх магадлал байж болохыг анхаарах.
8. 2021 оны IV улиралд төслийн хүрээнд суралцсан өвлөн уламжлагчдын дунд уралдаан зохион байгуулах тул "Лимбэдэх уламжлалт арга: Битүү амьсгаанд суралцах нь" гарын авлага дээрхи дасгал, сургуулилалтыг уралдааны удирдамжтай уялдуулан явуулах.

---xXx---

ХАВСРАЛТ 5

Цахим баримтын дотоод товъёог

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан

ХН дугаар		Он цагийн хязгаар	2020.05.29 – 2020.09.23

Хадгаламжийн нэгжийн гарчиг	“Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төсөл – Өмнөговь аймаг, Дорноговь аймаг, Өвөрхангай аймаг, Говь-Алтай аймаг, Ховд аймаг, Завхан аймаг, Улаанбаатар хотын шавь сургалтын баримтжуулалт.
Гэрэл зураг /pic/	95ш, 0.589GB
Дүрс бичлэг /video/	124ш, 09:47:05, 108.716GB
Аудио бичлэг /audio/	54ш, 02:43:36, 0.150GB

№	Баримтын төрөл, баримтжуулалт хийгдсэн газар	Дурсгалын нэр	Баримтжуулсан хүн, албан тушаал	Тоо ширхэг, хэмжээ, хугацаа	Огноо
1	Гэрэл зураг, Өмнөговь аймаг шавь сургалт	Лимбэчин Ө.Батжаргал шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	20ш, 0.132GB	2020.05.29
	Дүрс бичлэг, Өмнөговь аймаг шавь сургалт			31ш, 00:48:36, 17.15GB	
2	Дүрс бичлэг, Өмнөговь аймаг	Лимбэчин Ө.Батжаргалаас хүлээж авсан CD/DVD-г цахим файл болгосон	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	2ш, 00:21:06, 1.916GB	2020.06.08
	Аудио бичлэг, Өмнөговь аймаг			54ш, 02:43:36, 0.150GB	2020.06.22
3	Гэрэл зураг, Дорноговь аймаг шавь сургалт	Лимбэчин Б.Отгондүү шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	10ш, 0.047GB	2020.06.03
	Дүрс бичлэг, Дорноговь аймаг шавь сургалт			10ш, 00:50:42, 9.58GB	
4	Гэрэл зураг, Өвөрхангай аймаг шавь сургалт	Лимбэчин Н.Баярцэнгэл шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	8ш, 0.045GB	2020.06.26
	Дүрс бичлэг, Өвөрхангай аймаг шавь сургалт			6ш, 00:31:05, 5.78GB	
5	Гэрэл зураг, Говь-Алтай аймаг шавь сургалт	Лимбэчин Л.Жамбалдорж шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	3ш, 0.017GB	2020.06.27

	Дүрс бичлэг, Говь-Алтай аймаг шавь сургалт			10ш, 00:45:32, 8.55GB	
6	Гэрэл зураг, Ховд аймаг шавь сургалт	Лимбэчин Ч.Ваша шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	6ш, 0.019GB	2020.06.28 – 2020.06.29
	Дүрс бичлэг, Ховд аймаг шавь сургалт			5ш, 00:38:15, 6.89GB	
7	Гэрэл зураг, Завхан аймаг шавь сургалт	Лимбэчин Р.Эрдэнэлхагва шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	2ш, 0.007GB	2020.07.01
	Дүрс бичлэг, Завхан аймаг шавь сургалт			5ш, 00:49:34, 9.32GB	
8	Гэрэл зураг, орон нутаг	Лимбэний холбогдолтой гэрэл зураг, дүрс бичлэгүүд	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	8ш, 0.054GB	2020.06.29 – 2020.07.01
	Дүрс бичлэг, орон нутаг			18ш, 00:05:18, 1.10GB	
9	Дүрс бичлэг, Улаанбаатар хот лимбэчид	Лимбэчин Б.Оюунбат	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	5ш, 00:40:36, 7.3GB	2020.09.09
10	Дүрс бичлэг, Улаанбаатар хот шавь сургалт	Лимбэчин Ч.Даваажав шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	12ш, 00:35:44, 5.87GB	2020.09.10
11	Дүрс бичлэг, Улаанбаатар хот шавь сургалт	Лимбэчин Х.Цэнгэлсайхан шавь нарын хамт	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	4ш, 00:56:57, 9.12GB	2020.09.11
12	Гэрэл зураг, Улаанбаатар хот лимбэчид	Лимбэчин Д.Ганболд	Д.Мөнхбаатар, СӨҮТ, Дүрс бичлэгийн оператор	22ш, 0.180GB	2020.09.11
	Дүрс бичлэг, Улаанбаатар хот лимбэчид			10ш, 01:49:56, 17.54GB	

Дотоод товъёог хуудасны тоо:

_____

/тоо, үсгээр/

Дотоод товъёог үйлдсэн албан тушаалтан:

_____ гарын үсэг _____ гарын үсгийн тайлал

2020 он ..... сар ..... өдөр

ХАВСРАЛТ 6

Төсөл

МОНГОЛ АРДЫН УРТЫН ДУУ ЛИМБЭДЭХ УЛАМЖЛАЛТ АРГА-БИТҮҮ АМЬСГАА ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН АНХДУГААР УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Тайлбар: 2021 онд зохион байгуулагдах уралдааны удирдамжыг урьдчилсан байдлаар боловсруулж хүргүүлэв. Энэхүү удирдамж нь тус уралдааны эцсийн хувилбар биш болно.

Нийтлэг үндэслэл

Монгол улсын 1996 оны Соёлын тухай хууль, 2001 оны Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2011 онд Монгол улсаас хүн төрөлхтний яаралтай хамгаалах шаардлагатай биет бус соёлын өвд "Монгол ардын уртын дууг хөгжимдөх уламжлалт арга- битүү амьсгаа"- г албан ёсоор бүртгүүлсэн билээ. Энэхүү өв нь устаж үгүй болохоос хамгаалах, өв уламжлагчдыг тодруулах тэдгээрийн тоог нэмэгдүүлэх, судлах сурталчлах, цаашдын шат дараалсан авах арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авах зайлшгүй шаардлага бий болсон билээ.

Иймд 2019-2021 онд ЮНЕСКО-ийн санхүүжилтээр "Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь" төслийг хэрэгжүүлж үүний хүрээнд лимбэчдийн судалгаа, баримтжуулалт хийх, баримтат кино бүтээх, сургалтын танхим тохижуулах, сургалтын гарын авлага, DVD хичээл бэлтгэх, лимбэчид, лимбэдэх урлагийн тухай ном хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах болон Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Ховд, Сэлэнгэ, Хөвсгөл, Улаанбаатар хотод 10 өвлөн уламжлагч, сургагч багшийг түшиглэн 3 үе шаттай шавь сургалтыг явуулаад байна.

Уралдааны зорилго

"Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь" төслийн хэрэгжилт, үр дүнг олон нийтэд хүргэх, өв уламжлагчдын залуу халааг бэлтгэх, авьяас билэгтэй чадварлаг лимбэчдийг тодруулах, хөгжимдөх арга барил, ур чадварыг хөгжүүлэх, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, соёлын биет бус өвийг тогтворжуулахад оршино.

Уралдаанд оролцох журам

Уралдааныг өвлөн суралцагчид болон өвлөн уламжлагчид гэсэн хоёр ангилалаар зохион байгуулна. Уралдааны ангилал тус бүр 2 шаттай ба доорх бүтээлүүдийг хөгжимдөнө.

Уралдаанд оролцогчид

- Өвлөн суралцагчдын ангилалд "Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь" төслийн шавь сургалтаар суралцагчид,
- Өвлөн уламжлагчдын ангилалд тухайн өвийг өвлөн уламжилж байгаа лимбэчид хамрагдана.

Уралдааны хөтөлбөр:

ӨВЛӨН СУРАЛЦАГЧИД-ын тоглох хөтөлбөр

I шат

1. Монгол ардын бэсрэг уртын дуу а/ Хөөрхөн халиун
   б/ Цомбон туурайтай хүрэн
   в/ Нарийн сайхан хээр/сонгож тоглох/
2. Хувийн урын сан /уртын болон богино дуу өөрийн сонголтоор/

II шат

1. Монгол ардын бэсрэг уртын дуу а/Өнчин цагаан ботго
   б/Хүрэн толгойн сүүдэр
   в/ Эрдэнэ засгийн унага/сонгож тоглох/
2. Хувийн урын сан /уртын дуу өөрийн сонголтоор/

"ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИД"-ын тоглох хөтөлбөр

I шат.

1. Монгол ардын уртын дуу а/ Хоёр бор
   б/ Алтан богдын шил
   в/ Урьхан хонгор салхи/сонгож тоглох/
2. Хувийн урын сан /сонгосон уртын дууг уртын дууч, морин хуурчтай хамсран хөгжимдөнө/

II шат

1. Монгол ардын уртын дуу а/ Асрын өндөр
   б/ Дуртмал сайхан
   в/ Сэрүүн сайхан хангай/сонгож тоглох/
2. Хувийн урын сан /сонгосон уртын дууг хэн нэгэн өв уламжлагчийн арга барилаар хөгжимдөнө/

-oOo-

№1.2 ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

Гүйцэтгэлийн зорилт №1.2. “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Төлөвлөлтийн уялдаа:

1. Засгийн газрын 2019 оны 69 дугаар тогтоол “Чулуун соёлын өв”,
2. БСШУС-ын сайдын 2019 оны А/368 дугаар тушаал
3. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр баталсан “Соёлын өвийн үндэсний төвийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2015-2050”бичиг баримт.

Тэргүүлэх чиглэл 3. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ЧИГЛЭЛЭЭР. Стратегийн зорилт 3.3. Монгол Улсын байгаль, цаг агаарт тохиромжтой хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга зүй, аргачлал, технологи боловсруулах ажиллагааг эхлүүлэх;

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.1-р арга хэмжээ
“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.1.2, 2.1.4-д дурдсан дурсгалаас хэв, дардсыг авах, хуулбар хийж хадгалах.
Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.1.2, 2.1.4-д дурдсан дурсгалаас хэв, дардсыг авах, хуулбар хийж хадгалах арга хэмжээ хийгдээгүй болно.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.2-р арга хэмжээ
“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.2.1, 2.2.3, 2.2.7-д дурдсан дурсгалыг цэвэрлэж, бэхжүүлэх. (сэргээн засварлах)
Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 халдварт өвчнөөс үүдэн Улс, орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон Өвөрхангай аймгийн Хархорумын 1 дүгээр монгол бичээсийг сэргээн засварлах (хуулбараас сэргээх), Архангай аймгийн Тайхар чулууны бичээсийг цэвэрлэх, Өвөрхангай аймгийн Хархорумын мэлхий чулуудыг цэвэрлэх ажлын санхүүжилт шийдэгдээгүй, дээрх арга хэмжээ хэрэгжээгүй болно.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.3-р арга хэмжээ
“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 1.2.1, 1.2.4 дэх бүтээгдэхүүн баруун болон зүүн бүсийн соёлын өвийг бүртгэн бариматжуулах хээрийн судалгаа хийх.
Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд:
- Зүүн бүсийн 3 аймаг /Хэнтий, Дорнод, Сүхбаатар/, Баруун бүсийн 5 аймгийн / Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий/ нутаг дахь үл хөдлөх дурсгалуудын мэдээллийг “RICH-3” программаас шүүж нэгтгэн солбицлын жагсаалт бэлдсэн.
- Арга хэмжээ зохион байгуулах удирдамж, маршрут, үйл ажиллагаа, төсвийг боловсруулан “Чулуун дурсгалын бүртгэн баримтжуулалт” төслийг БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын зохицуулалтын газарт хүргүүлсэн болно /2020 оны 04 сарын 03-ны өдрийн 01/117 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн/.
Дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” халдварт өвчнөөс үүдэн улс, орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон санхүүжилтгүйн улмаас энэхүү ажил хийгдээгүй болно.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.3-р арга хэмжээ
Баруун болон Зүүн бүсийн соёлын өвийг бүртгэн баримтжуулах хээрийн судалгаа хийх, арга хэмжээ зохион байгуулах удирдамж, маршрут, үйл ажиллагаа, төсвийг боловсруулсан

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

“ЧУЛУУН ДУРСГАЛЫН БҮРТГЭН БАРИМТЖУУЛАЛТ”
(Баруун бүс)

“Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөр

Улаанбаатар хот
2020 он

ТӨСЛИЙН НЭР: “Чулуун дурсгалын бүртгэн баримтжуулалт” (Баруун бүс)

ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА: Соёл, Урлагийн газар
Соёлын өвийн үндэсний төв
ШУА-ийн Археологийн хүрээлэн

ТӨСӨЛД ХАМРАГДАХ ГАЗАР: Баруун бүс-Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудын нутагт орших буган хөшөө, хүн чулуу, хадны зураг.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2020 оны 5-11 дүгээр сар

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг баталсан ба түүх, соёл, шинжлэх ухаан, урлаг уран сайхны үнэ цэнэтэй ховор нандин хадны зураг, бичээс, буган ба хүн чулуун хөшөө, гэрэлт хөшөө зэргийг тусгайлан бүртгэн баримтжуулах зорилт тавьсан билээ.

“Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.2.1-т заасны дагуу 2020 онд Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ нутгийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах төслийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Чулуун соёлын өв нь хүн төрөлхтний хөгжлийн түүхийн тодорхой цаг үеийн гэрч болон үлдэж, хүмүүсийн нийгмийн байдал, оюуны соёлын түвшин, зан заншил, шашин шүтлэг болон ахуй амьдралын улирч мартагдсан түүхийг нэхэн сэргээж ойлгох гол эх сурвалж болдог, дэлхий нийтийн үнэ цэнэтэй дурсгал юм.

Хөтөлбөрийн хүрээнд чулуун дурсгалыг хамгаалахад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд санхүүгийн болон хүний нөөц, техник технологийн боломжид үндэслэн тодорхой дурсгалуудыг сонгон хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан арга зүйн дагуу гүйцэтгэх, дурсгалыг цаашид хэрхэн хамгаалах талаар хэтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, гадаад, дотоодод сурталчлах, уг хөтөлбөрт зориулсан программ хангамж, бүртгэл баримтжуулалт хийх зэрэг цогц арга хэмжээнүүд багтсан бөгөөд хамгийн түрүүнд хийх ажил нь дурсгалыг бүртгэн баримтжуулахад төслийн зорилго оршино.

Төслийн зорилт

Засгийн газрын 2019 оны 69, 280 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх үүднээс Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ба байгаль дээр оршин буй чулуун соёлын өвийн эх төрх, хийцийг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулах, мэдээллийн санд хадгалах, гэрэл зургийг ашиглаж дурсгалын эвдрэл гэмтэл, хадгалалтын талаарх мэдээллийг боловсруулан модуль үүсгэж, сэргээн засварлах, судлах, хамгаалах төлөвлөлтөд ашиглах боломжийг бүрдүүлэх;

- Сүйтгэсэн
- Будаж балласан
- Хугалсан
- Сийлсэн
- Зөөгдсөн
- Алга болсон
- Тос, сүүний бохирдолтой
- Буруу зассан
- Хадаг, бөс даавуу
- Дэд бүтцийн аюулд өртсөн зэрэг хүрээлэн буй орчны эрсдэлтэй орчинд хадгалагдаж байгаа зэрэгт эрсдэлийн түвшинг тодорхойлж мониторинг хийх.

Төслийн хүрээнд дараах арга зүйг хэрэгжүүлж ажиллана.

Орчин үеийн техник технологийн тусламжтай дурсгалын цахим баримтжуулалтыг хийж судалгаа шинжилгээ, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтанд ашиглах төрөл зүйлд гэрэл зураг, рентген зураглал, 3 хэмжээст цахим баримтжуулалт, дүрс бичлэг, СТ скан зураглал гэх мэт арга зүйгээр дурсгалын механик гэмтэл, биологийн гэмтэл, хими, физик гэмтэл, хүрээлэн буй орчны ажиглалт, эрсдэл, хадгалалтын түвшинг тодорхойлох бүрэн боломжтой байдаг. Энэхүү төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх баримтжуулалтын арга зүйд гэрэл зураг, дүрс бичлэгийн баримтжуулалт хийж гэрэл зургийг ашиглаж дурсгалын анхан шатны эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчны эрсдэл, хадгалалтын талаарх мэдээллийг боловсруулан модул үүсгэж, сэргээн засварлах, судлах, хамгаалах төлөвлөлтөд ашиглах боломжийг бүрдүүлэх.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөлт

Зорилтот ажил 2020 он	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1.Төслийн багийн хурал (төлөвлөгөөт ажлын зорилго, чиглэлийг тодорхойлох)												
2. Гэрэл зургийн сургалт, техниктэй ажиллах зааварчилгаа												
3.Баруун бүсэд ажиллах 1-р баг												
4.Баруун бүсэд ажиллах 2-р баг												
5. Хээрийн судалгааны ангийн тайлан боловсруулж дуусах												

Төслийн үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан улсын хамгаалалтадбайх түүх, соёлын үл хөдлөх 182 дурсгал, аймгийн хамгаалалтын урьдчилсан жагсаалтаар 285 дурсгалынжагсаалтыг баримтална.

“Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөрийн бүртгэн баримтжуулалтын 2020 оны ажлын хүрээндбаруун бүсийн 5 аймаг болох Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгийн нутагт орших улсын хамгаалалтын 37, аймгийн хамгаалалтын байх 38 дурсгал, 2015 онд зохион байгуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын хүрээнд бүртгэгдсэн зарим дурсгалуудыг (45)хамруулахаар төлөвлөсөн болно.

Баруун бүсийн 5 аймагт хээрийн бүртгэлийн 2 баг ажиллана. Үүнд:

1-р баг Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгийн нутагт буй буган хөшөө, хүн чулуу, хадны зургийн дурсгал, 2-р баг Завхан, Увс аймгийн нутаг дахь буган хөшөө, хүн чулуу, хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулахаар маршрут, километрыг тооцов (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү).

“Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх хээрийн шинжилгээний ажлын зардлын тооцоо

2020 онд Баруун бүс нутгийн Баян-Өлгий, Ховд, Завхан, Увс, Говь-Алтай аймагт ажиллах хээрийн судалгааны багийн зардлын төсвийг 2 багт хуваан дараах байдлаар тооцож байна.

Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн нутаг дахь дурсгалууд

Хавсралт 1.

Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн нутаг дахь дурсгалууд

№	Аймаг	Сум	Газрын нэр	Газарзүйн	байршил
1	Баян-Өлгий	Баяннуур	Цагаан Хөшөөтийн хүн чулуу	N48° 52' 30.0"	E90° 38' 55.0"
2	Баян-Өлгий	Бугат	Эрээн Харганатын хөшөө	N48° 55' 49.6"	E90° 08' 58.4"
3	Баян-Өлгий	Буянт	Хөлцөөтийн хадны зураг	N48° 35' 46.0"	E89° 16' 23.0"
4	Баян-Өлгий	Ногооннуур	Сумын төвийн хүн чулуу	N49° 30' 49.3"	E90° 20' 44.9"
5	Баян-Өлгий	Ногооннуур	Ямаат Улаан уулын хүн чулуу	N49° 40' 29.1"	E90° 17' 9.6"
6	Баян-Өлгий	Сагсай	Даяннуур орчмын хүн чулуу	N48° 16' 04.0"	E88° 52' 58.0"
7	Баян-Өлгий	Улаанхус	Бага Ойгорын хадны зураг	N49° 20' 01.0"	E89° 09' 47.0"
8	Баян-Өлгий	Улаанхус	Хар ямаатын голын хүн чулуу	N49° 09' 58.0"	E89° 18' 15.0"
9	Баян-Өлгий	Цэнгэл	Арал толгойн хадны зураг	N48° 44' 18.0"	E88° 9' 1.000"
10	Баян-Өлгий	Цэнгэл	Билүүтийн хадны зураг	N49° 6' 17.2"	E88° 15' 59.6"
11	Баян-Өлгий	Цэнгэл	Могойтын рашааны хүн чулуу	N48° 43' 56.0"	E88° 34' 16.0"
12	Баян-Өлгий	Цэнгэл	Цагаан голын цогцолбор дурсгал	N49° 5' 55.000"	E88° 15' 36.000"
13	Баян-Өлгий	Цэнгэл	Шивээт Хайрханы хадны зураг	N48° 46' 49.700"	E88° 33' 28.800"
14	Баян-Өлгий	Алтанцөгц	Олон нуурын Алаг үзүүрийн хүн чулуу		
15	Баян-Өлгий	Булган	Ёлт голын буган хөшөөд	N47 6 33	E91 8 50
16	Баян-Өлгий	Сагсай	Битүүгийн хүн чулуу	N48 49 48	E89 31 35
17	Баян-Өлгий	Сагсай	Цагаан асгын буган хөшөөд	N48° 30' 57.245"	E88° 54' 15.235"
18	Баян-Өлгий	Цэнгэл	Их Хатуугийн голын буган хөшөө		
19	Баян-Өлгий	Улаанхус	Хар ямаатын голын хадны зураг	N49 20 1	E89 9 47
20	Баян-Өлгий	Алтанцөгц	Бэлчирийн хөх хад		
21	Говь-Алтай	Бигэр	Бичигтийн бууцны хадны зураг, бичээс	N45° 31' 58.000"	E97° 4' 28.000"
22	Говь-Алтай	Жаргалан	Сүмийн дэнжийн цогцолбор дурсгал	N46° 51' 27.700"	E95° 47' 52.500"
23	Говь-Алтай	Жаргалан	Тоосготын хүн чулуун хөшөө	N46° 52' 27.000"	E95° 44' 39.800"
24	Говь-Алтай	Тонхил	Шататын бэлчирийн цогцолбор дурсгал	N45° 48' 56.000"	E93° 38' 5.000"
25	Говь-Алтай	Халиун	Цагаан голын хадны зураг	N46° 0' 7.020"	E96° 15' 28.020"
26	Говь-Алтай	Баян-Уул	Бага бэрх, Доогийн бууцны хадны зураг	N47° 14' 9.383"	E94° 54' 27.994"
27	Говь-Алтай	Баян-Уул	Их бэрх уулын хадны зураг	N47° 14' 43.600"	E94° 55' 6.000"
28	Говь-Алтай	Бигэр	Морин толгойн хадны зураг	N45° 34' 45.000"	E97° 6' 20.000"
29	Говь-Алтай	Бугат	Тамчийн бэлчирийн буган хөшөө, хүн чулууны цогцолбор дурсгал	N45° 41' 1.600"	E93° 59' 30.200"

30	Говь-Алтай	Тонхил	Зүйлийн Огтрогын хүн чулуу	N46° 27' 34.000"	E93° 45' 50.000"
31	Говь-Алтай	Тонхил	Улаан нурууны оцонгийн буган хөшөөд	N46° 21' 6.100"	E93° 37' 53.400"
32	Говь-Алтай	Тонхил	Хяр хараачийн хөшөө чулуу	N45° 56' 46.000"	E93° 56' 20.000"
33	Говь-Алтай	Чандмань	Шаахар толгойн хадны зураг	N45 25 39.2	E97 33 18
34	Говь-Алтай	Тайшир	Давиртын бууцны хадны зураг	N45 51 0	E96 29 27
35	Говь-Алтай	Жаргалан	Зурагт хадны зураг	N46 51 32.7	E95 53 29
36	Говь-Алтай	Есөнбулаг	Баянгийн амны хүн чулуу	N46 19 11.0	E96 04 30.1
37	Говь-Алтай	Эрдэнэ	Оройн түймэртийн хадны зураг		
38	Говь-Алтай	Шарга	Хөх өрцийн голын хүн чулуу	N46 37 46.7	E95 46 24.8
39	Говь-Алтай	Халиун	Цагаан голын хөтлийн хүн чулуу	N45 47 30.9	E96 03 12.6
40	Говь-Алтай	Цогт	Дээлтийн хадны зураг	N45 28 59.4	E96 18 44
41	Ховд	Манхан	Гурван цэнхэрийн агуйн хадны зураг	N47° 20' 17.820"	E91° 54' 50.820"
42	Ховд	Манхан	Ишгэн толгойн хадны зураг	N47° 28' 11.900"	E92° 13' 6.600"
43	Ховд	Мөнххайрхан	Улаан толгойн бичээс	N47° 0' 58.700"	E91° 30' 18.500"
44	Ховд	Мөст	Баянзүрхийн цогцолбор дурсгал	N46° 36' 49.100"	E92° 16' 29.900"
45	Ховд	Алтай	Ямаан усны хадны зураг	N46° 1' 23.700"	E92° 20' 3.300"
46	Ховд	Ховд	Сөртийн хөшөө чулуу	N48° 4' 14.300"	E91° 21' 58.300"
47	Ховд	Цэцэг	Халиуны хөтлийн хүн чулуун хөшөө	N46° 13' 31.030"	E92° 59' 49.400"
48	Ховд	Эрдэнэбүрэн	Цамбагаравын хадны зураг	N48° 31' 53.340"	E91° 5' 2.160"
49	Ховд	Буянт	Чандмань хар үзүүрийн хадны зураг	N48 9 29.7	E91 45 18.1
50	Ховд	Дарви	Жүргэрийн цагаан толгойн руни бичээс	N47 3 30.1	E93 18 1.9
51	Ховд	Дарви	Чулуутын огторгын буган хөшөө		
52	Ховд	Манхан	Нүхэн өтгийн хадны зураг	N47 22 16.4	E91 56 41.7
53	Ховд	Мөнххайрхан	Дээд улаан говийн аманд орших буган хөшөөд	N46 52 26.08	E91 59 12.4
54	Ховд	Мөнххайрхан	Улаан говийн амны хүн чулуу	N47 2 1.4	E91 51 8.7
55	Ховд	Мөнххайрхан	Шуурхайн хөх нуурын хүн чулуу	N46 55 36.7	E91 44 24.9
56	Ховд	Мөнххайрхан	Тэлэнгэдийн амны буган хөшөө	N47 0 25.5	E91 51 15.2
57	Ховд	Ховд	Торх улаан уулын хүн чулуу	N48 19 12.9	E91 45 14.4
58	Ховд	Алтай	Цагийн манааны толгойн хадны зураг	N46 24 53.3	E91 0 0.4
59	Ховд	Булган	Зурагтын хадны зураг	N46 24 27.8	E91 22 33.6
60	Ховд	Үенч	Баян салаагийн амны хүн чулуу	N46 21 24.4	E91 41 31.2

Эхлэх: Говь-Алтай–Чандмань- Шаахар толгойн хадны зураг-39.3км - Морин толгойн хадны зураг-5.7 км - Бичигтийн бууцны хадны зураг, бичээс-60.2 км - Дээлтийн хадны зураг-40.0 км - Цагаан голын хөтлийн хүн чулуу-34.8 км - Давиртын бууцны хадны зураг-24.9 км - Цагаан голын хадны зураг-38.3 км - Баянгийн амны хүн чулуу-41.7 км - Хөх өрцийн голын хүн чулуу-27.2 км - Зурагт хадны зураг-7.2 км - Сүмийн дэнжийн цогцолбор дурсгал-4.5 км - Тоосготын хүн чулуун хөшөө-75.5 км - Их бэрх уулын хадны зураг-1.3 км - Бага бэрх, Доогийн бууцны хадны зураг-123.9 км - Жүргэрийн цагаан толгойн руни бичээс-75.6 км - Зүйлийн Огтрогын хүн чулуу-15.8 км - Улаан нурууны оцонгийн буган хөшөөд-51.1 км - Хяр хараачийн хөшөө чулуу-29.5 км - Тамчийн бэлчирийн буган хөшөө, хүн чулууны цогцолбор дурсгал-31.5 км - Шататын бэлчирийн цогцолбор дурсгал-67.3 км –Ховд аймаг Халиуны хөтлийн хүн чулуун хөшөө-56.0 км - Ямаан усны хадны зураг-65.9 км - Баянзүрхийн цогцолбор дурсгал-53.2 км -Баян салаагийн амны хүн чулуу-25.0 км - Зурагтын хадны зураг-28.9 км - Цагийн манааны толгойн хадны зураг-91.3 км - Дээд улаан говийн аманд орших буган хөшөөд-19.7 км - Шуурхайн хөх нуурын хүн чулуу-12.5 км - Тэлэнгэдийн амны буган хөшөө-3.0 км - Улаан говийн амны хүн чулуу-26.5 км - Улаан толгойн бичээс-29.1 км - Ёлт голын буган хөшөөд-63.5 км - Гурван цэнхэрийн агуйн хадны зураг-4.3 км - Нүхэн өтгийн хадны зураг-23.4 км - Ишгэн толгойн хадны зураг-92.5 км - Сөртийн хөшөө чулуу-30.6 км - Чандмань хар үзүүрийн хадны зураг-18.0 км - Торх улаан уулын хүн чулуу-54.9 км - Цамбагаравын хадны зураг-49.9 км–Баян-Өлгий аймаг Цагаан Хөшөөтийн хүн чулуу-37.1 км - Эрээн Харганатын хөшөө-47.1 км - Битүүгийн хүн чулуу-32.0 км - Хөлцөөтийн хадны зураг-46.5 км - Даяннуур орчмын хүн чулуу-27.6 км - Цагаан асгын буган хөшөөд-34.4 км - Могойтын рашааны хүн чулуу-5.5 км - Шивээт Хайрханы хадны зураг-30.3 км - Арал толгойн хадны зураг-40.9 км - Цагаан голын цогцолбор дурсгал-0.8 км - Билүүтийн хадны зураг-70.1 км - Хар ямаатын голын хадны зураг-21.3 км - Бага Ойгорын хадны зураг-21.3 км - Хар ямаатын голын хүн чулуу-85.0 км - Сумын төвийн хүн чулуу-18.4 км - Ямаат Улаан уулын хүн чулуу- Олон нуурын Алаг үзүүрийн хүн чулууд- Их Хатуугийн голын буган хөшөө- Бэлчирийн хөх хад- Оройн түймэртийн хадны зураг- Чулуутын огторгын буган хөшөө зэрэг дурсгалуудыг бүртгэн, баримтжуулна.

Хавсралт

Увс, Завхан аймгийн нутаг дахь дурсгалууд

№	Аймаг	Сум	Газрын нэр	Газарзүйн	байршил
1	Завхан	Алдархаан	Мөнгөт хясааны хүн чулуун хөшөө	N47° 52' 6.900"	E96° 44' 13.0"
2	Завхан	Баянтэс	Хөх хошууны боом	N49° 44' 27.000"	E96° 45' 27.0"
3	Завхан	Цэцэн-Уул	Янживын шилийн хүн чулуун хөшөөд	N48° 37' 18.900"	E95° 41' 45.0"
4	Завхан	Шилүүстэй	Дааган дэлийн цогцолбор дурсгал	N47° 13' 43.700"	E97° 9' 51.0"
5	Завхан	Яруу	Хөшөөтийн амны хүн чулуу	N48° 12' 17.000"	E96° 43' 34.2"
6	Завхан	Яруу	Яруугийн голын хүн чулуу	N48° 4' 33.800"	E96° 45' 25.4"
7	Завхан	Баянтэс	Их Бэрх уулын зосон зураг	N49° 43' 36.600"	E95° 55' 30.7"
8	Завхан	Баянхайрхан	Урт булагийн дөрөлжийн хүн чулууд	N49° 15' 42.400"	E96° 7' 56.800
9	Завхан	Идэр	Ар дугуйтын буган хөшөөд	N48° 36' 29.900"	E97° 19' 11.4"
10	Завхан	Немрег	Ялаат нуурын буган хөшөө	N48° 53' 21.000"	E96° 18' 32.0"
11	Завхан	Сантмаргац	Буга Согоотын хадны зураг	N48° 38' 28.300"	E95° 20' 3.000
12	Завхан	Тэлмэн	Дунд шургахын амны буган хөшөөд	N48° 33' 14.200"	E97° 18' 31.6"
13	Завхан	Тэлмэн	Дээд шумуултайн буган хөшөөд	N48° 53' 15.600"	E97° 53' 8.200
14	Завхан	Цагаанчулуут	Хяларын өвөлжөөний хадны зураг	N46° 56' 55.100"	E96° 30' 54.0"
15	Завхан	Дөрвөлжин	Бор овооны хадны зураг	N47 48 51.3	E94 50 19
16	Завхан	Тэс	Овгорын хадны зураг	N49 30 35.6	E95 32 39.9
17	Завхан	Сонгино	Сонгино хайрхан уулын өврийн хадны зураг	N48 49 6.9	E95 33 52.1
18	Завхан	Тосонцэнгэл	Дааган дэлийн хадны зураг	N48 54 14.4	E98 10 46.3
19	Завхан	Түдэвтэй	Хар чулуутын хадны зураг	N49 2 42.3	E96 33 46.1
20	Завхан	Тэлмэн	Дунд шургахын хаалгатын хадны зураг	N48 33 14.2	E97 18 31.6
21	Завхан	Тэс	Овгорын хадны зураг	N49 29 32.4	E95 52 23.4
22	Завхан	Ургамал	Соёо цахирын хадны зураг	N48 23 24.4	E94 29 22
23	Завхан	Их-Уул	Зулзагын амны буган хөшөө		
24	Завхан	Шилүүстэй	Дөрвөлжин уулын хадны зураг	N46 33 54.5	E96 57 21.7
25	Завхан	Эрдэнэхайрхан	Бага хөлийн хадны зураг	N48 10 20.2	E95 46 4.9
26	Завхан	Яруу	Нил хадны зураг	N48 1 37.1	E96 31 43
27	Завхан	Идэр	Доод ногооны амны буган хөшөөд	N48 36 29.9	E97 19 11.4
28	Завхан	Немрег	Ар гозгорын буган хөшөө	N:493621,8	E:982110,2
29	Завхан	Тэс	Тосгоны өврийн буган хөшөө	N49 30 6.9	E95 37 5

31	Увс	Давст	Бор нурганы хүн чулуу	N50° 36' 37.900"	E92° 27' 57.1"
32	Увс	Зүүнхангай	Зураагийн улаан хадны зураг	N49° 23' 21.900"	E95° 25' 52.5"
33	Увс	Сагил	Дунд Турагийн хад үзүүрийн хадны зураг	N50° 33' 8.500"	E91° 30' 38.0"
34	Увс	Сагил	Можоогийн хадны зураг	N50° 12' 34.900"	E90° 34' 59.6"
35	Увс	Тариалан	Халхайтын дэнжийн цогцолбор дурсгал	N49° 43' 41.050"	E91° 42' 37.0"
36	Увс	Бөхмөрөн	Баадайн амны буган хөшөөд	N49° 39' 56.800"	E90° 17' 24.3"
37	Увс	Зүүнговь	Баяннуурын дурсгалт газар	N49° 18' 10.700"	E95° 18' 8.7"
38	Увс	Малчин	Хөтөл нуурын Бор толгойн хүн чулууд	N48° 56' 25.000"	E91° 38' 20.0"
39	Увс	Наранбулаг	Жаажаагийн хөтөлийн хүн чулууд	N92 875645	E49 706532
40	Увс	Өмнөговь	Хагийн улаан толгойн буган хөшөө ашиглан хийсэн түрэгийн үеийн тахилын байгууламж	N48° 54' 35.000"	E91° 47' 2.000"
41	Увс	Өмнөговь	Шарбулагийн онцын хадны зураг	N48° 59' 11.000"	E91° 44' 9.0"
42	Увс	Өндөрхангай	Чигжийн голын хүн чулуу, буган хөшөө бүхий дурсгал	N49° 12' 57.000"	E94° 50' 35.0"
43	Увс	Сагил	Ихсарын хадны зураг	N50° 10' 38.900"	E90° 47' 55.8"
44	Увс	Наранбулаг	Зурагт хадны зураг	N49 50 45	E91 37 59
45	Увс	Өмнөговь	Хүрэн үзүүр хадны зураг	N48 58 31	E91 44 41
46	Увс	Өндөрхангай	Чулуун хашаатын хадны зураг	N49 11 00.0	E94 44 03.0
47	Увс	Сагил	Бургастайн хөндийн хадны зураг	N50 32 46	E91 30 10.5
48	Увс	Түргэн	Байрамын дабааны хүн чулууд	N50 00 29.3	E091 02 55.9
49	Увс	Цагаанхайрхан	Хөшөөтийн хүн чулуу	N94 302621	E49 597528
50	Увс	Хяргас	Нийчийн амны хүн чулуу	N93 685819	E49 483231
51	Увс	Бөхмөрөн	Харзайн тохойн хүн чулуу	N90 262103	E49 940033
52	Увс	Бөхмөрөн	Хужиртын хүн чулуу	N90 795464	E49 876761
53	Увс	Зүүнхангай	Хүрдлэгийн амны хүн чулуу	N95 202692	E49 305467
54	Увс	Зүүнхангай	Хошуулт, Цэцэрлэгийн бэлчирийн хүн чулуу	N95 269433	E49 546503
55	Увс	Улаангом	Зүүн хоолын хөтлийн хадны зураг	N50 33 59	E92 5 41
56	Увс	Сагил	Хад үзүүрийн хадны зураг	N49 46 16	E93 14 37
57	Увс	Баруунтуруун	Хар цагаан усны хадны зураг	N49 35 58	E95 3 5
58	Увс	Баруунтуруун	Баруун туруун голын хиймэл нуурын буган хөшөө		
59	Увс	Зүүнхангай	Хар усны голын адгийн буган хөшөө	N49 18 10.7	E95 18 8.7
60	Увс	Түргэн	Хар толгойн буган хөшөө	N49 55 9.8	E91 23 28.9


Эхлэх: Завхан –Тосонцэнгэл-Дааган дэлийн хадны зураг-21.6 км -Дээд шумуултайн буган хөшөөд-51.9 км -Ар дугуйтын буган хөшөөд-6.1 км -Доод ногооны амны буган хөшөөд-8 км -Дунд шургахын амны буган хөшөөд-58 км -Дунд шургахын хаалгатын хадны зураг-60 км -Хөшөөтийн амны хүн чулуу-14.4 км -Яруугийн голын хүн чулуу-17.8 км -Нил хадны зураг-23.5 км -Мөнгөт хясааны хүн чулуун хөшөө-92.9 км -Буянтын буган хөшөө-80 км -Дааган дэлийн цогцолбор дурсгал-75.5 км -Дөрвөлжин уулын хадны зураг-54.3 км -Хяларын өвөлжөөний хадны зураг-159 км -Бор овооны хадны зураг-79.9 км -Бага хөлийн хадны зураг-99 км -Соёо цахирын хадны зураг-68.3 км -Буга Согоотын хадны зураг-26.7 км -Янживын шилийн хүн чулуун хөшөөд-23.9 км -Сонгино хайрхан уулын өврийн хадны зураг-55.1 км -Ялаат нуурын буган хөшөө-25.4 км -Хар чулуутын хадны зураг-39.5 км-Урт булагийн дөрөлжийн хүн чулууд-70 км -Хөх хошууны боом-60 км -Их Бэрх уулын зосон зураг-26.3 км -Овгорын хадны зураг-18.5 км -Тосгоны өврийн буган хөшөө-5.4 км -Овгорын хадны зураг-15.7 км -Зураагийн улаан хадны зураг-13.4 км -Баяннуурын дурсгалт газар-7.2 км -Хар усны голын адгийн буган хөшөө-8 км -Хүрдлэгийн амны хүн чулуу-28 км -Чигжийн голын хүн чулуу, буган хөшөө бүхий дурсгал-8.7 км -Чулуун хашаатын хадны зураг-217 км -Хагийн улаан толгойн буган хөшөө ашиглан хийсэн түрэгийн үеийн тахилын байгууламж-11.1 км -Хөтөл нуурын Бор толгойн хүн чулууд-8.6 км -Хүрэн үзүүр хадны зураг-1.3 км -Шарбулагийн онцын хадны зураг-82.4 км -Халхайтын дэнжийн цогцолбор дурсгал-14.2 км -Зурагт хадны зураг-19.1 км -Хар толгойн буган хөшөө-26.4 км -Байрамын дабааны хүн чулууд-23.3 км -Хужиртын хүн чулуу-43.3 км -Баадайн амны буган хөшөөд-30.5 км-Харзайн тохойн хүн чулуу-37.7 км -Можоогийн хадны зураг-15.8 км -Ихсарын хадны зураг-64.7 км -Бургастайн хөндийн хадны зураг-10 км -Дунд Турагийн хад үзүүрийн хадны зураг-41.4 км -Зүүн хоолын хөтлийн хадны зураг-26.7 км -Бор нурганы хүн чулуу-104 км -Жаажаагийн хөтөлийн хүн чулууд-27.4 км -Хад үзүүрийн хадны зураг-45.2 км -Нийчийн амны хүн чулуу-46.4 км -Хөшөөтийн хүн чулуу-54.1 км -Хар цагаан усны хадны зураг-16.8 км -Хошуулт, Цэцэрлэгийн бэлчирийн хүн чулуу -Зулзагын амны буган хөшөө -Баруун туруун голын хиймэл нуурын буган хөшөө -Ар гозгорын буган хөшөө зэрэг дурсгалуудыг бүртгэн, баримтжуулна.


Хүлээгдэж буй үр дүн:

Төслийн хүрээнд доорх үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Чулуун соёлын өвийг сурталчлах зорилтын хүрээнд ном, бүтээл хэвлүүлэхэд ашиглагдах дүрс бичлэг, гэрэл зураг зэрэг судалгаа, сурталчилгааны хэрэглэгдэхүүн бий болно.
- Чулуун соёлын өвдзориулсан тусгай программд оруулснаар байршлын солбицол, эвдрэл гэмтлийн мэдээлэл, дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс бүхий мэдээллийн санг бүрдүүлнэ.
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтад сөргөөр нөлөөлж буй байгаль, нийгмийн бодит хүчин зүйлсийг энэ ажлын хүрээнд тогтооно.
- Дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг олон улсын үнэлгээ хийхэд ашигладаг арга зүйн дагуу тухайн эрсдлийн дурсгалд тохиолдох цаг хугацаа, эрсдэлээс учрах эвдрэл гэмтлийн хувь хэмжээнээс үүдэн гарах тухайн соёлын өв, дурсгалын үнэ цэнийн алдагдлын хэмжээг дурсгалын төрөл тус бүр дээр тооцож эрсдлийн хэмжигдэхүүн, төвшин, эрэмблэх зэрэг ажлыг хийнэ.

Цаашид бүс нутагт оршин буй дурсгалын ангилал, төрөл зүйл, материал зэргийг төрөлжүүлж, нарийвчилсан судалгааг хийх эрэлт хэрэгцээ шаардлагатай хэмээн үзэж байна.


Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөрийн
хүрээнд 2020 онд ажиллах баруун
бүсэд орших дурсгал 1-р багийн маршрут
Масштаб 1:2 300 000
260 километр
130
65
0
Тэмдэг тэмдэг
Аймгийн төв
Сумын төв
Дурсгалт газар
Маршрут
Улсын хил
Гол
N


Чулуун соёлын ев үндэсний хөтөлбөрийн
хүрээнд 2020 онд ажиллах бүсэд орших дурсгал 2-р багийн маршрут
Масштаб 1:1 900 000
Тэмдэг тэмдэг
Айлгийн тов
Сумын тов
Дурсгалт газар
Маршрут
Гол
Улсын хил
0
55
110
220 километр

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.4-р арга хэмжээ

“ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРАГ БҮХИЙ ЦОГЦОЛБОРЫН КАДАСТРЫН ХЭМЖИЛТ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоол “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/368 дугаар тушаалаар “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/368 дугаар тушаалаар батлагдсан “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 1.3.2. Дэл уулын хадны зураг бүхий цогцолборыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2020 онд хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

Дэл уул нь Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутагт, сумын төвөөс баруун урд зүгт 80 км орчим зайд орших бөгөөд өргөргийн дагуу 30-аад км сунасан хар хүрэн, улаан хүрэн өнгийн босоо хуудаслаг чулуун гадаргуу бүхий намхан уул юм. Уулын гадаргуу эгнэсэн олон дэл мэт урт урт толгодоос бүрддэг тул эртнээс “Дэл” хэмээн нэрлэгдсээр иржээ. Дэл уул нь хадны зургаар нэн баялгийн зэрэгцээ руни, монгол, түвд, хятад бичээс, дөрвөлжин булш, зэл чулуу, хийдийн туурь зэрэг хэдэн төрлийн дурсгалууд оршдог. Дэл уулын хадны зураг тархалтын хувьд жигд хэдий ч дотор нь Баруун, Зүүн билүүн, Хамар ус, Элст хөтөл, Гучин хоёр хүнт, Өлзийтийн хуудас хэмээн бүлэглэж болно. Эндэхийн хадны зургийн дийлэнх хэсгийг нийт талбайгаар нь хонхойлон сийлж урласан зургууд эзлэх бөгөөд дүрслэлийн хувьд ан ав, нүүдэл суудал, дайн тулаан, шүтлэг бишрэл, үржил зэргийг харуулах араатан, жигүүртэн, тэрэг, гэр сууц, зэр зэвсэг, тамга тэмдэг, хүн, түүний үйл хөдлөл гэх мэт дүрслэлүүд зонхилдог. Энэхүү хадны зургийн агуулга, зохиомж, дүрслэлийн сэдэвт Монгол болон түүний хөрш зэргэлдээ орны хад чулуун дээр хадгалагдан үлдсэн хадны зургуудад нийтлэг байдаг дүрслэлтэй адил байгаа нь он цагийн хувьд эдгээр зургуудыг хүрэл зэвсгийн үе буюу МЭӨ III-I мянган жилээс төмөр зэвсгийн түрүү үед холбогдуулан үзэх баримжаа болох юм. Түүнчлэн Дэл уулын хадны зураг дотор хүрэл, төмрийн түрүү үеийн хадны зургуудаас гадна хүннү, түрэг, уйгурын үед холбогдуулж үзэж болох хадны зураасан зургууд байдгийг дурдах хэрэгтэй. Мөн “Гучин хоёр хүнт” хэмээх газар орших хөшөө бүхий дөрвөлжин булшны хашлага дээр ямар нэгэн зан үйл гүйцэтгэж буй бололтой ар араасаа цуварсан, гэзэг үсийг тод харуулсан олон хүн болон буга, согоо, тоодог шувуу зэргийг дүрслэн сийлсэн байдаг нь энэ төрлийн дурсгалд түгээмэл бус тохиолддог сонирхолтой дүрслэл юм. Тэрчлэн Дэл ууланд эртний түрэгийн үед хамаарах хэд хэдэн руни бичээс, нт 640-оод оны үед бичигдсэн ханз, монгол, түвд зэрэг бичгийн дурсгалууд бий.

Бэлтгэл ажил. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу 2020 оны 2 дугаар сард ажлын хэсгийг байгуулах мэдээлэл солилцох үүднээс Дундговь аймгийн засаг даргын тамгын газарт албан бичиг илгээн орон нутгаас ажиллах бүрдэхүүнд орох албан хаагчдын нэрсийг авсан болно (хавсралт 1, 2).

Мөн цогцолбор газрын Дэл уул орчмын дурсгалт газрыг ямар хэмжээгээр хамгаалалтын бүс тогтоож, кадастрын хэмжил хийлгэх талаар “Дэл уулын гайхамшиг” ТББ-ийн тэргүүн Б.Батмөнхтэй уулзаж хэмжилт хийх эхний байдлаар буюу кадастрын бүртгэлд оруулах саналын бэлтгэл ажлын хүрээнд Дэл уулыг тойрсон урьдчилсан 25 цэг төлөвлөн хээрийн хэмжилтийн ажилд гарсан (газрын зураг 1).

Хээрийн судалгаа. Соёлын өвийн үндэсний төв, Дундговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн музейгээс хамтарсан хээрийн судалгааны баг Дэл уул орчмын хадны зураг бүхий цогцолборын кадастрын хэмжилт хийх, улсын газрын удирдлагын нэгдсэн санд бүртгүүлэх ажлын бэлтгэлийг хангах, улсын аймгийн хамгаалалтад байх дурсгалт газруудын байршлын мэдээллийг баталгаажуулахад тус хээрийн судалгааны ажлын үндсэн зорилго оршиж байв. Хээрийн судалгааны баг 2020

оны 7 дугаар сарын 29-нөөс 8 дугаар сарын 5-ны өдөр хүртэх хугацаанд Г.Анхсанаа (СӨҮТ-ийн Авран хамгаалах газрын дарга), С.Баасандорж (СӨҮТ-ийн Авран хамгаалах газрын газар зүйн мэдээллийн инженер), П.Чинбат (СӨҮТ-ийн Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газрын мэргэжилтэн), Д.Шижир (СӨҮТ-ийн жолооч), Б.Шинэбаяр (Дундговь аймгийн БСУГ-ын Соёлын өв хариуцсан мэргэжилтэн), Г.Доржсүрэн (Дундговь аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан), болон “Дэл уулын гайхамшиг” ТББ-ийн тэргүүн Б.Батмөнх, Өлзийт сумын Байгаль хамгаалагч Б.Бадрах нар ажиллав (гэрэл зураг 1).

Газрын цэгийг тодорхойлохын тулд энгийн хэрэглээний Garmen Etrix 20 маркийн гар GPS ашиглалаа. Гар GPS-ын хувьд WGS-84 газарзүйн координатын систем ашиглан нийтлэг хэрэглэгддэг градус минут секундийн утгаар авсан. Дэл уулыг тойрон хэмжилт хийх явцад Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн систем бүртгэгдсэн уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудаас гаргах, айлын бууц өвөлжөөг оруулахгүйгээр хэмжилт хийлээ.

Дэл уулын хээрийн ажлын бэлтгэл ажлын хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийг зурагласан 1:100000 масштабтай L48-127, L48-128 L48-129 планшейттай байр зүйн зураг, Ландсат-8 хиймэл дагуулын багана-131 мөр-29 замналтай 2018 оны 7 сарын 21-ний сансрын зургийн 7, 5, 3-р сувгийн хольц ашиглан Дэл уулын ойр орчмыг тодруулан газрын гадарга, объект, худаг усны мэдээллийг гарган авч ашиглав.

Хэмжилтийн үр дүнд урьдчилсан байдлаар 20 газрын хэмжилтийн цэг (хүснэгт 1), 44153.6 га талбайг хамарсан. Хээрийн ажил дууссаны дараа боловсруулалт хийж талбайн хэмжээ, бусад газрын мэдээлэл буюу Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн систем бүртгэгдсэн уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудтай давхардуулж үзэхэд шинээр гурван уул уурхайн хайгуулын талбай өртөж байна (газрын зураг 2).

Хүснэгт 1.

№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Өндөр (ДТД)	N	E
1	Дэл уул 1-р цэг	Хөтөл ус	1353	44° 28' 13.015" N	105° 38' 17.214" E
2	Дэл уул 2-р цэг	Хонгор зоо 1	1366	44° 28' 35.591" N	105° 41' 14.136" E
3	Дэл уул 3-р цэг	Хонгор зоо 2	1408	44° 28' 33.391" N	105° 44' 23.629" E
4	Дэл уул 4-р цэг	Шар хунгас	1392	44° 29' 36.229" N	105° 45' 8.788" E
5	Дэл уул 5-р цэг	Бурхант	1326	44° 31' 31.487" N	105° 47' 27.064" E
6	Дэл уул 6-р цэг	Болдын ам	1292	44° 31' 45.800" N	105° 49' 59.718" E
7	Дэл уул 7-р цэг	Хөх өндөр	1260	44° 30' 26.986" N	105° 58' 38.942" E
8	Дэл уул 8-р цэг	Босгын өндөр	1285	44° 30' 34.711" N	106° 5' 0.053" E
9	Дэл уул 9-р цэг	Замын алаг	1326	44° 29' 1.835" N	106° 10' 43.853" E
10	Дэл уул 10-р цэг	Хар тээгийн зүүн	1322	44° 27' 41.015" N	106° 15' 6.275" E
11	Дэл уул 11-р цэг	Билүүтийн цагаан	1299	44° 27' 13.223" N	106° 14' 33.961" E
12	Дэл уул 12-р цэг	Хүрэн хана	1285	44° 26' 52.022" N	106° 11' 28.018" E
13	Дэл уул 13-р цэг	Алгын хажуу	1234	44° 24' 58.446" N	106° 9' 4.918" E
14	Дэл уул 14-р цэг	Шар хошуу	1259	44° 25' 53.663" N	106° 3' 45.720" E
15	Дэл уул 15-р цэг	Хошуун хонд	1223	44° 24' 48.960" N	106° 0' 48.694" E
16	Дэл уул 16-р цэг	Баруун билүүний сайр	1234	44° 25' 14.826" N	105° 52' 5.516" E
17	Дэл уул 17-р цэг	Зүүн даянгар	1271	44° 25' 32.567" N	105° 41' 13.060" E
18	Дэл уул 18-р цэг	Баруун даянгар	1336	44° 25' 19.448" N	105° 33' 45.176" E
19	Дэл уул 19-р цэг	Үзүүр овоо	1356	44° 25' 11.370" N	105° 30' 39.913" E
20	Дэл уул 20-р цэг	Өндөр	1380	44° 26' 20.288" N	105° 30' 35.431" E

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 7059-2494, Факс: 7059-2896
И-мэйл: info@dundgovi.gov.mn

2020.03.26 № А/386

танай _____-ны № _____-т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ
ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын Дэл уулын хадны зураг бүхий цогцолборт хамгаалалтын бүс тогтоох, кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулах холбогдох албан тушаалтнуудын мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт.1..хуудастай

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН

Г.Энхбаатар
Дэлгэрэх ард, гэмтэр
сахиф багах

30/III, 2020.


482050418


ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГТ ОРУУЛАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

2020.03.20.

д/д	Албан тушаал	Овог, нэр	Холбоо барих утас	Email хаяг
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл урлаг, спортын бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн	Маам Болор-Эрдэнэ	99598626	boogii_soyol@yahoo.com
2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Удирдлагын хэлтсийн дарга	Баттөмөр Рэнцэндорж	88079844	ereetei@yahoo.com
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын харилцаа хариуцсан мэргэжилтэн	Баттулга Батцэцэг	80088606	tsetseg_9@yahoo.com
4	Музейн захирал	Маам Бямбажав	99069914	byambaa8844@gmail.com
5	Өлзийт сумын газрын даамал	Намжилдорж Насанбаяр	88730738	nasaa04@yahoo.com
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, эрдэс баялаг, уул уурхай хариуцсан мэргэжилтэн	Пүрэвжав Очирбат	99244288 90114288	ochirbat@dundgovi.gov.mn

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС


Дэл уулын хадны зургийн цогцолборыг газрын мэдээллийн санд оруулах санал
Масштаб 1:180 000
N
Цагаан суварга
Харгант уул
Улаан
Ик уул
Дундговь
Өмнөговь
Бор толгой
Цагаан толгой
Өлзийт
Бага хөх цав
Таних тэмдэг
Эргэлтийн цэг санал
Зарим нас томоохон хадны зургууд
Хамгаалалтын санал болгох буй бүс
Аймаг хил
Хайгуулын талбай
0 5 10 20 километр
№ Өргөрөг Уртраг Талбай /га/
1 N44° 27' 45.718" E106° 16' 51.234"
2 N44° 28' 42.720" E106° 16' 42.966"
3 N44° 29' 25.638" E106° 16' 46.912"
4 N44° 24' 53.395" E106° 9' 15.108"
5 N44° 24' 51.017" E106° 4' 58.753"
6 N44° 25' 33.457" E106° 3' 52.276"
7 N44° 24' 6.725" E106° 0' 13.614"
8 N44° 24' 57.755" E105° 49' 6.460"
9 N44° 24' 59.248" E105° 38' 8.075"
10 N44° 23' 51.108" E105° 34' 26.662"
11 N44° 23' 52.664" E105° 26' 13.898"
12 N44° 26' 29.626" E105° 26' 45.044"
13 N44° 28' 11.709" E105° 26' 59.302" 60429.02
14 N44° 28' 28.734" E105° 32' 32.506"
15 N44° 31' 23.233" E105° 36' 26.076"
16 N44° 30' 19.658" E105° 39' 39.298"
17 N44° 28' 55.405" E105° 41' 23.747"
18 N44° 28' 49.268" E105° 43' 35.535"
19 N44° 30' 4.504" E105° 44' 46.759"
20 N44° 31' 8.938" E105° 44' 36.846"
21 N44° 31' 18.881" E105° 42' 27.002"
22 N44° 33' 6.019" E105° 43' 20.584"
23 N44° 31' 26.561" E105° 52' 2.830"
24 N44° 30' 33.932" E105° 58' 26.668"
25 N44° 28' 42.947" E106° 8' 14.691"


105°30'0"E
105°45'0"E
106°0'0"E
106°15'0"E
44°45'0"N
44°30'0"N
44°20'0"N
Хадны зургийн ойр
Дэл уулын хадны зураг, булш дурсгалыг газрын нэгдмэл санд оруулах санал
Талбайн хэмжээ: 44153,6 га
Эргэлтийн цэгийн тоо: 20 цэг
Таних тэмдэг
Эргэлтийн цэг
Өвөлжөө бууц
Худаг
Булш
Хадны зураг
Аймаг хил
Сум хил
Дэл уул бүс
2020 нэмэгдсэн хайгуулын талбай
Төлөвлөж буй бүс
Хар тэзэг уул 1
Хар тэзэг уул 2
0 5 10 20 километр
Байгуулага: Соёлын өвийн үндэсний төв
Боловсруулсан: Авран хамгаалах газар / С.Баясандорж /







“ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХААЛГАТ, СЭРВЭН ХААЛГАНЫ БИЧЭЭС, ИХ БУРХАНТЫН ЦОГЦОЛБОРЫН КАДАСТРЫН ХЭМЖИЛТ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоол “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/368 дугаар тушаалаар “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан.

Соёлын өвийн үндэсний төвөөс үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу 2020 оны 2 дугаар сард ажлын хэсгийг байгуулах мэдээлэл солилцох үүднээс Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн засаг даргын тамгын газарт албан бичиг илгээн орон нутгаас ажиллах бүрдэхүүнд орох албан хаагчдын нэрсийг авсан болно (хавсралт 1, 2, 3). Албан бичигт Хэнтий аймгаас хариу ирүүлээгүй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/368 дугаар тушаалаар батлагдсан “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 1.3.3. Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт орших Сэрвэн хаалганы бичээс, 1.3.4. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Хаалгатын хүн чулуун хөшөө бүхий цогцолбор, 1.3.5. Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Их бурхантын цогцолборын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2020 онд хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

Уг ажлын хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн хээрийн бүртгэл, судалгааны баг дээрх дурсгалт газруудад ажиллаж, хэмжилтийг газар дээр нь нягтлах, баталгаажуулах ажлыг 2020 оны 8 дугаар сарын 13-наас 25-ны хооронд хийж гүйцэтгэв.

Хаалгат (Сэнжмандал)-ын хүн чулуун хөшөө бүхий цогцолбор

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг, сумын төвөөс зүүн тийш 60 км-т Сэнжмандалын хөндийн хойд хэсэгт нэгэн багахан толгойн зүүн энгэрт 4 хүн чулуу бүхий цогцолбор дурсгал бий. Энэхүү цогцолбор дурсгалыг археологич Д.Баяр 1981, 1984 онд судалж, “Монголчуудын чулуун хөрөг (19948 2002)” хэмээх нэгэн сэдэвт зохиолдоо тодорхойлолт, гар зургийн хамт нийтлүүлсэн байдаг. Энд орших хүн чулуудыг өмнө нийтлэгдсэн дугаарыг баримтлан тодорхойлов.


Эхний буюу 58-р хун чулуу нь том ширхэгтэй шаргал боржингоор хийсэн босоо хүний дүрс. Лоовууз хэлбэрийн малгайтай бөгөөд өргөн дугариг царайтай, нүүрийн дүрс нэлээд сайн мэдэгдэнэ. Чихний араар мушгин боосон хоёр салаа гэзэг мөрөнд хүртэл унжуулжээ. Баруун гартаа урт иштэй хундага барьж зүүн гараа бүсэн дээр тавьжээ. Энгэр заам дүрслээгүй ба хос зураасаар нарийхан бүс гаргажээ. Хэмжээ 104х54х33 см.



Хоёр дахь буюу 59-р хун чулуу нь өмнөх хүн чулуунаас 5-6 м зүүн тийш, 8х6 м хэмжээтэй эвдэрч хэлбэр дүрсээ алдсан чулуун овооны дэргэд сул хэвтэнэ. Том ширхэгтэй шаргал боржингоор хийсэн босоо хүний дүрс. Гозгор оройтой бөмбөгөр малгай өмссөн ба өргөн дугариг царайтай, нүүр нь нэлээд сайн хадгалагджээ. Баруун гартаа урт иштэй хундага барьж, зүүн гараа унжуулжээ. Энгэр заам дүрслээгүй, цээжинд хоёр хөх сийлсэн нь эмэгтэй хүн болохыг гэрчилнэ. Хоёр шанаанд малгайн захнаас унжуулсан хатан сүйх хэлбэртэй унжлага байгаа нь баруун гар талд гурав, зүүн талд хоёр мэдэгдэнэ. Дээлийн хормой өргөн эмжээртэй ба дор нь хоёр хөлийг дүрсэлжээ. Хэмжээ 124х38х22 см.



Гурав дах буюу 60-р хун чулуу нь өмнөх хүн чулуутай нэг дор мөн хэвтээгээр байна. Том ширхэгтэй шаргал боржингоор хийсэн босоо хүний дүрс. Хавтгайдуу оройтой ар тийш унжсан шилэвчтэй малгай өмссөн, нүүрийн дүрс их л элэгдэн бүдгэрчээ. Чихний араар бөөгнүүлж боосон хоёр гэзэг унжина. Дээл хувцас, энгэр заам мэдэгдэхгүй. Баруун гартаа хундага хэлбэртэй том сав барьж, зүүн гараа өвдөг дээр тавьжээ. Түшлэгтэй сандалд суусан бололтой, хоёр хөлийг тодорхой гаргажээ. Баруун талд мөлгөр өнцөгтэй хавтага сийлсэн нь сандлын түшлэг дээр байгаа мэт дүрсэлжээ. Хавтаганы дор 15х15 см дөрвөлжин дүрс гаргажээ. Хэмжээ 157х55х34 см.



Сүүлийн буюу 61-р хүн чулуу өмнөх хоёр хүн чулууны баруун урд 12 м зайд 6 м голчтой чулуун цагаригийн дэргэд хэвтэж байна. Том ширхэгтэй шаргал боржингоор хийсэн суугаа бололтой хүний дүрс. 1980-аад онд тус хүн чулууны толгой нь хугаран алга болсон гэж тодорхойлж байсан бол өдгөө толгой нь олдсон байна. Баруун гараар цээжний өмнө хундага хэлбэртэй том сав барьж, зүүн гараа өвдөг дээр тавьжээ. Зүүн гараа нугалсан байдлыг харахад сандлын түшлэг дээр тохойлдсон мэт байна. Дээлийн хормойн зах, дороос нь цухуйсан хоёр хөл дүрсэлжээ. Хэмжээ 80х31х16 см.



Хаалгат (Сэнжмандал)-ын цогцолборын хүн чулууд нь Монголын эзэнт гүрний үед хамаарах 4 хүн чулууд болон тахилын байгууламжийн хамт оршиж байгаагаараа онцлог юм. Дурсгалт газрын хүн чулуудын дунд 2 эмэгтэй хүн чулуу байгаа нь өвөрмөц бөгөөд энэ үед хамаарах нийт хүн чулуудын дотор 6 эмэгтэй хүн чулууд урласан нь хатан болон малгай дээл хувцас зэргээс тодорхой болоод байна. Мөн хүн чулуудын тахилын байгууламжийн гадаад зохион байгуулалт ихэд өвөрмөц бөгөөд зарим хэсэгт дөрвөлжин чулуун өрлөг мэдэгдэж байна. Түүнчлэн нэг чулуун байгууламж дээр 2-3 хүн чулуу байх нь Монголын үеийн хүн чулууд дунд цөөн тохиолддог аж.

Их бурхантын цогцолбор:

Дорнод аймгийн Халхгол сумын төв Сүмбэрээс хойш 35 км-т, Халх голын баруун эргийн тохойн налуу энгэрт оршино. Их бурхантын цогцолборыг Халхын Сэцэн хан аймгийн Илдэн Жун ван То ван хэмээх Бат-Очирын Тогтохтөр (1797-1868)-ийн санаачилга, удирдлагаар бүтээсэн бөгөөд “Их шүтээн”, “Их бурхант” хэмээн олноо алдаршжээ. Найман аюулаас аврагч Жанрайсиг (Жигжаджав) бурхны дүр эл шүтээн бүхий тус цогцолборыг То ван хийгээд Сэцэн хан аймгийн хошуу ноёд чулуугаар хэвтээ байдлаар бүтээн залахаар шийдэж аймаг, хошуу нутгийнхны хандив хөрөнгөөр зуу шахам гар урчуудыг оролцуулж 1859-1864 оны хооронд урлан бүтээсэн байна. Уг цогцолбор дурсгалын гол шүтээн Жанрайсиг (Жигжаджав) бурхны өндөр нь 30 метр (дунджаар 94 тохой, 1 тохой 32 см) өндөртэй. Тус бурхан нь 8 мутартай бөгөөд мутар бүр нь найман төрлийн аюулаас аврахыг билэгдсэн барьцтай урласан. Их бурхан том бага хоёр хүрээтэй ба том хүрээ нь 220х97 м хэмжээтэй бөгөөд язгуурын гурван бурханы тарныг 16.5х1.1 м хэмжээгээр 20 ланз үсгийг хэвтээ байдлаар шигтгэн залсан. Бага хүрээн дотор 2х1.1 м хэмжээтэй 12 суваргыг мөн чулуу шигтгэн бүтээжээ. Энэхүү




цогцолбор дурсгал нь он цагийн уртад байгалийн элдэв гамшиг, үер ус, газар хөдлөлт, түймэр, хил орчмын самуун, мөргөлдөөн, социалист нийгмийн үзэл сурталд өртөж эвдэрч сүйдэн, гулсаж ихээхэн гэмтсэн байна. Харин 1990-ээд оноос уг дурсгалыг сэргээн бүтээх санаачилга гарч онд холбогдох судалгаа шинжилгээ, малталт, сэргээн засах ажил тэнд өрнөсөн байна. Энэ ажлын хүрээнд 1995 онд ШУА-аас Их Бурхантын чулуун дурсгалыг судлан шинжлэх баг томилон ажиллуулснаар уг дурсгалын ойролцоо оршдог болон Их Бурхантын дурсгалтай холбоотой хэд хэдэн бурханы дүрс бүхий чулуун дурсгалыг олж бүртгэсэн байна. Үүний дараа Монгол улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн хүрээнд 2012-2016 онд тус дурсгалыг Соёлын өвийн үндэсний төвөөс сэргээн засварлажээ.

Сэрвэн хаалганы бичээс:

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Жаргалант багийн нутаг Хэрлэн голын урд хөндийд орших зэрэгцсэн хадтай гурван шовх уулыг Сэрвэн хаалга хэмээн нэрийднэ. Энэ уулын баруун талын шовх өндрийн энгэрт хоорондоо 10-аад м-ийн зайтай орших 2 том боржин хадны наран зүгт харсан тэгш гадаргуу дээр эртний Нанхиад, Зөрчид хоёр бичээс бий. Зүүн талд нь 3.1х4.8м орчим хэмжээтэй хаднаа 9 мөр нанхиад бичээс, баруун талын 3.4х4.5м орчим хэмжээтэй өргөн хаданд 11-16 үсэгтэй 9 мөр Зөрчид бичээс байна. Энэхүү эртний бичээсийг анх Х.Пэрлээ сураглан олж, Ц.Шагдарсүрэн, Б.Сумъяабаатар нар хэвлэлд нийтэлжээ. Сэрвэн хаалганы бичээсийг 1986 онд Ц.Шагдарсүрэн судалж






Зөрчид бичээс гэж тогтоосон. 1991 онд археологич Д.Цэвээндорж, Японы судлаач Като Шимпей нарын удирдсан хээрийн шинжилгээний ангийн эрдэмтэд эдгээр бичээсийг дахин очиж судалжээ. Като Шимпей зөрчид бичээсний эхний мөрд “Их төвийн алтан улсын О-Гяо Жео-шёо” гэсэн хэргэм зэргийн нэр байна гэж уншаад “Алтан улсын түүхэнд” “Он-янг чангшиан” гэж тааралддаг монгол хэлний “Вангин Чэншиан” гэдэгтэй тохирно гэж үзсэн юм. Мөн бичээсний наймдугаар мөрд “Мэй-шүгийн 7 дугаар он” гэсэн үсэг тод үлджээ. Ихэнх хэсэг нь ховхорч унасан хятад бичээсний эхний өгүүлбэр нь "Их төвийн Алтан улсын хааны баруун гарын түшмэл Вангин Чинсан цэргээ удирдан татаарын сөнөөхөөр одовой” гэсэн бол сүүлийн хоёр мөрт нь дайн дуусаж, цэргээ татсан он сарыг тодорхой өгүүлсэн байх аж. Дээрх бичээс нь 1196 онд Алтан улсын цэргийн жанжин Вангин Чинсан, Татарын Мэгүжин сүүлттэй байлдахад Тэмүүжин эртний өст татаарууд даралцахад хүч хавсарсан Улз голын байлдааны талаар өгүүлсэн Их Монгол улс байгуулах үеийн түүхийн чухал сурвалж юм.

Бэлтгэл ажил:

Бид дурсгалт газруудыг кадастрын бүртгэлд оруулах талбайг тухайн дурсгалын онцлог болон судалсан байдал зэрэгт үндэслэн урьдчилсан байдлаар зайнаас тандан газрын зургийн эхний хувилбарыг боловсруулав. Үүнд,

Хаалгатын хүн чулуун хөшөө бүхий цогцолбор. Дурсгалт газарт очиж хээрийн ажил эхлэхээс өмнө Sentinel-2 хиймэл дагуулын (L1C_T50TMS 2018оны 7 сарны 22-ны) мэдээ, Arcgis Earth ашиглан зайнаас тандан ГМС-ын Arcgis программ хангамж, өмнө судалсан судалгааны материал ашиглан дурсгалт газрын байршил хүн чулуун хөшөөний тархалтын мэдээллийг цуглуулж авсан. Хээрийн ажлын хүрээнд өмнө төлөвлөж байсан 9 цэгийн байршил 3557 га талбайг хамруулан уул уурхайн ашиглалт, хайгуулын талбайтай давхардуулахааргүй авсан.




№	Цэгийн дугаар	Өндөр /ДТД м/	N	E
1	1-р цэг		46° 3' 25.926"	115° 51' 9.124"
2	2-р цэг		46° 3' 39.248"	115° 49' 22.941"
3	3-р цэг		46° 4' 48.184"	115° 48' 40.437"
4	4-р цэг		46° 6' 39.377"	115° 49' 35.714"
5	5-р цэг		46° 7' 15.003"	115° 51' 27.547"
6	6-р цэг		46° 7' 22.891"	115° 52' 27.858"
7	7-р цэг		46° 6' 44.881"	115° 53' 30.575"
8	8-р цэг		46° 5' 38.765"	115° 53' 52.813"
9	9-р цэг		46° 3' 34.864"	115° 52' 26.946"

Их бурхант цогцолбор дурсгалын хээрийн ажлын бэлтгэл ажлын хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийг зурагласан байрзүйн 1:100000 масштабтай L50-9 планшейттай байр зүйн зураг, Sentinel-2 хиймэл дагуулын 10м-ийн нарийвчлалтай, 2018 оны 7 сарын 22-ний сансрын зургаг ашиглан Их бурхант цогцолбор газрын ойр орчмыг тодруулан газрын гадарга, объект, гол мөрний голдирол, эрэг мөрөгцөгийн мэдээллийг гаргав авч ашиглав.


Дурсгалт газрыг тойруулан урьдчилсан байдлаар таван цэг төлөвлөн хээрийн хэмжилтийн хийлээ. Ингэхдээ энгийн хэрэглээний Garmen Etrix 20 маркийн гар GPS ашигласан. Гар GPS-ын хувьд WGS-84 газарзүйн координатын систем ашиглан нийтлэг хэрэглэгддэг градус минут секундийн утгаар авсан. Дэл уулыг тойрон хэмжилт хийх

явцад Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн систем бүртгэгдсэн уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудтай давхардуулахгүйгээр хэмжилт хийлээ.

Хэмжилтийн үр дүнд урьдчилсан байдлаар 7 газрын хэмжилтийн цэг, 683.8 га талбайг хамарсан. Хээрийн ажил дууссаны дараа боловсруулалт хийж талбайн хэмжээ, бусад газрын мэдээлэл буюу Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлийн систем бүртгэгдсэн уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудтай давхардуулж үзэхэд хайгуулын талбай өртөхгүй байна.




№	Цэгийн дугаар	Цэгийн нэр	Өндөр /ДТД м/	N	E
1	1-р цэг	Дэрс	710	47° 50' 38.930"	118° 27' 27.040"
2	2-р цэг	Өндөршил	708	47° 51' 10.590"	118° 25' 49.110"
3	3-р цэг	Өндөр хүчдэл 56-р шон	706	47° 51' 25.450"	118° 25' 35.890"
4	4-р цэг	Дээд цэг	692	47° 52' 33.359"	118° 26' 36.725"
5	5-р цэг	Застав-1	651	47° 52' 40.927"	118° 27' 8.656" E
6	6-р цэг	Застав-2	652	47° 52' 11.270"	118° 27' 15.550"
7	7-р цэг	Хүүхдийн овоо	646	47° 51' 52.510"	118° 28' 35.460"



Сэрвэн хаалганы бичээс. Дурсгалт газрыг Sentinel-2 хиймэл дагуулын мэдээ, ArcgisEarth ашиглан зайнаас тандан ГМС-ын Arcgis программ хангамжаар газрын гадаргын ерөнхий хэв шинж, хамгаалалтад авах газрын талбайг тодорхойлсон. Сэрвэн хаалганы бичээс ойр орчмыг Mavic-2pro дроноор төлөвлөгөөт нислэг үйлдэж Agisoft-ын Photoscan программ хангамж ашиглан газрын гадаргын ерөнхий зураг гаргаж авсан. Хээрийн судалгааны хүрээнд өмнө төлөвлөж байсан зургаан эргэлтийн цэг 9167 га талбайг хамаарсан.

№	Цэгийн дугаар	Өндөр /ДТД м/	N	E
1	1-р цэг		47° 29' 27.934"	111° 10' 32.020"
2	2-р цэг		47° 30' 54.043"	111° 15' 26.716"
3	3-р цэг		47° 29' 47.890"	111° 18' 16.803"
4	4-р цэг		47° 27' 44.595"	111° 20' 45.220"
5	5-р цэг		47° 25' 17.089"	111° 18' 46.597"
6	6-р цэг		47° 25' 17.353"	111° 13' 0.845"



СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХЭЛТЭС

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс:

2020.03.03 № 7/222
танай 2020.02.07 -ны № 01/68 -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт байрлах "Хаалгатын хүн чулуун хөшөөний цогцолбор" газарт хамгаалалтын бүс тогтоох, кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх "Ажлын хэсэг"-т орж ажиллах мэргэжилтнүүдийн мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.МӨНХЗАЯА

Г. Ажилсайхан!
– Бүтэн бүтэгчийг хэлнэ!
– Ажлын хэсэг, удирдагчаар нь
Батлав!
10/III, 2020. 000011Б

2020 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 7/222 тоот албан бичгийн хавсралт

"Хаалгатын хүн чулуун хөшөөний цогцолбор газар"-т
хамгаалалтын бүс тогтоох, кадастрын улсын бүртгэлд
бүртгүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт
ажиллах албан хаагчдын мэдээлэл

д/д	Албан тушаал	Овог нэр	Утас
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн	М. Мандах	93059212 70518841
2	Угсаатны зүйн музейн захирал	Д.Ариундэлгэр	96909617
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын кадастрын мэргэжилтэн	Ү. Цэцэгдэлгэр	99068158
4	Эрдэнэцагаан сумын Газрын даамал	Д. Батмандах	99937113

Нийгмийн бодлогын хэлтэс

ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
21000, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас: 7058-3040, факс: 7058-4681

2020.02.14 № 2/366
танай 2020.02.07-ны № 01/67 -т

СӨЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоолоор "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Халхгол сумын нутагт орших Их бурхант цогцолборыг хамруулж кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэхээр болсон.

Иймд манай аймгаас уг ажлыг зохион байгуулахад оролцох ажлын хэсгийн бүрэлдэхүүний танилцуулгыг хүргүүлж байна. Үүнд:

О.Ганчимэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын хэлтсийн Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн утас: 80087655 /ganchimegeee28@gmail.com/
М.Арьяазул	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн Газрын харилцаа, хот байгуулалт, архитектор төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн утас: 99584857 /ariyazul48@gmail.com/
Н.Энхбаяр	-Аймгийн Музейн захирал утас: 80055833 /dornod_naraa@yahoo.com/
Э.Мөнх-Уянга	-Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын газрын даамал утас: 88783062 /1uyanga1013@gmail.com/

ДАРГА Ц.БАТ-ӨЛЗИЙ

Г. Анхсэнд!
Амжилт хүсье ерөөе!
13/2, 2020.

010520079





ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХАД ШААРДАГДАХ ХАМГААЛАЛТЫН БҮСИЙГ ТОГТООХ АРГА ЗҮЙ

Нийтлэг үндэслэл: Монгол Улсын газар нутаг дээр оршиж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь (цаашид ТСҮХД гэх) байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийн нөлөөлөл, тэр тусмаа нийгмийн хөгжлийн бүтээн байгуулалт болох уул уурхай, газар олголт, авто болон төмөр зам зэрэг газрын харилцаатай холбоотой үйл ажиллагаанд санаатай болон санамсаргүй байдлаар өртөх, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, бодлого төлөвлөлтийг хийхэд нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүйгээс ТСҮХД устах, дурсгалын оршин байх орон зай хумигдах бодит эрсдэл үүсээд байна. Иймд Газрын удирдлагын цахим мэдээллийн санд ТСҮХД-ыг хамгаалахад шаардлагатай орон зайг тодорхойлж, тогтоох арга зүйг боловсруулан орон зайн мэдээлэл бүхий талбар бий болгох нь цаг үеийн шаардлагад нийцсэн хамгаалалтын нэг арга болно.

Зорилго: Хээр хөдөө орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байгалийн болон нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэлээс сэргийлэх зорилгоор 1972 оны Дэлхийн өвийн конвенц болон Соёлын өвийг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай зэрэг хуулийн хүрээнд улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авахад шаардлагатай дурсгалын соёлын орон зайг тодорхойлж, талбай үүсгэх, мөн соёлын орон зайг хамгаалах нөлөөллийн бүсийг тогтооход энэхүү арга зүйг боловсруулж мөрдлөг болгоход зорилго оршино.

Зорилт :

1.Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд,

2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд баталсан аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд,

3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хүрээнд баталсан сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг

4. Сум, дүүргийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамруулах зорилт тавьсан болно.

Арга зүйн зарчим

Энэхүү арга зүйгээр хийгдсэн мэдээлэл нь ТСҮХД-ын байршлыг Газрын удирдлагын цахим санд бүртгэхэд үндсэн мэдээлэл болно. Арга зүй нь:

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын соёлын орон зайг тодорхойлж, талбай үүсгэх,

2. Соёлын орон зайг хамгаалах нөлөөллийн бүсийг тогтоох гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

ТСҮХД-ын соёлын орон зайг тодорхойлохдоо тухайн дурсгалын судлагдсан байдал, дэвсгэр зураг, дагалдах хэрэглэгдэхүүнд үндэслэнэ. Харин тухайн дурсгалын соёлын орон зайг хамгаалах нөлөөллийн бүсийг тогтоохдоо холбогдох хууль, дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгааг үндэслэнэ. Соёлын орон зайн болон нөлөөллийн бүсийг хэмжигдэхүүнийг км-ийн зайгаар тооцно.

Энэхүү түүх, соёлын үл хөдлөх дурсгалын соёлын орон зай, нөлөөллийн бүс тогтоох арга зүйг боловсруулахдаа Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийн судалгаа хийх журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд, шинжлэх ухааны судалгаанд түгээмэл хэрэглэгддэг нийгмийн ухааны задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, байгалийн шинжлэлийн материал судлал болон салбар шинжлэх ухаан болох хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны багажид дүн шинжилгээ, ажиглалтын ба эрсдэл болон нөлөөллийн судалгаа, архитектурын шинжлэх ухааны (хүний хөдөлгөөн, орон зай) арга зүйг удиртгал болгов.

Арга зүйн дагуу хамгаалалтын бүсийг тогтоохдоо дараа үе шатыг баримтална. Үүнд,

1. ТСҮХД нь аль төрөл зүйлд хамаарахыг тогтооно.
2. ТСҮХД-ын байршлыг тогтооно.
3. Дурсгалын соёлын орон зайг тодорхойлно.
4. Нөлөөллийн бүсийг тогтооно.

Нэг. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН СОЁЛЫН ОРОН ЗАЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАЛБАЙ ҮҮСГЭХ

1.1 Орон зайг тодорхойлох төрөл зүйлийн ангилал

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.1-д Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

5.1.1.эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;

5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;

5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;

5.1.4.хадны зураг, бичээс;

5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;

5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;

5.1.7.хөшөө дурсгал;

5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9.тахилгат газар;

5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал хэмээн 11 хэсэгт ангилан заасан байдаг.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрлүүдийн өөр хоорондын адил төстэй шинж чанар, гадна харагдах байдал, дурсгалыг бүтээсэн материал, бүтээсэн арга ажиллагаа, хадгалалт хамгаалалтын онцлог, орон зайн хэмжээний онцлог зэргийг харгалзан үзэж хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.8, 5.1.10 гэсэн таван хэсгийг нэгтгэж 1. “нээлттэй талбайгаар илэрхийлэгдэх дурсгалт газрууд”; хуулийн 5.1.4 хадны зураг, бичээс хэсгийг 2.”хадны зураг, бичээс”; хуулийн 5.1.5 булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж гэсэн хэсгийг 3.“булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж”; хуулийн 5.1.6 эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал гэсэн хэсгийг хоёр задлан ангилж 4.“эртний хот, хэрэм, сүм хийдийн туурь, үлдэц”; 5.“уран барилга, архитектурын дурсгал”; хуулийн 5.1.7 хөшөө дурсгал гэсэн хэсгийг 6. “хөшөө дурсгал”; 5.1.9 тахилгат газар гэсэн хэсгийг 7.”тахилгат газар” хэмээн тус тус долоо ангилж, энэхүү арга зүйд ашиглав (Хүснэгт 1). Үүнд,

1. “НЭЭЛТТЭЙ” БУЮУ ТАЛБАЙГААР ИЛЭРХИЙЛЭГДЭХ ДУРСГАЛУУД:

Энэхүү ангилалд эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар, эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга, чулуун зэвсгийн олдворт газар, эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал болон түүхэн үйл явдал болсон дурсгалт газрыг хамруулна.

2. ХАДНЫ ЗУРАГ, БИЧЭЭС:

Энэхүү ангилалд хад чулуун дээр зурагдсан эртний бүх төрлийн хадны сийлмэл болон зос, бэхэн зураг, тамга тэмдэг болон бичээсийг хамруулна.

3. БУЛШ, ХИРГИСҮҮР, ОРШУУЛГА, ТАХИЛ, ТАЙЛГЫН БАЙГУУЛАМЖ,

Энхүү ангилалд түүхийн олон үе хамаарах бүх төрлийн булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламжийг хамруулна.

4. ЭРТНИЙ ХОТ, ХЭРЭМ, СҮМ ХИЙДИЙН ТУУРЬ, ҮЛДЭЦ:

Энэхүү ангилалд эртний хот, хэрэм, хэрмэн хана, хот суурингййн туурь, балгас, сүм хийдийн үлдэгдэл зэрэг дурсгалууд хамрах ба орон зайн илэрхийлэл буюу харагдах байдлын хувь өөр өөр эртний хот, хэрэм, сүм хийдийн туурийн орон зайн хэмжээг хэрэм, шуудуугаар илэрхийлж, голчон төв суурин газраас алслагдмал оршидог байгаа бол

5. УРАН БАРИЛГА, АРХИТЕКТУР ДУРСГАЛ;

Энэхүү ангилалд бүрэн бүтэн, барилга архитектурын хэв шинжийг бүрэн илэрхийлэхүйц дурсгал хамрах ба байрлыг хувьд төв суурин газарт орших дурсгалыг хамруулна.

6. ХӨШӨӨ ДУРСГАЛ:

Энэхүү ангилалд буган чулуу, түүхийн олон цаг үед холбогдох хүн чулуун хөшөө, гэрэлт хөшөө зэрэг дурсгалыг хамруулна.

7. ТАХИЛГАТ ГАЗАР:

Энэхүү ангилалд тахилга шүтлэгт газар нутаг, уул, овоо, суварга зэрэг дурсгалыг хамруулна.

Мөн ТСҮХД-ын нэгэн онцлог нь дээрх төрөл зүйл, ангилалд орсон дурсгалууд нь нэг газарт хэд хэдэн төрлөөрөө хамт цогцолбор байдлаар орших нь түгээмэл байдаг тул тухайн түүх, соёлын дурсгалт газарт давамгайлж байгаа ТСҮХД-ын төрлийг үндэслэн орон зайг тодорхойлж болно.

1.2. ТСҮХД-ын байршлыг тогтоох

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд нь ихэвчлэн хөдөө хээр, алслагдсан нутагт орших бөгөөд бүгд нэг бүрчлэн судлагдаагүй байдаг. Иймд тухайн ТСҮХД-ын байршлын анхдагч мэдээлэл маш чухал бөгөөд түүнийг үнэн зөв тогтоох нь цаашдын үйл ажиллагааны үндэс болно.

1. Тухайн ТСҮХД-ын байршил нь харилцан адилгүй байх бөгөөд байршлын тухай анхдагч мэдээллийг хэд хэдэн янзаар авч, байршлыг тогтоож болно. Түүнд, шууд болон шууд бус гэсэн хоёр байдлаар ангилж болно.

2. Шууд байдлаар дурсгалын мэдээллийг авч, байршлыг тогтоохдоо тухайн дурсгал оршиж байгаа газар дээр биеэрээ очиж байршил тогтоогчоор хэмжилт, байршлыг тогтооно.

3. Шууд бусаар мэдээлэл авах нь тухайн дурсгалыг өмнө нь судалсан, байршлын мэдээллийг агуулсан судалсан судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл, ном бүтээлээс анхдагч мэдээллийг нягтлан, авч зайнаас тандан судлал, Газарзүйн мэдээллийн системын програм хангамжуудыг ашиглан байршлыг тогтооно. Дээрх байдлаар дурсгалын байршлын мэдээллийг авч, ашигласан бол судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл, ном бүтээлийн зохиогч, нэр, хэвлэгдсэн газар, он, хуудасны нэр зэрэг эх сурвалжийн мэдээллийг газарзүйн мэдээллийн системийн атрибут мэдээнд тэмдэглэнэ.

1.3.ТСҮХД-ын соёлын орон зайг тодорхойлох, зураглах

1. ТСҮХД-ын төрөл тус бүр өөр өөрийн бүтэц бүрэлдэхүүнтэй, соёлын орон зай нь онцлог, хамрах талбайн хэмжээ нь өөр өөр байдаг. Тиймээс ТСҮХД-ын хэлбэр, хэмжээ, бүтээсэн материал, зохион байгуулалт зэрэг шинж чанараараа ялгаатай байхаас гадна түүнийг анх хийж бүтээсэн, барьж байгуулсан зорилго, зориулалтаараа бүгд ялгаатай байх ба тэдгээрийг тэдгээрийн цогц агуулгыг дурсгалын “соёлын орон зай” гэнэ.

2. ТСҮХД-ын соёлын орон зайг тодорхойлохдоо тухайн дурсгалын төрөл зүйлийн онцлогийг анхаарч, бүрэлдэхүүн хэсгүүдийг аль болох бүгдийг хамруулж гурваас дээш цэгийг тэмдэглэх бөгөөд тэдгээр цэгүүдийг холбосноор тухайн дурсгалын соёлын орон зайн талбай үүсгэнэ.

3. Ихэнх тохиолдолд ТСҮХД-ын хэд хэдэн төрөл зүйлүүд хамт цогцолбор байдлаар орших бөгөөд ийм үед бүх төрлийн дурсгалуудыг хамруулан соёлын орон зайн талбайг үүсгэнэ.

4. ТСҮХД-ын байршлын болон төрөл зүйлийн анхдагч мэдээлэл мэдэгдэж байгаа тохиолдолд соёлын орон зайг сансрын (Landsat, Sentinel, DigitalGlobe г.м) технологи ашиглан зайнаас тандах аргаар тодорхойлж болох бөгөөд ингэх дээ Газарзүйн мэдээллийн системийн (Arcgis, ArcgisEarth, GoogleEarth QGIS г.м) программ хангамжуудыг ашиглан байршлыг тодорхойлох, зураглах, цэг, талбайн хэмжээг бодуулан зураглана.

5. Дурсгалт газар нь судалгаанд хамрагдсан хэдий ч соёлын орон зайн нь тодорхойгүй тохиолдолд эрдэм шинжилгээний байгууллага, өндөр нарийвчлалын хиймэл дагуулын зураг хэрэглэн зайнаас тандах аргыг ашиглан тогтооно.

Хоёр. ТСҮХД-ЫН НӨЛӨӨЛЛИЙН БҮС ТОГТООХ

ТСҮХД-ын соёлын орон зайг тогтоосны дараа тухайн дурсгалт газарт сөрөг нөлөө үзүүлж болох эрсдэлүүдээс сэргийлэх тодорхой орон зайг тогтоох бөгөөд үүнийг “нөлөөллийн бүс” гэнэ. Нөлөөллийн бүс нь тухайн дурсгалт газрыг нийгмийн гаралтай сөрөг хүчин зүйлт эрсдэлээс сэргийлэх зорилготой бөгөөд дурсгалын төрөл зүйл тус бүрээс хамаараад өөр өөр байна.

1. Нөлөөллийн бүсийг тогтоохдоо түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн эрсдэлийн үнэлгээнд хийсэн судалгаанд тулгуурлан төрөл зүйл тус бүрд эрдэл учруулах хүчин зүйлсийн хэмжигдэхүүний нийлбэрийн дунджийг баримтлан тооцов.

2. Мөн нөлөөллийн бүсийг тогтооход тухайн ТСҮХД-нь Хээрийн хөдөө Сумын төв, Аймгийн төв, Нийслэл, гэсэн байршлын онцлогоос хамаарч орон зайн дундаж хэмжээнээс хувь хэмжээг хасаж тооцов. Дундаж хэмжээг хээр хөдөөд өөрчлөхгүй, сумын төвд 50%, аймгийн төвд 25%, нийслэлд 10% тай тэнцүү хэмжээг баримтална. лав.

3. Нөлөөллийн бүсийг тогтоохдоо соёлын орон зай нь тодорхойлогдсон ТСҮХД-ын захын цэгээс гадагш тооцоолж км-ээр тооцохдоо дурсгалын төрөл зүйл, төрөл зүйлийн онцлог, судалгаа шинжилгээнд үндэслэсэн хэмжээ, байршил зэргийг харгалзан арга зүйн 3 дугаар хэсэгт заасан нөлөөллийн бүсийн орон зайн хэмжээгээр тогтоов.

Нөлөөллийн бүсийн хэмжээг дурсгалын төрөл зүйл болон байршлын онцлогт тохируулан тогтоосныг хүснэгтэд оруулав.

1. Чулуун зэвсэг, үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан газар

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 8 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 10 км, Газар тариалангийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 0.1 км, “Голын үерт өртөх эрсдэл 0,5 км гэсэн 8 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 4.6 км дундаж гарч байна.

2. Хаднаах зураг, бичгийн дурсгал

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 15 км гэсэн 6 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 6.7 км дундаж гарч байна.

3.Булш оршуулга, тахил тайлгын байгууламжийн дурсгалт газар

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 8 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 10 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 1.5 км, Газар тариалангийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 0.1 км, “Голын үерт өртөх эрсдэл 0,5 км гэсэн 8 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 5.8 км дундаж гарч байна.

4. Сүм хийд, уран барилгын дурсгал

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 1.5 км, “Голын үерт өртөх эрсдэл 0,5 км гэсэн 7 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 3.6 км дундаж гарч байна.

5. Эртний хот, сүм хийдийн туурь, балгас бүхий дурсгал

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 1 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 1.5 км, Газар тариалангийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 0.1 км, “Голын үерт өртөх эрсдэл 0,5 км гэсэн 8 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 2.6 км дундаж гарч байна.

6. Хөшөө чулуун дурсгал

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км Газар тариалангийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 0.1 км, гэсэн 5 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 3.6 км дундаж гарч байна.

7. Палеонтологийн (Үлэг гүрвэлийн олдворт газар) дурсгалт газар


Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 3 км, Авто болон төмөр замын бүтээн байгуулалтын ажлаас үүдэх эрсдэл 7 км, Улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 5 км, Орон нутгийн чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 8 км, Суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл 10 км, гэсэн 6 эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч 6 км дундаж гарч байна


Хүснэгт 1. ТСҮХД-ын Соёлын орон зай болон нөлөөллийн бүсийг тогтоох хэмжээ


№	Энэ хэсэгт хамаарах Соёлын өвийн хамгаалах тухай хууль дахь ТСҮХД-ын ангилал	Арга зүйн ангилал	Онцлог, хамрах талбайн хэмжээ	А.Бйршлын онцлог Б. Орон зайн илэрхийлэл буюу харагдах байдал	Нөлөөллийн бүсийн орон зайг тооцох хэмжээ (км)			
					Хэзр хөдөөд	Сумын төвд	Аймгийн төвд	Нийслэлд
	1	2	3	4	5	6	7	8
1	5.1.1.эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;	1. Нээлттэй талбайгаар илэрхийлэгдэх дурсгалт газрууд	3500 сая жилийн тэртээгээс хүн үүсэх хүртэл амьдарч байсан организмын чулуужсан үлдэгдэл, тэдгээрийн ул мөр зэргийн агуулсан олдворт газрыг хэлдэг бөгөөд хамрах талбайн хувьд дунджаар 100 м-ээс 30 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А.Ихэвчлэн голын хөндий, тал, говь газарт илэрсэн байдаг. Б. Газрын гадарга дээр ил харагдах ямар нэгэн байгууламжгүй, талбай	4.6	2.3	1.15	0.46
	5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;		800 мянган жилийн тэртээгээс хүн амьдарч байсан ул мөр *(гал голомтын үлдэгдэл, хоол ундны үлдэгдэл болох яс, өндөгний хальс,ваарны хагархай, чулуун зэвсгийн үлдэц г.м)* зэргийг хөрсний доор болон дээрээ хадгалсан олворт газрыг хэлдэг бөгөөд хамрах талбайн хувьд дунджаар 100 м-ээс 25 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	Ихэвчлэн агуй, голын хөндийгөөс илэрсэн байдаг.				
	5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;			Уулын энгэр бэл, ам, хадны агуй, голын хөндий, булаг шанд орчимоос илэрдэг.				


	5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;		Эрт үед байгалийн баялаг, барилын материал олворлож *(төмөрийн хүдэр, шавар, чулуу г.м),* үйлдвэрлэл явуулж байсан эсвэл газар тариалан эрхэлж байсан талбар, суваг шуудуу, чулуун дурсгал зэргийг хадгалсан дунджаар 100 м-ээс 1.5 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	Тогтсон байршил тогтоогдоогүй				
	5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;		Түүхэнд холбогдох ямар нэгэн хэрэг явдал болж өнгөрсөн газар нутгийг хамрах бөгөөд 100 м-ээс 3 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.					
2	5.1.4.хадны зураг, бичээс;	**2.**Хадны зураг, бичээс	Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны толигор гадаргуу дээр хүн, амьтан, тэрэг, овгийн тамга, болон тодорхой үсэг бичгийг ашиглан зос, бэх болон сийлж урласан газрыг хэлэх бөгөөд нэг хэсэг хаднаас уул, толгодыг хамрах ба 100 м-ээс 5 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А.Уулын орой, хадан цохио, голын эрэг зэрэг хад чулуу элбэг газараас илэрдэг. Б. Уул, хадан дээр	6.7	3.3	1.66	0.66
3	5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;	3. Булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж	Түүхэн тодорхой цаг үед хүмүүс талийгаачдаа тусгай зан үйлийн дагуу оршуулж дарсан (ан цав, агуйг ашиглан талийгаачийг оршуулсан хадны оршуулга мөн хамаарна) мод, чулуу, шороогоор хийсэн байгууламжыг хэлэх бөгөөд нэг ширхэгээс хэдэн зуун хүртлэх бүлгээрээ тохиолдох ба дундаар 100 100 м-ээс 3 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А.Уулын шил таг, гүвээ толгодын энэр, хормрй, тал, хээр, голын эрэг, тохой зэрэг газар байгуулсан байдаг. Б. Чулуун байгууламж, бунхан	5.8	2.9	1.45	0.58
4	5.1.6.эртний хот, хэрэм, сүм хийдийн туурь	4.Эртний хот, хэрэм, сүм хийдийн туурь, үлдэц	Түүхэн тодорхой цаг үед хүмүүс урт хугацаагаар суурьшиж байсан үйл ажиллагааг харуулсан болон, цэргийн бэхлэлт болгон барьж байгуулсан	А.Тэгш тал, томоохон голын хөндий, цөөн тохолдолд уулын орой, голын арал зэрэгт	2.6	1.3	0.65	0.26

			барилга байшин, хэрмийн үлдэгдэл, шашин, мөргөлийн сүм, дуганы нурсан үлдэгдэлүүдийг хамааруулах ба дунджаар 500 м-ээс 25 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	байгуулсан байдаг. Б. Хэрэм, шуудуу				
5	Дурсгалт уран барилга, архитектурын дурсгал;	5:Уран барилга, архитектур дурсгал	Түүх, урлаг, шинжлэх ухаан, он цагийн хувьд үнэ цэн бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгуудыг хамаарах ба нэг байшингаас хэд хэдэн цогцолбор барилгууд бүрддэг бөгөөд дунджаар 100 м-ээс 3 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А.Ихэвчлэн хүн ам олноор төвлөрсөн хот, суурин газарт байгуулсан байдаг. Б. Барилаг, байшин	3.6	1.8	0.89	0.35
6	5.1.7.хөшөө дурсгал;	6.Хөшөө дурсгал	Түүхэн тодорхой цаг үед зан үйл, шүтлэг бишрэл, түүхэн тэмдэглэлт үйл явдалд зориулан босгосон, түүх, урлагийн үнэ цэн бүхий бүх төрлийн чулуугаар урлсан хөшөө дурсгал хамаарах ба нэгээс хэдэн арван хүртлэх цогцолбороороо орших бөгөөд 100 м-ээс 1 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А. Ихэвчлэн тэгш тал, уулын хамар, жижиг гүвээ толгойн орой зэрэгт босгодог. Б. Чулуун хөшөө (буган чулуу, хүн чулуун хөшөө)	3.6	1.6	0.95	0.36
7	5.1.9.тахилгат газар;	7.Тахилгат газар	Ямар нэгэн шүтлэг бишрэлийн үүднээс уламжлалт зан үйл хийж гүйцэтгэдэг байгалийн тогтоц (уул, толгод, мод, ургаа хад, булаг шанд г.м) газар болон түүнд зориулан босогосон байгууламж зэрэг хамаарах бөгөөд 100 м-ээс 3 км^2 хүртэлх хэмжээтэй талбайг эзэлнэ.	А. Ямар нэгэн байгалийн тогтоц болон уул, толгойн орой, шил дээр чулуу, модоор барьж байгуулсан овоо г.м. Б. Уул, мод, овоо	5.8	2.9	1.4	0.58


УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ
ТУУХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ
Масштаб 1:6 000 000
ТАНИХ ТЭМДЭГ
Улсын хил
Аймгийн хил
Аймгийн төв
Улсын хамгаалалтанд авсан дурсгалууд
Гол, мөрөн
Нуур
0
125
250
500 километр
Зурган үйлдсэн
Байгуулсан
Боловсруулсан
Соёлын өвийн үндэсний төв
Авсан хамгаалах нэмэр / С.Баасанхүү /
N


Засгийн газрын тогтоолоор хамгаалалтын бүс тогтоосон 36 дурсгалт газрын байршил
(1997-2013 он)
Таних тэмдэг
Улаанбаатар
Аймгийн төв
Хамгаалалттай дурсгалт газар
Улсын хил
Аймгийн хил
Сумын хил
Нуур
Sources: Esri, USGS, NOAA
0 145 290 580 километр


УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ
ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ
Масштаб 1:6 000 000
Улсын хамгаалалтанд авсан дурсгалууд
Хамгаалалтын бүс
Нөлөөллийн бүс


Access
Sign in
Tell me what you want to do
Table Tools
Fields
Table
File
Home
Create
External Data
Database Tools
Help
Cut
Copy
Format Painter
Paste
Views
Clipboard
Ascending
Descending
Remove Sort
Filter
Selection
Advanced
Toggle Filter
Sort & Filter
New
Save
Delete
Refresh All
Totals
Spelling
More
Records
Replace
Go To
Select
Find
Size to Fit Form
Switch Windows
Window
Calibri
11
Text Formatting
All Access Obje...
Search...
Tables
GDB_ColumnInfo
GDB_GeomColumns
GDB_ItemRelationships
GDB_ItemRelationshipTypes
GDB_Items
GDB_Items_Shape_Index
GDB_ItemTypes
GDB_ReplicaLog
GDB_SpatialRefs
Uls_data
Uls_data_Shape_Index
Нөлөөллийн_бүс
Нөлөөллийн_бүс_Shape_Index
Хамгаалалтын_бүс
Хамгаалалтын_бүс_Shape_In...
Нөлөөллийн_бүс
Uls_data
OBJECTID
Shape
Id
Name
Aimag
Sum_
Type
S_talbai
Tailbar
Angilal
BUFF_DIST
ORIG
Shape_Leng
Record: 1 of 128
No Filter
Search
Datasheet View
Num Lock
ENG
1:45 AM
12/3/2020


Table


Хамгаалалтын бүс


FID	Shape *	Id	Нэр	Анхлал	Аймаг	Сум	Хамгаалалтын зэрэг	Талбайн хэмжээ	Тайлбар
25	Polygon	35	Гандангэчэнлин хийдийн цогцолбор	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Баянгол	Улсын хамгаалалтад	7.09747	
26	Polygon	36	Гэсэр сүмийн цогцолбор	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Чингэлтэй	Улсын хамгаалалтад	0.415722	
27	Polygon	38	Чойжинламын сүмийн цогцолбор	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Сүхбаатар	Улсын хамгаалалтад	0.91104	
28	Polygon	39	Чинван Хандоржийн байшин	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Сүхбаатар	Улсын хамгаалалтад	0.283518	
29	Polygon	40	Богд хааны ногоон ордны цогцолбор	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Хан-Уул	Улсын хамгаалалтад	2.252216	
30	Polygon	41	Их тэнгэрийн аймаг хадны зураг	Хаднаах зураг, бичлэйн дурс	Улаанбаатар	Баянзүрх	Улсын хамгаалалтад	0.149697	
32	Polygon	43	Түүлын Хар түнхийн ордны түүрь	Эртний хот суц хийдийн түүр	Улаанбаатар	Хан-Уул	Улсын хамгаалалтад	8.540907	
59	Polygon	15	Аюны "Өндөр хөршөө"-ны 2 давхар бай	Сум хийд уран барилга	Улаанбаатар	Чингэлтэй	Улсын хамгаалалтад	0.268025	2009 оны 135 дугаар тогтоол ТМ эз
84	Polygon	0	Цавчбагавшвын хадны зураг	Хаднаах зураг, бичлэйн дурс	Ховд	Эрдэнэбүрэн	Улсын хамгаалалтад	12.18888	
85	Polygon	0	Сертэйн хөшөө чулуу	Хөшөө чулуун дурсгал	Ховд	Ховд	Улсын хамгаалалтад	0.081706	
86	Polygon	0	Гурван цэнхэрийн ачуйн хадны зураг	Хаднаах зураг, бичлэйн дурс	Ховд	Манхан	Улсын хамгаалалтад	8.408796	
87	Polygon	0	Ишгэн толгойн хадны зураг	Хаднаах зураг, бичлэйн дурс	Ховд	Манхан	Улсын хамгаалалтад	1.981874	
88	Polygon	0	Тахилтын хотгорын Хүннүгийн язгуурт		Ховд	Манхан	Улсын хамгаалалтад	119.025176	
89	Polygon	0	Улаан толгойн бичээс	Хаднаах зураг, бичлэйн дурс	Ховд	Мөнххайрхан	Улсын хамгаалалтад	8.644088	
90	Polygon	0	Баянзүрхийн цогцолбор дурсгал		Ховд	Мөст	Улсын хамгаалалтад	369.89855	
91	Polygon	0	Хаалгын хөтөлийн хүн чулуун хөшөө	Хөшөө чулуун дурсгал	Ховд	Цэцэг	Улсын хамгаалалтад	0.114861	
92	Polygon	0	Ямаан усны хадны зураг	Хаднаах зураг, бичлэйн дурс	Ховд	Алтай	Улсын хамгаалалтад	4.486773	
55	Polygon	11	Үүшгийн өвөрийн цогцолбор дурсгал	Хөшөө чулуун дурсгал	Хөвсгөл	Бүрэнтогтох	Улсын хамгаалалтад	231.1318896	2019 оны хэзүрийн ажил чулуун со
0	Polygon	2	Салбар уулын бичээс	Хаднаах зураг, бичлэйн дурс	Хэнтий	Мөрөн	Улсын хамгаалалтад	0.422446	
1	Polygon	3	Гэлэн гэх хүн чулуун хөшөө	Хөшөө чулуун дурсгал	Хэнтий	Мөрөн	Улсын хамгаалалтад	0.02902	
2	Polygon	6	Дуурлиг нарсны Хүннүгийн язгууртны ор	Булш оршуулга	Хэнтий	Баян-Адарга	Улсын хамгаалалтад	455.417136	
3	Polygon	7	Борбулгийн булш	Булш оршуулга	Хэнтий	Бичээр	Улсын хамгаалалтад	93.642515	
4	Polygon	9	Балдан Бэрэвэзн хийдийн цогцолбор, бу	Сум хийд уран барилга	Хэнтий	Өмнөдэлгэр	Улсын хамгаалалтад	27.252758	
5	Polygon	10	Дуулга уулын Хүннүгийн оршуулын газа	Булш оршуулга	Хэнтий	Жаргалтхаан	Улсын хамгаалалтад	17.089741	
6	Polygon	12	Аварлын балгас	Эртний хот суц хийдийн түүр	Хэнтий	Дэлгэрхаан	Улсын хамгаалалтад	39.393643	
61	Polygon	17	Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Үзүүр цох		Хэнтий	Батширээт	Улсын хамгаалалтад	11648.665807	2009 оны 135 дугаар тогтоол
64	Polygon	20	Дуча Жаргалантын цогцолбор дурсгал	Хөшөө чулуун дурсгал	Хэнтий	Өмнөдэлгэр	Улсын хамгаалалтад	4366.294547	2009 оны 135 дугаар тогтоол
65	Polygon	21	Цацэг ханы ордны цогцолбор	Сум хийд уран барилга	Хэнтий	Хэрлэн	Улсын хамгаалалтад	0.525054	2009 оны 135 дугаар тогтоол
66	Polygon	8	Өглөгчийн хэрэм	Эртний хот суц хийдийн түүр	Хэнтий	Батширээт	Улсын хамгаалалтад	72.079545	
67	Polygon	11	Рашаан хадны цогцолбор дурсгал	Хаднаах зураг, бичлэйн дурс	Хэнтий	Батширээт	Улсын хамгаалалтад	98.734862	
127	Polygon	0	Сэрвэн хавтгайны бичээс	Хаднаах зураг, бичлэйн дурс	Хэнтий	Баянхутаг	Улсын хамгаалалтад	0	2020 чулуун соёлын өв хөтөлбөр

0 (0 out of 128 Selected)

Хамгаалалтын бүс


Catalog
Add Data
Look in:
Ship_data
excel
182_data.mdb
Uls_data.gdb
Uls_data.shp
Uls_data_3bulsh.shp
Uls_data_3bulsh_5.shp
Uls_data_khentii_aimag_buffer_bulsh.shp
Uls_data_khentii_aimag_buffer_ertnii_hot.shp
Uls_data_khentii_aimag_buffer_hadnii zurag.shp
Uls_data_khentii_aimag_buffer
Uls_data_khentii_aimag_buffer
Uls_data_khentii_aimag_buffer
Uls_data_pal6km.shp
Uls_data_points.shp
Add
Cancel
Name:
Show of type:
Datasets, Layers and Results
Table Of Contents
Layers
Baynkhongor_RS_points
Zvan_dursgal
Хамгаалалтын бүс
Нөлөөллийн бүс
Улсын хамгаалалтанд авс
Uls_data_khentii_aimag_but
Polygons
Buffer_zone_polygon
Shiveetkhairkhan_Buffer_zo
Nominaled_line_polygon
File Edit View Bookmarks Insert Selection Geoprocessing Customize Windows Help
Georeferencing
1:45 AM
12/3/2020
ENG


Table Tools
Access
Sign in
File
Home
Create
External Data
Database Tools
Help
Fields
Table
Tell me what you want to do
View
Paste
Cut
Copy
Format Painter
Filter
Ascending
Descending
Remove Sort
Selection
Advanced
Toggle Filter
Refresh All
New
Save
Delete
Totals
Spelling
More
Find
Replace
Go To
Select
Size to Fit Form
Switch Windows
Calibri
11
Views
Clipboard
Sort & Filter
Records
Find
Window
Text Formatting
All Access Obje...
Search...
Tables
GDB_ColumnInfo
GDB_GeomColumns
GDB_ItemRelationships
GDB_ItemRelationshipTypes
GDB_Items
GDB_Items_Shape_Index
GDB_ItemTypes
GDB_ReplicaLog
GDB_SpatialRefs
Uls_data
Uls_data_Shape_Index
Нөлөөллийн_бүс
Нөлөөллийн_бүс_Shape_Index
Хамгаалалтын_бүс
Хамгаалалтын_бүс_Shape_In...
Нөлөөллийн_бүс
Uls_data
OBJECTID
Shape
Id
Name
Aimag
Sum_
Type
S_talbai
Tailbar
Angilal
BUFF_DIST
ORIG_
Shape_Leng
Record: 1 of 128
No Filter
Search
Datasheet View
Num Lock
ENG
1:45 AM
12/3/2020



ГХГЗГ-тай хамтын ажлын хүрээнд Улсын хамгаалалтад байх дурсгалт газрын хамгаалалтын бүс нөлөөллийн бүс татаж газрын нэгдсэн мэдээллийн санд оруулах ажилын хүрээнд 198 дурсгалт газрын байршлын мэдээллийг алдаагүй болгов. ГМС-д хамгаалалтын бүс, нөлөөллийн бүс, дурсгалт газрын атрибут 1.02 MB хэмжээтэй мэдээлэл үүсгэсэн.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.5-р арга хэмжээ

“ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД УСТАХ ЭРСДЭЛД ОРСОН ДУРСГАЛЫГ УНАГАН ГАЗРААС НЬ ЗӨӨЖ, ТЭЭВЭРЛЭН АЮУЛГҮЙ ГАЗАРТ ШИЛЖҮҮЛСЭН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 69 дүгээр тогтоол “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/368 дугаар тушаалаар “Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан билээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/368 дугаар тушаалаар батлагдсан Чулуун соёлын өв” үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.4.Устах эрсдэлд орсон дурсгалыг унаган газраас нь зөөж тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэн байрлуулах ажлыг 2020 онд хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

Соёлын сайдын 2020 оны А/15 дугаар тушаалын дагуу Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2020 оны А/20 тоот тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулан, Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа Сэргээн засварлах газрын сэргээн засварлагч Б.Даваадарь, Сэргээн засварлагч Т.Сүхбаатар, Бүртгэл судалгааны газрын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Б.Амгаланбат нарын бүрэлдэхүүнтэй баг устах эрсдэлд орсон Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөө, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Таван толгойн хүн чулуун хөшөөдийг холбогдох хууль, журмын хүрээнд, унаган газраас нь зөөж, тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Өмнө нь 2009 онд Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөөг татах ажлыг зохион байгуулах үед орон нутгийн удирдлага, иргэд малчдын зүгээс эсэргүүцэл үзүүлэн, ажилтан албан хаагчдын амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал үүсгэж, мөн тухайн орон нутгаас УИХ-д сонгогдсон гишүүдэд мэдэгдэн нөлөөлж, тухайн үйл ажиллагааг таслан зогсоож байв. Мөн 2016 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Алтан овооны хүн чулуудыг баримтжуулалтын хэмжилт хийх үед сумын удирдлага, иргэдийн зүгээс эсэргүүцэл үзүүлэн, орон нутгийн сонгуультай холбон, нам, улс төрийн зорилготой сурталчилгаа явуулж тухайн үйл ажиллагааг зогсоож байсан. Түүнчлэн Таван толгойн хүн чулуун хөшөөдийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хамтран ажиллах тухай Соёлын өвийн төвийн захирлын 2016 оны 248 тоот албан бичгийг Онгон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд явуулж байсан боловч одоог хүртэл ямар нэгэн хариу ирүүлээгүй. Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс тухайн дурсгалуудыг унаган газраас нь зөөж тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэн байрлуулах ажлыг зохион байгуулахдаа орон нутгийн удирдлагуудад мэдэгдээгүй бөгөөд харин холбогдох хуулийн байгууллагууд болох Цагдаагийн ерөнхий газрын асуудал хариуцсан ажилтан н.Билгүүдэйд амаар, Тагнуулын ерөнхий газрын дарга П.Одонбаатарт 2020 оны 10 сарын 14-ний 01/311 тоот албан бичгээр мэдэгдсэн.

Удирдамжийн дагуу бид Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөөний хоёр хугархай, нэг чулуун яст мэлхийг 2020 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1030-1330 цагийн хооронд, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Таван толгойн хоёр хүн чулуун хөшөөг 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 900-1100 цагийн хооронд ачаалж, тээвэрлэн Улаанбаатар хотод Соёлын өвийн үндэсний төвийн байранд байршууллаа.

2020 оны 10 дугаар сарын 26-ны өдөр дээрх дурсгалуудыг холбогдох хууль, журмын дагуу унаган газраас нь зөөж тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэн байрлуулах ажлыг зохион байгуулсан тухай Сүхбаатар аймгийн засаг дарга Ж.Эрдэнэбаатарт 01/323 тоот, Булган аймгийн засаг дарга З.Батзоригт 01/322 тоот албан бичгээр мэдээллийг хүргүүлсэн болно.

Могойн шинэ усны гэрэлт хөшөө









Таван толгойн хүн чулуун хөшөөд









Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.6-р арга хэмжээ. Соёлын өвийг аврах, хамгаалах, ашиглах үндэсний сүлжээг төгөлдөржүүлэх, "Чулуун соёлын өв", БСШУС-ын сайдын 2019 оны А/368 дугаар тушаал, төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6 дахь бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх

Соёлын өвийг аврах, хамгаалах, ашиглах үндэсний сүлжээг төгөлдөржүүлэх арга хэмжээ нь "Ковид-19" цар тахлын нөлөөгөөр бүрэн хийгдээгүй ч өөрсдийн нөөц боломжид тулгуурлан дараах арга хэмжээг зохион байгуулав.

Тайлант хугацаанд:

1. "Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн цогцолбор" өвийг Дэлхийн Өвд бүртгүүлэхтэй холбогдох нэмэлт засварыг бэлтгэн хүргүүлсэн. "Буган чулуун хөшөө, хүрлийн үеийн цогцолбор" дурсгалыг Дэлхийн Өвд бүртгүүлэх ажлын хүрээнд Дэлхийн Өвийн Хороо болон ИКОМОС-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу нэр дэвшүүлэх баримт бичигт нэмэх шаардлагатай 25 хуудас бүхий нэмэлт мэдээллийг ажлын хэсгийн гишүүд Соёлын Яамны Соёлын өвийн газрын дарга Б.Даваацэрэн, "Байгаль, соёлын өвийг хамгаалах сан" ТББ-ын тэргүүн Н.Уртнасан, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн секторын эрхлэгч Ц.Төрбат, Ж.Гантулга, СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах газрын Дэлхийн соёлын өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн Ц.Цолмон нар бэлтгэж, Англи хэл рүү орчуулан ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисст I, II улиралд хүлээлгэн өгсөн.

2. 2020 оны I,II улиралд "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөр-2020 төлөвлөгөөний 2.3.1, 2.3.2, 2.3.3, 2.3.6-д дурдсан дурсгалуудад хамгаалалтын хашаа, хайс барьж, танилцуулга байрлуулах арга зүй өгөх, хөшөө дурсгалыг хамгаалах хашаа барих болон түүний материалд тавигдах үндсэн шаардлагуудыг боловсруулав. Үүнд хөшөө дурсгалын тухай товч ойлголт, хамрах хүрээ, хашааг барихын өмнөх судалгаа болон бэлтгэл ажил, дурсгалын хашааг барих ерөнхий шаардлага, техникийн ерөнхий шаардлага, бүтцийн шаардлага гэсэн 5 үндсэн хэсгээс бүрдэх арга зүйн зааварчилгааг боловсруулан, ажлын зургийг Autocad программ хангамж дээр бэлтгэв.

3. Чулуун дурсгалын судалгааны бүтээлүүдийг энгийн хүмүүс уншиж ойлгоход хүнд, мөн ШУ-ны нэр томьёо ихтэй байдаг тиймээс судалгааны бүтээлүүдийг хөтөч тайлбарлагчдын ажлын хэрэгцээнд тохируулан хялбаршуулж, тэдэнд тусгайлан зориулсан агуулгаар баяжуулан хөтчийн гарын авлага буюу ном болгон 500 ширхэг хэвлэв. Гарын авлагыг ЗГХА Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ын Археологийн хүрээлэн, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг ТББ-тай хамтран бүтээв. Тус гарын авлага нь 5 бүлэгтэй. Үүнд: Удиртгал, Монгол нутаг дахь чулуун дурсгалын тухай товч танилцуулга, Нэг. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын уламжлал, шинэчлэл, Хоёр. Хадны зураг, Гурав. Буган чулуун хөшөөд, Дөрөв. Хүн чулуун хөшөөд, Тав. Эртний тахил тайлгын дурсгал ба гэрэлт хөшөөд, хавсралт, ном зүй гэсэн үндсэн агуулгатай.

4. 2020 оны 6 дугаар сард Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших олонд Цогтын хадны бичээс гэж алдаршсан Дуутын хар чулууны бичигт үүссэн тосны бохирдлыг цэвэрлэв. Дээрх дурсгалын сэргээн засварлалт, цэвэрлэгээний ажилд урьдчилан лабораторид хийсэн туршилт болон нэмэлт сорил судалгааны үр дүнд боловсруулсан арга зүйг ашигласан. Лабораторт хийсэн туршилт, урьдчилсан судалгаа нь цаашид цэвэрлэгээний арга зүй, бодис хэрэглэгдэхүүний төрөл, ажиллах төлөвлөгөө боловсруулах, үл хөдлөх чулуун дурсгалын материалын судалгаа хийж, хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тулгуурлаж чулуулгийн онцлогт таарсан сэргээн засварлалт, цэвэрлэгээний арга зүйг нутагшуулах ач холбогдолтой юм.

5. БСШУСЯ-ны дэргэдэх Палеонтологи, археологийн зөвлөлийн зөвшөөрлөөр Монголын Үндэсний музейтэй хамтран Увс, Ховд аймгийн нутагт орших зарим хадны оршуулга бүхий дурсгалт газрыг шалгах, авран хамгаалах малтлага хийсэн болно. Энэ

ажлын хүрээнд Увс аймгийн Наранбулаг сумын нутагт өмнө нь тоногдсон гэх хадны оршуулгыг шалгаж, хадны оршуулгаас илэрч иргэдийн гар дээр байсан олдворуудыг, дурсгалт газраа үлдсэн хүний яс, авсны мод зэргийн хамт аймгийн музейд шилжүүлэн өгөв. Мөн Ховд аймгийн Цэцэг, Зэрэг сумдын нутагт археологийн мэдээллийг шалгав. 5 дугаар сард хийгдсэн.

6. 2020 оны 9 дүгээр сарын 4-ны өдөр зохион байгуулагдсан Дэлхийн өв -Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны, менежментийн төлөвлөгөөний хэлэлцүүлэгт Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат оролцож “Дэлхийн өвийн дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтад соёлын өвийн бүртгэл, судалгааны үзүүлэх үүрэг, нөлөө” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Дэлхийн өвийн дурсгалт газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхдээ соёлын биет болон биет бус өвийг оршин буй байгаль, нийгмийн орчинд нь цогцоор нь хадгалж хамгаалах, судалгаанд суурилсан хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагааг тухайн өв оршин байгаа орон нутгийн иргэд, засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байгааг “Дэлхийн өв -Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” оршин буй Хэнтий аймгийн Батширээт, Өмнөдэлгэр, Төв аймгийн Мөнгөнморьт сумдын нутаг дэвсгэрт буй соёлын биет болон биет бус өвийн бүртгэл, судалгаа, хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан илтгэсэн.

7. ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн Ази, Номхон далайн бүсийн хугацаат тайланг 2021 онд бүсийн хэмжээнд хүргүүлэх ажлын хүрээнд Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад соёлын ангиллаар бүртгүүлсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаануудтай хамтран тайлангийн асуулга дээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн Дэлхийн өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч М.Цэцэнбилэг Үндэсний зөвлөхөөр томилогдон ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 10 сараас эхлэн 14 хоног тутам Дэлхийн өвийн төвөөс зохион байгуулж байгаа онлайн сургалтад хамрагдаж олон нийтийн сүлжээг ашиглан Хамгаалалтын захиргааны холбогдох мэргэжилтнүүдийг шаардлагатай мэдээллээр ханган, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Тайлангийн 1 дүгээр хэсгийг урьдчилсан байдлаар 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор хүргүүлэх бөгөөд 2 дугаар хэсгийг Дэлхийн өвийн газар нутгийн хамгаалалтын захиргаанууд 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлэхээр төлөвлөж байна. Тайланг эцсийн байдлаар 2021 оны 07 дугаар сард хүргүүлэх юм.

8. Төв аймгийн Баянцагаан сумын нутагт байрлах Монголын үеийн 2 ширхэг хүн чулуунд хүрээлэн буй орчны анхан шатны тандалт судалгаа хийж, үл хөдлөх чулуун дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэл үүсгэх суурь судалгааны аргазүйг боловсруулав.

9. Тайлант ажлын хүрээнд 6 дугаар сард Соёлын өвийн үндэсний төв нь Соёлын Өвийн Сүлжээ, Харилцаа Холбооны Зөвлөл ТББ-ийн санхүүгийн дэмжлэг, өөрсдийн нөөц боломжид тулгуурлан Архангай аймгийн Их тамир сумын Тайхар чулуу дурсгалт газар ажиллав. Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газар, Математик тоон технологийн хүрээлэнгийн судлаач мэргэжилтнүүд, Архангай аймгийн музей, Архангай аймгийн Ихтамир сумын Соёлын төвийн хамт олноос бүрдсэн баг Тайхар чулууны гадаргуу хэсгийн механик бохирдол болох будаг, сүү тосны бохирдол хими биологийн гэмтлээс хамааралтай чулуулгийн өгөршил, өнгөний гандалт, хүрээлэн буй орчны анхан шатны эрсдэлийг тодорхойлж, гэмтэл бохирдлыг цэвэрлэх, хадан дээрхи бичгийн дурсгалыг бэхжүүлэх аргазүйг боловсруулж, тус дурсгалын онцлогт тохируулан хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулах анхан шатны сорьц судалгаа, судалгаа явуулах практик сургалтыг зохион байгуулав. Тайхар чулууны хадгалалт хамгаалалтын тандалт судалгаан дээр бодит эрсдэлийн үнэлгээ гаргах ажлын модел зураг гаргасан. Цаашид тус судалгааны үр дүнд суурилсан хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.2.6-р арга хэмжээ

1. WORLD HERITAGE LIST 2020
DEER STONE MONUMNETS AND RELATED SITES, THE HEART OF BRONZE AGE CULTURE (MONGOLIA) ADDITIONAL INFORMATION OF STATE PARTY TO ICOMOS 2020/II/25

As regards the relation between deer stones and khirgisuurs, it is understood that deer stones always occur with khirgisuurs, but that there are khirgisuurs without deer stones. In the latter case, these are smaller khirgisuurs. Could further explanation be provided about the role of khirgisuurs and the narrative of the property which links them to the deer stones? In which way can we say that the deer stones and the khirgisuurs are part of the same cultural history?

Deer stones, which are a human wrapped in the ornamentation of a great stylized antlered stags, are found predominantly with more complex stone structures known as khirgisuur. The specifics of khirgisuur monumental structures are that they have big stone mounds in the center with either circular or square fences made of stones laid along the perimeter. In addition, ritual objects and structures may surround the stone framed perimeter. Deer stones are sometimes found within the perimeter of the khirgisuur stone frame, or separately a distance from the khirgisuur.

These monuments display a remarkable presentation of stone-built structure which together with Deer stone monuments demonstrate exceptional completeness of ritual and burial structures evolved within North Asian funeral cultures of nomadic people in the Bronze Age having high symbolic, cosmic endowment. The settings of khirgisuur in combination with their attendant Deer stone monuments are always characterized by great physical beauty which is a specific heritage site defined and bounded by rivers, valleys, mountains.

Many important issues related to the culture of Khirgisuur and deer stone monuments and their relationships, meanings and chronology have long been debated by scholars and even today it has not been fully solved yet. In recent years, progress has been made on the identification and research of khirgisuur and deer stone monuments and links between them.

Now in the scientific circle it is recognized that khirgisuur is a burial and sacrificial structure that belongs to “Culture of Khirgisuur and Deer Stone” already known in archeological research under this name.

Recent researches reveal that these deer stone monuments were erected in association with three kinds of stone-built funerary structures: khirgisuur, square-shaped burial mounds and dozens of sacrificial structures. It is becoming increasingly clear that deer stone is a memorial monument dedicated to the person who was buried in the Khirgisuur or burial structures. Deer stone and Khirgisuur are interlinked components of a single Late Bronze Age funerary ceremonial system dating to 1200-700 BC.

In most cases as at sites like Uushgiin Uvur and other deer stone sites with khirgisuur, apparently, deer stone monuments are erected in association with khirgisuur mounds containing human burials in shallow centrally placed pits or stone slab crypts.

Харин үүний дараа буюу 35-40 мянган жилийн үед холбогдох Германы Хохленштейн-Стадель (Hohlenstein-Stadel) агуйгаас олдсон арслан зааны ясаар хийсэн “Арслан хүн”-ий баримал, мөн нэг он цагт хамаарагдах Германы Хөхл Фелсийн Шеллингений (Venus of Hohle Fels) арслан зааны ясаар хийсэн эмэгтэй хүний баримал гэсэн хоёр ясан баримал нь оюун ухаант хүмүүсийн хийсэн анхны бүтээлүүд хэмээн тооцдог ажээ.

Дэлхий дээрх хамгийн эртний чулуугаар хийсэн хүн дүрс хөшөө бол НТӨ 9000 оны үед хамаарагдах Туркийн зүүн өмнөд хэсэг, Балыклыгөлийн малтлагаас олдсон “Урфа хүн” юм. Энэхүү хөшөө нь 1,9 м орчим өндөртэй бөгөөд нүдний ухархайнд хар обсидиан суулгаж, хүзүүнд нь гурвалжин хэлбэрийн зүүлт эсвэл хувцасны энгэр дүрслээд хоёр гарын урдаа барьсан байдлаар бүтээжээ.

Тав. Эртний тахил тайлгын дурсгал ба гэрэлт хөшөөд бүлэг нь 12 гэрэл зурагтай.

Дэлхийн эртний түүхт улс гүрнүүд тухайн үедээ өөрсдийн туулж өнгөрүүлсэн түүх болон ихэс дээдэс, баатар эрсийн алдар гавьяаг үеийн үед мөнхжүүлэх зорилгоор хөшөө чулуу босгон бичмэл түүхээ сийлбэрлэн үлдээж байсан бөгөөд түүнийг манай эх хэлнээ гэрэлт хөшөө хэмээн нэрийддэг.

Эрдэмтэд дэлхийн бүх бичээсүүд эртний Шумерээс (Месопотами) үүсч, тэндээс соёлын тархалтын үйл явцаар дамжин бүх нутагт тархсан гэж үздэг байжээ. Гэвч Ойрхи Дорнодын эх сурвалжаас алсагдсан эртний Месоамерикийн бичгийн дурсгалыг нээсэн нь бичиг үсэг нэг бус удаа бие даан хөгжсөн болохыг хүлээн зөвшөөрөх эхлэл болсон юм. Одоо Месопотами (НТӨ 3400-3000 оны хооронд), Египет (НТӨ 3250 оны орчим), Хятад (НТӨ 1200 оны орчим), Өмнөд Мексик, Гватемалын нам дор газар (НТӨ 500 оны орчим) гэсэн дөрвөн газарт бичиг үсэг үүссэн хэмээн судлаачид үздэг байна.

4. ДУУТ ХАР БИЧЭЭСИЙН ГАДАРГУУ ХЭСГИЙН БОХИРДОЛ ЦЭВЭРЛЭСЭН ТАЙЛАН

1. Удирдамж

Цогтын “Дуут хар чулууны бичиг” -ийг их хэмжээний тос болгон анхны хэлбэр төрхийг алдагдуулсан зөрчил илэрч, уг зөрчлийг арилгуулахаар мэргэжлийн хяналтын Боловсрол, Соёл хариуцсан улсын байцаагч, Төв аймгийн Музейн захирлын 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн №41 албан тоот бичгээр Соёлын өвийн үндэсний төвд “Сэргээн засварлуулах хүсэлт”, Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга Д.Жаргалмаад Музей захирлын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Хуулийн хэрэгжилт хангаж ажиллах тухай” №43 албан тоотын хүсэлтийн дагуу СӨҮТ-ийн ЗУГ-ын дарга О.Мэндсайхан, СБӨСЗГ-ын дарга ерөнхий технологич М.Оюунтулга, сэргээн засварлагч А.Мөнгөнцоож, сэргээн засварлагч Э.Батжаргал, жолооч Д.Шижир нарын судалгааны баг 2020 оны 06 сарын 21-22 өдөр Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт уг дурсгал дээр сэргээн засварлах бохирдлын цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Судалгаа ба зорилго

Албан тоотын мэдээлэл авсны дараа судалгааны баг СӨҮТ-ийн СБӨСЗГ-ын 2011 онд уг дурсгалаас хуулбар авах үед өнгө будгийн ажилд харьцуулалт хийхээр ойр орчмоос авчирсан чулуун дээж үлдсэн байсан хэсэгт цэвэрлэгээний арга зүй, бодис хэрэглэгдэхүүний төрөл, ажиллах төлөвлөгөө боловсруулах, үл хөдлөх чулуун дурсгалын материалын судалгаа хийж, хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тулгуурлаж чулуулгийн онцлогт таарсан сэргээн засварлалт, цэвэрлэгээний арга зүйг нутагшуулах зорилгоор лабораторийн сорил туршилт явуулсан.

3. Судалгааны арга зүй

3.1 Чулуулгийн материал судлал ба онцлог

3.2 Чулуулгийн өнгө

3.3 Усны агууламжийг тогтоох туршилт

3.4 Чулуулгийн тосны шингэлтийг ажиглах туршилт

3.4 Чулуулгийн тосны бохирдлыг цэвэрлэх туршилт гэсэн дарааллын дагуу судалгааны ажил хийж гарсан үр дүнд тулгуурлан арга зүй болоод ашиглах бодис хэрэглэгдэхүүнээ сонгон авч газар дээр нь ажилсан.

ДҮГНЭЛТ

Дуутын хар чулуун дурсгалын тосны бохирдлыг цэвэрлэх аргазүй нь үр дүнтэй болсон хэдий ч дурсгалын хувьд байгалийн хүчин зүйлээс хамаарах чулуулагт муугаар нөлөөлөх эрсдэлтэй орчны нөлөөнд байна. Механик болон химийн гэмтлээс хамаарах өгөршил, гадаргуу болон их биеийн хэсэгт хагарал явагдаж, биологийн гэмтэл зэрэг орчноос хамаарах бүхий л хүчин зүйлийн нөлөөлөлд уг дурсгал нь муудаж удаан хугацааны өгөршил явагдсаар байна. Цаашид чулуулгийн материалын судалгааг хүрээлэн буй орчны судалгаатай хослуулж механик болон хими, биологийн гэмтлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах арга зүйг дурсгалын онцлогт тааруулж нутагшуулах судалгааг хийх шаардлагатай байна. Манай орны үл хөдлөх дурсгалын хувьд хадгалалт хамгаалалтын судалгаа болон эрсдэлийг тодорхойлох бие даасан нарийвчилсан судалгааны арга зүй боловсруулж судалгаа хийсэн жишиг одоогоор цөөхөн хэдхэн эхлэл судалгаа төдий хэмжээнд байна. Тиймээс энэхүү судалгаагаар үл хөдлөх дурсгалд муугаар нөлөөлж буй орчны судалгааг олон талаас нь хийж, дурсгалын онцлог болон хүрээлэн буй орчны судалгааг нарийвчлан хийж, ажиглалт хийсний дүнд хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх арга зүй боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Дуутын хар чулуун дурсгалын чулуулгийн хувьд магмын гаралтай бялхмал

чулуулаг бөгөөд маш хатуу сайн чанартай чулууны төрөлд ордог учраас бусад хувирмал болон тунамал чулуулгийг бодвол хүрээлэн буй орчны нөлөөлөлд орох нь бага байдаг хэдий ч цаашид урт хугацааны явцад гэмтэл явагдаж өгөрших бүрэн эрсдэлтэй байна. Тиймээс цаашид ил чулуун дурсгалыг хадгалж хамгаалах хүрээнд:

1 Байгаль орчин хүрээлэн буй орчныг сайжруулах

2 Механик болон хими, биологийн гэмтлийг зогсоож, багасгах

3 Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засвар хийж, энэ удаагийн гэмтэл болох хүний нөлөөтэй механик гэмтлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхааруулга хаяг самбар зэргийг нэн яаралтай дурсгалын ойр орчимд тавих шаардлагатай байна.




5. УВС, ХОВД АЙМГИЙН ЗАРИМ СУМДАД МЭДЭЭ ШАЛГАСАН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Гарчиг

1. Танилцуулга.....
2. Буган хөшөө.....
3. Хиригсүүр.....
4. Хадны зураг ....
5. Хүннү булш .....
6. Түрэгийн үеийн хүн чулуу .....
7. Тамга тэмдэгтэй хөшөө чулуу бүхий тахилгын онгон.....
8. Дөрвөлжин хашлага бүхий тахилгын онгон .....
9. Түрэгийн тахилгын онгон.....
10. Руни бичээс, тамга тэмдэг.....
11. Уйгарын үеийн хүн чулуу.....
12. Хадны оршуулга.....
13. Судалгааны товч үр дүн.....
14. Холбогдох бичиг баримт .....

Танилцуулга

Монголын Үндэсний музей болон МУИС-ийн Түрэг судлалын хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв хамтран Монголын баруун бүс нутагт хийсэн энэхүү судалгааны явцад бид нийт 9 аймгийн нутаг дамжин 4000 км орчим замыг 12 хоногт туулан, эртний нүүдэлчдийн түүх соёлд хамаарах буган хөшөө 4, хиригсүүр 1, Хүннү булш бүхий дурсгалт газар 1, Түрэгийн үед холбогдох 20 хүн чулуу бүхий тахилгын онгон, дөрвөлжин хашлага дотор босгосон тамга тэмдэгтэй хөшөө чулуу бүхий тахилгын онгон 4, дөрвөлжин хашлагатай хөшөө чулуу бүхий тахилгын онгон 2, тамга тэмдэгтэй хадны зураг 2, баларч муудсан бичээс бүхий 2 дурсгал, түрэг бичээс бүхий 1 дурсгалт газар, Уйгурын үед холбогдох хүн чулуу 2, хадны оршуулга 3 буюу нийт 41 дурсгалыг янз бүрийн түвшинд баримтжуулан судалж, танилцлаа.




1	Хөшөөтийн гарам	8	Цумархай	15	Манхан	23	Сондуулийн гол
2	Тариат	9	Огзом	16	Цагаан хөшөөт	24	Морь тавьдаг хаг
3	Цонжийн сүүл	10	Чандманы цагаан хөшөө	17	Толь булгийн ганууд	25	Сондуулийн гол
4	Тэмээн чулуу	11	Бэлэн булаг	18	Хүрэн үзүүр	26	Бага баавай уул
5	Дулаан бууриин орой	12	Сумын төв	19	Хүрэн үзүүр	27	Гангын даваа
6	Жаажаагийн хөтөл	13	Завсрын булгийн эх	20	Хүрэн үзүүр	28	Бичигт хад
7	Хөшөөт	14	Загтын ам	21	Хавтгай сээр	29	Замын бууц
				22	Хавтгай сээр	30	Улаан цохиот

Судалгааны замын чиглэл, дурсгалын дэвсгэр зураг

Эдгээр дурсгалаас урьд өмнө судалгаанд хамрагдаагүй шинээр бүртгэн баримтжуулсан дурсгал цөөнгүй. Үүнд Завхан аймгийн Сонгино сум Цонжийн сүүлийн 1

буган хөшөө, Увс аймгийн Наранбулаг сумын Хөшөөтөд 1 буган хөшөө, Өмнөговь сумын Хүрэн үзүүрт 1 хүннүгийн оршуулгын газар, Сагил сумын Бэлэн булагт 1 хүн чулуу, Наранбулаг сумын Цумархайд 2 хүн чулуу, Өмнөговь сумын Толь булагийн гануud 1 хүн чулуу буюу нийт 4 хүн чулуу, тамга тэмдэгтэй 4 хөшөө чулуу, тамга тэмдэгтэй хадны зураг 2, баларч муудсан хадны бичээс бололтой 2 дурсгалт газар, Увс аймгийн Наранбулаг сум Дулаан буурийн орой, Ховд аймаг Зэрэг сум Гангын даваа зэрэг газар 2 хадны оршуулга, нийт 17 дурсгал багтана.

Судалгааны явцад бүртгэн баримтжуулсан хүн чулуудын ихэнх нь харьцангуй бүрэн бүтэн хадгалагдаж үлдсэн боловч цөөн тооны дурсгалт газарт буй хүн чулууд ихэд гэмтэж, хугарсан байдалтай байна. Тухайлбал, Увс аймгийн Наранбулаг сумын нутаг Жаажаагийн хөтөл хэмээх газарт буй уран нарийн хийцтэй хоёр хүн чулуу хугарч, хагарсан, олон хэсэг болж бутарсан, Сагил сумын Бэлэн булагт буй хүн чулуу нүүрэн хэсэг нь холторч үгүй болсон, дундуураа хуваагдсан байдалтай байгаа тул яаралтай сэргээн засах шаардалагатай болсныг цохон дурдмаар байна.



1	Загпын ам	6	Хавтгай сээр	11	Бэлэн булаг	16	Тэмээн чулуу	21	Улаан цохиот
2	Завсрын булгийн эх	7	Хавтгай сээр	12	Сондуулийн гол	17	Цумархай	22	Цагаан хөшөөт
3	Манхан	8	Хүрэн үзүүр	13	Огзом	18	Жаажаагийн хөтөл	23	Чандманы цагаан хөшөө
4	Толь булгийн гануу	9	Морь тавьдаг хаг	14	Тэмээн чулуу	19	Бичигт хад		
5	Сумын төв	10	Сондуулийн гол	15	Тэмээн чулуу	20	Замын бууц		

Түрэг Уйгурын үед холбогдох дурсгалын дэвсгэр зураг

БУГАН ХӨШӨӨ

1. Хөшөөтийн гарамын буган хөшөө

Архангай аймгийн Хотонт сумын төвөөс урд зүгт 30 орчим кт зайд 2 буган хөшөө байна. Тус буган хөшөөд нь УӨ 49°49′28,9, ДУ 106°57′54,9 цэгийн солбицолд далайн түвшинөөс дээш 896 метрийн өндөрт байрлана. **(Зураг 1)**



Зураг 1. Хөшөөтийн гарамын буган хөшөө

1-р буган хөшөө: Баруун талд буй буган хөшөөг 1-р буган хөшөө хэмээн дугаарлав. Тус хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. 178 см өндөр, 48 см өргөн, 40 см зузаан хэмжээтэй. Дүрслэлийн хувьд тус буган хөшөөний дээд талд хүний нүүрний ерөнхий дүрслэл гаргаж түүний доод хэсэгт буга болон чоно хэлбэрийн дүрслэлтэй бүс, сүх, хутга, бамбай зэргийг сийлжээ. **(Зураг 2)**



Зураг 2. Хөшөөтийн гармын 1-р буган хөшөө

2-р буган хөшөө: 1-р буган хөшөөнөөс зүүн зүгт 10 м орчим зайд тахилын байгууламжийн гол дунд байна. тус хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар хийсэн байна. 181 см өндөр, 54 см өргөн, 34 см зузаан хэмжээтэй. Дүрслэлийн хувьд буга, бамбай, сүх, зээтүү зэргийг дүрсэлжээ. 3 тал нь салхинд элэгдэж ихэд бүдгэрсэн байна. **(Зураг 3).**



Зураг 3. Хөшөөтийн гарамын 2-р буган хөшөө

2. Цонжийн сүүлийн буган хөшөө

Завхан аймгийн Сонгино сумын нутаг УӨ 48°58′23,2, ДУ 96°14′00,1 цэгийн солбилцолд Цонжийн сүүл хэмээх газар нэгэн жижиг товцог дээр нэгэн буган хөшөө байна. Тус хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. 181 см өндөр, 58 см өргөн, 24 см зузаан хэмжээтэй. Дүрслэлийн хувьд ээмэг, бүс, зэр зэвсгийн зүйлс дүрсэлсэн байна. **(Зураг 4)**



Зураг 4. Цонжийн сүүлийн буган хөшөө

3. Хөшөөтийн буган хөшөө

Увс аймгийн Наранбулаг сумын нутаг Алдар багийн төвөөс баруун хойш 2 км орчим зайд УӨ 49°75′52,7, ДУ 92°47′64,6 цэгийн солбилцолд Хөшөөт хэмээх газар хиригсүүрийн өмнө талд зоолттой 1 буган хөшөө байна. Тус хөшөөг хүрэн улаан өнгийн боржин чулуугаар хийсэн. Дүрслэлийн хувьд ээмэг хүзүүний зүүлт, бамбай, чинжаал хутга, саадаг зэргийг сийлсэн байна. **(Зураг 5)**






Зураг 5. Хөшөөтийн буган хөшөө

ХИРИГСҮҮР

1. Тариатын хиригсүүр

Архангай аймгийн Тариат сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км зайд УӨ 48°09′17,5, ДУ 99°26′02,4 цэгийн солбилцолд нэгэн том хиригсүүр байна. Тус хиригсүүрийн голын овоолго 5 м орчим өндөр, дугуй хүрээ 130 м, голын овоолго 68 м хэмжээтэй. Дугуй хүрээтэй урд талдаа тахилгын байгууламжтай. **(Зураг 6)**



Зураг 6. Тариатын хиригсүүр

ХАДНЫ ЗУРАГ

1. Тэмээн чулууны хадны зураг

Увс аймгийн Наранбулаг, Өмнөговь сумын зааг дээр Өмнөговь сумын төвөөс зүүн зүгт 40 орчим км зайд УӨ 49 24 48.50 ДУ 92 3 50.8 цэгийн солбилцолд олон тооны янгир бугыг бэлчиж буйгаар дүрслэн зурсан байна. ***(Зураг 7)***







Зураг 7. Тэмээн чулууны хадны зураг

2. Хүрэн үзүүрийн хадны зураг

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс урд зүгт 14 км зайд УӨ 48°59′02,5, ДУ 91°44′47,9 цэгийн солбилцолд Хүрэн үзүүр хэмээх газар олон тооны хадны зураг, булш хиргисүүр, хөшөө чулууд байна. Хүрэн үзүүрийн хадны зургийг археологич Д.Цэвээндорж, Б.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй "Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний анги" 1989 онд бүртгэжээ[1]. **(Зураг 8)**



вээндорж Д., Энхбат Б., 1989. Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний ангийн ан. // Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан 1987-1989. Боть VIII. 2016. Улаанбаатар




Зураг 8. Хүрэн үзүүрийн хадны зураг

ХҮННҮ БУЛШ

1. Хүрэн үзүүрийн хүннү булш

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс зүүн урагш 15 км зайд Хүрэн үзүүр хэмээх газар УӨ 48°59′08,9, ДУ 91°45′32,1 цэгийн солбилцолд 12 ширхэг хүннү булш байна. Хамгийн том нь 5 м хэмжээтэй. **(Зураг 9)**



Зураг 9. Хүннү булшны дэвсгэр зураг

ТҮРЭГИЙН ҮЕИЙН ХҮН ЧУЛУУ

1. Жаажаагийн хөтөлийн цогцолбор дурсгал

Увс аймгийн Наранбулаг сумын Алдар багийн нутаг Жаажаагийн хөтөл хэмээх газарт Хүрэл, төмрийн түрүү үе болон Түрэгийн үед хамаарах булш, хиригсүүр, тахилгын онгон, хүн чулууд бүхий цогцолбор дурсгал бий.**(Зураг 10аб ,11)** Уг дурсгал нь Алдар багийн төвөөс зүүн тийш 1 км орчим зайд, УӨ 49 43.00.3, ДУ92 33.29.0 цэгийн солбицолд ДТД 1885 м өндөрт оршино. Анх 1970 онд археологич Н.Сэр-Оджав эл дурсгалт газрын хүн чулуудын тухай товч тодорхойлолтыг өөрийн бүтээлдээ хэвлүүлж, судалгааны эргэлтэд оруулжээ[2]. Хожим судлаач Т.Бямбадорж, Ч.Амартүвшин нарын Увс аймгийн нутаг дахь хүн чулуудын бүртгэл судалгааны өгүүлэлд дахин нийтлэгдсэн[3]. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Жаажаагийн хөтөлийн хүн чулуудыг аймгийн хамгаалалтад авсан байна[4].

Дээр дурдсан судалгааны бүтээлүүдэд зөвхөн хүн чулуудын тухай дурдсан бөгөөд бусад дурсгалын талаар огт дурдаагүй орхигдуулжээ. Тиймээс бид анх удаа Жаажаагийн хөтөл дэх эртний түүхэн дурсгалуудын талаар бүрэн хэмжээний мэдээ баримтыг бүрдүүлэхийг зорилоо.

Бидний хийсэн судалгааны баримтжуулалтаар энд янз бүрийн цаг үед хамаарах, хоорондоо харилцан адилгүй зайтай 10 орчим дурсгал байна. Үүнд: дугуй чулуун дараастай булш 5, том хиригсүүрийн хойд талд байдаг зүүн талдаа жижиг дугуй байгууламжтай тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэрийн чулуун дараас 1, 8 чулууг нэлээд том тойргоор тойруулан өрсөн байгууламж 1, хүн чулуу, зэл чулуутай тахилгын онгон 2, хүн чулуугүй, зэл чулуутай дөрвөлжин тахилгын онгон 1, дугуй хүрээтэй хиригсүүр 1, сүүлд хүмүүс овоолсон бололтой жижиг чулуун овоолго 1 тус тус байна (Зураг). Өөрөөр хэлбэл энд Хүрлийн дундад үеэс Түрэгийн үе хүртэлх буюу НТӨ II мянганы сүүлээс НТ-ын VIII зуун хүртэлх түүхэн үед холбогдох дурсгалууд нэг дор цогцолбор байдлаар оршино.


Өмнөх судалгааны бүтээлүүдэд хүн чулуудын гэмтэл, хадгалалтын байдлын талаар тодорхой мэдээ дурдаагүй боловч 1998 онд Т.Бямбадорж, Ч.Амартүвшин нарын хэвлүүлсэн тойм гар зурагт нэг хүн чулуу нь бүтэн, нөгөө хүн чулууны толгой хэсгээс

[2] Сэр-Оджав Н. Эртний түрэгүүд // Studia archaeologica. Tom. V, Fasc. 2. УБ., 1970.
[3] Бямбадорж Т., Амартүвшин Ч. Увс аймгийн нутаг дахь Түрэгийн үеийн зарим хүн чулууд // Studia archeologica. Tom. XVIII, Fasc. 10. УБ., 1998, т. 116-124.
[4] http://www.monheritage.mn/mn/Immovable/Content.aspx?ContentID=2

хагарч унасан байдалтай дүрслэгдсэн байна. Үүнээс харахад харьцангуй бүрэн бүтэн байжээ. Харин биднийг очиход шаргал боржин чулуугаар хийсэн хүн чулуу нь тэг дундууpаа хугарсан, хөх боржин чулуугаар хийсэн хөшөөний эх бие болон толгой хэсэгт тус тус ташуу хугарч, толгойнооё хагарч унасан хэсэг дахин хоёр хэсэг болон хагарсан төдийгүй, хугарсан хэсгүүдийн ирмэгүүд энд тэндээ бутарч маш их гэмтжээ. Хоёр хүн чулууны хийц хэлбэр үнэхээр нарийн сайхан боловч өдгөө маш ихээр эвдэрч гэмтсэн тул яаралтай сэргээн засах зайлшгүй шаардлагатай болжээ.



Зураг 10а. Жаажаагийн хөтөлийн дэвсгэр зураг



Зураг 10б. Жаажаагийн хөтөлийн дэвсгэр зураг



Зураг 11. Жаажаагийн хүн чулууд

1-р хүн чулуу: Шаргал боржин чулуугаар хийсэн. Өндөр 162, өргөн 36 см, зузаан 17 см. Ар талын тахилгын хайрцаг нь 350х340 см хэмжээтэй. Энгэр задгай гурвалжин захтай дээл, тоорцог малгай өмсөж, цэцгэн хээтэй дөрвөлжин товруу чимэг бүхий бүс бүсэлж, бүснээс баруун ташаанд дугираг хавтага, урд талд чагтан балтагтай махир сэлэм агсаж, баруун чихэндээ үрлэн унжлагтай цагираг ээмэг зүүж, баруун гараа тохойгоор нугалан элгэндээ нааж, тагнай хээтэй тунраа хундага түшиж, зүүн гараа бүсэнд хавчуулсан, өргөн шанаа, бахим түүшин бүхий эрүүтэй, урт шулуун хамар, хүнхэр нүд, нуман хөмсөг, живэр сахалтай, уруулаа үл мэдэг цорвойсон, зузаавтар чихтэй эрэгтэй хүнийг уран нарийн сийлжээ. Гэвч хөшөөний ар тал хавтгай бөгөөд ямар нэгэн сийлбэргүй. Өдгөө хөшөө бүсний дээх талаар хугарч хоёр хэсэг болжээ. **(Зураг 12)**



Зураг 12. Жаажаагийн хөтөлийн хүн чулуу

2-р хүн чулуу: Хөх саарал өнгийн сайрмаг боржин чулуугаар хийсэн. 154 см өндөр, 53 см өргөн, 30 см, зузаан хэмжээтэй. Тахилгын байгууламжийн хэмжээ 375х430 см. Уг хүн чулуу нь хэлбэр хийцийн хувьд эхний хүн чулуутай төстэй бөгөөд баруун гараа нугалан

элгэндээ авч сав барин, зүүн гараараа бүсэндээ зүүсэн сэлэмний ишнээс барьжээ. Ихэд гэмтсэн, хөдөлгөх боломжгүй тул нарийн тодорхойлж чадсангүй. **(Зураг 13)**



Зураг 13. Жаажаагийн хөтөлийн хүн чулуу

2. Цумархай хүн чулуу

Увс аймгийн Наранбулаг сумын нутаг Алдар багийн төвөөс баруун хойш 2 км орчим зайд УӨ 49 46 27.3, ДУ 92 26 30.7 цэгийн солбилцолд Цумархай хэмээх газар хоорондоо 100 орчим м зайтай 2 хүн чулуу байна.

1-р хүн чулуу: Зэрэгцээ 2 Түрэгийн тахилын онгоны зүүн талын талын тахилын онгоны урд талд нэгэн хүн чулуу байна. Тус хүн чулууг цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. хүн чулууны нүүр хэсэг азимутын 140 хэмд чиглэсэн. 104 см өндөр, 30 см өргөн, 20 см зузаан хэмжээтэй. Тахилын онгон 2.3х2.9 м хэмжээтэй. Дүрслэлийн хувьд нуман

хөмсөг, хүнхэр нүд шулуун хамар гарган хүний нүүрний ерөнхий тэг гаргажээ. **(Зураг 14)**



Зураг 14. Цумархайн 1-р хүн чулуу

2-р хүн чулуу: 1-р хүн чулуунаас баруун тийш 100 м орчим зайд зэрэгцээ 2 тахилын онгоны зүүн талын тахилын онгон урд талд босоо нэгэн хүн чулуу байна. хүн чулууны нүүр хэсэг нь азимутын 120 хэмд чиглэсэн. Хүн чулуутай тахилын онгоны балбал хоорондоо 5 м зайтай 17 чулуу байна. Тахилын онгон 2.8х2.5 м хэмжээтэй. Дүрслэлийн хувьд хүний нүүрний ерөнхий тэг гаргаж нуман хөмсөг, хүнхэр нүд, шулуун хамар, үл мэдэг жимийсэн уруул гаргасан байна. мөн зүүн гараа цээжэн тус газар барьжээ. **(Зураг 15)**



Зураг 15. Цумархайн 2-р хүн чулуун хөшөө

3. Огзомын хүн чулуу

Увс аймгийн Улаангом сумын төвөөс баруун зүгт 3 км орчим зайд УӨ 49 57 43.1 ДУ 91 58 41.4 цэгийн солбилцолд зүүнээс баруун тийш цуварсан 4 тахилын онгон 3 хүн чулуу байна. Мөн тус дурсгалт газрын ойр орчим олон тооны том жижиг хиригсүүр байна. **(Зураг 16)**



Зураг 16. Огзомын хүн чулууд

1-р хүн чулуу: Тус хүн чулуу нь буган хөшөөг засаж хүн чулуу болгон ашигласан байна. 134 см өндөр, 47 см өргөн, 48 см зузаан хэмжээтэй. Тахилын онгон 3.5х3.3 м хэмжээтэй. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. **(Зураг 17)**



Зураг 17. Огзомын 1-р хүн чулуу

2-р хүн чулуу: 1-р хүн чулуунаас зүүн тийш 4 м орчим зайд дөрвөлжин хашлагын өмнө талд босоо нэгэн хүн чулуу байна. 42 см өндөр, 23 см өргөн, 17 см зузаан хэмжээтэй. Тахилын онгон 2.7х2.6 м хэмжээтэй. Дүрслэлийн хувьд улаан шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. хүний нүүрний ерөнхий тэг гаргаж нуман хөмсөг, шулуун хамар, ам гаргасан байна. **(Зураг 18)**



Зураг 18. Огзомын 2-р хүн чулуу

3-р хүн чулуу: 2-р хүн чулуунаас зүүн тийш 5 м орчим зайд дөрвөлжин хашлагын өмнө талд босоо нэгэн хүн чулуу байна. Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. 66 см өндөр, 40 см өргөн, 43 см зузаан хэмжээтэй. Тахилгын онгон 2.8х3 м хэмжээтэй.**(Зураг 19)**



Зураг 19. Огзомын 2-р чулуу

4. Увс аймгийн Сагил сумын төв хүн чулуу

Увс аймгийн Сагил сумын төвд УӨ 50 20 10.3, ДУ 91 36 37.1 цэгийн солбилцолд, хуучин музейн барилгын гадна талд 2 хүн чулуу босгосон байна.

1-р хүн чулуу: Бид урд талд буй хүн чулууг 1-р хүн чулуу хэмээн дугаарлав. Хөх өнгийн чулуугаар хийсэн. 145 см өндөр, 27 см өргөн, 22 см зузаан хэмжээтэй. Урт шулуун хамар, хүнхэр нүдтэй, үл мэдэг жимийсэн амтай, хоёр талдаа “С” хэлбэрийн чихтэй баруун гараа нугалж жижиг хундага барьсан, зүүн гараа хагас нугалж сэлэм атгасан, дөрвөлжин ялтаст товруу бүхий бүстэй, урд талдаа бүснээсээ хутга зүүсэн, баруун ташаандаа унжлага бүхий хэт зүүсэн байна. Тус хүн чулууг сумын төвөөс баруун хойно 15 км орчимд орших Боролдой тавиач гэдэг газраас 1960-аад онд Гомбын Энхээ гэдэг хүний аман тушаалаар зөөж авч ирсэн гэж Соёлын төвийн эрхлэгч байсан Энхчмээ мэдээлэв. **(Зураг 20)**



Зураг 20. Сагил сумын төвийн 1-р хүн чулуу

2-р хүн чулуу: 1-р хүн чулуунаас хойд зүгт 10 м орчим зайд байна. Хөх саарал өнгийн чулуугаар хийсэн. 113 см өндөр, 48 см өргөн, 20 см зузаан хэмжээтэй. Тоорцог малгай, нуман хөмсөг, хүнхэр нүд, “С” хэлбэрийн чихтэй үрлэн унжлагатай цагариг ээмэг зүүсэн баруун гараа нугалан хундага сав барьж, зүүн гараа хагас нугалсан байна. Тус хүн чулууг сумын төвөөс баруун урагш 7-8 км орчимд орших Хоолын сарьдаг гэдэг газраас 1960-аад онд Гомбын Энхээ гэдэг хүний аман тушаалаар зөөж авч ирсэн гэж Соёлын төвийн эрхлэгч байсан Энхчмээ мэдээлэв.**(Зураг 21)**



Зураг 21. Сагил сумын төвийн 2-р хүн чулуу

5. Бэлэн булагийн хүн чулуу

Увс аймгийн Сагил сумын төвөөс баруун урагш 10 орчим км зайд УӨ 50°30′24,7, ДУ 91°51′70,9 цэгийн солбилцолд Бэлэн булаг хэмээх газар тахилын онгоны урд талд босоо нэгэн хүн чулуу байна. 90 см өндөр, 35 см өргөн, 15 см зузаан хэмжээтэй. Тахилын онгон 330х310 см хэмжээтэй. Тус хүн чулуу нь тал дундуураа хугарсан, толгойн нүүрэн хэсэг нь холторч үгүй болсон бүрэн дүрслэлтэй байсан бололтой .Баруун гараа хагас нугалсан зүүн гараа хутга барьсан, дөрвөлжин ялтсан чимэгтэй, дугараг аралтай бүстэй. **(Зураг 22)**



Зураг 22. Бэлэн булагийн хүн чулуу

6. Толь булагийн ганууГийн хүн чулуу

Увс аймгийн Өмнөговь сумын 2-р багын төвөөс зүүн урагш 10 км зайд УӨ 48 53 25.5, ДУ 91 23 31.6 цэгийн солбилцолд, далайн түвшнээс дээш 1343 м Толийн гануу хэмээх газар нэгэн хүн чулуу байна. Тус хүн чулууг улаан өнгийн боржин чулуугаар хийсэн заримдаг дүрслэлтэй. 76 см өндөр, 28 см өргөн, 16 см зузаан хэмжээтэй. Хүний нүүрний ерөнхий тэг гаргаж, хүнхэр нүд, шулуун хамар гарган дүрсэлжээ. **(Зураг 23)**



Зураг 23. Толь булагийн ганууугийн хүн чулуу

7. Хавтгай сээрийн хүн чулуу

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс 16 км орчим зайд УӨ 48˚ 58’ 26.4”, ДУ 91˚ 45’ 58.1” солбицолд буюу Хавтгай сээрийн заагт улаан хүрэн өнгийн толгойтой, толгойгүй хоёр хүн чулуу бий. Уг хүн чулууд нь бүрэн дүрслэлтэй ажээ. **(Зураг 24)**



Зураг 24. Хавтгай сээрийн хүн чулууд

1-р хүн чулуу. Уг хүн чулуу нь дөрвөлжин хашлаганы урд талд газарт унаж эх биеийн тал нь шороонд булагдсан байдалтай байна. Хүн чулуу нь 105 см өндөр, 42 см өргөн, 20 см

зузаан. Дүрслэлийн хувьд бүрэн дүрслэлтэй нүүр, хамар ам, живэр сахал, баруун гартаа хундага барьсан, зүүн гартаа сэлэм барьж, баруун хажуудаа талдаа хавтага зүүсэн байна.Уг хүн чулууны бүсийг цэглэж цохих аргаар хийсэн бөгөөд нүүрэн тал болон баруун, зүүн хажуугаар тод мэдэгдэнэ. Хашлага чулууны хэмжээ нь ойролцоогоор 240х240 см. **(Зураг 25)**



Зураг 25. Хавтгай сээрийн 1-р хүн чулуу

2-р хүн чулуу. Энэхүү хүн чулуу нь дөрвөлжин хашлаганы өмнө талд толгойгүй унасан байдалтай байна. Хүн чулууг улаан хүрэн өнгийн чулуугаар хийсэн бөгөөд нь баруун гартаа хундага, зүүн гартаа сэлэм барьсан, баруун хажуудаа бүснээс хавтага зүүжээ. 80 см өндөр, 31 см өргөн, 20 см зузаан хэмжээтэй. Хашлага чулуу 240х220 см хэмжээтэй. **(Зураг 26)**



Зураг 26. Хавтгай сээрийн 2-р хүн чулуу

8. Сондуулийн голын хүн чулуу

Морь тавьдаг хагийн түрэгийн тахилын байгууламжаас урд зүгт 2 км зайд Ховд аймгийн Мянгад сумын нутаг Сондуулийн гол хэмээх газар УӨ 48 53 10.5 ДУ 91 47 26.9 цэгийн солбилцолд буган хөшөө ашиглан босгосон бүрэн дүрслэлтэй хүн чулуу байна. Цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. 138 см өндөр, 36 см өргөн, 21 см зузаан хэмжээтэй. Нуман хөмсөг, хүнхэр нүдтэй, шулуун хамар, живэр сахал жимбэгэр уруул, “С” хэлбэрийн чих болон цагариг унжлагатай ээмэг дүрсэлжээ. Баруун гараа бүтэн нугалж цээжин тус газраа хундага барьсан, баруун гараа хагас нугалж сэлэм барьжээ.**(Зураг 27)**





Зураг 27. Сондуулийн голын хүн чулуу

9. Манханы хүн чулуу (Майхан толгойн хүн чулуу)

Баяннуур сумаас баруун хойд зүг 3.5 км зайд, баруунаас орж ирсэн амны адагт боржин чулуугаар үйлдсэн нэгэн хүн чулуу бий. Ховд голын баруун эрэгт, голоос 1.3 км, Манхан хэмээх газар байгуулсан орчин цагийн казакуудын оршуулгын газраас баруун хойт зүгт 700 м орчим зайд УӨ 48 57 25.4, ДУ 91 06 46.4 цэгийн солбилцолд, далайн түвшнээс дээш 1343 м-ийн өндөрт оршино.

Бүсэлхий хэсгээрээ далд орсон, боржин чулуугаар үйлдсэн, толгойгүй хүн чулуу. Зүүн зүгт хандуулан босгосон, баруун талд нь хавтан чулуугаар хайрцаглан суулгасан тахилын онгонтой. Тахилын онгоны хашлага чулууны зарим нь нэлээд хөдөлсөн. Хүн чулуу баруун талруугаа хазайсан байдалтай, баруун гараа цээжин тушаа байрлуулж, хундага аяга мэтийг барьж зүүн гартаа илд атгажээ. Илдний бариул, балтаг тодорхой мэдэгдэх бөгөөд нийт урт нь 60 см хэмжээтэй. Илдний үзүүр хүн чулууны зүүн талаар ороосон. Өргөн бүс бүсэлж, зүүн талдаа хавтага зүүжээ. Хүн чулууны ойр орчимд зэл чулуу гэх зүйл мэдэгдэхгүй. 115 см өндөр, 27 см зузаан, 58 см өргөн хэмжээтэй. **(Зураг 28)**



Зураг 28. Манханы хүн чулуу

10. Загтын амны хүн чулуу (Загийн амны хүн чулуу)

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумаас баруун хойш, шулуунаар 10 км, Ховд голын баруун эрэгт, голоос 800-д м зайд УӨ 49 01 03.3, ДУ 91 03 16.1 хэмийн солбилцолд, далайн түвшнээс дээш 1374 м өндөрт аймаг явах замын хажууд нэгэн хүн чулуу байна.

Зүүн хойт зүг хандуулан босгосон, саарал боржингоор урласан, бүтэн хөшөө. Хүний нүүрийг хөмсгөөс үргэлжлүүлэн хамрыг уртаар сийлж, зууван хэлбэрийн нүд, үзүүр нь дээш дэрвийсэн нуман сахалтай, амыг хөндлөн зураасаар хонхойлгон сийлж, эрүүний сахлыг доош унжсан байдлаар дүрсэлжээ. Хоёр гарыг тохойгоор нугалан, цээжин тушаа тэгш амсартай, өндөр хүзүүтэй, цулхэгэр бөөртэй сав барьсан зохиомжтой. Баруун гарын хуруу тодруулан гаргахыг зорьсон, эрхий болон долоовор хуруу нарийн тодорхой сийлжээ. Бүсэлхийгээр дугариг тольттой нарийвтар бүс бүсэлж, арлын зүүн хажуугаас хос унжлага бүхий хутга зүүжээ. Магнай дээрээ үсээ овоолон зассан байдалтай. Баруун чихнээс бөөрөнхий унжлага бүхий эмэг зүүсэн байна. Хөшөөний зүүн талд хавтгай чулууг ханалуулан зоосон тахилын байгууламжтай. 113 см өндөр, 27 см зузаан, 28 см өргөн хэмжээтэй. **(Зураг 29)**





Зураг 29. Загтын амны хүн чулууны дүрслэл

11. Тарнын голын хүн чулуу

Өвөрхангай аймгийн Бүрд, Төв аймгийн Эрдэнэсант, Булган аймгийн Рашаант сумын зааг нутаг Тарнын голын гүүрнээс баруун зүгт 1,5 км зайд нэгэн жижгэвтэр товцог дээр нэгэн шивээ байх ба түүний зүүн урд талд тойруулан төмөр хашаа хайс татсан толгойгүй хүн чулуу бий. Уг хүн чулууг анх 1987 онд чулуун шивээн дотроос гаргаж иржээ[5]. Тус дурсгалт газар нь УӨ 47° 17.491' ДУ 103° 37.772' цэгийн солбицолд ДТД 1277 метрийн өндөрт байрлана. Тус хүн чулуу нь цайвар шаргал өнгийн боржин чулуугаар хийсэн. Толгой хугарч алга болсон ба бүрэн дүрслэлтэй. Баруун гараар цээжний өмнө сав барьж байсан нь хэлтрэн унажээ. Баруун энгэртээ эргэсэн захтай дээлтэй бөгөөд тус дээлийг дөрвөн дэлбээт цэцгэн хээгээр нэлэнхүйд нь чимэглэжээ. Суган доогуур нэвт нүхлэн ухаж гарыг нь их биеэр нь зааглаасан байна. Дөрвөн дэлбээт цэцгэн товруу бүхий ялтсан чимэгтэй бүстэй. 120х75х33 см хэмжээтэй. **(Зураг 30)**

[5] Баяр Д. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. УБ., 1997. Тал 91.



Зураг 30. Тарнын голын хүн чулуу

12. Дунд улааны хүн чулуун хөшөө

Завхан аймгийн Сонгино сумын төвөөс баруун зүгт 20 орчим км зайд УӨ 48 57 93,6 ДУ 95 36 52,7 цэгийн солбилцолд ДТД 1698 м өндөрт Дунд улаан хэмээх газар зэрэгцээ хоёр тахилгын байгууламжийн зүүн өмнө талд зоосон 2 хүн чулуун хөшөө байна. **(Зураг 31)**



Зураг 31. Дунд улааны хүн чулуун хөшөө

1-р хүн чулуу: Тус хүн чулуу нь буган хөшөөг засаж хүн чулуу болгон ашигласан байна. 86 см өндөр, 34 см өргөн, 32 см зузаан хэмжээтэй. Улаан өнгийн боржин чулуугаар хийсэн. Дүрслэлийн хувьд буган хөшөөний ээмэг, хүзүүний зүүлт, гурван ширхэг ташуу зураас, хожим хүний нүүрний дүрслэл гаргасан байна. Хүний нүүрний дүрслэл гаргахдаа урт шулуун хамар, хүнхэр нүд, нуман хамар, живэр сахал, гурвалжин зах зэргийг дүрсэлжээ.**(Зураг 32)**



Зураг 32. Дунд улааны 1-р хүн чулуун хөшөө

2-р хүн чулуу: 1-р хүн чулуунаас баруун зүгт 10 м орчим зайд дөрвөлжин хашлага өмнө талд нэгэн хүн чулуу байна. Тус хүн чулууг улаан өнгийн боржин чулуугаар хийсэн. Дүрслэлийн хувьд урт шулуун хамар,живэр сахал, гурвалжин зах зэргийг дүрсэлжээ. **(Зураг 33)**



Зураг 33. Дунд улааны 2-р хүн чулуу

ТАМГА ТЭМДЭГТЭЙ ХӨШӨӨ ЧУЛУУ БҮХИЙ ТАХИЛГЫН ОНГОН

1. Тэмээн чулууны тахилгын байгууламж

Увс аймгийн Өмнөговь сумын нутаг зүүн зүгт 50 орчим км зайд УӨ 49 24 42.8 ДУ 92 3 11.06 цэгийн солбилцолд Тэмээн чулуун хэмээх газар дөрвөлжин хашлага бүхий хөшөө чулуу байх ба түүний нэг хөшөө чулуун дээр чагт маягийн тамга сийлжээ. Өөр ямар нэгэн дүрслэл байхгүй. 140 см өндөр, 43 см өргөн, 15 см зузаан хэмжээтэй. **(Зураг 34)**



Зураг 34. Тэмээн чулууны тамгат хөшөө

2. Рашааны амны тамгатай хөшөө

Увс аймгийн Өлгий сумын төвөөс баруун урагш Сондуулын голын хөндийд рашааны аманд УӨ 48 56 60.0 ДУ 91 54 34.2 цэгийн солбилцолд нэгэн үл мэдэгдэх тамгатай дөрвөлжин хашлагатай хөшөө чулуу байна. 181 см өндөр, 61 см өргөн, 26 см зузаан хэмжээтэй. **(Зураг 35)**



Зураг 35. Рашааны амны тамгат хөшөө

3. Хавтгай сээрийн тамгатай хөшөө


Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс өмнө зүгт 15 км орчим зайд УӨ 48 58 15.3 ДУ 91 45 26.8 цэгийн солбилцолд Хавтгай сээр хэмээх газар нэгэн балбал чулуу бүхий дөрвөлжин хашлагатай Түрэгийн тахилын байгууламж байна. Балбал чулуу нь азимутын 70 хэмд 200 м үргэлжлэх ба 110 см хэмжээтэй цагираг байгууламж байна. **(Зураг 36,37)**

1-р хөшөө чулуу: Хүрэн улаан өнгийн боржин чулуугаар хийсэн. 180 см өндөр, 42 см өргөн, 26 см зузаан хэмжээтэй. Тус хөшөө чулуун дээр тамга тэмдэг дүрсэлсэн. Чулуун хашлага нь 1.3х1.4 м хэмжээтэй.

2-р хөшөө чулуу: 1-р хөшөө чулууны хажууд хүрэн улаан өнгийн боржин чулуугаар хийсэн. Ямар нэгэн дүрслэл байхгүй. 81 см өндөр, 32 см өргөн, 28 см зузаан хэмжээтэй.



Зураг 36. Хавтгай сээрийн тамгатай хөшөө



Зураг 37. Хавтгай сээрийн тамгатай хөшөө

ДӨРВӨЛЖИН ХАШЛАГА БҮХИЙ ТАХИЛГЫН ОНГОН

1. Завсрын булгийн эхний түрэгийн тахилгын байгууламж

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс хойд зүгт 30 гаруй км орчим зайд Ёлын шилийн өвөрт Завсрын булгийн эх хэмээх газар УӨ 49 17 20.9 ДУ91 3 29.09 цэгийн солбилцолд далайн түвшнээс дээш 1780 м өндөрт байрлана. Тус дурсгалт газар нь 1 буган хөшөө, 3 дүрслэлгүй хөшөө чулуу тус тус байна. **(Зураг 38)**

1-р тахилын байгууламж: Тус буган хөшөө нь тус дурсгалт газрын зүүн талд байрлана. 62 см өндөр, 46 см өргөн, 13 см зузаан хэмжээтэй. Дүрслэлийн хувьд 2 ширхэг дугуй ээмэг, 3 ташуу зураас дүрсэлжээ. Бусад хөшөөд нь ямар нэгэн дүрслэл байхгүй.



Зураг 38. Завсрын булгийн эхний Түрэгийн тахилын байгууламж

1. Морь тавьдаг хагийн Түрэгийн тахилгын байгууламж

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс урд зүгт 20 гаруй км зайд Ховд аймгийн Мянгад сумын нутагт УӨ 48 54 35.0 ДУ 91 47 01.9 цэгийн солбилцолд буган хөшөө ашиглан босгосон Түрэгийн 3 тахилын байгууламж байна. **(Зураг 39)**

1-р тахилын байгууламж: Буган хөшөө ашигласан босгосон тахилын байгууламж. Буган хөшөө нь 290 см өндөр, 54 см зузаан, 17 см өргөн хэмжээтэй. Хүрэн өнгийн боржин чулуугаар хийсэн. Бугын хийсвэр дүрслэлтэй.

2-р тахилын байгууламж: Буган хөшөө ашиглан босгосон тахилын байгууламж. Буган хөшөө нь 166 см өндөр, 66 см зузаан, 15 см өргөн хэмжээтэй. Хүрэн өнгийн боржин чулуугаар хийсэн. Бугын хийсвэр дүрслэлтэй.

3-р тахилын байгууламж: Ямар нэгэн дүрслэлгүй хөшөө чулуу.



Зураг 39. Морь тавьдаг хагийн Түрэгийн тахилгын байгууламж

ТҮРЭГИЙН ТАХИЛЫН ОНГОН

1. Тэмээн чулууны түрэгийн тахилгын онгон

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс баруун зүгт 50 км зайд Тэмээн чулуу хэмээх газар УӨ 49 24 42.8 ДУ 92 3 11.06 цэгийн солбилцолд хугарч унасан олон тооны хөшөө чулуу болон хашлага чулуун дээрээ холбоо онгин тамга, балбал чулуутай. Тамгатай хашлага чулуу нь 140 см урт, 43 см өргөн, 12 см зузаан хэмжээтэй. Тамга нь 30 см хэмжээтэй. **(Зураг 40)**





Зураг 40. Тэмээн чулууны тахилгын онгон

РУНИ БИЧЭЭС ТАМГА ТЭМДЭГ

1. **Тэмээн чулууны тамга**

Увс аймгийн Наранбулаг, Өмнөговь сумын зааг дээр Өмнөговь сумын төвөөс зүүн зүгт 40 орчим км зайд УӨ 49 24 48.50 ДУ 92 3 50.8 цэгийн солбилцолд олон тооны янгир бугыг бэлчиж буйгаар дүрслэн зурсан байна. Мөн нэгэн тамга тэмдгийн дүрс сийлжээ. Тамга нь 20 см өргөн, 30 см өндөр хэмжээтэй. **(Зураг 41)**



Зураг 41. Тэмээн чулууны тамга тэмдэг, хадны зураг

2. Хүрэн үзүүрийн өвөлжөөний тамга

Увс аймгийн Өмнөговь сумын төвөөс 16 км орчим зайд УӨ 48˚ 58’ 26.4”, ДУ 91˚ 45’ 58.1” солбицолд буюу Хүрэн үзүүр хэмээх газар нэгэн өвөлжөөний арын хадан олон тооны хадны зураг тамга тэмдгийн дүрслэл байна. **(Зураг 42)**






Зураг 42. Хүрэн үзүүрийн өвөлжөөний тамга

3. Бичигт хадны дурсгал

Ховд аймгийн Цэцэг сумын төвөөс зүүн урагш 10 гаруй км зайд УӨ 46˚ 32’ 44.8”, ДУ 93˚ 22’ 78.2” цэгийн солбилцолд Бичигт хад хэмээх олон тооны хадны зураг болон руни бичгийн дурсгал байна. **(Зураг 43, 44)**



Зураг 43. Бичигт хадны дурсгалт газар



Зураг 44. Бичигт хадны балархай бичээс

4. Улаан цохиотын дурсгал

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын төвөөс зүүн зүгт 10 км зайд 46˚ 09’ 25.9”, ДУ 98˚ 48’ 66.2” цэгийн солбилцолд Улаан цохиот хэмээх газар хадны зураг болон тамга тэмдэг руни бичгийн дурсгал байна. **(Зураг 45)**



Зураг 45. Улаан цохиотын дурсгал

5. Замын бууцын түрэг бичээс

Монгол улсын Баянхонгор аймгийн Бууцагаан сумын төвөөс зүүн зүгт 5.6 км зайд УӨ 46°09,743′ ДУ 98°46.210′ цэгийн солбицолд ДТД 1940 м өндөрт оршино. Замын бууц хэмээх зүүн талдаа чулуун хороо, малын бууц бүхий боржин хадтай жижиг толгой бий. Уг толгойн зүүн урд байрлах 310 см урт 175 см өндөр хавтгай хадны дээд хэсэгт 16-17 тэмдэгт үсэг бүхий эртний түрэг бичээс байна. Түүний ар талын хаднаа онгин тамга сийлжээ. Бичээсийн нийт урт 190 см, 19 см өндөр.**(Зураг 46,47)**



Зураг 46. Замын бууцны руни бичээстэй хад



Зураг 47. Замын бууцны руни бичээс

УЙГУРЫН ҮЕИЙН ХҮН ЧУЛУУ

1. Чандманы цагаан хөшөөны хүн чулуу

Увс аймгийн Улаангом сумын нутаг Чандманы цагаан хөшөө хэмээх газар УӨ 50˚ 00’ 25.2”, ДУ 92˚ 02’ 45.4” цэгийн солбилцолд нэгэн хүн чулуу байна. Тус хүн чулууг улаан өнгийн боржин чулуугаар маш нарийн хийцтэйгээр урласан. Магнайн хэсэгт малгайны урд талын хэсэгт хэвлий тус газраа 2 гараараа цүлхэгэр бөөртөй аяга барьсан. Дөрвөлжин ялсатай унжлага бүхий агсарга бүс зүүсэн байна. **(Зураг 48)** Дээрх хүн чулууг судлаачид Уйгурын үе хэмээн тодорхойлсон байдаг. Чандманий цагаан хөшөөний хүн чулууг судлаач Т.Бямбадорж, Ч.Амартүвшин нарын Увс аймгийн нутаг дахь хүн чулуудын бүртгэл судалгааны өгүүлэлд нийтлсэн байна[6].



Зураг 48. Чадманий цагаан хөшөөний хүн чулуу

2. Цагаан хөшөөтийн хүн чулуу

Баян-Өлгий аймгийн төвөөс зүүн урагш шулуунаар 14 км-т, Ховд голын баруун урсгал, голын тохойн тэгш дэвсэгт УӨ 48 50 32.1, ДУ 91 16 31.2 цэгийн солбилцолд, далайн түвшнээс дээш 1343 м-ийн өндөрт зүүн урагш хандуулан босгосон нэгэн хүн чулуу бий. Цагаан саарал боржин чулуугаар урласан, томоохон хэмжээтэй, бүрэн дүрслэлтэй, хадгалалт сайтай аж. Газарт зоолттой уг хүн чулуу одоогийн байдлаар газраас 176 см

[6] Бямбадорж Т., Амартүвшин Ч. Увс аймгийн нутаг дахь Түрэгийн үеийн зарим хүн чулууд // Studia archeologica. Tom. XVIII, Fasc. 10. УБ., 1998, т. 116-124.

өндөр, 72-86 см өргөн, 28-37 см зузаан хэмжээтэй. Эл хүн чулууны ойролцоо ямар нэг тахилын онгон гэхээр зүйл байхгүй. **(Зураг 49)**

Чихэвчийг дээш сөхсөн дүгрэг малгай өмссөн байдалтай, дугуйрсан хөмсөг, шулуувтар урт хамрыг нэгэн үргэлж товгор байдлаар залгуулан сийлсэн. Баруун талын нүд жаахан бүдгэрсэн ба зүүн нүдийг зууван хэлбэртэй давхар хүрээ гарган зовхийг тодруулжээ. Нумарсан живэр сахал гаргаж, түүний доор уруулыг бодитойгоор дүрсэлжээ. Хоёр чихийг С үсэг мэт товойлгон дүрсэлж, ээмэг зүүсэн шинж ажиглагдахгүй. Хоёр гараа тохойгоор нугалан хэвлийн өмнө босоо хүзүүтэй, цүлхэн бөөртэй, босоо тэгш суурьтай савыг хоёр бөөрнөөс нь шахан барьсан бөгөөд гарын хурууг тодорхой, уран нарийн дүрсэлжээ. Ялангуяа эрхий хурууг хойш нумарсан байдалтай ур чадвартай сийлсэн байна. Дээлний энгэр заам, ханцуйн зураас мэдэгдэхгүй, бүсний товруу чимэг зүүн хэсэгтээ багахан мэдэгдэх боловч бусад хэсгээр мэдэгдэхгүй цулгуй аж. Хоёр ташаандаа нэгжээд дүгрэг хавтага унжуулсан нь доороо унжлагатай.Түүнчлэн бүснээсээ баруун талдаа гурав, зүүн талдаа хоёр шулуун унжлага бүхий агсарга бүстэй.

Уг дурсгалыг 2008 онд Монгол Улсын Засгийн газрын 175-р тогтоолоор Улсын хамгаалалтад байх түүх соёлын дурсгалын жагсаалтад оруулжээ. Цагаан хөшөөтийн дурсгалыг судлаачид хэдэнтээ ирж судалж, зарим нь хэвлэн нийтлүүлжээ.



Зураг 49. Цагаан хөшөөтийн хүн чулуу

ХАДНЫ ОРШУУЛГА

1. Дулаан буурийн оройн хадны оршуулга

Эл дурсгалын тухай Увс аймгийн Наранбулаг суманд хадны оршуулга тоногдсон нум сум болон зарим эд өлгийн зүйлс сумын сургууль дээр хадгалагдаж буй тухай Наранбулаг сумын иргэн А.Ихбаньд Монголын Үндэсний музейн Эрдэм шинжилгээний төвийн дарга, доктор Ж.Баярсайханд анх мэдээлсэн. Тус хадны оршуулгнаас илэрсэн эвдэрхий нум, сумыг зүйлсийг тухайн үедээ Наранбулаг сумын соёлын төвийн эрхлэгч байсан (одоо Байгаль хамгаалагч) Иштавхай гэдэг хүн 2011 оны 10 сард өөртөө хадгалж байгаад сумын 10 жилийн дунд сургуульд шилжүүлэн өгчээ. Мөн дээрх оршуулгаас гарсан модон аягыг Юнгэр (нутгийнхан Жагаа хэмээн нэрлэдэг) одоо өөртөө хадгалж байгаа аж.**(Зураг 50)** Хадны оршуулгыг анх тус сумын малчин Юнгэрийн хүү олсон ажээ. Иштавхай дээрх эд зүйлсийг өөрийн биеэр Улаанбаатар хотод очиж БСШУСЯ-ны хүмүүст аваачиж үзүүлсэн боловч тодорхой чиглэл өгөөгүйн улмаас буцаан аваачжээ.

Бид Наранбулаг сумын дунд сургуульд очиж хадны оршуулгаас гарсан гэх олдворуудыг үзэж танилцахад хугархай нум, төмөр болон модон болцуутай хоёр сум зэрэг зүйлс байсныг хүлээн авч, сургуулийн удирдлагуудтай хамт Увс аймгийн музейн арга зүйч Э.Анхбаяр, бүртгэл мэдээллийн санч О.Мянганбуу нарт хүлээлгэн өглөө. **(Зураг 41,52)** БСШУСЯ-ны Соёлын өв хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэнгийн зөвлөснөөр дээрх олдворуудыг Увс аймгийн музейд түр хүлээлгэн өгч, улмаар Улаанбаатар хотруу аваачиж, сэргээн засварлуулах, цэвэрлэж, бэхжүүлэх ажлыг Соёлын өвийн үндэсний төвд хийлгэх юм. Сумны мөс хугарсныг сургуулийн багш нар эвлүүлэн боож, мяндсаар ороосон байв. **(Зураг 53)**




Зураг 50. Дулаан буурийн оройн хадны оршуулганаас гарсан аяга (*Наранбулаг сумын иргэн Юнгэр хэмээх хүнд хадгалагдаж байсан*)



Зураг 51. Наранбулаг сумын сургууль дээр нум хүлээлцэж буй байдал



Зураг 52. Сургууль дээр хадгалагдаж байсан нум сумны хэсэг



Олдвор хүлээлцсэн акт

Увс аймгийн Наранбулаг сумын эрхлэгч баговерлын сургуулийн соёл үйлчилгээ танихад зориулагдаж байсан нүх сурах эрдэм шинжилгээ хийх зорилгоор олж авсан музейд шилжүүлэх авлаа. Нүх - 1 ширхэг сүх - 2 ширхэг (дугаарлаж хүлээлгэн).


Хүлээлгэж өгсөн: ЕБСургуулийн багш менежер. Б. Баттөгөлдөр /
газрын дүн Б. Эрхбаяр /
Захирал Ж. Пүрэвжав /

Хүлээж авсан Музейн бүртгэл мэдээллийн сан. О. Мянганбуу /
ажилтан Э. Анхбаяр /

Байцаан: Мянгадын урлагийн Музей
Эрдэм шинжилгээний төвийн дарга
Ж. Бозрсайхан /
Г. Одбаатар /
Соёлын орчин Г. Анхаяа /
Байгаль хамгаалагч: Шаравхай /
2020.05.13. 12 цаг 35 минут

Зураг 53 . Олдвор хүлээлцсэн акт

2020 оны 5 дугаар сарын 13-ний өдөр Дулаан буйрын оройн хадны оршуулга буй газар Увс аймгийн Наранбулаг сумын Соёлын өвийн эрхлэг Р.Өлзийбаяр, Болд, сургуулийн багш нар, Увс аймгийн музейн ажилтан Э.Анхбаяр, О.Мянганбуу, жолооч Ч.Батхүү нарын хамт очив. Наранбулаг сумаас хойт зүгт шулуунаар 30 км орчим зайд УӨ 49˚ 37’ 11.5”, ДУ 92˚ 19’ 29.9” цэгийн солбицолд Дулаан буурь хэмээх өвөлжөөнөөс баруун хойд зүгт, өмнө зүг хошууран орсон хадтай уулын оройд уг оршуулгыг үйлджээ. **(Зураг 54,55)**



Зураг 54. Дулаан буурийн оройн хадны оршуулгын дэвсгэр зураг



Зураг 55. Дулаан буурийн оройн хадны оршуулга харагдах байдал

Биднийг очиход агуйд банзан авсны үлдэгдэл болох эвдэрхий мод, шургаагны үлдэгдэл, хүний гавал зэрэг зүйлс агуйд байв. Агуйн ерөнхий байдлаас үзвэл хүнийг толгойгоор нь зүүн хойд зүгт хандуулан оршуулсан байжээ. Агуйн хойт буланд нэгэн хавтгай чулууг босгож, түүний өмнө талд хүний гавлыг байрлуулсан байлаа. Оршуулга ихэд хөндөгдсөн бөгөөд дагалдуулж тавьсан эд зүйлсийг эрт цагт тоножээ. Хадны оршуулга бүхий хөмөг хүний нүдэнд ил, агуйн ам онгорхой тул эрт цагаас хүмүүс мэддэг байсан бололтой. Сониуч хүмүүсийн үйлдлээр, олон цаг үед хөндөгдсөн аж. Агуй доторх эд зүйлсийг сандаачиж, хүний яс, нэхмэл эдлэлийн тамтаг, банзан авс зэргийн эвдэрхий хэсгүүд уулын уруу, өмнө зүгт гулгаж тогтсон байлаа. Анх жижиг сараалж шургаагаар холбосон, банзан хашлагатай австай байсан бололтой. Тэрэгний арал ч байсан байж болохоор харагдана. Бид дээрх олдворуудыг авч агуйг шалгаж үзэхэд өөр ямар нэг олдвор эд зүйл илэрсэнгүй. **(Зураг 56-59)**



Зураг 56. Дулаан буурийн оройн хадны оршуулгын ерөнхий байдал



Зураг 57. Дулаан буурийн оройн хадны оршуулга



Зураг 58. Дулаан буурийн оройн хадны оршуулга малтлага



Зураг 59. Дулаан буурийн оройн хадны оршуулганаас илэрсэн нум, даавууны тасархай хэсгүүд


2. Бага баавай уулын хадны оршуулга

Ховд аймгийн Манхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Энхтөр тус сумын нутагт “Бага баавай” хэмээх газар хадны оршуулга тонуулчид сүйтгэж нэг аяга хоёр хэсэг болгон хагалж хаясан тухай мэдэгдээд яаралтай авран хамгаалах шаардлагатай буйг албан бичгээр ирүүлсэн болно.

Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун урагш 15 орчим км зайд УӨ 47°23′54,5, ДУ 91°56′04,3 цэгийн солбицолд далайн түвшинөөс дээш 2032 метрийн өндөрт Бага баавай хэмээх ууланд тоногдож сүйтгэгдсэн нэгэн хадны оршуулга байна. Тус хадны оршуулгыг 1989 онд Доктор Д.Наваан анх малтан судалж[7] гарсан эд өлгийн зүйлсийг тус сумын орон нутаг кабинетид өгсөн байна. **(Зураг 60)** Хадны оршуулгын модон авс болон хүний хатмал шарилыг Манхан сумын нэгдэл, Сүсэгтний холбоо, Сумын захиргаа хамтран хариу буцааж Бага баавай ууланд тус оршуулга байсан газар нь аваачиж тавьсан байна. Биднийг очиход тус хадны оршуулга нь хүний яс нь энд тэнд тарсан, модон авс нь хоёр хэсэг болсон, 2 хуваагдсан хүрэн өнгийн будагтай модон аяга байсан. **(Зураг 61, 62)**

Аяганы тодорхойлолт: Улаан хүрэн өнгийн модон аяга. Хоёр хэсэг болж хуваагдсан. Аяганы ёроолын 4 талд хар бэхээр зурсан үсэг тэмдэгтэй, ёроолдоо хар бэхээр зурсан үсэг тэмдэгтэй. Амсарын диаметр 195,74 мм, амсарын зузаан 7,79 мм, ёроолын диаметр 87,26 мм хэмжээтэй. **(Зураг 63).**


[7] Наваан.Д., Бүтээл туурвилын эмхэтгэл., Ховд аймагт явуулсан археологийн судалгаа 2018 УБ. тал 14



Зураг 12. Ховд аймгийн Манхан сумын Бага Баавайн хадны оршуулга



***Зураг 9**. Ховд аймгийн Манхан сумын Бага Баавайн хадны оршуулга малтсаны дараа модон авсыг зөөж байгаа нь. 1990 он*



***Зураг 10**. Ховд аймгийн Манхан сумын Бага Баавайн хадны оршуулгын зарим олдвор*

Зураг 60. Бага баавайн хадны оршуулга 1989-1990 он. Зургийг Д.Наваан





Зураг 61. Бага Баавай уулын хадны оршуулгын одоогийн байдал



Зураг 62. Бага Баавай уулын хадны оршуулга байсан хадны хөмөг



Зураг 63. Бага баавай уулын хадны оршуулганаас гарсан модон аяга

3. Гангын дабааны хадны оршуулга

Гангын дабааны хадны оршуулгыг анх Ховд аймгийн Зэрэг сумын Гүвээ багын иргэн Г. Болдбаатар анх мэдээлэлсэн. Тус оршуулга нь Ховд аймгийн Зэрэг сумаас баруун тийш 20 орчим км зайд УӨ 47°14′52,6, ДУ 92°30′57,3 цэгийн солбицолд далайн түвшинөөс дээш 818 метрийн өндөрт Гандын даваа хэмээх хадтай уулын арын энгэрт нэгэн том хадны хөмөгт байрлана. **(Зураг 64)**

Биднийг очиж шалгахад тус хадны хөмөгт эмээлийн урд бүүрэг, 2 ширхэг төмөр дөрөө (нэг дөрөө 2 хэсэг болсон), модны хэсгүүд байлаа. Өөр ямар нэгэн эд өлгийн зүйлс байхгүй байна. **(Зураг 65, 66)**

Эмээлийн бүүрэг: Хувхайрч гандсан эмээлийн урд модон бүүрэг. Тус бүүрэг нь хоёр хавтаст бэхлэгдэх хэсэг (муж) 2 хос 4 ширхэг нүхтэй. Урд талруу харсан хэсэгт 48,83 мм өргөн ховил гаргаж түүний доод хэсэгт 6,03 мм зузаан 32,83 мм өргөн хөмсөг гаргажээ. Бүүрэгний дээд хэсэг 18 см өргөн, доод хэсэгт 32 см өргөн, 7,6 см зузаан хэмжээтэй. **(Зураг 67)**

1-р дөрөө: Нумарсан нимгэн зууван тавагтай төмөр дөрөө. Таваг хэсэгээр тасарсаныг нимгэн төмөр тавьж тавлаж хадсан. Гурвалжин сэнж бүхий төмөр дөрөө. 14 см өндөр, 11.3 см өргөн, тавагийн өргөн 4.9 см хэмжээтэй. **(Зураг 68)**

2-р дөрөө: 1-р дөрөөтэй хийцийн хувьд төстэй боловч хэмжээр жижиг, хоёр хэсэг болон салсан байна. Нумарсан нимгэн тавагтай гурвалжин сэнж бүхий төмөр дөрөө. 10.8 см өндөр, 11.5 см өргөн, тавагийн өргөн 5.5 см хэмжээтэй. **(Зураг 69)**

Модны хэсэгүүд: Янз бүрийн хэмжээтэй модны хэсгүүд. Хэмжээ, хэлбэр үзэхэд хоромсого болон эмээлийн хавтасны хэсгүүд бололтой. **(Зураг 70)**



Зураг 64. Гангын дабааны хадны оршуулгын дэвсгэр зураг



Зураг 65. Гангын дабааны хадны оршуулга буй хадны хөмөг







Зураг 66. Гангын дабааны хадны оршуулга буй хадны хөмөг



Зураг 67. Эмээлийн бүүрэг



Зураг 68, 69. Төмөр дөрөө



Зураг 70. Модон эдлэлийн хэсгүүд

СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Энэхүү мэдээ шалгах судалгааны явцад буган хөшөө 4, хиригсүүр 1, Хүннү булш бүхий дурсгалт газар 1, Түрэгийн үед холбогдох хүн чулуу бүхий тахилгын онгон 20, дөрвөлжин хашлага дотор босгосон тамга тэмдэгтэй хөшөө чулуу бүхий тахилгын онгон 4, дөрвөлжин хашлагатай хөшөө чулуу бүхий тахилгын онгон 2, тамга тэмдэгтэй хадны зураг 2, баларч муудсан бичээс бүхий 2 дурсгал, түрэг бичээс бүхий 1 дурсгалт газар, Уйгурын үед холбогдох хүн чулуу 2, тоногдож сүйтгэгдсэн хадны оршуулга 3 буюу нийт 41 дурсгалыг бүртгэн баримтжуулж, танилцлаа. Эдгээрийн 17 нь шинээр бүртгэн баримтжуулсан дурсгал болно.

Наранбулаг сумын нутаг Дулаан буурийн оройн хадны оршуулга, Манхан сумын Бага баавайн хадны оршуулга нь зан үйл, олдворуудаас үзвэл урьдчилсан байдлаар XII-XIV зуунд холбон үзэж болохоор байна. Түүнчлэн Зэрэг сумын Гангын дабааны хадны оршуулгыг цаашид нарийвчлан судалж он цаг тогтоох шаардлагатай байна. Дулаан буурийн оройн хадны оршуулгын зүүн бэлд нэгэн булшийг 2-3 жилийн өмнө тонож, хүний ясыг гарган хаяснаас үзвэл энэ бүс нутагт тонуулчид археологийн дурсгалыг сүйтгэсээр буйг харуулж байна.

Хээрийн судалгааны явцаас ажиглахад Увс аймгийн нутагт буй Түрэгийн үеийн хүн чулууд нь бусад бүс нутагт буй хүн чулуудаас харьцангуй бүрэн бүтэн хадгалагдаж үлджээ. Цаашид Монголын баруун болон баруун хойд бүс нутагт хадны оршуулга, Түрэгийн үеийн хүн чулуу, бичиг үсгийн дурсгалыг илрүүлэн судлах, бүртгэн баримтжуулах өргөн хэмжээтэй хайгуул, малтлага судалгаа хийвэл судалгааны үр дүн өндөр байх боломжтой юм.

6. ДЭЛХИЙН ӨВИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ҮЗҮҮЛЭХ ҮҮРЭГ, НӨЛӨӨ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Дэлхийн өвийн дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтад соёлын өвийн бүртгэл, судалгааны үзүүлэх үүрэг, нөлөө




Дэлхийн өв- “Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийн жишээн дээр

Г.ЭНХБАТ
Ph.D, Соёлын өвийн үндэсний төвийн захирал

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар



- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт,
- Төв аймгийн Мөнгөнморьт
- хамгаалалтын бүс 441507.7 га
- орчны бүс 711332 га

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал










- Палеолит,
- Неолит
- Монголын эртний овог аймаг улсуудын сүлд, тамга тэмдэг бүхий археологийн цогцолбор дурсгал "*Рашаан хад*",
- "*Өглөгчийн хэрэм*",
- "*Сарьдагийн хийд*",
- "*Гүнжийн сүм*",
- "*Бэрээвэн хийд*"

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

2015 оны Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогоор...



СӨУНБМС-д:


- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын 103 дурсгалт газрын 500 үл хөдлөх дурсгал
- Тэнүүний голын дунд биед байрлах Гуна хайрханы өвөрт байх хиргисүүр,
- Буган хөшөө



Зураг 1. Хэнтий, Өмнөдэлгэр сумын ТСҮХД-ын байр зүйн зураг

Мухар Гутайн амны буган хөшөө

Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалатын бүсэд хамаарагдаж байна.



СӨУНБМС-д:

- Хэнтий аймгийн Батширээт сумын 65 дурсгалт газрын 250 үл хөдлөх дурсгал
- Бурхан Халдун уулын хамгаалалтын бүсэд дурсгал бүртгэгдээгүй болно.

Зураг 2. Хэнтий, Батширээт сумын ТСҮХД-ын байр зүйн зураг

Хамгаалалтын бүсэд багтсан



СӨУНБМС-д:

- Төв аймгийн Мөнгөнморьт сумын 24 дурсгалт газрын 132 үл хөдлөх дурсгал
  - Тэрэлжийн дөрвөлжин,
  - Тэнүүний голын хийдийн туурь

Зураг 3. Төв, Мөнгөнморьт сумын ТСҮХД-ын байр зүйн зураг



Тэрэлжийн дөрвөлжин


СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ


Соёлын биет бус өв

Шинэчилсэн бүртгэлд Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд 7-н ай савд хамаарах 279 өв, Яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэлд 7 ай савд хамаарах 83 өв, нийт 362 соёлын биет бус өвийн зүйл бүртгэгдсэн .




Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд





Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд




СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2019 оны байдлаар бүртгэгдсэн Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

№	Аймаг, нийслэлийн нэр	Өвийн тоо	Аймаг, нийслэлийн СӨБМС-нд 2010-2017 онд бүртгэгдсэн хүний (хяналтын) тоо	2018-2019 оны баяжилтын тоо	Хасагдсан өвлөн уламжлагчийн тоо	Өвлөн уламжлагчийн нийт тоо
1	Архангай	35	231	149	3	377
2	Баян-Өлгий	105	404	237	20	621
3	Булган	31	177	18	0	195
4	Баянхонгор	65	133	178	24	287
5	Говь-Алтай	77	530	148	78	600
6	Говьсүмбэр	48	116	228	25	319
7	Дархан-Уул	28	74	7	6	75
8	Дорнод	87	273	92	43	322
9	Дорноговь	43	314	108	20	402
10	Дундговь	0	195	175	0	370
11	Завхан	72	473	109	74	508
12	Орхон	35	0	227	0	227
13	Өвөрхангай	55	169	109	15	263
14	Өмнөговь	65	236	85	16	305
15	Сүхбаатар	76	232	64	43	253
16	Сэлэнгэ	108	599	59	166	492
17	Төв	72	554	62	11	605
18	Увс	94	223	262	84	401
19	Ховд	111	265	692	33	924
20	Хөвсгөл	72	1060	163	318	905
21	Хэнтий	0	360	295	40	615
22	Улаанбаатар	0	1428	408	407	1429
	Нийт дүн		8046	3875	1426	10495

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд:



- 2020 оны байдлаар *Дэлхийн өв- "Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг" –ийн орчны бүс буюу дээрхи **2** аймгийн **3** сумын нутгаас СӨУНБМС-ийн соёлын биет бус өвийн анхан шатны бүртгэлд давхардсан тоогоор **52** соёлын биет бус өвийн **57** өвлөн уламжлагчийн бүртгэл цуглагдсан байна.*

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Хэнтий аймаг Батширээт сум



- **7 ай савын 14 өвийн 19 өвлөн уламжлагч**

- Монгол бичиг
- Бөө мөргөлийн холбоотой илэрхийлэл
- Халх богино дуу
- Буриад богино дуу
- Эсгий хийх уламжлалт арга
- Монгол гэрийн уламжлалт урлал
- Морин тэрэг хийх уламжлалт арга
- Халх хувцасны уламжлалт урлал
- Модон сийлбэрийн урлал
- Үйсэн урлал гэх мэт...

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Хэнтий аймаг Өмнөдэлгэр сум

- 7 ай савын 22 өвийн 22 өвлөн уламжлагч



- Халх хувцасны уламжлалт урлал
- Монгол гэрийн уламжлалт урлал
- Хөөрөг урлал
- Монгол гэрийн урлал
- Арьс, ширэн эдлэлийн урлал
- Модон сийлбэрийн урлал
- Цол дуудлага
- Ерөөл
- Халх уртын дуу
- Хурдан морины гийнгоо
- Халх богино дуу
- Шагайн харваа
- Мал хөнгөлөх зан үйл
- Шагай харваа
- Монгол зурхай
- Байгаль орчин сав ертөнцийн тухай мэдлэг

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Төв аймаг Мөнгөнморьт сум

- 7 ай савын 16 өвийн 16 өвлөн уламжлагч



- Буриад аман аялгуу
- Цол дуудлага
- Ерөөл
- Халх уртын дуу
- Буриад богино дуу
- Халх богино дуу
- Халх хувцасны уламжлалт урлал
- Монгол эмээл хийх урлал
- Монгол дархны уламжлалт арга ухаан
- Модон сийлбэрийн урлал гэх мэт...

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ДӨ-ийн Конвенцид

"Соёлын болон байгалийн өвийг хамгаалах" *гэж*

- *Соёлын болон байгалийн өвийг нийгмийн амьдралд тодорхой үүрэгтэй болгох,*
- *Менежментийн зохих төлөвлөгөө бий болгох,*
- *Бариимтжуулах*
- *Чадавхыг нэмэгдүүлэх болон судалгаа хийх*
- *Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх*
- *Өвийг сурталчлах, хамгаалахад орон нутгийн болон үндэсний хүн амын оролцоог нэмэгдүүлэхийг хэлнэ*

СББӨ-г хамгаалах Конвенцид

"Соёлын биет бус өвийг хамгаалах" *гэж*

- *тухайн өвийн оршин тогтнох чадварыг хангах зорилгоор*
- *түүнийг таньж тогтоох,*
- *бариимтжуулах,*
- *судлах,*
- *хадгалах, хамгаалах,*
- *олны хүртээл болгох,*
- *өвийн ач холбогдлыг нэмэгдүүлэх,*
- *албан болон албан бус сургалтаар өвлүүлэн уламжлуулах,*
- *мөн сэргээн амилуулахыг хэлнэ.*

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Дэлхийн өвийн конвенци ба СББӨ-г хамгаалах тухай 2003 оны Конвенци хоорондын шүтэлцээг сайжруулах хэрэгцээ, шаардлага

"Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг" өв 2015 онд ДӨ-ийн Жагсаалтад бүртгэгдсэн

"Уул овоо тахих Монгол зан үйл өв 2017 онд ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн



СӨУНБМС-нд ирүүлсэн анхан шатны бүртгэлд "Уул овоо тахих зан үйл"-тэй холбоотой өвлөн уламжлагч дээрхи 3 сумын нутаг буюу ДӨ-БХУТХТГ-ын нутагт бүртгэгдээгүй нь цаашид тахилга шүтлэгт газар нутаг, уул овоо тахих зан үйлийг хамгаалахын тулд эдгээр өвийг өвлөн уламжлагчдыг сурвалжлан олох, бүртгэх, судлах, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаанд татан оролцуулах шаардлага буйг харуулж байна.

Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хөдөлгөөнт сургалт



- Дэлхийн өв-Бурхан Халдун уулын хамгаалалтын талаар Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалтыг 2019 онд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, БСШУСЯ, Соёл урлагийн бодлогын газар, Соёлын өвийн үндэсний төв, Хан Хэнтийн УТХГ-ын Хамгаалалтын захиргаа хамтран зохион байгуулав.




Хамгаалалтын бүсийг тодорхойлох тэмдэглэгээ бүхий багана босгов



- ЮНЕСКО-ийн эмблем бүхий хөшөө босгох үйл ажиллагааг 2018 онд Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Хэрлэнгийн дээд Цагаан Аралд зохион байгуулав.
- 2019 онд “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийн хамгаалалтын бүсийг тодорхойлох тэмдэглэгээ бүхий баганыг бүсийн дагуу босгох арга хэмжээг БОАЖЯ, ЗГХА Соёл, урлагийн газар, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс зохион байгуулав.



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



- Сургалттай уялдуулж “Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” гарын авлага, товхимолыг бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд тараасан.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ




Анхаарал тавьсанд баярлалаа!!!

7. ДЭЛХИЙН ӨВИЙН ХУГАЦААТ ТАЙЛАНГИЙН СУРГАЛТ

ЮНЕСКО-ийн Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны конвенцын хүрээнд Ази, Номхон далайн бүсийн хугацаат тайланг 2021 онд бүсийн хэмжээнд хүргүүлэх ажлын хүрээнд Дэлхийн өвийн төвөөс сургалт 2020 оны 10 дугаар сараас зохион байгуулагдаж байна. Ковид-19 цар тахлын улмаас сургалт нь цахимаар явагдаж байна.



Энэхүү ажлын хүрээнд Соёлын өвийн үндэсний төвийн Дэлхийн өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч М.Цэцэнбилэг үндэсний зөвлөхөөр томилогдон ажиллаж байгаа бөгөөд хугацаат тайлангийн асуулга дээр Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад



соёлын ангиллаар бүртгүүлсэн дурсгалт газруудын хамгаалалтын захиргаанууд ажиллаж байна. Үүнд: Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын (мэргэжилтэн Ч.Догсом, Үүрийнтуяа), Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (мэргэжилтэн С.Жадира), Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн (мэргэжилтэн П.Сугармаа) хамгаалалтын захиргаанууд хамрагдаж байна.

Үндэсний зөвлөхүүд нь 2020 оны 10 сараас эхлэн 14 хоног тутам Дэлхийн өвийн төвөөс зохион байгуулж байгаа онлайн сургалтад хамрагдаж олон нийтийн сүлжээг (Email, Facebook, Messenger) ашиглан Хамгаалалтын захиргааны холбогдох мэргэжилтнүүдийг шаардлагатай мэдээллээр ханган, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Тайлангийн 1 дүгээр хэсэг (Section 1) буюу улсын түвшний ерөнхий мэдээллийг урьдчилсан байдлаар 2021 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор хүргүүлэх бөгөөд 2 дугаар хэсэг (Section 2) буюу Дэлхийн өвийн газар нутгийн хамгаалалтын захиргаанууд өөрсдийн тус бүрийн хариуцсан Дэлхийн өвийн газрын мэдээллийг 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүргүүлэхээр төлөвлөж байна. Тайланг эцсийн байдлаар 2021 оны 07 дугаар сард хүргүүлэх юм.

8. XIII-XIV ЗУУНЫ ҮЕИЙН ХҮН ЧУЛУУДЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН АСУУДАЛ

***Түлхүүр үг**: Монголын үе, хүн чулуу, тархалт, хадгалалт хамгаалалт, харьцуулалт, орчны суурь судалгаа, үр дүн*

***Товч агуулга:** Бид энэхүү өгүүллээр Монголын XIII-XIY зууны үеийн хүн чулуудын тархалтыг уулсын мужлалд хуваан, байгаль цаг уур болон орчны нөлөөлөл зэрэг дээр тулгуурлан, хүн чулуудын хадгалалтын өнөөгийн тулгамдсан асуудлыг хөндсөнөөс гадна хадгалалтын шинэ арга зүй боловсруулж Төв аймгийн Баянцагааны Тосон бэлх, Эрчүүдийн адгийн хүн чулууд дээр орчны болон чулуулгийн, агаар чийгшлийн судалгаа багтсан туршилт хийсэн талаар өгүүлэх болно. Уг судалгаа нь өмнө нь манай улсын нутагт хийгдэж байгаагүй бөгөөд чулуун дурсгал дээр хийсэн хадгалалтын анхны цогц судалгаа гэдгээрээ шинэлэг билээ.*

Өнөөгийн Монгол улсын нутаг нь эртний нүүдэлчдийн үдээсэн түүх археологийн дурсгалаар нэн баялаг билээ. Тэдгээр дурсгалуудын нэг төрөл, хүн чулуу нь нүүдэлчдийн соёл, зан заншлын онцлогийг судлах, танин мэдэхэд чухал хэрэглэгдэхүүн болсоор байна. Өнөө үед хүн чулуудын хадгалалт хамгаалалт муудан эвдэрч сүйдсээр байгаа нь Байгал орчны болон хүний буруутай үйл ажилгаанаас хэмээх үндсэн хоёр шалтгаанаас үүдэлтэй, байна. Бидний судалгааны зорилго хүн чулуудын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, бүртгэн баримтжуулалт, хүрээлэн буй орчны судалгааг хийж тухайн дурсгалыг муутгаж буй эрсдэлийг тогтоож урт хугацааны хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлалтын арга зүйг боловсруулан нутагшуулахад оршино. Хүн чулууд нь урт хугацааны туршид хөрсөн дээр хадгалагдаж үлдсэнтэй холбоотой хөрс, эрдсийн нөлөөнд өртөн микро элементийн өөрчлөлтөд орж байгалийн болон хүн малын нөлөөллөөс гэмтэж муудах, устаж үгүй болох эрсдэлийг бүрдүүлдэг. Тиймээс чулуун эдлэлийг удаан хугацаагаар хадгалж хамгаалахын тулд хүрээлэн буй орчныг тогтворжуулах, гадны нөлөөллийг багасгах болон нөлөөллөөс тусгаарлах зорилгоор энэхүү судалгааг хийх шаардлагатай байгаа билээ.

Дорнод Монголын хүн чулууг анх судалж нийтэд мэдээлсэн хүн бол Оросын судлаач В.А.Казакевич билээ. Тэрээр 1927 онд БНМАУ-ын Дарьгангын хязгаарт угсаатны зүй-хэл шинжлэлийн судалгааны ажлаар явахдаа тэр нутагт буй эртний дурсгалт зүйлсийг сонирхон судалж Түрэгийн үеийн хүн чулуудаас хийц загварын хувьд эрс ялгаатай 17 ширхэг хүн чулуу илрүүлэн олж Дарьгангын хүн чулуу хэмээх нэрээр судалгааны эргэлтэнд оруулсан байдаг . Харин хүн чулуудын голлох судалгааг археологич Д.Баяр хийж, 69 хүн чулуун чулуудын мэдээллийг багтаасан Монголчуудын чулуун хөрөг XIII-XIV зуун хэмээх бүтээлдээ хэвлүүлсэн байна . Сүүлийн үеийн судалгаагаар Монгол нутгаас 14, ӨМӨЗО-ны нутгаас 11 хүн чулууд шинээр бүртгэгдсэнээр нийт 94 хүн чулуу болж байна (Зураг 01). Хүн чулуудын тархалтыг бүс нутгийн онцлог болон уулсын системээр захын байршлыг харахад баруун тал нь Алтайн уулсын салбар, хойд тал нь Хангайн нурууны салбар, зүүн тал нь Хэнтий нуруу болон Дорнод Монголын бүсийн хэсэгт тархсан байна. Тархалт нь өнөөгийн Монгол улсын нутгийн төв, зүүн хэсгээр болон хил залгаа бүс нутгаар голлосон байдаг нь хүн чулуудыг ямар нэгэн бүс нутгийн онцлог, угсаа гарлын үүднээс зөвхөн тухайн орчимд үйлдсэнийг тодорхой харуулж байна. Мөн хүн чулуудын тархалтыг дотор нь гол цөм болон тарсан хэмээн хоёр хуваан ангилж болохоор байна. Үүнд Алтай, Хангай, Хэнтийн улсын бүс нутгаар хосоороо эсвэл ганц нэгээр тархсан байдаг. Харин Дорнод Монголын бүс нутаг болох Сүхбаатар аймгийн

* Соёлын өвийн үндэсний төвийн, Үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн
* Соёлын өвийн үндэсний төвийн, Сэргээн засварлах газрын дарга

Казакевич В.А “НАМОГИЛЬНЫЕ СТАТУН В ДАРИГАНГЕ “ Ленинградский, 1930
Баяр Д. “Монголчуудын чулуун хөрөг” УБ., 2002.
Амгаланбат Б. Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуудын дүрслэл, он цагийн зарим асуудал. УБ. 2019, (Магистрын дипломын ажил)

Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан сумдын нутгаар гол цөм буюу нэг газар олон тоогоор, бүлэглэн тархсан байдаг (Зураг 02).

Хүн чулуудын хадгалалтын харьцуулсан судалгаа 1927-2018 он: Хүн чулуудыг үйлдсэн чулуулаг дээр тулгуурлан хадгалалтын байдлыг харьцуулахын тулд бид цагаан гантиг, занарлаг, хүрмэн чулуугаар бүтсэн хүн чулуудыг сонгон авч 1927 онд В.А.Казакевич авсан гэрэл зураг, 1983-1985 онд Д. Баярын үйлдсэн гар зураг, 2018 онд өөрсдийн авсан гэрэл зургуудыг жишээн харуулсан болно. Энэхүү харьцуулалтаас хүн чулуудын эвдрэл гэмтэл эрсдэлд орж буй асуудлыг тодорхой харж болохоор байна.

Таван толгой. Сумын төвөөс баруун урагш 30 гаруй км зайд, Таван толгой хэмээх газарт 2 хөрөг бий. Эдгээрийг 1927 онд анх илрүүлсэн ба 1981 онд давтан судалжээ. 1927 он В.А.Казакевич (Зураг 03), 1981 он археологич Д.Баяр (Зураг 04) хүн чулуудын одоогийн байдал (Зураг 05).

Шивээт. Онгон сумын төвөөс урагш 40 гаруй км зайд, Шивээтийн Гурван овоо хэмээх газарт 4 хүн чулуу бий. Эдгээрийг археологич Д.Баяр1981 онд анх олж илрүүлсэн байна. 1981 он археологич Д. Баяр (Зураг 06), одоогийн байдал. (Зураг 07).


Хөргийн хөндий. Сумын төвөөс зүүн хойш 45 км зайд, Хөргийн хөндий хэмээх газарт 7 хүн чулуу баруунаас зүүн тийш цувран байрласан байна. Эдгээрийг 1927 онд илрүүлж олсон бөгөөд 1981-1984 онд давтан судалсан. 1927 он В.А.Казакевич (Зураг 08), 1981-1984 онд археологич Д. Баяр (Зураг 09), одоогийн байдал (Зураг 10).

Хүн чулуудын хамгаалалтын байдал, (Монгол болон Өвөр Монголын харьцуулсан жишээн дээр): XIII-XIV зууны үеийн хүн чулууд манай улсын нутаг болон ӨМӨЗО-ны нутагт тархсан байдгийг бид дээр дурдсан харин тэдгээрийн хамгаалалтын байдлын харьцуулан үзвэл эрс ялгаатай байдаг. Тухайлбал манай улсын нутагт орших хүн чулуудаас зөөж тээвэрлэсэн Шонх таван толгойн хүн чулууг эс тооцвол тухайн дурсгалт газар дээрээ олонх нь байдгаас гадна хугарч гэмтсэн болон дүрслэл нь элэгдсэн тохиолдол бараг бүх хүн чулууд дээр бий болсон гэж хэлж болно (Зураг 11,12). Харин ӨМӨЗО-ны нутагт орших хүн чулууд нь хадгалалтын хувьд харьцангүй сайн байгаа учир нь зөөж тээвэрлэн аюулгүй газарт байрлуулсан явдал юм. Тухайлбал хүн чулуудыг Шулуун хөх хошууны шандын музей, Зүүн үзэмчин хошууны музей, Авга хошууны музейд зөөж байрлуулсан (Зураг 13-16) байна. Энэхүү ӨМӨЗО-ны нутагт орших хүн чулуудыг нэгтгэн ойр орчмын бүс нутагт байрлах музейд зөөж байрлуулсан нь цөөхөн хэдэн хүн чулуудын хувьд тохиромжтой шийдэл болсон байдаг. Мөн манай улс сүүлийн жилүүдэд чулуун дурсгалын хадгалалт хамгаалалт дээр анхаарал хандуулж буй нь Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулж буй “Чулуун соёлын өв” хөтөлбөрийн хүрээнд зөөж тээвэрлэх журмын дагуу Онгон сумын Таван толгойн хүн чулуудыг тээвэрлэсэн нь тухайн цаг үед зөв шийдэл болсон байна . Цаашлан бид бусад хүн чулуудын хадгалалт хамгаалалт дээр хэрхэн анхаарал хандуулах талаар асуулт хэвээрээ үлдэх юм. Тэдгээр хүн чулуудыг газар дээр нь хамгаалах асуудлыг хөндөх нь зүйтэй, үүний нэгэн хариулт бол хүн чулуудыг байгаа газар дээр орчны судалгаа хийж, гэмтэл учруулж буй хүчин зүйлийг багасгах арга хэмжээ авж хадгалах хамгаалах ажил юм.

ХҮН ЧУЛУУДЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН АРГА ЗҮЙ

Хүн чулуудыг тухайн газар дээр нь хадгалж хамгаалхын тулд нэн тэргүүнд үйлдсэн чулуулгийг тодорхойлох нь чухал билээ. Манай улсын нутагт орших XIII-XIV зууны үеийн 83 хүн чулуудын 8 гантиг, 56 боржин, 3 ногоон занар, 16 хүрмэн чулуугаар үйлдсэн байдаг.

Хүн чулуудыг үйлдсэн чулуулгийн бүтэц: Чулуулаг үүсэх процесс нь цельсийн 11-12 мянган градус температур бүхий шингэн, өтгөрсөн байдалтай хайлмаг биет цагийн эрхэнд царцсаар нарийн төвөгтэй урвалын дүнд бэхжин гантиг, боржин, хүрмэн чулуу, диорит мэтийн хатуу чулуулаг болон хувирсан байдаг. Чулуулгийн силикатуудыг



бүрдүүлэгч үндсэн химийн элементүүдэд Si, O, Al, Fe2+, Fe3+, Mg, Mn, Ca, Na, K зэрэг багтдаг. Эдгээр нь чулуулаг үүсгэгч эрдсүүд бөгөөд, уулын чулуулгийн дийлэнхийг бүрдүүлэгч хээрийн жоншууд, кварууд, оливинууд, пироксенууд, амфиболууд, гранатууд энэ бүлэгт багтдаг.

Хүн чулуудыг үйлдсэн чулуулаг дунд хамгийн олон тохиолдох боржин, хүрмэн чулуун дээр жишээ авч үзвэл. Боржин нь пегматик гаралтай гол чулууны нэг бөгөөд ширхгийн хувьд том, жижиг байхаас гадна саарал, хөх, цагаан, шаргал, улаан, ягаан, ногоон, хар зэрэг олон өнгөтэй байдаг. Hvx cvвгvй, ус нэвчдэггvй, элэгддэггvй, их бөх, хvйтэн даахдаа сайн учир дурсгалуудын хувьд монгол орны эрс тэрс уур амьсгалд удаан хугацааны туршид хадгалагдаж ирэх гол хүчин зүйл нь болсон. Галт уул дэлбэрэхэд дэлхийн цөмөөс гадагшилж байгаа 6000 градус цельсийн температуртай буцламгай лав замд таарсан чулуу, шороог хайлуулж цахиурын давхар ислийг (SiO2) 40%-50%-тай агуулсан дэлхийн гадаргуун дээр түрэгдэж гарч ирсэн сүвэрхэг чулууг хүрмэн чулуу, Боржин чулуу гэдэг.

Хүрмэн чулуу нь халуун хайлмаг үедээ асар их даралтын нөлөөн доор олон талт багана хэлбэртэй болж тогтдог ба өнгө үзэмж, бат бөх чанар, хагалж цуулахад ширхэг дагаж цуурах эрсдэл бага байдаг зэргээс боржин чулуу болон хүрмэн чулууг ашиглаж байсан байх магадлал өндөр байна .

Хүн чулуудын гэмтэл ба түүнийг үүсгэж буй шалтгаан: Хүн чулуудын эвдрэл гэмтлийн хувьд механик, химийн, биологийн, байгалийн хүчин зүйлээс хамааралтай, орчинд урт удаан хугацааны туршид хадгалагдан ирсэн учир эрсдэл ихтэй байдаг.

Түүнчлэн химийн, биологийн, байгалийн хүчин зүйлээс нөлөөлж буй нь хөрсний давсжил, халуун хүйтний хэлбэлзэл, агаар мандлын бохирдол зэргээс гадна бүр задлан авч үзвэл. Шувууны сангаснаас үүсэх аммиакийн хий NH3 гэх мэт химийн болон чулуун гадарга дээр ургасан хаг бүхий биологийн гэмтэл зэрэг болно. Мөн давсны ууршилт буюу давсжилт нь хамгийн гол муудах хүчин зүйл болдог. Чулуу нь хөрсний усанд агуулагдах давсыг уусгаж авдаг (CaCO3, CaSO4, NaCl, Na2SO4 гэх мэт). Хөрсөн дахь давсны усан уусмал нь чулуунд нэвчин орж халуунд усаа ууршуулснаар чулуулгийн давсны агууламж ихэсдэг. Үүний үр дүнд чулууны хөндийд давсны талстууд үүсч чулуун хөндийн дотоод хананд гадагш чиглэлтэй аажим нэмэгдэж чулуулгийн гадаргууг гэмтээж цаашлаад чулуулгийн бүтцийг гэмтээж хагалбар үүсгэж бутлах хүчин зүйл нь болдог. Давсны талстжилт нь хөрсний уснаас шууд хамааралтай байдаг.

Өөр нэг чухал хүчин зүйл нь чулуунд ус хөлдсөнөөс болж усны эзлэхүүн тэлж мөсөн талстууд чулуулгийн эзлэхүүнийг гэмтээх юм. Харин хүн чулуудын хугарал болон эвдрэл гэмтлийн гол шатгаан бол мал, амьтан, хүнээс үүдэлтэй механик гэмтэл бөгөөд тухайн гэмтэл хүн чулууд бүрт тохиолдож буйг бид дээр харьцуулсан судалгаа

Балжинням В. Эрдэс ба чулуулаг. УБ., 2013, т. 142-148.

байдлаар тодорхой харуулсан билээ. Энэхүү хүн чулуудыг үйлдсэн, чулуулгийн төрлөөс эхлэн химийн, биологийн, байгалийн хүчин зүйлүүдийн талаар болон механик гэмтлийн тодорхой ойлголттой болсон билээ.

Харин тэдгээр эрсдэл үүсгэж буй гэмтлүүдээс цаашид хэрхэн сэргийлэх тал дээр үндсэн гурван дүгнэлт арга зүй гарч байна. Үүнд: Нэг дүгээрт байгаль орчин хүрээлэн буй орчныг сайжруулах, Хоёр дугаарт механик болон хими, биологийн гэмтлийг зогсоож, багасгах, Гурав дугаарт хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засвар хийх зэрэг арга зүйг баримталж хүн чулууд бүрт хамгаалалт хийвэл боломжтой билээ.

Хадгалалтын арга зүйн туршилт судалгаа
(Тосон бэлх болон Эрчүүдийн адгийн хүн чулуудын жишээн дээр)

Хадгалалт хамгаалалт болон бэхжүүлэлт хийх аргазүйг хээрийн нөхцөлд бодит болгож Монгол нутаг дахь эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хадгалагдан үлдсэн үл хөдлөх чулуун дурсгалын хадгалалт хамгаалалт болон сэргээн засварлалтын аргазүйг боловсруулахын тулд хүрээлэн буй орчны эрсдэлийн суурь судалгааг зайлшгүй хийсэн байх шаардлагатай. Үл хөдлөх чулуун дурсгалын хувьд гадаах орчинд байгалийн хүчин зүйлээс шууд хамааралтай гэмтэл явагддаг учир Монгол орны цаг уурын онцлогт таарсан 4 улирлын харьцуулсан судалгаа хийж үр дүнг, цаг уураас хамааралтай чийг дулааны өөрчлөлт, салхи, хөрс шорооны нөлөөллийг нэгтгэн ажиглалт судалгаа хийх хэрэгтэй байдаг. Тиймээс энэ удаагийн судалгаагаар хүрээлэн буй орчны тандалт судалгааны хаврын судалгааг бид эхлүүлж, газар дээр нь очиж чийг дулааны тандалт болон хүн чулууны гадаргуу хэсгийн гэмтэлд ажиглалт хийх байдлаар, Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших, 2011 онд археологич Д.Эрдэнэбаатар нарын, Төв Халхын нутгаар хийсэн архео-этнологийн судалгааны ажлын хүрээнд олж илрүүлсэн , Тосонбэлх, Эрчүүдийн адгийн хүн чулууд дээр чийгшил дулаан, механик гэмтэл зэргийн анхан шатны судалгааг 2019 оны 2 сарын 20 нд хийж гүйцэтгэлээ. Хүн чулуудын хувьд чулуулгийн гадаргуу хэсгийн бохирдол нь сангасын нөлөөгөөр хими, физик гэмтлийн нөлөөнд цайж, чулуулагт нэвчин орсон байдалтай байсан. Элсэрхэг кварц ихтэй говь тал хээрийн нөлөөнд салхи шороонд идэгдэн чулуулгийн гадаргуу хэсгийг сүвлэн идэж өгөршүүлсэн байдал ажиглагдсан. Хагарал цууралт ихтэй, салхи шорооны нөлөөл, нарны хэт ягаан туяаны тусгалд чулуулгийн кальцийн агууламжууд түлэгдэж харласан, малын хөлийн газарт зэрэг гэмтлийн эрсдэлтэй орчинд хадгалагдаж үлдсэн байна (Зураг 17). Мөн энэхүү хүн чулуун дээр үндэслэн цаашид хийх үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэлийн хэмжээг тодорхойлох анхан шатны судалгааны аргазүйг боловсруулан, бүтэн жилийн харьцуулсан судалгаа хийх арга зүйг бэлэн болгосон.

Хүрээлэн буй орчны эрсдэлийн судалгаа

*1.Судалгааны зорилго:*Үл хөдлөх чулуун дурсгалын материалын судалгаа хийн, хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тулгуурлаж чулуулгийн онцлогт таарсан хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга зүйг нутагшуулан, механик болон хими биологийн гэмтлийг зогсоож гадаргуу хэсгийн гүн бохирдлыг цэвэрлэн устгалд оруулж гэмтлийг багасгах зорилготой юм.

2.Чулуун дурсгалд гэмтэл үүсгэж буй шалтгаан: Тосонбэлх, Эрчүүдийн адгийн хүн чулуудын эрсдэл учруулж буй гол хүчин зүйлд дараах хүчин зүйл хамаарч байна. Үүнд:

-- Шувууны сангаснаас үүсэх аммиакийн хий NH3

--Чулуун гадарга дээр ургасан хаг бүхий биологийн гэмтэл

--Давсны хөдөлгөөн буюу давсжилт(CaCO3, CaSO4, NaCl, Na2SO4 гэх мэт)

Эрдэнэбаатар Д., Чулуун С. Төв Халхын нутгаар хийсэн архео-этнологийн судалгаа. //Nomadic heritage studies, Tom. XI, Fas-c.19,УБ., 2011, т. 227-233.

-- Цаг агаарын нөлөөлөл

-- Хүхрийн исэл (SO) ба чулуулгийн кальцийн карбонатын (CaCO3) урвал

-- Механик гэмтэл гэсэн шалтгааны улмаас чулуун дурсгалд өгөршил явагдаж эхэлсэн бөгөөд энэ удаагийн судалгаагаар эдгээр хүчин зүйлийн нөлөөлөлд орсон эсэх тандалт болон гадаргуу хэсгийн механик гэмтэл зэргийг тодорхойлох анхан шатны суурь судалгааг хийлээ (Зураг 18).

3.Сэргээн засварлахын өмнөх суурь судалгааны арга зүй: Хүн чулууны хувьд ил дурсгал учраас урт хугацааны туршид үүсэх гэмтлийн шалтгаан нь хөрсний давсжилт, халуун хүйтний хэлбэлзэл, салхи шуурга, цөлжилт, агаар мандлын бохирдлоос үүдэлтэй өгөршил буюу физик гэмтэл үргэлжлэх эрсдэл маш өндөртэй байгаа тул, урьдчилан сэргийлж, урт хугацааны хүрээлэн буй орчны судалгаа явуулж, үл хөдлөх чулуун дурсгалыг хадгалан хамгаалж, сэргээн засварлахын тулд дэс дараалсан үе шаттай арга зүй ашиглах шаардлагатай байна. Үүнд:

3.1 Гадна орчны чийгшил дулааны хэмжилт хийх: Чулуун дурсгал нь халуун хүйтэн, хуурайшилт болон чийгийн нөлөөлөлд орж өгөршил явагдаж, хагарч цуурах гэмтэл Орчны чийгшил дулааны хэмжилт хийж, багадаа 4 улирал, цаашлаад 1 жилээс дээш урт хугацааны хэмжилт явуулж чийгшил дулааны хэлбэлзэл их багын хэмжээг харьцуулан тогтоох зайлшгүй шаардлагатай байна.

3.2 Нарны тусгалын хэт ягаан туяаны хэмжилт: Чулууны гадаргууд туссан нарны тусгалын дулааны хэм харилцан адилгүй байдаг бөгөөд чулуулгийн өгөршилд нарнаас үүдэлтэй халалт нөлөөлдөг учир тусгал ихтэй гадаргуун хэсгүүдийн гэмтэл илүү явагддаг. Тиймээс чулуулгийн гадаргууд тусах нарны тусгалыг тухайн дурсгалд ямар байдлаар тусаж буйг бүрэн тогтоосон байх шаардлагатай.

3.3 Чулуунд агуулагдах усны агууламжийг хэт улаан туяаны хэмжилт хийх: Чулууны сийрэг орон зайд агуулагдах усны агууламж нь халуунд ууршиж, хүйтэнд хөлдсөнөөр чулуулгийн хатуулаг шинж чанарыг зөөллөх гэмтлийн эх үүсвэр болсоор байдаг. Ялангуяа хүйтний улиралд чулуун агуулагдах ус хөлдөж тэлэлт үүссэнээр чулуулгийн эзлэхүүнд өөрчлөлт оруулан ан цав, цууралт үүсгэж зарим тохиолдолд гадаргуу хэсгийг эмтэлж ховхлон унагаах эрсдэлтэй байдаг учир усны агууламжийг тогтоох шаардлагатай байна.

3.4 Чулуун гадаргуу дахь хагарлыг хэмжих: Чулуулагт үүссэн хагарал цууралтын хэмжээг бүртгэн баримтжуулж, урт хугацааны ажиглалт хийж, үүссэн ан цав орон зайд хуримтлагдсан бохирдол шороог цэвэрлэж битүүмжилж нөхөх шаардлагатай.

3.5 Чулуулгийн эрдсийн нягтралыг оношлох: Чулуулгийн нягтрал нь төрөл зүйл, элэгдэл гэмтэл, өгөршлөөсөө хамааран сийрэг ба нягтрал ихтэй байдаг. Чулуулгийн нягтралыг дуу авианы хэмжилт болон усны шингээлтээр хэмжиж тогтоодог. Чулуу нь бүрэлдэн тогтож буй эрдэс кварцын найрлага нь байгалийн хүчин зүйлээс хамааран сийрэгжилтэд орж хатуулаг шинж чанараа алдаж эрдсийн хооронд зай үүсэх хэлбэрээр нягтрал нь багасаж хэмхдэс болж эхэлдэг. Тиймээс урт хугацааны туршид жилдээ нэгээс багагүй чулуулгийн эрдсийн нягтралыг оношлох шаардлагатай.

3.6 Хөрсний давсжилтын хэмжээг тогтоох: Чулуулаг нь хөрсөнд агуулагдах CaCO3, CaSO4, NaCl, Na2SO4 гэх мэт төрлийн эрдэст давсыг борооны ус болон хөрсний чийгээр дамжуулан халуун үед уурших хэлбэрээр зөөгдөн өөртөө шингээж аван талст үүсгэх хэлбэрээр үлдээдэг учир эдгээр талстын хэмжээ ихсэж гадаргуу хэсэгт түрэн гарснаар чулуулгийг буталж өгөршилд оруулах эрсдэл учруулдаг. Тиймээс хөрсний давсны найрлага хэмжээг тухайн дурсгал болоод дурсгалын ойр орчмын хөрсөнд тогтоох зайлшгүй шаардлагатай.

3.7 Чулуулгийн материал судлал ба онцлог: Чулуулгийн үндсэн 3 төрлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт болон судалгаа шинжилгээ хийх арга зүйг чулуулгийн төрөл зүй онцлогт тааруулан боловсруулах шаардлагатай (Зураг 19). Чулуулгийн материал судлалыг минералогийн судалгаа болон рентген флуоресцент спектрийн шинжилгээ болон рентген дифракц спектрийн шинжилгээ гэсэн үндсэн 2 арга зүйгээр

чулуунд агуулагдаж буй эрдэс найрлагыг тодорхойлдог. Рентген флуоресценцийн шинжилгээний аргачлал нь олдворыг гэмтээхгүй гадаргуу дээр шууд шинжилгээ хийж элементийн найрлагыг бүрэн тогтоох боломжтой хэдий ч элементийн эрдсийн бүтцийн төвшинд тогтоох боломжгүй юм. XRD буюу рентген дифракц спектрийн шинжилгээний аргачлал нь зарчмын хувьд XRF багажид дүн шинжилгээтэй адилхан хэдий ч дээж бэлдцийг нунтаглаж тэгш гадарга дээр хэмжилт хийдэг учраас дээжийг бүрэн эвдэх сул талтай ч элементийн эрдсийн бүтцийг тогтоох боломжтой арга юм.


ДҮГНЭЛТ

Төв Азийн зүүн хойд хэсэгт орших агуу түүхт нүүдэлчин монголчуудын түүх археологийн голлох дурсгал болох хүн чулуудыг нэгтгэн нарийвчилсан судалгаа хийх ажлыг зохион байгуулж эхлээд байгаа билээ. Уг судалгааны нэгээхэн тулгамдсан асуудал нь хүн чулуудын хадгалалт хамгаалалт бөгөөд тэдгээрт чулуулгийн материалын судалгааг хүрээлэн буй орчны судалгаатай хослуулж механик болон химийн, биологийн гэмтлийг тодорхойлон хадгалах, хамгаалах, сэргээн засварлах арга зүйг дурсгалын онцлогт тааруулж нутагшуулах судалгааг хийх шалгавар юм.


Энэхүү судалгаа нь Монголд анх удаа хэрэгжүүлж буй судалгаа бөгөөд нүүдэлчдийн өв болох хүн чулуудыг урт хугацааны туршид авч үлдэх чухал ажлын нэг болох суурь судалгааны эхлэл болж байна. Хүн чулуудад дээрх судалгааг хийх төлөвлөгөө гаргаж, шат дараалан тандалт судалгаа хийх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ удаагийн судалгаа нь анхан шатны тандалт судалгаа байсан. Тиймээс цаашид олон талын нарийвчилсан судалгааг дотоодын нөөц бололцоог ашиглан хийж хүрээлэн буй орчны эрсдэлийн төвшинг тодорхойлж гаргаснаар хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлах аргазүйг цогц хэлбэрээр байгаль дээр нь нутагшуулах ач холбогдолтой судалгааны эхлэл боллоо.

Монгол улсын нутагт орших хүн чулууд нь түүхийн эздрээт замыг туулан хүний буруутай үйл ажиллагаанд өртөж эвдэрч сүйдэхийн зэрэгцээ байгалийн өгөршил элэгдэлд орж бутран муудсаар байна. Дурсгалыг нарийвчлан судалж, түүхийн үнэн учрыг тодруулах, хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх нь бидний үүрэг билээ.


Хавралт




(Зураг 01) Хүн чулуудын тархалтын зураг



(Зураг 02) Бүсчлэлийн зураг



(Зураг 03-05) судлаач В.А.Казакевич 1927 он, археологич Д.Баяр 1981 он, археологич Б.Амгаланбат 2018 он



(Зураг 06) археологич Д.Баяр 1981он



(Зураг 07) археологич Б.Амгаланбат 2018 он



(Зураг 08-10) Хөргийн хөндийн хүн чулууд В.А.Казакевич 1927 он, археологич Д.Баяр 1981он, археологич Б.Амгаланбат 2018 он



(Зураг 11) Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хонгорын голын хүн чулуу




(Зураг 12) Төв аймгийн Сэргэлэн сумын Хүрэн хүнтын хүн чулуу



(Зураг 13-16) ӨМӨЗО-ны Шулуун хөх хошууны Шанд хотын музей болон Авга хошууны музейн хүн чулууд



Сангасны бохирдол Механик гэмтэл Чулууний хагарал



Гадаргуу хэсгийн өгөршил Чулуулгийн сийрэгжилт

(Зураг 17) Баянцагаан сумын Тосонбэлх, Эрчүүдийн адгийн хүн чулуудын гэмтэл



(Зураг 18) Баянцагаан сумын Тосонбэлх, Эрчүүдийн адгийн хүн чулуудад



(Зураг 19) Чулуулгийн үүсэл ба төрөл зүйл

9. ТАЙХАР ЧУЛУУН ДУРСГАЛЫН ГАДАРГУУН БОРХИРДОЛ ЦЭВЭРЛЭХ АНХАН ШАТНЫ СУДАЛГАА

1.Удиртгал

Архангай аймгийн Ихтамир сумын нутагт Цэцэрлэг хотоос 22 километрт Хойд Тамир голын захад байдаг. Тайхар чулуунд Түрэг, Уйгар, Монгол, Төвд, Манж, Хятад зэрэг эрт эдүгээгийн олон улс үндэстний хэлээр бичсэн YII-XYII зууны үеийн 150 гаруй бичээс байдаг боловч он жил өнгөрөх тусам чулуулгийн физик өгөршил болон механик гэмтлийн нөлөөнд улам бүдгэрсээр байна. Бичээсийн 70 орчим нь Монгол үсгээр бичсэн байдаг.

Тайхар чулууны өндөр нь 18 метр бөгөөд боржин чулуунаас бүтсэн цохион дурсгал дээр ажиллаж дурсгалын механик болон органик гэмтэл бохирдлын хүчин зүйл болсон олон төрлийн будаг болон тос, сүү өргөх, шувуу хооллох гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүрээлэн буй орчны бохирдол, хими биологийн гэмтлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж уг дурсгалын эх төрхийг алдагдуулан бохирдуулж эрээчсэн бичээс будгуудын төрлийг ангилах, арилгах анхан шатны сорил тавих ажлуудыг хийв.

2.Судалгааны зорилго

Үл хөдлөх чулуун дурсгалын материалын судалгаа хийж, хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, нарийвчилсан суурь судалгааны үндсэн дээр тулгуурлаж чулуулгийн онцлогт таарсан хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын арга зүйг нутагшуулан, механик болон хими биологийн гэмтлийг зогсоож гадаргуу хэсгийн гүн бохирдлыг цэвэрлэн устгалд оруулж гэмтлийг багасгах зорилготой юм.

3.Чулуун дурсгалд гэмтэл үүсгэж буй шалтгаан

Чулуун дурсгал тэр дундаа үл хөдлөх ил чулуун дурсгалд эрсдэл учруулдаг гол хүчин зүйлд дараах хүчин зүйл хамаардаг. Үүнд:

-- Шувууны сангаснаас үүсэх аммиакийн хий NH3

--Чулуун гадарга дээр ургасан хаг бүхий биологийн гэмтэл

--Давсны ууршилт буюу давсжилт(CaCO3, CaSO4, NaCl, Na2SO4 гэх мэт)

-- Цаг агаарын нөлөөлөл

-- Хүхрийн исэл (SO) ба чулуулгийн кальцийн карбонатын (CaCO3) урвал

-- Механик гэмтэл гэсэн шалтгааны улмаас чулуун дурсгалын өгөршиж эхэлдэг бөгөөд энэ удаагийн судалгаагаар эдгээр хүчин зүйлийн нөлөөлөлд орсон эсэх тандалт болон гадаргуу хэсгийн механик гэмтэл болох будаг, тосны бохирдол цэвэрлэх туршилт хийсэн.





4.Сэргээн засварлахын өмнөх суурь судалгааны арга зүй

Тайхар чулууны хувьд ил дурсгал учраас урт хугацааны туршид үүсэх гэмтлийн шалтгаан нь хөрсний давсжилт, халуун хүйтний хэлбэлзэл, салхи шуурга, цөлжилт, агаар мандалын бохирдлоос үүдэлтэй өгөршил буюу физик гэмтэл үргэлжлэх эрсдэл маш өндөртөй байгаа тул, урьдчилан сэргийлж, урт хугацааны хүрээлэн буй орчны судалгаа явуулж, үл хөдлөх чулуун дурсгалыг хадгалан хамгаалж, сэргээн засварлахын тулд дэс дараалсан үе шаттай арга зүй ашиглах шаардлагатай байна. Үүнд:

4.1 Гадна орчны чийгшил дулааны хэмжилт хийх.

Чулуун дурсгал нь халуун хүйтэн, хуурайшилт болон чийгийн нөлөөлөлд орж өгөршил явагдаж, хагарч цуурах гэмтэл Орчны чийгшил дулааны хэмжилт хийж, багадаа 4 улирал, цаашлаад 1 жилээс дээш урт хугацааны хэмжилт явуулж чийгшил дулааны хэлбэлзэл их багын хэмжээг харьцуулан тогтоох зайлшгүй шаардлагатай байдаг.

4.2 Нарны тусгалын хэт ягаан туяаны хэмжилт

Чулууны гадаргууд туссан нарны тусгалын дулааны хэм харилцан адилгүй байдаг бөгөөд чулуулгийн өгөршилд нарнаас үүдэлтэй халалт нөлөөлдөг учир тусгал ихтэй гадаргуун хэсгүүдийн гэмтэл илүү явагддаг. Тиймээс чулуулгийн гадаргууд тусах нарны тусгалыг тухайн дурсгалд ямар байдлаар тусаж буйг бүрэн тогтоосон байх шаардлагатай.

4.3 Чулуунд агуулагдах усны агууламжийг хэт улаан туяаны хэмжилт хийх

Чулууны сийрэг орон зайд агуулагдах усны агууламж нь халуунд ууршиж, хүйтэнд хөлдсөнөөр чулуулгийн хатуулаг шинж чанарыг зөөллөх гэмтлийн эх үүсвэр болсоор байдаг. Ялангуяа хүйтний улиралд чулуун агуулагдах ус хөлдөж тэлэлт үүссэнээр чулуулгийн эзлэхүүнд өөрчлөлт оруулан ан цав, цууралт үүсгэж зарим тохиолдолд гадаргуу хэсгийг эмтэлж ховхлон унагаах эрсдэлтэй байдаг учир усны агууламжийг тогтоох шаардлагатай байдаг.

4.4 Чулуун гадаргуу дахь хагарлыг хэмжих

Чулуулагт үүссэн хагарал цууралтын хэмжээг бүртгэн баримтжуулж, урт хугацааны ажиглалт хийж, үүссэн ан цав орон зайд хуримтлагдсан бохирдол шороог цэвэрлэж битүүмжилж нөхөх шаардлагатай.

4.5 Чулуулгийн эрдсийн нягтралыг оношлох

Чулуулгийн нягтрал нь төрөл зүйл, элэгдэл гэмтэл, өгөршлөөсөө хамааран сийрэг ба нягтрал ихтэй байдаг. Чулуулгийн нягтралыг дуу авианы хэмжилт болон усны шингээлтээр хэмжиж тогтоодог. Чулуу нь бүрэлдэн тогтож буй эрдэс кварцын найрлага нь байгалийн хүчин зүйлээс хамааран сийрэгжилтэд орж хатуулаг шинж чанараа алдаж эрдсийн хооронд зай үүсэх хэлбэрээр нягтрал нь багасаж хэмхдэс болж эхэлдэг. Тиймээс урт хугацааны туршид жилдээ нэгээс багагүй чулуулгийн эрдэсийн нягтралыг оношлох шаардлагатай.







4.6 Хөрсний давсжилтын хэмжээг тогтоох

Чулуулаг нь хөрсөнд агуулагдах CaCO3, CaSO4, NaCl, Na2SO4 гэх мэт төрлийн эрдэст давсыг борооны ус болон хөрсний чийгээр дамжуулан халуун үед уурших хэлбэрээр зөөгдөн өөртөө шингээж аван талст үүсгэх хэлбэрээр үлдээдэг учир эдгээр талстын хэмжээ ихсэж гадаргуу хэсэгт түрэн гарснаар чулуулгийг буталж өгөршилд оруулах эрсдэл учруулдаг. Тиймээс хөрсний давсны найрлага хэмжээг тухайн дурсгал болоод дурсгалын ойр орчмын хөрсөнд тогтоох зайлшгүй шаардлагатай.

4.7 Чулуулгийн материал судлал ба онцлог

Чулуулгийн үндсэн 3 төрлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт болон судалгаа шинжилгээ хийх арга зүйг чулуулгийн төрөл зүй онцлогт тааруулан боловсруулах шаардлагатай.

Чулуулгийн материал судлалыг минералогийн судалгаа болон рентген флуоресцент спектрийн шинжилгээ болон рентген дифракц спектрийн шинжилгээ гэсэн үндсэн 2 арга зүйгээр чулуунд агуулагдаж буй эрдэс найрлагыг тодорхойлдог.

Рентген флуоресценцийн шинжилгээний аргачлал нь олдворыг гэмтээхгүй гадаргуу дээр шууд шинжилгээ хийж элементийн найрлагийг бүрэн тогтоох боломжтой хэдий ч элементийн эрдсийн бүтцийн төвшинд тогтоох боломжгүй юм. XRD буюу рентген дифракц спектрийн шинжилгээний аргачлал нь зарчмын хувьд XRF багажид дүн шинжилгээтэй адилхан хэдий ч дээж бэлдцийг нунтаглаж тэгш гадарга дээр хэмжилт хийдэг учраас дээжийг бүрэн эвдэх сул талтай ч элементийн эрдсийн бүтцийг тогтоох боломжтой арга юм. Тайхар чулуун дээр эдгээр судалгааг хийх төлөвлөгөө гаргаж, шат дараалан тандалт судалгаа хийх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ удаагийн судалгаа нь анхан шатны тандалт судалгаа байсан бөгөөд багаж техникийн дутмаг байгаа шалтгаанаар хийх боломжгүй байна.

5.Тайхар чулуулгийн дурсгалд хийсэн анхан шатны сорил судалгаа

Манай судлаачид Тайхар чулуун дурсгалын гадаргуу хэсгийн механик, хими, биологийн гэмтлийг анхан шатанд тодорхойлж газар болон агаарын зураглал хийн бохирдол хэсгийг баримтжуулсан. Мөн гадаргуу хэсгийн будагдсан бохирдол дээр төрөл зүйн ангилал хийж, цэвэрлэж устгах туршилтыг сорил тавьж хийсэн. Чулуулгийн өндөр дунджаар 18 метр, 4 талт бөгөөд 1 талын урт нь 10 метр гэж тооцож нийт чулуулгийн бичээс бичих боломжтой гадаргуу 720-оос 800 метр квадрат байна гэж үзсэн.

6.Судалгааны үр дүн

Чулуун дурсгалын нийт гадаргуу хэсэгт газраас дээш 5 м орчим өндөрт ялангуяа хүний гар хүрэх хэсгүүдэд төрөл бүрийн бичвэр болох бохирдол маш ихээр нэмэгдсэн байдалтай байсан. Бохирдол хэсгүүд нь он цагийн хувьд 1970-аад оноос хойш одоог хүртэл үргэлжилсэн байх тэмдэг тэмдэглэгээ үлдсэн байна.

Дурсгалыг бохирдуулсан будгийн болон бусад бохирдлын төрөл:

- Тосон будаг /хуучин, шинэ/
- Шүршдэг будаг
- Маркер
- Цагаан өнгийн бичгийн штрик
- Сийлмэл бичгүүд
- Сүү өргөх
- Тос түрхэх
- Шувуу хооллосны улмаас тагтаа болон бусад шувуудын сангас
- Хаг
- Физик өгөршил багтаж байгаа ба эдгээр нь эрээчиж бохирдуулсан цаг үеийн хувьд харьцангуй өөр өөр байна.

Тосон будгийн доорх өнгүүд дурсгалын бохирдолд зонхилж байна.

- Цагаан



- Ногоон
- Улаан
- Улбар шар
- Шар
- Хөх
- Цэнхэр

Эдгээр будгийн бохирдлууд дээр доорх төрлийн уусгагчдыг хэрэглэн бэгнэх болон шууд арчиж уусгах зэргээр сорил хийж үзэв.

- Ксилол C8H10
- Толуол C7H8
- Ацетон C3H6O
- Уайт спирит

Бэгнүүр тавьж сорил хийхдээ дурсгалын гадаргууд нэлээд хуучирч удсан зузаан давхарга бүхий тосон будгийг сонгож дээрх уусгагчдыг тус тусад нь хөвөнд шингээн нийлэг уутаар битүүлэн скочоор даруулж 30-40минут хугацаатай байлгаж бэгнүүрийг нэг бүрээр нь сөхөж тухайн уусгагчдаар арчих болон механик аргаар хөндийрүүлэх, будгийн зузаан давхарга бүхий хэсгүүдийг ховхлох зэргээр цэвэрлэсэн ба эдгээрээс хамгийн үр дүнтэй уусгагч нь ксилол байв. Ксилолоор бэгнэсэн хэсгийн будгийн давхарга нийтдээ дэвтэн хөндийрч улмаар механик цэвэрлэгээ хийхэд чулууны нарийн судалд сууж үлдэх будгийн үлдэгдлийг эс тооцвол бараг бүрэн арилгах боломжтой байв. Харин бусад уусгагчууд хуучин тосон будгийн давхаргыг бага зэрэг хөдөлгөж байсан боловч бүрэн нэвчих эсвэл хөндийрүүлж чадахгүй байв.

Гэвч бусад уусгагчууд тус бүрийн онцлог шинж чанар болон бохирдуулж буй будгийн онцлог зузаан нимгэнээс хамааран өөр өөр үр дүнг үзүүлж байв жишээ нь Уайт-спирит маркераар бичсэн бичээсийг арилгахад илүү амар, хурдан байсан бол харьцангуй сүүл үед будсан байж болох эмальтай будаг гэгддэг гялгар гадаргуу үүсгэдэг тосон будгууд дээр ацетон илүү үр дүнтэй байв.

Штрикээр бичиж эрээчсэн хэсгүүд дээр мөн дээрх уусгагчуудаар тест хийж үзхэд ксилол илүү үр дүн үзүүлж байв.

Харин чулуун дурсгалын эргэн тойронд өргөсөн сүү болон тосны бохирдлыг арилгахад толуол буюу тосонд уусах чадвартай үнэрт нүүрс ус төрөгч үр дүн сайтай байсан.

Мөн чулуулгийн гадаргуу хэсгийн хүрээлэн буй орчноос хамаарах, ялангуяа нарны хурц гэрэл, чийгшил дулааны хэлбэлзлийн нөлөөлөлд хэрхэн гандаж буй гандалтын төвшинг тодорхойлох зорилгоор дурсгалын гадаргуу хэсэгт хэд хэдэн өнгөний хэмжилтийг хийсэн.

7.Хадгалалт хамгаалалт ба сэргээн засварлах аргазүй

Уг дурсгал ил дурсгал учраас хүрээлэн орчны олон талын эрсдэлийг тооцож судалгаа шинжилгээ явуулах шаардлагатай бөгөөд нэн яаралтай механик, хими, биологийн гэмтлийг багасгах нь чухал байна. Хүхрийн исэл (SO), Шувууны сангаснаас үүсэх аммиакийнNH3 хийнээс үүсэлтэй чулуулгийн кальцийн карбонатын (CaCO3) урвал нь чулуулгийг зөөллөж өгөршүүлдэг учир шувууны сангас, амьтны сэг зэмээс тусгаарлах мөн агаарын бохирдлыг тооцож хяналт тавих шаардлагатай. Ил дурсгалын хувьд өгөршиж цуурсан хэсгүүд болон эргэн тойрны чулуулгийн цуурч ангайсан хэсгүүдэд хаг ургаж улмаар чулуулгийн хатуулаг болон цууралтад нөлөөлж хагны төрлөөсөө хамаарч хувирмал чулуулаг ялангуяа шохойн чулуулгийн эпилит хайрст, наалдмал хаг боргол хадандай, талын наалдаахай зэрэг нь чулуулгийн дотор 20 мм орчим гүн шигдэж тухайн чулуулгийг уусгах бодисыг ялгаруулж уулын чулуулгийн биологийн өгөршлийн процессыг нэг талаар түргэсгэх эрсдэл үзүүлдэг учир цууралтыг нөхөж гадаргуу хэсгийн орон зайг багасгаж битүүмжлэх шаардлагатай. Чулуулгийн цууралтыг нөхөж гадаргуу хэсгийн орон зайг багасгаснаар чулуулагт салхиар туугдан дүүрсэн шороо тэдгээрт ургасан өвс ургамлын үндэсний тэлэлтээс үүдэлтэй гэмтлийг мөн зогсоох давуу талтай.

Хөрсний давсжилт болон нарны хурц гэрлийн нөлөөллийг багасгаж зогсоохийн тулд саравч хийж дурсгалыг дэглэх боломжтой бөгөөд механик гэмтэл болох хүн малын буруутай үйл ажилгаа, байгалын эрсдэл болох үер ус, газар хөдлөлт гэх мэт гамшигаас урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлсэн байх зайлшгүй шаардлагатай ба ил чулуун дурсгалын эх төрхийг хадгалан үлдээхийн тулд:

- Байгаль орчин хүрээлэн буй орчныг сайжруулах
- Механик болон хими, биологийн гэмтлийг зогсоож, багасгах
- Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засвар хийх
- Хэв авч хуулбар хийх замаар хадгалан хамгаалах боломжтой юм.

Чулуун дурсгалын эрсдэлийг тодорхойлох хадгалалт хамгаалалт сэргээн засварлалтын ерөнхий судалгаа нь олон салбарын шинжлэх ухааны арга зүйд суурилсан урт хугацааны судалгаа шинжилгээний үр дүнд харьцуулалт хийж хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт боловсруулан хийдэг онцлогтой судалгаа хэрэгтэй юм.

8. Цаашид хийгдэх судалгаа

Цаашид яаралтай дээрх дутуу орхигдсон нарийвчилсан судалгааг бүрэн хийж, материалийн онцлог болоод эрсдэлийг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх аргазүйг боловсруулж хадгалан хамгаалах, сэргээн засварлах аргазүйг нутагшуулах урт хугацааны судалгаа, багажит дүн шинжилгээ хослуулсан шинжилгээ үр дүнд суурилсан аргазүй боловсруулах хэрэгтэй байна. Мөн чулуун дээрх дурсгалт бичээс хэсгүүд байх газрыг бүрэн тодорхойлж, гэмтлийн хувь хэмжээг тогтоож, сэргээх боломжтой эсэх талаар сорил тавьж эрсдэлийг тооцох судалгаа хийж, бохирдлыг бүрэн цэвэрлэж, хүрээлэн буй орчны эрсдэлийг багасгах урт хугацааны судалгааны төлөвлөгөө гаргаж ажиллах зайлшгүй шаардлагатай байна.



Будгийг арилгах сорьц



Бичээстэй хэсгүүд




Сорил тавьсан байдал



Гандалт хэмжиж буй байдал



Сангас арилгах сорьц




Будагдсан байдал



Найрлага тогтоох байдал




Хаг ургасан байдал




Өгөршиж буй байдал




Тос түрхэгдсэн байдал












Механик гэмтэл
Олон давхарлаж бичсэн хэсэг
Дангаар нь бичсэн хэсэг
Сүү болон тос түрхсэн хэсэг

Биологийн бохирдол
Хаг
Сангас


Хойд тал
18 m
0
10 m
Зүүн тал
18 m
0
10 m
Механик гэмтэл
Олон давхарлаж бичсэн хэсэг
Дангаар нь бичсэн хэсэг
Сүү болон тос түрхсэн хэсэг
Биологийн бохирдол
Хаг
Сангас

№1.3. “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

Гүйцэтгэлийн зорилт №1.3 “Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр”-2020 төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Төлөвлөлтийн уялдаа:

1. Засгийн газрын 2019 оны 68 дугаар тогтоол “Соёлын биет бус өвийг хамгаалах хөтөлбөр”

2. БСШУС-ын сайдын 2019 оны А/235 дугаар тушаал, төлөвлөгөөний 2.1.3 дахь бүтээгдэхүүн

3. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр баталсан “Соёлын өвийн үндэсний төвийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2015-2050”бичиг баримт. Тэргүүлэх чиглэл 2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН БҮРТГЭЛ, СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР. Стратегийн зорилт 2.1. Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах тогтворжсон арга зүй, аргачлалтай болсон байх; Стратегийн зорилт 2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагатай соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр хамтын ажиллагааг сайжруулах;

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.3.1-р арга хэмжээ.

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ”-ИЙГ БОЛОВСРУУЛАВ

“Соёлын биет бус өвийн үндэсний хөтөлбөр”-2020 төлөвлөгөөн дахь 2.1.2,2.1.3 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх.

Соёлын биет бус өвийн үзлэг зохион байгуулахад хамтран оролцох.

Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамжийг боловсруулах:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1. /Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд... соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна/, “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг 2019-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.3.-т хуулинд заасны дагуу Соёлын биет бус өвийн үзлэг, тооллогыг зохион байгуулна гэж тусгагдсан.

Үзлэг, тооллогын бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын хэрэгжилтийг хангах, Монгол улсын үндэсний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтын байдлыг нягтлан үзэж дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор “Соёлын биет бус өвийн үзлэг хийх ажлын удирдамж”-ыг боловсруулсан.

Удирдамжид үйл ажиллагаатай холбоотой арга зүйг дараах байдлаар тодорхой зааж өгсөн. Үүнд:

- Салбар комиссыг байгуулах, /Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга салбар комиссын даргаар ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга эсхүл Боловсрол, соёл урлагийн газрын даргыг томилж ажиллуулна гэх мэт байдлаар тодорхой зааж өгсөн/
- Үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаа, /Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох, Үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах, соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тандан судлах, олж тогтоох хээрийн судалгаа, Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, өвлөн уламжлагч, ард иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах хээрийн судалгаа, Үзлэгээр цуглагдсан мэдээллийг нэгтгэн тайлагнах, дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах/
- Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын оролцоо,
- Үзлэг зохион байгуулах ажлын календарчилсан төлөвлөгөө,
- Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын ажиллах хуваарь, /Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т заасан бүсчлэлийн дагуу Аймаг, нийслэлийн салбар комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, Их дээд сургууль, Судалгааны хүрээлэн, эрдэмтэн судлаач нарыг томилон ажиллуулахаар тусгасан/
- Соёлын биет бус өвийн нийтлэг өвийн төрөл зүйлс, /6 ай савын хүрээнд нийтлэг өвийн нэр томъёог оруулсан/
- Соёлын биет бус өвийн онцлог өвийн төрөл зүйлс, /Тухайн аймагт хамаарах өвийн онцлог төрөл зүйлс/
- Үзлэгийн ажлыг тайлагнах зэрэг болно.

Тайлбар:

1. Тухайн бүс нутагт шилжилт хөдөлгөөнөөс хамааран тухайн орон нутагт суурьшсан угсаатны бүлгүүдийг соёлын биет бус өвийг үзлэгт хамруулна.

2. Үзлэгийг хийхдээ тухайн өвийн онцлогоос хамаарч ёс, заншил зан үйл, өвийг үйлдэхэд хамаарах улирал, цаг хугацааг хүндэтгэн үзэх зарчим баримтална.

3. Нийслэлийн дүүргүүдийн угсаатны бүлэг, онцлог өвийн төрөл зүйлсийг нарийвчлан гаргах боломжгүй тул шилжилт хөдөлгөөнөөс хамааран хавсралт 2-т заасан өвийн төрөл зүйлсийг бүгдийг хамруулж авч үзнэ.

Хавсралт 1

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам”-ын хэрэгжилтийг хангах, Монгол улсын үндэсний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтын байдлыг нягтлан үзэж дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Соёлын биет бус өвийн үзлэгийг бүлэг хамт олон, өвлөн уламжлагч хувь хүнтэй уялдуулан тухайн өвийн оршин байгаа газар, ахуй орчинд нь үзлэгийг хийх

Монгол улс дахь үндэстэн, угсаатны нийтлэг хэв шинжтэй соёлын биет бус өвийн төрөл, зүйл, угсаатны бүлгийн онцлог өвүүдийг заавал хамруулах зарчим баримтална. /Хавсралт 1, 2-т нийтлэг болон бүс нутгийн, угсаатны онцлог өвийн жагсаалтыг тусгав, Нийслэлийн дүүргүүдийн угсаатны бүлэг, онцлог өвийн төрөл зүйлсийг нарийвчлан гаргах боломжгүй тул шилжилт хөдөлгөөнөөс хамааран хавсралт 1, 2-т заасан өвийн төрөл зүйлсийг бүгдийг хамруулж авч үзнэ./

Хоёр. Зохион байгуулагч

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, Урлагийн газар
Дэмжигч байгууллага:
Соёлын өвийн үндэсний төв
Нийслэлийн соёл, урлагийн газар
21 аймаг, 9 дүүргийн ЗДТГ

Үзлэг хийх хугацаа:

2020 оны 5 дугаар сарын 15-аас 2021 оны 5 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Хамрах хүрээ:

Нийслэлийн 9 дүүргийн 152 хороо, 21 аймгийн 328 сум.

Гурав. Салбар комиссыг байгуулах

3.1. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга салбар комиссын даргаар ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга эсхүл Боловсрол, соёл урлагийн газрын даргыг томилж ажиллуулна.

3.2. Салбар комиссын бүрэлдэхүүнд үзлэгт хамрагдаж буй байгууллагын дарга, захирлыг заавал оролцуулна.

3.3. Салбар комиссын нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан ажилтан /мэргэжилтэн/ байна.

3.4. Үзлэгийн явцад хүндэтгэн үзэх шалтгаангүй салбар комиссын дарга, гишүүдийг чөлөөлж өөрчлөхгүй.

3.5. Салбар комиссын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас комиссын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах боломжгүй болсон бол нарийн бичгийн дарга түр хугацаанд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж болно.

Дөрөв. Үзлэгийг зохион байгуулах үйл ажиллагаа

4.1. Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох:

4.2. Үзлэг хийх бэлтгэл ажлыг хангах, сургалт зохион байгуулах:

4.3. соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тандан судлах, олж тогтоох хээрийн судалгаа:

4.4. Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, өвлөн уламжлагч, ард иргэдтэй уулзаж мэдээлэл цуглуулах хээрийн судалгаа:

4.5. Үзлэгээр цуглагдсан мэдээллийг нэгтгэн тайлагнах, дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах.

Тав. Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын оролцоо

5.1. Аймаг, нийслэлийн салбар комисст мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, Их дээд сургууль, Судалгааны хүрээлэн, эрдэмтэн судлаач нарыг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилон ажиллуулна.

5.2. Аймаг, нийслэлд томилолтоор ажиллах эрдэмтэн судлаачдын томилолт, ажлын хөлсийг тухайн салбар комисс хариуцна.

Зургаа. Үзлэгийн ажлыг тайлагнах

6.1. Салбар комисс үзлэгийн ажлын тайланг тогтсон хугацаанд Төв комиссд ирүүлнэ.

6.2. Салбар комисс тайландаа холбогдох байгууллагын зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагааны талаарх санал дүгнэлтийг тусгана.

-oOo-

Соёл, урлагийн газрын даргын
2020 оны .. дугаар сарын .. өдрийн
.. тоот тушаалын хавсралт

ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1. Бэлтгэж ажлын хүрээнд:			
1.1.	Үзлэгийн ажлын удирдамж, төлөвлөгөөг холбогдох байгууллагад хүргүүлэх	2020.05.15	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
1.2.	Үзлэг хийхэд ашиглах гарын авлага боловсруулж, хэвлүүлэх,	2020.6.10	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс Соёлын өвийн үндэсний төв
1.3.	Соёлын биет бус өвийг бүртгэх програм хангамжийг бий болгох	2020.6.20	ЗГХА, Соёл, урлагийн газар Соёлын өвийн үндэсний төв
1.4.	Мэргэжил, аргй зүйгээр хангах нэгдсэн сургалт зохион байгуулах	2020.6.25	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
2. Үзлэйин ажлыг зохион байгуулах хүрээнд:			
2.1.	Салбар комиссыг байгуулах	2020.6.30	ЗГХА, Соёл, урлагийн газар Улсын комисс
2.2.	Үзлэгийн ажлыг эхлүүлэх	2020.8.01	Улсын комисс Салбар комисс
2.3.	Үзлэгийн ажлыг зохион байгуулж дуусгах	2021.5.15	Улсын комисс Салбар комисс
3. Үзлэгийн ажлын дүнг тайлагнах:			
3.1.	Салбар комиссоос үзлэгийн тайланг төв комисст хүргүүлэх	2021.6.15	Улсын комисс Салбар комисс
3.2.	Үзлэгийн ажлыг тайлагнах	2021.6.30	Улсын комисс

---oOo---

Соёл, урлагийн газрын даргын
2020 оны .. дугаар сарын .. өдрийн
.. тоот тушаалын хавсралт

Үзлэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагуудын ажиллах хуваарь

№	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.3-т заасан бүсчлэл	СББӨ-ийн үзлэгт хамрагдах бүс нутгийн дэд бүсчлэл	Хариуцах байгууллагын нэрс
1.	Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	1.1. Баян-Өлгий, Увс, Ховд	- Ховд их сургууль - Соёл, урлаг судлалын хүрээлэн - “Монгол тууль” ТББ - “Хүннү цуурчдын холбоо” ТББ
		1.2. Говь-Алтай, Завхан,	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн - Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж - “Баруун монголын урлаг соёлын төв” - “Монгол бүжиг” төв
2.	Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл	2.1. Архангай, Булган, Өвөрхангай	- ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн - Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа - “Айрагны Нутгаар” ТББ - “Уран хатгамалчдыг дэмжих Эгнэшгүй санаа” ТББ
		2.2. Баянхонгор, Орхон, Хөвсгөл	- ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн - ШУА-ын Хэл зохионын хүрээлэн - Соёл урлагийн их сургууль - “Монгол тулгатны өв” ТББ
3.	Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь,	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь,	- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн - “Тахилгат газрын судалгаа, мэдээллийн төв”

	Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв		- Монгол тулгатны өв
		Дархан-Уул, Сэлэнгэ, Төв	- Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн - "Уртын дууны холбоо" - Монголын ардын уламжлалт урлагийг хөгжүүлэх "Икэл сан" - "Монгол Шувуучлахуйн холбоо"
4.	Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий	- Соёл, урлагийн их сургууль - "Буриад судлалын академи" - "Буриадын соёл спортын холбоо" - "Монгол шагайн харваа" ТББ	
5.	Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.	5.1. Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг	- Нийслэлийн соёл, урлагийн газар - ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн - "Монгол костюмс" - "Монгол дархан"-ы холбоо
5	1.Бямбасүрэнгийн гүүр усаалтын нүүр-Байгалийн музей 2020-05-05-ны 44 тоот, 1980 онд музейд бэлэглэсэн "Хүрэл морь"-ийг бэлэглэгч Г.Цэллэмээ, түүний ачхуужир бүүвэй авахаар Нийслэлийн захиргааны харилцаа шүүхэд жижиглэгдэн тараасан түүх жижиглэгдэл арга нэрийн тусламж үзүүлэх хүсэлт. **Шийдвэрлэсэн :** Тухайн үеийн тодорхойлолт, Монгол Улсын өмч болох, музейн эд хөрөнгийн жагсаалт, музейн үзмэрийг шилжүүлэх хөдөлгөөнгүй байх тухай 7 хэсэгтэй акт гаргаж хүргүүлсэн. 2.Нийслэлд дэх захиргааны харилцаа шүүхэд 2020-06-08-ны 1/4404 тоот, нотлох баримтын шаардлага хангуулан ирүүлэхийг хүссэн. **Шийдвэрлэсэн :** Шүүгчийн хүсэлтийн дагуу музейд үзүүлсэн акт гаргаж 1 хувийг нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлэх.		Музейн ЕБД-т "Хос хүрэл адуу" жартай, х.д 80.1.3 хувийн 8.5х63 см, жин 177 гр, Хүрэл хөлөгийн үе	1	1		
6	Хан-Уул дүүргийн дэх цагдаагийн газрын жолоодлого хэлтэс, 2020.06.10-ны 2711-2/3168 тоот, шинжээч томилж, дүгнэлт гаргуулах тухай. **Шийдвэрлэсэн :** Эд өлгийн зүйлийг биет хэлбэрээр гаргуулахын хүсэлт харгуулбан тоот ирүүлсэн.						

- Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газарт “Монг-Эм” ХХК-ны барилгын өргөтгөл зурагт зөвлөмж боловсруулан 2020 оны 01/316 тоот албан бичгээр тус тус зөвлөмж, дүгнэлтийг цаг тухайд нь хүргүүлж ажилласан.

7	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн 2020-06-19-ны 02-03/2614 тоот, Тагтай данх, Цанц, Цорго, Бадны тагтаасан хийдшижилгээ хийлгэх. **Шийдвэрлэсэн :** Захиалгадсан Данх түүх, соёлын дурсгалд хүйл болно, бусадынхамаардахгүй		Тагтай данх. Гууль, 13х18см	1	1		Соёлын өвийн үндэсний төвийн БСОСЗ-ын дарга М.Оюунтуяа, сэргээн засварлагч Н.Жамбал, Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч, шинжээч Ш.Энхтуяа,
8			Цанц. 2ширхэг, гууль, 6, 5.2см, Цорго. Гууль, 10 см. Бадны таг. 3ш, 9.5х13см	4		4	
9	Иргэн Э.Отгонбаатар /ОД 86121718/-ын ирүүлсэн 5 дархны бүтээлд тодорхойлолт гаргасан. Шийдвэрлэсэн: Соёлын өвийн үндэсний төв 2020-11-06-ны № 01/335 тоот албан бичгээр Түүх, соёлын дурсгалт хүйлдхамаардахүй тухай тодорхойлолт, хэвлэлт бүтээлийн төлөө танилцуулга /Өвөр Монголын иргэний хөгжлөөр хийж Өвөр Монгол хүүхэлдэр/		Арюхны сав. Мөнгө, 5 хэсэг сагана. Өндөр 35, жин 1036гр	1		1	Соёлын өвийн үндэсний төвийн Сэргээн засварлагч Н.Жамбал, Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч, шинжээч Ш.Энхтуяа,
10			Дундаргын мөнгөн аяганы тонот. 3хэсэг, голч 12см, 8.2см, 3.7 см, ул хэс 6.4см. Нийт жин 187гр	1		1	
11		 	Дундаргын мөнгөн аяганы тонот. 2хэсэг, голч 12см, 6.4см, 3.7 см, Ул хэс 6.4 см. Нийт жин 136гр	2		2	
12			Багаргын мөнгөн аяганы тонот. 3хэсэг, голч 7см, 5.4см, 3.7 см, жин 84гр	1		1	
13			Багаргын мөнгөн аяганы тонот. 2хэсэг, голч 7см, 3.5см, жин 43гр	1		1	

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2019.8.20 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/619 тоот захирамжаар Улаанбаатар музейг сэргээн засварлах, анхны түүхэн дурсгалт барилгаас бусад өргөтгөсөн хэсгийг буулгаж өргөтгөлийг шинэ барилга барих зураг төсөл боловсруулах шийдвэр гарсантай холбогдуулан Улаабаатар музейгээс 2019 оны 7-р сарын 5-ны 66 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гишүүд барилгын нөхцөл байдлыг газар дээр нь очиж үзээд дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын музей нь Ардын Засгийн газар, Ардын намын Төв хороо түр байрлаж байсан түүхийн дурсгалт барилгад байрладаг бөгөөд албан ажлын зориулалтаар барилгын ар талд буюу зүүн талд өргөтгөж гурван тасалгаанд үйл ажиллагаагаа явуулж байна. Уг өргөтгөлийг хэсгийг газар дээр судалж үзэхэд анхны барилгатай залгаж шинээр барьсан байна. Тийм ч учраас буулгаж шинэ өргөтгөл барихаар НЗД-ын шийдвэр гарсныг дэмжих;
2. Улаанбаатар музей байрлах түүхийн дурсгалт барилгад хэмжилт судалгаа хийж анхных нь төрх байдлаар сэргээн засварлах зураг төсөл боловсруулж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллагаар сэргээн засварлуулах;
3. Шинээр барих өргөтгөлийн барилга нь дурсгалт барилгын харагдах сүр барааг хаахгүй байх, архитектур, өнгө, зохиомж, орон зайн төлөвлөлтийн хувьд түүхийн дурсгалт барилгатайгаа зохицсон байх, өргөтгөлийн барилга нь арын фон болж дурсгалт барилгаа тодотгож өгсөн байх зэрэг шийдлийг бодолцох.

---o O o----

Шинжээчийн зөвлөлийн дарга: З.Оюунбилэг (МУ-ын Зөвлөх архитектор, доктор)

Гишүүд: Г.Анхсанаа (СӨҮТ-ийн СӨАХГазрын дарга)

Б.Адъяа (Архитектор)

Нарийн бичгийн дарга: Ц.Цолмон (СӨҮТ-ийн Дэлхийн өвийн дурсгал хариуцсан мэргэжилтэн)

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2020.4.08 Улаанбаатар хот

Улаанбаатар хотын музейг сэргээн засварлах, анхны түүхэн дурсгалт барилгаас бусад өргөтгөсөн хэсгийг буулгаж өргөтгөлийн шинэ барилга барих зураг боловсруулах талаар Нийслэлийн ЗД-ын 2019 оны А/619 тоот Захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын музейгээс ирүүлсэн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 28 тоот албан хүсэлт, холбогдох материал, музейн зургийн архитекторын мэдээлэлтэй Шинжээчийн зөвлөл танилцан хэлэлцээд дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. “Тито Архитектс” ХХК-ийн архитектор н.Батзоригийн танилцуулснаар “музейн барилгын баруун талын өргөтгөлийн хэсэгт 1940-д оны үед Тува Улсын Элчин сайдын яам байрлаж байсан” гэх мэдээллийг нягталж, эх сурвалжаар нотлох;

2. “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах тухай Венецийн Харти”-ийн 11 дүгээр зүйл, “Архитектурын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, дүн шинжилгээ хийх ИКИМОС-ийн дүрэм”-ийн 3.12 дахь зүйлийг тус тус үндэслэн Улаанбаатар музейн барилгын хойд хэсэг буюу үйлчлүүлэгчдийг хүлээн авах үүдний өрөө нь эх барилгаас сүүлд шинээр баригдсан ч монгол улсын түүх, түүхэн үйл явдалтай холбоотой түүхийн баримт учраас нураахгүй хадгалж үлдээх.

---o0o---

Шинжээчийн зөвлөлийн дарга:

З.Оюунбилэг Сэргээн засварлалтын Зөвлөх архитектор, доктор(PhD)

Гишүүд:

Г.Анхсанаа Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга

М.Оюунтулга Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газар, ерөнхий технологич

Б.Адъяа Сэргээн засварлагч-архитектор

Ж.Баясгалан Сэргээн засварлалтын барилгын инженер

Б.Бизъяасүрэн ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийн багш

Нарийн бичгийн дарга:

Ц.Цолмон (СӨҮТ-ийн Дэлхийн өвийн дурсгал хариуцсан бүртгэл мэдээллийн санч)

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 10-р сарын 01 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2008 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 351 дугаар захирамжаар Улаанбаатар хотын БЗД-т орших “Монг-Эм” ХХК-д эмнэлгийн зориулалтаар олгогдсон газар дээр архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан, уг архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу тухайн барилгыг хэвээр үлдээн, өргөтгөл хийж ашиглахаар загвар зургийг ирүүлжээ. Загвар зургийг зөвшилцөх талаар нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар 2020 оны 09 сарын 16-ний өдрийн 03/3722 тоот албан бичгээр СӨҮТ-д ирүүлсэн. Хүсэлтийн дагуу “Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөл” хуралдаж зөвлөлийн гишүүд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тус барилга нь чулуун хийцтэй, тухайн үеийн нийслэл хүрээний европ загвартай анхны хоёр давхар барилга бөгөөд XX зууны Монголын түүхтэй холбоотой үйл явдлууд болж байсан түүхэн дурсгалт барилга тул анхны төрхийг өөрчлөхгүй байх;
2. Загвар зургийн дагуу ажлын зургийг боловсруулаж, инженерийн тооцоо хийх үед хуучны барилга нь даац авах боломжгүй нь тогтоогдвол хадгалалт хамгаалалтын /консерваци/ ажлыг хийх;
3. Загвар зураг дээр барилгын нүүр тал буюу фасадын хэсгийн өргөтгөл нь зөвхөн хүлээн авах хэсэг байхаар төлөвлөгдсөн байна. Энэхүү өргөтгөлийн хэсэг нь шаардлагатай талбай биш бөгөөд барилгын хамгийн чухал хэсэг нүүрэн талд зурсан шилэн фасадыг хийхгүйгээр анхны төрх байдлаар нь авч үлдэх боломжийг судлах;
4. Загвар зурагт тусгагдсан барилгын үндсэн фасадын хэсгээс хойшоогоо хамгийн багадаа 2м ухрааж өргөтгөлийн хэсгийг барьж, барилгын анхны төрхийг хадгалж үлдээх;
5. Цаашид хийгдэх барилгын өргөтгөлийн ажлыг сэргээн засварлалтын архитектораас мэргэжлийн зөвлөгөөг авч, ажиллах.

--- oOo ---

Шинжээчийн зөвлөлийн дарга,
МУ-ын Зөвлөх архитектор, доктор: З.Оюунбилэг

Гишүүд:
СӨҮТ-ийн Соёлын өвийг авран хамгаалах
газрын дарга: Г.Анхсанаа

Барилгын инженер: Ж.Баясгалан

МУ-ын мэргэшсэн Архитектор: Б.Бизъяасүрэн

СӨҮТ-ийн Дурсгалт уран барилга,
архитектурын зураг төслийн мэргэжилтэн: А.Намуун

--- oOo ---

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 08-р сарын 24 Улаанбаатар хот

Өвөрхангай аймгийн орон нутгийн өмчийн газраас зарласан “Эрдэнэ зуу хийд” буюу Эрдэнэ Зуу музейн Лавранг сэргээн засварлах ажлын тендерт “Зэндмэнэ суварга” ХХК шалгарч “Барилгын засварын ажлыг гүйцэтгэх гэрээ”-г байгуулан 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс засварын ажлыг эхлүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэлийн явцад Өвөрхангай аймгийн Засаг дарга Соёлын өвийн Үндэсний төвийн дэргэдэх “Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх” шинжээчийн зөвлөлөөр хяналт, дүн шинжилгээ хийлгэх талаар 2020 оны 07 сарын 16-ны өдрийн 210 тоот албан бичгээр хамтран ажиллах санал гаргасан байна.

Дээрх саналын дагуу СӨҮТ-ийн захирлын баталсан Удирдамжийн дагуу Шинжээчийн зөвлөлийн дарга З.Оюунбилэг, гишүүд Ж.Баясгалан, Б.Адъяа, А.Намуун нар 2020 оны 8 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Хархорин сумд орших Эрдэнэ Зуу музейн Лаврангийн сэргээн засварлалтын ажил болон Эрдэнэ Зуу музейн барилгууд, Шанхын Баруун хүрээний сүм дуганы техникийн болон хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалтай танилцаж дараах Дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сэргээн засварлах ажлын зургийг иж бүрэн хийгээгүй, ажлын гүйцэтгэлийн үед зургийн автороос асууж шийдүүлэх замаар ажил хийгдэж байгаа учраас шинээр шийдвэрлэсэн өнгө будгийн болоод инженерийн ажлын зургийг нөхөж хийх шаардлагатай;
2. Ажлын зураг барилгын инженер оролцоогүй учраас хийц, бүтээцийн сэргээн засварлалтыг газар дээр нь буруу шийдвэрлэсэн байна. Тухайлбал, хойд талын ханын баруун талын өнгөлгөөний хөх тоосгоны буулгах шаардлагагүй хэсгийг буулгасан, нүүрэн талын баруун, зүүн жигүүрийн хаалганы дөрвөн баганын ялзарсан хэсэгт багахан залгаас хийх байтал бүгдийг шинээр сольсон г.м;
3. Түүнчлэн ажлын зураг эх бүтээлийн зураач оролцоогүй учраас өнгө будгийн ажлын технологи алдагдсан, судалгаагүйгээр шинээр өнгө будаг тавьсан, дээврийн ваарны хэмжээ, хээ зэргийг сольсон байна;
4. Гүйцэтгэгч байгууллагын барилгын талбай зохион байгуулалтгүй, эмх цэгцгүй, талбайн дүрэм горим алдагдсан, ажлын календарчилсан төлөвлөгөөгүй, сэргээн засварлалтын ажил үндсэндээ талбайн инженергүй ажиллаж байгаа нь ажлын чанарт муугаар нөлөөлж байна. Иймд талбайн инженер эсвэл туршлагатай барилгын техникч талбай дээр байнга ажиллуулах хэрэгтэй.
5. Эрдэнэ Зуу музейн барилга байгууламжийн техникийн байдалд ерөнхий үзлэг хийхэд гадна хэрмийн суврагууд он цагийн эрхээр байнга тордлого засвар шаардаж байдаг тул жил бүр 3 суврага засварлах зардлыг төсөвт тусгаж байх, Цамба, Аюушийн сүм болон гурван Зуугийн гаднах хэрмийн эргэн тойронд 1-1,3 м өргөнтэй бетон манаас (отмостка) барилгуудын гадна тал болон хэрмийн ханын гадна ба дотор талд хийж суурийг уснаас хамгаалах ажлыг ирэх онд заавал хийх хэрэгтэй.

1

6. Шанхын Баруун хүрээний Гол дуганы дээврээс бороотой үед ус гоождог учраас хурлаа Сахиусын дуганд хурдагаас гадна Гол дуганд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр бүртгэгдсэн танка зурагнууд норж гэмтэх аюултай нөхцөлд байгаа учраас Гол дуганыг анхных төрх байдлаар яаралтай сэргээн засварлах шаардлагатай.

Дээрх Дүгнэлтийг үндэслэн Эрдэнэ Зуу музейн Лавранг сэргээн засварлах ажилд дараах Зөвлөмжийг өгч байна.

Нэгдүгээрт, Хийц бүтээцийн талаар:

1. Лаврангийн баруун жигүүрийн баруун ханын суурийг 1980-аад онд бэхэлсэн учир ан цавууд нь хуучин ан цавууд гэж үзээд баруун ханыг хэвээр үлдээх;
2. Хойд ханын хөх тоосгон өнгөлгөөний буулгасан хөх тоосгон өргийг буцаан өрөх, тэгэхдээ парапетын одоо буулгасан байгаа хэсэгт 1,6м орчим урттай шаарган бетон 20см орчим зузаан үеийг буулгаж түүний оронд 3 үе тоосгон өргийг 50см орчим өргөнтэй төмөр тор бүхий өрөг хийх, төмөр торыг 5мм төмөр утсаар хийх, мөн түүнээс дээших парапетын буулгасан хэсгийн өргийн үе бүрийг мөн ижил тортойгоор өрөх, шинэ ба хуучин өргийн барьцалдалгааг булангийн уулзвар болон боломжтой хэсгүүдэд хангаж өгөх;
3. Баруун ба зүүн жигүүрийн үүдний 4 баганыг сольсон нь буруу байсан тул хуучин 4 баганыг залгаастайгаар угсрах.

Хоёрдугаарт, Өнгө будгийн ажлын талаар

1. Эрдэнэ Зуу музейн Лаврангийн сэргээн засварлалтын ажил нь өнгө будгийн ажлын зураггүй хийгдэж байгаа учраас өнгө будгийн ажлын гүйцэтгэлийн зургийг заавал хийх шаардлагатай;
2. Дам нурууны ланз болон соёмбо үсгийн алтан бичгээс бусад алт будаг орсон хээ угалзыг байтуу (будгийн дэвсгэр) хийж гадна, доторгүй зүмбэр тавьж будах ба 3-р давхрын Гонхоны гадна талын 6 үсгийг сийлбэртэй байснаар нь үлдээж бусад хэсэгт зүмбэр хийх, бусад өнгө будгийн ажил хийсэн хэсэгт байтуу хийж, зүмбэр тавьж, шороон будгаар будаж, маажиндах;
3. Цоолбороор хээ тавихийг хориглох, зөвхөн ланз, соёмбо үсгийг цоолбор хийж гүйцэтгэх;
4. Ажлын тайлан дээрээ ямар үндэслэлээр уг будгийг ашигласнаа тайлбарлан бичих, өөр будаг ашиглах, дотор өнгө будгийн ажилд лак хэрэглэх зэрэг асуудлыг тухайн үед нь судалж шийдэх;
4. Барилгын дотор, гадна ханыг бүгдийг цагаан шохойгоор шохойдох, дотор ханын шамбыг гурван Зуугийн сүмийн ханын шамбаны аль зохицож байгааг нь хуулж тавих ба тайланд бичих;
5. Голын Гонхоны хэсгийн 9 дүүжин тааз, түүний голын болон хажуу талын зургийг музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа эх зургаас хуулбарлан хийж эргүүлэн тавих ба бусад бүх дүүжин таазыг авч дөрвөлжин унийг гарган хөх өнгөөр будаж, дээд банзыг хүрэн өнгөөр будах;
6. Дээврийн вааран эдлэл болох дэлний хаалтыг засах, автор архитекторын судалгааны үндсэн дээр гаргасан зургаар хийсэн нөмрөг болон тосгуур нүүр ваараар солих, дээврийн ваарны хаглаасыг шохойгоор хийх.

2

Гуравдугаарт, Бусад ажлын талаар:

1. Хийдийн лам нар гол ба зүүн хэсгийг дулаалуулах хүсэлт тавьсан учир цонхыг дотор талаас нь модон хүрээтэй, онгойлгох нугастай вакуум цонх хийх;
2. Банзан шалыг ховхолж 20-30 см зузаантайгаар керамзит дүүргэж шалыг дахин хийх, тухайн хэсгүүдэд 2-р давхрын шалан дээр эрдэс хөвөн 10 см зулж дулаалан давхар шал хийх;
3. Лавранг цахилгаанаар халаах учир цахилгааны иж бүрэн зураг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, галын байгууллагаар батлуулж цахилгааны монтажийг мэргэжлийн хүнээр хийлгэх;
4. Голын хэсгийн орох хаалганы дотор талд шилтэй модон тамбур хийх зургийг автор архитектороор хийлгэж угсрах;
5. Дулаалгатай холбоотой бүх зардлыг Эрдэнэ зуу хийд хариуцах;

Эрдэнэ Зуу музейн Лавран дуганы сэргээн засварлах ажилтай газар дээр нь танилцахад зургийн автор архитектор Г.Нямцогт, гүйцэтгэгч компани болох “Зэндмэнэ суврага” ХХК-ийн захирал С.Цэдэвсүрэн, инженер М.Буянтамир, Барилгын хөнжлийн төвийн хяналтын инженер Б.Баярмаа, Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга А.Энхцэцэг, захиалагчийн төлөөлөгч Эрдэнэ Зуу музейн менежер Ц.Содномсүрэн, Эрдэнэ зуу хийдийн тэргүүн ловон лам О.Эрдэнэчулуун нар байлцсан болно.

--- oOo ---

Шинжээчийн зөвлөлийн дарга,
МУ-ын Зөвлөх архитектор, доктор: З.Оюунбилэг

Гишүүд:

Барилгын инженер: Ж.Баясгалан

Архитектор: Б.Адьяа

СӨҮТ-ийн Дурсгалт барилга хариуцсан мэргэжилтэн: А.Намуун

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛД ХЯНАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2020.07.10 Улаанбаатар хот

Соёлын өвийн үндэсний төвийн дэргэдэх Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлийн гишүүд Чин ван Ханддоржийн байшингийн өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаад дараах ДҮГНЭЛТИЙГ гаргаж байна.

1. Чин ван Ханддоржийн байшинг 1975 онд архитектор Ө.Эрдэнэбат, 1990 онд архитектор З.Оюунбилэг нарын боловсруулсан сэргээн засварлах ажлын зургийн дагуу 1976, 1991 онд Түүх, соёлын дурсгал зүйлийг сэргээн засварлах газар сэргээн засварласан байна. Түүнээс хойш эзэмшиж байсан байгууллагууд нь хэд хэдэн удаа урсгал засвар хийж дотор талын төлөвлөлт, модон хийцийн өнгө будаг, зураг чимэглэлийг өөрчилсөн байна. 2020 оны 07 сарын 07-ны өдөр тухайн газар дээр ажилласан зөвлөлийн гишүүдийн ажигласнаар гадна дээврийн банз, дээврийн хормойн хэсгийн зарим нь унаж, өмхөрч муудсан, барилгын гаднах өнгө будаг гандаж, байтуу нь ховхорч хагарсан байдалтай байгаа учраас Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтын дагуу эрх авсан мэргэжлийн байгууллага анхных нь төрх байдлаар сэргээн засварлах шаардлагатай болжээ.

2. Засгийн газрын 2001 оны 96 дугаар тогтоолоор Чин ван Ханддоржийн байшингийн Хамгаалалтын бүсийг 0,5 га газар байхаар баталсан боловч урд, хойд талаас нь газрыг нь авч ашиглан, байгаа багахан хамгаалалтын бүсэд нь Чин ван Ханддоржийн өргөөний харагдах сүр барааг хаасан, массын харьцааг алдагдуулсан хоёр том гэр шинээр барьсан, гал тогоог дурсгалт барилгатай залгаж шинээр барьж нэг орон зай болгон ашиглаж байгаа нь түүнээс гарах халуун уур, чийг, үйлчлүүлэгчдийн хөдөлгөөн зэрэг нь сөргөөр нөлөөлж байна. Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38, 43 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн талаарх заалтыг зөрчиж байгаа бөгөөд цаашид шинээр барьсан бүх объектыг буулгаж, Чин ван Ханддоржийн өргөөг бүрэн бүтэн харагдах нөхцөлийг хангаж, хадгалж хамгаалах арга хэмжээ авах нь зүйтэй.

3. Аливаа дурсгалт барилгыг хамгаалах шилдэг арга бол түүнийг ашиглаж байх явдал учраас эзэмшигч байгууллага нь уг байшинг сэргээн засварласны дараа “Чин ван Ханддоржийн музей”-гээ өргөтгөж музейн стандартын дагуу холбогдох үзмэрийг цуглуулж, дэглэж, хадгалж хамгаалах ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, монголын гадаад харилцааны хөгжлийн түүх болон Чин ван Ханддорж, түүний өргөөний түүхийн үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд нээлттэй сурталчлах хэрэгтэй.

4. Чин ван Ханддоржийн байшинг музейн зориулалтаар ашиглахад үзэгчид, олон нийтэд зориулсан бусад соёлын үйлчилгээний болон бэлэг дурсгал, номын дэлгүүр, кофе, цайны газар, ариун цэврийн өрөө, хурлын танхим

зэргийг тусад нь төлөвлөхдөө дурсгалт барилгыг хадгалж хамгаалах олон улсын дүрэм, журам, зарчмыг дагаж мөрдөх ёстой.

5. Чин ван Ханддоржийн байшингийн эвдрэл гэмтлийн тусгайлсан судалгааг Соёлын яамны дэргэдэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад оруулах, тухайн эвдрэл гэмтлийн судалгааны дагуу ажлын зураг, төсөв боловсруулж батлуулах, батлагдсан эскиз зураг, төсвийн дагуу улсын төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжилт бүрдүүлэн сэргээн засварлах боломжийг эрэлхийлэх, сэргээн засварлах байгууллагын сонгох шалгаруулалтыг төрийн захиргааны төв байгууллагад хандан холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх нь зүйтэй.

--- oOo ---

Шинжээчийн зөвлөлийн дарга,
МУ-ын Зөвлөх архитектор, доктор: З.Оюунбилэг

Гишүүд:

СӨҮТ-ийн Соёлын өвийг авран
хамгаалах газрын дарга: Г.Анхсанаа

Барилгын инженер: Ж.Баясгалан

Архитектор: Б.Адьяа

СӨҮТ-ийн Дурсгалт барилга хариуцсан
мэргэжилтэн: А.Намуун

4.Соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажил:

- Үндэсний төв архивын хүсэлтийн дагуу тус архивын сан хөмрөгт хадгалагдаж буй Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл нийт 53 ширхэг металл тамга, захирлага, тэмдгийн орц найрлагыг тогтоох хүсэлтийн дагуу соёлын биет өвийг сэргээн засварлах газраас зөөврийн рентген флуоресцент спектрийн хэмжилтийн багаж ашиглан орц, найрлагыг тогтоож, тайланг 2020 оны 01/304 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Богд хааны ордон музей дурсгалт уран барилгын будгийн сэргээн засварлах ажилбарт анх удаа будгийн төрөл зүй болон найрлагын технологи гарган авч, дээж хэлбэрээр бэлтгэн Монгол орны эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хүрээлэн буй орчны эрсдэлд урт хугацааны тэсвэртэй будгийн төрөл, технологийг нутагшуулах зорилгоор дээж будгийн будгийн орцын найрлагыг тогтоон гандалт, гэрлийн тусгал, чийгшил дулааны хэмжилтийг бүтэн жилийн турш харьцуулан судлах 100 төрлийн дээжийг бэлтгэн судалгаанд оруулсан.

- Олон улсын музейн гэрэлтүүлгийн стандарт, Музейн гэрэлтүүлгийн люкс хэмжилтээс гадна гэрлийн дулаан, гэрлийн индекс, гэрэл суулгах загвар, үзмэрт тусах өнцөг, худалдан авалт хийх байгууллага гэсэн цогц судалгааг хийж, Чингис хаан музейн ажлын хэсэгт аргазүйн заавар зөвлөмж, судалгааг бэлтгэж хүргүүлсэн.

- Олон улсын музейн жишиг, стандартыг харьцуулан судалж, хадгалалт хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлэх зорилгоор металл болон органик эдлэлийг хадгалах сан хөмрөгийн зохион байгуулалтын зөвлөмжийг боловсруулан Монголын археологи, угсаатны зүйн музейн Ажлын хэсэгт хүргүүлэв.

- Дорнод аймгийн ЗДТГ-ын хүсэлтийн дагуу тус аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Зүүн дайвар орчмоос илэрсэн олон үеийн дурсгалт газарт ажиллаж чулуун зэвсэг болон, хүрэл эдлэл, ваарны хагархай, эртний амьтны яс зэрэг нийт 760 орчим олдворыг баримтжуулан, хэмжилт хийж, товч тодорхойлолт бүхий тайлан бичиж, 2020 оны 01/298 тоот албан бичгээр хүргүүлэв.

ДОРНОД АЙМГИЙН ЦАГАА-ОВОО СУМЫН НУТАГ ЗҮҮН ДААВАР ОРЧМЫН ОЛОН ҮЕИЙН ДУРСГАЛТ ГАЗАР ХИЙСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

А.Энхтөр , Г.Анхсанаа,
П.Чинбат

Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Хүрээт буюу 4 дүгээр багийн нутаг “Дэрдэвийн арын манхан” “Зүүн даавар” зэрэг газраас эртний янз бүрийн олдвор илэрсэн тухай мэдээллийг тус сумын иргэн Ч.Мөнхсайхан аймгийн Мэргэжлийн хяналтын соёлын улсын байцаагч Б.Мангалжавт өгсөн байна. Энэ ирүүлсний мэдээллийн дагуу 2020 оны 5 дугаар сард аймгийн музей, Мэргэжлийн хяналтын газраас газар дээр нь ажиллаж олон тооны олдворуудыг түүвэрлэн аймгийн музейд авч ирж хадгалжээ.

Тэндээс олдсон олдворууд нь чулуун зэвсгийн үеэс хүрэл, төмрийн түрүү үед хамаарах дурсгалууд байсан тул тус газрыг шалгах, он цагийг тогтоох, түүх соёлын ач холбогдлыг тодорхойлж, дурсгалт газрын хамрах хүрээг тогтоож, мэргэжил арга зүйн дэмжлэг авах хүсэлтийг аймгийн музейгээс Соёлын өвийн үндэсний төвд хандсан болно.

Энэ хүсэлтийн дагуу Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ын Археологийн хүрээлэн болон Дорнод аймгийн холбогдох байгууллуудаас бүрдсэн баг 2020 оны 8 сард Дорнод аймгийн музей болон Цагаан-овоо сумын нутагт ажиллаа.

Бид эхний удаа дурсгалт газраас түүвэрлэн, аймгийн музей дээр авч ирсэн олдворуудыг үзэж, товч тодорхойлолт үйлдэн, гар болон гэрэл зургаар баримтжуулалт хийв. Үүнд, Үлдэц, ялтас, хусуур, зэв зэрэг чулуун зэвсгийн олдвор болон чулуун нухуур, тээрмийн чулуу, нүдүүр, хүндрүүлэгч, цутгуурын шанага зэрэг чулуун эдлэл, сувс, зэв, хутга, товруу, хонх, “У-шу” зоос зэрэг хүрэл эдлэл, жигүүрт зэв, хонх, хутга зэрэг зэрэг төмөр эдлэл, төмрийн үлдэгдэл (баас), цөн болон ширэмний үлдэгдэл, ваарны хоёр төрлийн хагархай, мал, амьтны яс зэрэг 350 орчим олдворууд байна.

Үүний дараа Цагаан-Овоо сумын нутагт орших дурсгалт газарт ажилласан бөгөөд “Дэрдэвийн арын манхан”, “Зүүн даавар” зэрэг элсэн хонхруудыг шалгах явцад, зэв, хүндрүүлэгч, нухуур, ялтас, залтас, цагаан сувс, хүрэл морь, шөвөг зэрэг хүрэл эдлэл, төмөр шөвөг, төмрийн үлдэгдэл (баас), ваарны хэд хэдэн төрлийн хагархай, мал амьтны зэрэг 360 гаруй олдворууд түүвэрлэн авч, баримтжуулав . Хоёр удаагийн хайгуулаар 750 орчим олдворууд хэрэглэгдэхүүн цуглуулснаас шинэ чулуун зэвэг, хүрлийн үед хамаарах хүрэл олдворууд, сувс, хүннү гүрний үед хамаарах ваарны хагархай, дундад зууны үед ашиглагдаж байсан харвуулын сумны төмөр зэв, тэрэгний ширмэн цөн зэрэг илэрч олсон нь уг дурсгалт газар нь хэд хэдэн түүхэн үеийн төлөөлөл болсон чухал дурсгалт газар болохыг илтгэж байгаа юм.

Дээрх олон үеийн олдвор бүхий дурсгалт газар нь Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Хүрээт буюу 4 дүгээр багийн нутаг, сумын төвөөс зүүн хойш (шулуунаар) 26.5 км орчим зайд (зураг 1) намхан гүвээ толгодын дундуур хойноос урагш цуварсан элсэн хонхруудад юм. Энэ орчмыг нутгийн малчид “Дэрдэвийн арын манхан”, “Зүүн даавар” хэмээн нэрэлдэг байна. Энэ орчимд жижиг нуур, булаг шанд элбэгтэй. Элстэй хонхрууд хойноос урагш зурвас байдлаар 10-15 км үргэлжлэх бөгөөд олдворууд илэрсэн элсэн хонхруудыг бид урдаас нь эхлэн дугаарлаж, товч тодорхойлов.

1-р хонхор: 230х65 м орчим хэмжээтэй хойд талаараа огцом эрэгтэй бол урд хэсгээрээ налуу эрэгтэй, төв хэсэгтээ эргийн төвшинтэй адил өргөгдсөн 50х26 м орчим хэмжээтэй аралтай. Эргийн төвшнөөс 2-4.5 м орчим гүнтэй. Эндээс чулуун зэвсгийн болон хүрэл, хүннү, дундад зууны үед хамаарах олдворуудын дийлэх хэсэг олдсон байна.

2-р хонхор: 630х120 орчим хэмжээтэй баруун хойд талаасаа түрсэн эрэгтэй, хойд болон баруун урдуураа огцом, эрэгтэй, зүүн урдуураа налуу эрэгтэй, эргийн төвшнөөс 2-3.7 м орчим гүнтэй. Эндээс голчлон чулуун зэвсгүүд олдсон (зураг 2).

Чулуун зэвсгийн үеийн олдворууд: Нийт түүвэрлэсэн олдворуудаас чулуун зэвсгийн үед хамаарах чулуун эдлэл, ваарны хагархай гэсэн хоёр төрлийн олдвор байна. Хоёр удаагийн хайгуулаар нийт 326 чулуун эдлэл түүвэрлэснээс 247 чулуун зэвсэг (зураг 3) байгаа бөгөөд ихэнх зэвсгийг янз бүрийн өнгөт хаш болон цахиур чулуугаар, цөөн эдлэлийг жижиг ширхэгтэй боржин чулуугаар хийсэн байна. Чулуун зэвсгүүд нь үлдэц, ялтас, эсгүүр, струг (харуул, холтослуур), хусуур, хутга, сүх, ойл, бифас, зэв, нүдүүр, хавтгай тээрмийн чулуу, хүндрүүлэгч чулуу зэрэг арав гаруй төрөл байна (зураг 4).

Мөн 30 орчим ваарны хагархай олдсоноос ваарны хагархайнуудын дунд неолитын үед холбогдуулж болохоор хэд хэдэн хэсгүүд байна. Ийм төрлийн ваарны хагархай Байгал нуурын наад биеийн энэ үеийн дурсгалт газар болох “Муханские озера” хэмээх неолитын сууринаас олдсон нь сонирхолтой бөгөөд он цагийг одоогоос 4620 жилийн өмнө холбогдоно хэмээн үзсэн байна (зураг 5).

Хүрэл үеийн олдворууд: Дурсгалт газраас 2 жигүүрт хүрэл зэв, 2 жигүүрт хүрэл зэв, 2 ш хүрэл хутга, цэцгэн хээтэй, шулуун хүрээтэй, дугуй хүрээтэй зэрэг хэдэн янзын хүрэл товруу, дөрвөн дэлбээт хүрэл цэцгэн чимэглэл (нэг дэлбээн байхгүй), ялтас, хүрэл хутганы үзүүр, 3 ш хүрэл хадаас, хүрлийн хэлтэрхий, хүрэл зүү, хүрэл адууны дүрслэлтэй чимэглэл зэрэг 20 орчим хүрэл эдлэл олдсон билээ (зураг 7).

Мөн хэд хэдэн бүтэн хүрэл хутга, гурвалжин болон навчин хэлбэрийн онигт зэв, дөрвөн төрлийн таван ширхэг хүрэл товруу зэрэг хэд хэдэн сонирхолтой хүрэл эдлэлүүд байгаа юм. Үүний зэрэгцээ нэг сонирхолтой олдвор олдсон нь цутгуурын чулуун шанага юм (зураг 6).

Хүннүгийн үеийн олдворууд: Бидний түүвэрлэсэн олдворуудын дотор энэ үед лавтай холбогдох хэд хэдэн олдвор байна. Үүнд, Эхний элст хонхроос олдсон хүннү ваарны амсрын хагархай болон хүннү булшнаас түгээмэл олддог “У-шу” зоос орно (зураг 10, 11).


Дундад зууны үеийн олдворууд: Энэ үед холбогдох гурван жигүүрт болон хоёр жигүүрт хавтгай төмөр зэв, хонх, хутга, шөвөг, янз бүрийн хэлбэр хэмжээтэй эдлэлүүд,

янз бүрийн хадаас зэрэг 20 гаруй зүйлс олдсоноос гадна төмрийн шаар (зураг 12) зэрэг сонирхолтой олдворууд тус тус олдсон юм.

Тус олон үеийн олдвор хэрэглэгдэхүүн нь тухайн бүс нутагт наанадаж шинэ чулуун зэвсгийн үеэс эхлэн хүрэл, хүннү, дундад зууны үеүдэд хүмүүс идэвхтэй амьдарч, аж ахуйгаа хөтлөн, хөрш зэргэлдээ бүс нутгийн ард түмнүүдтэй өргөн харилцаатай байсныг нотлон харуулж байна. Тиймээс энэхүү дурсгалт газар орчимд төлөвлөгөөт хайгуул зохион байгуулж, орчин үеийн археологийн шинжлэх ухааны арга зүйн дагуу цаашид төвлөрөн малтлага судалгаа явуулах нь чухал юм.



Зураг 1. Дурсгалт газрын байршил



Зураг 2. Элсэн хонхрууд болон олдворуудын тэмдэглэгээ



Зураг 3. Дурсгалт газраас олдсон зарим чулуун зэсвэг



Зураг 4. Чулуун самар, нүдүүр



Зураг 5. Ваарны хагархай



Зураг 6. Чулуун шанага



Зураг 7. Хүрэл олдворууд



Зураг 8. Хүрэл адууны дүрслэлтэй чимэглэл



Зураг 9.Дөрвөн дэлбээт хүрэл цэцгэн хэлбэрийн чимэглэл



Зураг 10. "У-шу" зоос



Зураг 11. Хүннү ваарны амсар



Зураг 12. Төмрийн шаар (баас)

5.Үзмэр шилжүүлсэн тухай:

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.7, 52 дугаар зүйлийн 52.8 дахь заалтыг үндэслэсэн дурсгалт зүйлийг шилжүүлж, хүлээлцүүлэх тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын даргын 2020 оны А/44 тоот тушаал, 2020 оны 01/225 тоот албан бичгийн дагуу Соёлын өвийн үндэсний төвийн сан хөмрөгт түр хадгалагдаж байсан Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2019/ШЦТ/77, 2019/ШЦТ/79, 2019/ШЦТ/92, 2019/ШЦТ/93 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан 119 эд зүйлийг музейд шилжүүлж, бүртгэлд авах арга хэмжээг зохион байгуулав. Уг ажлын илтгэх хуудсыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт 2020 оны 01/358 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. Үүнд,

- Дархан-Уул аймгийн музейд 2019/ШЦТ/79, 2019/ШЦТ/92 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан 46 дэсийн 48 ширхэг зүйлийг,

- Орхон аймгийн музейд 2019/ШЦТ/77, 2019/ШЦТ/93 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан 41 дэсийн 71 ширхэг дурсгалт зүйлийг тус тус шилжүүлсэн.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ИЛТГЭХ ХУУДАС

Дурсгалт зүйлийг шилжүүлж, хүлээлцсэн тухай

2020 оны 11 дүгээр сарын 30 Улаанбаатар хот

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.7, 52 дугаар зүйлийн 52.8 дахь заалтыг үндэслэсэн дурсгалт зүйлийг шилжүүлж, хүлээлцүүлэх тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын даргын 2020 оны А/44 тоот тушаал, 2020 оны 01/225 тоот албан бичгийн дагуу Соёлын өвийн үндэсний төвийн сан хөмрөгт түр хадгалагдаж байсан Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2019/ШЦТ/77, 2019/ШЦТ/79, 2019/ШЦТ/92, 2019/ШЦТ/93 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан дурсгалт зүйлийг музейд шилжүүлж, эзэмшүүлэх, бүртгэл мэдээллийн санд бүртгэх арга хэмжээг дараах шат дараалаар зохион байгууллаа. Үүнд:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2019/ШЦТ/77, 2019/ШЦТ/79, 2019/ШЦТ/92, 2019/ШЦТ/93 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан дурсгалт зүйл, төвд ном, судрын нэршлийг тодруулахаар 2020 оны 09 сарын 18-ны өдөр Үндэсний номын сангийн Төвд номын сан хөмрөгийн номын санч мэдээллийн ажилтан Б.Хүрэлцоож, Гар бичмэл монгол судлалын сан хөмрөгийн номын санч мэдээллийн ажилтан Ч.Гансүх, Соёлын өвийн үндэсний төвийн Санхөмрөгч Б.Эрдэнэсувд нар ажилласан.
2. 2020 оны 09 сарын 24-ний өдөр Соёлын өвийн үндэсний төвийн Санхөмрөгч Б.Эрдэнэсувд хураагдсан эд зүйлийн нэршил, жагсаалтыг гаргасан.
3. 2020 оны 09 сарын 28-ны өдөр тус үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүрэг гүйцэтгэгч Д.Нарантуяа, Ерөнхий бүртгэл мэдээллийн санч Ш.Энхтуяа, Сан хөмрөгч Б.Эрдэнэсувд нар улс, аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлийн төрөл зүйлийн ангилалын тоон дүнг үндэслэн шашны холбогдолтой үзмэр, эд өлгийн зүйлийн төрөл бусад музейнүүдээс харьцангуй цөөн тоогоор хадгалагддаг Дархан-Уул аймгийн музейд 2019/ШЦТ/79, 2019/ШЦТ/92 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан дурсгалт зүйлийг, Орхон аймгийн музейд 2019/ШЦТ/77, 2019/ШЦТ/93 дугаар шийтгэх тогтоолоор хураагдсан дурсгалт зүйлийг тус тус

шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

4. 2020 оны 09 сарын 29-ны өдөр Дурсгалт зүйлийг шилжүүлэх тухай 01/292, 01/293 тоот албан бичгийг Орхон аймгийн музей, Дархан-Уул аймгийн музейн захиралд тус тус хүргүүлсэн.
5. 2020 оны 10 сарын 20-ны өдөр Дархан-Уул аймгийн музейн төлөөлөл, 10 сарын 21-ны өдөр Орхон аймгийн музейн төлөөлөл тус үндэсний төв дээр ирж дурсгалт зүйлийг хүлээн авав. Дээрх музейн удирдлага, ажилчдад Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын дарга Д.Нарантуяа нар хүлээлцсэн эд зүйлийг соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу зөөж тээвэрлэх, музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар, зохих журмын дагуу дурсгалт зүйлсийг сан хөмрөгтөө хүлээн авч, зохион байгуулалт хийх, ажлын тайланг ирүүлэх тухай мэргэжил, аргазүйн зөвлөмжийг өгсөн болно.
6. Шилжүүлсэн дурсгалт зүйлийг зохих журмын дагуу сан хөмрөгтөө хүлээн авч үнэлгээ хийж, бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн тухай тайлан мэдээ Орхон аймгийн музейгээс 2020 оны 11 сарын 09-ны өдрийн 36 тоот албан бичгээр, Дархан-Уул аймгийн музей 2020 оны 11 сарын 09-ны өдрийн 59 тоот албан бичгээр тус тус манай төвд ирсэн болно.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ДУРСГАЛТ ЗҮЙЛС ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

2020 оны 11 сарын 09 №01 Улаанбаатар хот

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2019.07.26-ны №79, 2019.08.28 №92 тоот шийтгэх тогтоолоор шийдвэрлэгдсэн, 1920000680071, 1920000100021 хэргийн дугаартай дараах эд, өлгийн зүйлийг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцсэн тухай акт 2 хувь үйлдэв.

Нэг. 2019.07.26-ны №79, 1920000680071

№	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Тэмдэглэл
1	Сундуй судар	1	
2	Дэвтэрлэсэн монгол бичгийн модон барын судар	1	
3	Цагц	1	
4	Хийморийн дарцагны бар	1	
5	Хүрэл толь	2	Гууль
6	Дэншиг	1	
7	Үлгэрийн далай	1	
8	Хийморын дарцагны хэлний бар	1	
9	Суварганы модон бар	1	
10	Хүрэл толь	1	
11	Модон гуутай бурхан багш голлосон дүншигийн 35 бурханы дүр	1	
12	Модон гуутай Жүжигшил Жанрайсаг	1	
13	Гууль цутгамал Намсрай бурхан	1	
14	Хүрэл цутгамал очир	1	Гууль
15	Толгойгүй хятад шавзан хөөрөг	1	
16	Гууль цутгамал суврага	1	
17	Тал хэвийн шавар бурхан багш	1	
18	Доржэодво судар	1	
19	Бумбатай дарь эх загал шүтээн зураг	1	
20	Цагаан дарь эхийн загал шүтээн зураг	1	
21	Цагаан шүхэрт загал зураг	1	
22	Хүрэл морь	1	
23	Цэнд судар	1	9 эрдэнээр бичсэн
24	Тал хэвийн Гонгор бурхан	1	
25	Судартай цэхэр манан хөөрөг	1	

1

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

26	Гууль цутгамал мөнгөн бурхан	1	
27	Зэс гуу	1	
28	Зэс завъяа	1	
29	Сангийн бойпор	1	гууль
30	Пүрэв	1	
31	Ган сийлбэртэй хутга	1	
32	Хийморийн дарцагны бар	1	
33	Жадамба сударт	1	
34	Алтангэрэл сударт	1	
35	Найман мянгат их хөлгөн сударт	1	
36	Алтангэрэл сударт	1	
37	Сангийн бойпор	1	
38	Ногоон дарь эх ш/зураг	1	
39	Нягтан бичиг	2	
Нийт		39 дэс 41 ширхэг	
Орчин цагийн хийцтэй эд зүйлс			
1	Тал хэвийн гууль цутгамал Замбал бурхан	1	
2	Бургасан савваа	1	
2	Дүйнхор танка	1	
4	Жигжид зураг	1	
5	Махагал зураг	1	
6	Модон хавтас	2	
Нийт		7ш	

Хоёр. 2019.08.28 №92 , 1920000100021

№	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Тэмдэглэл
1	Санжид молом сударт	1	

Бүгд 39 дэсийн бүгд 41 ширхэг эд өлгийн зүйл
(Тоо, үсгээр)

ХҮЛЭЭН АВСАН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Музей

Албан тушаал: Сан хадгалах
Овог, нэр: Ж. Мөнх
Гарын үсэг:

Албан тушаал: Ерөнхий
Овог, нэр: Ц. Энхтуяа
Гарын үсэг:

Огноо: 2020-10-20.

2

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр: .....СӨҮГ.....

Албан тушаал: .....Ерөнхий ажилтан, мэргэжилтэн.....

Овог, нэр:.....Ц.Энхтуяа.....

Гарын үсэг: .....

Албан тушаал: .....Соёлын өвийн үндэсний төв. Захиралын.....

Овог, нэр:.....Ө.Ариунаа.....

Гарын үсэг: .....

Огноо...2020.10.20.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр: ...Эрүүл мэнд, хөдөлмөрийн.....

Албан тушаал: .....

Овог, нэр:.....

Гарын үсэг: .....

Огноо.....

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ДУРСГАЛТ ЗҮЙЛС ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

2020 оны 12 сарын 21 №02 Улаанбаатар хот

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2019.07.19 №77, 2019.08.28 №93тоот шийтгэх тогтоолоор шийдвэрлэгдсэн, 9200004500б0, 1920000100022 хэргийн дугаартай дараах эд, өлгийн зүйлийг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцсэн тухай акт 2 хувь үйлдэв.

Нэг. Тогтоолын он, сар , өдөр, дугаар 2019.07.19 №77-, Хэргийн дугаар-1920000450060

№	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Тэмдэглэл
1	Богд Зонховын намтар	1	Монгол бичгээр бичсэн
2	Үлгэрийн далай	1	Монгол бичгээр бичсэн
3	Жигжид	1	Төвд
4	Дулба-ийн хураангуй	1	Төвд
5	Бум ла жуг шүтсэ	1	Төвд
6	Чойжод санбий донма	1	Төвд
7	Гүнрэг ансон	1	Төвд
8	Гэндэн лүгсэнгийн Моломын судар	1	Төвд
9	Дагва жалцангийн зохиол	1	Төвд
10	Дайсныг дарагч тэргүүтэй ерөөл үг	1	Төвд, гар бичмэл
11	Судрын аймгийн найман зуут оршивой	1	Төвд, модон бар
12	Бодь мөрийн зул	1	Төвд, гар бичмэл
13	Умайпа жуг	1	Төвд, модон бар
14	Их манал	1	
15	Очирвааны үүднээс цагаан хар үгаал оршив	1	Монгол, гар бичмэл
16	Дүртэддагта бурхны хөрөг	1	зураг
17	Цэнд, манал судрууд	1	Төвд, модон бар
18	Үрийн зурхай тэргүүтэй судар	1	Төвд, гар бичмэл
19	Ногоон дарь эхийн 108 алдар	1	Төвд, гар бичмэл
20	Жамбалцанхид	1	Төвд, модон бар
21	А гон до	1	Төвд, гар бичмэл
22	Жамбалцанхид	1	Төвд, модон бар
23	Дашизэгва	1	Төвд, хятад бар
24	Цагаан шүхэрт	1	Төвд, модон бар
25	Уман жуг	1	Төвд, модон бар
26	Говийн лха	1	Төвд, модон бар
27	Их Манал	1	Төвд, модон бар
28	Гомбын тахилга	1	Төвд, модон бар
29	Догсүм судар	1	Төвд
30	Дулбагийн хураангуй	1	Төвд

1

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

31	Мэргэд гарах нөхөн үргахуй ухааны аймаг	1	Төвд, Монгол хадмал
32	Жигжид тэргүүтэн ядам сахиусчнуудын тахилгын сударт	1	Төвд
33	Норву дрэнвай	1	
34	Догсүм сударт	1	
35	Багшийг тахих зан үйлийн сударт	1	Модон шоолтой
36	Мөнгөн аяга	1	
37	Бариулгүй хонх	1	
38	Хүрэл толь	1	
39	Хонх	2	
40	Очир	1	
	Нийт	40 дэс 41 ширхэг	

Хөөр: Тогтоолын он, сар , өдөр, дугаар-2019.08.28 №93, Хэргийн дугаар-1920000100022

№	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Тэмдэглэл
1	Танка	30	Жижиг хэмжээтэй

Бүгд 41 дэсийн ДАЛАН НЭГЭН ширхэг эд өлгийн зүйл
(Тоо, үсгээр)

ХҮЛЭЭН АВСАН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр: .....
Албан тушаал: .....
Овог, нэр: .....
Гарын үсэг: .....

Албан тушаал: .....
Овог, нэр: .....
Гарын үсэг: .....

Огноо.....

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

Байгууллагын нэр: .....
Албан тушаал: .....
Овог, нэр: .....
Гарын үсэг: .....

2

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Албан тушаал: .....
Овог, нэр:.....
Гарын үсэг: .....
Огноо.....

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ

Байгууллагын нэр: .....

Албан тушаал: .....
Овог, нэр:.....
Гарын үсэг: .....
Огноо.....

6.Ажлын хэсэг орсон тухай:

- Соёл, урлагийн газрын даргын 2019-10-31-ны А/69, 2019-02-18-ны А/10 тоот тушаалаар Чингис хаан музейн үзмэр цуглуулга, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт,
- “Соёлын төв-Чанартай үйлчилгээ-IV” болзолт уралдааныг дүгнэх;
- Хэнтий аймгийн музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт;
- Улаанбаатар хотод орших түүхэн дурсгалт барилга байшингийн хадгалалт хамгаалалтын үзлэгийн ажлын хэсэгт;
- Улаанбаатар хот орчмын археологийн дурсгалын бүртгэл, судалгааны ажлын хэсэгт;
- Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлд тус үндэсний төвийн Захирал болон мэргэжилтнүүд орж ажилласан.

2020 онд соёлын өвийн үндэсний төвөөс байгууллага, аж ахуйн нэгжийг соёлын өвийн лавлагаа, мэдээллээр 35 удаа, сургалт, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах ажлын хүрээнд байгууллага 8 удаагийн сургалт, 17 удаагийн мэргэжил, арга зүйн зөвлөмж, соёлын биет өвийн шинжээчийн дүгнэлтийг үндэсний төвийн шинжээчид болон тус төвийн дэргэдэх архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөлөөс нийт 9 удаа, соёлын өвийн судалгаа, шилжилгээний ажлаар түүх, соёлын дурсгалт зүйлийн орчны судалгаа, хадгалалт хамгаалалтын чиглэлээр 5 судалгаа, шинжилгээний ажил тус тус хийгдсэн.

Соёл, урлагийн газрас үүрэг болгосны дагуу хил гааль дээр хураагдсан эд өлгийн зүйлийг музейд шилжүүлэх ажлыг хийж, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн тогтоолоор хураагдсан 48 ширхэг эд өлгийн зүйлийг Дархан-Уул аймгийн музейд 71 ширхэг эд өлгийн зүйлийг Орхон аймгийн музейд тус тус шилжүүлсэн байна.

Соёлын өвийн хадгалат хамгаалалт, судалгаа шинжилгээний чиг үүргийнхээ дагуу 6 ажлын хэсэгт тус төвийн захирал болон мэргэжлийн ажилтнууд орж ажилласан байна. Нийтдээ энэ жил давхардсан тоогоор нийт 83 байгууллагад хүрч үйлчлэв.

ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, 3.1

Гүйцэтгэлийн зорилт №3.1.1.1 Соёлын биет өвийг сэргээн засварлах.

Эрх зүйн акт:

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр бүлэг, Соёлын өвийг сэргээн засварлах.
2. Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм 2.1.3 Соёлын биет өвийг сэргээн засварлах чиг үүрэг

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.1.1-р арга хэмжээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн олдвор эд зүйлийг бэхжүүлэх, сэргээн засварлах.

2020 ОНЫ ҮНДСЭН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2020 онд 17 музейн металл, баримал, модон эдлэл, танка, уран зураг, даавуу зөөлөн эдлэл, археологийн олдвор гэсэн 6 төрөл зүйлийн 45 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажлыг хийж, сэргээн засварлалтын явцын тайланг бүрэн бичиж дуусгав. 6 үзмэр, эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын ажил хийгдэж байна. 2 үзмэр, эд өлгийн зүйлийн сэргээн засварлалтын ажил тухайн орон нутагт хийгдэх байсан боловч “Ковид-19” цар тахлын улмаас хэрэгжээгүй болно.

№	Төрөл зүйл	Музейн нэр, үзмэрийн нэр, хувийн дугаар	Хийгдсэн ажилбар
1	Металл эдлэл	БУ- зэс данх № 54.09,	Сэв, гажилт гаргасан, цоргоны эвдэрсэн хэсгийг шинээр хийсэн.
		БУ- дашмаг № 80.33,	Салсан хэсгийг холбож хадаж гагнасан, модоор таг хийсэн.
		ГА - мөнгөн завьяа №ГАҮ2013.1.1	Үзмэрийн гадаргууг зүлгүүрдсэний улмаас үүссэн сэвийг дарж өнгө, гадаргын засал хийсэн,цохигдсон сэвүүдийг гаргасан, таг бариул 2-ыг холбосон гинжийг шинээр хийж мөнгөлөн хооронд нь холбосон.
		ГА - мөнгөн саахуу № ГАҮ2013.1.2,	Үзмэрийн гадаргууг зүлгүүрдсэний улмаас үүссэн зүлгүүрийн сэвийг гаргасан, өнгөний засал хийсэн, цохигдсон сэвийг гаргасан.
		Өмнөговь – гөш №07-13	Хуучин салсан гагнаасыг шинээр эвлүүлж гагнасан
		ОР- мөнгөн бүслүүртэй зэс сав №94.16	Зээ бадны дүрстэй бариулын суурь бариул 2-ыг шинээр хийж мөнгөлсөн.
2	Баримал	АР- Чойжингийн баг № 63-1-17	Цаасан шуумал цамын баг нь хэвээ алдаж гажсан, өнгө будаг гэмтсэн байсныг гажилтыг гаргах, дутсан зарим дутуу хэсгийг нөхөж, өнгө будгийн сэргээн засварлалтын ажил хийсэн
		АР - Гомбо бурханы баг № 63-1-22	Цаасан шуумал цамын баг нь өнгө будаг гэмтсэн сэргээн засварлалт хийгдэж байгаа.

		АР - Гомбо бурханы баг № 63-1-22	Цаасан шуумал цамын баг нь өнгө будаг гэмтсэн сэргээн засварлалт хийгдэж байгаа.
		ТӨВ- самдан баатар №89-1720	Хуучин сэргээн засварлалт хийгдэж байсныг цэвэрлэж дутуу хэсгийг нөхөх сэргээн засварлалт хийгдэж байгаа
		Өвөрхангай – шавар ваар № 74-103	Цэвэрлэгээ, хагарсан хэсгүүдийг эвлүүлж наасан, нөхөлт хийсэн, өнгө будаг нөхсөн
		ӨВ - зонхов № 63-46	Цэвэрлэгээ, хагарсан хэсгүүдийг нааж бэхжүүлсэн, дутуу хэсгүүдийг нөхөх зэрэг сэргээн засварлалтын ажил хийгдэж байгаа.
		Уран зургийн галерей Хайр № 89.25	Цэвэрлэгээ хийсэн, механик гэмтэл болох эмтэрч, сэтэрсэн болон цуурхай хэсгүүдэд нөхөлт хийж өнгө будгийн засвар хийсэн.
		Уран зургийн галерей	Цэвэрлэгээ хийсэн, механик гэмтэл болох эмтэрч, сэтэрсэн болон цуурхай хэсгүүдэд нөхөлт
		Байкалов №07.08	хийж өнгө будгийн засвар хийсэн.
3	Модон эдлэл	ГС-суман модон ширээ № 95.28	Тавцангийн хагарал нөхөх, хэсэ угалзны дутууг нөхсөн, хөдөлгөөн орсон углуургыг бэхжүүлсэн
		Шанаган морин хуур № 09.66	Сэргээн засварлалт хийгдэж байгаа
		Даржинтай дамар № 09.24	Дамарны модны наалтаар салсан хэсгийг эвлүүлж наасан дамарны арьсыг шинээр татаж сольсон.
		ӨМ- луун сийлбэртэй цацал № 59-25	Цэвэрлэгээ хийж хугарч дутсан хэсгүүдийг шинээр нөхсөн, өнгө будаг зүмбэрийг сэргээн засварласан
		Баянхонгор – зодын дамар № 61.3.1	Дамарны модны наалтаар салсан хэсгийг эвлүүлж нааж бэхжүүлсэн, дамарны арьсыг шинээр татаж сольсон.
		Цагаан дарь эх № 92.2.17	Мутар, рэгнааны дутсан чимэглэлийг нөхсөн, цэцгэн чимгийг шинээр хийж өнгө будгийн засвар хийсэн
		Увс - модон хувин № Y.83.105	Салж хагсарч унасныг эвлүүлж дутсан 2ш модыг шинээр нөхөж хийсэн.

		Хуучир № Ү.60.0.12	Хуучир хөгжмийн хоёр чих дутуу байсныг шинээр нөхөж хийсэн, ясан чимэг дутуу байсныг нөхөж хийсэн.
4	Танка зураг, уран зураг	Театр "Бүжигчин" зохиомж – №2008 -67	Силкэн дээр усан суурьтай будгаар зурсан театрын чимэглэлийн зургаг тогтсон тоос, шорооны бохирдол толбо зэрэгт хуурай болон химийн бодисоор цэвэрлэгээ хийсэн.
		ГС-намсрай бурхан №09.52	Хуурай цэвэрлэгээ, өнгө будаг, торгоны уранхай ханзархайг нөхөж оёсон
		ГС- жанрайсаг № ГСМ2017.2.10	Хуурай цэвэрлэгээ, торгоны уранхай ханзархайг нөхөж оёсон
		Эрдэнэ-Зуу, жигжид голлосон ганзай № 65-1608	Цэвэрлэгээ хийсэн. Татаж тэгшилгээ хийсэн, сэргээн засварлалтын ажил хийгдэж байгаа.
		Эрдэнэ-Зуу, жамсран № 65-1607	Сэргээн засварлалт хийгдэж байгаа.
		ДУМ- гомбо чагдүгва № 76.16.1514,	Цэвэрлэгээ, өнгө будгийн сэргээн засварлалт , торго сольсон.
		Дамжин нагбо гарва № 76.16.1466	Цэвэрлэгээ, өнгө будгийн сэргээн засварлалт , торго сольсон.
5	Даавуу зөөлөн эдлэл	АР- нархажид № 60-2-10	Цэвэрлэгээ, дутуу хэсгүүдийг шинээр нөхсөн, сэмэрсэн хэсгүүд болон саа утсыг даруулж оёсон.
		АР- хилэн малгай	Цэвэрлэгээ, залааны алтан утас хөвөрснийг даруулж оёсон.
		АР - малгай № 71-5-13	Цэвэрлэгээ, залааны алтан утас хөвөрснийг даруулж оёсон.
		ДУМ- дээл № 76.16.1755	Алтан саа утас хөвөрснийг даруулж оёсон.
		Увс- баяд сэтгэр малгай № Ү.61.20	Цэвэрлэгээ, орой хэсгийн шовгорын дундаас доош хэсэг байхгүй болсныг шинээр нөхөж
			сэргээн засварласан, үс халцарсан хэсэгт шинэ үсээр нөхөлт хийсэн, орой дээр сампин шинээр зангидаж хийсэн.
		Халх авгайн өвлий №Ү.87.75	Цэвэрлэгээ, үнгэгдэж хорхойд идэгдэж халцарсан үстэй хэсгийг шинэ арьсаар нөхөж сэргээн засварласан, торгоны уранхайг нөхсөн.
		Буриад дээл № 94.10	Цэвэрлэгээ, дээлийн сэмэрхийг даруулж оёсон.
		ӨМ- монгол гутал № 99-11	Цэвэрлэгээ, салсан хэсгүүдийг бэхжүүлж оёсон.
		Хүүхдийн гутал № 72-02	Цэвэрлэгээ, салсан хэсгүүдийг бэхжүүлж оёсон.
		Аяганы уут № 84.24	90 орчим хувийн сэмрэлттэй байсныг даруулж бэхжүүлж оёсон.

		Төв – хүрэм № 07- 244	Сэргээн засварлалт хийгдэж байгаа.
		Нэхий дээл № 75-855,	Цэвэрлэгээ, ханзарч урагдсаныг нөхөж оёсон.
		Тоорцог № ТӨМ89.0.57	Цэвэрлэгээ, шүрэн чимэглэл болон дарсан оёдлыг бэхжүүлж оёсон, дотор талд үүссэн хөгц мөөгөнцрийг цэвэрлэсэн.
		ӨХ- хөөрөгний даалин № 70-42	Даалингийн ирмэг дагуу үүссэн сэмэрч урагдсаныг нөхөж оёсон.
		Орхон – ирвэсийн арьсан бөөгийн дээл №05.04,	Цэвэрлэгээ, арьсны урагдалтад нөхөөс, урагдлыг оёж бэхжүүлсэн.
		ГА- лам дээл № ГАҮ77.30	Цэвэрлэгээ, даавууны сэмэрсэн хэсгийг даруулж оёсон.
6	Археологийн олдвор	5ш - Хархорум – индүү №ХХМ2017.1.2, сөргөө № 733	Металл олдворт цэвэрлэгээ хийгдсэн, , эрдэс давсыг гадагшлуулж бэхжүүлэлт хийсэн.
		Үндэсний музейн үзмэрүүд 2019онд ирсэн	Металл олдворт цэвэрлэгээ хийгдсэн, эрдэс давсыг гадагшлуулж бэхжүүлэлт хийсэн.

2020 оны нэмэлтээр хийгдсэн сэргээн засварлалт хадгалалт хамгаалалтын ажлын гүйцэтгэл

Тус үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газар 2020 онд нэмэлтээр 8 байгууллагын 4 үзмэр, эд өлгийн зүйл, 184 ширхэг археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдворт хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажил, 3 музейн үзмэрт хуулбар хийв.

№	Байгууллагын нэр	Үзмэр, Олдворын тоо	Нэр	Хийгдсэн ажилбар
1	Дүрслэх урлагийн музей	1	Хувин	Цэвэрлэгээ хийгдсэн
2	Монгол цэргийн музей	1	Хүрэл баримал	Цэвэрлэгээ, хугарсан болон алга болсон хэсгүүдийг шинээр хийж сэргээн засварласан
3	ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн	1 ширхэг	Ваар	Цэвэрлэгээ, сэргээн засварлалт
4	ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн	11 хэсэг	Үйсэн ном	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт
5	ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн	55 хэсэг	Үйсэн ном	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт
6	Монголын үндэсний музей	1	Ваар	Цэвэрлэгээ, хагарч салсан хэсгүүдийг эвлүүлж наасан, нөхөлт, бэхжүүлэлт хийсэн

7	ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн	20	Сарьдагийн хийдийн олдворууд	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт
8	Үндэсний төв архив	1	АЖ Д.Чимэд-Осорын нүүрний гипсэн хэв	Цэвэрлэгээ, хагарсан хэсгүүдийг эвлүүлж нааж бэхжүүлэлт хийсэн
9	ШУА-ийн Археологийн хүрээлэн	68	Хоригийн олдвор-2020	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт
10	Монголын үндэсний музей	28	Хоригийн олдвор-2018, 2019	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт, нөхөлт
11	Булган аймгийн музей	3	Хүрз, зоотуу, тогоо	Цэвэрлэгээ, хэв авч 1х1 хэмжээт хуулбарыг полистер материалаар хийсэн
12	Уран зургийн галерей	1	"Эмнэг сургагч" уран зураг	Цэвэрлэгээ, бэхжүүлэлт, өнгө будгийн сэргээн засварлалт


Увс аймгийн музейн үзмэр




Сэргээн засварлалтын өмнө



Сэргээн засварлалтын дараа




Сэргээн засварлалтын өмнө



Сэргээн засварлалтын дараа



Сэргээн засварлалтын өмнө



Сэргээн засварлалтын дараа



Сэргээн засварлалтын өмнө



Сэргээн засварлалтын дараа

Сэргээн засварлалтын судалгаа болон нэмэлт ажил:

Дорноговь аймгийн музейн хүсэлтийн дагуу тус аймгийн Даланжаргалан сумын Их нартын цогцолбор дурсгалаас илрүүлсэн хадны оршуулгын хатмал шарилд хөгц мөөгөнцөр болон гүн бохирдлыг цэвэрлэгээ, бүрэн ариутгал хийн хүлээлгэн өгөх ажлыг сэргээн засварлагч судлаачийн бүрэлдэхүүнтэй баг 2020 оны 03 дугаар сарын 5-аас 03 дугаар сарын 7-ны өдөр, 3 хоногийн хугацаанд гүйцэтгэлээ. Цаашид хатмал шарилын хөгц, мөөгөнцрийн гэмтэл үүсэхийг зогсоох, хадгалалт, хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлж хадгалалтын зөвлөгөө өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга зүйгээр ханган ажиллав.





УРАН ЗУРГИЙН НҮҮРЭНД ХИЙСЭН ХАМГААЛАЛТЫН ГЯЛГАР БҮРЭЭСҮҮДИЙГ САЛГАХ АЖИЛ БОЛОН МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН САН ХӨМРӨГТ ХИЙСЭН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр Монголын уран зургийн галерейн сан хөмрөгт хадгалагдаж буй Монгол зураг, график зургийн нийт 50 гаруй бүтээлүүдэд гялгар нүүрлэгээ хийсэн байсан бөгөөд эдгээрээс 42ш зургийн нүүрэнд хийсэн хамгаалалтын гялгар бүрээсүүдийг салгах ажлыг СБӨСЗГазрын сэргээн засварлагчид хийж гүйцэтгэв. Уран зургийн галерейн ажилчдын хэлж буйгаар уг хамгаалалтын нүүрлэгээг 2013-2014 оны хооронд хийсэн хэмээж байгаа бөгөөд уг нүүрлэгээ нь зургуудын хадгалалтад ямар нөлөө үзүүлж буй болон үзүүлж болох талаар Соёлын өвийн үндэсний төвд хандаж улмаар тодорхой хугацааны туршид буюу 2019 оны 12 сараас 2020 оны 1 сар хүртэл уг зургуудын хадгалалтын орчинд хэмжих багажаар хэмжилт хийж тодорхой дүгнэлтийг гаргасан болно.


Уг дүгнэлтийг үндэслэн Монголын уран зургийн галерейн хүсэлтийн дагуу Соёлын өвийн үндэсний төвийн СБӨСЗГазрын сэргээн засварлагчид ажиллаж доорх бүтээлүүдийн гялгар хамгаалалтын нүүрлэгээг авах ажлыг хийж гүйцэтгэв.

Уг гялгар хамгаалалтын нүүрлэгээ нь бүтээлүүдэд гаднаас шууд учруулж болох эрсдэл болох ус, чийг, шороо тоосны бохирдлоос хамгаалж байгаа боловч технологийн хувьд оновчтой, зөв шийдлээр хийгдээгүй тул тухайн хадгалалтын жигд, тогтвортой бус орчны нөлөөнд тухайн бүтээлүүд агаарын чөлөөт сэлгэлт хийх нөхцлийг битүүмжлэн чийг хуримтлагдах улмаар хамгаалалтын гялгар нүүр нь зургийн гадаргад наалдах зэргээр бүтээлүүдийн өнгө будаг, будгийн суурь үе давхаргыг гэмтээж болох эрсдэл учруулж байгаа нь судалгааны үр дүнд тогтоогдсон тул тэдгээрийг салгаж авах ажлыг хийсэн.

Үлдсэн бүтээлүүдийн гялгар нүүрлэгээг дараагийн шатны зохих хадгалалт хамгаалалтын орчин болон шаардлагатай материал, арга зүйг боловсруулсаны дараа салгаж авхаар хэлэлцэн түр хойшлуулсан болно.




Уг ажилд СБӨСЗГазрын сэргээн засварлагч



1. Д. Нямдорж
2. М. Оюунтулга
3. Н. Жамбал
4. А. Мөнгөнцоож
5. Э. Батжаргал
6. С. Даваадарь
7. Т. Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй ажиллав.









Зураасан зургийн сан хөмрөгийн Гялгар материалаар бүрсэн бүтээлүүдийн жагсаалт

№	Хувийн дугаар	Бүтээлчийн нэр	Бүтээлийн нэр	Хэмжээ	Материал	Зураг
1	68.31	Б. Аварзэд	Сургуульдаа	44x63.5 см	Гуашь даавуу	
2	99.06	А.Амараа	Салхин морьд 2 иж	59.2x42 см	Пастель, цаас	
3	85.08	Ц.Баянзул	Таван бухал	52.5x41 см	Усан будаг, цаас	
4	92.03	Ш.Баатар	Шивэгчин	64x44.5 см	Гуашь, даавуу	
5	92.109	Ч.Батмөнх	Дорнотын хязгаар	32x45см	Усан будаг, цаас	
6	66.12	Д.Амгалан	Улаан тоос	164.2x67см	Гуашь, цаас	
7	79.25	Б.Баясгалан	6 сарын 1	80x55см	Гуашь, даавуу	
8	85.23	Г.Пүрэвбат	Морин эрдэнэ	94.5x75 см	Гуашь, даавуу	
9	96.37	Д.Гунгаа	Өндөр Гонгор	84.5x66.4см	Тушь, нүүрс, цаас	
10	80.15	О.Найдан	Шивнээн бороо	97x61см	Усан будаг, цаас	
11	80.21	О.Найдан	Сүм хадны говьд	59.5x89.5см	Усан будаг, цаас	
12	78.32	А.Сэнгэцохио	Хоёр буур	75x103см	Гуашь, даавуу	

13	02.02	Д.Батбаяр	Уран бичлэг	107x76.4см	Бэх, муутуу	
14	60.15	Д.Маньбадар	Хатанбаатар	121.3x83.5см	Гуашь, даавуу	
15	85.17	Ц.Даваахүү	Шилдэг бүхнээ фронтод	72.5x132.5см	Гуашь, даавуу	
16	68.39	Л.Дамба	Бэлчээрт	40x120см	Гуашь, даавуу	
17	85.09	Ц.Доржсүрэн	Бүсгүйчүүд	61x86см	Нүүрс, цаас	
18	77.38	Ц.Дагванам	Ургацын далай	70x59.6см	Өнгөт хулдаасан бар	
19	62.40	А.Сэнгэцохио	Уургач	50x99.5см	Гуашь, даавуу	
20	81.38	Б.Чинтогтох	Адуучин	61x110см	Гуашь, цаас	
21	65.28	Ү.Ядамсүрэн	Зун	64.5x90см	Гуашь, даавуу	
22	70.19	Ү.Ядамсүрэн	Чойбалсан	78x56см	Гуашь, цаас	
23	68.60	Д.Шагдар	Адуун сүрэг	150x200см	Гуашь, даавуу	
24	06.05	М.Баярмагнай	Их бишрэл	110x200см	Гуашь, даавуу	
25	67.35	А.Сэнгэцохио	Ленинд бараалхсань	99x137.5см	Гуашь, даавуу	

30	62.91	А.Сэнгэцохио	Марзаншарав	120x90см	Гуашь, даавуу	
31	61.53	Д.Амгалан	Энхтайван	70x100см	Гуашь, даавуу	
32	58.32	Ц.Доржпалам	Ногоон дээлтэй өвгөн	19x19см	Усан будаг цаас	
33	77.47	Л.Дарьсүрэн	Урт наст зургаа	93.5x122см	Гуашь, даавуу	
34	68.38	Д.Маньбадар	Сүхбаатар Янжмаа	102.143см	Гуашь, даавуу	
35	81.47	Ц.Даваахүү	Хувьсгалын дуудлага	82.6x115см	Гуашь, даавуу	
36	06.04	Т.Нурмаажав	Уйгар соёл	120x153см	Гуашь, даавуу	
37	87.37	М.Хайдав	Балин хад	62x86см	Гуашь, даавуу	
38	63.29	Д.Дамдинсүрэн	Саальчин	130x88см	Тосон будаг зотон	
39	88.02	С.Мижиддорж	Сарлагийн уралдаан	81x43см	Гуашь, даавуу	
40	59.68	Д.Лувсанжамц	БНМАУ	115x149см	Гуашь цаас	
41	95.29	Б.Баярт-од	Хатад	160x49см	Гуашь, даавуу	
42	00.04	Г.Амарсанаа	Их нүүдэл	226x99.3см	Торго усан будаг	

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ОЛДВОР ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛД ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, БЭХЖҮҮЛЭЛТ СЭРГЭЭН ЗАСВАР ХИЙСЭН ТАЙЛАН

1.Өмнөтгөл

Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет өвийг сэргээн засварлах газарт Монголын үндэсний музейгээс 19ш олдвор хүлээж авсан.

2.Олдворын ерөнхий хадгалалтын байдал

Хөрсний урвалын орчин хүчтэй хүчиллэг орчин зонхилсон,органик болон металл олдворууд өндөр чийглэг хөрсний нөлөөнд олон зуун жил нян бактерт идэгдэж өгөршил болон зэврэлт явагдаж муудсан байдалтай байсан.

3.Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн зорилго

Тал хээрийн бүсээс илэрч буй усны агууламж багатай органик эдлэл, металл болон бусад олдворын анхны эх төрхийг хадгалж тэр хэвээр нь удаан хугацааны хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийг хийж, эсийн бүтцийн гэмтлийн бат бөх байдлыг тогтворжуулах зорилготой юм.

4.Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт

Хүрэл сав 1ш, хүрэл савны таг 1ш, хүрэл товруу 4ш олдворуудад хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд хүрлийн өвчлөл буюу ногоорч зэвэрсэн байдалтай, зарим хэсгүүд нь толбот төрлийн физик хөнөөлт шинжид орсон тогтворгүй орчинд хурдан хугацаанд зэвэнд идэгдэх чийгний төрлийн хөх ногоон өнгийн физик хөнөөлт шинж ихтэй өвчлөлд орсон байдалтай байсан.

Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт сэргээн засвар хийх ажлын үндсэн дараалалд

-Баримтжуулалт
-Цэвэрлэгээ
-Зэврэлтийг зогсоох
-Бэхжүүлэлт
-Сэргээн засварлах
- Баримтжуулалт
-сав баглаа боодол хийх арга зүйн дарааллаар хийдэг

4.1 Баримтжуулалт


CANON2T2i болон OLYMPUS-ToughF2загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургийг авч баримтжуулсан.

4.2 Цэвэрлэгээ

Хүрэл олдворуудыг эхний ээлжид мэс хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилон Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорсныг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 30 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар гадаргууд ялгарсан зэвний ногоорсныг цэвэрлэсэн.



Зураг 1: трилион Б-EDTA 30 минут



Зураг 2: трилион Б-EDTA хатаалт

4.3 Зэврэлтийг зогсоох

Хүрэл эдлэлийн зэврэлтийг зогсоолгүй гадаргуун бэхжүүлэлт хийх нь богино хугацаанд дотроосоо зэврэлт явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс зэвний физик хөнөөлийн үүсгэврийг бензотриазол C6H5N3 -3%, этанол C2H5OH 97%-ийн уусмалд 10 хоног байлгаж, уусмалаас гаргаж 3 хоног, дунджаар 25 градусын тасалгаанд тасалгаанд хатааснаар бүрэн устгасан.



Зураг 3: хатаалт 5 дахь өдөр

4.4 Бэхжүүлэлт

Зэврэлтийг зогсоосон хэдий ч чийгшил дулааны хэлбэлзэлтэй орчинд хүрэл эдлэл нь тогтворгүй орчны нөлөөнөөс дахин урвалд орж зэврэлт үүсэх магадлал өндөр байдаг. Тиймээс олдворын сийрэгжсэн гүний нүх сүв, гадаргуун эмзэг давхаргыг бэхжүүлэгч бодисоор дүүргэх шаардлагатай байдаг. Олдворын гүнд бэхжүүлэгчийг сайн хийхийн тулд агаарын даралтыг ашиглах зорилгоор вакуум үүсгэх төхөөрөмжид паралойд B72-10%, ацетон C3H6O-90%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



Зураг 4: вакуум үүсгэгч



Зураг 5: B72-10%

4.5 Сэргээн засварын ажилбар

Эдгээр олдворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээх ажилбар хийх шаардлагагүй болно.

4.6 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

4.7 Сав баглаа боодол

Хадгалалтын тогтвортой орчин бүрдүүлэх анхан шатны арга зүй нь олдворын сав баглаа боодлыг ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон.

5. Төмөр эдлэлийн хадгалалт хамгаалалт

Төмөр хутга 1ш, Төмөр арал 5ш олдворт хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд зэвэрсэн байдалтай, зарим хэсгүүд нь шороон гадарга үүсэн хуяглаж давхарга үүссэн, үндсэн их бие нь зэвэнд идэгдэж их хэмжээний гэмтэлтэй байсан.

5.1 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургыг авч баримтжуулсан.

5.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжид этанолоор чийгтэй цэвэрлэгээ хийж, мэс хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргуун зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэсэн.



Зураг 6: зэвний цэвэрлэгээ



Зураг 7: чийгтэй цэвэрлэгээ

5.3 Зэврэлтийг зогсоох, давсгүйжүүлэх

Төмөр эдлэлийн зэврэлтийн гол шалтгаанд он удаан жил хөрсний найрлагаас татаж авсан эрдэс давс нь гол нөлөө үзүүлдэг. Тиймээс археологийн малтлагаас илэрсэн төмөр олдворын гүн бохирдлыг натрийн сескикарбонат дигидрат $Na3H(CO3)2{\cdot}2H2O$ ашиглан уусмалын аргаар давсгүйжүүлэх арга зүйг хэрэглэдэг. Энэ удаагийн төмөр эдлэлүүд нь хар хүрэн өнгийн тогтвортой зэврэлт зонхилсон, давсны нөлөө багатай орчноос илэрсэн учраас давсгүйжүүлэлтийг хийх шаардлагагүй байсан.

5.4 Бэхжүүлэлт

Вакуум үүсгэх төхөөрөмжид паралойд B72-10%, ацетон C3H6O-90%- ийн уусмалд төмөр хутгыг 30 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан. Бүсний арал хэсгүүдэд бийр ашиглан түрхлэг хэлбэрээр 5 удаагийн давтамжтай бэхжүүлсэн.



Зураг 8: B72-ийн бэлтгэх байдал

5.5 Сэргээн засварын ажилбар

Олдворын хувьд төмөр хутга нь голоороо хугарсан байсан ба холигч эпокси цавуу ашиглан нааж, акрилкан будгаар будаж өнгө өгсөн. Бүсний арал хэсгүүд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээх ажилбар хийх шаардлагагүй болно.

5.6 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

5.7 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон.

6.Ясан эдлэлийн хадгалалт хамгаалалт

Ясан чимэг 4ш, ясан савх 2ш олдвор дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүд жигд шороон гадарга үүсэн нимгэн хуяглаж давхарга үүссэн, ясны бүтцийн гэмтэл багатай сайн хадгалагдаж үлдсэн байдалтай байсан.

6.1 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын

өмнөх зургийг авч баримтжуулсан.

6.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжид бийр, багс, чигчлүүр мод ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргуун шороог цэвэрлэж дууссаны дараа этанол C2H5OH 99%-ийн уусмалаар химийн чийгтэй цэвэрлэгээ хийсэн.



Зураг 9: чийгтэй цэвэрлэгээ

6.3 Бэхжүүлэлт

Вакуум үүсгэх төхөөрөмжид паралойд B72-3%, ацетон C3H6O-97%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.

6.4 Сэргээн засварын ажилбар

Ясан эдлэл бүхий олдворуудын хувьд хугарсан болон халцарч цуурсан гэмтэлгүй учраас нөхөх, будах зэрэг сэргээх ажилбар хийх шаардлагагүй болно.

6.5 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

6.6 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон.

7. Лакан аяганы хадгалалт хамгаалалт


Лакан аяганы хувьд гадаргуу хэсгүүд ёроол хэсэг нь нумарсан амсар болон хана хэсгүүд нь гажилт өгч зарим хэсгээрээ хагарч ховхорсон тааран суурьтай учир орчны нөлөөнд маш хурдацтай хаталт өгч лакны чийгэнд нөлөөлж агшилт өгснөөр гадна болон дотор талын гадаргуун нимгэн лакнуудад хагарал үүссэн байдалтай байсан.

7.1 Баримтжуулалт

CANON2T2i болон OLYMPUS-ToughF2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургийг авч баримтжуулсан.

7.2 Цэвэрлэгээ

Малтлагын талбай дээр боосон сав баглаа боодлоос нь авах үед маш хурдацтай агшилт өгч байсан учраас усаар чийгтэй цэвэрлэгээ хийж гадаргууд тогтсон шороог арилгасан. Хүрэл амсрыг эхний ээлжид мэс хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргуун зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилион Б-EDTA 1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорсныг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 30 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар гадаргууд ялгарсан зэвний ногоорсныг цэвэрлэсэн.



Зураг 10 цэвэрлэгээ



Зураг 11 : цэвэрлэж, нааж нөхсөн байдал

7.3 Бэхжүүлэх

Лакан аяга нь нимгэн тааран суурьтайгаас гадна нимгэн лакан гадаргуутай учир орчны нөлөөнд хурдан хугацаанд орж муудаж байсан учир шороон гадаргуутай нөхцөлд тасалгааны орчинд аажим хатаалт өгөх хэлбэрээр хатааж өгч хагарал болон нумрах эрсдэлийг багасгасан.



Зураг 12 битүүмжилсэн байдал

7.4 Түрхэх аргын бэхжүүлэлт

Аяганы нийт гадаргуу хэсгийг паралойд В72-03%, ацетон С3Н6О-97%- ийн уусмал ашиглаж бийрний тусламжтай 5 удаагийн давтамжтай түрхэж 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатааж бэхжүүлсэн.



Зураг 13 : В72-ийн түрхлэг



Зураг 14 : В72-ийн түрхлэг

7.5 Сэргээн засварын ажилбар

Ерөнхий хэлбэрийг авч үлдсэний дараа лакан эдлэлийн хагарч, нумарсан хэсгүүдийг нарийн ажилбар хийх боломжтой гар индүүгээр 80 градусаар халааж тааран суурин дээр лакыг PAOGEN-PP15 төрлийн усан суурьтай цавуугаар нааж эвлүүлсэн. Цуурч ангайсан хэсгүүдэд холигч эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WEN-SOR маркийн акрилкийн будгаар өнгө будгийн сэргээн хийсэн. Амсрын хэсгийг холигч эпоксийн төрлийн цавуугаар нааж залгасан.

10.7 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

10.8 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон.

ХАВСРАЛТ-1



Зураг 14 : сэргээхийн өмнө



Зураг 15 : сэргээсний өмнө




Зураг 16 : сэргээхийн өмнө




Зураг 17 : сэргээсний өмнө



Зураг 18 : сэргээхийн өмнө




Зураг 19 : сэргээсний өмнө



Зураг 20 : сэргээхийн өмнө



Зураг 21 : сэргээсний өмнө



Зураг 22 : сэргээхийн өмнө



Зураг 23 : сэргээсний өмнө




Зураг 24 : сэргээхийн өмнө



Зураг 25 : сэргээсний өмнө



Зураг 26 : сэргээхийн өмнө



Зураг 27 : сэргээсний өмнө



Зураг 28 : сэргээхийн өмнө



Зураг 29 : сэргээсний өмнө



Зураг 30 : сэргээхийн өмнө



Зураг 31 : сэргээсний өмнө



Зураг 32 : сэргээхийн өмнө



Зураг 33 : сэргээсний өмнө



Зураг 34 : сэргээхийн өмнө



Зураг 35 : сэргээсний өмнө



Зураг 36 : сэргээхийн өмнө



Зураг 37 : сэргээсний өмнө



Зураг 38 : сэргээхийн өмнө



Зураг 39 : сэргээсний өмнө



Зураг 40 : сэргээхийн өмнө



Зураг 41 : сэргээсний өмнө

ХАВСРАЛТ-2

Ашиглагдсан багаж хэрэгсэл:

хуванцар сав	ацетон
шилэн сав	гуурсан шүршигч
зөөлөн үстэй бийр	өнгө ялгагч тестер
ширүүн үстэй бийр	ширээний гэрэл
зөөлөн үстэй багс	томруулагч шил
ширүүн үстэй багс	уураар буудагч индүү
чигчлүүр мод	битүүмжлэгч хуванцар сав
чих цэвэрлэгч	түрхэгч саваа мод
хөвөн	үлээгч гуурс
даавуу	хүнсний скоч
техникийн цаас	зөөлөвч уут
ам дарагчтай уут	шүлтлэггүй цаас
мэсний хутга	хэмжилттэй колор
нунтаг шороо	дижитал штангенциркуль
нийлэг цавуу	тасалгааны сэнс
бонд, эпокси цавуу	гуурсан термометр
трехалос сахар	зөөврийн компьютер
хатаах зуух	суурин компьютер
вакуум үүсгэгч багаж	А4-ийн цаас
элсэн буу	хатуулагтай цаас
нарийн индүү	резинэн бээлий
моторт зүлгүүр	маск
принтер	жин хэмжүүр
микроскоп	тугалган цаас
дижитал аппарат	аппаратын хөл
трилон Б	хавчуурга
паралойд	нэрмэл ус
бензотриазол	хүндрүүлэгч
уутан бээлий	цаасны хутга
дулаан, чийгшил хэмжигч	цаасан скоч
акрилкан будаг	өөлөвчтөй савх
этанол	
холигч шил	

ХАР ХОРУМ МУЗЕЙД ХАДГАЛАГДАЖ БУЙ ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛД ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, БЭХЖҮҮЛЭЛТ СЭРГЭЭН ЗАСВАР ХИЙСЭН ТАЙЛАН

1.Өмнөтгөл

Анхан шатны цэвэрлэгээ хийгдээгүй, малтлагын талбайгаас олдворуудыг шууд савласан байдалтай хадгалсан бохирдол шороо ихтэй, зэвэрсэн гэмтэл бүхий 4 ш төмөр сөргөө, 1 ш хүрэл индүүг 2-р сард СӨҮТ-д хүлээлгэн өгсөн. Олдворын төрөл зүйл нь хүрэл эдлэл 1 ш: Cu, төмөр эдлэл 4 ш: Fe, тус тус байсан.

2.Олдворын ерөнхий хадгалалтын байдал

Олдворын гэмтлийг харвал хөрсний давс бага, чийгшил, сэрүүн, агаарын урсгал багатайгаас шалтгаалж хадгалагдаж байгаа олдворууд харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн байдалтай байна. Гэвч байгалийн болоод хүний хүчин зүйлийн нөлөөллөөс шороонд дарагдсан металл олдворууд өндөр чийглэг хөрсний нөлөөнд олон зуун жил олдворын гадаргуу хэсэг нь нян бактерт идэгдэж өгөршилт болон зэврэлт явагдаж муудсан байдалтай байна. Газрын гадаргаас доош дунджаар 1-аас 4-н метрийн гүнд 5-аас 10^2-н хэмд, 40%-н чийгшилд агаарыг урсгал багатай тогтвортой орчноос илэрдэг.

3.Хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн зорилго

Тал хээрийн бүсээс илэрч буй усны агууламж багатай металл болон бусад олдворын анхны эх төрхийг хадгалж тэр хэвээр нь удаан хугацааны хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийг хийж, эсийн бүтцийн гэмтлийн бат бөх байдлыг тогтворжуулах, хийгдэх боломжтой материал судлал дээр багажид дүн шинжилгээ хийх зорилготой юм.

4.Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт

Хүрэл индүүн олдвор дээр хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдворуудын нийт гадаргуу хэсгүүдэд жигд хүрлийн өвчлөл буюу ногоорч зэвэрсэн байдал харьцангуй багатай хэдий ч зарим хэсгүүд нь толбот төрлийн физик хөнөөлт шинжид орсон тогтворгүй орчинд хурдан хугацаанд зэвэнд идэгдэх чийгний төрлийн хөх ногоон өнгийн физик хөнөөлт шинж өвчлөлд ороход хялбар байдалтай байсан.

Хүрэл эдлэлийн хадгалалт хамгаалалт сэргээн засвар хийх ажлын үндсэн дараалалд

-Баримтжуулалт
-Цэвэрлэгээ
-Зэврэлтийг зогсоох
-Бэхжүүлэлт
-Сэргээн засварлах
- Баримтжуулалт
-сав баглаа боодол хийх арга зүйн дарааллаар хийдэг

4.1 Баримтжуулалт

CANON 2 T2i болон OLYMPUS-ToughF2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургийг авч баримтжуулсан.

4.2 Цэвэрлэгээ

Хүрэл олдворуудыг эхний ээлжид мэс хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээнд оруулж гадаргууны зэвний хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэж дууссаны дараа химийн цэвэрлэгээ буюу трилион Б-EDTA

1%, нэрмэл ус 99%-ийн уусмалаар гадаргуун зэвний ногоорсныг арилгах зорилгоор 3 цаг уусмалд байлгаж, 30 минут тутамд уусмалаас гаргаж хөвөн болон техникийн цаасаар гадаргууд ялгарсан зэвний ногоорсныг цэвэрлэсэн.




4.3 Зэврэлтийг зогсоох

Хүрэл эдлэлийн зэврэлтийг зогсоолгүй гадаргуун бэхжүүлэлт хийх нь богино хугацаанд дотроосоо зэврэл явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс зэвний физик хөнөөлийн үүсгэврийг бензотриазол C6H5N3 -3%, этанол C2H5OH 97%-ийн уусмалыг түрхлэг хэлбэрээр арван удаагийн давтамжтай хийж, дунджаар 25 градусын тасалгаанд тасалгаанд хатааснаар устгал хийсэн.




4.4 Бэхжүүлэлт

Зэврэлтийг зогсоосон хэдий ч чийгшил дулааны хэлбэлзэлтэй орчинд хүрэл эдлэл нь тогтворгүй орчны нөлөөнөөс дахин урвалд орж зэврэлт үүсэх магадлал өндөр байдаг. Тиймээс олдворын сийрэгжсэн гүний нүх сүв, гадаргуун эмзэг давхаргыг бэхжүүлэгч бодисоор дүүргэх шаардлагатай байдаг. Олдворын гадаргуу хэсгийг паралойд B72-10%, ацетон C3H6O-90%- ийн уусмалаар таван удаа түрхлэг хийж бүрэн бэхжүүлж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.



4.5 Сэргээн засварын ажилбар

Эдгээр олворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээн засах ажилбар хийх шаардлагагүй болно.

4.6 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

4.7 Сав баглаа боодол

Хадгалалтын тогтвортой орчин бүрдүүлэх анхан шатны арга зүй нь олдворын сав баглаа боодлыг ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.







5. Төмөр эдлэлийн хадгалалт хамгаалалт

4 ширхэг төмөр сөргөө нь зэврэлт өгч гадаргуу хэсэгтээ цуурч ангайсан байдалтай, зэв хэсгүүд нь шороон бохирдолтойгоо нийлж давхарга үүсгэсэн, хадгалалт дунд зэрэгтэй төмөр сөргөөн дээр хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн.


5.1 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх зургийг авч баримтжуулсан.

5.2 Цэвэрлэгээ

Олдворуудыг эхний ээлжид мэс хутга, бийр, багс, чигчлүүр мод, моторт зүлгэгчийг ашиглан механик цэвэрлэгээ болон этанол C2H5OH 99%-ийн уусмалд оруулж гадаргуун зэв хэсгүүд, шороо, жижиг чулуунуудыг цэвэрлэсэн.







5.3 Зэврэлтийг зогсоох, давсгүйжүүлэх

Төмөр эдлэлийн зэврэлтийн гол шалтгаанд он удаан жил хөрсний найрлагаас татаж авсан эрдэс давс нь гол нөлөө үзүүлдэг. Тиймээс археологийн малтлагаас илэрсэн төмөр олдворын гүн бохирдлыг натрийн сескикарбонат дигидрат $Na3H(CO3)2{\cdot}2H2O$ ашиглан уусмалын аргаар давсгүйжүүлэх арга зүйг хэрэглэдэг. Энэ удаагийн төмөр эдлэлүүд нь хар хүрэн өнгийн зэврэлт зонхилсон, давсны нөлөө багатай орчноос илэрсэн учраас давсгүйжүүлэлтийг хийх шаардлагагүй байсан.

5.4 Бэхжүүлэлт

Вакуум үүсгэх төхөөрөмжид паралойд B72-10%, ацетон C3H6O-90%- ийн уусмалд олдворыг 20 минутын хугацаагаар 3 удаа бэхжүүлэгчийг татуулж, 3 хоног дунджаар 25 градусын тасалгаанд хатаасан.





5.5 Сэргээн засварын ажилбар

Олдворын хувьд хугарч халцарсан гэмтэлгүй учраас нөхөх, наах, будах зэрэг сэргээх ажилбар хийх шаардлагагүй болно.

5.6 Баримтжуулалт


CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

5.7 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.




Зураг 11: сэргээн засварын өмнөх ба дараах



Зураг 12: сэргээн засварын өмнөх ба дараах



Зураг 13: сэргээн засварын өмнөх ба дараах



Зураг 14: сэргээн засварын өмнөх ба дараах

ШУА-ТҮҮХ-УГСААТНЫ ХҮРЭЭЛЭНД ХАДГАЛАГДАЖ БУЙ ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛД ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, БЭХЖҮҮЛЭЛТ СЭРГЭЭН ЗАСВАР ХИЙСЭН ТАЙЛАН

Вааран эдлэлийн хадгалалт хамгаалалт

Олдворын дугаар СӨҮТ-2020Н3 ваарны ёроол хэсгийн хагархай хэсгийг нааж хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн ажлыг хийсэн. Олдвор нь шаталт сайтай учраас сайн хадгалагдаж үлдсэн байсан.

1 Баримтжуулалт

CANON2T2i болон OLYMPUS-ToughF2 загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж хадгалалтын өмнөх ба дараах болон хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлтийн явцын зургийг авч баримтжуулсан.

2 Цэвэрлэгээ

Шаталт сайтай байсан учраас чийгтэй усан цэвэрлэгээг сойз, багс, бийр хэрэглэж гадаргуу болон дотор талын шороо чулууны хэсгүүдийг арилгаж цэвэрлэсэн. Уснаас гаргаж 2 хоног 15-20 градусын тасалгаанд тасалгаанд хатаасан.

3 Сэргээн засварын ажилбар

Ваарын хагархайн ёроол хэсгийг UHU загварын нийлэг төрлийн цавуугаар нааж, нөхөх хэсгүүдийг бонд эпоксийн төрлийн цавуугаар нөхөлт хийж WENSOR маркийн акрилкийн будгаар өнгө будгийн сэргээнийг хийсэн.

4 Баримтжуулалт

CANON2T2i загварын дижитал аппарат, KODAK Color ашиглаж бэхжүүлэлтийн дараах зургийг авч баримтжуулсан.

5 Сав баглаа боодол

Ус чийг болон агаарын урсгалаас тусгаарлаж, хайрцагны материалаас үүсэлтэй хүчлүүдээс тусгаарлах зорилгоор хүчил шүлтлэггүй цаасанд боох шаардлагыг хангаж боосон. Мөн зөөж тээвэрлэх үед доргилтоос үүсэх эрсдэлийг хязгаарлаж зөөлөвч хийсэн.







ИХ ТЭНГЭР ЦОГЦОЛБОРТ ХАДГАЛАЖ БАЙСАН 17Ш ЗУРАГТ ХИЙСЭН ГЭМТЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Их тэнгэр цогцолборт” байршиж байсан 17 зурагт үүссэн гэмтлийн тодорхойлолт
Зураг 1. Гэмтлийн тодорхойлолт
Хувийн дугаар:..... 4284-225
Уран бүтээлчийн нэр:..... Ц.Гүдбазар
Бүтээлийн нэр:..... “Шуудан хүргэгч”
Бүтээсэн он:..... ..... 1957 он
Хэмжээ:..... ..... 48х70см
Материал: ....Тос, зотон
Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн доод хэсэгт цохигдон хонхойлт үүссэн, тоос шорооны бохирдолтой, жааз гажсан, жаазыг цэвэрлэх, засах, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 145 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.






Зураг 2. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 5649-75
Уран бүтээлчийн нэр:..... Б.Содномжамц
Бүтээлийн нэр:..... “Хамтач уламжлал”
Бүтээсэн он:..... ..... 1969 он
Хэмжээ:..... ..... 59х160см
Материал: ....Гуашь, даавуу
Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг ховхорч унасан, шингэн зүйл урссан, дуссан толботой, зураг нийтдээ хунирсан, будагны толботой мөн зураг дээр шууд хадаасаар хадсан, зурагдсан, жаазны зүмбэр хээнүүд хагарч, хугарч унасан, тоос шорооны бохирдолтой гэх мэт гэмтлүүд их байна. Гэрлийн хэмжилт хийхэд 72 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зургийн баруун доод хэсэгт шингэн зүйл урссан, дуссан толботой байна.







Зургийн будаг ховхорч унасан, будагны толботой, жаазны зүмбэр хээнүүд хагарч, хугарч унасан хэсгүүд.

Зураг 3. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 6058-737
Уран бүтээлчийн нэр:..... С.Рэнцэн
Бүтээлийн нэр:..... “Цэцэрлэг хот”
Бүтээсэн он:..... ..... 1981 он
Хэмжээ:..... ..... 50х76см
Материал: ....Ислэг хавтан, тосон будаг
Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн дээд өнцөгт бронзны толбо болсон, зураг захаараа эмтэрсэн, тоос шорооны бохирдолтой, жаазны зүмбэр хээ хагарч, ховхорч унасан гэмтлүүдтэй байна. Гэрлийн хэмжилт хийхэд 124 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг 4. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3937-136
Уран бүтээлчийн нэр:..... М.Цэмбэлдорж
Бүтээлийн нэр:..... “Шаргын говь”
Бүтээсэн он:..... ..... 1966 он
Хэмжээ:..... ..... 60х245см
Материал: ....Тос, зотон

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг нь маш их хагарсан, ховхорч унасан, өнгө гандсан, тоос шорооны бохирдолтой, жаазны зүмбэр хээ хагарч, ховхорч унасан гэх мэт гэмтлүүд их байна. Гэрлийн хэмжилт хийхэд 59 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зургийн будаг нь маш их хагарсан, ховхорч унасан, өнгө гандсан мөн жаазны зүмбэр хээ хагарч, ховхорч унасан гэх мэт гэмтлүүдийг харуулж байна.

Зураг 5. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:.....

Уран бүтээлчийн нэр:..... А.Сэнгэцохио

Бүтээлийн нэр:..... “Хүрхэрээ”

Бүтээсэн он:..... ..... 1962 он

Хэмжээ:..... ..... 47х60см

Материал: ....Цаас, гуашь

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийг чийгтэй даавуугаар цэвэрлэж будгийг арчсан, зургийн доод дунд хэсэгт цохигдон урагдаж цоорсон, захаараа сэтэрсэн, шингэн зүйлийн толбуудтай, тоос шорооны бохирдолтой, зураг нийтдээ хунирсан, жаазны зүмбэр хээ хагарч, ховхорч унасан гэх мэт гэмтлүүд их байна. Гэрлийн хэмжилт хийхэд 58 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зургийг чийгтэй даавуугаар цэвэрлэж будгийг арчсан, зургийн доод дунд хэсэгт цохигдон урагдаж цоорсон, захаараа сэтэрсэн гэмтлүүдийг харуулж байна.

Зураг 6. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3901-64
Уран бүтээлчийн нэр:..... Г.Цэрэндондог
Бүтээлийн нэр:..... “Эхийн гол”
Бүтээсэн он:..... ..... 1962 он
Хэмжээ:..... ..... 60х150см
Материал: ....Тос, зотон

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг халцарч ховхорч унасан, дээд талд жижиг хадаасаар цоолж нүх гаргасан, зургийн зүүн талд бронзоор будсан, тоос шорооны бохирдолтой, жаазыг цэвэрлэх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 148 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг 7. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3966-38
Уран бүтээлчийн нэр:..... М.Хайдав
Бүтээлийн нэр:..... “Борооны дараа”
Бүтээсэн он:..... ..... 1972 он
Хэмжээ:..... ..... 55х121см
Материал: ....Цаас, гуашь

Гэмтлийн тодорхойлолт

Уг зураг дээр будгийн болон ус үсэрсэн толботой, будаг хагарсан, халцарсан, зүүн дээд хэсэгт цоорсон, баруун доод хэсэгт цаас наалдсан, тоос шорооны бохирдолтой байна. Гэрлийн хэмжилт хийхэд 435 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг дээр будгийн болон ус үсэрсэн толботой, будаг хагарсан, халцарсан гэмтлийг харуулж байна.

Зураг 8. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3834-576
Уран бүтээлчийн нэр:..... Д.Мөнх
Бүтээлийн нэр:..... “Говь”
Бүтээсэн он:..... ..... 1976 он
Хэмжээ:..... ..... 45х55см
Материал: ....Ислэг хавтан, тосон будаг

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг их хагарсан, хөндийрсөн, ховхорсон, дээд хэсэгт хадаасны нүхтэй, тоос шорооны бохирдолтой, жаазыг цэвэрлэх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 340 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр будаг их хагарсан, хөндийрсөн, ховхорсон гэмтлийг харуулж байна.

Зураг 9. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3372-460
Уран бүтээлчийн нэр:..... Г.Цэрэндондог
Бүтээлийн нэр:..... “Говь”
Бүтээсэн он:..... ..... 1970 он
Хэмжээ:..... ..... 50х100см
Материал: ....Зотон, тос

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн доод талын дунд хэсэгт цоорч урагдсан, өнгө бүдгэрсэн, будгийн толботой, тоос шорооны бохирдолтой, жаазыг цэвэрлэх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 182 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр зургийн доод талын дунд хэсэгт цоорч урагдсан, өнгө бүдгэрсэн, будгийн толботой хэсгийг харуулж байна.

Зураг 10. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 4261-436
Уран бүтээлчийн нэр:..... Ц.Бүдбазар
Бүтээлийн нэр:..... “Намар”
Бүтээсэн он:..... ..... 1963 он
Хэмжээ:..... ..... 60х83см
Материал: ....Цаас, усан будаг

Гэмтлийн тодорхойлолт

Уг зураг нь будаг болон усны толботой, цохигдож цоорсон, нийтдээ шарлаж муудсан, тоос шорооны бохирдолтой, жаазыг цэвэрлэх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 235 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг дээр зургийн зүүн дээд өнцөгт будгийн толбо болсон мөн усны толботой, нийтдээ шарлаж муудсан, тоос шорооны бохирдолтой гэмтлүүдийг харуулж байна.

Зураг 11. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3903-378
Уран бүтээлчийн нэр:..... М.Цэмбэлдорж
Бүтээлийн нэр:..... “Хяргас нуур”
Бүтээсэн он:..... ..... 1960 он
Хэмжээ:..... ..... 45х200см
Материал: ....Зотон, тос

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг нь их хагарсан, ховхорсон, бүдгэрсэн, зургийн доод баруун талд шингэн зүйл цацарч толбо их тогтсон, тоос шороо, утаа тортогны бохирдолтой, жаазны зүмбэр хээнүүд маш их ховхорч унасан, жаазыг цэвэрлэх, зүмбэр хээнүүдийг нөхөх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 135 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг дээр будаг хагарсан, ховхорсон, бүдгэрсэн, зургийн доод баруун талд шингэн зүйл цацарч толбо их тогтсон, тоос шороо, утаа тортогны бохирдолтой, жаазны зүмбэр хээнүүд маш их ховхорч унасан гэмтлүүдийг харуулж байна.

Зураг 12. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 5662-581
Уран бүтээлчийн нэр:..... Л.Гаваа
Бүтээлийн нэр:..... “Газар”
Бүтээсэн он:..... ..... 1977 он
Хэмжээ:..... ..... 90х169см
Материал: ....Зотон, тос

Гэмтлийн тодорхойлолт

Уг зураг нь будгийн толботой, зургийн зүүн талд урагдаж цоорсон, тоос шороо, утаа тортгийн бохирдолтой, жаазны зүмбэр хээн ховхорч унасан, жаазыг цэвэрлэх, зүмбэр хээг нөхөх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 169 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг дээр нь зүүн талд урагдаж цоорсон хоёр цоорхой болон тоос шороо, утаа тортгийн бохирдол, жаазны зүмбэр хээ ховхорч унасан гэмтлийг харуулж байна.

Зураг 13. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 3915-613
Уран бүтээлчийн нэр:..... М.Цэмбэлдорж
Бүтээлийн нэр:..... “Эрдэнэзуугийн замд”
Бүтээсэн он:..... ..... 1977 он
Хэмжээ:..... ..... 69х200см
Материал: ....Зотон, тос

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг хагарсан, ховхорч унасан, урагдаж цоорсон мөн захаараа хадаасны нүхэн цоорхойтой, зургийн дээд талд бронзоор будагдсан, тоос шороо, утаа тортгийн бохирдолтой, жаазыг цэвэрлэх, дахин будах шаардлагатай байна. Гэрлийн хэмжилт хийхэд 196 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр будаг хагарсан, урагдаж цоорсон, зургийн дээд талд бронзоор будагдсан, тоос шороо, утаа тортгийн бохирдолтой хэсгүүдийг харуулж байна.

15

Зураг 14. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 5651-36
Уран бүтээлчийн нэр:..... Ц.Даваахүү
Бүтээлийн нэр:..... “Хөдөөгийн нэг өдөр”
Бүтээсэн он:..... ..... 1972 он
Хэмжээ:..... ..... 80х180см
Материал: ....Цаас, гуашь

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг хагарсан, ховхорч унасан, ус урссан болон дуссан толбуудтай, тоос шорооны бохирдолтой байна. Гэрлийн хэмжилт хийхэд 313 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.




Зураг дээр будаг хагарсан, ховхорч унасан, ус урссан болон дуссан толбуудтай мөн тоос шорооны бохирдолтой хэсгүүдийг харуулж байна.

Зураг 15. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 916-362
Уран бүтээлчийн нэр:..... Д.Амгалан
Бүтээлийн нэр:..... “Буур ба чоно”
Бүтээсэн он:..... ..... 1962 он
Хэмжээ:..... ..... 60х80см
Материал: ....Зотон, тос

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг халцарсан, хагарч ховхорч унасан, дээд талын дунд хэсэгт цоорсон, тоос шороо, утаа тортогны бохирдолтой байна. Гэрлийн хэмжилт хийхэд 299 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр будаг халцарсан, хагарч ховхорч унасан, цоорсон, тоос шороо, утаа тортогны бохирдолтой байгаа гэмтлүүдийг харуулж байна.

Зураг 16. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:..... 5648-65
Уран бүтээлчийн нэр:..... Ү.Ядамсүрэн
Бүтээлийн нэр:..... “Наадам”
Бүтээсэн он:..... ..... 1962 он
Хэмжээ:..... ..... 120х100см
Материал: ....Даавуу, гуашь
Гэмтлийн тодорхойлолт

Уг зураг дээр ус гоожин урсаж дээрээс доод тал хүртэл усны их толботой болсон, будаг халцарсан, цоорсон (дээд хэсэгт хадаасны нүхтэй) байна. Гэрлийн хэмжилт хийхэд 290 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр ус гоожиж урсан дээрээс доод тал хүртэл усны их толботой, мөн бусад хэсгүүдэд ус цацран үсэрч толбууд маш их тогтсон байна.



Энэ зураг дээр будаг их халцарсан байгааг харуулж байна.

Зураг 17. Гэмтлийн тодорхойлолт

Хувийн дугаар:.....
Уран бүтээлчийн нэр:..... Д.Амгалан
Бүтээлийн нэр:..... “Жаахан шаргын нутаг”
Бүтээсэн он:..... ..... 1965 он
Хэмжээ:..... ..... 70х190см
Материал: ....Тосон будаг, зотон

Гэмтлийн тодорхойлолт

Уг зургийн будаг хагарсан, халцарсан, ховхорон унасан, зургийн баруун дээд хэсэг болон дүрслэгдсэн эмэгтэйн малгай дээр цоорсон, тоос шорооны бохирдолтой, жаазны зүмбэр хээ хагарч ховхорон унасан, жаазыг цэвэрлэх, зүмбэр хээг нөхөх, дахин будах шаардлагатай байна.Гэрлийн хэмжилт хийхэд 290 люкс, орчны температур 24оС, харьцангуй чийг 18% байна.



Зураг дээр будаг хагарсан гэмтэлтэй нэг хэсгийг харуулж байна.

Зураг дээр будаг халцарч ховхорон унасан мөн зургийн баруун дээд хэсэг болон дүрслэгдсэн эмэгтэйн малгай дээр цоорсон гэмтэлтэй хэсгийг харуулж байна.

Гэмтлийн ангилал, дүгнэлт

Соёлын биет өв нь орчны болон механик нөлөөллийн гэмтэлд орж муудах гол шалтгаан болж байдаг. Эдгээр “Их тэнгэр цогцолборт” байршиж байсан 17 зурагт нийт 19 төрлийн гэмтэл ажиглагдсан ба эдгээр гэмтлийг орчны гэмтэл, механик гэмтэл, жаазны гэмтэл гэж 3 ангилж болохоор байна. Аль төрлийн ямар гэмтлүүдэд энэ 17 зураг их гэмтсэн байгааг дараах хүснэгтэд харуулав.

“Их тэнгэр цогцолборт” байршиж байсан 17 зурагт үүссэн гэмтлийн ангилал

Дээрх хүснэгтээс харахад зурагууд тоос шорооны гэмтэлтэй 16, утаа тортогны бохирдолтой 2, будаг халцарсан 4, будаг хөндийрсөн 1, будаг хагарсан 7, будаг ховхорч унасан 8 , Өнгө гандаж, бүдгэрсэн 4, үрчийсэн 2 байна. Эдгээр гэмтлүүд нь орчны температур, харьцангуй чийгшил, гэрлийн тусгалаас шалтгаалан зургийн шинж чанар, материалын онцлогт нөлөөлж үүссэн гэмтлүүд юм. Харин хүний болгоомжгүй үйлдэл,

	Орчны гэмтэл								Механик гэмтэл									Жааз	
Зургийн №	Тоос шорооны бохирдол	Утаа тортогны бохирдол	Будаг халцарсан	Будаг хөндийрсөн	Будаг хагарсан	Будаг ховхорч унасан	Өнгө гандаж, бүдгэрэх	Зураг үрчийж, хүнирсэн	Урагдсан	Цоорсон	Шингэн зүйлийн толбо, бохирдол	Будагны толбо болсон	Зурагдсан	Цохигдож хонхойх	Зураг дээр юм наалдсан	Нойтон зүйлээр арчсан	Зураг захаараа эмтэрсэн	Жаазыг дахин будах	Жаазны зүмбэр хээ харагч унасан
1	+													+				+	
2	+					+		+		+	+	+	+					+	+
3	+											+					+	+	+
4	+				+		+											+	+
5	+							+	+	+	+					+	+		+
6	+		+			+				+		+						+	
7	+		+		+					+	+	+			+				
8	+			+	+	+				+								+	
9	+						+		+	+		+						+	
10	+						+			+	+	+		+				+	
11	+				+	+	+				+							+	+
12	+	+								+		+						+	+
13	+				+	+			+	+		+						+	
14	+				+	+					+								
15	+	+	+			+				+									
16			+							+	+								
17	+				+	+				+								+	+

хайхрамжгүй байдлаас механик гэмтлүүд үүсч байдаг. Дээрх хүснэгтээс харвал урагдсан 3, цоорсон 12, шингэн зүйлийн толбо, бохирдол 7, будагны толбо болсон 8, зурагдсан 1, цохигдож хонхойсон 2, зураг дээр юм наалдсан 1, нойтон зүйлээр арчсан 1, зураг захаараа эмтэрсэн 2 байна. Уран зургийг чимэж байдаг салшгүй нэг зүйл бол түүний жааз байдаг. Тиймээс жаазны гэмтлийг тусд нь ангилж гэмтлийг тодорхойлов. Үүнд жаазыг дахин будах 12, жаазны зүмбэр хээ харагч унасан 7 байна.

Эдгээр “Их тэнгэр цогцолборт” байршиж байсан 17 зурагт учирсан гэмтлүүдэд дүгнэлт хийхэд зургуудийг зориулалтын бус орчинд (орчны температур, харьцангуй чийгшил, гэрлийн тусгал зэрэгт хяналтгүй) хадгалж, мэргэжлийн бус хүмүүс харьцаж байсан нь 17 зургийн 12 зурагт хүний хайхрамжгүй байдлаас үүссэн цохиж цоолсон болон нойтон зүйлээр усан суурьтай будгийг арчсан, шингэн зүйл болон будгийн толбо их мөн зургийн будаг гэмтэлтэй байгаагаас тодорхой харагдаж байна. Тиймээс эдгээр зургийг мэргэжлийн хүмүүс зориулалтын хяналттай орчинд хадгалах ба цаашид сэргээн засварлах шаардлагатай гэж үзэж байна.

САРЬДАГЫН ХИЙДИЙН ОЛДВОРТ СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН 1

Хувийн дугаар-СӨҮТ2020Н-7

Гүйцэтгэсэн хугацаа-2020 оны 8 сарын 6 наас 2020 оны 9 сарын 10 ны өдөр хүртэл

Төрөл зүйл :1.Монгол бичигтэй мод 2.Цаас 3.Арьсан эдлэлийн тасархай Эсгий, 5.Сүлжмэл өвс 6.Давирхай 7. Даавуу

Тодорхойлолт :

1. Монгол бичигтэй мод

Нийт 7 ширхэг нимгэн жижиг хавтас модон дээр хар бэхээр монгол бичиг бичигдсэн ба хөрсний шороон бохирдолтой зарим хавтас банз нь дундууpаа цуурсан ан цав гарсан байдалтай байсан бөгөөд. Модон дээрх монгол бичиг нь он цагын явцад бүдгэрсэн шороо тортгонд дарагдсан өмхөрч муудсан ба гадаргуу хэсэг нь биологийн бохирдолд нилээд орсон, модны үндсэн хатуулаг шинж болох лигнин, целлюлоз, гемицеллюлоз нь харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн байна. Хуурай наалдсан хөрс шорооны гадаргуу хэсгийг модны үндсэн эх биеийг гэмтээлгүй савх, багс бийр ашиглаж бохирдолыг нь хусаж авсны дараа чийгтэй хөвөн савханд ороож чийгтэй цэвэрлэгээ хийж гүн бохирдолд цэвэрлэгээ хийв. Хөгц мөөгөнцөр харьцангуй бага болон бэхэн бичээс, модны гадаргуу хэсэгт улаан өнгө зонхилж байсан учраас спорт гэх мэт органик хүчтэй уусгагч цэвэрлэгээнд ашиглаагүй болно. Гажилт өгч нумарсан хавтас модны хэсэгт даавуугаар жийрэглэн модоор сэндвичлэн хавчуулж 7 хоног чиг тавьж шулуун хэлбэрт оруулсан. Бичвэрийн хэсгийг бэхжүүлхийн тулд паралойд 2%-ийг ацетоноор шингэлсэн бэхжүүлэгч уусмалаар 2-оос 3 удаагийн давтамжтай гадаргуу хэсгийг гялаалгахгүй хэмжээнд хүртэл түрхэн бэхжүүлсэн.

2.Цаас

Нойтон чийгтэй хөрс шаварны бохирдолтой, цаасны найрлаган дахь целлюлоз нь гэмтэж урт хугацааны явцад өгөршил явагдсан хэсгүүдтэй, үрчийж хунирсан байдалтай байсан. Ногоон, улаан, цайвар яагаан шороон будган түрхэцтэй. Шороон будаг нь цаасны гадаргуу хэсэгт наалдац муу маш эмзэг болж хөдөлгөөнд орсон, хөрсөн доор чийглэг ихтэй газар агаарын урсгал бага байсан нь хөгц мөөгөнцөр нян бактери үүсгэх эрсдэлийг багасгаж байсан байна. Зарим цаасны завсарт нь модон хүж хавчуулж ороосон байдалтай байсан ба чийг ихтэй байсан тул огцом хатаалт хийлгүй тасалгааны темпратурт дундаж 22 градусаас 25 градусд өөрөөр нь хатаасан. Хуурай цэвэрлэгээг зөөлөн үстэй багс бийр ашиглаж хийх явцад сүлжмэл өвс болон модон эдлэлүүд илэрсэн. Цаасны хэсгүүдийг ууpаар чийгшүүлж зөөллөн тусгаарлагч цаас болон чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан чийгийг алгуурхан гадагшлуулж цаасны үрчийсэн хэсгийг тэггшилж засах хэлбэрээр бүрэн хатаалтанд оруулсан.

3.Даавуу

Маш их чийгтэй байсан тул тасалгааны темпратурт хатаав. Бийр багс ,савх мод ашиглан бохирдолыг цэвэрлэж байх яавцад Хятад ханз олдсон. Дараа нь тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.

4. Эсгий

Тоос шорооны бохирдол болон шаварны бохирдол ихтэй, хар хөх өнгөтөй ба гадаргуу хэсэгтээ ямар нэгэн хэө угалз, зүү ороосон утасны оромгүй байсан. Нойтон

чийгтэй байдалтай. Хунирсан чийгтэй эсгийг дэлгэхэд дунд хэсэгт нь модон хүж ороож байрлуулсан ,баруун доод хэсэгт нь ногоон өнгийн шороон будган түрхэцтэй илэрсэн. Ууpаар чийгшил нэмж дээр доороос нь шилээр чиг тавин тэнийлгэж тасалгааны хэмд дундаж 22 градусаас 25 градусд өөрөөр нь хатаан тэнийлгэсний дараа зөөлөн үстэй багс бийр, савх мод ашиглан гадаргуу хэсгийн гүн бохирдолыг үлээлгэх буюу товших маягаар цэвэрлэв.

5. Сүлжмэл өвс

Бүдүүн ширхэгт ургамлыг хавтгай хэлбэрт оруулж нарийн аргаар сүлжсэн хэсэг нь хунирч базагдсан зарим сүлжээс нь нойтон чийгтэй байдлаас болж задарч эсийн гэмлээс болж зөөлөрч задарсан байдалтай байсан. Гадаргуу хэсэгт ямар нэгэн будаг өнгөний өөрчлөлт байхгүй тоос шороо, шаварлаг бохирдол ихтэй байсан. Зөөлөн бийр багс ,савх мод ашиглан бохирдолд хуурай цэвэрлэгээ хийж дууссаны дараа тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр чиг барин даруулж дээрээс нь хүндрүүлэгчээр даруулан ар өвөргүй эргүүлэн хяналт тавин тасалгааны орчинд дундаж 22 градусаас 25 градусд өөрөөр нь хатааж тэнийлгэсэн.

6. Давирхай

Хүрэн яагаан өнгийн шороон будган тогтоцтой шавар шороон бохирдол ихтэй, модон хүж гадаргуу хэсэгт шавартай зууралдан наалдсан байдалтай байсан. Нийт хэсгээрээ чийгийн нөлөөллөөр агшиж хумигдан хатсан шавар гадаргуугаар бүрхэгдсэн байсан. Гадаргуу хэсгийн будаг нь хаьцангуй тогтвортой наалдац сайтай байсан учир ус ашиглан гадаргуу хэсгийн шаврыг зөөллөж савх модоор чийгтэй цэвэрлэгээ хийж шорооны гүн бохирдолыг арилгаж цэвэрлэсэн. Шавар хэсгүүдийг бүрэн арилгах явцад гадагуу хэсгийн хүж салж, хунирсан хэсгүүд тэнийж хэд хэдэн салсан хэсгүүд болон хуваагдсан. Хуваагдаж салсан жижиг хэсгүүдийг тасалгааны орчинд дундаж 22 градусаас 25 градусд өөрөөр нь хатааж тэнийлгэсэн байдлаар хатаасан.

7.Арьсан эдлэлийн тасархай


Бүх арьсан эдлэлийн тасархай нь бага зэргийн чийгтэй шороо болон шаварны бохирдолтой үрчийж хунирсан хэлбэр дүрсээ алдсан байдалтай байсан. Зарим арьсан эдлэлийн тасархайн гадаргуу хэсгийн дээд болон зүүн доод, баруун доод, гол хэсгүүдэд ногоон, улаан, цайвар яагаан шороон будгийн түрхэц илэрсэн. Шороон будгийн хэсэг нь арьсны гадаргуу дээр тогтоц сайтай хөдөлгөөнгүй байсан. Чийгний агууламж багатай тоос шорооны бохирдол ихтэй хөгц мөөгөнцөр харьцангуй бага байсан. Ус ашиглан чийгшүүлж зөөлөн багс, савх модоор үрж хөрс шороон гүн бохирдолыг арилгасан. Чийгшил өгсөн арьсийг тусгаарлагч цаас, чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр чиг барин даруулж дээрээс нь хүндрүүлэгчээр даруулан ар өвөргүй эргүүлэн хяналт тавин тасалгааны орчинд дундаж 22 градусаас 25 градусд өөрөөр нь хатааж тэнийлгэсэн.

Хийгдсэн ажил.Олдворуудыг гэрэл зургаар баримтжуулан хуурай болон чийгтэй цэвэрлэгээг хийж шаардлагатай хэсгүүд дээр бэхжүүлэлт хийж олдворуудыг хайрцагт байрлуулж гүйцэтгэсэн болно.

-Сэргээн засварлах үеийн явц өмнөх болон дараах-

Д/д	Олдворын нэр	Олдворын дугаар	Олдворын сэргээн засах үеийн тодорхойлт	Гэрэл зураг	
				Өмнө (явц)	Дараа
1.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020т-1	Бага зэргийн чийгтэй хөрс, шорооны бохирдолтой байсан . Хуурай наалдсан хөрс шорооны бохирдолыг хусаж арилган.Чийгтэй хөвөн савханд ороож цэвэрлэгээ хийв.		
2.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020т-2	Шороо тоосны бохирдолтой чийггүй байсан тул савхаар хуурай наалдсан хөрс шорооны бохирдолыг хусаж цэвэрлэсэн.Багс бийр ашигласан .Чийгтэй хөвөн савханд ороож нарийн тоосны бохирдолыг арчиж цэвэрлэсэн.		
3.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020т-3	Хуурай шороо тоосны бохирдолыг савх мод багаж ашиглан цэвэрлэгээ хийсэн. Савх модонд чийгтэй хөвөн ороож зөөлөн, хөнгөн арчиж бохирдолыг цэвэрлэв.		


4.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т -2020т-4	Чийгүй хөрс, шорооны бохирдолтой байсан. Хуурай наалдсан хөрс шорооны бохирдолыг хусаж арилгасан.Чийгтэй хөвөн савханд ороож цэвэрлэгээ хийв.		 
5.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т -2020т-5	Чийгүй хөрс, шорооны бохирдолтой булан хэсэгт мөөгөнцөртсөн байсан. Чийгтэй хөрс шорооны бохирдолыг хатаасны дараа наалдсан хөрс шорооны бохирдолыг хусаж арилгасан.Чийгтэй хөвөн савханд ороож этилийн спиртийн 10%-аар арчиж цэвэрлэгээ хийв.	 	 
6.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т -2020т-6	Бага зэргийн чийгтэй хөрс, шорооны бохирдолтой хугарч дээшээ овойж хэлбэр алдсан байсан. Хуурай наалдсан хөрс шорооны бохирдолыг хусаж арилгасан.Чийгтэй хөвөн савханд ороож цэвэрлэгээ хийв.Бичгийг тодруулахын тулд паралиод 2% ацетоноор шингэлж хувийг багасгаж арчисан.Модны хэлбэрийг даавуугаар жийрэглэн модоор сэндвичлэн	   6	 

			хавчуулж 7 хоног хэлбэрт оруулсан.	 	
7.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т-2020т-7	Хуурай шороо тоосны бохирдолыг савх мод багаж ашиглан цэвэрлэгээ хийсэн. Савх модонд чийгтэй хөвөн ороож зөөлөн, хөнгөн арчиж нимгэн бохирдолыг цэвэрлэв		
8.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т-2020т-8	Чийгүй хөрс, шорооны бохирдолтой. Усанд умбуулан зөөлөн багсаар үрж хөрс шороон бохирдолыг арилгасан.Нойтон арьсийг тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.зъ	 	

				 	
9.	Сүлжмэл өвс	С.Ө.Ү.Т-2020т-9	Бага зэргийн чийгтэй, шороо тоосны бохирдолтой байсан.Бийр багс ,савх мод ашиглан бохирдолыг цэвэрлэж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.		

10.	Даавуу	С.Ө.Ү.Т-2020т-10	Маш их чийгтэй байсан тул тасалгааны темпратурт хатаав. Бийр багс ,савх мод ашиглан бохирдолыг цэвэрлэж байх яавцад Хятад ханз олдсон. Дараа нь тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.		
11.	Даавуу	С.Ө.Ү.Т-2020т-11	Хуурай хуйлаастай байсан даавууг багс бийрээр шороо тоосны бохирдолыг цэвэрлэсэн. Чийг өгж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.		

					
12.	Цаас	С.Ө.Ү.Т-2020т-12	Маш их чийгтэй байсан тул тасалгааны темпратурт хатаав. Хуурай цэвэрлэгээг хийх явцад сүлжмэл өвс болон мод олдсон. Чийг өгж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаав.		
13.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т-2020т-13	Маш их чийгтэй, шороо тоосны бохирдолтой.Бару ун доод болон зүүн доод буланд хэсэгт цайвар ягаан шороон будган түрхэцтэй.Тасалгаа ны темпратурт хатаан. Бийр багс ,савх мод ашиглан бохирдолыг цэвэрлэж байх явцад хуудсан алт олдов Чийг өгж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.		

					
14.	Цаас	С.Ө.Ү.Т-2020т-14	Өнгөн талдаа ногоон өнгийн шороон будган түрхэцтэй, хөндийрч эмзэг болсон.Хуурай цэвэрлэгээг суларсан ногоон өнгөтэй шороон будагтай хэсгүүд дээр болгоомжтой багс бийр ашиглан цэвэрлэсний дараа,чийг өгж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.	  	
15.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т-2020т-15	Чийгтэй цайвар ягаан өнгөтэй шороон будган тогтоцтой хөрс, шорооны бохирдолтой.Бийр багс ашиглан хөрс шорооны бохирдолыг арилгасан.Нойтон		


			арьсийг тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.	 	
16.	Сүлжмэл өвс	С.Ө.Ү.Т-2020т-16	Чийгтэй шороо тоосны бохирдолтой байсан.Бийр багс ,савх мод ашиглан бохирдолыг цэвэрлэж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.	  	
17.	Эсгий	С.Ө.Ү.Т-2020т-17	Чийгтэй эсгийг дээр доороос нь сэндвичэлсэн хэлбэртэй дунд хэсэгт модон хүж байрлуулсан ,баруун доод хэсэгт ногоон өнгын шороон будган түрхэцтэй. Багс бийр ашиглан бохирдолыг цэвэрлэв.	 	


18.	Эсгий	С.Ө.Ү.Т -2020т-18	Шороон болон хатсан шавар бүхий бохирдолтой. Хуурай цэвэрлэгээг бургуу,савх мод ашиглан үлээлгэх буюу товших маягаар цэвэрлэв.		
19.	Давирхай	С.Ө.Ү.Т -2020т-19	Шороон болон хатсан шавар бохирдолтой. Усанд умбуулан савх модоор хусаж хөрс шорооны бохирдолыг арилгасан.		
20.	Цаас	С.Ө.Ү.Т -2020т-20	Ногоон өнгын шороон будган түрхэцтэй маш их чийгтэй байсан тул тасалгааны темпратурт хатаав.Багс бийр ашиглан шороо тоосны бохидолыг арилгав. Чийг өгж тусгаарлагч цаас,чийг авах хөвөн цаасаар сэндвичлэн хавчуулж шилээр даруулж хүндрүүлэгчээр даруулан сольж тавин хатаасан.	 	

Хайрцаг сав

-Бүгд нэг орхоор том хайрцаг хийв.Дээр доорос нь шүлтгүй цаасар сэндвичлэн дээр дээрэсэ давхарлдхаар буюу давхар тасалгаатай хийв.

Зураг














САРЬДАГЫН ХИЙДИЙН ОЛДВОРТ СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН 2




Хувийн дугаар-СӨҮТ2020Н-7 (Өмнөх ,Дараа)

Гүйцэтгэсэн хугацаа-2020 оны 8 сарын 6 наас 2020 оны 9 сарын 2 ны өдөр хүртэл

Д/д	Олдворын нэр	Олдворын дугаар	Гэрэл зураг	
			Өмнөх	Дараа
1.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-1		
2.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-2		
3.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-3		
				
4.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-4		

5.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-5		
6.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-6		
7.	Монгол бичигтэй мод	С.Ө.Ү.Т - 2020н-7		
8.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т - 2020н-8		
9.	Сүлжмэл өвс	С.Ө.Ү.Т - 2020н-9		

10.	Даавуу	С.Ө.Ү.Т - 2020н-10		
11.	Даавуу	С.Ө.Ү.Т - 2020н-11		
12.	Цаас	С.Ө.Ү.Т - 2020н-12		
13.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т - 2020н-13		
14.	Цаас	С.Ө.Ү.Т - 2020н-14		
15.	Арьсан эдлэлын хэсэг	С.Ө.Ү.Т - 2020н-15		

16.	Сүлжмэл өвс	С.Ө.Ү.Т - 2020н-16		
17.	Эсгий	С.Ө.Ү.Т - 2020н-17		
18.	Эсгий	С.Ө.Ү.Т - 2020н-18		
19.	Давирхай	С.Ө.Ү.Т - 2020н-19		
20.	Цаас	С.Ө.Ү.Т - 2020н-20		

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙД ХИЙСЭН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монголын Уран зургийн галерейн албан хүсэлтийн дагуу тус галерейн сан хөмрөгт хадгалагдаж буй тоос, шороо болон бусад хүчин зүйлээс хамгаалах зорилгоор хийгдсэн гадаргуу хэсэгтэй гялгар уутан хучлагатай 52 ширхэг уран зурагт хадгалалт хамгаалалтын эрсдэлийн дүн шинжилгээг хийлээ. Байгаль, цаг агаарын харьцангуй тогтвортой үе буюу өвөл цагт халаалт эхэлсэн үеийг сонгож 2019 оны 12 сарын 25-ны өдрөөс, 2020 оны 1 сарын 15-ны өдрийг хүртэлх 21 хоногийн хугацаанд тухайн зураг хадгалагдаж буй сан хөмрөгт дулаан чийгшлийн хэмжилтийг хийж ажиглалт явуулсан.

“TR-72wf” загварын дулаан чийгшил хэмжигч багажийг ашиглан, дулаан чийгшлийн хэмжилтийг 504 цагийн давтамжтай хэмжсэн бөгөөд хэмжилтийн үр дүнд дулаан харьцангуй тогтвортой байгаа хэдий ч чийгшил өсөж буурах үзэгдэл 2019 оны 12 сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд харьцангуй тогтвортой байсан чийгшил /дунджаар 17%-тай байсан/ тус сарын 07-ны өдөр огцом хэлбэлзэх үзэгдэл /20%/ ажиглагдсан болно. Тухайн өдөр шинэ үзэсгэлэнгийн хүлээн авалт хийж 100-с дээш хүн цугласан нь үзүүлэнгийн танхимын хэмд шууд нөлөөлж үүнээс үүдэн сан хөмрөгийн чийгшил хэлбэлзсэн гэж үзэхээр байна.

Сан хөмрөгийн чийгшилийн хэлбэлзэл огцом өөрчлөгдсөн гол шалтгаан нь агааржуулах хоолой нь бусад өрөө тасалгаа, үзмэрийн танхимтай шууд холбоотой байгаагаас сан хөмрөгийн өрөөний дулаан чийгшилийн хэлбэлзэлд нөлөөлж буй нь уран зургийн хадгалалт хамгаалалтанд эрсдэл үүсгэх магадлал өндөртэй юм.

Орчны чийгшил хэлбэлзэлтэй, зориулалтын сан хөмрөгийн өрөө тасалгаагүй учир тухайн сан хөмрөгт хадгалагдаж байгаа нүүрэн талыг гялгар уутаар бүрсэн уран зургийн ар талаас нэвтэрсэн чийгшил эсвэл дулааны хэлбэлзлийн улмаас гадаргуу хэсгийн уутан хамгаалалтын бүрхэлт дотор конденсац буюу хөлрөө үүсгэх, улмаар зургийн гадаргуу хэсэгт наалдаж будаг болон суурь грунт, зотон даавуун үе давхаргуудад гэмтэл болон хөгц, мөөгөнцөр үүсгэх эрсдэлтэй тул уутан хучлагыг авах нь зүйтэй юм.

Дунд зэргийн мэдрэмтгий	Тослог зураг, Темпера зураг, Фрескогийн з ураг, будаагүй арьсан эдлэл, эвэр, яс, заа ны соёо, модон эдлэл, лакны эдлэл	○150	тод, дунд зэрэг	Ra>90
Харьцангуй нөлөөлөл бага	Металл, чулуу, шил, үнэт эдлэл, паалан	○500	тод, дунд зэрэг, бага	Ra>90
галерей		50	тод, дунд зэрэг, бага	90>Ra>80
Видео, гэрэл ашиглан үзэсгэлэн гаргах		10	тод, дунд зэрэг, бага	90>Ra>80

Чингис хаан музейд гэрэлтүүлэг хийх анхан шатны загвар

Үзмэрүүдийг жигд тод харагдах байдалтай болгохын тулд арын хана, шал зэрэг ойрын хүрээнд байгаа эд зүйлсийн харагдах байдлаас 2-3 дахин тод гэрэлтүүлэг өгөх шаардлагатай. Үзмэрийн материал тус бүрийг харгалзан үзэж тусгах гэрлийн тохиромжтой люкс хүч гэрлийн дулааны кельвин, гэрлийн өнгийг хувиргах индексжүүлэх нь олон улсын стандартад мөрдөгддөг R1-ээс R15 гэсэн төрлөөс R10 буюу дугаар 10 төрлийн хувиргагч, үндсэн гэрлийн өнгөний индекс RA-г тохируулах нь чухал юм. Гэрэл сонголтын хувьд LED буюу диодын гэрэлтүүлгийг хэрэглэх нь дараах давуу талтай юм.

-Энгийн гэрэл шиг шаталт үүсэхгүй,

-тог цахилгаан бага зарцуулна,


-хэт ягаан туяа ялгаруулдаггүй учир дулаан хуримтлал үүсэхгүй, хорхой шавьж цуглахгүй,

-нүүрс төрөгч бага ялгаруулдаг ба энгийн лаан гэрэл буюу галоген гэрлийг бодвол илүү тод тусдаг хэдий ч халалтын хэмжээ бага гэх мэт давуу талтай юм


Диодын гэрэл байхгүй нөхцөлд галоген төрлийн гэрлийг ашиглахдаа дурсгалын гадаргууд нөлөөлөх халалтыг байнгын хянах нь зүйтэй юм. Давхар хүрээтэй гэрэл ашиглах нь гэрлийн дулааны хуримтлал үүсгэж олдворын гадаргууг халаах гол шалтгаан нь болдог учраас дан хүрээтэй, гэрлээс гарах халалтыг сарниулах загварын гэрэл хэрэглэх нь зохистой юм. Үзмэрийн гадаргуу дээр гэрэлтүүлэг тусгахдаа дээрх дурдсан гэрлийн дулаан, гэрэлтүүлгийн люкс хүчний стандартыг хэтрүүлбэл үзмэрийн материалын онцлогоос хамаарч үндсэн их биед халалт үүсч, гэрэлтүүлгээс хамааралтай орчны нөлөөллийн удаан хугацааны физик хөнөөлийн өгөршил явагдаж, муудах гол хүчин зүйл нь болох эрсдэлтэй.




Зураг 1: гэрлийн өнгийг хувиргах индексжүүлэлт



Зураг 2 : гэрлийн өнгийг шараар хувиргах нь гадаргууг жигд тодруулна.



Зураг 3 : гэрлийн өнгийг шараар хувиргах нь гадаргууг жигд тодруулна. Зураг 2 барзгар гадаргууд гэрлийг хэт босоо тусгаснаар гадаргуу цайрч, сүүдэр үүсэх сул талтай тул ташуу байдлаас тусгах нь зүйтэй. Харин гөлгөр гадаргууг босоо байдлаас гэрэлтүүлэх нь зүйтэй байдаг.



Зураг 4 : үзэгчдийн нүдэнд гэрлийн тусгал тусахгүй байх нь зүйтэй.




Зураг 5 : доороос гадаргууд жигд гэрэл тусгасан байдал.



Зураг 6 : дээрээс гадаргууд жигд гэрэл тусгасан байдал.





Чингис хааны музейн гэрэлтүүлэгт музейн гэрэлтүүлэг чиглэлд олон улсад туршлагатай Япон улсын Дайко ХХК -ний музейн гэрэлтүүлгийг сонгон авч харьцуулсан байдлаар үнийг дундчилан гаргасан болно.


Гэрэл 1 ш үнийн санал: 250 америк доллар https://www.denzaido.com/list/360140100400/

үндсэн енге цагаан	COB төрөл	кельвин +3000	Гэрлийн тархалтын енцөг (°): 30	100 вольт	Хяналтын линзтэй
гэрлийн хувиргалт(%): 1-100	12V галоген 85W төрлийн 60W	индекс 98	22VA	Жин (кг): 0.6	

Гэрэл суурилуулах замыг Япон улсын Панасоник ХХК -ний музейн гэрэлтүүлгийг сонгон авч харьцуулсан байдлаар үнийг дундчилан гаргасан болно.

Гүүдэг зам 1 м үнийн санал: 50000 төгрөг https://www.denzaido.com/page/5912/





ТАНКА ЗУРАГ БҮТЭЭХ, СЭРГЭЭН ЗАСВАРЛАХАД АШИГЛАЖ БУЙ ЭРДЭС БУДГИЙН X-RAY ЭЛЕМЕНТИЙН СУДАЛГАА

Abstract

In this study, we have identified the features of each mineral pigments ingredients which have been used to paint and restore thangka paintings, through Horiba XGT5200 X-Ray analytical microscope. So far, 151 pigments from 10 types which are extensively used to paint and restore thangka paintings, have been classified as their composition, and minerals in pigments and its distinctive features have been identified. As well, we have developed methodology based on the study whether pigments are resistant to environmental factors such as discoloring and damages, during restoration and preservation of thangka paintings.

Түлхүүр үг: Өнгө, найрлага, бүтэц, төрөл зүй, хадгалалт хамгаалалт

Оршил

Танка зураг буюу шүтээн зураг нь Монголын үндэсний соёлын үнэт өв төдийгүй, Монголын дүрслэх урлагийн бие даасан төрөл болон үүсч хөгжиж, уламжлагдан ирсэн байдаг. Энэхүү үнэт өвийн олон зуун дурсгал Монголын олон музейд хадгалагдаж, олны хүртээл болсоор байна.

Монгол зураг бол манай эх орны байгаль-нийгэм-түүхийн өвөрмөц онцлогоос нөхцөлдөн үүссэн, нүүдэлчин малчин хүний ертөнцийг үзэхүй, зан үйл, уран сайхны сэтгэлгээг илэрхийлсэн өвөрмөц шинж чанар бүхий урлаг, соёлын гайхамшигт өв, урлагийн бүтээл туурвил билээ. (Баяртөр, 2014: 18). Тиймээс энэ эрхэм нандин урлагийн томоохон нэг төрөл бол танка зураг буюу шүтээн зургийн урлал бөгөөд өөрийн гэсэн олон онцлогтой байдаг. Жишээлбэл Танка зураг Монголд хөгжихдөө нүүдэлчдийн өвөрмөц зан заншилтай уялдан зөөж тээвэрлэхэд хялбар, хуйлж ороох боломжтой байхаар бүтээгдсэн байдаг.

2012-2013 онд явагдсан улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогоор тоологдсон үзмэрээс зөвхөн танка зурагтай холбогдох төрөл зүйлийн ангилалд судалгаа хийв. Нийт музейн үзмэрийн тоо 228652 байгаагаас шашин шүтлэгийн төрөлд хамаарах үзмэрийн тоо 57209 ширхэг байгаа бөгөөд нийт үзмэрийн 25,02%-ийг эзэлж байна.

Мөн улс, аймгийн 34 музейд нийт 17593 ширхэг зураг хадгалагдаж байна. Үүний 9441 ширхэг нь уран зураг, 8152 ширхэг нь танка буюу бурхны зураг байна. (Энхтуяа, 2018; Х246). Үүнээс үзэхэд шашин шүтлэгийн төрөлд хамаарах үзмэрийн тоо 57209 ширхэг байгаатай харьцуулж үзэхэд танка зураг нь шашин шүтлэгийн холбогдолтой үзмэрийн 14.24%-ийг, нийт музейн үзмэрийн 3,72%-ийг эзэлж байна.

Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл /1995-2015/-ийн бүртгэлээс үзэхэд нийт 777 ширхэг хосгүй үнэт бүтээл байгаагаас шашин шүтлэгийн төрөлд хамаарах үзмэрийн тоо 274 ширхэг буюу нийт үзмэрийн 35,26%-ийг эзэлж байна. Эдгээр хосгүй үнэт үзмэрээс танка зургийн бүтээл 67 ширхэг байгаа нь шашин шүтлэгийн холбогдолтой үзмэрийн 23,35%-ийг, нийт хосгүй үнэт дурсгалын 8.62%-ийг эзэлж байна.

Танка зураг бол монголчуудын олон зуун жилийн түүх, өв соёл, зан заншил, ёс уламжлалыг өөртөө тээн хадгалж ирсэн хосгүй нандин өв бөгөөд энэ нь гал, ус зэрэг орчны олон эрсдэлд маш тэсвэргүй эмзэг, хэврэг материалаар бүтээгдсэн байдаг онцлогтой. Тиймээс бид эцэг өвгөдөөс уламжлан ирсэн энэхүү хосгүй нандин соёлын биет өвөө зөв зүйтэй хадгалж хамгаалан хойч үедээ өвлүүлж үлдээх нь маш чухал байна.

Судалгааны зорилго

Монголын музейн үзүүллэгийн танхим болон сан хөмрөгт хадгалагдаж буй танка зургийн бүтээл дэх гэмтлийн шалтгааныг тодруулах, аюул гэмтлээс урьдчилан сэргийлэх, хадгалж хамгаалахад тохиромжтой орчинг бүрдүүлэх болон гэмтэлтэй танка зургийг

сэргээн засварлах явцад материал, өнгө будгийн судалгаа хийж, орчин үед ашиглаж буй олон улс, олон үйлдвэрийн материал, будгаас зохимжтой, зохимжгүйг ялган таних, цаашид багажит дүн шинжилгээнд суурилсан шинжлэх ухааны суурь судалгааны арга зүйгээр судлах, судалгааны үр дүнд хүрээлэн буй орчны нөлөөлөлд учрах гэмтлийг бууруулах, танка зургийн онцлогт таарсан хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын аргазүйг боловсруулах анхан шатны судалгааг хийж, санал зөвлөмж гаргах зорилготой.

Судалгааны арга зүй

Судалгаанд мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг боловсруулахдаа “тоон шинжилгээ”, “ажиглалт, өгөгдөл”, “анализ хийх”, “харьцуулсан шинжилгээ”-ний арга болон “Horiba XGT5200 X-Ray analytical microscope” багаж ашиглан будгууд химийн ямар элементээс голчлон бүрдэж байгааг харуулав. Уг багаж нь ямарваа нэгэн материалын химийн найрлагыг тогтоохдоо (XRF) буюу Рентген флуоресцентийн шинжилгээний хэмжилтийг ашигладаг ба ионжуулагч цацрагч ашиглан дээжийн атомын электронуудыг сугалан гаргах, түүнээс үүссэн рентген флуоресцентийн (РФ) цацрагийг бүртгэх зарчимд үндэслэгдэнэ. Өдөөгдсөн атомаас цацаргаж байгаа Рентген флуоресцентийн цацрагийг хэмжин, түүний спектрийн шугамын энергиэр химийн ямар элемент болохыг тогтоож эрчмийг нь үнэлэн тоон хэмжээг тодорхойлдог аргазүйгээр хийсэн.

Өнөө үед танка зураг бүтээх, сэргээн засварлахад өргөнөөр ашиглаж буй эрдэс будаг

Монголчууд эрдэс будгийг уламжлалт аргаар гарган авахдаа үндсэн хоёр түүхий эд хэрэглэдэг байсан. Үүнд:

• Амьтан ургамлын гаралтай өөрөөр хэлбэл амьд бодисоос гаргаж авдаг будгийг “Шимийн будаг” гэж нэрлэдэг.

• Янз бүрийн шороо, шавар, чулуулаг зэргийг боловсруулан гаргаж авдаг будгийг эрдэс гаралтай буюу “Шороон будаг” гэж нэрлэдэг байжээ. (Адъяа нар., 2006: 247).

Монголд өнөө үед танка зураг бүтээх болон сэргээн засварлахад зураач, уран бүтээлч, сэргээн засварлагч нар янз бүрийн орны олон үйлдвэрийн будгийг хэрэглэж байна. Тэдгээр будгийг уран бүтээлчид гадаад орноос болон монголын зах зээл дээр худалдаалагдаж буй будгаас сонгон авч хэрэглэдэг. Гэхдээ эдгээр будгийн химийн найрлага болон хоорондын онцлог ялгааг төдийлөн сайн мэддэггүй. Судалгаанд ихэвчлэн монголд өргөнөөр хэрэглэдэг, зарагддаг будаг мөн гадаад орноос сэргээн засварлахад зориулж авч ирсэн гээд нийт 10 төрлийн 151 будгийн химийн найрлагыг тодорхойлж, бүтцээр нь ангилан будаг хоорондын түвшинг тогтоох оролдлого хийж, танка зургийн бүтээлийг зөв зохистой хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар судалгаанд үндэслэн боловсруулсан арга зүйн мэдлэг, мэдээллийг бий болгохоор судалж буй билээ. Энэ судалгаа нь цаашдаа үргэлжилсээр байх бөгөөд янз бүрийн орны үйлдвэрийн, олон төрлийн будгийг нэмж судалсаар байна. Энэ судалгаанд дараах будгийг хамруулав.

1. Ленинград 24ш - /невская палитра/ Орос
2. Сонет 24ш - /невская палитра/ Орос
3. Рембрант 24ш-/ Royal Talens/ Голланд
4. Гуашь 30ш - /Marie’s poster colour/ Хятад
5. Эрдэс будаг 12ш - /Tianya/ Хятад
6. Эрдэс будаг 7ш - /Terra naturale. Aromafarmacoteca d’Alene Via Cavour 260 Roma/ Итали
7. Эрдэс будаг 9ш - /Баян-Өлгий аймаг, Буянт сум/ Монгол
8. Эрдэс будаг 10ш - /100 айл худалдааны зах/ Хятад
9. Venezia 5ш - / Усан будаг/ Итали
10. Winsor newton 8ш - /Усан будаг/ Франц
1. Ленинград

Невская Палитра уран зургийн будгийн үйлдвэр нь 1934 онд байгуулагдаж өдгөө 86 жилийн турш мэргэжлийн уран бүтээлчид, урлаг сонирхогчдод зориулан өндөр чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж иржээ. Невская Палитра /ZHK/ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа л Оросын болон гадаадын уран зургийн мастеруудтай нягт хамтран ажиллаж, тэдний шинжээчдийн дүгнэлтийг сонсож, зах зээлийн чиг хандлага, технологийн шинэчлэлийг даган мөрдөж өөрсдийн лабораторийн шинэлэг тал, хөгжил дэвшил, цаг хугацаагаар туршиж боловсруулсан жороороо ОХУ-д мэргэжлийн урлагийн материал үйлдвэрлэх цорын ганц бүрэн хэмжээний аж ахуйн нэгж юм. (www.nevskayap-alitra.ru/about-the-company)

Мөн энэ лабораторид боловсруулсан олон төрлийн будгаар Эрмитаж, ОХУ-ын төрийн музей, улсын Третьяков галерейн цуглуулгаас эхлээд дэлхийн алдартай уран зургуудыг сэргээн засварлахад өргөнөөр ашигладаг байна.

Доор невская Палитра үйлдвэрийн “Ленинград” усан будгийг Horiba XGT5200 X-Ray analytical microscope багаж ашиглан энэ будгийн өнгүүд ямар химийн элементээс бүрдэж байгааг хүснэгт 1-т харуулав.

№	Өнгө	Өнгөний нэр	Химийн элемент-массын хувь
1	Шар өнгө	Cadium lemon 203	**Cd-71.87%, Zn-27.49%,** Si-0.63%
2		Cadium yellow medium 201	**Cd-60.99%, Ba-33.29%, S-4.92%,** Si-0.66%, Sr-0.15%
3		Yellow ochre 218	**Fe-85.51%, Si-5.77%, K-3.27%, Ca-1.78%, Ti-1.50%, S-1.32%,** Zr-0.49%, Cr-0.32%, Mn-0.03%
4		Raw sienna natur 405	**Fe-86.58%, As-9.66%, Ca-1.62%, Si-1.22%,** K-0.62%, Ti-1.50%, Mn-9%, Pb-0.01%
5		Golden 216	**Ti-40.56%, Cl-34.48%, Ca-7.53%, Fe-6.28%, Si-4.91%, K-3.95%, S-2.30%**
6		Cadium orange	**Ba-63.86%, Se-15.77%, S-14.21%, Si-3.76%, Sr-1.63%,** Ca-0.55%, Zn-0.21%
7	Улаан өнгө	Red ochre 309	**Fe-77.27%, Si-10.00%, Ti-3.89%, Ca-3.22%, Zr-1.76%, S-1.74%, K-1.70%,** Zn-0.28%, Cr-0.13%
8		Burnt sienna 406	**Fe-87.45%, Si-4.63%, Ni-2.01%, S-1.08%, Cr-1.07%,** Ti-0.90%, Zr-0.82%, Mn-0.80%, K-0.78%, Sr-0.32%, Zn-0.14%
9		English red 321	**Fe-72.10%, Ba-23.24%, Si-1.72%, S-1.69%,** Zn-0.56%, Ca-0.31%, K-0.27%, Sr-0.10%
10		Scarlet	**Ba-77.69%, Ce-9.56%, S-5.01%, Ca-2.66%, Si-2.38%, Pd-1.38%,** Fe-0.83%, Sr-0.51%
11		Madder lake red light 313	**Ba-89.12%, S-4.73%, Si-2.80%, K-1.34%, Ca-1.05%,** Fe-0.53%, Sr-0.44%
12		Carmine 319	**Ca-22.22%, Fe-21.72%, Si-20.84%, Ba-13.05%, K-12.83%, S-7.62%, Sr-1.73%,**
13	Хөх өнгө	Violet 607	**W-48.47%, Mo-46.29%, Ca-1.80%, Si-1.55%, K-1.15%,** Fe-0.66%, Ba-0.09%
14		Ultramarine 511	**S-36.42%, Ca-25.63%, Si-14.36%, K-14.22%, Fe-6.16%, Ti-2.24%,** Sr-0.96%
15		Cobalt blue 508	**Co-83.85%, Zn-13.32%,** Ca-1.06%, K-0.95%, Si-0.41%, Fe-0.40%, Mo-0.00%
16		Azure	**Ba-76.85%, Cu-11.30%, S-3.55%, Si-3.15%, Fe-1.33%, Ca-3.10%,** Pd-0.71%
17	Ногоон өнгө	Emerald green 713	**Ba-52.63%, Cl-24.71%, Cu-12.01%, S-3.58%, Si-3.43%, Ca-1.04%,** K-0.95%, Fe-0.88%, Br-0.51%, Sr-0.27%
18		Yellowish green 718	**Ba-42.01%, Cl-33.93%, Cu-12.20%, S-3.08%, Si-2.55%, K-2.18%, Ca-2.07%, Fe-1.40%,** Br-0.58%
19		Green 725	**Ba-58.72%, Fe-30.35%, S-3.96%, Si-3.79%, Ca-1.97%,** Pd-0.80%, Sr-0.41%
20		Umber 418	**Fe-86.35%, Si-4.40%, Mn-3.06%, K-2.08%, Ca-1.32%, S-1.00%,** Zr-0.84%, Ti-0.79%, Zn-0.15%,

21	Бор өнгө	Mars brown 412	**Fe-86.11%, Mn-9.81%, Al-1.11%, Si-1.06%,** K-0.83%, Ca-0.62%, S-0.45%,
22		Burnt umber	**Fe-87.99%, Mn-5.16%, Si-2.64%, Ca-1.92%, K-1.07%,** S-0.76%, Ti-0.45%
23		Sepia 413	**Fe-77.02%, Si-9.35%, Ti-4.24%, Ca-3.77%, K-2.67%, S-1.98%,** Zr-0.97%
24	Хар	Natural black 805	**Cu-79.00%, K-6.91%, Ca-6.25%, Si-3.97%, S-3.13%, Fe-**0.73%

Хүснэгт 1. Ленинград будгийн элементийн шинжилгээ

Шар өнгө: Дээрх хүснэгтэд 6 шар өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элементийг 3 төрөлд хувааж болохоор онцлогтой байна. Нэгдүгээрт Cd-Кадми, Zn-цайр, Ba-бари, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгүүд тод алтан шар өнгийг үүсгэж байна. Хоёрдугаарт Fe-төмөр, Si-цахиур, As-хүнцэл элементээс бүрдэж буй өнгө бор шарга өнгийг үүсгэж байна. Гуравдугаарт Ti-титан, Cl-хлор, Ba-бари, Se-Селени элементээс бүрдэж буй өнгө улбаршар өнгийг үүсгэсэн байна.

Улаан өнгө: Дээрх хүснэгтэд 6 улаан өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элементийг 3 төрөлд хувааж болохоор онцлогтой байна. Нэгдүгээрт Fe-төмөр, Si-цахиур элементээс бүрдэж буй өнгүүд борлог хүрэн улаан өнгийг үүсгэж байна. Хоёрдугаарт Ba-бари, Se-Селени, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгө тод ухаа улаан өнгийг үүсгэж байна. Гуравдугаарт Ca-кальци, Fe-төмөр, Si-цахиур элементээс бүрдэж буй өнгө ягаан өнгийг үүсгэж байна.

Хөх өнгө: Дээрх хүснэгтэд 4 хөх өнгө байна. Тэдгээр өнгүүд бүгд хоорондоо өөр элементээс бүрдсэн байна. Violet 607 өнгө нь W-Вольфрам, Mo-Молибден элементээс бүрдэж чернилэн ягаан өнгийг үүсгэсэн байна. Ultramarine 511 өнгө нь S-хүхэр, Ca-кальци, Si-цахиур, K-кали элементээс бүрдэж тэнгэрийн гүн цэнхэр өнгийг үүсгэсэн байна. Cobalt blue 508 өнгө нь Co-Кобальт, Zn-цайр элементээс бүрдэж тод хөх өнгийг үүсгэсэн байна. Azure өнгө нь Ba-бари, Cu-Зэс, S-хүхэр, Si-цахиур, Ca-кальци элемент бараан хөх өнгийг үүсгэсэн байна.

Ногоон өнгө: Дээрх хүснэгтэд 3 ногоон өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элемент нь Ba-бари, Cl-хлор, Fe-төмөр байна. Эдгээр элмент нь тухайн өнгөндөө их бага хувьтай орж тод, бараан ногоон өнгүүдийг үүсгэсэн байна.

Бор өнгө: Дээрх хүснэгтэд 4 бор өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элемент нь Fe-төмөр, Si-цахиур, Mn-манган байна. Эдгээр элементүүд тухайн өнгөндөө их бага хувьтай орж тод, бараан бор өнгүүдийг үүсгэсэн байна.

Хар өнгө: Дээрх хүснэгтэд 1 хар өнгө байна. Энэ Natural black 805 хар өнгө нь Cu-Зэс, K-кали, Ca-кальци элементээс голчлон бүрдсэн байна.

2. Сонет

Энэ будаг нь Невская Палитра будгийн үйлдвэрээс гаргасан усан будаг бөгөөд үүнийг гадна талаас нь харвал ленинград будагтай хэмжээ савлагаа нь яг адилхан байдаг. Зөвхөн ленинград, сонет гэсэн бичгээр л ялгагдаж харагдана. Гэхдээ худалдаанд энэ хоёр будгийн үнэ сонет 35000 төгрөг байхад ленинград 75000 төгрөгний үнэтэй зарагддаг. Тиймээс энэ хоёр будгийн найрлага, ялгааг мэдэхээр Horiba XGT5200 X-Ray analytical microscope ашиглан химийн ямар элментээс бүрдэж байгааг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Сонет будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Цагаан	Zinc white 100	**Zn-98.61%,** Si-0.89%, S-0.51%
2	Шар өнгө	Hanza lemon 227	**Ca-87.22%, Cl-9.32%, Si-1.90%,** S-0.95%, Fe-0.61%
3		Yellow medium 220	**Ca-95.55%, Si-2.30%, S-1.29%,** Fe-0.48%, K-0.39%
4		Yellow deep 221	**Ca-94.07%, Si-3.03%, Fe-1.57%, S-1.32%**
5		Gold ochre 205	**Fe-50.60%, Ca-40.03%, Si-4.77%, Ti-1.69%, K-1.26%, S-1.25%,** Zr-0.41%
6		Orange 315	**Ca-94.06%, Si-2.87%, S-1.43%, Ti-1.24%,** Fe-0.40%
7	Улаан өнгө	Red light 336	**Ca-94.97%, Si-2.64%, S-1.51%,** Fe-0.87%
8		Carmine 319	**Ca-95.13%, Si-2.75%, S-1.37%,** Fe-0.75%
9		Madder lake red 317	**Ca-91.79%, Ba-3.66%, Si-2.02%, S-1.85%,** Fe-0.68%
10		English red 300	**Fe-70.71%, Ca-27.27%,** Si-0.76%, Zn-0.71%, S-0.55%
11	Хөх өнгө	Azure 513	**Ca-56.11%, Cu-40.88%, Si-1.70%, S-1.15%,** Fe-0.16%
12		Ultramarine light 501	**Ca-84.84%, S-7.79%, Si-5.14%, Fe-1.41%,** Ti-0.82%
13		Blue 515	**Ca-66.92%, Cu-30.16%, Si-1.90%, S-1.02%**
14		Violet light 605	**W-63.04%, Ca-21.78%, Mo-14.04%,** Pd-0.82%, Fr-0.25%
15		Violet deep 606	**Mo-39.58%, W-34.96%, Ca-24.54%,** Si-0.81%, Fe-0.12%
16	Ногоон өнгө	Bluish green 514	**Ca-67.15%, Cu-28.96%, Si-2.34%, S-1.55%**
17		Emerald green 720	**Cl-41.96%, Ca-32.47%, Cu-21.19%, Ba-1.89%, Si-1.68%,** S-0.82%
18		Sap green 716	**Ca-56.75%, Cl-28.57%, Cu-8.64%, Si-3.12%, S-1.43%,** Fe-0.97%, Ti-0.53%
19		Green deep 710	**Ca-71.43%, Fe-25.48%, Si-1.78%, S-1.13%,** K-0.17%
20	Бор өнгө	Raw sienna 405	**Fe-90.03%, Si-4.06%, Mn-1.22%, S-1.19%, K-1.00%,** Ti-0.85%
21		Burnt sienna 406	**Fe-85.76%, Si-6.69%, Ni-1.96%, Tm-1.13%, Cr-1.23%, Ti-1.08%,** S-0.99%, Mn-0.92%, K-0.25%
22		Burnt umber 408	**Fe-88.55%, Mn-4.99%, Si-3.19%, Ti-1.29%, Ca-1.28%,** K-0.70%, Mo-0.00%
23		Sepia 413	**Fe-49.72%, Ca-40.76%, Si-4.18%, Ti-3.52%, S-1.45%,** K-0.37%
24	Хар	Lamp black 801	**Cu-49.69%, Ba-26.09%, Ca-13.32%, S-3.71%, Si-3.60%, Pd-2.66%,** Fe-0.92%

Дээрх хүснэгтэд байгаа 24 төрлийн өнгийг бүрдүүлж буй химийн элеменэд анализ хийхэд шар, улаан, хөх, ногоон, бор, хар гээд нийт 20 өнгөнд Ca-кальци элмент 13%- 95%-ийг эзлэн бүрдүүлж үлдсэн хувийг Si-цахиур, S-хүхэр, Fe-төмөр, Cl-хлор, Ba-бари, Mo-Молибден, W-Вольфрам гэх мэт элементүүд эзэлж байна. Zinc white100 өнгө нь Zn-цайр 98%тай бүрдсэн байна. Raw sienna 405, Burnt sienna 406, Burnt umber 408 эдгээр бор өнгүүд голчлон Fe-төмөр, S-хүхэр, Si-цахиур, Mn-манган элементээс бүрдэж байна.

3. Рембрант

1899 оны эхээр банкны эзэн Мартин Таленс будаг, лак, бэх үйлдвэрлэдэг компанийг Голланд улсад байгуулжээ. Энэ компани нь анх зөвхөн бэх, бичгийн хэрэгслэлүүдийг үйлдвэрлэдэг байсан бол 1899 оны сүүлээр Рембрандтын тосон будгийг үйлдвэрлэж эхэлсэн. 1904 онд хүү Хилдебрэнд Таленс компаны нэрийг Talens-Zoon хэмээн нэрлэжээ. АНУ, ОХУ-руу экспортлох үйл ажиллагаа нь 1905 онд эхэлсэн бөгөөд 1912 он гэхэд АНУ-д тус компаний нэрийн борлуулалтын алба нээгдэв. 1949 онд Talens-Zoon компани нь Royal хэмээх нэрийг авч “Royal Talens” болгон өөрчилжээ. Одоо уг компани олон шинэ брэнд бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж нэр хүнд асар их өсөж дэлхийн олон оронд салбарууд нь байгуулагдсан. Алдартай брэнд бүтээгдэхүүнүүдээс нь дурьдвал Рембрандт, Ван Гог, Амстердам, Сакура, Таленс гэх мэт “Royal Talens”-ийн логотой бүх төрлийн бичиг хэрэг, уран зургийн будаг, хэрэгслүүд багтана. (www.royaltalens.com/en/about-royal-talens/our-story)

Доор “Royal Talens” үйлдвэрийн Рембрандт 24 өнгийн усан будагт Horiba XGT5200 X-Ray analytical microscope ашиглан энэ будгийн өнгүүд ямар химийн элементээс бүрдэж байгааг хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Рембрант будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	Cadmium orange 211	**Cd-48.47%, Ba-39.67%, Zn-3.82%, S-3.69%, Se-2.68%, Si-1.67%**
2		Cadmium lemon 207	**Cd-51.94%, Ba-20.56%, Zn-19.80%, S-5.62%, Si-1.28%,** Sr-0.51%
3		Cadmium yellow light 208	**Ba-66.15%, Si-13.87%, Zn-9.43%, Si-9.00%, Sr-1.54%**
4		Gamboge238	**Ca-74.86%, S-15.89%, Fe-3.79%, Si-2.75%, Sr-2.71%**
5		Raw sienna 234	**Fe-88.83%, Ti-4.69%, Si-2.94%, Ca-1.92%,** K-0.71%, S-0.59%, Mn-0.21%, Cr-0.10%
6		Yellow ochre 227	**Fe-86.23%, Ca-8.99%, S-3.19%,** Si-0.78%, K-0.41%, Sr-0.30%, Zn-0.10%
7	Улаан өнгө	Cadmium red light 303	**Cd-68.84%, Ba-14.46%, Se-11.55%, S-3.58%, Si-1.23%,** Sr-0.23%, Fe-0.11%
8		Cadmium red 305	**Ba-34.26%, Si-25.58%, S-21.29%, Se-18.86%,** Nd-0.01%
9		Madder lake deep 331	**Ca-77.11%, S-11.28%, Sr-3.77%, Si-3.40%, Fe-2.76%, K-1.67%**
10		Light oxide red 339	**Fe-59.35%, Ca-29.27%, S-8.30%, Si-1.63%,** Sr-0.95%, K-0.50%
11	Хөх өнгө	Cerulean blue 534	**Sn-73.15%, Ca-13.17%, Co-11.86%, S-0.71%,** Cr-0.67%, Zn-0.26%, Fe-0.18%
12		Rembrandt blue 520	**Ca-53.55%, Cu-26.67%, S-13.00%, Sr-1.79%, Si-1.79%, K-1.01%,** Br-0.78%, Fe-0.58%, Ba-0.44%, Ce-0.40%
13		Combalt blue 511	**Co-94.70%, Si-1.66%, Al-1.28%,** K-0.72%, S-0.54%, Pm-0.31%, Cr-0.27%, Zn-0.26%, Fe-0.18%, Ti-0.08%
14		Ultramarine deep 506	**S-44.50%, K-21.83%, Ca-17.77%, Fe-11.63%, Ti-2.12%, Rb-1.33%,** Zr-0.83%
15	Ногоон өнгө	Rembrandt green 634	**Ca-60.10%, S-14.19%, Cu-13.16%, Sr-3.64%, Si-2.08%, Br-1.95%, Fe-1.77%, Pd-1.61%,** Ba-0.82%, Ce-0.68%
16		Sap green 623	**Ca-38.60%, Ni-27.56%, S-11.43%, Fe-10.71%, Ba-4.94%, Sr-2.60%, Si-2.09%, Pd-1.11%,** Cu-0.97%
17		Viridian 616	**Cr-73.76%, Br-13.88%, Pm-6.82%, S-1.85%, Si-1.33%, K-1.10%,** Cu-0.60%, Sr-0.50%, Fe-0.17%

7			1.10%, Cu-0.60%, Sr-0.50%, Fe-0.17%
18	Бор өнгө	Burnt sienna 411	**Fe-83.70%, Ca-11.38%, Si-2.64%, Ti-1.45%,** Sr-0.57%, Mn-0.26%, Mo-0.00%
19		Burnt umber 409	**Fe-77.23%, Ca-10.08%, Mn-6.09%, S-2.47%, Si-2.31%,** Sr-0.78%, As-0.64%, Ti-0.41%
20		Raw umber 408	**Fe-63.89%, Ca-23.40%, S-7.14%, Si-2.62%, Sr-1.47%, Cr-1.10%,** K-0.36%, Pm-0.01%
21		Sepia (modern) 416	**Ca-44.82%, Fe-37.10%, S-13.42%, Ti-1.93%, Si-1.63%,** Sr-0.98%, Mn-0.11%
22	Цагаан	Chinese white 108	**Zn-88.76%, Ca-6.64%, S-2.42%, Si-1.76%,** La-0.42%
23	Саарал	Payne's gray 708	**Ca-77.15%, S-13.15%, Cu-3.91%, Sr-1.86%, Si-1.29%, K-1.03%,** Cr-0.99%, Fe-0.62%
24	Хар	Ivory black 701	**Ca-71.08%, Fe-19.87%, Mn-3.19%, K-2.37%, Si-2.11%, S-1.39%**

Шар өнгө: Дээрх хүснэгтэд 6 шар өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элементийг 3 төрөлд хувааж болохоор онцлогтой байна. Нэгдүгээрт Cd-Кадми, Ba-бари, Zn-цайр, S-хүхэр, Se-Селени элементээс бүрдэж буй өнгө улбаршар өнгийг үүсгэж байна. Хоёрдугаарт Cd-Кадми, Ba-бари, Zn-цайр, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгө тод алтан шар өнгийг үүсгэж байна. Гуравдугаарт Fe-төмөр, Ca-кальци, Si-цахиур Ti-титан, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгө борлог шар өнгийг үүсгэж байна.

Улаан өнгө: Дээрх хүснэгтэд 4 улаан өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элементийг 3 төрөлд хувааж болохоор онцлогтой байна. Нэгдүгээрт Кадми, Ba-бари, Se-Селени, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгө тод ухаа улаан өнгийг үүсгэж байна. Хоёрдугаарт, Ca-кальци, S-хүхэр, Sr-Стронци, Si-цахиур, Fe-төмөр элементээс бүрдэж буй өнгө ягаан улаан өнгийг үүсгэж байна. Гуравдугаарт Fe-төмөр, Ca-кальци, S-хүхэр, Si-цахиур, Sr-Стронци элементээс бүрдэж буй өнгө хүрэн улаан өнгийг үүсгэж байна.

Хөх өнгө: Дээрх хүснэгтэд 4 хөх өнгө байна. Тэдгээр өнгүүд бүгд хоорондоо өөр элементээс бүрдсэн байна. Cerulean blue 534 өнгө нь Sn-Цагаантугалга, Ca-кальци, Co-Кобальт элементээс бүрдэж тод хөх өнгийг үүсгэсэн байна. Rembrandt blue өнгө нь Ca-кальци, Cu-Зэс, S-хүхэр элементээс бүрдэж бараан хөх өнгийг үүсгэсэн байна. Cobalt blue 511 өнгө нь Co-Кобальт, S-хүхэр, Al-Хөнгөнцагаан элементээс бүрдэж тэнгэрийн хөх өнгийг үүсгэсэн байна. Ultramarine 506 өнгүүд S-хүхэр, K-кали, Ca-кальци, Fe-төмөр, Ti-титан элементээс бүрдэж гүн цэнхэр өнгийг үүсгэж байна.

Ногоон өнгө: Дээрх хүснэгтэд 3 ногоон өнгө байна. Тэдгээр өнгүүд бүгд хоорондоо өөр элементээс бүрдсэн байна. Rembrandt green 634 өнгө нь Ca-кальци, S-хүхэр, Cu-Зэс, Sr-Стронци, Si-цахиур, Br-Бром элементээс бүрдэж тод ногоон өнгийг үүсгэсэн байна. Sap green 623 өнгө нь Ca-кальци, Ni-никель, S-хүхэр, Fe-төмөр, Ba-бари элементээс бүрдэж газрын ногоон өнгийг үүсгэсэн байна. Viridian 616 өнгө нь Cr-Хром, Br-Бром, Pm-Промети элементээс бүрдэж бараан ногоон өнгийг үүсгэсэн байна.

Бор өнгө: Дээрх хүснэгтэд 4 бор өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элемент нь Fe-төмөр, Ca-кальци, S-хүхэр, Mn-манган байна. Эдгээр элемент тухайн өнгөндөө их бага хувьтай орж тод, бараан бор өнгийг үүсгэсэн байна.

Цагаан өнгө: Дээрх хүснэгтэд 1 цагаан өнгө байна. Энэ Chinese white 108 өнгө нь Zn-Цайр, Ca-кальци, S-хүхэр элементээс бүрдсэн байна.

Саарал өнгө: Дээрх хүснэгтэд 1 саарал өнгө байна. Энэ Payne's gray 708 өнгө нь Ca-кальци, S-хүхэр, Cu-Зэс элементээс бүрдсэн байна.

Хар өнгө: Дээрх хүснэгтэд 1 хар өнгө байна. Энэ Ivory black 701 хар өнгө нь Ca-кальци, Fe-төмөр, Mn-манган, K-кали, S-хүхэр элементээс бүрдсэн байна.

4. Гуашь

/Marie's Poster colour/

Мэриес будагны үйлдвэр анх 1919 онд байгуулагдсан ба 1958 онд "Шанхайн уран зургийн хэрэгслийн үйлдвэр" нэртэй болжээ. Одоо энэ үйлдвэрийн бүтээгдхүүн чанарын хяналтын ISO9001:2000 стандартын гэрчилгээтэй дэлхийн нийт 60 гаруй оронд худалдаалагдаж байна. Мөн америк болон европын орнуудад алдартай брэндийн зургийн хэрэгсэлд хятадын мэриес будагны үйлдвэрийн бүтээгдэхүүн албан ёсоор багтдаг байна. (www.chinamaries.com/En/about/Default_144396663052566528.aspx)

Монголын зураач, уран бүтээлчид ч мөн олон төрлөөр үйлдвэрлэгдэх мэриес будгийг уран бүтээл болон бусад зүйлд өргөнөөр хэрэглэдэг. Эдгээр олон төрлийн будагнаас доорх хүснэгтэд мэриес үйлдвэрийн "POSTER COLOUR" буюу гуашь будгийн найрлагыг Horiba XGT5200 X-Ray analytical microscope ашиглан энэ будгийн өнгүүд ямар элементээс голчлон бүрдэж байгааг хүснэгт 4-т харуулав. Энэ будаг нь 70 төрлийн өнгөөр үйлдвэрлэгддэг бөгөөд доор уран бүтээлчдийн өргөнөөр хэрэглэдэг 30 төрлийн өнгийг харуулав.

Хүснэгт 4. Гуаш /Marie's Poster colour/ будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	Yellow Ochre 676	**Fe-42.77%, Ba-39.13%, S-10.41%, Al-3.58%, Si-3.27%,** Sr-0.84%
2		Orange Yellow 301	**Ba-75.43%, S-11.74%, Zn-7.66%, Si-4.05%,** Sr-0.62%, Fe-0.50%
3		Yellow Mid 227	**Ba-54.84%, S-20.56%, Zn-16.77%, Si-7.32%,** Ca-0.52%
4		Lemon Yellow 215	**Ba-49.10%, S-21.34%, Si-8.95%, Al-7.38%, Cl-7.01%,** Ca-5.50%, Sr-0.40%, Fe-0.32%
5		Yellow Pale 216	**Ba-49.04%, S-25.72%, Zn-15.76%, Si-8.95%,** Fe-0.52%
6	Улаан өнгө	Vermilion 324	**Ba-76.17%, S-13.37%, Si-5.50%, Al-3.64%, Fe-1.32%**
7		Light Red 12	**Fe-97.42%, S-1.02%,** Zn-0.63%, Ti-0.41%, Si-0.39%, Ca-0.13%
8		Carmine 2	**Ba-86.95%, S-7.09%, Si-2.72%, Sr-2.60%,** Fe-0.43%, Ca-0.21%, Ag-0.01%
9		Crimson Red 315	**Si-40.98%, S-27.95%, Al-19.70%, Fe-5.62%, Ca-3.15%, Ba-2.60%**
10		Orange Red 313	**Ba-60.47%, S-20.88%, Si-9.74%, Al-6.80%,** Fe-0.92%, Ca-0.67%, Sr-0.53%
11		Scarlet 302	**Ba-66.03%, S-15.38%, Si-6.86%, Al-5.78%, Ca-5.03%,** Sr-0.35%, Fe-0.32%, Pd-0.24%
12		Mauve 402	**Ba-68.92%, Al-11.74%, W-8.57%, Zn-8.57%,** Fe-0.95%, Mo-0.95%, Ca-0.12%, Yb-0.07%
13	Хөх өнгө	Peacock Blue 448	**Ba-93.28%, S-3.82%, Cu-1.34%,** Sr-0.97%, Fe-0.36%, Ca-0.24%
14		Prussian Blue 445	Ba-50.38%, Fe-41.29%, Zn-4.49%, S-2.28%, Sr-1.56%
15		Ultramarine Blue 443	**Ba-56.01%, Si-22.76%, Fe-5.86%, S-5.77%, Pd-4.44%, Ca-3.79%, Zn-1.37%**
16		Cobalt Blue 453	**Ba-74.89%, S-9.17%, Si-8.97%, Al-5.15%, Ca-1.12%,** Fe-0.48%, Sr-0.21%,
17		Cobalt Blue 38	**S-31.51%, Ba-28.456%, S-25.66%, Al-10.68%, Ca-1.32%, Fe-1.27%,** Sr-0.69%, Cu-0.27%, Zn-0.13%
18		Cerulean Blue 455	**Ba-50.64%, S-19.83%, Si-18.72%, Al-7.70%, Cu-1.01%,** Fe-0.52%, Sr-0.50%, Ca-0.45%, Zn-0.33%, K-0.31%,
19		Violet 430	**Ba-59.81%, Zn-14.76%, W-11.34%, Si-9.42%, Fe-1.96%, Mo-1.40%,** Ca-0.47%, Sr-0.44%, K-0.40%, Yb-0.01%
20		Green Mid 505	**Ba-76.50%, Zn-10.54%, S-8.08%, Si-2.42%, Fe-1.82%,** Nd-0.63%

21	Ногоон өнгө	Olive Green 69	**Fe-33.74%, Zn-25.14%, S-23.00%, Ba-6.23%, Si-4.16%, Ca-3.24%, Pd-2.03%, Cu-1.43% Sr-1.02%**
22		Olive Green 569	**Ba-46.86%, Fe-18.72%, S-15.12%, Zn-11.56%, Si-6.49%,** Cu-0.53%, Ca-0.39%, Sr-0.34%
23		Green Pale 503	**Ba-47.38%, S-25.21%, Si-10.50%, Al-7.28%, Zn-6.78%, Fe-1.34%,** Sr-0.97%, Cu-0.32%, Pd-0.21%
24		Blackish Green 572	**Ba-58.16%, S-22.41%, Zn-10.32%, Si-3.27%, Al-2.44%, Cu-1.53%, Ca-1.18%,** Sr-0.47%, Fe-0.24%
25	Бор өнгө	Umber Deep 689	**Fe-63.49%, Si-13.68%, Al-12.49%, S-8.78%,** Zn-0.79%, Ca-0.52%, Mn-0.23%, Ba-0.02%
26		Burnt Umber 687	**Fe-79.21%, Si-7.18%, Al-7.05%, S-5.48%,** Ti-0.37%, Mn-0.36%, Cr-0.04%
27	Цагаан	White 102	**Ti-45.56%, Zn-24.22%, S-24.05%, Si-5.89%,** I-0.28%
28	Саарал	Yellowish Gray 781	**Ba-67.09%, Fe-30.66%, S-1.51%,** Sr-0.74%
29		Gray 798	**S-46.54%, Zn-14.68%, Fe-13.89%, Si-10.89%, Ca-7.27%, Ba-6.42%,** Sr-0.30%
30	Хар	Lamp Black 794	**Si-39.52%, Fe-28.45%, S-19.00%, Al-12.16%,** Ca-0.62%, Zn-0.25%, Ba-0.01%

Дээрх хүснэгтэд байгаа 30 төрлийн өнгийг бүрдүүлж буй элементэд анализ хийхэд улаан, шар, ногоон, хөх, ягаан гэх мэт 23 өнгөнд Ba-бари элемент 47%- 93%-ийг эзлэн бүтээж байна. 12 Light red, 315 Crimson red, 689 Umber deep, 687 Burnt umber, 794 Lamp black эдгээр өнгүүд голчлон Fe-төмөр, S-хүхэр, Si-цахиур, Al-хөнгөн цагаан элементээс бүрдэж байна. Мөн 102 White өнгө Ti-титан, Zn-цайр, S-хүхэр элементээс бүрдсэн байна.

5. Эрдэс будаг

Хүснэгт 5. Tianya /Хятад улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	C135	**Ca-85.72%, Fe-9.21%, Si-5.07%**
2		C55	**Pb-87.93%, Cr-8.30%, Si-3.49%,** Pm-0.28%
3	Улаан өнгө	C26	**Ca-78.76%, Si-13.43%, Zn-3.91%, Ti-2.15%, S-1.75%**
4		C23	**Ca-91.82%, Si-5.10%, S-2.60%,** Fe-0.48%
5	Хөх өнгө	C89	**Ca-51.34%, Cu-40.73%, Si-7.51%,** Fe-0.42%
6		C39	**Ca-75.26%, Si-14.49%, Cu-4.29%, S-4.21%, Fe-1.75%,**
7		C82	**Si-56.31%, Fe-32.45%, Ca-11.25%**
8	Ногоон өнгө	C143	**Pb-53.13%, Ca-25.60%, Fe-8.34%, Cr-5.16%, Si-4.97%, Cu-2.45%,** Pm-0.35%
9		C58	**Ca-85.97%, Si-7.61%, Ba-5.88%,** S-0.53%
10	Бор өнгө	C17	**Fe-75.18%, Ca-16.78%, Si-7.95%,** Ba-0.10%, U-0.00%
11		C88	**Ca-71.84%, Fe-20.12%, Si-5.96%, S-1.78%,** Mn-0.30%
12	Хар	C7	**Fe-84.10%, Ca-11.36%, Si-4.54%**

Дээрх хүснэгтэд байгаа 12 төрлийн өнгийг бүрдүүлж буй химийн элементэд анализ хийхэд шар, улаан, хөх, ногоон, бор, хар нийт 11 өнгөнд Ca-кальци элемент 11%- 91%-ийг эзлэн бүрдүүлж үлдсэн хувийг Si-цахиур, S-хүхэр, Fe-төмөр, Cu-Зэс, Zn-Цайр, Ti-титан, Ba-бари гэх мэт элемент эзэлж байна. Мөн C55 өнгө нь Pb-Хартугалга, Cr-Хром, Si-цахиур элементээс бүрдэж алтан шар өнгийг үүсгэж байна.

6. Эрдэс будаг

Хүснэгт 6. Terra naturale. Aromafarmacoteca d'Alene Via Cavour 260 Roma /Итали улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	Terra di siena naturale	**Ca-54.62%, S-24.06%, Fe-18.96%, Sr-1.21%, Si-1.15%,**
2		Terra di siena bruciata	**Fe-40.31%, Ca-38.50%, S-18.25%, Si-1.67%,** Sr-0.91%, K-0.19%, Mn-0.16%
3	Улаан өнгө	Terra d'ombra bruciata	**Fe-61.54%, Ca-24.37%, S-12.29%,** Si-0.97%, Mn-0.41%, Sr-0.38%, Zn-0.04%
4	Хөх өнгө	Blu oltkemare	**S-51.57%, Si-34.26%, Al-5.65%, Fe-3.54%, Ti-3.20%, Ca-1.54%,** Zr-0.24%
5	Ногоон өнгө	Terra verde scura	**Ca-66.19%, S-24.88%, Fe-5.50%, Si-2.53%,** Sr-0.90%
6		Viridian	**Ba-81.03%, S-9.28%, Ca-5.05%, Si-2.47%, Sr-1.69%,** Cu-0.47%
7	Бор өнгө	Terra d'ombra naturale	**Ca-44.46%, Fe-32.77%, S-21.08%, Si-1.02%,** Sr-0.57%, Mn-0.10%

Шар өнгө: Дээрх хүснэгтэд 2 шар өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй элемент Fe-төмөр, Ca-кальци, S-хүхэр, Si-цахиур, Sr-Стронци байна. Эдгээр элемент тухайн өнгөндөө их бага хувьтай орж тод, бараан шар өнгүүдийг үүсгэсэн байна.

Улаан өнгө: Дээрх хүснэгтэд 1 улаан өнгө байна. Энэ өнгө нь Fe-төмөр, Ca-кальци, S-хүхэр, Si-цахиур элементээс бүрдсэн байна.

Хөх өнгө: Дээрх хүснэгтэд 1 хөх өнгө байна. Энэ өнгө нь S-хүхэр, Si-цахиур, Al-Хөнгөнцагаан, Fe-төмөр, Ti-Титан, Ca-кальци элементээс бүрдсэн байна.

Ногоон өнгө: Дээрх хүснэгтэд 2 ногоон өнгө байна. Тэдгээр өнгүүд бүгд хоорондоо өөр элементээс бүрдсэн байна. Terra verde scura өнгө нь Ca-кальци, S-хүхэр, Fe-төмөр, Si-цахиур, Sr-Стронци элементээс бүрдэж бараан ногоон өнгийг үүсгэсэн байна. Viridian өнгө нь Ba-бари, S-хүхэр, Ca-кальци, Si-цахиур, Sr-Стронци элементээс бүрдэж тод ногоон өнгийг үүсгэсэн байна.

Бор өнгө: Дээрх хүснэгтэд 1 бор өнгө байна. Энэ өнгө нь Ca-кальци, Fe-төмөр, S-хүхэр, Si-цахиур элементээс бүрдсэн байна.

7. Эрдэс будаг

/Баян-Өлгий аймаг, Буянт сум/ Монгол улсад үйлдвэрлэсэн.

Эдгээр будгийг Баян-Өлгий аймгийн Буянт суманд байрлах социализмын үед ажиллаж байсан будгийн үйлдвэрийн тууринд үлдсэн будгаас дээжилж авав.

Хүснэгт 7. Баян-Өлгий аймаг, Буянт сум /Монгол улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Элемент-массын хувь
1	Улаан өнгө	**Ba-45.46%, S-20.39%, Si-15.02%, Ca-7.96%, Fe-5.51%, As-2.51%, Zn-1.80%, Sr-1.35%**
2	Цагаан өнгө	**Ba-47.51%, Zn-36.81%, S-12.26%, Si-1.76%, Sr-1.36%,** Ca-0,25%, Pd-0.06%
3	Хөх өнгө	**Ba-76.29%, S-16.39%, Si-2.12%, Cu-2.10%, Sr-1.19%,** Ca-0.96%, Al-0.71%, Fe-0.24%
4	Шар өнгө	**Pd-82.32%, Cr-13.86%, Pm-3.55%,** Ba-0.27%, Sr-0.00%
5	Хар бор өнгө	**Fe-68.68%, Si-19.61%, Al-5.18%, K-3.39%, Ca-1.30%,** Ti-0.70%, Sr-0.32%, Mn-0.25%, Zn-0.20%, As-0.18%, Ni-0.14%, Cr-0.05%
6	Цайвар хөх өнгө	**Ca-88.76%, Si-5.40%, Al-1.79%, Fe-1.21%,** S-0.76%, Ti-0.69%, Cu-0.69%, K-0.38%, Sr-0.31%,
7	Цайвар шарга өнгө	**Si-40.51%, Fe-30.45%, Ca-11.53%, Al-6.43%, K-5.86%, Ti-4.03%,** S-0.92%, Zr-0.28%
8	Улбар шар өнгө	**Fe-71.35%, Si-15.98%, K-5.15%, Al-2.68%, Ti-2.35%, Ca-1.85%,** S-0.36%, Mn-0.28%
9	Бор өнгө	**Fe-41.90%, Si-41.50%, K-7.00%, Ca-5.31%, Ti-4.10%,** Rb-0.19%

Улаан өнгө: Дээрх хүснэгтэд 1 улаан өнгө байна. Энэ өнгө нь Ba-Бари, S-хүхэр, Si-цахиур, Ca-кальци, Fe-төмөр, As-хүнцэл, Zn-цайр, Sr-стронци элементээс бүрдсэн байна.

Цагаан өнгө: Дээрх хүснэгтэд 1 цагаан өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй элемент Ba-Бари, Zn-цайр, S-хүхэр, Si-цахиур, Sr-Стронци байна.

Хөх өнгө: Дээрх хүснэгтэд 1 хөх өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Ba-Бари, S-хүхэр, Si-цахиур, Cu-Зэс, Sr-стронци байна.

Шар өнгө: Дээрх хүснэгтэд 1 шар өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Pd- хар тугалга, Cr-хром, Pm-промети байна.

Хар бор өнгө: Дээрх хүснэгтэд 1 хар бор өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Fe-төмөр, Si-цахиур, Al-Хөнгөнцагаан, K-Кали, Ca-Кальци байна.

Цайвар хөх өнгө: Дээрх хүснэгтэд 1 цайвар хөх өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй элемент Ca-Кальци, Si-цахиур, Al-хөнгөнцагаан, Fe-төмөр байна.

Цайвар шарга өнгө: Дээрх хүснэгтэд 1 цайвар шарга өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй элемент Si-Цахиур, Fe-Төмөр, Ca-Кальци, Al-хөнгөнцагаан, K-Кали, Ti-Титан байна.

Улбар шар өнгө: Дээрх хүснэгтэд 1 улбар шар өнгө байна. Түүнийг голчлон бүрдүүлж буй элемент Fe-төмөр, Si-Цахиур, K-Кали, Al-Хөнгөнцагаан, Ti-Титан, Ca-Кальци байна.

Бор өнгө: Дээрх хүснэгтэд 1 бор өнгө байна. Энэ өнгө нь Fe-төмөр, Si-Цахиур, K-Кали, Ca-Кальци, Ti-Титан элементээс бүрдсэн байна.

8. Эрдэс будаг

/Хятад улсад үйлдвэрлэсэн/

Эдгээр будгийг 100 айл худалдааны захаас авсан бөгөөд хүмүүс оохор хэмээн нэрлэдэг эрдэс будаг юм.

Хүснэгт 8. Оохор /Хятад улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	4500	**Ca-92.83%, Si-2.77%, Fe-2.16%,** Eu-0.79%, S-0.65%, As-0.29%, Ti-0.28%, K-0.23%
2		2500	**Fe-58.77%, Ca-38.12%, Si-2.44%,** K-0.67%
3	Улбар шар өнгө	4500	**Ca-84.73%, Pb-4.62%, Fe-4.11%, Si-3.50%, K-2.12%,** Cr-0.92%
4	Улаан өнгө	4500	**Ca-94.77%, Si-2.54%, Fe-1.69%,** Sr-0.41%, K-0.31%, S-0.28%
5		2500	**Fe-66.34%, Ca-27.78%, Si-3.65%, K-1.48%,** Mn-0.75%
6	Хөх өнгө	2500	**Ca-88.71%, Pb-4.52%, Si-2.96%, Fe-2.41%, Cu-1.22%,** Ti-0.18%
7	Ногоон өнгө	4500	**Ca-78.72%, Fe-6.75%, Pb-5.93%, Cl K 3.52, Si-2.03%,** Cr-0.83%, Pm-0.80%
8		2500	**Ca-54.78%, Fe-40.25%, Si-2.89%,** Cu-0.94%, Ti-0.47%, K-0.40%, S-0.27%
9	Хар өнгө	2500	**Fe-96.69%, Al-1.15%,** Si-0.98%, Mn-0.87%, Zn-0.15%, I-0.02%, Cs-0.00%

Дээрх хүснэгтэд байгаа 9 төрлийн өнгийг бүрдүүлж буй химийн элементэд анализ хийхэд шар 4500, улбар шар 4500, улаан 4500, хөх 2500, ногоон 2500, 4500 өнгүүд Ca-кальци элемент голчлон 54%- 94%-ийг эзлэн бүрдүүлж үлдсэн хувийг Fe-төмөр, Si-цахиур, S-хүхэр, Cu-Зэс, Pb-Хартугалга, Zn-Цайр, Ti-титан, Cr-Хром гэх мэт элемент эзэлж байна. Мөн шар өнгө 2500, улаан өнгө 2500, хар өнгө 2500 өнгүүдэд Fe-Төмөр элемент 58%-96%-ийг эзлэн бүрдүүлж үлдсэн хувийг Ca-кальци, Si-цахиур, S-хүхэр, Zn-Цайр, Mn-Манган гэх мэт элемент эзэлж байна.

9. Venezia

/ Усан будаг 5ш/ Итали улсад үйлдвэрлэсэн.

Эдгээр будгийг 2015, 2016, 2017 онуудад “Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах нь” сургалтыг БСШУСЯ, Монакагийн засгийн газар, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс-оос зохион байгуулж Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Соёл урлагийн их сургууль болон гадаад орны холбогдох мэргэжилтэн, судлаач, сэргээн засварлагч нар хамтран оролцсон. Сургалтыг ЮНЕСКО-гийн зөвлөх мэргэжилтэн ханын зураг сэргээн засварлагчаар мэргэшсэн Родолфо Люжан Лансфорд багш удирдан явуулсан. Энэ сургалтанд зориулж доорх (Хүснэгт 9, Хүснэгт 10) будгийг авч ирсэн ба Родолфо багш хэлэхдээ: Өнөөдрийн байдлаар дэлхий дээр хэрэглэж байгаа усан будгаас сэргээн засварлалтанд хамгийн тохиромжтой, чанартай, ганддаггүй сайн будаг хэмээн бардам хэлж байв. Будгийг үзэхэд 13 төрлийн өнгөтэй Итали, Францад үйлдвэрлэсэн 2 өөр үйлдвэрийн 3 төрлийн будгаас түүвэрлэн авсан байв. (Хүснэгт 9, Хүснэгт 10)

Хүснэгт 9. Venezia /Итали улсад үйлдвэрлэсэн/ будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	Venezia 161. Raw Siena	**Fe-50.72%, Si-18.35, Ca-16.32, Al-8.23, Ti-4.52,** P-0.74, K-0.73%, S-0.39
2	Улаан өнгө	Venezia 278. Burnt Siena	**Fe-54.01%, Si-19.39%, Ca-11.64%, Al-8.37%, Ti-3.49%, S-1.84%,** K-0.78%, As-0.22%, Mn-0.20%, Cr-0.05%
3	Бор өнгө	Venezia 492. Burnt Umber	**Fe-65.84%, Mn-20.90%, Si-6.55%, Ca-3.68%, Al-1.09%,** K-0.89%, Cu-0.30%, Ti-0.18%, Sr-0.18%, As-0.16%, Zn-0.13%, V-0.08%, Mo-0.00%

4		Venezia 493. Baw Umber	**Fe-68.32%, Mn-11.78%, Si-11.75%, Ca-5.34%, K-1.18%,** Sr-0.76%, Cu-0.28%, Al-0.23%, Zn-0.16%, Ni-0.12%, V-0.08%, Ba-0.01%, Mo-0.00%
5	Хар өнгө	Venezia. 535. Ivory Black	**Ca-76.17%, Fe-13.50%, Si-6.37%, K-3.97%,** Mo-0.00%

10. Winsor newton

/ Усан будаг 8ш/ Франц улсад үйлдвэрлэсэн.

Химич Уильям Винсор, зураач Хенри Невтон нар хамтран чанартай будаг гаргаж авах, үйлдвэрлэхээр шийдэж “Winsor newton” нэртэй компаныг 1832 онд анх үүсгэн байгуулжээ. Уг компани нь үнэхээр сайн ажиллаж тосон болон усан будгийн өнгө чанарыг мэдэгдэхүйц их сайжруулж байснаар эзэн хааны нэрийн том шагналаар шагнагдаж байсан бөгөөд 1800 оны сүүлч гэхэд “Winsor newton”-ны зураг, будгийн хэрэгслүүдийг дэлхийн олон улс оронд хэрэглэдэг болсон байв. Дэлхийн хоёр дайны үед ч “Winsor newton”-ны үйлдвэр өвдөг сөхрөлгүй тэмцэж компаниа өргөжүүлэн шинэлэг санаа гаргаж хүний хэрэглээний хэрэгслүүд сойз, багс мөн гуаш, хурдан хатдаг тосон будаг, ус хольж буддаг тосон будаг зэргийг үйлдвэрлэж хувьсгалт уран бүтээлчид энэ будаг хэрэгслүүдийг өргөнөөр ашиглаж байв. Өнөө үед уг компани нь дэлхийн олон оронд салбар үйлдвэрүүдээ нээж, уран бүтээлч, хэрэглэгчдийнхээ хүсэлд нийцүүлэн, шинэ санааг нь хүлээн авч, сүүлийн үеийн технологи, материалыг ирэлхийлж дэлхийн шилдэг уран бүтээлчдийн ашигладаг дэлхийн шилдэг урлагийн материалыг үйлдвэрлэхийн тулд бүхий л цаг хугацаагаа зориулан ажиллаж байна.(//www.winsornewton.com/na/heritage/about-us/)

Доор “Winsor newton”-ийн Франц улсад үйлдвэрлэсэн усан будагт Horiba XGT5200 X-Ray analytical microscope ашиглан энэ будгийн өнгүүд ямар химийн элементээс бүрдэж байгааг хүснэгт 10-т харуулав.

Хүснэгт 10. Winsor newton /Франц улсад үйлдвэрлэсэн/ будгийн элементийн шинжилгээ

№	Өнгө	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Шар өнгө	Yellow Ochre	**Fe-50.61%, Si-34.17, Al-9.087, Ca-2.38, K-1.86%, Zr-1.03,** Ti-0.48, S-0.39, Cr-0.10%, Zn-0.06
2	Улаан өнгө	Alizarin Crimson	**P-33.01%, Ca-31.41%, Al-15.39, W-9.25%, Si-7.48%, Fe-2.04%, Cu-1.09%,** Mn-0.33
3		Indian Red	**Fe-92.90%, Si-6.01%,** Ca-0.65%, Cu-0.17%, Cr-0.13%, Mn-0.08%, Zn-0.06%
4		Cadium Red	**Cd-55.70, Ba-16.16, Se-14.42%, S-10.67%, Si-2.72%,** Zn-0.32
5		Venetian Red	**Fe-82.39%, Mg-14.14%, Si-2.10%,** Ca-0.90%, Ba-0.20, Cu-0.14%, Cr-0.07%, Mn-0.06
6	Ногоон өнгө	Oxide of Chromium	**Cr-97.75%, Si-1.40%,** Pm-0.48%, S-0.17%, K-0.10%, Ti-0.05%, V-0.03%
7		Viridian vert de guignet viridiano	**Cr-83.28%, Pm-7.33%, K-6.82%, Si-1.86%,** Fe-0.42%, Zn-0.24%, S-0.04%
8	Хөх өнгө	Franch ultramarine	**Si-44.91%, S-42.70%, K-6.34%, Ca-3.39%,** Fe-0.93%, Zn-0.63%, Br-0.61%, Ti-0.49%

Шар өнгө: Дээрх 9, 10дугаар хүснэгтэд 2 шар өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Fe-төмөр, Si-цахиур, Ca-кальци, Al-хөнгөн цагаан, Ti-титан элемент голчлон борлог шар өнгийг үүсгэж байна. Fe-төмөр, Si-цахиур, Al-хөнгөн цагаан элемент голчлон тод алтан шар өнгийг үүсгэж байна.

Улаан өнгө: Дээрх 9, 10 хүснэгтэд 5 улаан өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элементийг 3 төрөлд хувааж болохоор онцлогтой байна. Нэгдүгээрт Fe-төмөр, Si-цахиур, Mg-магни, Ca-кальци элементээс бүрдэж буй өнгүүд борлог хүрэн улаан өнгийг үүсгэж байна. Хоёрдугаарт P-фосфор, Ca-кальци, Al-хөнгөн цагаан, W-Вольфрам, Si-цахиур элементээс бүрдэж буй өнгө тод ягаан улаан өнгийг үүсгэж байна. Гуравдугаарт Cd-Кадми, Ba-бари, Se-Селени, S-хүхэр элементээс бүрдэж буй өнгө тод ухаа улаан өнгийг үүсгэж байна.

Ногоон өнгө: Дээрх 10дугаар хүснэгтэд 2 ногоон өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй Cr-хром, Si-цахиур элемент нь тод ногоон өнгийг үүсгэж байна. Мөн Cr-хром, Pm-промети, K-кали, Si-цахиур элемент бараан ногоон өнгийг үүсгэж байна.

Хөх өнгө: Дээрх 10дугаар хүснэгтэд 1 хөх өнгө байна. Үүнийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Si-цахиур, S-хүхэр, K-кали, Ca-кальци элемент тэнгэрийн гүн хөх өнгийг үүсгэсэн байна.

Бор өнгө: Дээрх 9дүгээр хүснэгтэд 2 бор өнгө байна. Тэдгээрийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Fe-төмөр, Mn-манган, Si-цахиур, Ca-кальци байна. Эдгээр элемент тухайн өнгөндөө их бага хувьтай орж тод, бараан бор өнгүүдийг үүсгэсэн байна

Хар өнгө: Дээрх 9дүгээр хүснэгтэд 1 хар өнгө байна. Үүнийг голчлон бүрдүүлж буй химийн элемент Ca-кальци, Fe-төмөр, Si-цахиур, K-кали нь хар өнгийг үүсгэж байна.

Ижил нэртэй өнгийн найрлагын онцлог, харьцуулалт

Уран зургийн хэрэгсэл будаг үйлдвэрлэдэг компаниуд үйлдвэрлэн гаргаж буй будгийн өнгө болон олон төрлийн өнгүүдэд нэр өгөхдөө олон улсын стандартыг даган мөрдөж байдаг. Жишээ нь: Yellow Ochre, Ultramarine Blue, Burnt Umber, Scarlet гэх мэт өнгүүд аль ч улсад үйлдвэрлэсэн бай олон улсын стандартын дагуу ижил нэртэй будгууд ижил өнгөтэй байдаг. Харин ижил нэр өнгөтөй байдаг ч тухайн будагны найрлагууд нь хоорондоо өөр байдаг. Уг будгийн найрлагын онцлогоос шалтгаалан химийн болон амьтан ургамлын гаралтай, эрдэс шороон будгийн найрлагаас хамааран орчны нөлөөллөөс гэмтэх хими физик, механик гэмтэл нь өөр өөр түвшинд гэмтэх, будгийн сайн муугийн ялгаа гарч ирдэг. Доорх хүснэгтэд дээрх олон улс, үйлдвэрийн будгаас зарим ижил нэртэй өнгө хоорондын найрлагын ялгаа, онцлогийг харуулав.

Шар өнгө

Хүснэгт 11.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Cadium lemon 203	**Cd-71.87%, Zn-27.49%,** Si-0.63%
2	Рембрант	Cadmium lemon 207	**Cd-51.94%, Ba-20.56%, Zn-19.80%, S-5.62%, Si-1.28%,** Sr-0.51%

Ленинград будгийн Cadium lemon 203 өнгө нь Cd-кадми, Zn-цайр элементээс голчлон бүрдсэн бол Рембрант будгийн Cadmium lemon 207 өнгө Cd-кадми, Ba-бари, Zn-цайр, S-хүхэр, Si-цахиур элементээс голчлон бүрдсэн байна.

I

Хүснэгт 12.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Yellow ochre 218	**Fe-85.51%, Si-5.77%, K-3.27%, Ca-1.78%, Ti-1.50%, S-1.32%,** Zr-0.49%, Cr-0.32%, Mn-0.03%
2	Рембрант	Yellow ochre 227	**Fe-86.23%, Ca-8.99%, S-3.19%,** Si-0.78%, K-0.41%, Sr-0.30%, Zn-0.10%
3	Marie's гуаш Poster colour	Yellow Ochre 676	**Fe-42.77%, Ba-39.13%, S-10.41%, Al-3.58%, Si-3.27%,** Sr-0.84%
4	Winsor newton	Yellow Ochre	**Fe-50.61%, Si-34.17, Al-9.087, Ca-2.38, K-1.86%, Zr-1.03,** Ti-0.48, S-0.39, Cr-0.10%, Zn-0.06

Ленинград будгийн Yellow ochre 218 өнгө Fe-Төмөр, Si-Цахиур, K-Кали, Ca-Кальци,Ti-Титан, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Yellow ochre 227 өнгө Fe-Төмөр, Ca-Кальци, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Yellow Ochre 676 өнгө Fe-Төмөр, Ba-Бари, S-Хүхэр, Al-Хөнгөнцагаан, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна. Winsor newton будгийн Yellow Ochre өнгө Fe-Төмөр, Si-Цахиур, Al-Хөнгөнцагаан, Ca-Кальци, K-Кали, Zr-Цайр элементээс голчлон бүрдсэн байна.

Улаан өнгө

Хүснэгт 13.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Scarlet	**Ba-77.69%, Ce-9.56%, S-5.01%, Ca-2.66%, Si-2.38%, Pd-1.38%,** Fe-0.83%, Sr-0.51%
2	Marie's гуаш Poster colour	Scarlet 302	**Ba-66.03%, S-15.38%, Si-6.86%, Al-5.78%, Ca-5.03%,** Sr-0.35%, Fe-0.32%, Pd-0.24%

Ленинград будгийн Scarlet өнгө Ba-Бари, Ce-Селень, S-Хүхэр, Ca-Кальци, Si-Цахиур, Pd-Паллади элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Scarlet 302 өнгө Ba-Бари, S-Хүхэр, Si-Цахиур, Al-Хөнгөнцагаан, Ca-Кальци элементээс голчлон бүрдсэн байна.

Хүснэгт 14.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Carmine 319	**Ca-22.22%, Fe-21.72%, Si-20.84%, Ba-13.05%, K-12.83%, S-7.62%, Sr-1.73%,**
2	Сонет	Carmine 319	**Ca-95.13%, Si-2.75%, S-1.37%,** Fe-0.75%
3	Гуаш Poster colour	Carmine 2	**Ba-86.95%, S-7.09%, Si-2.72%, Sr-2.60%,** Fe-0.43%, Ca-0.21%, Ag-0.01%

Ленинград будгийн Carmine 319 өнгө Ca-Кальци, Fe-Төмөр, Si-Цахиур, Ba-Бари, K-Кали, S-Хүхэр, Sr-Стронци элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Carmine 319 өнгө Ca-Кальци, Si-Цахиур, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Marie's /Poster colour/ гуаш будгийн Carmine 2өнгө Ba-Бари, S-Хүхэр, Si-Цахиур, Sr-Стронци элементээс голчлон бүрдсэн байна.

Хөх өнгө

Хүснэгт 15.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Ultramarine 511	**S-36.42%, Ca-25.63%, Si-14.36%, K-14.22%, Fe-6.16%, Ti-2.24%,** Sr-0.96%
2	Сонет	Ultramarine light 501	**Ca-84.84%, S-7.79%, Si-5.14%, Fe-1.41%,** Ti-0.82%
3	Рембрант	Ultramarine deep 506	**S-44.50%, K-21.83%, Ca-17.77%, Fe-11.63%, Ti-2.12%, Rb-1.33%,** Zr-0.83%
3	Marie's гуаш Poster colour	Ultramarine Blue 443	**Ba-56.01%, Si-22.76%, Fe-5.86%, S-5.77%, Pd-4.44%, Ca-3.79%, Zn-1.37%**
4	Winsor newton	Franch ultramarine	**Si-44.91%, S-42.70%, K-6.34%, Ca-3.39%,** Fe-0.93%, Zn-0.63%, Br-0.61%, Ti-0.49%

Ленинград будгийн Ultramarine 511 өнгө S-Хүхэр, Ca-Кальци, Si-Цахиур, K-Кали, Fe-Төмөр, Ti-Титан элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Ultramarine light 501 өнгө Ca-Кальци, S-Хүхэр, Si-Цахиур, Fe-Төмөр элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Ultramarine deep 506 өнгө нь S-Хүхэр, K-Кали, Ca-Кальци, Fe-Төмөр, Ti-Титан, Rb-Рубиди элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Ultramarine Blue 443 өнгө Ba-Бари, Si-Цахиур, Fe-Төмөр, S-Хүхэр, Pd-Паллади, Ca-Кальци, Zn-Цайр элементээс голчлон бүрдсэн байна. Winsor newton будгийн Franch ultramarine өнгө Si-Цахиур, S-Хүхэр, K-Кали, Ca-Кальци элементээс голчлон бүрдсэн байна.

Хүснэгт 16.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Cobalt blue 508	**Co-83.85%, Zn-13.32%, Ca-1.06%,** K-0.95%, Si-0.41%, Fe-0.40%, Mo-0.00%
2	Рембрант	Combalt blue 511	**Co-94.70%, Si-1.66%, Al-1.28%,** K-0.72%, S-0.54%, Pm-0.31%, Cr-0.27%, Zn-0.26%, Fe-0.18%, Ti-0.08%
3	Гуаш Poster colour	Cobalt Blue 453	**Ba-74.89%, S-9.17%, Si-8.97%, Al-5.15%, Ca-1.12%,** Fe-0.48%, Sr-0.21%,
4	Гуаш Poster colour	Cobalt Blue 38	**S-31.51%, Ba-28.456%, Si-25.66%, Al-10.68%, Ca-1.32%, Fe-1.27%,** Sr-0.69%, Cu-0.27%, Zn-0.13%

Ленинград будгийн Cobalt blue 508 өнгө Co-Кобальт, Zn-Цайр, Ca-Кальци элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Combalt blue 511 өнгө Co-Кобальт, Si-Хүхэр, Al-Хөнгөнцагаан элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Cobalt Blue 453 өнгө Ba-Бари, S-Хүхэр, Si-Цахиур, Al-Хөнгөнцагаан, Ca-Кальци элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Cobalt Blue 38 өнгө S-Хүхэр, Ba-Бари, Si-Цахиур, Al-Хөнгөнцагаан, Ca-Кальци, Fe-Төмөр элементээс голчлон бүрдсэн байна.

Хүснэгт 17.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Violet 607	**W-48.47%, Mo-46.29%, Ca-1.80%, Si-1.55%, K-1.15%,** Fe-0.66%, Ba-0.09%
2	Сонет	Violet light 605	**W-63.04%, Ca-21.78%, Mo-14.04%,** Pd-0.82%, Fr-0.25%
3	Сонет	Violet deep 606	**Mo-39.58%, W-34.96%, Ca-24.54%,** Si-0.81%, Fe-0.12%
4	Marie's гуаш Poster colour	Violet 430	**Ba-59.81%, Zn-14.76%, W-11.34%, Si-9.42%, Fe-1.96%, Mo-1.40%,** Ca-0.47%, Sr-0.44%, K-0.40%, Yb-0.01%

Ленинград будгийн Violet 607 өнгө W-Вольфрам, Mo-Молбиден, Ca-Карьци, Si-Хүхэр, K-Кали элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Violet light 605 өнгө W-Вольфрам, Ca-Карьци, Mo-Молбиден элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Violet 430 өнгө нь Mo-Молбиден, W-Вольфрам, Ca-Карьци элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Violet 430 өнгө нь Ba-Бари, Zn-Цайр, W-Вольфрам , Si-Цахиур, Fe-Төмөр, Mo-Молбиден элементээс голчлон бүрдсэн байна.

Ногоон өнгө

Хүснэгт 18.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Emerald green 713	**Ba-52.63%, Cl-24.71%, Cu-12.01%, S-3.58%, Si-3.43%, Ca-1.04%,** K-0.95%, Fe-0.88%, Br-0.51%, Sr-0.27%
2	Сонет	Emerald green 720	**Cl-41.96%, Ca-32.47%, Cu-21.19%, Ba-1.89%, Si-1.68%,** S-0.82%

Ленинград будгийн Emerald green 713 өнгө Ba-Бари, Cl-Хлор, Cu-Зэс, S-Хүхэр, Si-Цахиур, Ca-Кальци элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Emerald green 720 өнгө Cl-Хлор, Ca-Кальци, Cu-Зэс, Ba-Бари, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна.

Бор өнгө

Хүснэгт 19.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Burnt umber	**Fe-87.99%, Mn-5.16%, Si-2.64%, Ca-1.92%, K-1.07%,** S-0.76%, Ti-0.45%
2	Сонет	Burnt umber 408	**Fe-88.55%, Mn-4.99%, Si-3.19%, Ti-1.29%, Ca-1.28%,** K-0.70%, Mo-0.00%
3	Рембрант	Burnt umber 409	**Fe-77.23%, Ca-10.08%, Mn-6.09%, S-2.47%, Si-2.31%,** Sr-0.78%, As-0.64%, Ti-0.41%
4	Marie's гуаш Poster colour	Burnt Umber 687	**Fe-79.21%, Si-7.18%, Al-7.05%, S-5.48%,** Ti-0.37%, Mn-0.36%, Cr-0.04%
5	Venezia	Venezia 492. Burnt Umber	**Fe-65.84%, Mn-20.90%, Si-6.55%, Ca-3.68%, Al-1.09%,** K-0.89%, Cu-0.30%, Ti-0.18%, Sr-0.18%, As-0.16%, Zn-0.13%, V-0.08%, Mo-0.00%

Ленинград будгийн Burnt umber өнгө нь Fe-Төмөр, Mn-Манган, Si-Цахиур, Ca-Кальци, K-Кали элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Burnt umber 408 өнгө Fe-Төмөр, Ca-Кальци, Mn-Манган, S-Хүхэр, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Burnt umber 409 өнгө Fe-Төмөр, Ca-Кальци, Mn-Манган, S-Хүхэр, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Burnt Umber 687 өнгө Fe-Төмөр, Si-Цахиур, Al-Хөнгөнцагаан, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Venezia будгийн Burnt Umber 492 өнгө нь Fe-Төмөр, Mn-Манган, Si-Цахиур, Ca-Кальци, Al-Хөнгөнцагаан элементээс голчлон бүрдсэн байна.

Хүснэгт 20.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Sepia 413	**Fe-77.02%, Si-9.35%, Ti-4.24%, Ca-3.77%, K-2.67%, S-1.98%,** Zr-0.97%
2	Сонет	Sepia 413	**Fe-49.72%, Ca-40.76%, Si-4.18%, Ti-3.52%, S-1.45%,** K-0.37%
3	Рембрант	Sepia (modern) 416	**Ca-44.82%, Fe-37.10%, S-13.42%, Ti-1.93%, Si-1.63%,** Sr-0.98%, Mn-0.11%

Ленинград будгийн Sepia 413 өнгө Fe-Төмөр, Si-Цахиур, Ti-Титан, Ca-Кальци, K-Кали, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Sepia 413 өнгө нь Fe-Төмөр, Ca-Кальци, Si-Цахиур, Ti-Титан, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Sepia (modern) 416 өнгө Ca-Кальци, Fe-Төмөр, S-Хүхэр, Ti-Титан, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна.

Хар өнгө

Хүснэгт 21.

№	Будгийн нэр	Өнгөний нэр	Элемент-массын хувь
1	Ленинград	Natural black 805	**Cu-79.00%, K-6.91%, Ca-6.25%, Si-3.97%, S-3.13%,** Fe-0.73%
2	Сонет	Lamp black 801	**Cu-49.69%, Ba-26.09%, Ca-13.32%, S-3.71%, Si-3.60%, Pd-2.66%,** Fe-0.92%
3	Рембрант	Ivory black 701	**Ca-71.08%, Fe-19.87%, Mn-3.19%, K-2.37%, Si-2.11%, S-1.39%**
4	Гуаш Poster colour	Lamp Black 794	**Si-39.52%, Fe-28.45%, S-19.00%, Al-12.16%,** Ca-0.62%, Zn-0.25%, Ba-0.01%
5	Venezia	Ivory Black 535	**Ca-76.17%, Fe-13.50%, Si-6.37%, K-3.97%,** Mo-0.00%
6	Tianya	C7	**Fe-84.10%, Ca-11.36%, Si-4.54%**
7	Эрдэс будаг	2500	**Fe-96.69%, Al-1.15%,** Si-0.98%, Mn-0.87%, Zn-0.15%, I-0.02%, Cs-0.00%

Ленинград будгийн Natural black 805 өнгө Cu-Зэс, K-Кали, Ca-Кальци, Si-Цахиур, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Сонет будгийн Lamp black 801 өнгө Cu-Зэс, Ba-Бари, Ca-Кальци, S-Хүхэр, Si-Цахиур, Pd-Паллади элементээс голчлон бүрдсэн байна. Рембрант будгийн Ivory black 701 өнгө Ca-Кальци, Fe-Төмөр, Mn-Манган, K-Кали, Si-Хүхэр, S-Хүхэр элементээс голчлон бүрдсэн байна. Marie's гуаш /Poster colour/ будгийн Lamp Black 794 өнгө Si-Цахиур, Fe-Төмөр, S-Хүхэр, Al-Хөнгөнцагаан элементээс голчлон бүрдсэн байна. Venezia будгийн Ivory Black 535 өнгө Ca-Кальци, Fe-Төмөр, Si-Цахиур, K-Кали элементээс голчлон бүрдсэн байна. Tianya будгийн C7 хар өнгө Fe-Төмөр, Ca-Кальци, Si-Цахиур элементээс бүрдсэн байна. Эрдэс будгийн 2500 хар өнгө Fe-Төмөр, Al-Хөнгөнцагаан, Si-Цахиур элементээс голчлон бүрдсэн байна.

Үр дүн

Дээрх будгийн найрлага, химийн элементийн бүтцэд анализ хийхэд Fe-Төмөр элементээс голчлон бүрдэж буй өнгүүд ихэвчлэн шар(бараан), улаан, хүрэн, бор, хар байна. Cd-Кадми, Pd-Паллади элемент голчлон тод алтан шар өнгийг бүтээж байна. Мөн Cd-Кадми элемент голчлон тод ухаа улаан өнгийг үүсгэж байна. W-Вольфрам, Mo-Мольбедин элемент голчлон чернелин ягаан өнгийг үүсгэж байна. S-Хүхэр элемент голчлон бараан цэнхэр (Ultramarine) өнгийг үүсгэж байна. Co-Кобальт элементээс голчлон тод хөх өнгийг үүсгэж байна. Cl-Хлор, Cr-хром элемент голчлон ногоон өнгийг үүсгэж байна. Cu-Зэс элементээс голчлон хар өнгийг үүсгэж байна. Zn-Цайр, Ti-Титан элемент голчлон цагаан өнгийг үүсгэж байна. Pb-Хартугалга элемент голчлон шар, тод ногоон өнгийг үүсгэж байна. P-Фосфор элемент голчлон тод ягаан улаан өнгийг үүсгэж байна.

Монголчууд эрдэс будгийг ямар түүхий эдээс гарган авсанаар нь хоёр ангилдаг. Амьтан ургамлын гаралтай будгийг "Шимийн будаг", шороо, шавар, чулуунаас гаргаж авсан будгийг "Шороон будаг" гэж нэрлэдэг. Шороон будаг нь атмосфер, хими, гэрлийн үйлчлэлд тэсвэртэй учир сүм дуганы барилгын өнгө будагт өргөн хэрэглэгддэг ба түүхий эд нь байгаль дээр байгаа өнгөт шороо, чулууллаг учраас гадаа нар салхи байгалийн нөлөөлөл ихтэй газар хэрэглэдэг байжээ. Иймээс шимийн будаг, шороон будаг хоёрыг

хооронд нь харьцуулвал он цаг, байгалийн нөлөөллийг илүү тэсвэрлэж чадахаар нь шороон будгийг шимийн будгаас илүү сайн будаг гэж үзэж болохоор байна.

Дээрх 10 төрлийн 151 өнгийн найрлагыг үзэхэд Ленинград, Рембрант, Terra naturale Aromafarmacoteca d'Alene Via Cavour 260 Roma Итали, Баян-Өлгий аймаг Буянт сум Монгол, Venezia Усан будаг Итали, Winsor newton Усан будаг Франц будагт олон өнгө тус бүр хоорондоо өөр олон төрлийн эрдэс, элементээс бүрдсэн байна. Харин Сонет, Tianya, 100 айл худалдааны захаас авсан эрдэс будгийн өнгүүд голчлон кальци элементээс бүрдсэн байна. Кальци нь ургамал болон амьд организмуудад, ялангуяа эсийн физиологид чухал үүрэгтэй ба яс, дун зэргийн эрдэсжилтэд ордог кальци нь олон амьтны биед хамгийн их масс эзэлдэг металл юм. Үүнээс үзэхэд кальциас голчлон бүрдэж буй будгуудыг шимийн будаг гэж үзэж болох боловч мөн кальцийг байгалийн цэрд (CaCO3; шохойн чулууны нэг төрөл)-ийг шохой, цемент, шил, саахар, резин, цаас, төмөрлөг, хиймэл шүд, шүдний оо үйлдвэрлэх, түүнийг боловсруулж бичгийн шохой хийхэд өргөнөөр ашигладаг юм. Тиймээс цаашдаа кальци элементээс голчлон бүрдэж буй будгуудад шинжлэх ухааны олон шилдэг технологиуд дээр үргэлжлүүлэн судалж амьтан ургамлаас эсвэл чулуунаас гарган авсан эсэхийг танин тогтоох шаардлагатай байна.

Дээрх будгаас хамгийн онцгой найрлагатай будаг бол Гуашь /Marie's poster colour/ будаг байна. Энэ будгаас 30 төрлийн өнгийг судалсан бөгөөд бүрдүүлж буй элементэд анализ хийхэд улаан, шар, ногоон, хөх, ягаан гэх мэт 23 өнгөнд Ba-бари хэмээх элемент 47%- 93%-ийг эзлэн бүтээж байна. Эдгээр өнгийг голчлон бүрдүүлж, ихэнх хувийг эзлэн буй химийн элемент 56 атомын дугаартай Ba-бари (Barium) нь зөөлөн, мөнгөлөг өнгөтэй газрын шүлтэт металл юм. Уг элемент байгаль дээр цэврээр тохиолдохгүй. Бариг (Грек bary - "хүнд" гэсэн утгатай) анх 1774 онд Карл Шееле тодорхойлж, 1808 онд Английн химич, физикч Хемпри Дэви ялгаж авсан байна. Бари нь шинжийн хувьд кальцтай төстэй гэхдээ илүү их химийн идэвхитэй элемент юм. Бариг эмнэлгийн болон үйлдвэрлэлийн зориулалтаар өргөн ашигладаг. Жишээлбэл эмнэлэгт хоол боловсруулах эрхтний рентгэн зураг авах үед будагч бодисоор ашиглана, никелтэй хамт хайлшны хольц болно, Барийн карбонат шилний үйлдвэрт хэрэглэгдэнэ. Бариг нэмсэнээр шилний галгар байдал, хугарлын индексийг ихэсгэнэ, мөн төрөл бүрийн будаг гарган авахад өргөн ашигладаг. Мөн бари нь бенитоите-д (ховор эрдэнийн чулуу) бага хэмжээгээр агуулагдаг. (https://mn.wikipedia.org/wiki/Бари) Үүнээс үзэхэд уг бари элементийг үйлдвэрийн аргаар гаргаж авдаг бөгөөд будаг гарган авахдаа будагны өнгө гаргаж авдаг мөн будагны хэмжээг ихэсгэхэд ашиглаж байна гэж үзэж болохоор байна.

Гэхдээ гуашь /Marie's poster colour/ будгийн судалгаанд хамрагдсан 30 өнгөний 23 нь бари элементээс голчлон бүрдсэн, бусад 7 өнгө нь эрдсээс бүтсэн байгааг хүснэгт 4-өөс харж болно. Тиймээс энэ будгийн бүх өнгийг бари элементээс бүрдэж байна гэж үзэж болохгүй, доторх найрлагыг нь мэдэж байж зохицох ажилд хэрэглэх шаардлагатай. Мөн гуашь /Marie's poster colour/ будгаас бусад будгийн өнгүүдэд бари элемент орсон байна. Жишээ нь Ленинград будгийн Cadium yellow, Cadium orange, Scarlet, Azure өнгөнд, Рембрант будгийн Cadium yellow, Cadium red өнгөнд, Terra naturale. Aromafarmacoteca d'Alene Via Cavour 260 Roma /Итали улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн Viridian ногоон өнгөнд, Баян-Өлгий аймаг, Буянт сум /Монгол улсад үйлдвэрлэсэн/ эрдэс будгийн улаан, цагаан, хөх өнгүүдэд орсон байна.

Дээрх будгийг голчлон бүрдүүлж буй элементүүд болох кальци, төмөр , цахиур , хөнгөнцагаан , хүхэр , кали нь орчлон ертөнц, байгаль дэлхийн ихэнх хувийг бүрдүүлж байдаг учраас байгаль дэлхий дээр оршиж буй бүх зүйлд их бага хэмжээгээр агуулагддаг учир байгалийн хүчин зүйлийн нөлөөллийн улмаас тус тусийн өнгө будгийн нөллөөллийг бүрдүүлсээр байна.

Эдгээр будгийн орц найрлагыг мэдэж авсанаар: Сэргээн засварлагдаж буй танка зургийн будгийн найрлагатай ижил найрлага бүтэцтэй будгаар сэргээн засварлах. Энэ нь зураг сэргээн засварласны дараа хадаглагдаж буй сан хөмрөг, музейн танхим, орчны

нөлөөлөл, олон жилийн хугацаанд хими, физикийн хувирал тэгш явагдаж соёлын үнэ цэнийг бууруулахгүй байна. Цаашдаа орчин үеийн олон улс, олон үйлдвэрийн будгаас сэргээн засварлах ажилд тохиромжтой, тохиромгүйг ялган таних, будгийн найрлага онцлогт нь тохирсон хадгалалт хамгаалалтын арга зүйг боловсруулна. Мөн эдгээр будгийг өргөнөөр хэрэглэдэг уран бүтээлчид өөрсдийн хэрэглэж буй будгийн найрлага онцлогийг мэдэж авах, будгийн сайн муугийн ялгаа, ямар түүхий эдээс гаргаж авсныг харж болно.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар орчин үед танка зураг бүтээх болон сэргээн засварлахад ашиглаж буй эрдэс будгийн найрлагын судалгааг Horiba XGT5200 X-Ray analytical microscope багажны тусламжтай тогтоож өнгө тус бүрийн найрлагын онцлогийг тодорхойлсон. Одоогоор Монголд танка зураг бүтээх болон сэргээн засварлахад өргөн хэрэглэгддэг 10 төрлийн 151 будгийн химийн элементийн найрлагыг бүтцээр нь ангилан будгийн найрлагын эрдэс, ялгарах онцлог шинжийг тодорхойлж, танка зургийн бүтээлийг сэргээн засварлах, зөв зохистой хадгалж хамгаалахад будаг тус бүр нь хүрээлэн буй орчны эрсдэлт нөхцөлд гандалт, гэмтэлд тэсвэртэй эсэх талаар судалгаанд үндэслэн сэргээн засварлалтын аргазүйг боловсруулах анхан шатны судалгааг хийж, танин мэдэхүйн мэдлэг, мэдээллийг бий болгов.

Энэ судалгааг хийснээр уран бүтээлчид болон холбогдох хүмүүст будгийн сайн, муу түвшинг тогтоох, цаашид энэ төрлийн судалгааг гүнзгийрүүлэн судлахад анхдагч суурь мэдээлэл болох ба сэргээн засварлах ажилд өнгө будаг, материалын шинж чанар бүтцийг зөв таньж мэдсэнээр ижил төрлийн найрлага, бүтэцтэй өнгө, будаг материалаар нөхөж засах, зассаны дараа он цаг, орчны нөлөөний үйлчлэлд өөрчлөлт тэгш явагдах, хадгалж хамгаалахад музейн орчин, тоног төхөөрөмжийг сайжруулах, музейн ажилтнуудад соёлын өвийг хамгаалах мэдлэгийг нь дээшлүүлэхэд үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Мөн манай улсад ийм төрлийн бодит судалгаа хийгдэж байгаагүй нь энэ судалгааны шинэлэг тал болж байна.

Номзүй

1. Адъяа Б., Батсуурь Ж., Пүрэвбат Г., Уртнасан Н., Хишигт Д., Шархүү С. Бурханы шашны сүм, дуганы урлал, чимэглэлийг сэргээн амилуулах монгол уламжлалт арга ухааны гарын авлага. Хархорин УБ., 2006.

2. Адъяа Д., Баярмаа Г. Химийн нэвтэрхий толь. УБ., 2012.

3. Баяртөр Б. Дүрслэх урлаг судлал шинжлэл. УБ., 2014.

4. Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод хамрагдсан үзмэр, эд өлгийн зүйлийн төрөл зүйлийн ангилал. 2012-2013 оны улсын тооллогоор тоологдсон үзмэрүүд

5. Монгол улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл /1995-2015/

6. ЭнхтуяаШ. Нүүдэлчдийн өв судлал. Монголын үндэсний түүхийн музей. / Монгол уран зургийн өв Цагаан Жамбын бүтээлийн сангаас/. УБ., 2018.

7. //www.nevskayapalitra.ru/about-the-company/

8. //www.royaltalens.com/en/about-royal-talens/our-story/

9. //www.chinamaries.com/En/about/

10. https://mn.wikipedia.org/wiki/Кальци

11. https://mn.wikipedia.org/wiki/Бари

12. https://mn.wikipedia.org/wiki/Төмөр_(химийн_элемент)

13. https://mn.wikipedia.org/wiki/Цахиур

14. https://mn.wikipedia.org/wiki/Хөнгөн

15. https://mn.wikipedia.org/wiki/Хүхэр

16. https://mn.wikipedia.org/wiki/Кали

САРЬДАГИЙН ХИЙДЭЭС ИЛЭРСЭН МОДОН ЭДЛЭЛД “ТРЕХАЛОС” САХАРЫН УУСМАЛ АШИГЛАХ НЬ

Н.Нандинцэцэг /Магистр/
ШУА-ийн Археологийн хүрээлэн, Сан хөмрөг, лабораторийн
салбарын эрдэм шинжилгээний ажилтан
nandia678@yahoo.com
М.Оюунтулга /Ph.D/
Соёлын өвийн үндэсний төв СБӨСГ, ерөнхий технологич
ponyma49@yahoo.com

Түлхүүр үгс: Сарьдагийн хийд, Модон эдлэл, Хадгалалт хамгаалалт, Бэхжүүлэлт, Трехалос сахарын уусмал

Хураангуй. Энэхүү өгүүлэлдээ Халхын Өндөр гэгээн Занабазарын байгуулсан Номын их хүрээ буюу Сарьдагийн хийдэд 2015-2017 онд “XVII зууны Монголын хотууд” төслийн хүрээнд явуулсан археологийн малтлага судалгааны үр дүнд илэрсэн барилгын модон эдлэлийн хэсгүүд болон хээтэй модон чимэглэлд Трехалос /C2H22O11/ сахарын уусмалаар бэхжүүлэлт хийсэн ажлын урьдчилсан үр дүнг танилцуулна. Тус судалгаанд хэрэглэж буй хадгалалт хамгаалалтын аргачлалыг судлаач, доктор М.Оюунтулгын өмнө хийж байсан “Монголын тал хээрийн бүсээс илэрч буй чийгшилтэй орчны модон эдлэлийн онцлогт таарсан хадгалалт, хамгаалалт, бэхжүүлэлтийн арга зүй” хэмээх судалгаан дээр үндэслэсэн ба Японы Нарагийн их сургуулийн доктор Ито Коужи нарын удирдлагаар ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн лабораторид хэрэглэж байгаа зориулалтын дулаан тохируулагчтай усан банныг(Water bath) ашигласан болно.

Трехалос сахарын уусмалын аргаар бэхжүүлэлт хийсэн модон олдворууд нь одоогийн байдлаар гадаргууд сахарын уусмалын царцмаг бүхий цагаан талстаар бүрхэгдэж цайрсан, 160-900г (№7 390.23-160г, №8 264.99-220г, №-9 1058-900г) хүртэлх жинд хүрч тогтож хатсан, урт өргөний өөрчлөлтгүй, хөнгөн шинж чанартай байна. Бид энэхүү аргыг анх удаа туршилтын журмаар ашиглаж байгаа тул цаашид модон эдлэлийн хадгалалт, нөхцөл байдалд нь тохируулан хялбар, хурдан энгийн шинэ арга зүйг боловсруулах боломжтой сэргээн засварлалтын арга зүйн нэг дэвшил болж байгаа билээ.

Удиртгал

2016 оноос эхлэн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн /хуучин нэршлээр/, Монголын үндэсний музей, Соёлын өвийн үндэсний төв, Өвөрхангай аймгийн Хархорум музей, Орхон аймгийн музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Үлэг гүрвэлийн музей зэрэг судалгааны байгууллагууд археологийн малтлага судалгаагаар илэрсэн модон эдлэлийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны салбартаа Японы эрдэмтдийн гаргаж авсан сахарын уусмалын нэгэн төрөл Трехалос /C2H22O11/ сахарын уусмалыг бэхжүүлэлтийн судалгааны ажилдаа эхлүүлээд байна.

Хадгалалт хамгаалалт нь тухайн дурсгалын хадгалах хугацааг уртасгах, дурсгалын бүтэц, найрлагыг судалж тохирох орчинг бүрдүүлэх, хадгалж буй орчныг хянаж олдворыг гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг хэлэх ба малтлагын талбай дээрээс эхлэх ажил юм. Малтлагын түүх, сэргээн засварлалт, хадгалалтын нөхцөл бүгд нэгдсэн мэдээлэлтэй, цогц байдлаар байвал жинхэнэ хадгалалт, хамгаалалт болно. Малтлагаас

Чулуун, С., Энхтуул,Ч., Нандинцэцэг, Н., “XVII зууны Монголын хотууд” төсөл Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. “Трехалос” сахарын уусмалын хадгалалтын арга зүйг ашиглан модон эдлэлд бэхжүүлэлт хийх нь. АХГБС. УБ., 2017.

Чулуун, С., Энхтуул,Ч., Нандинцэцэг, Н., “XVII зууны Монголын хотууд” төсөл.Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Археологийн дурсгалаас илэрсэн модон олдворын бэхжүүлэлт, хадгалалт хамгаалалтын тайлан. АХГБС. УБ., 2016.

Чулуун, С., Энхтуул,Ч., Нандинцэцэг, Н., “XVII зууны Монголын хотууд” төсөл Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. “Трехалос” сахарын уусмалын хадгалалтын арга зүйг ашиглан модон эдлэлд бэхжүүлэлт хийх нь. АХГБС. УБ., 2017.

гарч ирсэн олдворуудад тухайн газарт нь сэргээн засварлах, хадгалж хамгаалах ажлыг гүйцэтгэснээр олдворыг нэмж гэмтээх, химийн урвалд орохоос урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой бөгөөд хадгалалтын нөхцөлийг уртасгах чухал ач холбогдолтой байна.

Манай орны эрс тэс уур амьсгал, нөхцөл байдалд тохирсон хадгалалт хамгаалалтын богино, урт хугацааны арга зүйг боловсруулах арга хэмжээг авахгүй бол устаж үгүй болох органик эдлэл маш их байна. Тэр дундаа модон эдлэлүүд судалгааны эргэлтэд орохоосоо өмнө эмтэрч гэмтэх, хадгалалтын байдлаас шалтгаалан хэлбэр дүрс өөрчлөгдөх, хагарч муудах, өмхөрч үгүй болох, модны төрөл бүтцийн эрсдлүүд үүсэх нь олонтоо. Тиймээс орчин нөхцөлд тохирсон арга зүйг ашиглан модон эдлэлийн өв соёлыг сэргээн хадгалж хамгаалах асуудалд анхаарал хандуулан судалгааны эргэлтэд оруулах, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, сурталчилан таниулах зорилгоор үе шаттай алхамуудыг хийсээр байна.

Энэ удаагийн судалгаагаар, Монгол улсын нутаг дэвсгэрийн хойд хэсгийн сэрүүн бүсэд багтдаг хээр тал, ойт хөвч, тайга зонхилсон бага Хэнтийн уулс их ой хөвчийн төв хэсэг Төв аймгийн Эрдэнэ суманд орших Сарьдагийн хийдэд 2015-2017 онд явуулсан археологийн малтлага судалгааны үр дүнд илэрсэн барилгын ерөнхий байдал, хийцийг тодорхойлж болох түвэд хийцийн барилгын модон эдлэлүүд, модон хаалга, тооно хэлбэртэй барилгын модон эдлэл, хулсан сүлжээ хээтэй модон багана зэрэг модон олдворуудыг хээрийн нөхцөлд хадгалж хамгаалан, модон эдлэлийн хэсгүүд, хээтэй модон чимэглэлд Трехалос /C2H22O11/ сахарын уусмал хэрэглэсэн урьдчилсан үр дүнг танилцуулахыг зорив.

Тус хийдийн барилгын модон эдлэлүүд нь 14-290 см урттай, овор хэмжээний хувьд том жижиг байх ба зарим эдлэл нь цэвдэгтэй газраас малтаж гаргасан учир хадгалалт сайн ч ус чийг ихтэй, нойтон шавар шорооны үлдэгдэлтэй, олон жил хөрсөн дор дарагдан үнэр орж, өгөршин үхэжсэн, галд өртөж шатсан ул мөртэй, хагарч хугарсан зэрэг олон шинжийг агуулсан нөхцөл байдалтайгаар анх малтлагын талбайгаас олдсон. Тиймээс бүрэн гүйцэд хатаагүй, усны агууламж ихтэй, чийгшилтэй орчинд хадгалагдаж байсан нь уг олдворуудад энэхүү аргачлалыг хэрэглэх гол шалтгаан болсон юм.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Сарьдагийн хийдийн барилгын ерөнхий байдал, бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, хамрах хүрээг тодорхойлох зорилгоор цогчин дуганы зүүн хойд буланд залган байрлах барилга №6 хэмээн дугаарласан турд нарийвчлан судалгаа явуулж овор хэмжээний хувьд харилцан адилгүй том, жижиг хэмжээтэй, нарийн хийц бүхий түвэд загвартай барилгын нийт 30 орчим материал илэрсэн. Малтлагын 15-р талбайн 6-р үеэс өмхөрсөн дээврийн мод, 7-р үед хойд ханын дагуу унь модны үзүүр хэсэг, 8-р үе буюу цэвдэгтэй хэсгээс дээврийн модны хэсгүүд болох их нум, дам нуруу, туслах нуруунууд нь талбай дээр хөндлөн болон хэвтээ эмх замбараагүй, талбайн дунд бөөн байдалтайгаар хэд хэдэн модны үлдэгдэл илрэн гарчээ. Эдгээр нь цэвдэгтэй, чулуу, шороон нурангид дарагдсан, ихээхэн хэмжээний ус шавхайтай холилдсон, олон жилийн хуршсан хөрс шорооны эхүүн үнэртэй, нойтон шавраар бүрхэгдсэн нөхцөл байдалд хадгалагдаж (Зураг 1) байжээ. Мөн энэ талбайгаас сийлбэр далавч бүхий нум, дам нуруу, туслах нуруу, түгжих үүрэг бүхий углуургатай хавтгай нимгэн банз, унь модны тулгуур зэрэг нийлээд 20 олдвор, мөн 7 хэсэг углуургаар салган нийлүүлэх боломжтой, баруун талын хойд хананы дагуу нийт урт нь 185 см, өргөн 110 см зүүн талын хаалганы хүрээндээ монгол төмөр цоож өлгөөстэй нэг иж бүрдэл бүхий түвэд хийцийн модон хаалга тус тус илэрсэн байна.

Г.Сайнбаяр. Дендроархеологийн судалгаанд үндэслэн ойн түүхийг сэргээн босгох нь (Сарьдагийн хийдийн жишээ). Магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС, ХШУИС, Хүрээлэн Буй Орчин Судлал, Химийн Инженерчлэлийн Тэнхим. УБ., 2016

Чулуун, С., Сарьдагийн хийд, Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хийд. УБ., 2019. т. 382-387

Нялхай, Х., Цэндсүрэн, Т., Мод боловсруулах технологи. УБ., 2014. т. 22-24






Зураг 1. Малтлагын талбайгаас модон эдлэлүүд илэрч буй байдал

Уг хийдээс илэрсэн модон эдлэлийн насжилтыг тогтоох, материалын зүйлийн нэр, анатоми бүтцийг тодруулах зорилгоор турын малтлагаас болон ойр орчмын унанги, амьд модноос нийт 43 дээж авсан ба эдгээр дээжийн зарим нь өмхрөл ихтэй, хэт богино настай зэргээс хамааран амьд модны 10 дээж, унанги модны 2 дээж, археологийн малтлагаар илэрсэн 13 дээжид дүн шинжилгээ (зураг 2) хийж хооронд нь харьцуулан нарсны овог (Pine spp)-эгэл нарс (Pinus sylvestris L.) болохыг Монгол Улсын их сургуулийн Байгалийн ухааны сургуулийн доктор Н.Баатарбилэг, оюутан Г.Сайнбаяр нар GSL1 микротомыг ашиглан тогтоосон байна.

Археологийн малтлагаар илэрсэн олдворууд нь ихэвчлэн газар доор удаан байснаас модлог нь хатуурч үхэжсэн байдаг аж. Шилмүүст модны төрөл болох нарс нь хүрэндүү улаан цөмтэй, зулам нь шаргалдуу цагаан өнгөтэй, бүх огтлол дээр сайн харагддаг байна. Нарс нь давирхайлаг, бат бөх, хөгцрөлтөд тэсвэртэй, хагарах ба хөрөөдөхөд амархан учир барилгын материалд өргөн хэрэглэсээр иржээ. Шилмүүст моддын модлогийн онцлог бол давирхайгаар дүүрсэн нарийн сувгуудын байдалтай, давирхайн замуудтай байдаг байна.



Зураг 2. Амьд мод, унанги мод болон археологийн дээж моддын холбогдсон байдал

Хадгалалт хамгаалалтын арга зүй

Хэзээ /үечлэл/, хаанаас /газарзүйн байршил/ илэрсэн болон хадгалалтын нөхцөл байдал, анхны төрх, олдворын төрөл, зориулалт, хэрэглээ, тоо хэмжээ зэргийг тодорхойлох арга зүйн хүрээнд модны төрөл, бүтцийн гэмтлийг тогтоох зэргээр хадгалалт хамгаалалтын аргыг тодорхой үе шаттай явуулснаар тухайн нөхцөлд таарсан анхан шатны арга хэмжээг авах бүрэн боломжтой болох юм.

Археологийн модон эдлэлийн хадгалалт хамгаалалтад дэлхийн олон улсууд Полиэтилен гликол, спиртийн уусмал, сахарын уусмал, вакумжуулж хөлдөөх зэрэг өөр өөрийн онцлог, үе шат, арга зүйтэй, өндөр өртөг бүхий лабораторийн орчин шаарддаг аргуудыг өргөн хэрэглэж байна. Дээрх аргуудаас хамгийн өргөн хэрэглэгдэж буй Полиэтилен гликол буюу бидний мэдэх ПЭГ /PEG- $C_{2n}H_{4n+2}O_{n+1}$,/ атом молекул нь 3800 масстай, усанд уусдаг бодисын аргачлал юм. Гэвч сүүлийн жилүүдэд энэхүү аргачлал нь модон эдлэлтэй хамт олдох металлуудтай химийн урвалд орж олдворыг цайруулах, ялзруулах зэрэг урвалыг үзүүлэх асуудлууд гарч ирсэн нь өөр арга зүйг хэрэглэх үндэслэл болжээ.

Сүүлийн үед хадгалалт хамгаалалтын арга зүйн хувьд Японы эрдэмтдийн гаргаж авсан нэгэн аргачлал болох сахарын уусмалын нэгэн төрөл Терахалос /$C_2H_{22}O_{11}$/-д олон судлаач анхаарлаа хандуулж байна. Энэхүү уусмал нь атом молекулын хувьд 380 масстай буюу маш жижиг масстай учраас хаталттай модонд ороход хялбар, дигедри буюу маш хүчтэй талст үүсгэдэг онцлогтой аж. Уг аргачлалын давуу тал нь сахарын уусмалыг олдвортоо тааруулж хэмжээг нь өөрчилж болдог, бусад бодистой харьцуулахад талст үүсгэдэг учраас гэрлийн хагас хугарлаар олдворын гадаргууг гэрлийн нөлөөнөөс хамгаалах чадвартайд оршино.

Трехалос нь 10%-ийн ус агуулдаг тул усанд уусан уусмалын хэлбэрт орж модны гол бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болох лигнин, хэмисэмирос, сэмиросын төвшинд очиж

Оюунтулга, М., Модон эдлэлийн хадгалалт хамгаалалтанд “Трехалос” сахарын уусмалыг ашигласан судалгаа (тал хээрийн бүсийн олдворын жишээн дээр). //Музей судлал. Том. XVII, fasc.29. УБ., 2016. т. 248-249

Даваадарь, С., Бат-Эрдэнэ, Н., Оюунтулга, М., Сэцуо Имазу., Коужи Ито., Хироаку Фүжита. Археологийн малтлага судалгаагаар илэрсэн модон эдлэлийн хадгалалт хамгаалалтын асуудалд. (Айрагийн гозгорын жишээн дээр). //Монголын археологи - 2017 эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2018. т. 214-217.

талст үүсгэн бэхжүүлдэг байна. Трехалос уусмалын бэхжүүлэлтийн арга зүй гэдэг нь модонд агуулагдах усны тодорхой хэмжээг 60-80%-ийн халуунд ууршуулан ус агуулж байгаа усны эзэлхүүний оронд солин оруулж уурын төлвийг хөргөөж хатуу төлөвт шилжүүлж талст үүсгэх байдлаар бэхжүүлэхийг хэлдэг. Энэхүү талст нь 90% хүртэлх чийгшилд ууршдаггүй, сэрүүн хуурай нөхцөлд бат бөх чанараа алддаггүй онцлогтой.

Малтлагын талбай дээрх цэвэрлэгээ: Овор хэмжээний хувьд харилцан адилгүй жин хэмжээтэй, нойтон шавар их, чийгтэй барилгын материалыг малтлагын талбай дээр энгийн хэрэглээний гар доорх багаж хэрэгслийг ашиглан бохирдлоос ангижруулж нян бактерийг нь устган шороо, шавхайн дарагдмал эхүүн үнэрийг арилгах зорилгоор этанол (EtOH (CH3)2CO) болон H.P.C (CH2CH(OH)CH3) уусмалыг 1-2%-иар найруулан хэрэглэхийн сацуу голын урсгал усаар нойтон шавар, анхны бохирдлыг арилгаж олдворт анхан шатны урьдчилсан цэвэрлэгээг (Зураг 3) гүйцэтгэсэн юм.



Зураг 3. Овор хэмжээ ихтэй модон олдворуудын малтлагын талбай дээрх цэвэрлэгээ

Оюунтулга, М., Монгол нутаг дахь тал хээрийн бүсээс илэрч буй модон эдлэлийн хадгалалт хамгаалалтын арга зүй. –“Хүрэл тогоот - 2019” эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 129-130

Нойтон байгаа археологийн органик олдворын чийгийг алдагдуулахгүйн тулд гялгар скочоор ороож гадна талаас нь органик материалд даралт бага өгөх уяаны ором гарахаас сэргийлэн хатуу дэмжигч материал ашиглан бэхэлж баглаа боодолд анхааран зөөж тээвэрлэн лабораторийн орчинд авчирсны дараа дэлгэж хатаан дараагийн үйл ажиллагаанд шилжихэд бэлэн болгосон. Археологийн малтлагын үе дэх анхан шатны цэвэрлэгээ, бэхжүүлэлт нь түр хугацаанд олдвор, эд зүйлийг бэхжүүлэн хамгаалж мэргэжлийн сэргээн засварлах байгууллага, зориулалтын хадгалж хамгаалах орчин, лабораторид шилжүүлэн өгөх хүртэлх хугацаанд хийх ажиллагаа юм.


Бэхжүүлэлт: Тус хүрээлэнгийн лабораторид Сарьдагийн хийдийн 2016-2017 оны малтлага судалгаагаар илэрсэн хээтэй болон 6 см өргөн 30 см урт 0.3-0.5 см зузаантай нийт 18 ш модноос №7, №8, №9 эдлэлүүдийг сонгон авч зориулалтын дулаан тохируулагчтай банныг 50^{C}-д халааж олдворын жин хэмжээнд тааруулан 20%-30% Трехалос сахарын уусмалыг найруулж тусгайлан бэлдсэн савтай олдворт хийн 14 хоногийн хугацаатай (зураг 4) ажиллуулав.



Зураг 4. Трехалос сахарын уусмалд хийж буй үйл явц

Нямдорж, Д., Анхсанаа, Г., Оюунтулга, М., Археологийн малтлагын үед олдворыг хадгалах, хамгаалах арга зүйн зөвлөмж. Соёлын өвийн үндэсний төв. УБ., 2019

Эхний өдөр 390.23г жинтэй №7, 264.96г жинтэй №8, 1058г жинтэй №9 модон эдлэлүүдэд уусмал нэвчүүлэхдээ буцалсан халуун усанд трехалос сахарын уусмалыг 20%-иар хийж найруулан 50^{C} градусын усан баннд хийв. Дараагийн долоо хоногт нь дахин жигнэж сахарын уусмалыг 40% болгон нэмсэн ба өөр жижиг хэмжээтэй моддыг хамтад нь хийсэн юм. Эхний 7 хоногийн дараа дахин жигнэж үзэхэд №7-оос 103,15г хасагдаж 287,08г, №8-д 301,20г нэмэгдэж 303,85г, №9-д 10г нэмэгдсэн буюу 1062г болж тус тус өөрчлөлт орсон нь харагдаж байлаа. Энэ хугацаанд олдворын өнгө гялтганасан хар, барихад наалдамхай шинжтэй, ихээхэн элсэн чихэртэй болсон байна.



	МОДОН ЭДЛЭЛ №7	МОДОН ЭДЛЭЛ №8	МОДОН ЭДЛЭЛ №9
11.05	390.23	264.96	1058
11.06	287.08	303.85	1062
	103,15	- 30120	- 10
11.11	300	340	1070
11.12	280	340	1072
	20	-	2
11.13	300	340	1087
11.14	280	320	1078
	20	20	9
11.15	260	320	1060
11.16	260	320	1060
	-	-	-
11.17	240	280	1064
11.23	180	220	1054
	60	40	10
11.28	160	220	1026
12.01	160	220	1006
	-	-	20
12.13	160	220	900
	- -		106

Хүснэгт 1. Органик эдлэлүүдийн хаталт ба талсжих явц

Үр дүн: Сарьдагийн хийдийн модон эдлэл нь усны агууламж багатай тул олдворт сахарын уусмалын шингэлт сөргөөр нөлөөлөх талтай байсан учир усанд хөвж гарч ирсэн олдворын дээр таг тавьж хүндийн даралтыг үүсгэж дотогш живүүлэн сахарыг олдворын гүнд улам их шингээхийг зорьсон юм. Модон эдлэлийн усны агууламж өндөр байсан бол сахарын уусмал усыг шахаж оронд нь түрж орон талст үүсгэн усны үлдээсэн зайд

шингэн орж хатуу төлөвт шилжин бэхжих боломжтой байх байлаа.

Сахарын уусмалд хийсэн олдворуудаа 14 хоногийн дараа баннаас гаргахад гадаргууд сахарын гялтганасан хайлмаг бүрхсэн байв. Олдворын шингэц, гадаргуу дахь хаталтыг тодорхойлохдоо анхны жин, бүрэн хатсаны дараах жин хоёрыг харьцуулан тогтмол жинд хүртэл өдөр бүр олдворын жинд хяналт тавьж (зураг 5) баримтжуулах энгийн аргыг туршсан билээ. Энэ нь олдворт сахар нэвчин орж талст үүсч байгааг өдөр тутмын жин хэмжилтийн аргачлалаар бүрэн хянах боломжтой үйл явц юм. Бид дээрх олдворуудаа гаргаж өрөөний температурт хүйтнээр үлээх сэнсний дор хатааж ууршуулан өдөр бүр жигнэн өөрчлөлтийг 1 сарын хугацаанд ажиглав. Эдгээр модон олдворуудын хувьд өнгөний өөрчлөлтгүй, гадаргуу нь сахарын уусмалын царцмаг бүхий цагаан талстаар цайрсан, урт өргөний өөрчлөлтгүй байна.



Зураг 5. Хаталт ба жигнэх аргачлал

Одоогоор дээрх дээж моднууд нь сахарын цагаан талстаар хучигдсан байдалтайгаар хадгалагдаж байгаа бөгөөд бид шаардлагатай үед сахарын талстыг хайлуулж үндсэн олдворыг харуулах боломжтой. Энэхүү аргыг Монгол нутгаас илэрсэн усны агууламж их, бага хэмжээтэй археологийн модон эдлэлүүдийг бэхжүүлэх журмаар ашиглаж байгаа учир цаашид модон эдлэлийн хадгалалт, нөхцөл байдалд нь тохируулан хялбар, хурдан энгийн арга зүйг боловсруулах сэргээн засварлалтын арга зүйн нэг дэвшил болж нутагших юм.


Трехалос сахарын уусмалд хийхийн өмнө

Хээтэй Модон эдлэл №9



Жин 1058 г

Модон эдлэл №8



Жин 264,96 г


Модон эдлэл №7



Жин 390,20 г

Трехалос сахарын уусмалд хийсний дараа

Хэтэй Модон эдлэл №9




Жин **900** г

Модон эдлэл №8



Жин **220** г

Модон эдлэл №7



Жин **160** г

Туршилтад орсон дээрх дээжүүд гадна тус оны малтлагаар илэрсэн хийдийн барилгын багана, хаалга, дээврийн мод зэрэг овор хэмжээ ихтэй олдворыг бүрэн хатааж цэвэрлэсний дараа этанол /C2H5OH/, Paraliod B72 /Acryloid/-ийн 5%-иар найруулсан уусмалаар гадна талаас нь олон удаа бэхжүүлж хадгалалтын арга хэмжээг авсан. Эдгээр олдворын хувьд овор хэмжээ том, халаагч танканд хийх боломжгүй, мөн хадгалалтын нөхцөл байдал сайн, одоогоор хими, физикийн урвалд орж гадаргууд нь өөрчлөлт ороогүй учир гадна талаас нь бэхжүүлэлтийн бодисыг түрхэх, шүрших аргаар бэхжүүлэлтийг хийж өгсөн. Манай орны нөхцөлд сан хөмрөгийн байрны хангамж хангалтгүй байдаг учраас гэрэл, чийг, дулаан, орчны агаараас шалтгаалан эдгээр олдворын бүтцэд өөрчлөлт орж муудах, хатах, тэлэх, хөгз, шавжинд идэгдэх зэрэг эрсдэл үүсэх боломжтой тул цаашид сан хөмрөгийн хадгалалт, зүй зохистой орчныг бүрдүүлэхэд анхаарал хандуулах нь хадгалалт хамгаалалтын нэн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Хадгалалт хамгаалалтын орчинг бүрдүүлэх:

Хайгуул, малтлагаар илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг нэг доор цуглуулж зохистой хадгалах, арчлан хамгаалах, судалгаа шинжилгээ хийх газрын нэг бол сан хөмрөг юм.

Сан хөмрөгийн хадгалах орчин нь эд өлгийн зүйлийг муутгадаг бүхий л нөлөөнөөс хамгаалагдсан байх, агаарын хэм чийгшил, гэрэлтүүлэг, бохирдлыг зохицуулсан байх, тухайн эд өлгийн зүйлд зориулсан бичил орчныг бий болгох зэрэг маш олон шалгуур үзүүлэлт, хадгалалтын горимыг шаардаж байдаг.

Археологийн дурсгалаас илэрч буй органик эдлэл, тэр дундаа модыг урт хугацаанд хадгалж хамгаалах горим нь гэрэлтүүлэг 50 люксээс доош, +14 +180С-ийн дулаантай, харьцангуй чийгшил 50-60% байх нь зохистой хэмээдэг.

Археологийн малтлагаас илрэх цагаас эхлэн орчны байдлыг түр хадгалах, стандартын сав боодол бэлтгэх, гаднын нөлөөллийг багасгах, тээвэрлэх явцад анхаарах, сан хөмрөг болоод, үзмэрийн танхимд таатай орчныг бүрдүүлэх, гэрэл, гэрлийн тусгалыг тохируулах, халуун дулаан чийгшлээс үүсэх мөөгөнцөр, хорхой шавжнаас үүдэлтэй олдворыг гэмтээх нөхцлийг судлах, гадаад орчны нөлөөлөл, нян бактери, агаарын органик хүчлүүд зэрэг олон талын сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлийн нарийн судалгааг хийх зайлшгүй шаардлага тулгарч [нар 2011] байна. Хадгалалт хамгаалалтын шинжлэх ухаан нь бүхий л төрлийн судалгааны арга зүйг шаарддаг тул өөрийн оронд тохирох арга зүйг боловсруулах, соёлын үнэт өвийг хадгалах, сурталчилан таниулах, өвлүүлэн үлдээхэд энэхүү салбарын үүрэг оролцоо чухал ач холбогдолтой билээ.

Дүгнэлт

Сарьдагийн хийдийн археологийн малтлага судалгаагаар илэрсэн модон олдворуудад хадгалалт хамгаалалтын Трехалос сахарын уусмалын арга зүйг туршин судалсны үр дүнд модон олдворууд нь гадаргуудаа сахарын уусмалын царцмаг бүхий цагаан талстаар бүрхэгдэж цайрсан, 160-900г хүртэлх жинд хүрч тогтож хатсан, урт өргөний өөрчлөлтгүй байв. Энэ арга нь энгийн хялбар ажиллагаатай, дахин цэвэршүүлж ашиглах боломжтой, хүний биед хоргүй, зэрэг давуу талуудтай болохыг манай судалгаа баталж байна. Талсжилтын явцын үр дүнгээс харахад Трехалос сахарын уусмал нь модны усны агууламжийг маш тогтвортойгоор гадагшлуулан усны эзлэхүүн болон модны эсийн хөндий, агаарын хэсгүүдийн оронд орж байгаа нь судалгааны явцад мэдэгдэж байна. Цаашид Трехалос сахарын уусмалыг ашиглан археологийн модон эдлэл бэхжүүлэх аргыг туршилт судалгаанд илүү өргөн цар хүрээтэй хэрэглэх шаардлагатай нь бидний судалгаа харуулж байна.

THE USE OF “TREHALOS” SUGAR SOLUTION FOR PRESERVATION OF WOODEN ARTIFACTS FOUND FROM SARIDAG

N.Nandintsetseg, M.Oyuntulga

Keywords: Saridag Monastery, Wooden object, Preservation, Treatment, Consolidation, Trehalose method

In this article, we introduce our research result of Trehalos (C2H22O11) sugar solution method for conservation of the construction wooden objects and wooden ornaments. The 2015-2017 excavation of the Saridag Monastery. Saridag Monastery was founded by Undur Gegeen Zanabazar in 1654-1686 and it is located in Erdene soum, Tuv province. The advantage as a result of our research, we conclude that of Trehalos sugar solution method is non-toxic, simple, cheap and very suitable for the preservation organic materials. Wooden artifacts in such conditions can only keep their value through dimensional stabilization treatment this process not only removes moisture without causing the wood to change its shape but also reinforces the weakened wood.

Ашигласан эх сурвалж

Даваадарь 2014-2019 - Даваадарь, С. Археологийн органик эдлэлд Трехалос сахарын уусмал ашиглах нь. //Соёлын өвийн мэдээ мэдээлэл. УБ., 2014-2019/1. №8. т. 47-42

Даваадарь нар 2018 - Даваадарь, С., Бат-Эрдэнэ, Н., Оюунтулга, М., Сэцуо Имазу., Коужи Ито., Хироаку Фүжита. Археологийн малтлага судалгаагаар илэрсэн модон эдлэлийн хадгалалт хамгаалалтын асуудалд. (Айрагийн гозгорын жишээн дээр). //Монголын археологи - 2017 эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2018. т. 214-217.

Мөнхтогоо нар 2012 - Мөнхтогоо, Д., Эрдмаа, Д., Музейн сан хөмрөгийн хадгалалт гарын авлага. Монголын үндэсний музей. УБ., 2012. т. 12-19

Нялхай нар 2014 - Нялхай, Х., Цэндсүрэн, Т., Мод боловсруулах технологи. УБ., 2014. т. 22-24

Нямдорж нар 2019 - Нямдорж, Д., Анхсанаа, Г., Оюунтулга, М., Археологийн малтлагын үед олдворыг хадгалах, хамгаалах арга зүйн зөвлөмж. Соёлын өвийн үндэсний төв. УБ., 2019

Оюунтулга 2016 - Оюунтулга, М., Модон эдлэлийн хадгалалт хамгаалалтанд “Трехалос” сахарын уусмалыг ашигласан судалгаа (тал хээрийн бүсийн олдворын жишээн дээр). //Музей судлал. Том. XVII, fasc.29. УБ., 2016. т. 248-249

Оюунтулга 2019 - Оюунтулга, М., Монгол нутаг дахь тал хээрийн бүсээс илэрч буй модон эдлэлийн хадгалалт хамгаалалтын арга зүй. –“Хүрэл тогоот - 2019” эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 129-130

Сайнбаяр 2016 - Сайнбаяр, С., Дендроархеологийн судалгаанд үндэслэн ойн түүхийг сэргээн босгох нь (Сарьдагийн хийдийн жишээ). Магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС, ХШУИС, Хүрээлэн Буй Орчин Судлал, Химийн Инженерчлэлийн Тэнхим. УБ., 2016

Чулуун нар 2016 - Чулуун, С., Энхтуул,Ч., Нандинцэцэг, Н., “XVII зууны Монголын хотууд” төсөл.Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Археологийн дурсгалаас илэрсэн модон олдворын бэхжүүлэлт, хадгалалт хамгаалалтын тайлан. АХГБС. УБ., 2016.

Чулуун нар 2017 - Чулуун, С., Энхтуул,Ч., Нандинцэцэг, Н., “XVII зууны Монголын хотууд” төсөл Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. “Трехалос” сахарын уусмалын хадгалалтын арга зүйг ашиглан модон эдлэлд бэхжүүлэлт хийх нь. АХГБС. УБ., 2017.

Чулуун 2019 - Чулуун, С., Сарьдагийн хийд, Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн хийд. УБ., 2019. т. 382-387

Г. ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙД ХИЙСЭН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХЭМЖИЛТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Abstract: Three types of detector tubes were placed inside display cases, in the galleries, collection storage rooms, and outside of the Zanabazar Fine Arts Museum to measure the Ammonia NH3, Formaldehyde, R-CHO, Organic acid R-COOH. The level of concentration differed depending on the duration and location.

From the measurements it was determined that the air quality level was stable when there were no visitors, but higher than standard levels when the halls were busy, therefore, the gas from the breaths of the visitors affects the objects in the galleries. Having free-entry for all events once a year poses numerous risks and negative impacts on silk-appliques, thangka paintings that are displayed without casing.

It is commendable that the Zanabazar Fine Arts Museum was able to conduct air quality measurements with the latest, Japanese made, ASP-1200 air sampler with the international ISO 14000 environmental standard.

The current study allowed to determine the level of contamination in the air surrounding objects in the collection storage, display cases, and on display. The study was important in ways that it allowed, for the first time, to gain information on, to control, and prevent further risks posed on objects and makes repeat comparative studies possible to determine results.

Түлхүүр үг: Аммиак, органик хүчил, формальдегид- мэдрэгч шил, ASP-1200 агаар сорогч багаж, үзмэрийн агаарын бохирдол

Удиртгал

Музейд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлуудын нэг нь үзмэр, эд өлөг, соёлын өв, музейн цуглуулгад хадгалалт хамгаалалтын тогтвортой орчин бүрдүүлэх юм. Монголын музейнүүд өөрсдийн боломжид тулгуурлан механик арга хэрэглэн хадгалалт хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан бөгөөд 1990-ээд оноос эхлэн гадаад дотоодын олон улсын стандартад нийцсэн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдан хадгалалт хамгаалалтын орчноо сайжруулж эхэлсэн. Жишээлбэл: Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн хувьд анх 1998 онд АНУ-ын Сан-Францискогийн “Азийн урлагийн сан”-гаас хэрэгжүүлсэн төслөөр үзмэрийн хадгалалтын аюулгүй байдлыг бий болгох зорилгын хүрээнд сан хөмрөгийн зориулалтын төмөр тавиур, шүлтгүй хатуу цаасаар бөс даавуун эдлэлд хайрцаг хийж, 2005-2010 онд ЮНЕСКО-гийн “Соёлын өвийг хамгаалах ба музейг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд үзмэрийн бүртгэлийн баримт бичгийн хадгалалтыг сайжруулах, бүртгэл мэдээллийн санг тоног төхөөрөмжөөр хангах, дохиоллын систем шинэчлэх, үзмэрийн орчныг хянах гол хэрэгсэл гэрэлтүүлэг, чийгшил хэмжигч тоног төхөөрөмж, биологийн бохирдлоос хамгаалахын тулд барилгын цонх болон тоос шороо нэвтрэх боломжтой бүхнийг битүүлэх, файлын шүүгээнд буй үзмэрт шүлтгүй цаасаар хамгаалалт хийх, ил үзмэрт бүтээлэг хийх зэрэг ажлыг хэрэгжүүлж хадгалалтын орчноо сайжруулж ирсэн билээ (Уранчимэг. Лхагвадулам., (2011:104-106)

Энэ мэтчилэн монголын музейнүүд үзмэрийн чийгшилт, агаарын хэм, хорхой шавьж, биологийн бохирдол, механик нөлөө зэрэг хадгалалтын орчинд анхаарал хандуулан ажиллаж ирсэн боловч үзмэрийн орчны агаарын бохирдлын судалгааг хийхгүй байгаагаас үүдэж музейд хадгалагдаж буй соёлын биет өв орчны нөлөөллийн эрсдэлд өдөр бүр тогтмол орсоор байна.

Үзмэр, соёлын өвийг муутгахад нөлөөлж буй хорт хий үүсгэх гол хүчин зүйл нь барилгын цемент, музейн үзүүллэгийн танхим, шилэн хорго хийхэд ашигласан материал, зориулалтын бус цавуу, жижиг эд ангиуд мөн музей үзэж буй үзэгчид ч нөлөөлдөг. Иймээс музейд болон үзмэрт учирч буй хорт хийн эх үүсвэр болоод тэдгээр нь ямар төрлийн хийнээс болж буйг ялган төрөлжүүлж, мэдэх шаардлага урган гарч ирнэ. Учир нь металл

болон органик эдлэлд муугаар нөлөөлдөг гурван хүчил байдаг. Үүнд: аммиак, органик хүчил, формальдегид (Цууны хүчил, шоргоолжны хүчил, азотын исэл) ордог.

Дээрх гурван хүчлийн агаар дахь хэмжээ ихэсвэл цавуулаг нь соёлын өвийг хагалах, хатаах мөн уран зургийн өнгө будаг болон металлтай урвалд орж тугалганы ацетат, хар тугалганы формац болж үзмэрийн гадаргууг харлуулах, өнгийг гандаах, органик үзмэрийг хэврэг болгох, металл эдлэлийг зэврүүлэх, цаашилбал соёлын биет өв устаж үгүй болох эрсдэлийг бий болгож байдаг.

Нэгэнт тогтворгүй орчны нөлөөллөөс болж муудсан соёлын биет өв материалын байдлаас шалтгаалж дахин сэргээж хадгалах боломжтой үзмэр ч бий, сэргээн засварлах боломжгүй эмзэг үзмэр ч байдаг (Оюунтулга нар., 2019:243). Үүнээс сэргийлэхийн тулд тухайн соёлын өвийн орчны агаарын бохирдлын хэмжээ ихэссэнээс болж муудах, устах эрсдэл буйг стандарт хэмжигч багажаар хянах бүрэн боломжтой тул тус багажаар хэмжилт судалгаа хийж, эрсдлийн тунг тогтоох, хянах, цаашид харьцуулсан суурь судалгаа болгоход гол анхааарлаа хандуулахыг зорьсон билээ.

Судалгааны арга зүй

Агаарын бохирдлын хэмжилтийг урьд өмнө суурин багажит дүн шинжилгээгээр урт хугацааны ажилбар ихтэй арга зүйд суурилсан Ион хроматографи гэдэг багажаар хэмжилт хийдэг байсан учираас музейн салбарт төдийлөн нийтлэг ашиглах боломжгүй байсан.

Харин сүүлийн жилүүдэд агаарын бохирдлын хэмжилтийг Япон улсын Китагава -“Komyo Riagaku Kogyo” ХХК-ны агаар сорогч ASP-1200 зөөврийн багажаар хийж байна. 2010-аад оноос эхэлж энэ төрлийн судалгааг Японы ихэнх музей, судалгааны хүрээлэнгүүдэд сан хөмрөг, үзмэрийн хорго, үзэсгэлэнгийн танхимд хийж эхлэх боломжтой болсон

Одоогоор эдгээр судалгаанаас хамгийн өргөн хэрэглэгдэж буй орчин үеийн шинэлэг ажилбар бол хүрээлэн буй орчны нөлөөллийн судалгаа юм. Уг судалгааг дээрх багажаар тогтоох нь үр дүнтэй бөгөөд сонгодог аргын нэг гэж үзлээ. Энэ нь музейн үзмэрийн агаарын бохирдол болоод хүрээлэн буй орчинд байх бохирдлын зэргийг төрөлжүүлэн судалж, тэдгээр нь дурсгалд хэрхэн муугаар нөлөөлж байгааг шинжлэн тогтоох үйл ажиллагаа юм (Оюунтулга нар., 2018:254)

Судалгаа явуулсан орчны онцлог; Бид туршилт судалгааг Дүрслэх урлагийн музейн сан хөмрөг, үзүүллэгийн танхим, үзмэрийн хорго, гадна орчинд 2018 оны 8 сард гүйцэтгэсэн ба тус хэмжилт судалгаагаар музейн сонгосон орчинд үзмэрийн бохирдол ямар тун хэмжээтэй буйг судлан тогтоосон болно.

Музейд бохирдлын тунг тогтоох хэмжилт судалгааны аргыг туршсан аргачлал:

Тус судалгаанд Япон улсад үйлдвэрлэсэн, Японы музейн стандартад нийцсэн агаарын бохирдлыг хэмждэг ASP-1200 багажаар гурван төрлийн Формальдегид R-CHO, Органик хүчил R-COOH, Аммиак NH3 гэсэн хүчил хэмжигч шилэн тестийг ашиглан хэмжилт судалгааг гүйцэтгэв.

Уг музейн судалгаанд хэрэглэж буй багаж нь овор хэмжээ багатай, зөөж тээвэрлэхэд хөнгөн, музейн мэргэжилтнүүд хэрэглэхэд хялбар тул заавал мэргэшсэн хүн хийх бус музейн мэргэжилтнүүд зааврын дагуу хийж болдог учир давуу талтай юм.

Хэмжилт судалгааг дараах аргын дагуу гүйцэтгэв.

Үзмэрийн агаарын бохирдлын хэмжилтийг хийх арга- Агаар сорогч багажны сорох хэсэгрүү 3 төрлийн мэдрэгч хуруу шилний үзүүрийг хийж байрлуулна, тестны шил нь халууны шил шиг дотроо мэдрэгчтэй, тестны шилэнд агаар орж, бохирдлын тун нь гадна талд байх тоогоор илэрхийлэгдэнэ. Хэмжилт хийх цаг хугацаа, ажиллуулах горим агаар сорогч багажин дээр тус тус тэмдэглэгдсэн байдаг.

Үүнд: Агаар сорогч ASP-1200 багаж 2 ширхэг, Формальдегид R-CHO, Органик хүчил R-COOH, Аммон NH3 гэсэн хүчил хэмжигч шилэн тест-12 ширхэгийг ашиглаж, төлөвлөсөн хэсгүүдэд зай талбай харилцан адилгүй хэмжээнд 15 минут, 30 минут, 1

цаг, 18 цагийн хугацаатай хийж нийт 4 хувилбараар ажиглан бохирдлын хэмжээг тус тус хэмжин тэмдэглэсэн.

Дүрслэх урлагийн музейд хийсэн үзмэрийн агаарын бохирдлын хэмжилт, судалгаа ба үр дүн

Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд Японы физик орчны судалгааны хүрээлэн ХХК, орчны бохирдол судлах хүрээлэнгийн захирал, хорхой шавьж, соёлын биет өвийн хадгалалт орчны судалгааны арга зүйч Масахико Ямазаки, Японы Нара их сургуулийн хадгалалт хамгаалалтын тэнхим М.Оюунтулга нартай хамтарсан судалгааны ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: музейн гадаад урлагийн сан хөмрөг (№106), Занабазарын урлаг үзүүллэгийн танхим дахь Цагаан дарь эхийн хорго (металл, хүрэл), үзүүллэгийн танхим, Монгол зургийн танхим дахь Лойлин (мод, металл), музейн гадна орчин гэсэн 4 хэсэгт ASP-1200 багажаар агаарын бохирдлыг хэмжих гурван төрлийн Формальдегид, R-CHO, Органик хүчил R-COOH, Аммон NH3, PM2,5 гэсэн хүчил хэмжигч тестээр хэмжилт, судалгаа хийж тунг тогтоов.

Хүснэгт 1. Музейн материал хадгалах онол-Соёлын үнэт зүйл ба агаарын бохирдол сэдэвт 2010 оны Сано Чиэгийн гаргасан *Японы музейн стандарт дахь 5 төрлийн хүчлийн хэмжээг хүснэгтээр харуулав.*

№	Хүчлийн нэр	Химийн томъёо	Стандарт хэмжээ	Эзэлхүүн
1.	Шоргоолжний хүчил (органик хүчил)	HCOOH	10ppb	20 mg/m^3
2.	Цууны хүчил (органик хүчил)	CH3COOH	170 ppb	430 mg/m^3 192
3.	Аммиак	NH3	30ppb	22 mg/m^3
4.	Формальдегид	R-CHO	80 ppb	100 mg/m^3
5.	Ацетальдегид (органик хүчил)	CH3CHO	30ppb	48 mg/m^3

Монголын музейнүүдэд хүрээлэн буй орчны хорт хийн судалгаа байдаггүй учир Японы ерөнхий стандартад тулгуурлан хэмжилт хийсэн болно. Жишээ:нь Органик хүчлийн найрлагад байх шоргоолжны хүчлийн 1% нь цууны хүчлийн 9%-тай тэнцдэг гэсэн судалгаа (Оюунтулга нар., 2018:256) байдаг.

1. Дүрслэх урлагийн музейн гадаад урлагийн сан хөмрөг (№ 106) өрөөнд хийсэн хэмжилт:

Хэмжилт хийсэн огноо. 2018. 8 дугаар 29.

Хэмжилт хийсэн цаг- 10.30-11.30 хэмжилтийн хугацааг 1 цагийн горимд байрлуулсан. Доорх хүснэгтүүдэд буй хорт хийн хэмжээг “ppb”нэгжид хувирган бодож гаргасан.

Хүснэгт 2. Сан хөмрөг № 106 уран зургийн орчинд хийсэн 1 цагийн хэмжилт

№	Сорилын төрөл	Стандарт	Сан хөмрөгийн тун	Сорилын тун
1	Аммиак NH3 Ammonia	30 ppb	24 ppb	Бага
2	Формальдегид, R-CHO Formaldehyde	80 ppb	80ppb	Хэвийн
3	Органик хүчил R-COOH Organic acid	170 ppb	192ppb	Стандартаас ялимгүй их

Гадаад урлагийн сан хөмрөг (№106)-ийн өрөөнд Энэтхэг, Хятад, Болгар, Хятад зэрэг гадаад орнуудын гар урлалын бүтээлүүд, уран зураг, тосон будаг, мод, шаазан, яс, шир, метал зэрэг холимог материалтай үзмэр хадгалдаг ба чийгшил, агаарын хэм нь стандарт хэмжээнд нийцсэн байв. Сан хөмрөгийн өрөөн дэхь хэмжилтийг эх уран зургийн тавиурт хийв. Дээрх гурван төрлийн мэдрэгч шилээр сорил тавихад органик хүчил ялимгүй их тунтай байв. Жилийн дөрвөн улиралд хийх тул улирлын онцлог цаг агааараас шалтгаалаад хэмжилтийн тун өөр гарна гэж үзсэн тул дахин хэмжих шаардлагатай.

2. Дүрслэх урлагийн музейн үзүүллэгийн танхимд хийсэн хэмжилт Хэмжилт хийсэн огноо. 2018. 8 дугаар 29.

Хэмжилт хийсэн цаг- 1455-1600 хэмжилтийн хугацааг 1 цагийн горимд байрлуулсан.

Хүснэгт 4. Занабазарын бүтээлийн танхимд хийсэн 1цагийн хэмжилт

№	Сорилын төрөл	Стандарт	mg^{m3}	Ppb
1	Аммиак NH3	30 ppb	50 $мg^{m3}$	70 ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb	270 $мg^{m3}$	30 ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	0,04mg ^{m3}	100 ppb

Занабазарын бүтээлийн танхимд: Тус танхимд танка зургууд, барын дардас, мод, металл зэргээр хийсэн янз бүрийн материалаар хийгдсэн үзмэр дэглэгдсэн. Энэ удаагийн хэмжилтийг шилэн хоргонд бус тус үзүүллэгийн танхимд нийтэд нь агаарын бохирдол ямар байгааг хэмжсэн. Хэмжилт хийх 1 цагийн хугацаанд танхимд үзэгчтэй байсан. Мөн л агаар сорогч багажаар дээрх гурван төрлийн мэдрэгч шилээр тест тавьсан дүнгээс харахад Аммиакийн хий стандартаас ялимгүй их, Формальдегид болон Органик хүчил стандартаас бага гэсэн үзүүлэлттэй гарсан.

3. Дүрслэх урлагийн музейн үзмэрийн шилэн хоргуудад хийсэн хэмжилт

Хэмжилт хийсэн огноо: 2018. 8 дугаар 29-30

Хэмжилт хийсэн цаг: 1445-1600 хэмжилтийн хугацааг 15 минут, 1600-1700 1 цаг, 18 цагийн горимд тус тус байрлуулав.

Шилэн хорготой үзмэрүүдээс Занабазарын бүтээлийн танхимд байрлах музейн хосгүй үнэт үзмэр Цагаан дарь эх бүтээлийг сонгон авч шилэн хоргон дахь агаарын бохирдлыг 3 янзын байдлаар хэмжилт хийсэн. Цагаан дарь эх бүтээлийн шилэн хоргонд эхний удаа 15 минутын хугацаатай хэмжилт хийв.

Хүснэгт 5.1 Цагаан дарь эх шилэн хоргонд хийсэн 15 минутын хэмжилтийн үр дүн

№	Сорилын төрөл	Стандарт	mg^{m3}	Ppb
1	Аммиак NH3	30 ppb	10 $мg^{m3}$	56,44ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb	0,09 $мg^{m3}$	180ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	200mg ^{m3}	560 ppb

Судалгааны баг Цагаан дарь эх үзмэрийн хоргонд 15 минутын хугацаатай хэмжилт хийхэд Аммиак стандарт хэмжээнээс 1 дахин их, Формальдегид мөн 1 дахин их, Органик хүчил 2 дахин их хэмжээний бохирдолтой гарсан. Үзмэрийн шилэн хоргоны агаарын бохирдол их тунтай гарсан нь хоргоны материал, цавуунаас ялгарч буй хор нөлөөлсөн, мөн хоргыг байнга онгойлгож агаар оруулдаггүй зэргээс үүдэлтэй юм. Учир нь зориулалтын бус материалаар хийгдсэн хоргонд бохир агаар исэлдэж, үзмэртэй урвалд орж үзмэрт муугаар нөлөөлж гэмтээж байна гэсэн үг.

Хүснэгт 5. 2 Цагаан дарь эх шилэн хоргонд 1 цагийн хэмжилтийн үр дүн

№	Сорилын төрөл	Стандарт	mg^{m3}	Ppb
1	Алмони NH3	30 ppb	40 $мg^{m3}$	56 ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb	0,1х2 ppm	200 ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	200х10=2000 $мg^{m3}$	800 ppb

Цагаан дарь эхийн барималын шилэн хоргонд 15 минутын хугацаатай хэмжилт хийхэд гурван төрлийн мэдрэгч тестны үр дүн стандарт хэмжээнээс 1,2 дахин их бохирдолтой гарсан бол хугацааг нь уртасгаж 1 цагийн хэмжилт хийхэд Аммиакийн хий 1 дахин, Формальдегид- 3 дахин, Органик хүчил- 6 дахин их бохирдолтой үзүүлэлт гарлаа.

Цагаан дарь эхийн барималын шилэн хоргонд 15 минутын хугацаатай хэмжилт хийхэд гурван төрлийн мэдрэгч тестны үр дүн стандарт хэмжээнээс 1,2 дахин их бохирдолтой гарсан бол хугацааг нь уртасгаж 1 цагийн хэмжилт хийхэд Аммиакийн хий 1 дахин, Формальдегид- 3 дахин, Органик хүчил- 6 дахин их бохирдолтой үзүүлэлт гарлаа.

Хүснэгт 5.3 Цагаан дарь эх шилэн хоргонд (орчинд нь хонуулаад хэмжилт хийсэн үр дүн)

№	Сорилын төрөл	Стандарт	mg^{m3}	Ppb
1	Алмони NH3	30 ppb	40 $мg^{m3}$	56 ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb	0,1х2 ppm	200 ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	200х10=2000 $мg^{m3}$	800 ppb

Цагаан дарь эх баримлын шилэн хоргонд нийт 3 удаа хэмжилт хийв. Нэг үзмэрийн шилэн хоргонд 3 янзын хувилбараар хэмжилт хийж үзэхэд хугацаанаас шалтгаалаад бохирдлын тун өөр өөр үзүүлэлттэй байлаа. Үүнээс үзэхэд хоргонд агаар оруулахгүй удах тусам, зориулалтын бус хоргоны материалаас үүдэж бохирдлын тун их гарч үзмэр, соёлын өвд муугаар нөлөөлж байгааг энэ удаагийн туршилтын хэмжилтээс харж болно.

Хүснэгт 6. Цамын танхимын том шилэн хоргонд (11:00-12:00) хийсэн 1 цагийн хэмжилт

№	Сорилын төрөл	Стандарт	mg^{m3}	Ppb
1	Аммиак NH3	30 ppb	22,2$мg^{m3}$	62 ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb	0,05 mg ^{m3}	50 ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	120х2,5$мg^{m3}$ /300	120 ppb

Дүрслэх урлагийн музейн цамын танхимд байрлах цамын хувцас, хэрэглэл дэглэсэн шилэн хоргонд туршилтын хэмжилт хийв. Тус шилэн хоргонд буй үзмэрүүд нь органик буюу даавуун эдлэл, бөс даавуун материал мөн металл эдлэлээс бүрдсэн. Цамын хувцас дээл дэглэсэн маникен буюу сууринд нь мод, цавуу зэрэг материал орсон ба шилэн хоргыг бас цавуугаар нааж хийсэн байдаг. Тус цамын хоргонд хэмжилт хийхэд стандарт хэмжээнээс Аммиак- 1 дахин их, Формальдегид- стандартаас харьцангуй бага харин Органик хүчил мөн стандарт хэмжээнээс бага бохирдолтой үзүүлэлт илэрсэн.

Лойлин /Хот мандал/ шилэн хоргонд хийсэн хэмжилт
Хэмжилт хийсэн огноо. 2018. 8 дугаар 29.
Хэмжилт хийсэн цаг- 1335-1435 хэмжилтийн хугацааг 1 цагийн горимд

байрлуулсан.

Тус шилэн хоргонд 1900-аад оны эхэн үед монгол гар урчуудын хийсэн цагийн хүрд бурханы хот мандалыг мод, шавар, металл гэх мэт материал оруулан бодитоор хийсэн үзмэр байдаг. Үзмэрийн шилэн хоргонд агаар сорогч багаж, Аммиак NH3, Формальдегид, R-CHO, Органик хүчил R-COOH гэсэн 3 төрлийн мэдрэгч шилээр хэмжилт хийхэд Аммиак-37.8 ppb, Формальдегид-80 ppb, Органик хүчил-250 ppb хэмжээтэй байгаа нь органик хүчил өндөр хэмжээтэй гарсан.

Хүснэгт 7. Үзүүллэгийн шилэн хорго Лойлон дотор хийсэн 1 цагийн хэмжилт (13^{35}-14^{35})

№	Сорилын төрөл	Стандарт	Сорилын тун	Сорилын тун
1	Аммиак NH3	30 ppb	27мg m^3	37.8 ppb
2	Формальдегид, R-CHO	80 ppb		80 ppb
3	Органик хүчил R-COOH	170 ppb	400мg m^3	250 ppb

4.Музейн гадна орчинд хийсэн хэмжилт

Хэмжилт хийсэн огноо: 2018. 8 дугаар 30

Хэмжилт хийсэн цаг: 1230-1330 хэмжилтийн хугацааг 1 цагийн горимд тавив.

Дүрслэх урлагийн музей нь замтай ойр учир бид энэ удаагийн хэмжилтийг музейн гаднах орчинд хийхээр сонгосон юм. Музейн гаднах хашаанд харуулын байрны ойролцоо муу усны хоолой байрлах орчимд агаар сорогч багажаар 3 төрлийн мэдрэгч шилээр 1 цагийн хугацаатай тест тавихад Аммиак, Формальдегид, Органик хүчил гурвуулаа стандартаас бага тунтай нөлөөллийн өөрчлөлтгүй гарсан. Улирлаас шалтгаалаад бохирдлын хэмжээ өөр өөр гарах тул өвлийн улиралд дахин хэмжилт хийх хэрэгтэй гэсэн дүгнэлт гарав.

Хүснэгт 8 . Музейн гадна орчинд орчинд хийсэн 1 цагийн хэмжилтийн үр дүн (12^{30}-13^{30})

№	Сорилын төрөл	Стандарт	Гадаах орчны тун	Сорилын тун
1	Аммиак NH3	30 ppb	ppb	Бага
2	Формальдегид, R-CHO	80 ppb	ppb	Бага
3	Органик хүчил R-COOH	170 ppb	ppb	Бага

Бидний хийсэн үзмэрийн агаарын бохирдлын тунг тогтоох хэмжилт судалгаагаар 4 өөр цэгт, цаг хугацааны хувьд ялгамжтай хийж тэмдэглэн үзэхэд: Музейн үзүүллэгийн танхимд хэмжилт хийхэд агаарын бохирдлын хэмжээ стандарт хэмжээнээс бага тунтай, гадаад урлагийн сан хөмрөгийн хувьд мөн дээрх гурван төрлийн мэдрэгч багажаар тест тавихад японы стандарт судалгаатай харьцуулахад харьцангуй бага бохирдолтой, харин сонгон авсан үзмэрийн шилэн хоргуудад хийсэн хэмжилт судалгаагаар агаарын бохирдол стандартаас өндөр тунтай, музейн гадна орчинд бага тунтай үзүүлэлттэй байв.

Үүнээс харахад үзүүллэг дэглэлтэд, шилэн хоргонд буй үзмэрүүдийн агаарын бохирдол их тунтай гарлаа. Энэ нь хоргоны зориулалтын бус материал, цавуу, хавтан гэх мэтээс, мөн шилэн хоргонд агаарын бохирдлыг шингээж авах шүлтгүй цаас мэт байхгүй, удаан хугацаагаар агаар оруулдаггүй зэргээс шалтгаалж соёлын өвд гэмтэл учирах эрсдэл буйг мэдэж авлаа.

Иймээс музейнүүд шилэн хорго руу анхаарал хандуулан цаашдаа тус багаж төхөөрөмжөөр жилийн дөрвөн улиралд тогтмол хэмжилт хийх шаардлагатай.

Харьцуулсан судалгаа хийснээр үзмэрт хэдий хугацаанд ямар гэмтэл учирч болохыг мэдэхээс гадна түүний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж чадна.

Цаашид үзмэрийн агаарын бохирдлыг хүчил сорогч шүлтгүй цаас, цэвэр агаарын урсгал ашиглах ч юм уу агаар сэлгэлтийг хийж сан хөмрөг, шилэн хорго, үзмэрийн танхим зэрэгт 4 улирлын судалгаа хийж үр дүнг харьцуулсан байдлаар гаргах нь чухал байна.

Бохирдлын судалгаа хийсэн багаж, төхөөрөмжийн танилцуулга, загвар

Бидний хэмжилт судалгаа хийсэн багаж төхөөрөмж нь Япон улсын Китагава- “Komyo Riagaku Kogyo” компаны бүтээгдэхүүн юм. Тус багаж төхөөрөмжийг Японы физик орчны судалгааны хүрээлэнгээс зохион бүтээсэн.

Зураг 1- Китагава “Komyo Riagaku Kogyo” Агаар сорогч багаж



Агаар сорогч багаж - ASP-1200

Нэр	ASP-1200
Хэмжих хүрээ	10~1200mL/min
Хэмжих орчин	0~40^0, 10~90%RH
Зайн тоогоор	4 ширхэг
Хэмжих цаг	Тогтмол 12 цагаас дээш
Хэлбэр хэмжээ	145(W)x54(D)x99(H)mm
Жин:	490g зай ороод

Багажны үзүүлэлт



Зураг 2. Китагава“Komyo Riagaku Kogyo” хорт хийн мэдрэгч тестерүүд

Хорт хийн мэдрэгч тестер: 3 төрлийн мэдрэгч шилэн тестер

1. Китагава органик хүчил мэдрэгч багаж –загвар 910

Китагава аммиак хийг хэмжигч багаж –загвар 900

Китагава формальдегид хийг хэмжигч багаж –загвар 710

- Органик хүчил мэдрэгч 910 загварын тестэр нь шоргоолжны хүчлийг
- формальдегид хүчил мэдрэгч 710 загварын тестер нь ацетальдегид C2H2O хүчлийг давхар мэдэрдэг учраас хорт хийн нийлбэрт тооцно(Оюунтулга нар., 2018:245).




Зураг.3 Органик хүчил мэдрэгч багаж – загвар 910



Хүснэгт 1. Органик хүчил мэдрэгч багаж 910 (Мэдрэгч багажны тайлбар)


Нэр	№910	Өнгөний хувирал	Ягаан -цайвар шар
Хэмжих хүрээ	10-10000mg/m^3	Хэрэглэх дулааны орчин	5-35^{0}C
Хэмжих хүрээ ба цаг	10-100mg/m^3 60 мин 25-1000mg/m^3 30 мин	Чийгшил	(20-80%RCH)
		Хүчинтэй хугацаа	3 жил
Агаарыг сорох хэмжээ	200 ml/ min	Хадгалах орчин	Гэрлээс хол(0-25^{0}C)



Зураг 4. Аммиак хийг хэмжигч багаж 900

Хүснэгт 2. Аммиак хийг хэмжигч багаж 900 (Мэдрэгч багажны тайлбар)

Нэр	№900	Өнгөний хувирал	Ягаан -цайвар шар
Хэмжих хүрээ	10-80 ug/m^3	Хэрэглэх дулааны орчин	10-40^{0}C
Хэмжих хүрээ ба цаг	10-80 ug/m^3 /60 min	Чийгшил	(10-90%RH)
	Хувьсах боломжтой	Хүчинтэй хугацаа	2 жил



Зураг 5. Формальдегид мэдрэгч багаж 710

Хүснэгт 3. Формальдегид мэдрэгч багаж – 710 (Мэдрэгч багажны тайлбар)

Нэр	№710	Өнгөний хувирал	Улбар шар-ягаан
Хэмжих хүрээ	0.01~0.48 ppm	Хэрэглэх дүлааны орчин	10~35^{0}C
Хэмжих хүрээ ба цаг	0.0~0.12ppm/30 min/	Чийгшил	(5~90%RH)
	0.0~0.48ppm/10min/	Хүчинтэй хугацаа	1 жил
Агаарыг сорох хэмжээ	300mL/min	Хадгалах орчин	0~10^{0}C



Үзүүллэгийн танхим, цагаан дарь эхийн шилэн хоргонд хийсэн хэмжилт



Гадаад урлагийн сан хөмрөгт хийсэн хэмжилт

Дүгнэлт

1.1 Дүрслэх урлагийн музейн гадаад урлагийн сан хөмрөгийн хувьд бусад цэгүүдтэй харьцуулахад аммиакийн хий, формальдегид хий бага харин органик хүчлийн тун стандартаас ялимгүй их тунтай байгаа нь агаарын урсгал бага, зориулалтын агааржуулагч байхгүй, битүү байдагтай холбоотой гэж үзэв. Органик хүчлийн хэмжээг стандарт болгохын тулд агаарын урсгалыг сайжруулах шаардлагатай мөн чийгшил, агаарын хэмийн хэлбэлзлийг анхаарах мөн агааржуулалт хийх, эрсдэлтэй нөхцөлд органик хүчил шүүгч шүлтгүй цаас / химийн хор сорогч цаас/ ашиглах нь зүйтэй.

1.2 Үзүүллэгийн танхимд хийсэн судалгаагаар формальдегид , органик хүчил стандарт хэмжээнээс бага тунтай байсан нь олзуурхууштай ч аммиакийн хий стандарт хэмжээнээс 1 дахин их тунтай байгаа нь мөн л агаарын урсгал бага, хэмжилт хийх үед танхимд үзэгчтэй байсан учир гадны нөлөөллөөс болж өндөр гарсан гэж үзсэн. Аммиакийн хийг багасгахын тулд химийн хор шүүгч тусгай бодис ашиглавал тустай.

1.3 Үзмэрийн шилэн хоргонд 3 хэсэг газар хэмжилт хийж үр дүнг нэгтгэсэн.

1.3.1 Эхний хэсэг нь цамын танхимын том шилэн хоргонд аммиакийн хий стандартаас өндөр тунтай гарсан нь гадны нөлөөлөлтэй буюу хорго нь зай завсар ихтэй, цонхны ойролцоо байрласан зэргээс шалтгаалсан гэж үзсэн. Аммиакийн хий их гарсан нь цонхны ойролцоо, авто замтай ойр байгаа учир машины тэсрэлтээс ялгарч байгаа утаан дотор азотын хүчил агуулагдаж байдаг. Азот нь үзмэрт ямар хор хөнөөлтэй вэ? гэхлээр металлыг зэврүүлэх, будгийг задлах, металлуудын өнгийг хувиргах чадвартай элемент учраас азотын тунг сайн хянах хэрэгтэй гэж үзлээ.

1.3.2 Хоёр дахь хэсэг буюу Лойлингийн хоргонд хэмжилт хийхэд аммиак, формальдегид стандарт хэмжээнд хэвийн харин органик хүчлийн хэмжээ өндөр тунтай гарсан нь тухайн үзмэрт орсон модны цавуу, металл эдлэл зэрэг материал, мөн гадны нөлөөлөл хоргоны шилний зай завсар нөлөөлсөн гэж үзсэн. Органик хүчлийг багасгахын тулд мөн л тогтмол хэмжилт хийж хянах, хор шүүгч тусгай бодис хэрэглэх нь чухал.

1.3.3 Гурав дахь хэсэг нь Цагаан дарь эхийн шилэн хоргонд хэмжээний хувьд ялгаатай 3 удаагийн хэмжилт хийхэд дээрх гурван төрлийн хүчил харьцангуй өндөр агууламжтай гарсан. Энэ нь шилэн хоргоны агаар бага, хоргыг хийсэн материалаас бохирдол үүссэн гэж дүгнэв. Цаашид дээрх гурван төрлийн хийг багасгахын тулд шилэн хорготой үзмэрт анхаарал хандуулах, агаарын бохирдлыг тогтмол хэмжин анализ хийх, шилэн хоргонд Кимикал paper буюу химийн хор сорогч цаас хийж бохирдлыг бууруулах нь зүйтэй.

1.4 Музейн гадна орчны бохирдлыг хэмжихэд Аммиак, Формальдегид, органик хийн хэмжээ бүгд стандарт хэмжээнээс бага тун үзүүлсэн. Энэ нь тухайн улирлаас шалтгаалаад бага тунтай гарсан гэж үзсэн. Өвлийн улиралд ч юм уу агаарын бохирдол ихтэй үед хэмжилт хийж харьцуулан тогтоох нь зүйтэй гэж үзэв.

Дүрслэх урлагийн музейн жишээн дээр 4 хэсэг газрын хэмжилтийн үр дүнгээс харахад. Үзмэр, соёлын өвд таатай хүрээлэн буй орчныг бүрдүүлэхийн тулд агаарын бохирдлын судалгааг стандарт хангасан дээрх тоног төхөөрөмжөөр тогтмол хэмжилт хийх, харьцуулан судлах нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Ерөнхийдөө музейн сан хөмрөг, үзүүллэгийн танхим, шилэн хоргоны цэвэр агаарын урсгалыг байнга сольж байх мөн тусгай агаар сорогч филтертэй шүүгч байрлуулж бохирдсон агаарын урсгалыг гаргаж, агаар солих нь чухал юм. Металл болон органик эдлэлд аюул учруулдаг хорт бодисыг багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй.

Монголд тус багажаар туршилтийн судалгаа хийсэн анхны музей бол Хархорум музей бөгөөд удаах нь Орхон аймгийн орон нутаг судлах музей дараа нь агаар сорох багажийг худалдан авч музей дээрээ хэмжилт судалгааны ажлыг эхлүүлэн тууштай судлах зорилт тавин ажиллаж буй Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей юм.

Манай музейн салбар үзмэрийн агаарын бохирдлын судалгаанд бага ч атугай анхаарал хандуулан эхлэл тавин ажиллаж байна.

Цаашид монголын бүх музейд энэ чиглэлээр голлон анхаарч дагнан тууштай, судлан, хэмжилт хийх, баг бүрдүүлэн ажиллах, туршлага солилцох, харьцуулсан судалгаа хийснээр соёлын өвд учирч болох эрсдлээс урдчилан сэргийлэх, орчны нөлөөллийг багасгах, үзмэрт тогтвортой орчин бүрдүүлэх суурь судалгааны нэгээхэн нь чухал ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Уг судалгаанд эхлэл тавиад зогсохгүй, бохирдлын судалгаа хийх хариуцсан ажилтанг гадаад, дотоодын сургалтанд хамруулж, мэргэшүүлэх, музейд хийгддэг өдөр тутмын ажлын нэг болгох, тогмолжуулах, асуудлыг зохистой шийдвэрлэхэд яам, агентлаги дэмжлэг үзүүлэн анхааран ажиллах нь чухал юм.

ЦААСАН СУУРЬТАЙ МАТЕРИАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Ном хадгалхад тохиромжтой газар

Номын санд шинээр бүртгэгдэн ирсэн болоод өмнө нь байсан ном зохиолыг нийтийн танхим болон сан хөмрөгийн тавиур тавцан дээр овойлгож дээр дээрээс нь тавих үзэгдэл багагүй байдаг болов уу. Цаасан суурьтай материалыг тохиромжтой газар хадгалах нь эмзэг төрөлд багтдаг цаасан материалыг удаан хугацааны туршид аюулгүй хадгалж авч үлдэх гол хүчин зүйл нь болдог. Тиймээс дараах зүйлүүдийг анхаарах зайлшгүй шаардлагатай.

Нарны шууд тусгалаас тусгаарлах

Нарны гэрэлд агуулагдах хэт ягаан туяа нь химийн өөрчлөлтийг үүсгэдэг учраас номын үндсэн өнгийг гандуулж цаасны чанарыг доройтуулж өөрчлөлтөд оруулдаг. Ихэнх тохиолдолд номын нуруу хавтас нь гандсан жишээ их тохиолддог. Тиймээс аль болох номын тавиуруудыг наранд ил гаргалгүй суулгаж, хэт ягаан туяаны хурц гэрэл тусгаарлах хөшиг ашиглан хааж, цонхондоо бууруулагч нааж хамгаалах хэрэгтэй. Эсвэл номоо хайрцаглах болон номын хавтас хийж хамгаалах хэрэгтэй.

Ном хадгалах орон зай

Ном нэмэгдэхийн хэрээр номын тавиуруудыг дүүргэж, хооронд нь хэт ойр бөөгнүүлж тавих нь агаарын урсгалыг хязгаарлаж чийг тоос шорооны хуримтлал үүсгэж хөгц мөөгөнцөр, нян бактери, хорхой шавьж үүсгэх гол хүчин зүйл нь болдог. Тиймээс аль болох агаар сэлгэлт сайтай газар номуудыг хэт шахалгүй тавих нь зүйтэй.

Агааржуулалт сайтай газар

Чийг бол цаасан суурьтай материалыг гэмтлийн эрсдэлд оруулах гол хүчин зүйл нь болдог. Цаас нь чийгийн нөлөөнд хөгцөрч хатуулаг шинж чанараа алдан үрчийж эхэлдэг. Тиймээс чийгшил дулааны хэлбэлзэл өндөр тогтворгүй орчинд хадгалахаас аль болох татгалзах хэрэгтэй. Ном хадгалахад тохиромжтой өрөө тасалгааны хэм нь 16-22 градус, чийгшил нь 40-60 хувь байх нь тохиромжтой гэж олон улсад үздэг. Чийгшлээс урьдчилан сэргийлэхийн тулд чийг сорох үйлчилгээтэй хатаагчийг бага тунгаар тавиурууд болон номуудын хооронд хавчуулж тавих хэрэгтэй.

Босоо байрлалтай хадгалах

Номын тавиур дээр зай багатай тохиолдолд хөндлөн хэлбэрээр дээр дээрээс нь тавих нь хялбар байдаг. Иймэрхүү байдалтай ном хадгалах нь даралтын нөлөөнд орж үрчлээ үүсгэж, агаарын урсгалыг хязгаарлах гол хүчин зүйл нь болдог учраас номыг босоо хэлбэрээр тавин хадгалах нь зохистой арга юм. Босоо хэлбэрээр хадгалж буй тохиолдолд номын тавиурууд хотойх зэрэг гэмтэл нь номын хэлбэр өөрчлөгдөхөд шууд нөлөөлөх учраас тавиуруудын гажилт гэмтлийг бас давхар хянах нь зүйтэй.

Тоос шороо болон шавьжны эсрэг авах арга хэмжээ

Цаасан суурьтай материалын гэмтээх эрсдэлд тоос шорооны бохирдол голлон нөлөөлдөг. Номын гадаргуу хэсэгт хуримтлагдсан тоос шороо нь хөгц мөөгөнцөр, шавьж үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Цаасны төрлийн шавьж номын завсраар орж цаасыг нүхлэн идэж, бичээс хэсгийн бэхний хэсгийг иддэг. Тиймээс урьдчилан сэргийлэх үүднээс химийн урвал үүсгэж номуудад толбо үүсгэх эрсдэлгүй шавьжаас хамгаалах бодис ашиглах, тоос шорооны гүн бохирдолд байнгын хуурай цэвэрлэгээ хийх шаардлагатай.

Номын давхар хавтас хийх

Бид номтойгоо хэчнээн болгоомжтой харьцсан ч механик гэмтлийн нөлөөллөөр шингэн зүйлийн толбо, тоос шороо гэх мэт эрсдэл учрах шалтгаан өндөр байдаг. Тиймээс хэрэглээнд байнга байдаг ном зохиолдоо номын хавтас, хальсаар бүрж учрах эрсдэлээс урьдчилан хамгаалах нь зүйтэй. Мөн ашиглагдахгүй номуудаа сав баглаа боодол хийж, эсвэл гялгар уутанд хийж битүүмжлэх нь илүү найдвартай.

Номын тавиурын зай хуваарилалт

Нийт номын тавиурын дүүргэлтийг 100 хувь гэж үзвэл 80 хувьд нь дүүргэлт хийж хязгаарлах хэрэгтэй. Үлдсэн 20 хувийг агаар сэлгэлтийн орон зай болгон үлдээх нь үзэмж талаасаа ч зохистой байж болох юм.

Ном тус бүрийг шалгах

Ил задгай болон номын шүүгээнд урт хугацаагаар ном хадгалах нь эрсдэлээс бүрэн хамгаална гэсэн үг биш юм. Тиймээс байнгын үзлэг шалгалтыг ном тус бүр дээр хийж, анхаарал тавих нь чухал юм. .

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ЧУЛУУН ДУРСГАЛЫН ГАДАРГУУ ДЭЭРХ ӨНГӨНИЙ АНАЛИЗ

Б.Отгонсувд*1, Э.Батзаяа1, Т.Галбаатар1, Э.Батжаргал2, М.Оюунтулга2
1- ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэн, Мэдээллийн технологийн салбар
2- Соёлын өвийн үндэсний төв, Соёлын биет өвийг сэргээн засварлах газар

Abstract
We have tried to analyze the color and color difference in ancient buildings and heritages. The color measurement we started can be used to determine how the colorants change by environmental influence, and to develop the methodology for such analysis will predict the initial object color. This will allow the cultural heritage to be restored by its original color, as well as to determine which colorants have the least changing and the most durable. Therefore, in this study we started measurements to analyze color fading performed on some museum heritages by 2 weeks and season. In this paper is discussed about the color difference of stone heritage in Kharkhorum soum and to process the color measurement data . In the future, we need to increase the measurement data, so the data analysis will be more precise, and the aim is to forecast the initial color of the object using a machine learning approach based on regression analysis by more color measurement values.

Түлхүүр үгс: соёлын биет өв, өнгөний хэмжилт, L*a*b* утга, өнгөний зөрүү, өгөдлийн сан

ОРШИЛ

Соёлын биет өвийн сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны салбарт өнгө будгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах нь өндөр ач холбогдолтой. Соёлын өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах ажлын хамгийн чухал үнэт зүйл бол тухайн соёлын өвийн анхны эх хэлбэр төрхийг алдагдуулахгүйгээр хадгалан хамгаалах явдал юм. Манай орны хувьд соёлын биет өв ялангуяа үл хөдлөх соёлын өв болох хуучны сүм хийд, музейн барилга байгууламжийн сэргээн засварлалтын асуудлуудыг судалгааны байгууллагад даатгалгүйгээр хувийн компаниар шийдүүлснээр соёлын өвийг ямар нэг судалгаагүйгээр гарал үүсэл нь тодорхой бус зориулалтын бус материал, будгаар будаж соёлын өвийн шинж чанарыг алдагдуулах эрсдэл ихээр гарч байна. Ийм байдлаар сэргээн засварлагдсан ажил чанар муутай болдог учраас сэргээн засварлах ажлыг ойр ойрхон хийх шаардлага гарч соёлын биет өвийг гэмтээж бат бөх чанарыг алдагдуулж цаг хугацаа болон эдийн засгийн хувьд ч алдагдал их хүлээдэг. Тиймээс өнгө судлалыг материал судлал болон будгийн технологийн салбартай хослуулан Монголын эрс тэс уур амьсгалтай цаг уурын нөхцөлд таарсан сэргээн засварлалтын аргазүй ашиглан нутагшуулах нь зүйтэй юм. Мөн өнгөний технологиудын тусламжтайгаар өнгө будгийн гандалт болон сонголт, соёлын өвийн эрсдлийн үнэлгээ хийх, улмаар хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт, сэргээн засварлалтын арга зүйг боловсронгуй болгох боломжтой болно.

Өнгөний зөрүүг тооцох аргыг ашигласан олон ажлууд гадаад хэвлэгдсэн байдаг ч соёлын өв тэр дундаа соёлын үл хөдлөх биет өв дээр хийгдсэн судалгаануудаас харвал ихэнхи нь өндөр чанарын камер, сканнер ашиглан 3D модел босгож анализ хийх, материалын бүтэц, чанарын судалгаа болон биологийн гэмтлийг тооцоолсон судалгаанууд байдаг.

Дээрхи хэрэгцээ шаардлагын үндсэн дээр манай судалгааны хамтарсан баг соёлын биет өвүүдийн өнгө будгийн гандалтыг орчны нөлөөнөөс хамааран хэрхэн явагдаж байгааг урт хугацааны өнгөний хэмжилт хийн тогтоож, арга аргачлал боловсруулж судлах зорилготой уг судалгааны ажлыг эхлүүлсэн. Мөн хэмжилтүүдээр

өнгөний өгөгдлийн сан үүсгэх ба ирээдүйд ашиглахад шаардлагатай бүх шинж чанарыг тусгасан байх шаардлагатай. Энэхүү судалгааны ажлаар эртний барилга байгууламж болон музейн гадна ба дотор орчинд байрлах соёлын өвүүд материал, шинж чанар, орчны нөлөөнөөс хэрхэн хамааран өнгөний өөрчлөлт өгч байгааг тогтоох бөгөөд соёлын өвийн эрсдлийн үнэлгээ хийх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын зөвлөмж дүгнэлт гарах боломжтой юм.


СОЁЛЫН ӨВИЙН ТУХАЙ

Соёлын өв гэдэг нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг хэлдэг бөгөөд соёлын биет өв гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг, соёлын биет бус өв гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлдэг байна. Соёлын биет өвийг хоёр ангилах ба соёлын үл хөдлөх дурсгал гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг, соёлын хөдлөх дурсгалт зүйл гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг хэлнэ [8].



Диаграм 1. Соёлын өв

Соёлын өвийн тухай судлагаа мэдээлэл, түүхэн эх сурвалжийг тогтоож бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах технологийг судалдаг салбар шинжлэх ухааныг соёлын өв судлал гэх бөгөөд энэ салбар нь түүх, археологийн шинжлэх ухаанаас гадна материал судлал, өнгө судлал, байгаль, хими, физик гэх мэт олон салбаруудыг хамарсан нарийн судалгаа шинжилгээг шаарддаг салбар шинжлэх ухаан юм.



Диаграм 2. Соёлын өв судлал

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГАЗҮЙ

Хэмжилтийн объект:


Бид Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Улаанбаатар хот болон Өвөрхангай аймгийн хэд хэдэн музейг сонгон төрөл бүрийн материал гадаргуу бүхий соёлын биет өвүүд дээр урт хугацааны өнгөний анализ хийхээр хэмжилт судалгааны ажлын 7-р сараас эхлүүлсэн.

Хүснэгт 1. Хэмжилтийн обьектүүдийн мэдээлэл

№	Хэмжилтийн газар	Хэмжилтийн обьектийн нэр	Хэмжилтийн цэгийн тоо	Хэмжилтийн давтамж	Материалын төрөл
1.	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	Морины хөл	Нэг өнгө: Улаан хүрэн	Хоёр долоо хоногт 1 удаа	Мод, гадаргуу нь шороон будаг
2.	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	“Очирт айлган үйлдэгч” бурханы Танка зураг	Гурван өнгө: ногоон, улбар шар, хөх	Хоёр долоо хоногт 1 удаа	Шороон будаг
3.	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	“Нүглийг наминчлах гучин таван бурхан” зээгт наамал	Гурван өнгө: ногоон, улаан шар, ногоон	Хоёр долоо хоногт 1 удаа	Даавуу
4.	Уран зургийн галерей	Чогсомын “Тайхар чулуу” уран зураг	Зургаан өнгө: шаргал, нуурын цэнхэр, Тэнгэрийн цэнхэр, Морины хүрэн бор, Чулууны хүрэн, улаан	Хоёр долооо хоногт 1 удаа	Тосон будаг
5.	Богд хааны Ордон музей	Гадаа баганын хавтас	Гурван өнгө: улаан хүрэн, хөх, ногоон	Хоёр долоо хоногт 1 удаа	Мод, гадаргуу нь шороон будаг
6.	Богд хааны Ордон музей	“Дамдин хаяагрива” бурханы Танка зураг	Гурван өнгө: улаан, хөх, ногоон	Хоёр долоо хоногт 1 удаа	Шороон будаг
7.	Хархорин музей	Перс бичээст хөшөө	Гурван өнгө	Улиралд 1 удаа	Чулуу
8.	Хархорин музей	Монголчуудын төсөөлөл Перс уран зураг	Гурван өнгө: бор, хөх, улаан	Улиралд 1 удаа	Усан будаг
9.	Хархорин музей	Монгол бичээст хөшөө	Хоёр өнгө	Улиралд 1 удаа	Чулуу
10.	Дэлхийн өвд бүртгэлтэй Орхоны хөндийн дурсгалт газар	Мэлхий чулуу	Таван өнгө	Улиралд 1 удаа	Чулуу
11.	Дэлхийн өвд бүртгэлтэй Орхоны хөндийн дурсгалт газар	Мэлхий толгой	Дөрвөн өнгө	Улиралд 1 удаа	Чулуу
12.	Шанхын баруун хүрээ хийд	Баруун дуганы цэцгэн хээтэй дотор хаалга	Гурван өнгө: цагаан, ногоон, ягаан	Улиралд 1 удаа	Мод, гадаргуу нь шороон будаг
13.	Шанхын баруун хүрээ хийд	Баруун дуганы гадаа хаалганы баруун дээд талын жимстэй хэсэг	Гурван өнгө: улбар шар, ногоон, шар	Улиралд 1 удаа	Мод, гадаргуу нь шороон будаг
14.	Эрдэнэзуу хийд	Хийдийн дотор талбай дахь чулуун арслан	Гурван өнгө	Улиралд 1 удаа	Чулуу


15.	Эрдэнэзуу хийд	Зүүн зуугийн баруун талын ханын зураг	Дөрвөн өнгө: улбар шар, ногоон, хөх, улаан	Улиралд 1 удаа	Шавар, гадаргуу нь шороон будаг
16.	Эрдэнэзуу хийд	Гол зуугийн баруун багана	Гурван өнгө: улаан, алтлаг, ногоон	Улиралд 1 удаа	Мод, гадаргуу нь шороон будаг
17.	Архангай аймгийн Их тамир сум	Тайхар чулуу	Дөрвөн өнгө	1 жилийн зайтай	Чулуу

Судалгааны ерөнхий арга зүй:
Уг туршилт, судалгааны ажлыг дараах ерөнхий арга зүйн дагуу гүйцэтгэнэ [5].



Диаграм 3. Судалгааны арга зүй

Өнгөний хэмжилтийн арга зүй:
Өнгөний хэмжилтийг дараах ерөнхий арга зүйн дагуу гүйцэтгэнэ.



Диаграм 4. Өнгөний хэмжилтийн арга зүй

Өнгөний хэмжилтийг бид X-Rite i1 Pro Colorimeter гэдэг өнгө хэмждэг спектрийн багажаар гүйцэтгэсэн. Эхлээд хэмжилтийн обьектоо хэмжилтэнд бэлтгээд багажаа хэмжилт хийх компьютертоо USB-ээр холбож хэмжилтийн горимынхоо дагуу бэлтгэнэ. Бидний хувьд хэмжилтийн Spot хэмжилт буюу дурын обьектийн өнгөний хэмжилтийн горимоор хэмжинэ. Дараа нь Patch Tool программаа нээгээд хэмжилтийн тоо, хэмжилтийн төхөөрөмж, хэмжилтийн орчин буюу гэрэлтүүлэг зэргийг тохируулан хэмжилтийн тохиргоог хийнэ. Үүний дараагаар White tile буюу цагаан өнгө тохируулга хийх цонх гарч ирмэгц багажаа тохируулгын хавтан дээр байрлуулан цагаан өнгийг тохируулж хэмжинэ. Ингээд багаж маань хэмжилт хийхэд бэлэн болох бөгөөд багажаа обьект


дээрээ байрлуулан хэмжилтүүдээ хийж өнгөний кодууд үүсгэнэ. Хэмжилтийн утгыг хадгалахдаа тохиргоо хэсэгт өөрт хэрэгтэй өгөгдлийн төрлүүдээ сонгоод мөн спектрийн хамрах хүрээ, спектрийн хэмжээ зэргийг сонгож хэмжилтийн файлдаа нэр өгч хадгална [3]. Үүний дараа хэмжилтийн үр дүнгүүдээр мета өгөгдлийн сан үүсгэнэ.

Өгөгдлийн сан үүсгэх арга зүй:

Соёлын өвийн объектийн өгөгдлийн сан бүрдүүлэхэд өгөгдлийн шинж чанар, өгөгдлийг тодорхойлох, талбаруудыг нарийн зохион байгуулалттай бэлдэж өгөгдлийн менежментийг зөв хийх хэрэгтэй. Өгөгдлийн сангийн менежментийг зөв хийснээр өгөгдлийн боловсруулалт хийхэд хялбар болно. Бид энэхүү судалгааны ажлын өгөгдлийн санг бүрдүүлэхэд DBMS буюу өгөгдлийн сангийн менежментийн систем ашигласан ба энэ нь дараах боломжуудыг олгож байна. Үүнд:

- Өгөгдлийн сангийн бүтцийг тодорхойлох, дүрслэх, өгөгдөл тодорхойлох хэл буюу (LDD)
- Зохих хэлний тусламжтайгаар өгөгдөлд хандах, ачааллах, өгөгдөл удирдах хэл буюу (DML)
- Query буюу Асуулгын тусламтайгаар өгөгдөлд хандах, засварлах, устгах г.м
- Өгөгдлийн сангийн аюулгүй байдал

Дараах арга зүйгээр өгөгдлийн санг үүсгэнэ.



Диаграм 5. Өгөгдлийн сан үүсгэх

Үүний дараа хэмжилтийн үр дүндээ боловсруулалт хийх шат эхэлнэ.

Өгөгдөл боловсруулалтын арга зүй:

Ингээд хэмжилтийн үр дүн буюу өгөгдлүүдэд статистик боловсруулалт хийгдэх бөгөөд шинж чанарын статистик үзүүлэлтүүдийг тодорхойлох аргыг дараах байдлаар гурав хувааж авч үздэг бөгөөд туршилт хэмжилтийн тоо харьцангуй бага бол статистик үзүүлэлтүүдийг томъёо ашиглан тодорхойлдог. n-ээр хэмжилтийн тоог илэрхийлнэ [5].

1. Томъёоны арга (n=<30)
2. Нийлбэрийн арга (n>30)
3. Үржвэрийн арга (n>30)

Бидний хувьд хэмжилтийн тоо 30-аас бага учраас томъёоны аргаар өгөгдлийн боловсруулалтыг статистик боловсруулалтын R программ дээр дараах статистик үзүүлэлтүүдийг тодорхойлно.

-Арифметик дундаж

$$\mu = \frac{\sum_{i=1}^{N} x_i}{N}$$

- Дисперс буюу вариац

$$s^2 = \frac{\sum_{i=1}^{n} (x_i - \bar{x})^2}{n-1}$$

- Стандарт хазайлт буюу дундаж квадрат хазайлт

$$\sigma = \sqrt{\frac{\sum_{i=1}^{N} (x_i - \mu)^2}{N}}$$

- Налуугийн коэффициент

$$CS = \frac{\frac{1}{N}\sum_{i=1}^{N} (x_i - \mu)^3}{\sigma^3}$$

- Жигд бишийн коэфициент


$$CK = \frac{\frac{1}{N}\sum_{i=1}^{N} (x_i - \mu)^4}{\sigma^4}$$

Ингээд өгөгдлийн боловсруулалтууд хийгдсэний дараагаар өгөгдлийн дүн шинжилгээ хийж үр дүнг тайлбарлах хэсэг рүү орно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Өгөгдлийн сангийн хөгжүүлэлт:

Өгөгдлийн санг хөгжүүлэхдээ 6 алхамаар хэрэгжүүлсэн бөгөөд пигмент будгуудын судалгаа, объект бэлтгэх аргачлал, өгөгдлийн шинж чанарыг тодорхойлох, мета өгөгдлийн сан бэлтгэх, өгөгдлийн сангийн зохиомж, эцэст нь MySQL мэдээллийн бааз руу экспортлоно [9].



Диаграм 6. Өнгөний өгөгдлийн сангийн диаграм

Мета өгөгдлийн санг хэмжилтийн өгөгдөл дээр дараах байдлаар бэлтгэсэн. ([Sample_Num], [Year], [Month], [Day], [Dye_Type], [Pigment_Color], [TXT], [Graph], [IMG], [Sample_ID], [Sample_Name], [XYZ_X], [XYZ_Y], [XYZ_Z], [LAB_L], [LAB_A], [LAB_B], [LAB_C], [LAB_H], [NM400]…[NM700])

Чулуун дурсгалын гадаргуун жишээн дээрх өнгөний анализ:

Бид энэхүү өгүүлэлд дээрхи соёлын өвийн хэмжилтийн обьектүүдээс жишээ болгон зөвхөн нэг соёлын өвийг сонгон өнгөний анализ хийж харуулсан бөгөөд Хархоринд байрлах Дэлхийн өвд бүртгэлтэй Орхоны хөндийн дурсгалт газарт хамаарагддаг Мэлхий чулуу нэртэй 13-р зууны үеийн боржгон чулуун материалаар хийгдсэн соёлын үл хөдлөх биет өвийг сонгон авсан. Учир нь уг дурсгал гадаа эрс тэс уур амьгалд байрлах бөгөөд нар, салхи зэрэг орчны нөлөөнд их өртөхөөс гадна иргэд шар тос түрхэх гэх мэтээр физик, механик, биологийн гэмтэл ихээр учруулдаг байна. Чулуун эд нь гадаргууд үүссэн бохирдлоос хамааран маш ихээр өнгө хувирч харалдаг бөгөөд тос, шувууны сангас, сүү зэрэг нь чулуунд аажмаар нэвчсээр өнгийг хувиргаж соёлын өвийг ихээр гэмтээдэг.

Ингээд Мэлхий чулуун дээр дөрвөн тал болон дээрээс гээд таван газар 10 см-ийн диаметртэй өнгөний бүс дотор санамсаргүй байдлаар 10 цэг сонгож одоогоор зун болон намрын улирлын 2 удаагийн өнгөний хэмжилт хийгээд байна. Судалгааны арга зүйн дагуу тус өнгөний хэмжилтийн L*a*b* утгуудад статистик боловсруулалт хийсэн бөгөөд үр дүнг дараах хүснэгтүүдэд илэрхийлэв [6,7].

Хүснэгт 2. Мэлхий чулууны урд талаас авсан өнгөний хэмжилтийн боловсруулалт

Өнгө 1	2020.07.22			2020.10.22		
Статистик	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**
Арифметик дундаж	28.4891	1.7164	4.6091	21.8724	1.4606	4.3414
Стандарт алдаа	0.879496	0.11382484	0.243196	1.972679	0.150629	0.342403
Медиан	29.002	1.7605	4.386	21.728	1.601	4.454
Стандарт хазайлт	2.78121	0.35994574	0.769054	6.23816	0.476332	1.082772
Вариац	7.735131	0.12956093	0.591445	38.91464	0.226892	1.172395
Жигд бишийн коэф	-0.67441	-0.3748691	-1.64716	-1.55621	-0.95748	0.470506
Налуугийн коэф	0.006076	-0.636527	0.232894	-0.02595	-0.58195	-0.81754
Хэмжилтийн тоо	10	10	10	10	10	10

Хүснэгт 3. Мэлхий чулууны баруун талаас авсан өнгөний хэмжилтийн боловсруулалт

Өнгө 2	2020.07.22			2020.10.22		
Статистик	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**
Арифметик дундаж	52.9487	1.7432	8.6239	37.634	2.4674	9.3719
Стандарт алдаа	0.833837	0.21973539	0.534882	1.122642	0.287161	0.648386
Медиан	52.05	1.822	8.8125	36.145	2.443	9.633
Стандарт хазайлт	2.636824	0.6948643	1.691445	3.550106	0.908084	2.050377
Вариац	6.952843	0.4828364	2.860986	12.60325	0.824617	4.204048
Жигд бишийн коэф	-0.95399	1.47662305	0.749939	2.398793	-0.70779	-0.44611
Налуугийн коэф	0.359464	-0.832137	-0.65467	1.657788	-0.11131	-0.61436
Хэмжилтийн тоо	10	10	10	10	10	10

Хүснэгт 4. Мэлхий чулууны зүүн талаас авсан өнгөний хэмжилтийн боловсруулалт

Өнгө 3	2020.07.22			2020.10.22		
Статистик	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**	**LAB_L**	**LAB_A**	**LAB_B**
Арифметик дундаж	41.0125	1.8289	9.5802	41.1456	1.4414	8.5512
Стандарт алдаа	0.948639	0.13225518	0.495362	2.581761	0.16611	0.638932
Медиан	41.007	1.856	9.4835	38.069	1.5015	8.3335
Стандарт хазайлт	2.99986	0.4182276	1.566473	8.164244	0.525286	2.020479
Вариац	8.999161	0.17491432	2.453839	66.65488	0.275925	4.082336
Жигд бишийн коэф	-1.38445	-1.4164837	-0.18957	-1.35591	-1.09225	-1.5218
Налуугийн коэф	0.004554	-0.3265765	0.621114	0.517426	0.166798	0.233261
Хэмжилтийн тоо	10	10	10	10	10	10

Хүснэгт 5. Мэлхий чулууны хойд талаас авсан өнгөний хэмжилтийн боловсруулалт

Өнгө 4	2020.07.22			2020.10.22		
Статистик	LAB_L	LAB_A	LAB_B	LAB_L	LAB_A	LAB_B
Арифметик дундаж	53.0899	2.8752	12.8642	49.2725	2.8722	12.5023
Стандарт алдаа	0.908318	0.22989465	0.578271	2.31374	0.318959	0.960778
Медиан	52.368	2.839	13.292	53.2565	3.288	13.459
Стандарт хазайлт	2.872354	0.72699072	1.828655	7.316688	1.008638	3.038248
Вариац	8.250417	0.52851551	3.343978	53.53392	1.01735	9.230948
Жигд бишийн коэф	-0.22225	0.00981895	-0.37634	-1.7892	-1.66072	-1.76386
Налуугийн коэф	0.353254	-0.2670798	-0.57908	-0.55538	-0.49351	-0.31179
Хэмжилтийн тоо	10	10	10	10	10	10

Хүснэгт 6. Мэлхий чулууны дээд талаас авсан өнгөний хэмжилтийн боловсруулалт

Өнгө 5	2020.07.22			2020.10.22		
Статистик	LAB_L	LAB_A	LAB_B	LAB_L	LAB_A	LAB_B
Арифметик дундаж	49.5155	4.0572	14.0824	49.2415	2.7002	11.9291
Стандарт алдаа	0.729511	0.21184726	0.400365	1.271556	0.282211	0.667781
Медиан	49.736	3.9625	13.366	49.34	2.6145	11.7925
Стандарт хазайлт	2.306916	0.66991986	1.266067	4.021012	0.892431	2.111709
Вариац	5.321862	0.44879262	1.602925	16.16854	0.796433	4.459316
Жигд бишийн коэф	-0.38127	-1.6831382	-0.49597	0.231491	4.318186	1.24513
Налуугийн коэф	-0.09154	0.24752891	1.027028	-0.4131	1.761007	0.273209
Хэмжилтийн тоо	10	10	10	10	10	10

Ингээд өгөгдлийн боловсруулалтаас гарсан дундаж утгуудаар өнгийг дараах байдлаар илэрхийлж өнгөний зөрүүг нүдээр харж болно. Эхний өнгө нь зуны хэмжилт буюу 7 сарын 22-ны өдрийнх, 2 дахь өнгөөр намрын буюу 10 сарын 22-ны өдрийн хэмжилтийн утгуудыг дундажлаж өнгөөр илэрхийллээ.



Зураг 1.Өнгө 1-ийн дундаж утга



CIE-L*ab

L	52.9487
A	1.7432
B	8.6239

CIE-L*ab

L	37.634
A	2.4674
B	9.3719

Зураг 2. Өнгө 2-ын дундаж утга



CIE-L*ab

L	41.0125
A	1.8289
B	9.5802

CIE-L*ab

L	41.1456
A	1.4414
B	8.5512

Зураг 3. Өнгө 3-ын дундаж утга



CIE-L*ab

L	53.0899
A	2.8752
B	12.8642

CIE-L*ab

L	49.2725
A	2.8722
B	12.5023

Зураг 4. Өнгө 4-ийн дундаж утга



CIE-L*ab

L	49.5155
A	4.0572
B	14.0824

CIE-L*ab

L	49.2415
A	2.7002
B	11.9291

Зураг 5. Өнгө 5-ын дундаж утга

Өнгөний зөрүү тооцсон үр дүн:

Хоёр хэмжилтийн өнгөний зөрүү буюу ΔE-г дараах томъёогоор олно.

$$\Delta E^*_{ab} = \sqrt{(L^*_2 - L^*_1)^2 + (a^*_2 - a^*_1)^2 + (b^*_2 - b^*_1)^2}$$

Дээрхи томъёогоор зуны болон намрын хэмжилтийн дунджуудаар таван өнгөн дээрээ зөрүүг тооцоолоход дараах утгуудыг өгсөн [2].

№	ΔE	ΔE Өнгөний зөрүү	Шинж чанар
Өнгө 1	6.6271	<= 1.0	Хүний нүдэнд ажиглагдахааргүй өнгөний зөрүүтэй.
Өнгө 2	15.35	1 - 2	Ойроос сайн ажиглахад мэдрэгдэх.
Өнгө 3	1.1076	2 - 10	Зэрвэс харахад ажиглагдах.
Өнгө 4	3.8345	11 - 49	Өнгөний эрс зөрүүтэй.
Өнгө 5	2.5599	100	Эсрэг өнгөтэй.

Өнгөний зөрүүг тооцсон үр дүнгээс харахад өнгө 3 буюу мэлхийн зүүн тал хамгийн бага өнгөний өөрчлөлт өгсөн бөгөөд өнгө 4 болон өнгө 5 буюу хойд болон зүүн талууд өнгөний дундаж өөрчлөлттэй гарсан нь бохирдол багатай байсан хэсгүүд юм. Харин хамгийн их өөрчлөлт өгсөн өнгө 2 буюу мэлхийний зүүн тал болон өнгө 1 буюу мэлхийний хошуу хэсгүүд нь бохирдол ихтэй хэсгүүд буюу шар тос болсон хэсгүүд байв. Энэ нь тус чулуун өвд тос улам нэвчин өнгийг өдөр өдрөөр хувирган харлуулж байгааг нотолж байна.

ДҮГНЭЛТ

Уг судалгааны ажлыг гүйцэтгэж өнгөний технологи, арга аргачлал, өгөгдлийн дүн шинжилгээний аргыг соёлын өвд ашиглах нь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтойгоос гадна соёлын өвийн үнэ цэнийг хадгалах түүх, соёлд үзүүлэх нөлөө их юм. Тус судалгааны ажлын үр дүнгээс харахад дараах дүгнэлтүүдийг өгч болохоор байна.

- Чулуун гадаргуу дээр хэмжилт хийсэн өнгөний хэмжилтийн үр дүнгийн харьцуулалтыг 2 улирлын байдлаар гүйцэтгэхэд гадаргуугийн бохирдлоос хамааран өнгөний нилээн зөрүү ажиглагдсан бөгөөд 4 улирлын байдлаар өнгөний өөрчлөлтийг тооцвол бүтэн жилийн хугацаанд орчны нөлөөллөөс хамааралтай гандалт өгч буй эрсдлийн үнэлгээ гаргах боломжтой болно.
- Цаашид өнгөний хэмжилтүүдийг үргэлжлүүлэн өнгөний өгөгдлийн санг нэмэгдүүлж өнгөний анализ хийснээр үр дүнг ашиглан соёлын биет өвийн эрсдлийн үнэлгээ гаргах, хадгалалт хамгаалалтын зөвлөмж боловсруулах, материал судлалтай холбон хадгалалт хамгаалалт сэргээн засварлалтын аргазүй боловсруулах бүрэн боломжтой юм.

Ашигласан материал

1. Roy S. Berns, “Principles of Color Technology”, New York, John Wiley& Sons, 2000
2. Kurt Nassau, “Color for Science, Art and Technology”, Netherland, Elsevier, 2006
3. User Manual of X-rite i1 Pro Colorimeter, China, Trademark of X-rite, 2017
4. Ganesh Ramanathan, Understanding Tristimulus Values: Taking the Guess-work Out of Color Measurement Instrumentation, hunterlab.com, 2015

5. Ч.Авдай, Д.Энхтуяа,”Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй”, Улаанбаатар, 2015

6. F.M. Dekking C. Kraaikamp, H.P. Lopuhaa¨ L.E. Meester, “A Modern Introduction to Probability and Statistics”, ISBN 978-1-85233-896-1, Springer, 2013

7. Siegmund Brandt, Data Analysis Statistical and Computational Methods for Scientists and Engineers, ISBN 978-3-319-03761-5 , DOI 10.1007/978-3-319-03762-2, Springer, 2014

8. Монгол улсын хууль, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”, 2014 он.

9. Robin Nixon, “Learning PHP, MySQL, JavaScript, CSS & HTML5: A Step-by-Step Guide to Creating Dynamic Websites”, 2009

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙП ХАДГАЛАГДАЖ БУЙ “ЭМНЭГ СУРГАГЧ” УРАН ЗУРГИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАСАН ТАЙЛАН

Уран зургийн галерей
О. Цэвэгжав “Эмнэг сургагч” уран зургийг сэргээн засварлах ажлын явц

Холбогдох мэдээлэл
Уран зураг, зотон/тос
Өндөр: 210см, Өргөн: 151см
Холбогдох он цаг: 1963он
Хувийн дугаар: 63.49
Гэмтэл бохирдол:

Уг бүтээл нь 210см х 151см хэмжээний бүтээл бөгөөд бүтээлч анх бүтээхдээ зотон даавууг цардаж тосон будгаар туурвисан.

Хадгалалтын явцад 2009 онд уран зургийн галерейн сан хөмрөгт гарсан галын улмаас их хэмжээний утаа тортгийн бохирдолтой. Зарим хэсгээр буюу зургийн дүрслэлийн гол дүр болох эмнэг сургагч болон морины хүзүү орчмоор галын халалтын улмаас зургийн өнгө будгийн давхаргад цэврүү үүсэж хүнд гэмтэл учирсан байна. Уг гэмтэл нь ойролцоогоор зургийн 20% орчимд тархсан байна. Мөн зургийн ар талын ажиглахад баруун доод хэсгээр зотон даавуу галын халалтад өртөж түлэгдсэн байна.

Зургийн дотуур раммны хөндөл мод тэгш бус хэмээр буюу далий хийгдсэн мөн зургийн зотон дэвсгэрт шууд хүрэлцэж шүргэснээр зургийн нүүрэн талд мэдэгдэхүйц ул мөр ором гаргасан байна, модон жааз он цагийн явцад ихэд илэгдэж муудсан, галын тортог, тоос шорооны их хэмжээний бохирдолтой. Жаазны өнгө будаг халцарч муудсан, жаазыг хэд хэд дахин давхарлаж будсан байна.

Бүтээлийн одоогийн байдал.(гэмтэлтэй хэсгийг тэмдэглэв)



Уг бүтээлийг сэргээн засварлах ажлыг доорх байдлаар төлөвлөн ажиллав.

О. Цэвэгжав “Эмнэг сургагч” уран зурагийг сэргээн засварлах ажлыг эхлүүлэхээс өмнө доорх хийх шаардлагатай бэлтгэл ажил.

1. Уг бүтээлийг арлах ажилд зориулан уран зургийн өөрийн хэмжээнээс хааш хаашаагаа 15см том хэмжээтэй тэлүүр рамм захиалж хийлгэх

Уг рамм нь дээр дурьдсан тэлүүр раммны зориулалттай тул голдоо хөндөлгүй, ташуу налуугүй 4х6см-ийн прусс модыг хэвтээ байдлаар хийх ба раммыг дөрвөн буланд нь углуурга гаргах бөгөөд угсрах, салгах тул наалт хийхгүй байвал зохино.

2. Зургийг бүрэн арлах ажиллагаа хийгдэх ба үүнд зориулсан арлагааны бөс материалыг урьдчилан худалдаж авсан байх.

Арлагаа хийх материал нь суналт, агшилт багатай байх ба хэмжээ нь уг зургийн үндсэн хэмжээнээс хааш хаашаагаа 30см илүү байх шаардлагатай. /материалыг судалж сонгох/

3. Уг уран зургийн дотуур раммны хөндөл моднууд дотогш хотойж зургийн зотон даавуутай шууд харьцаж байгаа тул уг хуучин дотуур раммыг солих бол урьдчилан ижил хэмжээтэй дотуур раммыг захиалах.

4. Сэргээн засварлалтын ажил эхлэхээс өмнө өнгө будгийн найрлагын шинжилгээ судалгааг хийх

5. Өнгө будгийн гадаргын галд халж өнгө хувирсан хэсэг ба халалт бага нөлөөлсөн ижил буюу ойролцоо өнгө бүхий хэсгүүдэд өнгө будгийн гандалтын индекс хийх.

6. Шаардлагатай сэргээн засварлалтын ажлыг хийх

Сэргээн засварлалтын ажил


Уг бүтээлийг сэргээн засварлахад зайлшгүй шаардлагатай тэлүүр раммыг захиалж хийлгүүлж бэлдсэн. Мөн зургийг шинээр арлах зотон даавуу болон акрелик гель зэрэг зарим хэрэгцээт материалыг худалдан авч бэлдэв.

Эмнэг сургагч уран зургийн бүтээлийг 2020 оны 10 дугаар сарын 01 ний өдөр сэргээн засварлалтад оруулахаар Уран зургийн галерейгаас хүлээн авсан ба хүлээн авах үед уг бүтээлийн гэмтэл бохирдлын анхны байдлыг харуулах гэрэл зургийн баримтжуулалтыг хийв.

Уг бүтээлийг анхлан хүлээж аван жаазнаас салгаж нарийвчилсан үзлэг хийх үед дээр дурьдсанчлан галын тортог, хөө, тоос шорооны бохирдол ихтэй, хуучин лак гандаж шарласан, өнгө будгийн харьцангуй зузаан бичилттэй хэсэг буюу гол дүрийг дүрсэлсэн хэсгүүдэд будаг халж цэврүү үүссэн цэврүүний хэмжээ харьцангуй байх бөгөөд дунджаар 0,5-5мм орчим диаметртэй байна.



Цэврүүний тархац байдал мөн харилцан адилгүй байгаа бөгөөд будгийн давхаргын зузаан нимгэнээс шалтгаалан өөр өөр байна.






Жишээ нь зургийн гол дүр болох эмнэг сургагчийн нүүр болон гар, гарын 2 шуу хэсгүүдээр хамгийн их цэврүүтсэн, үүссэн цэврүү нь өөр хоорондоо бараг зайгүй нягт байгаа нь сэргээн засварлалтын ажилд нилээд хүндрэл учруулхаар харагдаж байна.


Өнгө будгийн хэт нимгэн хэсгүүдэд зотон дэвсгэрийн толгой ил гарч халцарсан байгаа нь зарим хэсгүүдэд өнгө будаг харласан мэт ажиглагдаж байна. (жишээ нь тэнгэрийн цэнхэр өнгө бүхий хэсэг)

Дотуур рамм доод болон дээд захаараа зургийн хэмжээнээс илүү гарсан байна энэ нь дээд талдаа 1см орчим, доод захаараа 1.5см орчим илүү гарсан байна.

Холстны булангууд элэгдэж цоорсон зэрэг гэмтлүүд байна.


Эмнэг сургагч бүтээлийг сэргээн засварлалтад хүлээж авч нөхцөл байдалтай танилцсаны дараа өнгө будгийн гадаргын галд халж өнгө хувирсан хэсэг ба халалт бага нөлөөлсөн ижил буюу ойролцоо өнгө бүхий хэсгүүдэд өнгө будгийн гандалтын индексийг тогтоох ажлыг ШУА-ийн математик, тоон технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б. Отгонсувдтай хамтарч хийсэн.






Мөн өнгө будгийн давхаргад XRF багажит дүн шинжилгээ хийх ажлуудыг шат дараатай хийсэн.

Эдгээр судалгааны ажил хийгдсэний дараа зургийн өнгө будгийн цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэв. Цэвэрлэгээнд ксилол, толуол, этиль ацетат, этанол зэрэг химийн уусгагчуудыг дангаар болон харьцангуй процентоор найруулан хэрэглэсэн.









Мөн зургийн зотон дэвсгэрийн ар тал, хажуу ирмэг зэрэг хэсгүүдэд хуурай цэвэрлэгээ хийж зургийг дотуур раммнаас салгаж зотон дэвсгэрийн ар талын зотонгийн утасны зангилаа, гогцоо буюу бидний хэлж заншсанаар нэхмэл эдлэлийн бөөсийг цэвэрлэх, дотуур рамманд хадагдаж байсан нугалаа ирмэгийг амраж буулгах, тогтсон тортог хөөг механик аргаар цэвэрлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх, зургийг ар талаас BEVA371 цавуу түрхэж халдаг вакум ширээнд бэхжүүлэх арлагаа хийх ажилд бэлдэв.

Зургийн арыг цэвэрлэж дууссаны дараа BEVA371 цавууг түрхэж хатаан вакум халдаг ширээнд зургийн нүүрэн талыг дээш харуулан тавьж silicone coated mylar буюу силикон бүрхүүл бүхий наалддаггүй гадаргуут гялгар уутаар хучиж битүүмжлэн вакум соролтыг 20-40psi даралттай 80-85ºC градус хүртэл халааж өнгө будгийн давхаргад үүссэн цэврүү бүхий хэсгүүдэд тэдгээрийг буулгах гар багаж болон халдаг үзэг индүү зэргээр массажлан зургийн өнгө будгийн давхаргад үүссэн цэврүүг буцаан буулгав.





Уран зургийн өнгө будгийн давхаргад галын халалтаас үүссэн цэврүүг буулгахад үүссэн цэврүүний хэмжээ, хоорондын зай, цэврүүний ханын зузаан зэрэг хүчин зүйлс өнгө будгийн давхарга хэр жигд тэгш болж анхны байдалдаа ороход нөлөөлөх буюу сэргээн засварлалтын ажлын үр дүнд шууд нөлөөлдөг.



Эмнэг сургагч уран зургийн хувьд зургийн өнгө будгийн давхаргын зузаан бичилттэй хэсгүүдийг дагаж цэврүү үүссэн гэдгийг дээр дурьдсан, уг үүссэн цэврүү нь 0,5-5мм-ийн дундаж хэмжээтэй маш зузаан ханатай, цэврүү хоорондзай бараг байхгүй, үүссэн цэврүү халалтын улмаас маш их хатуурсан зэрэг нөхцөл байдал нэгэнт үүссэн байсан. Эдгээр үүссэн нөхцөл байдлын улмаас цэврүүг буулгах ажилд нилээд цаг хугацаа орсон ба үр дүн нь өнгө будгийн давхарга гэмтлийн өмнөх эх байдалдаа бүрэн орох боломжгүй болсон.




Үүний дараа зургийг вакум халдаг ширээнээс гаргаж ар талаас нь BEVA371 хальс нааж индүүдэн нийлэг, суналт агшилтгүй нимгэн капрон материалаар арлаж наан дахин вакум халдаг ширээнд хийж дээрх цэврүү буулгах, индүүдэх үйлдлийг дахин давтаж будгийн давхаргыг бэхжүүлж, галын халалтад хэт хатаж хугарамтгай болсон зотонг дэмжих арлагааг нааж бэхжүүлсэн.

Арлагаа, бэхжүүлэлтийн ажил дууссаны дараа зургийн ирмэг дагуу зургийг дотуур раманд татаж хадах 10см өргөнтэй зотон даавууг зигзаг хайчаар ирмэгийг хайчилж бэлдэн тус ирмэгийг дагуулан 2,5см өргөн BEVA371 хальсыг нааж мөн зургийн ирмэг дагуу 2,5см өргөнтэй

BEVA371 хальсыг тус тус нааж бэлдэв. Эдгээр бэлтгэл ажил дууссаны дараа зургийн ирмэг дагуу бэлдсэн 10см өргөнтэй зотонг нааж зургийн дотуур раманд татах давхар зах ирмэг хэсгийг бэлэн болгосон.





Уг бүтээлийн дотуур раммыг боломжтой бол сэргээн засварлаж буцааж хийхээр сэргээн засварлах ажил эхлэхийн өмнө төлөвлөж байсан хэдий ч зургийг дотуур раммнаас салгахад раммны үндсэн хүрээний доод хийц гол хэсэгтээ хугаралтай углуургууд маш их хөдөлгөөн орсон, дотор хэрээс хөндөл углуургаараа хугарсаны улмаас дотогш цүлхийж зургийн ар талаас шүргэх болсон зэрэг их хэмжээний гэмтэлтэй байсан тул дотуур раммыг шинээр захиалж сольж хийхээс өөр аргагүй болсон. Иймд хуучин дотуур рамм болон зургаас нарийвчилсан хэмжээ авч шинээр захиалан хийлгэж зотон дэвсгэрт зургийг шинэ дотуур рамманд татаж хадсан.

Үүний дараа уран зургийн өнгөн давхаргад нэвчсэн BEVA371 цавууны үлдэгдлийг цэвэрлэж грунт болон өнгө давхаргын сэргээн засварлах ажлын өмнөх ялгах давхарга тавих ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ үе давхаргад Paraloid B-67-ийн 10%-ийн Ксилол дахь уусмалыг 2 удаагийн давтамжтайгаар хийн компрессороор шүршиж бэлдсэн.



Өнгө будаг гэмтсэн хэсгүүдэд BEVA Gesso грунтээр нөхөлт хийж хатаан гадаргын илүүдлийг ксилол уусгагч хэрэглэн арчиж тэгшлэв.





Грунтийн давхарга бэлэн болсоны дараа акрелик гель хэрэглэж будгийн бичилтийг нөхсөнөөр уг зургийн өнгө будгийн гэмтэлтэй хэсгийн өнгө будгийн сэргээн засварлалт хийхэд бэлэн болсон.

Эмнэг сургагч уран зурийн өнгө будгийн сэргээн засварлалтын ажилд эх бүтээлийн үндсэн материал болон сэргээн засварлалтад хэрэглэсэн материал хоорондоо ялгаатай байх зарчмыг баримтлан усан будаг хэрэглэсэн.





Өнгө будгийн сэргээн засварлалтын ажил дууссаны дараа хамгаалах давхарга тавьсан. Үүнд мөн Paraloid B-67-ийн 10%-ийн Ксилол дахь уусмалыг шүршиж хэрэглэсэн.

Эмнэг сургагч уран зургийн жааз мөн нилээд хуучирч гэмтсэн үүнд жааз бүхэлдээ тоос, тортог болж бохирдсон, гадаргад механик гэмтлүүд үүссэн, жаазны зүүн ирмэг галд их хэмжээгээр халж хайрагдсан, булангууд суларч хөдөлгөөн орсон, боронз будаг халцарсан гэх зэрэг гэмтэлтэй байсан тул жаазанд хуурай болон чийгтэй механик цэвэрлэгээ хийж, хөдөлгөөн орж ангайсан булангуудын хөдөлгөөнийг хорьж шаантаглан гадаргад үүссэн байсан механик гэмтлүүдийг замаскдаж нөхөн боронзон өнгөөр нөхөж сэргээн будсан.





“Эмнэг сургагч” уран зургийн сэргээн засварлах ажил дээрх үндсэн дэс дарааллаар хийгдэж дууссан болно.




Гэрэл зурагт: Сэргээн засварлалтын ажлын дараа.

Сэргээн засварлах ажлыг Соёлын өвийн үндэсний төвийн СБӨСЗГазрын ерөнхий сэргээн засварлагч Д. Нямдорж, сэргээн засварлагч Н. Чинтөгөлдөр нар хийж гүйцэтгэсэн.


Сэргээн засварлалтад холбогдох өнгө будгийн XRF багажит судалгаа, өнгөний гандалтын индекс тодорхойлох судалгааг СБӨСЗГазрын дарга, ерөнхий технологич М. Оюунтулга, ШУА-ийн Математик, тоон технологийн хүрээлэнгийн ЭША Б. Отгонсувд нар хийж ажиллав.

ЭМНЭГ СУРГАГЧ” УРАН ЗУРГИЙН СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТЫН ӨМНӨХ БА ДАРААХ ӨНГӨНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

Б.Отгонсувд
ШУА-ийн МТТХ-ийн ЭША


1.Ерөнхий ойлголт

Өнгө хэмээх ойлголтыг манайд харагдах байдлаас нь л авч үздэг байсан бол дэлхийд өнөөдөр өнгөний шинжлэх ухаан болон хөгжжээ. Биднийг өнгийг боловсруулж ялгаж харахад гэрлийн эх үүсвэр, гэрэлтүүлэх обьект, ажиглагч буюу хүн гэсэн гурван хүчин зүйл оролцдог бөгөөд хүний нүд гэрлийг хүлээн авч тэрхүү гэрлийг хүний тархи өнгө болгож таних дохионд хувиргадаг. Обьектийн өнгөний харагдах байдалд гэрлийн эх үүсвэрийн спектр шинж чанар, гэрэлтүүлгийн түвшин, суурь гэрэлтэлт болон сэтгэл зүй зэрэг олон төрлийн хүчин зүйлүүд нөлөөлдөг. Хүний нүдний мэдрэлийн эсүүд “үзэгдэх гэрлийн муж” буюу 380–720 нанометрт электрон соронзон долгионыг мэдэрдэг байна. Өнгөний хэмжилт гэдэг нь ажиглагч юу харж байгааг хараагаар болон багажаар тогтоохыг хэлэх бөгөөд өнгийг багажаар хэмжих нь хараагаар хэмжихээс илүү нарийвчлал сайтай боловч зарим тохиолдолд харааны хэмжилттэй харьцуулан авч үзэх шаардлага гардаг. Хараагаар хэмжилт хийхэд тохирсон гэрэлтүүлэг, харах орчин бүхий гэрэлт хайрцган төхөөрөмж шаардлагатай бол өнгийг багажаар хэмжихэд багажны геометр, стандарт ажиглагч, колориметрийн /өнгө хэмждэг багаж/ тооцооллын эх үүсвэрийг сонгох шаардлагатай байдаг. Мөн багажны оновчлол болон нарийвчлалыг хангалттай байхаар сайн баталгаажуулах хэрэгтэй. Өнгийг хэмжих хамгийн сайн арга нь харааны хэмжилтийг багажны хэмжилттэй харьцуулж корреляцилах хэмжилтийн харьцуулсан судалгаагаар өнгөний харьцуулалт судалгаа хийсэн.



Зураг 1. Гэрлийн эх үүсвэрийн тусламжтайгаар обьектийн өнгийг мэдрэгч, дохио боловсруулагчаар дамжуулан багажаар өнгийг тодорхойлох процесс

Өнгийг багажаар хэмжих арга нь спектрийн хэмжилтэнд суурилдаг бол хараагаар хэмжих арга нь “Light Booth” гэх гэрэлт хайрцган төхөөрөмжийг ашигладаг бөгөөд хүний нүдний хэмжилтэнд суурилдаг.



Зураг 2. Гэрэлт хайрцган төхөөрөмжөөр харааны хэмжилт хийх процесс

Харин багажаар өнгө хэмжихэд гурван утга ашиглан өнгийг тодорхойлдог бөгөөд энэ нь L*a* b* гэсэн координатаар тодорхойлогдоно. CIELAB-ийн координат /L* a* b*/ эсвэл өнгөний гурван утгыг /X Y Z/ тодорхойлдог маш олон төрлийн технологиуд байдаг. Гэхдээ эдгээр нь хамгийн багадаа 3 /гурван утга бүр дээр нэг/, хамгийн ихдээ 471 /360 нанометрээс 830 нанометрийн хооронд долгионы уртын нанометр бүрт нэг/ сигналын тоогоор ангилагдана. Колориметр нь өнгөний тоон утгыг шууд хэмждэг бол спектрометр нь спектрийн өгөгдлөөс колориметрийн утгыг бодож гаргадаг ялгаатай. Колориметрийн болон спектрийн утгыг тооцоолоход өөр өөр математик аргууд ашиглагддаг.

2.Өнгө хэмжихэд ашиглагддаг багажууд

• Колориметр /Colorimeter/: CIE-ийн гурвалсан утга болон өдөөгчийг хэмжихэд ашиглагддаг багаж

• Спектрометр /Spectrometer/: Долгионы уртын функц төдийгүй оптик шинж чанарыг тодорхойлон хэмжихэд ашиглагддаг багаж

• Хураангуйлсан спектрометр /Abridged spectrometer/: Нэг эсвэл олон дискретээр спектрийн хөндлөн байрлал дахь оптик шинж чанарыг тодорхойлон хэмжихэд ашиглагддаг багаж

• Спектрофотометр /Spectrophotometer/: Спектрийн ойлт, нэвтрүүлэх коэфициентийг хэмжихэд ашиглагддаг багаж

• Спектрорадиометр /Spectroradiometer/: Спектр туяа, цацрагийг хэмжихэд ашиглагддаг багаж

Багажаар хэмжсэн өнгөний утгуудыг тусгай өнгөний оронгуудаар дүрслэн илэрхийлдэг. Энэ удаагийн хэмжилтийг Колориметр /Colorimeter/: CIE-ийн гурвалсан утга болон өдөөгч X-Rite i1 PRO багажийг ашигласан.

3.Хэмжилтийн утгууд

№	Өнгө	LAB_L	LAB_A	LAB_B
1	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	56.951	-9.428	-9.619
2	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	55.072	-8.997	-8.881
3	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	54.847	-8.347	-6.403
4	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	57.431	-10.09	-8.255
5	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	55.607	-9.689	-9.577
6	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	56.865	-8.968	-9.774
7	Тэнгэрийн цэнхэр- бохир	41.55	-5.998	1.455
8	Тэнгэрийн цэнхэр- бохир	45.903	-7.067	0.156
9	Тэнгэрийн цэнхэр- бохир	45.249	-5.905	1.866
10	Тэнгэрийн цэнхэр- бохир	43.972	-7.128	-0.587
11	Тэнгэрийн цэнхэр- бохир	43.896	-6.157	1.582
12	Тэнгэрийн цэнхэр- бохир	43.964	-6.213	1.119
13	Үүлний цагаан- цэвэр	62.94	1.812	15.578
14	Үүлний цагаан- цэвэр	63.657	2.193	15.674
15	Үүлний цагаан- цэвэр	63.405	1.735	13.921
16	Үүлний цагаан- цэвэр	62.145	0.534	13.716
17	Үүлний цагаан- цэвэр	62.395	2.214	15.674
18	Үүлний цагаан- цэвэр	62.892	1.114	13.689
19	Үүлний цагаан- бохир	54.121	0.069	10.336
20	Үүлний цагаан- бохир	55.733	0.886	12.112
21	Үүлний цагаан- бохир	58.195	1.318	14.071
22	Үүлний цагаан- бохир	57.648	1.018	11.808
23	Үүлний цагаан- бохир	53.862	0.696	12.695
24	Үүлний цагаан- бохир	53.795	0.818	12.542
25	Газрын ногоон- цэвэр	43.705	-8.888	20.57
26	Газрын ногоон- цэвэр	39.606	-9.477	19.482
27	Газрын ногоон- цэвэр	43.487	-7.381	16.936
28	Газрын ногоон- цэвэр	39.681	-7.736	18.763
29	Газрын ногоон- цэвэр	40.902	-8.998	19.343
30	Газрын ногоон- цэвэр	40.083	-7.173	19.214
31	Газрын ногоон- бохир	34.28	-8.905	22.554
32	Газрын ногоон- бохир	33.874	-8.848	22.804
33	Газрын ногоон- бохир	31.352	-8.115	16.857
34	Газрын ногоон- бохир	34.381	-6.875	17.873
35	Газрын ногоон- бохир	33.729	-7.357	19.826
36	Газрын ногоон- бохир	33.954	-9.467	22.603

37	Тугны шар- цэвэр	60.261	1.258	31.88
38	Тугны шар- цэвэр	61.186	5.059	44.549
39	Тугны шар- цэвэр	61.369	4.736	47.255
40	Тугны шар- цэвэр	59.887	-0.531	24.414
41	Тугны шар- цэвэр	60.06	3.471	40.526
42	Тугны шар- цэвэр	60.312	4.055	44.227
43	Тугны шар- бохир	53.598	-2.525	27.066
44	Тугны шар- бохир	52.212	-1.388	27.096
45	Тугны шар- бохир	54.537	-1.163	23.716
46	Тугны шар- бохир	55.684	-1.083	28.722
47	Тугны шар- бохир	53.458	-2.31	25.908
48	Тугны шар- бохир	51.642	-2.399	28.073
49	Морины хурэн-цэвэр	30.621	9.834	9.002
50	Морины хурэн-цэвэр	25.967	8.588	8.291
51	Морины хурэн-цэвэр	30.493	12.218	10.865
52	Морины хурэн-цэвэр	31.132	9.356	8.598
53	Морины хурэн-цэвэр	30.487	11.472	10.414
54	Морины хурэн-цэвэр	31.234	10.21	9.383
55	Морины хурэн-бохир	25.194	9.715	9.27
56	Морины хурэн-бохир	27.156	7.583	7.369
57	Морины хурэн-бохир	27.676	9.461	8.37
58	Морины хурэн-бохир	24.578	8.102	7.846
59	Морины хурэн-бохир	25.13	6.615	6.53
60	Морины хурэн-бохир	28.394	5.295	5.104
61	Дээлний ногоон-цэвэр	35.51	0.65	15.839
62	Дээлний ногоон-цэвэр	41.565	1.784	16.452
63	Дээлний ногоон-цэвэр	40.601	1.529	19.603
64	Дээлний ногоон-цэвэр	38.421	1.892	14.606
65	Дээлний ногоон-цэвэр	38.653	-0.701	15.624
66	Дээлний ногоон-цэвэр	40.946	1.564	19.167
67	Дээлний ногоон-бохир	30.581	0.313	11.934
68	Дээлний ногоон-бохир	27.069	-0.144	18.251
69	Дээлний ногоон-бохир	33.252	0.306	11.132
70	Дээлний ногоон-бохир	24.347	2.058	11.818
71	Дээлний ногоон-бохир	29.649	0.347	11.708
72	Дээлний ногоон-бохир	22.273	2.234	12.21
73	Цамцны цагаан- цэвэр	76.247	-0.601	14.895
74	Цамцны цагаан- цэвэр	71.547	0.42	15.368
75	Цамцны цагаан- цэвэр	74.049	-0.696	14.493
76	Цамцны цагаан- цэвэр	75.459	0.146	15.014
77	Цамцны цагаан- цэвэр	74.45	1.012	17.195
78	Цамцны цагаан- цэвэр	76.707	0.029	15.407
79	Цамцны цагаан- бохир	55.428	-0.476	12.534

80	Цамцны цагаан- бохир	55.915	0.635	15.936
81	Цамцны цагаан- бохир	56.388	1.673	17.464
82	Цамцны цагаан- бохир	53.988	1.791	16.185
83	Цамцны цагаан- бохир	59.871	2.847	20.707
84	Цамцны цагаан- бохир	56.449	1.325	17.411
85	Тэнгэрийн цэнхэр- цэвэр	27.967	-1.313	2.024
86	Тэнгэрийн цэнхэр- бохир саарал	47.719	-10.543	-15.599
87	Тэнгэрийн цэнхэр- бохир хар	34.93	-5.87	-1.519

4.Өнгөний зөрүү

Өнгөний зөрүү буюу ΔE-г дараах томъёогоор тооцно.

$$\Delta E^*_{ab} = \sqrt{(L^*_2 - L^*_1)^2 + (a^*_2 - a^*_1)^2 + (b^*_2 - b^*_1)^2}$$

Өнгөний зөрүүний утгын шинж чанаруудыг дараах байдлаар тайлбарлана.


Delta E / өнгөний зөрүү	Шинж чанар
<= 1.0	Хүний нүдэнд ажиглагдахааргүй өнгөний зөрүүтэй.
1 - 2	Ойрын ажиглахад мэдрэгдэх.
2 - 10	Зэрвэс харахад ажиглагдах.
11 - 49	Өнгөний эрс ялгаатай.
100	Эсрэг өнгөтэй.

5.Үр дүн

Цэгэн хэмжилтийн утгаас өнгөний зөрүүг тооцсон үр дүн дараах байдлаар гарсан.

Өнгө	delta E
Тэнгэрийн цэнхэр	19.2766
Үүлний цагаан	10.4063
Газрын ногоон	9.6316
Түгны шар	9.0488
Морины хүрэн	5.4349
Дээлний ногоон	6.2974
Цамцны цагаан	20.9528
Тэнгэрийн цэнхэр	28.034





“ЭМНЭГ СУРГАГЧ” УРАН ЗУРГИЙН ӨНГӨ БУДГИЙН МАТЕРИАЛ СУДАЛГАА

М.Оюунтулга PhD
СӨҮТ-ийн СБӨСЗГ-ын дарга

1.Ерөнхий ойлголт

Рентген флуоресценцийн багаж нь шугаман спектрийн рентген туяаны зарчмаар ажилладаг ба гаднын өдөөх цацрагийн нөлөөгөөр атомын электроны дотоод төвшнөөс электрон сугаран гарч, сугаран гарсан электроны байранд, гадаад төвшнөөс электрон шилжин орж, энэ шилжилтийн үр дүнд цахилгаан соронзон долгион цацарч, түүний шилжих хугацааг бүртгэх замаар элементийн агууламжийг тодорхойлдог өргөн хэрэглээний багаж юм. Энэ багажаар Na-Pu хүртэлх химийн элементүүдийн агууламжийг тодорхойлно. Атомын их энергитэй орбиталиос бага энергитэй орбиталь руу электрон шилжихэд фотон цацардаг. Цацруулсан фотоны энергийн хэмжээ хоёр орбиталийн хооронд электрон шилжихэд үүссэн энергийн ялгавартай тэнцүү байдаг. Х-гау нь электрон соронзон цацаргалтын хуульд захирагддаг ба долгиолог болон бөөмлөг шинжтэй. Рентген туяаны шингээлт ба сарнилтыг судлахдаа Е энерги бүхий фотоны урсгалыг ашигладаг. Фотоны шингээлтийн дараа атом цочирсон төлөвт орно. Электрон хоосон байр нь гадаад давхрааны электроноор бөглөгдөнө. Эдгээр 2 төлөвийн энергийн ялгаанаас рентген туяаны фотон цацарна. Элемент болгоны электронууд хувийн энергитэй бөгөөд түүнээс нь хамаарч элемент болгоны хувьд энергиэрээ ялгаатай рентген туяа үүсэх бөгөөд энэ туяаны шилжих хугацаагаар элементийн төрлийг олдог багаж юм.Энэхүү шинжилгээний аргын давуу тал нь материалыг гэмтээлгүй гадаргуу дээр шууд шинжилгээ хийж элементийн найрлагыг бүрэн тогтоох боломжтой хэдий ч эрдсийн найрлагыг тогтоох боломжгүй юм.

2.Материалын төрлийг тогтоох аргазүй

Уран зурагт ашигласан цэнхэр, ногоон, шар, цагаан төрлийн үндсэн 4 төрлийн будгийн найрлагыг тодорхойлоход зөөврийн рентгенфлоуресценцийн спектрометрийн багажид шинжилгээний X-MET7500 ашигласан. Энэхүү багажны таргет нь химийн элементийн 45-т дугаарлагдах Роди RhodiumRh болно. Хэмжилтийн хугацаа болон спектрийн хүчдэлийн хувьд харилцан адилгүй байдаг ба зөөврийн болон суурин шугаман спектрийн багаж нь харилцан адилгүй үзүүлэлттэй байдаг. СӨҮТ-д хийсэн будгуудийн параметрийн үзүүлэлт хэмжилтийн төрлийг уул уурхайн эрдсийн тохиргоон дээр тохируулж будгийн бохирдолтой хэсэг болон цэвэрлэсэн хэсэгт харьцуулсан хэмжилтийг хүчдэл 40Kv, хугацаа 10 секунд, хэмжилт хийхийн өмнө зэсний агууламжаар тестэр хийж тус тус спектрийг шалгаж хийсэн. Хэмжилтийн үед маш их энерги халалт үүсдэг учир шингэн Nазотоор -100 градусаас дээш хэмд төхөөрөмжийг хөргөх зарчим бүхий XRF байдаг хэдий ч СӨҮТ-ийн XRF нь арай сүүлийн загвар бөгөөд шингэн азот хэрэглэгдэхгүй болно. Хэмжилтэнд анхаарах зүйл нь хөдөлгөөнд спектрийн энерги сарниж цахилгаан соронзон долгионд алдаа гардаг учир аль болох хөдөлгөөнгүй тэгш гадаргуу хэмжиж тодорхойлон гаргаж будгийн материалын судалгааг хавсралт 1 дээр боловсруулан гаргав.



Зураг 5. X-MET7500



Зураг 6. Хэмжилт хийж буй байдал

3.Үр дүн

Хэмжилтийн үр дүнгээс будгийн найрлага, химийн элементийн бүтцэд анализ хийхэд Zn-цайрын элементээс голчлон бүрдэж буй өнгүүд ихэвчлэн шар(бараан), улаан хүрэн түүхий эд болж байна. Co-Кобальт элементээс голчлон тод хөх өнгө, Cl-Хлор, Cr-хром элемент нь голчлон ногоон өнгө, Zn-Цайр нь цагаан өнгийг үүсгэж буй түүхий эд болж байна.



Зураг 7. Co-Кобальтын цэнхэр



Зураг 8 Cl-Хлор, Cr-хромийн ногоон



Зураг 9. Zn-цайрын шар



Зураг 10. Zn-Цайрын цагаан

4.Цаашид хадгалах орчин бүрдүүлэх

Уран зургийг хадгалах хамгийн гол анхаарах зүйл нь хүрээлэн буй орчны чийг дулааны хэлбэлзэл, тоос шорооны бохирдол багатай, механик, хими, биологийн гэмтэл үүсэх эрсдэлгүй орчинд хадгалж хамгаалах нь тохиромжтой юм.

4.1 Тогтвортой орчин

Галерей болон музейн орчин чийгшил болон дулаан, хэт ягаан туяан хурц гэрэл ихээхэн гэмтэл учруулах гол шалтгаан болдог. Уран зургийн хувьд 18 хэмээс 20 хэмийн градус, 50 хувийн чийгшлээс 60 хувийн чийгшилтэй, гэрэлтүүлгийг 50-100 люкс гэрлийн тусгалын дулаан 4000 кельвинтэй орчинд хадгалах нь зохистой юм.

4.2 Анхаарах зүйл

Халуун дулааны хэт их хэлбэлзэлтэй орчин үүсгэхгүй байх нь чухал юм. Байгууламжаас хамааралтай агаарын урсгал багасаж, чийг тунаж дулаан орчин бүрдэхээс сэргийлж агааржуулах төхөөрөмж ашиглан үзэсгэлэнгийн танхим сан хөмрөгийн агаар сэлгэлтийг стандартын горимд хийж, тогтмол хяналт тавих шаардлагатай. Мөн

хадгалагдаж буй орчны чийгтэй болон хуурай цэвэрлэгээг тогтмол хийх хэрэгтэй.

4.3 Хадгалах арга

Нарны шууд тусгалаас тусгаарлаж, хэвтээ байдлаас зайлсхийж босоо байдлаар хадгалах нь зүйтэй. Сан хөмрөгт хадгалах тохиолдолд тоос шорооны бохирдлоос сэргийлэх зорилгоор уран зургийн гадаргуу хэсэгт агаарын урсгал сайтай шүлтлэггүй материал ашиглаж бүрэн боож хадгалах шаардлагатай.

4.4 Арчилгаа

Уран зургийн гадаргуу хэсэгт тогтсон тоос шорооны бохирдолд байнгын хуурай цэвэрлэгээ хийж байх шаардлагатай. Агааржуулалт муутай, чийглэг газар удаан хугацаагаар хадгалах нь уран зургийн нөхцөл байдлыг доройтуулах нэгээхэн хүчин зүйл нь болдог. Агааржуулагчгүй орчин нь хөгц, толбо, түлэгдэлт, бүдгэрэх зэрэг гэмтлийг үүсгэдэг учир агаар сэлгэлт сайтай эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.

Гүйцэтгэлийн зорилтын 3.1.1.2

Шороон бумбагарын дурсгалт газрын ханын зургийн цэвэрлэгээ, судалгааны ажил.

БУЛГАН АЙМГИЙН БАЯННУУР СУМЫН НУТАГТ ОРШИХ МАЙХАН УУЛЫН ШОРООН БУМБАГАРЫН БУНХАНТ БУЛШНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВЬСАН ТАЙЛАН

1. Удиртгал

Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын шороон бумбагарын бунхант булшны өнөөгийн нөхцөл байдалд хяналт тавих, бунханд байрлуулсан бичил цаг уурын төхөөрөмжүүдийн санамжийг хуулж, бунхны модон бэхэлгээ болон хананд ургасан бичил биетэн, хөгц мөөгөнцрийг ажиглах, зургаар баримтжуулах зэрэг ажлыг хийхээр Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет өвийг сэргээн засварлах газрын Ерөнхий технологич М. Оюунтулга, сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Э. Батжаргал, нярав С. Сайнзолбоо, жолооч Д. Шижир нарын бүрэлдэхүүнтэй баг 2020 оны 05 сарын 26 өдөр 1 хоног томилолтоор ажиллав.

2. Хяналтын зорилго

Ил дурсгал болох бунхант булшны эх төрхийг хамгаалж хадгалан үлдээх, дурсгалыг тал хээрийн бүсийн онцлогт таарсан эрсдэлээс хамгаалах орчин бүрдүүлж цаг уур, байгалийн хүрээлэн буй тогтвортой ба тогтворгүй орчны нөлөөллөөс үүсэх физик хими, механик гэмтлийг тодорхойлж ажиглалт хийж гэмтлийн эрсдэлийг багасгах зорилготой юм.

3. Баримтжуулалт

Дурсгал дээр очиж дурсгалын байдалтай танилцахад үүдэвч хэсэгт хуучин хөрсний чийг голлон нэвчиж, зүүн ханын хэсэгт эрдэс давсны талстжилт харьцангуй их хэмжээгээр үүссэн байдалтай, баруун ханын хэсэг эрдэс давсны талстжилт харьцангуй бага хэдий ч шавар үе давхарга үйрч унан дүрслэл хэсгүүд их хэмжээгээр гэмтсэн байдалтай үүдэвч хэсгийн 2 хана дээрээсээ доош бунханлуу чиглэн өндөр чийгийн хэлбэлзэл нөлөөнд аажмаар үйрч, чийгний улмаас өнгө будаг бүхий нимгэн шавар давхаргын өнгөн хэсэгт тэлэлт үүсэн улмаар хананаас хөндий үүсэж, үйрч унах үзэгдэл үргэлжилсээр байна.



Зураг 1: зүүн ханын нуранга



Зураг 2: баруун ханын луутай хэсэг



Зураг 3: зүүн ханын хүн, морьтой хэсэг

Цаашлан бунхны дотор хэсэгт ажиглалт хийхэд модон бэхэлгээ болон ханын зураг бүхий ханын зарим хэсгүүдээр хөгц мөөгөнцөр нэлээд ургасан ба ихэнх хэсэг нь харьцангуй хатаж хуурайшсан хэвээр байсан. Энэ Бунхны дотор талд хойд болон баруун хананаас нуралт хуучин нурж байсан хэсгээс нэмж нурсан, бунхны урд хүзүүвч хэсэгт шинээр их хэмжээний чулуу шороо нурсан байдалтай байсан ба эдгээр нуралтын явцад ханын зургийн хэсэг бүрэн идэгдэж устах эрсдэл өндөр байна.

Өрхүүдэд хийсэн модон бэхэлгээнүүд нилээд өгөршиж муудсан, зарим газраа хамгаалалтын модон бэхэлгээний цүлхийлт нэмэгдсэн, мөн бунхны зүүн хөмөгний бэхэлгээ нурж унасан байдалтай, хоёр дахь хөмөгний дарын дээд хананд байрлах ханын зурагт чийг хуримтлагдаж, гол хэсгээрээ хөгц мөөгөнцөр үүссэн байдалтай байсан.

4. Чийгшил дулааны хэмжилт

Япон улсын Киотогийн их сургуулийн докторант О. Ангарагсүрэн СӨҮТ-ийн СБӨСЗГ-тай хамтран хийж буй бичил орчны судалгааны хэмжилтийн багаж төхөөрөмжүүдийн цуглуулсан мэдээллийг гадна орчны дулаан чийгшил, шүүдэр хэмжигч 14ш, хөрсний дулаан чийгшил хэмжигч 4ш санамжийг хуулж авах ажлыг хийсэн.




Зураг 4: үүдэвч хэсгийн дүрслэл




Зураг 5: хөмөгний дээд хэсгийн дүрслэл




Зураг 6: модон бэхэлгээний хэсгүүд




Зураг 7: чийгшил дулааны мэдээлэл хуулах байдал



Хүснэгт 1: Бунхны байгууламжны гадна байрлах хэмжигч



Хүснэгт 2: Бунхны үүдэн хэсгийн дээд хэсэг №16



Хүснэгт 3: Бунхны үүдэн хэсгийн доод хэсэг №03

Бунхны байгууламжийн гадна байрлах хэмжилтийн хүснэгт 1-т гарсан үр дүнгээс хархад 1-р сараас 6 сар хүртэлх хугацаанд гадаах орчинд халууны хэлбэлзэл нэмэх хасах 30 градус цельстэй байгаа нь эрс тэрс уур амьсгалтай бүс нутагт байрлаж байгаа нь тодорхой байна. Чийгшлийн хувьд хүйтний улирал болох сэрүүн үеүүдэд чийгшил 80 хувиас дээшилж, дулааны улирал эхэлж 30 градус цельс хэмээс дээш дулаарахад агаарын хуурайшилт явагдаж чийгшил 10 хувиас доош орж байгаа нь халуун хүйтний хэлбэлзлээс үүдэлтэй чийгшлийн тогтворгүй орчны нөлөөллийн бүсэд тухайн дурсгал байна. Дурсгалын гадна талд гадаад орчноос тусгаарлах байгууламж барьж үүдэвч хэсгийг давхар гялгар уутаар хучиж битүүмжилсэн нь гаднаас тусгаарлах давуу тал болж байгаа хэдий ч бунхны үүдэвч хэсгийн дээд хэсэгт хийсэн хэмжилтийн үр дүн хүснэгт 2-с хархад хүйтны улиралд 2 градус цельстэй байгаа орчин дулааны улирал эхэлхэд 6 градус цельс, чийгшил тогтмол 80 хувиас дээш 90 хувь, 100 хувь болж хэлбэлзэлж байгаа нь үүдэвчний дээд хэсгийн битүүмжлэл муу гадны нөлөөллөөс хамааралтай байгаа нь тодорхой байна. Бунхны үүдэн хэсгийн доод хэсэгт хийсэн хэмжилтийн үр дүн хүснэгт 3-с хархад хүйтний улиралд -2 градус цельстэй байгаа орчин дулааны улирал эхлэхэд 3 градус цельс, чийгшил тогтмол 90 хувиас дээш 100 хувь болж хэлбэлзэж байгаа нь үүдэвч хэсгийн доод хэсгийн битүүмжлэл муу гадны нөлөөллөөс хамааралтай байгаа хэдийч дээд хэсэгтэй харьцуулбал гаднын шууд нөлөөллөөс бага байгаа нь тодорхой байна. Гэвч энэхүү өндөр чийгшил битүүмжлэл бага байгаа нөлөөллөөс агаар салхи, тоос шорооны нөлөөллөөс байгалийн хүчин зүйлээс хамааралтай гэмтэл явагдсаар байна. Мөн энэ оны намраас бунхны ханын зургийн гандалт хэрхэн явагдаж байгаа төвшинг бүтэн жилээр тогтоох зорилгоор өнгөний гандалтыг үүдэвч хэсэг болон бунхны дотор хэсгийн зургуудад хийж эхлээд байна.

5. Дүгнэлт

Хүйтний улиралд хөлдөөс байсан хөрс гэсэж, гаднын дулаан болон агаарын урсгалын нөлөөнд халуун хүйтэн хэлбэлзэж, бунхны өндөр чийгшил сэрүүн нөхцөлд шууд нөлөөлөл үзүүлснээр хөгц мөөгөнцөр үүсгэх нян бактерийг үйлчлэлд оруулж, цас хайлж, бороony улирал эхэлснээс үүдэн уур чийгнийн хамааралтай хөрсний эрдэс хөдөлгөөнд орж ханын гадаргуу хэсэгт эрдсийг түрэн гаргаснаас болж ханын зургийн гэмтэл явагдсаар байна. Цаашид байгалийн хөрснөөс тусгаарлах, гаднаас авах дулаан чийг, агаарын урсгалыг багасгаж битүүмжлэх арга хэмжээ авахгүй бол газар гэсэж хөлдөх давтамжаас болж дурсгалын нийт ханын зураг бүрэн гэмтэлд орж ямар нэг хэмжээнд нуранга үүсэж болзошгүй ба цаашид бунхан дотор ажиллах нь эрсдэлтэй байж болохоор харагдаж байна.

Гүйцэтгэлийн зорилт №3.1.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийг төгөлдөржүүлэх

Эрх зүйн акт:

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйл, Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл.

2. Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм 2.1.1 Соёлын өвийг бүртгэн мэдээлэх чиг үүрэг

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.1-р арга хэмжээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах төрийн захиргааны төв байгууллагаас томилогдох Ажлын хэсэг гарах бөгөөд дээрх ажил хэрэгжээгүй. Тайлант хугацаанд 5 орон нутгийн музейд очиж ажиллахаар төлөвлөсөн ч дэлхий нийтэд тархсан covid-19 цар тахлын хорио цээрийн дэглэм нөхцөл байдлаас хамааран орон нутгийн томилолт явагдаагүй болно.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 тооллогын мөрөөр дараах арга хэмжээг зохион байгууллаа.Үүнд:

1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогын баримтыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээн авав. Одоо тооллогын нэгдсэн тайлан болон холбогдох бусад цаасан суурьтай баримт, төрийн өмчийн голдуу 16 байгууллагын цахим баримт дутуу байгаа бөгөөд санд хүлээн авсан цахим баримтаа нэг бүрчлэн шалгаж тогтоох ажлыг хийлээ.

2. 2007-2008, 2012-2013 оны улсын тооллогоор хасаж актлагдсан үзмэр, эд өлгийн зүйлийг Регистр болон RCH программаас хасаж, тухайн музейн хасаж акталсан тухай бүртгэлд шилжүүлэн, улсын тооллогын үр дүнгийн мөрөөр музейн цахим бүртгэлийг цэгцлэх ажлыг эхлүүлээд байна. Хэнтий аймгийн музей, Монгол Цэргийн музей, Төв аймгийн музей зэрэг газруудаас Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны а/335 тоот тушаалаар батлагдсан “музейн сан хөмрөгийг бүртгэн баримтжуулах заавар”-ын 2.6.4 дүгээрт заасны дагуу ирүүлсэн албан бичиг, холбогдох баримт материалыг үндэслэн Регистр программаас хасах ажлыг зохион байгуулав.

- Хэнтий аймгийн музейгээс ирүүлсэн 2012-2013 оны улсын тооллогоор хасаж актласан тухай холбогдох баримтыг үндэслэн музейн сан хөмрөгийн ерөнхий бүртгэлээс хасаж эргэлтийн хөрөнгөд шилжүүлсэн 23 дэсийн 89 ширхэг үзмэрийн бүртгэлийг, мөн хасаж акталсан 8 дэсийн 8 үзмэрийн бүртгэлийг (нийт 31 дэсийн 97 ширхэг) Регистр программаас хассан. Регистрийн бүртгэлээс хасагдсантай холбогдуулан RCH программд бүртгэгдсэн бол мөн дагаж өөрчлөлт орос ёстой. Тус үндэсний төв нь RCH бүртгэлийн программд нэмэлт хөгжүүлэлт хийхтэй холбогдуулан дээрх хасаж акталсан 8 дэсийн 8 ширхэг, эргэлтийн хөрөнгөд шилжүүлсэн 23 дэсийн 89 үзмэрийн бүртгэлийг RCH программаас мэдээллийг хасаагүй ба цаашдаа “архивлан хадгалах” талбарыг бий болгон, шилжүүлэхээр бэлтгэсэн.

- Монгол цэргийн музейгээс ирүүлсэн 2020 оны 9 сарын 07 тоот албан бичиг, холбогдох баримтуудад үндэслэн: тус музейгээс хулгайд алдагдсан нь хууль хяналтын байгууллагаар асуудал нь шийдвэрлэгдсэн 3 дэсийн 4 ширхэг, Төрийн түүхийн музейд шилжүүлсэн 3 дэсийн 5 ширхэг үзмэрийн (нийт 6 дэсийн 9 ширхэг) бүртгэлийг ерөнхий бүртгэлийн Регистр программаас тус тус хасалт хийж дэсийг нөхөн эрэмблэв.

- Төв аймгийн музейн 2020 оны 66 тоот албан бичиг, холбогдох баримт материалд дурдсанчилан 2012-2013 оны музейн сан хөмрөгийн улсын тооллогын мөрөөр Төв

аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2013 оны хөрөнгө шийдвэрлэх тухай 114 тоот тогтоолоор Төв аймгийн музейгээс 22 дэсийн 25 ширхэг үзмэрийг актлах тухай шийдвэрлэсэн ба уг шийдвэрийн дагуу тус музейн захирлын 2013 оны Б/38 тоот тушаалаар 16 дэсийн 19 ширхэг үзмэрийг акталж устгасан байх тул Регистр программаас хасалт хийсэн.

- Соёлын өвийн УНБМСангаас дараах үзмэрүүдийн бүртгэлд тус, тус хасалт хийхийг түдгэлзсэн. Үүнд: Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2012-2013 онд акталж устгасан гэж тайланд тусгасан хэрнээ 2018-2019 онд явагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогоор Хэнтий аймгийн музей 3 ширхэг үзмэрт, Төв аймгийн музейн 6 ширхэг үзмэрт тус тус Регистр программд “Тоолов” тэмдэг дарсан маргаантай асуудалтай байх тул түр түдгэлзүүлсэн.

3. 2018-19 оны Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн Улсын тооллогоор бүртгэгдсэн REGISTER прогаммын мэдээллийн санг нэгдсэн онлайн горимд шилжүүлж www.register.mongoluv.mn домэйнд байрлуулах ажлыг Сайбер-Андромеда ХХК-тай хамтран хийж гүйцэтгэв. Энэхүү систем нь тусгай байгууллага хэрэглэгчийн эрхээр нэвтэрч мэдээлэл авах боломжтой болно.



Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.2-р арга хэмжээ.

Цаасан болон цахим суурьтай соёлын өвийн мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байр руу нүүлгэн шилжүүлэх.

2020 оны төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх ажил хийхээр төлөвлөсөн боловч дэлхий нийтэд тархаад буй “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр энэхүү ажил бүрэн хийгдэж дуусаагүй болно.

Бэлтгэл ажлын хүрээнд 40 удаагийн нүүлгэлт хийхээр төлөвлөсөнөөс өнөөдрийн байдлаар хэсэгчилсэн 2 удаагийн нүүлгэлт хийгдэж, тавилга, тоног төхөөрөмж болон СӨУНБМСанд хадгалагдаж байгаа 2008, 2012 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын Ерөнхий бүртгэлийн нийт 536 дэвтэр, 108 хадгаламжийн нэгж тайлан байснаас 484 ширхэг Ерөнхий бүртгэлийн дэвтэр болон 108 хадгаламжийн нэгж тайланг 10 хайрцагт хийж нэр, дугаар өгч, шинэ барилгад байршууллаа.

Баримтын нэр	СӨУНБМСанд байгаа		Хайрцагласан баримт		
	ЕБД	Тайлан	ЕБД	Тайлан	Хайрцаг тоо
2008 оны улсын тооллого	143	44	97	44	**10 ширхэг**
2012 оны улсын тооллого	393	64	387	64	
Нийт	**536**	**108**	**484**	**108**	

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.3-р арга хэмжээ. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цаасан болон цахим архивыг төгөлдөржүүлэх.

1. УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ ТАЙЛАН

Гарчиг

Удиртгал
Нэгдүгээр бүлэг: Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл
Шинээр нэмэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл
Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний мэдээлэл
Дүгнэлт
Хавсралт

Хоёрдугаар бүлэг: Түүх соёлын үл хөдлөх дурсгал
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн мэдээлэл
Дүгнэлт

Гуравдугаар бүлэг: Соёлын биет бус өв
Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн тайлан
Дүгнэлт
Хавсралтууд

Дүгнэлт
Цаашид авах арга хэмжээний санал

УДИРТГАЛ

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 23.2, 23.3, 20.8, “Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 2.3-т д заасны дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн тайланг жил бүр авч ирлээ.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн 2019 оны тайланг 2020 оны 02 дугаар сарын 15-ны дотор холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн гаргав. Түүх, соёлын үл хөдлөх, хөдлөх дурсгалт зүйлийн тайланг “Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан”, “Музей болон байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан”, “Соёлын өвийн авран хамгаалах, хайгуул, малтлага, судалгаа явуулдаг байгууллагын тайлан” гэсэн маягтаар авч нэгтгэсэн.

Соёлын биет бус өв түүнийг өвлөн уламжлагчдын тайланг “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл”, “Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн”, “Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн”, “Соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн” гэсэн 4 төрлийн хүснэгтээр авч нэгтгэн гаргав.

Тус тайланд нийслэлийн соёл урлагийн газар, 21 аймгийн боловсрол, соёл урлагийн газар, төрийн болон орон нутгийн өмчийн 30 музей, Эрдэм шинжилгээ судалгааны 6 байгууллага, Монголын Бурхан шашины төв- Гандантэгчинлэн хийд, Монгол банкны Эрдэнэсийн сан зэрэг нийт 66 байгууллагын соёлын өвийн бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэл хамрагдсан болно.

СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН
БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛ

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайланг нэгтгэхэд нийт тайлан ирүүлэх ёстой 48 байгууллагаас Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Улаанбаатарын Их Сургуулиас мэдээлэл ирээгүй. Үлдсэн 45 байгууллагаас ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа тайлан ирүүлсэн ч хөдлөх дурсгалт зүйлийн мэдээлэл байхгүй тул тайлангийн мэдээнд ороогүй болно.

Нийслэлийн соёл, урлагийн газар Улаанбаатар хотын музейн мэдээллийг хувилан ирүүлсэн. Нийслэлийн хэмжээний соёлын өвийн мэдээллийг нэгтгэх ёстой уг байгууллага 2015 оноос хойш байнга ийм тайлан ирүүлж байгаад анхаарал хандуулах шаардлагатай болоод байна.

Тайлан ирүүлсэн 40 байгууллагаас Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Монгол төрийн түүхийн музей, Хөшөө цайдам музей, Үндэсний номын сан, Улаанбаатар хотын музей, Ялалт музей, Эрдэнэ-зуу музей, Гандантэгчинлэн хийд гэсэн нийт 9 байгууллагад үзмэр, эд өлгийн зүйлийн нэмэлт баяжилт хийгдээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн музей. 2019 онд улс, аймгийн 28 музей нийт 725 дэсийн 1101 ширхэг ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. Үүнийг сан хөмрөгт авсан арга замаар нь авч үзвэл нийт үзмэрийн 19.3% буюу 140 дэсийн 234 ширхэг үзмэрийг 21 музей худалдаж авсан. Өндөр дүнтэй музейг дурьдвал: Говьсүмбэр аймгийн музей 28 дэсийн 32 ширхэг, Дархан-Уул аймгийн музей 22 дэсийн 25 ширхэг, Дорнод аймгийн музей 23 дэсийн 24 ширхэг үзмэр тус тус худалдан авсан байна.

Бэлэг хандиваар нийт үзмэрийн 53% буюу 17 музей 384 дэсийн 594 ширхэг үзмэрийг авсан. Өндөр дүнтэй нь, Баянхонгор аймгийн музей 110 дэсийн 119 ширхэг үзмэр, Өмнөговь аймгийн музей 70 дэсийн 95 ширхэг, Монголын уран зургийн галерей 40 дэсийн 45 ширхэг үзмэр тус тус авсан.

Шилжүүлэгээр 13.5% буюу 10 музей 98 дэсийн 143 ширхэг үзмэр авсан. Өндөр дүнтэй нь, Байгалийн түүхийн музей 43 ширхэг, Хархорум музей 13 дэсийн 48 ширхэг, Баянхонгор аймгийн музей 15 дэсийн 16 ширхэг үзмэр тус тус авчээ.

Эрдэм шинжилгээ судалгаагаар: 10.4% буюу 3 музей 76 дэсийн 95 ширхэг үзмэр авсан. Үүнд: Монголын Үндэсний музей 42 дэсийн 61 ширхэг, Байгалийн түүхийн музей 25 дэсийн 25 ширхэг, Орхон аймгийн музей 9 дэсийн 9 ширхэг үзмэр авсан.


Бусад арга зам ангиллаар: 3.3% буюу Дундговь аймгийн музей 24 дэсийн 26 ширхэг үзмэр оруулсан байна. Тус музей нь эдгээр үзмэрийг хайгуулаар олж авчирсан тул эрдэм шинжилгээ судалгаа ангилалд оруулах нь зүйтэй байсан боловч энэхүү ангилалыг сонгожээ. Музейд орсон арга замыг энэ мэт буруу тодорхойлох, мөн үзмэрийн дэс, тоо ширхэгийг дутуу, зөрүүлж бичих, түүнчлэн гарын үсэг зуралгүй явуулах зэрэг асуудал Уран зургийн галерей, Монголын театрын музей болон Архангай, Орхон, Хөвсгөл зэрэг ихэнх аймагт байсаар байгааг анхаарах нь зүйтэй юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн бусад байгууллага. Энэ удаагийн тайланг ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монгол банкны Эрдэнэсийн сан, Ховд их сургууль шинээр нэмэгдсэн дурсгалын мэдээлэл ирүүлж, нийтдээ 384 дэсийн 895 ширхэг дурсгалаар сан хөмрөгөө баяжуулсан ба үүний 86% буюу 330 дэсийн 728 ширхэг дурсгалыг эрдэм, шинжилгээ судалгаагаар олж авсан байна. Археологийн хүрээлэн 2019 оны тайландаа 2018 онд дурсгалаа оруулж явуулсан тул жагсаалтыг гаргасан ЭШАжилтантай холбогдож дахин засвар хийлгүүлснээр 320 дэсийн 437 ширхэг дурсгал болсон. Гэвч эдгээр дурсгалаа цахим бүртгэлдээ оруулаагүй байна. Палеонтологийн хүрээлэнгийн хувьд 6 дэсийн 6 ширхэг дурсгалаар сан хөмрөгөө

баяжуулж цахим бүртгэлд оруулсан боловч сан хөмрөгт авсан арга замаа “бусад” гэсэн тодорхойгүй ангиллыг сонгосон байна. Ховд их сургууль мөн ангиллаа буруу сонгосон. Эрдэнэсийн сан тайлангаа хуучин буруу маягтаар хийж ирүүлжээ. Эдгээр байгууллагууд бүгд баяжилтаар нэмэгдсэн дурсгалдаа “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-*ын дагуу хувийн дугаар өгөөгүй, бүртгэлд авсан тухай албан ёсны баримт байхгүй, тэмдэглээгүй зэрэг асуудал байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн нийт 32 музей, байгууллага 2019 онд нийтдээ 1109 дэсийн 1996 ширхэг дурсгалаар сан хөмрөгөө баяжуулсан ба үүнийг сан хөмрөгт авсан арга замаар хувилан гаргахад нийт үзмэрийн 34.7%-ийг бэлэг хандиваар авсан дүн гарч байна. Хүснэгтлэсэн нийт тоон дүнг хавсралтаас харна уу. (Хавсралт №1).

Шинээр нэмэгдсэн үзмэрийг сан хөмрөгт авсан арга замыг дор зургаар илэрхийлэв.



Шинээр нэмэгдсэн 1096 дэсийн 1682 ширхэг үзмэрийн 58.3 % буюу 640 дэсийн 888 ширхэг үзмэр нь зөвхөн “Register” программд орсон, 33.4% буюу 367 дэсийн 511 ширхэг үзмэрийг RCH программд оруулсан байна. Цахим программд оруулсан үзмэрийн хүснэгтлэсэн нийт дүнг хавсралтаас харна уу. (Хавсралт №2).

Шинээр нэмэгдсэн нийт дурсгалыг төрөл зүйлээр нь ангилбал:

Археологийн олдвор 448 дэсийн 1020 ширхэг дурсгалаар 12 байгууллага,
Түүхийн үзмэр 200 дэсийн 382 ширхэг дурсгалаар 19 музей,
Угсаатны зүйн үзмэр 167 дэсийн 242 ширхэг дурсгалаар 20 музей,
Шашин шүтлэг 110 дэсийн 145 ширхэг дурсгалаар 11 музей,
Урлаг, уран сайхан 94 дэсийн 112 ширхэг дурсгалаар 13 музей,
Байгалийн түүхийн 89 дэсийн 93 ширхэг дурсгалаар 8 музей тус тус баяжилт хийсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас харна уу. (Хавсралт №3)

Шинээр нэмэгдсэн үзмэрийн төрөл зүйлийг хувилан харахад нийт үзмэрийн 40% буюу 448 дэсийн 1020 ширхэг үзмэрийг археологийн дурсгал эзлэж байна. Гэтэл үүний 74%-ийг зөвхөн Археологийн хүрээлэн, Ховд их сургуулийн нийт 333 дэсийн 751 ширхэг дурсгал бүрдүүлж байна. Төрөл зүйлийн эзлэх хувийг зургаар үзүүллээ. (Зураг 2)



Орон нутаг судлах танхим. Орон нутаг судлах танхимын баяжилтын мэдээг 15 аймгийн бүртгэл, мэдээллийн сан ирүүлсэн. Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Орхон, Төв, Сүхбаатар гэсэн 6 аймгийн Орон нутаг судлах танхим баяжилт хийгдээгүй байна.

Мэдээлэл ирүүлсэн 15 аймагт нийт 104 сумын Орон нутаг судлах танхим 1119 дэсийн 1160 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжуулсан ба үүнийг сан хөмрөгт авсан арга замаар нь ангилбал:

Бэлэг хандиваар 76.3 % буюу 854 дэсийн 894 ширхэг үзмэрийг

Худалдаж авсан 9.0 % буюу 101 дэсийн 102 ширхэг үзмэрийг

Шилжүүлгээр 0.35 % буюу 4 дэсийн 4 ширхэг үзмэрийг

Эрдэм шинжилгээ судалгаагаар 0.26% буюу 3 дэсийн 3 ширхэг үзмэрийг

Бусад арга замаар 14 % буюу 157 дэсийн 157 үзмэрийг тус тус цуглуулсан байна. Орон нутаг судлах танхимуудаас хамгийн их үзмэрээр баяжигдсан аймагт: Дундговь аймгийн 13 сумын Орон нутаг судлах танхим нийт 361 дэсийн үзмэрээр, Ховд аймгийн 10 сумын Орон нутаг судлах танхим нийт 184 дэсийн үзмэрээр, Хөвсгөл аймгийн 7 сумын Орон нутаг судлах танхим нийт 3161 дэсийн үзмэрээр тус тус баяжуулсан байна. Орон нутаг судлах танхимын баяжилтын дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №1

№	Нэрс	Сумдын тоо	Худалдаж авсан		Бэлэг, хандиваар ирсэн		Шилжиж ирсэн		Эрдэм шинжилгээ судалгаагаар ирсэн		Бусад замаар ирсэн		Дүн	
			дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1	Архангай аймаг	5	0	0	30	42	1	1	0	0	1	1	32	44
2	Баян-Өлгий аймаг	8	1	1	20	47	0	0	0	0	0	0	21	48
3	Баянхонгор аймаг	10	0	0	22	22	0	0	0	0	0	0	22	22
4	Булган аймаг	1	0	0	15	15	0	0	0	0	0	0	15	15
5	Говь-Алтай аймаг	3	0	0	7	7	0	0	1	1	0	0	8	8
6	Дорноговь аймаг	11	0	0	106	106	0	0	0	0	0	0	106	106
7	Дундговь аймаг	13	0	0	274	274	0	0	0	0	87	87	361	361

8	Завхан аймаг	22	6	6	110	110	0	0	2	2	4	4	122	122
9	Өвөрхангай аймаг	1	0	0	0	0	0	0	0	0	14	14	14	14
10	Өмнөговь аймаг	4	9	10	12	13	0	0	0	0	3	3	24	26
11	Сэлэнгэ аймаг	2	0	0	5	5	0	0	0	0	0	0	5	5
12	Увс аймаг	4	0	0	34	34	0	0	0	0	0	0	34	34
13	Ховд аймаг	10	59	59	125	125	0	0	0	0	0	0	184	184
14	Хөвсгөл аймаг	7	20	20	90	90	3	3	0	0	48	48	161	161
15	Хэнтий аймаг	3	6	6	4	4	0	0	0	0	0	0	10	10
	Нийт	104	101	102	854	894	4	4	3	3	157	157	1119	1160

Баяжилтаар нэмэгдсэн үзмэрийг төрөл зүйлээр нь ангилахад:
Археологийн олдвор 4.3% буюу 48 дэсийн 48 ширхэг,
Түүхийн үзмэр 13% буюу 146 дэсийн 155 ширхэг,
Угсаатны зүйн үзмэр 53.3 % буюу 595 дэсийн 597 ширхэг,
Шашин шүтлэгийн 17.3 % буюу 194 дэсийн 195 ширхэг,
Урлаг, уран сайхны 6.4 % буюу 78 дэсийн 81 ширхэг,
Байгалийн түүхийн 5.4% буюу 63 дэсийн 89 ширхэг байна.

Төрийн өмчийн бусад байгууллага. Төрийн өмчийн бусад байгууллагаас 1 байгууллага буюу Хэнтий аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас аймгийн Р.Чойномын нэрэмжит Нийтийн номын санд 5 судар авсан тухай мэдээлсэн.

Хувь хүний эд өлгийн зүйлийн бүртгэл. Хувь хүнд хадгалагдаж байгаа дурсгалт зүйлийн бүртгэлийг 4 аймгийн бүртгэл мэдээллийн сан нийт 123 иргэний 155 ширхэг эд өлгийн зүйлийг бүртгэсэн байна. Хувь хүнд хадгалагдаж байгаа эд өлгийн зүйлийн бүртгэлийн мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №2

№	Аймгийн СӨБМС	Хамрагд-сан хүн	Дурсгалын тоо	
			Дэс	Шир
1	Баянхонгор аймгийн СӨБМСан	46	66	66
2	Говьсүмбэр аймгийн СӨБМСан	71	78	78
3	Өмнөговь аймгийн СӨБМСан	3	3	3
4	Сүхбаатар аймгийн СӨБМСан	3	8	8
	Нийт	**123**	**155**	**155**

ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ

Түүх, соёлын дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөн улсын 10 музей, орон нутгийн 20, судалгаа шинжилгээний 2 байгууллага (ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн), шашны 1 байгууллага (Гандантэгчинлэн хийд) нийт 33 байгууллагад хийгдсэн байна. Үүнд, дотоодын үзэсгэлэнд 28 музейн 3423 дэсийн 5797 ширхэг үзмэр, гадаадын үзэсгэлэнд 4 байгууллагын 206 дэсийн 478 ширхэг үзмэр, судалгаа шинжилгээнд 10 музейн 1272 дэсийн 2066 ширхэг үзмэр, сэргээн засварлалтад 17 байгууллагын 147 дэсийн 363 ширхэг нийтдээ 4901 дэсийн 8704 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл шилжилт хөдөлгөөнд орсон байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №3

д/д	Нэрс	Байгууллагын тоо	Дотоодын үзэсгэлэнд оролцсон		Гадаадын үзэсгэлэнд оролцсон		Судалгаа, шинжилгээнд хамрагдсан		Сэргээн засварлагдсан		Дүн	
			дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1	Улс, орон нутгийн музей	10	1546	2123	25	40	1046	1323	36	251	4496	5907
2	Орон нутгийн музей	20	1709	2832	27	32	226	743	46	47	208	5870
3	Судалгаа, шинжилгээний байгууллага	2	151	823	154	406			40	40	345	1959
4	Шашны байгууллага	1	17	19					25	25	42	44
Нийт		**33**	**3423**	**5797**	**206**	**478**	**1272**	**2066**	**147**	**363**	**4901**	**8704**

Дэлгэрэнгүй тоон дүнг хүснэгтээр үзүүлэв. (Хавсралт №6)

Шилжилт хөдөлгөөнд хамрагдсан үзмэрээс сэргээн засварлагдсан үзмэрийн мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн тайлантай тулгахад: Чойжин ламын сүм музей 7 үзмэр засварлагдсан боловч тайланд 1, Уран зургийн галерей 5 үзмэр засварлагдсан боловч тайланд 2 гэж бичсэн бол Улаанбаатар хотын музей 1, Дархан-Уул аймгийн музей 1, Дорнод аймгийн музей 5, Увс аймгийн музей 2 үзмэр сэргээн засварлуулсанаа тайланд оруулаагүй байна.

Шилжилт хөдөлгөөнд хамрагдсан үзмэрийг хувилан зургаар үзүүлэв.



ДҮГНЭЛТ

• Улс, аймаг, байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн баяжилт төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей, орон нутаг судлах танхим 104, орон нутгийн өмчийн бусад байгууллага 1 нийт 136 байгууллагад хийгдсэн.

• Төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей нийт 1109 дэсийн 1119 ширхэг, Орон нутаг судлах танхим нийтдээ 1119 дэсийн 116 ширхэг, орон нутгийн өмчийн номын сан 5 дэсийн 5 ширхэг нийт 2233 дэсийн 3161 ширхэг дурсгалаар сан хөмрөгөө баяжуулсан байна.

• Нэмэгдсэн үзмэрийн 11% буюу 246 дэсийн 341 ширхэг үзмэрийг улсын болон орон нутгийн төсвөөс худалдаж авсан бол үлдсэн 89 %-ийг бэлэг хандив, шилжүүлэг, судалгаа шинжилгээ, бусад арга замаар авсан байна. Үүнээс манай музейнүүд үзмэрийн шаардлага хангасан чанартай үзмэрээр сан хөрмрөгөө баяжуулж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

• Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд 4 аймгийн 123 хувь хүний 155 дэсийн 155 ширхэг эд өлгийн зүйлийг улсын бүртгэлд авсан байна.

• Түүх, соёлын дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөнд нийт 33 байгууллагын 4901 дэсийн 8704 ширхэг дурсгал хамрагдав. Үүнээс, дотоодын үзэсгэлэнд 28 музейн 3423 дэсийн 5797 ширхэг үзмэр, гадаадын үзэсгэлэнд 4 байгууллагын 206 дэсийн 478 ширхэг үзмэр, судалгаа шинжилгээнд 10 музейн 1272 дэсийн 2066 ширхэг үзмэр, сэргээн засварлалтад 17 байгууллагын 147 дэсийн 363 ширхэг үзмэр хамрагдсан байна.

• ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монгол банкны Эрдэнэсийн сан, Ховд их сургуулийн тайлангаас харахад санд зааврын дагуу хувийн дугаар өгөгдөөгүй, цахим бүртгэлд оруулаагүй зэрэг асуудал байна.

Хавсралт №1

Шинээр нэмэгдсэн үзмэрийн нэгдсэн тоон дүн

Д/д	Нэрс	Худалдаж авсан		Бэлэг, хандиваар ирсэн		Шилжиж ирсэн		Эрдэм шинжилгээ судалгаагаар ирсэн		Бусад замаар ирсэн		Дүн	
		дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
Төрийн болон орон нутгийн өмчийн музей													
1	Монголын үндэсний музей	1	1	31	49			42	61			74	111
2	Байгалийн түүхийн музей	3	3			43	43	25	25			71	71
3	Чойжин ламын сүм музей					9	9					9	9
4	Монголын уран зургийн галерей	5	5	40	45							45	50
5	Монголын театрын музей	9	9	6	12							15	21
6	Хархорум музей			3	5	13	48					16	53
7	Монгол цэргийн музей	1	82	4	16							5	98
8	Архангай аймгийн музей	1	1			2	2					3	3
9	Баян-Өлгий аймгийн музей	1	2	8	27							9	29

10	Баянхонгор аймгийн музей	9	9	110	119	15	16					134	144
11	Булган аймгийн музей			23	31							23	31
12	Говь-Алтай аймгийн музей	1	1	2	25							3	26
13	Говьсүмбэр аймгийн музей	28	32	27	32							55	64
14	Дархан-Уул аймгийн музей	22	25									22	25
15	Дорноговь аймгийн музей			6	7	8	15					14	22
16	Дорнод аймгийн музей	23	24									23	24
17	Дундговь аймгийн музей	6	7	8	9					24	26	41	51
18	Завхан аймгийн музей			11	55							11	55
19	Орхон аймгийн музей	7	7					9	9			16	16
20	Өвөрхангай аймгийн музей					1	3					1	3
21	Өмнөговь аймгийн музей	1	1	70	95							71	96
22	Сүхбаатар аймгийн музей	2	2			3	3					5	5
23	Сэлэнгэ аймгийн музей	1	1									1	1
24	Төв аймгийн музей			8	11	1	1					9	12
25	Увс аймгийн музей	3	4	14	37							17	41
26	Ховд аймгийн музей	2	3	13	19							15	22
27	Хөвсгөл аймгийн музей	3	4									3	4
28	Хэнтий аймгийн музей	11	11			3	3					14	14
Төрийн болон орон нутгийн өмчийн бусад байгууллага													
29	Монгол банкны Эрдэнэсийн сан	5	5			40	133					45	138
30	ШУА-ийн Археологийн хүрээлэн							320	437			320	437
31	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн									6	6	6	6
32	Ховд их сургууль, Түүх, нийгмийн ухааны тэнхимийн сан хөмрөг			3	23			10	291			13	314
нийт		145	239	387	617	138	276	406	823	30	32	1109	1996

Хавсралт №2

Шинээр нэмэгдсэн үзмэрийн цахим бүртгэлийн нэгдсэн тоон дүн

Д/д	Нэрс	Баяжилт хийгдсэн нийт дүн		Register программд оруулсан		RCH программд оруулсан	
		дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1	Монголын үндэсний музей	74	111	74	111		
2	Байгалийн түүхийн музей	71	71	71	71	71	71
3	Чойжин ламын сүм музей	9	9	9	9	9	9
4	Монголын уран зургийн галерей	45	50	5	5		
5	Монголын театрын музей	15	21	15	21	15	21
6	Хархорум музей	16	53	16	53	16	53
7	Монгол цэргийн музей	5	98				
8	Архангай аймгийн музей	3	3	3	3	3	3
9	Баян-Өлгий аймгийн музей	9	29				
10	Баянхонгор аймгийн музей	134	144	134	144		
11	Булган аймгийн музей	23	31	23	31	23	31
12	Говь-Алтай аймгийн музей	3	26	3	26		
13	Говьсүмбэр аймгийн музей	55	64	55	63	55	63
14	Дархан-Уул аймгийн музей	22	25	22	25	22	25
15	Дорноговь аймгийн музей	14	22				
16	Дорнод аймгийн музей	23	24				
17	Дундговь аймгийн музей	41	51	41	51	41	51
18	Завхан аймгийн музей	11	55	11	55	11	55
19	Орхон аймгийн музей	16	16	16	16		
20	Өвөрхангай аймгийн музей	1	3	1	3	1	3
21	Өмнөговь аймгийн музей	71	96	71	96	71	96
22	Сүхбаатар аймгийн музей	5	5	5	5	5	5
23	Сэлэнгэ аймгийн музей	1	1	1	1	1	1
24	Төв аймгийн музей	9	12	9	12		
25	Увс аймгийн музей	17	41	17	41		
26	Ховд аймгийн музей	15	22	15	22		
27	Хөвсгөл аймгийн музей	3	4	3	4	3	4
28	Хэнтий аймгийн музей	14	14	14	14	14	14
29	Монгол банкны Эрдэнэсийн сан	45	138				
30	ШУА-ийн Археологийн хүрээлэн	320	437				
31	ШУА-ийн Палеонтологи хүрээлэн	6	6	6	6	6	6
32	Ховд их сургууль, Түүх, нийгмийн ухааны тэнхимийн сан хөмрөг	13	314				
Нийт		**1109**	**1996**	**640**	**888**	**367**	**511**

Хавсралт №3

Шинээр нэмэгдсэн үзмэрийн төрөл зүйлийн ангилалын нэгдсэн тоон дүн

Д/д	Нэрс	Археологийн олдвор		Түүхийн цуглуулга		Угсаатны зүйн цуглуулга		Шашин шүтлэг		Урлаг, уран сайхан		Байгалийн түүхийн цуглуулга		Дүн	
		дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
Төрийн болон орон нутгийн өмчийн музей															
1	Монголын үндэсний музей	44	63	28	44	2	4							74	111
2	Байгалийн түүхийн музей											71	71	71	71
3	Чойжин ламын сүм музей							9	9					9	9
4	Монголын уран зургийн галерей									45	50			45	50
5	Монголын театрын музей									15	21			15	21
6	Хархорум музей	15	52	1	1									16	53
7	Монгол цэргийн музей			5	98									5	98
8	Архангай аймгийн музей					1	1		2	2				3	3
9	Баян-Өлгий аймгийн музей			3	18	4	9			2	2			9	29
10	Баянхонгор аймгийн музей	1	1	65	74	42	43	23	23	2	2	1	1	134	144
11	Булган аймгийн музей			19	27	2	2			1	1	1	1	23	31
12	Говь-Алтай аймгийн музей			1	15	1	1	1	10					3	26
13	Говьсүмбэр аймгийн музей			10	11	33	37	4	4	1	1	7	11	55	64
14	Дархан-Уул аймгийн музей			13	15	9	10							22	25
15	Дорноговь аймгийн музей			4	4	1	2	8	15	1	1			14	22
16	Дорнод аймгийн музей			18	19	1	1			4	4			23	24
17	Дундговь аймгийн музей	5	7	2	2	24	26	2	2	7	13	1	1	41	51
18	Завхан аймгийн музей			4	15	3	36			3	3	1	1	11	55
19	Орхон аймгийн музей	9	9			6	6					1	1	16	16

20	Өвөрхангай аймгийн музей	1	3											1	3
21	Өмнөговь аймгийн музей	1	3	7	13	4	4	59	76					71	96
22	Сүхбаатар аймгийн музей					5	5							5	5
23	Сэлэнгэ аймгийн музей					1	1							1	1
24	Төв аймгийн музей							1	1	8	11			9	12
25	Увс аймгийн музей			8	9	7	30	1	1	1	1			17	41
26	Ховд аймгийн музей	1	1	3	7	9	11			2	2			15	22
27	Хөвсгөл аймгийн музей			2	3	1	1							3	4
28	Хэнтий аймгийн музей			2	2	10	10	2	2					14	14
Төрийн болон орон нутгийн өмчийн бусад байгууллага															
29	Монгол банкны Эрдэнэсийн сан	40	133	5	5									45	138
30	ШУА-ийн Археологийн хүрээлэн	320	437											320	437
31	ШУА-ийн Палеонтологи хүрээлэн											6	6	6	6
32	Ховд их сургууль, Түүх, нийгмийн ухааны тэнхимийн сан хөмрөг	11	311			1	2	1	1					13	314
НИИТ		**448**	**1020**	**200**	**382**	**167**	**242**	**111**	**146**	**94**	**112**	**89**	**93**	**1109**	**1996**

Хавсралт №4

Орон нутаг судлах танхимд шинээр нэмэгдсэн үзмэрийн нэгдсэн тоон дүн

Нэрс	Худалдаж авсан		Бэлэг, хандивааар ирсэн		Шилжиж ирсэн		Эрдэм шинжилгээ судалгаагаар ирсэн		Бусад замаар ирсэн		Дүн	
	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1.Архангай аймгийн СӨБМСан		0	30	42	1	1	0	0	1	1	32	44
Өндөр-Улаан сумын ОНСТ			15	15							15	15
Өлзийт сумын ОНСТ			2	2							2	2
Хангай сумын ОНСТ			1	1	1	1			1	1	3	3
Төвшрүүлэх сумын ОНСТ			3	12							3	12
Их тамир сум ОНСТ			9	12							9	12
2.Баян-Өлгий аймгийн СӨБМСан	1	1	20	47	0	0	0	0	0	0	21	48
Алтай сумын ОНСТ			6	6							6	6
Алтанцөгц сумын ОНСТ			4	4							4	4
Баяннуур сумын ОНСТ			3	3							3	3
Булган сумын ОНСТ			3	29							3	29
Ногооннуур сумын ОНСТ	1	1									1	1
Сагсай сумын ОНСТ			1	1							1	1
Толбо сумын ОНСТ			2	3							2	3
Улаанхус сумын ОНСТ			1	1							1	1
3.Баянхонгор аймгийн СӨБМСан	0	0	22	22	0	0	0	0	0	0	22	22
Бууцагаан сумын ОНСТ			2	2							2	2
Хүрээмарал сумын ОНСТ			2	2							2	2
Баянбулаг сумын ОНСТ			2	2							2	2
Баацагаан сумын ОНСТ			2	2							2	2
Өлзийт сумын ОНСТ			2	2							2	2
Бөмбөгөр сумын ОНСТ			4	4							4	4
Баян-Овоо сумын ОНСТ			2	2							2	2
Баянцагаан сумын ОНСТ			2	2							2	2

	Гурванбулаг сумын ОНСТ			2	2							2	2
	Шинэжинст сумын ОНСТ			2	2							2	2
4.Булган аймгийн СӨБМСан		0	0	15	15	0	0	0	0	0	0	15	15
	Хишиг-Өндөр сумын ОНСТ			15	15							15	15
5.Говь-Алтай аймгийн СӨБМСан		0	0	7	7	0	0	1	1	0	0	8	8
	Чандмань сумын ОНСТ			5	5							5	5
	Цээл сумын ОНСТ			1	1							1	1
	Шарга сумын ОНСТ			1	1			1	1			2	2
6.Дорноговь аймгийн СӨБМСан		0	0	106	106	0	0	0	0	0	0	106	106
	Алтанширээ сумын ОНСТ			8	8							8	8
	Даланжаргалан сум ОНСТ			25	25							25	25
	Дэлгэрэх сумын ОНСТ			8	8							8	8
	Иххэт сумын ОНСТ			12	12							12	12
	Мандах сумын ОНСТ			3	3							3	3
	Өргөн сумын ОНСТ			10	10							10	10
	Сайхандулаан сумын ОНСТ			10	10							10	10
	Улаанбадрах сумын ОНСТ			9	9							9	9
	Хатанбулаг сумын ОНСТ			3	3							3	3
	Хөвсгөл сумын ОНСТ			5	5							5	5
	Эрдэнэ сумын ОНСТ			13	13							13	13
7.Дундговь аймгийн СӨБМСан		0	0	274	274	0	0	0	0	87	87	361	361
	Адаацаг сумын ОНСТ			8	8					8	8	16	16
	Цагаандэлгэр сумын ОНСТ			84	84					2	2	86	86
	Сайхан-Овоо сумын ОНСТ			10	10					3	3	13	13
	Гурвансайнхан сумын ОНСТ			9	9					3	3	12	12
	Дэрэн сумын ОНСТ			32	32					9	9	41	41
	Эрдэнэдалай сумын ОНСТ			11	11					1	1	12	12
	Хулд сумын ОНСТ			20	20					2	2	22	22
	Өндөршил сумын ОНСТ			20	20					7	7	27	27

	Өлзийт сумын ОНСТ			2	2							2	2
	Луус сумын ОНСТ			15	15					4	4	19	19
	Дэлгэрцогт сумын ОНСТ			54	54					45	45	99	99
	Дэлгэрхангай сумын ОНСТ									3	3	3	3
	Говь-Угтаал сумын ОНСТ			9	9							9	9
8.Завхан аймгийн СӨБМСан		6	6	110	110	0		2	2	4	4	122	122
	Алдархаан сумын ОНСТ			1	1							1	1
	Асгат сумын ОНСТ			10	10							10	10
	Баянтэс сумын ОНСТ			1	1							1	1
	Баянхайрхан сумын ОНСТ			9	9							9	9
	Завханмандал сумын ОНСТ	5	5	2	2							7	7
	Идэр сумын ОНСТ	1	1	1	1							2	2
	Их-Уул сумын ОНСТ			6	6							6	6
	Нөмрөг сумын ОНСТ			8	8							8	8
	Отгон сумын ОНСТ			4	4							4	4
	Сантмаргац сумын ОНСТ			4	4			2	2			6	6
	Сонгино сумын ОНСТ			6	6							6	6
	Тосонцэнгэл сумын ОНСТ			7	7							7	7
	Түдэвтэй сумын ОНСТ			8	8							8	8
	Тэлмэн сумын ОНСТ			3	3							3	3
	Тэс сумын ОНСТ			7	7							7	7
	Ургамал сумын ОНСТ			3	3							3	3
	Цагаанхайрхан сумын ОНСТ			10	10							10	10
	Цагаанчулуут сумын ОНСТ			4	4							4	4
	Цэцэн-Уул сумын ОНСТ			5	5					4	4	9	9
	Эрдэнэхайрхан сумын ОНСТ			5	5							5	5
	Шилүүстэй сумын ОНСТ			2	2							2	2
	Яруу сумын ОНСТ			4	4							4	4
9.Өвөрхангай аймгийн СӨБМСан		0	0	0	0	0	0	0	0	14	14	14	14
	Баян-Өндөр сумын ОНСТ									14	14	14	14
10.Өмнөговь аймгийн СӨБМСан		9	10	12	13	0	0	0	0	3	3	24	26

	Манлай сумын ОНСТ	1	1	5	5							6	6
	Ханхонгор сумын ОНСТ	8	9							3	3	11	12
	Булган сумын ОНСТ			2	3							2	3
	Сэврэй сумын ОНСТ			5	5							5	5
11.Сэлэнгэ аймгийн СӨБМСан		0	0	5	5	0	0	0	0	0	0	5	5
	Ерөө сумын ОНСТ			3	3							3	3
	Бугат тосгоны ОНСТ			2	2							2	2
12.Увс аймгийн СӨБМСан		0	0	34	34	0	0	0	0	0	0	34	34
	Бөхмөрөн сум ОНСТ			1	1							1	1
	Завхан сум ОНСТ			23	23							23	23
	Өндөрхангай сум ОНСТ			6	6							6	6
	Малчин сум ОНСТ			4	4							4	4
13.Ховд аймгийн СӨБМСан		59	59	125	125	0	0	0	0	0	0	184	184
	Алтай сумын ОНСТ	59	59									59	59
	Дуут сумын ОНСТ			2	2							2	2
	Зэрэг сумын ОНСТ			73	73							73	73
	Манхан сумын ОНСТ			4	4							4	4
	Мөнххайрхан сумын ОНСТ			3	3							3	3
	Мөст сумын ОНСТ			1	1							1	1
	Мянгад сумын ОНСТ			8	8							8	8
	Үенч сумын ОНСТ			14	14							14	14
	Цэцэг сумын ОНСТ			6	6							6	6
	Эрдэнэбүрэн сум ОНСТ			14	14							14	14
14.Хөвсгөл аймгийн СӨБМСан		20	20	90	90	3	3	0	0	48	48	161	161
	Баянзүрх сум ОНСТ			17	17	1	1			11	11	29	29
	Бүрэнтогтох сум ОНСТ			15	15	2	2			3	3	20	20
	Тариалан сум ОНСТ	20	20	1	1							21	21
	Тосонцэнгэл сум ОНСТ			24	24					2	2	26	26
	Цагааннуур сум ОНСТ			11	11					11	11	22	22
	Чандмань-Өндөр сум ОНСТ			22	22					5	5	27	27
	Шинэ-Идэр сум ОНСТ									16	16	16	16

15. Хэнтий аймгийн СӨБМСан		6	6	9	9	0	0	0	0	0	0	15	15
	Биндэр сум ОНСТ			3	3							3	3
	Дадал сум ОНСТ	6	6									6	6
	Дархан сум ОНСТ			1	1							1	1
	Нийтийн номын сан			5	5							5	5
		101	102	859	899	4	4	3	3	157	157	1124	1165

Хавсралт №5
Шилжилт хөдөлгөөний мэдээллийн нэгдсэн тоон дүн

Д/д	Нэрс	Дотоодын үзэсгэлэнд оролцсон		Гадаадын үзэсгэлэнд оролцсон		Судалгаа, шинжилгээнд хамрагдсан		Сэргээн засварлагдсан		Дүн	
		дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо	дэс	тоо
1	Монголын үндэсний музей	372	713	25	40	464	625	13	115	874	1493
2	Байгалийн түүхийн музей	10	10							10	10
3	Богд хааны ордон музей	289	400					4	112	293	512
4	Дүрслэх урлагийн музей	130	153			425	502			555	655
5	Чойжин ламын сүм музей					60	60	1	1	61	61
6	Монголын уран зургийн галерей	5	5					2	2	7	7
7	Монголын театрын музей	5	7					2	2	7	9
8	Хархорум музей	5	5							5	5
9	Монгол цэргийн музей	681	779			94	133	14	19	789	931
10	Улаанбаатар хотын музей	49	51			3	3			52	54
11	Баян-Өлгий аймгийн музей	20	22			15	17	10	10	45	49
12	Баянхонгор аймгийн музей	216	268			51	56			267	324
13	Булган аймгийн музей	192	422							192	422
14	Говьсүмбэр аймгийн музей							3	3	3	3
15	Дорноговь аймгийн музей	73	82			9	9			82	91
16	Дорнод аймгийн музей	233	684							233	684
17	Дорнод, Ялалт музей			27	32					27	32
18	Дундговь аймгийн музей	67	67					2	2	69	69
19	Завхан аймгийн музей	35	178			120	282			155	460
20	Орхон аймгийн музей	5	5					2	2	7	7
21	Өвөрхангай аймгийн музей	7	7					2	2	9	9
22	Өмнөговь аймгийн музей					31	379			31	379
23	Сүхбаатар аймгийн музей	455	455					15	15	470	470
24	Сэлэнгэ аймгийн музей	17	34							17	34
25	Төв аймгийн музей	151	181							151	181
26	Увс аймгийн музей	87	96							87	96
27	Ховд аймгийн музей	61	175							61	175
28	Хөвсгөл аймгийн музей	16	26					3	3	19	29
29	Хэнтий аймгийн музей	74	130					3	3	77	133
30	Эрдэнэ-зуу музей							6	7	6	7
31	Гандантэгчинлэн хийд	17	19					25	25	42	44
32	ШУА-ийн Археологийн хүрээлэн	88	217	147	393			40	40	275	650
33	ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн	63	606	7	13					70	619
	Нийт	3423	5797	206	478	1272	2066	147	363	4901	8704

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын баяжилтын мэдээг 21 аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас ирүүлсэн ба үүн дээр үл хөдлөх дурсгалын хайгуул, судалгааны эрхтэй 6 байгууллагаас тайлан ирүүлсэн бөгөөд нийт 27 газрын мэдээллийг нэгтгэлээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын баяжилтын мэдээллийг зарим аймгууд хангалтгүй хийж ирүүлсэн гэж болно. Үүнд, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь аймгийн бүртгэл, мэдээллийн санг тайлангийн үл хөдлөх дурсгалын хэсгийг “бөглөөгүй” ирүүлсэн. Баян-Өлгий, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Дорнод аймгийн бүртгэл, мэдээллийн сан үл хөдлөх дурсгалын “баяжилт хийгдээгүй” гэсэн мэдээлэл байгаа нь хэр бодитой эсэхийг бид тодруулах болно.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллэл ирүүлсэн 15 аймгийн бүртгэл мэдээллийн санд нийт 843 дурсгал шинээр бүртгэгдсэн байна. (Хавсралт №8)

Шинээр бүртэгдсэн дурсгалыг дараах байдлаар төрөл зүйлээр нь ангилахад 10 гаруй тооны зөрүү гарч байна. Энэ нь аймгуудын бүртгэл мэдээллийн санч нарын дурсгал болон дурсгалт газрын талаарх ойлголтын зөрөөнөөс хамааралтай хэмээн үзэж байна.

Үүнийг дурсгалын төрөл зүйлээр нь ангилбал:

- Хадны зураг, бичгийн дурсгал 46,
- Булш оршуулгын дурсгал 753,
- Чулуун зэвсэг 2,
- Тахил тайлгын байгууламж 19,
- Барилга архитектурын дурсгал 11,
- Хөшөө дурсгал 24,
- Палеонтологийн дурсгал 2,
- Үйлдвэрийн ул мөр хадгалсан дурсгал 3 байна.

Аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийг шүүхэд:

- Судалгаа шинжилгээ хийсэн дурсгалын тоо 35,
- Алга болсон, гэмтсэн, зөөгдсөн дурсгалын тоо 108,
- Аймаг, нийслэлийн хамгаалалтад авсан дурсгалын тоо 9,
- Сум, дүүргийн хамгаалалтад авсан дурсгалын тоо 848,
- Хамгаалалт хийсэн дурсгалын тоо 104,

Үл хөдлөх дурсгалын авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны зөвшөөрөлтэй 9 байгууллагаас мэдээллээ ирүүлсэн 6 байгууллагын мэдээг нэгтгэв. Үүнд, авран хамгаалах ажлаар эдгээр 6 байгууллага 522, Эрдэм шинжилгээний судалгаагаар 985 газарт судалгаа явуулсан бөгөөд нийт 1859 дурсгалт газар ажиллажээ.

Хүснэгт 1

№	Дурсгалын төрөл зүйл	Эрдэм шинжилгээний судалгаагаар илрүүлсэн дурсгалт газрын тоо	Авран хамгаалах ажлаар илрүүлсэн дурсгалт газрын тоо	Нийт тоо
1.Монголын үндэсний музей				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар	2		2
2	Хадны зураг, бичгийн дурсгал			
3	Булш оршуулгын дурсгал	11		350
4	Тахил тайлгын байгууламж			
5	Барилга архитектурын дурсгал			
6	Хөшөө дурсгал			
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	**13**		**352**
2.ШУА-ийн Археологийн хүрээлэн				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар	41		
2	Хадны зураг, бичгийн дурсгал	13		
3	Булш оршуулгын дурсгал	754		
4	Тахил тайлгын байгууламж	74		
5	Барилга архитектурын дурсгал	9		
6	Хөшөө дурсгал			
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар	23		
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	**914**	**443**	**1357**
3.ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар	1		1
2	Хадны зураг, бичгийн дурсгал			
3	Булш оршуулгын дурсгал	61	9	70
4	Тахил тайлгын байгууламж		8	8
5	Барилга архитектурын дурсгал	1		1
6	Хөшөө дурсгал	1		1
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	**64**	**17**	**81**
4.ШУА-ийн Палеонтлогийн хүрээлэн				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар			
2	Хадны зураг, бичгийн дурсгал			
3	Булш оршуулгын дурсгал			
4	Тахил тайлгын байгууламж			
5	Барилга архитектурын дурсгал			
6	Хөшөө дурсгал			
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар		9	
	Нийт		**9**	**9**
5.Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар			
2	Хадны зураг, бичгийн дурсгал			

3	Булш оршуулгын дурсгал			
4	Тахил тайлгын байгууламж			
5	Барилга архитектурын дурсгал	2		
6	Хөшөө дурсгал			
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	**2**		**2**
6.Ховд Их сургууль				
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар			
2	Хадны зураг, бичгийн дурсгал		6	
3	Булш оршуулгын дурсгал	4	39	
4	Тахил тайлгын байгууламж	1	7	
5	Барилга архитектурын дурсгал			
6	Хөшөө дурсгал		1	
7	Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар			
8	Палеонтологийн олдворт газар			
	Нийт	**5**	**53**	**58**
	НИЙТ ДҮН	**985**	**522**	**1859**

Үл хөдлөх дурсгал алга болсон, эдвэрсэн, зөөгдсөн тухай мэдээ Булган, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Хэнтий аймгуудаас нийт 108 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд,

• Булган аймаг: Баяннуур сумын Цохын булан хэмээх газар орших чулуун дурсгалыг эртний Пугу аймгийн нэрт жанжны гэрэлт хөшөө хэмээн СӨҮТ-ийн мэдэгдсэнээр аймгийн музейд зөөвөрлөн авчирч байршуулсан.

• Сүхбаатар аймаг: Алаг морьтын хүн чулууг байсан газраас нь зөөвөрлөх оролдлого хийсэн байдалтай байсан учир иргэд санаачлагаараа зөөвөрлөсөн. Асгат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019,10,16 ны өдрийн 32 тоот тогтоолоор тээвэрлэсэн болно.

• Ховд аймаг: Улаан дэвсгийн хүн чулуу гэмтэлтэй болохыг Манхан сумын ЕБС-ийн багш Ц.Мөнхбат, Ч.Энхтөр нар мэдээлсэн.

• Хоригийн амны тоногдсон дурсгалуудыг сумын удирдлагууд, соёлын төвд хандаж ажлын хэсэг байгуулан газар дээр нь очиж баримтжуулсан байна. Авран хамгаалах ажлын хэсэгт Монголын үндэсний музей, АНУ Питсбургийн их сургууль, Америкийн монгол судлалын холбоо хамтран тоногдсон дурсгал дээр ажиллажээ.

• Хэнтий аймаг: Бөөр булгийн дурсгал, Хөшөөт чулуутын дөрвөлжин булш тоногдсоныг олж тогтоон сумын цагдаад мэдэгдсэн.

Хамгаалалтад авсан дурсгалын талаарх мэдээлэл Дорноговь, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас нийт 848 дурсгал хамгаалалтад авсан мэдээ байна. Үүнд,

• Сүхбаатар аймгийн Уулбаян суманд түүх, соёлын үл хөдлөх 309 дурсгалаа Сумын ИТХ-ын 2020.02.09 шийдвэрээр,

• Дорноговь аймгийн АИТХурлын шийдвэрээр Аймаг, нийслэл – 9, сум, дүүрэг – 9 дурсгал хамруулсан байна. Үүнд: Хатны булаг, Өлийн хийд, Цонжийн чулуу, Хан Баянзүрх хайрхан, Хамарын хийд, Эрээн-Уул, Дариатын булаг, бүсийн чулуу, Дунд баруун Мандал, суманд Анги Шагдарын дурсгалын багана, Туулай чулуу, Аймаг байгуулагдсан, газрын дурсгал, Улаан толгойн хөөврийн хурал, Саран хөөврийн хийдийн туурь, Бумбатын хийдийн туурь, Бөөрийн хийдийн туурь, Сүлдэнэ хөх овоо, Бурхант.

• Өвөрхангай аймгийн ИТХурлын 2018/06/27 07 тоотоор 530 дурсгал хамгаалалтанд авсан.

Хамгаалалтын хайс, хашаа барьсан тухай мэдээлэл Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл аймгийн бүртгэл, мэдээллийн сангаас ирсэн ба нийт 104 дурсгалт газар хамгаалалтын хайс, хашааг дотоод нөөц бололцоогоороо хийж гүйцэтгэсэн байна.



ДҮГНЭЛТ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Аймаг, нийслэлийн 15 бүртгэл, мэдээллийн санд шинээр 843 дурсгал бүртгэгдсэн байна. Үл хөдлөх дурсгалын авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны зөвшөөрөлтэй 6 байгууллагын авран хамгаалах ажлаар 6 байгууллага 522 авран хамгаалах малтлага, эрдэм шинжилгээ судалгаагаар 985 газарт судалгаа явуулсан бөгөөд нийт 1859 дурсгалт газар ажиллажээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН 2019 ОНЫ ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 23.2-т заасны дагуу Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг боловсруулах хүснэгтийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 15-ны дотор цахимаар info@ncch.gov.mn хаягаар, цаасан хэлбэрээр Соёлын өвийн үндэсний төвийн албан ёсны шуудангийн хаягаар ирүүлэх тухай албан бичгийг 21 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Нийслэлийн соёл, урлагийн газарт 2020 оны 01 дүгээр сарын 9-нд хүргүүлсэн.

Тайланг дараах 4 төрлийн хүснэгт (хавсралт 1-4)-ээр авсан болно. Үүнд:

1. Хүснэгт №1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл

2. Хүснэгт №2 Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн

3. Хүснэгт №3 Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн

4. Хүснэгт №4 Соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

Шинэчилсэн бүртгэлийн мэдээлэл боловсруулах хүснэгт болон БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалыг Соёлын өвийн үндэсний төвийн www.ncch.gov.mn вэб сайтын татах цэсний - мэргэжил арга зүй - Соёлын биет бус өв талбарын жагсаалтаас татаж авахаар оруулсан.

Тус хугацаанд ирүүлэх байсан 22 байгууллагаас 10 байгууллага ирүүлсэн ба 12 байгууллага тайланг ирүүлээгүй. Мэдээлэл ирүүлсэн 10 байгууллагаас Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн тайлан шаардлага хангаж, мэдээлэл, тоон дүнг бүрэн гүйцэд ирүүлсэн ба бусад аймгуудын тоон дүн зөрүүтэй, нэр томъёо буруу, мэдээлэл дутуу зэрэг нийтлэг алдаа дутагдалтай, шаардлага хангахгүй тайлан ирүүлсэн байна.

Хүснэгтийн дагуу ирүүлсэн мэдээллийг хянаж үзэхэд дараах алдаа дутагдал илэрсэн. Үүнд:

Хүснэгт №1 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл: (13 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Эзэмшсэн өвийн нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийг 1 хүнд хамаатуулж бичих, БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалд дурдсан өвийн нэр томъёог өөрчилж оруулах зэрэг нийтлэг дутагдал байна.

2. Регистрийн дугаарыг бичихгүй орхих, зөвхөн он сарыг бичих, үсэг дутуу бичих

3. Оршин суугаа хаягын мэдээлэл дутуу, шилжсэн тухай газрын нэр зөрөх, утасны дугаар бичигдээгүй, бүртгэгдсэн он бичигдээгүй, бүртгэлээс хассан шалтгаан ойлгомжгүй, давхардуулж бичих зэрэг нийтлэг алдаа дутагдал гарлаа.

Хүснэгт №2 Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн: (9 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй,

2. Тоон дүн хүснэгт 3, 4-өөс зөрүүтэй,

Хүснэгт №3 Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн: (9 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй,

2. Тоон дүн нь хүснэгт 1, 2, 4-өөс зөрүүтэй,

3. СӨУНБМС, аймаг, нийслэлийн СӨБМС-нд бүртгэгдсэн хүний хяналтын тоон дүн зөрүүтэй,

Хүснэгт №4 Соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн: (6 төрлийн асуулгыг бөглөхөөр тусгасан)

1. Өвийн оноосон нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийн нэрийг хамтад нь бичих, , өвийн болон өвлөн уламжлагчийн тоон дүн зөрүүтэй,

2. Сум, дүүргийн тархалт бичигдээгүй, бичигдсэн сумын нэрс нь тоон дүнтэй зөрөх, УНБМС-нд ирүүлсэн хяналтын тоо зөрүүтэй зэрэг нийтлэг алдаа дутагдал гарсан.

Дээрх алдаа дутагдлыг залруулах зорилгоор Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг хүлээн авах хугацааг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хүртэл сунгаж холбогдох аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, олон нутаг судлах музейн бүртгэл, мэдээллийн санч нарт мэйл хаяг болон утасаар арга зүйн зөвлөмж өгч албан бусаар мэдээллийг хүргүүлсэн.

2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс өмнө мэдээллийн алдаа дутагдлыг засварлан нийт 21 аймаг, нийслэлийн соёл, урлагийн газраас шинэчилсэн бүртгэлийн мэдээллийг ирүүлсэн байна. (Хавсралт 5.)


2020 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495 хүмүүс бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2020 онд хүснэгт 3-аар ирүүлсэн 21 аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоон дүнг нэгтгэн хүснэгт болон хувь, графикаар харуулав.

Хүснэгт 1

Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2019 он байдлаар бүртгэгдсэн Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

№	Аймаг, нийслэлийн нэр	Өвийн тоо	Аймаг, нийслэлийн СӨБМС-нд 2010-2017 онд бүртгэгдсэн хүний (хяналтын) тоо	2018-2019 оны баяжилтын тоо	Хасагдсан өвлөн уламжлагчийн тоо	Өвлөн уламжлагчийн нийт тоо
1	Архангай	35	231	149	3	377
2	Баян-Өлгий	105	404	237	20	621
3	Булган	31	177	18	0	195
4	Баянхонгор	65	133	178	24	287
5	Говь-Алтай	77	530	148	78	600
6	Говьсүмбэр	48	116	228	25	319
7	Дархан-Уул	28	74	7	6	75
8	Дорнод	87	273	92	43	322
9	Дорноговь	43	314	108	20	402
10	Дундговь	0	195	175	0	370
11	Завхан	72	473	109	74	508
12	Орхон	35	0	227	0	227
13	Өвөрхангай	55	169	109	15	263
14	Өмнөговь	65	236	85	16	305
15	Сүхбаатар	76	232	64	43	253
16	Сэлэнгэ	108	599	59	166	492
17	Төв	72	554	62	11	605
18	Увс	94	223	262	84	401
19	Ховд	111	265	692	33	924
20	Хөвсгөл	72	1060	163	318	905
21	Хэнтий	0	360	295	40	615
22	Улаанбаатар	0	1428	408	407	1429
	Нийт дүн		**8046**	**3875**	**1426**	**10495**





Нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал малллах арга ухаан зэрэг ай савд хамаарагдаж байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2020 онд хүснэгт 2-оор ирүүлсэн 21 аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 7 ай савын

тоон дүнг нэгтгэн хүснэгт болон графикаар харуулав.

Тус хүснэгтэд Булган аймаг сум тус бүрээр гаргаагүй, Дорнод аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Дундговь аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Орхон аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Хэнтий аймаг хүснэгт 1, 3-аас тоон дүн зөрүүтэй, Улаанбаатар хотын дүүргүүдийн тоон дүн, нэр томьёог буруу оруулсан тул тоон дүнг нийт дүнгээр авч гаргав.

Хүснэгт 2

Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд 2019 оны байдлаар бүртгэгдсэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын ай савын нэгдсэн тоон дүн:

№	Ай сав	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Уламжлалт арга ухаан	Мал маллах арга ухаан	Уламжлалт гар урлал	Дүн
1	Архангай	33	119	65	8	43	5	104	377
2	Баян-Өлгий	74	242	68	16	71	8	142	621
3	Булган								195
4	Баянхонгор	34	105	53	8	24	3	60	287
5	Говь-Алтай	74	282	42	23	33	30	116	600
6	Говьсүмбэр	14	138	64	5	24	0	74	319
7	Дархан-Уул	8	53	1	1	1	0	11	75
8	Дорнод								322
9	Дорноговь	32	181	38	12	24	22	93	402
10	Дундговь								370
11	Завхан	47	211	12	5	23	0	210	508
12	Орхон								227
13	Өвөрхангай	18	106	49	4	10	0	76	263
14	Өмнөговь	40	122	26	2	6	2	107	305
15	Сүхбаатар	23	110	12	14	24	5	65	253
16	Сэлэнгэ	33	235	62	6	13	5	138	492
17	Төв	39	345	37	24	10	0	150	605
18	Увс	41	188	40	21	30	14	67	401
19	Ховд	49	595	45	18	52	45	120	924
20	Хөвсгөл	94	603	21	14	19	2	152	905
21	Хэнтий								615
22	Улаанбаатар								1429
	Нийт	653	3635	635	181	407	141	1685	10495



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч нь нийт өвлөн уламжлагчийн 1 хувийг эзэлж байна.


Тус жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын 36 хүн нь үндсэн захиргаа буюу төрсөн нутагтаа амьдарч байна. Шилжилт хөдөлгөөн хийсэн нийт 49 хүний 43 нь Улаанбаатар хотруу, 2 хүн Ховд аймаг, 2 хүн Орхон аймаг, 1 хүн Сэлэнгэ аймаг, 1 хүн Ховд аймагт тус тус шилжэн суурьшсан бол 13 хүн нас барж, 4 хүний мэдээлэл илрээгүй үзүүлэлтэй байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3

“Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагчдын шилжилт хөдөлгөөний мэдээлэл.

Аймаг, нийслэлийн нэр	Одоо байгаа	Нас барсан	Шилжсэн	Шилжиж ирсэн	Үндсэн захиргаа	Мэдээлэлгүй
Архангай	1	1	1		3	
Баян-Өлгий	2	1	1		4	
Баянхонгор			4		6	2
Булган	1	1			2	
Говь-Алтай	1		1		3	1
Говьсүмбэр				2		
Дархан-Уул						
Дорноговь			1		1	
Дорнод	2		1		3	
Дундговь	4	2	6		12	
Завхан		1	4		5	
Өвөрхангай	2	1	5		8	
Өмнөговь	4	1	4		9	
Орхон				2		
Сүхбаатар		1	2		3	
Сэлэнгэ				1		
Төв		1	2		3	
Увс	6	1	6		13	
Ховд	8	1	7	1	16	
Хөвсгөл	1		3		5	1
Хэнтий	1	1	1		3	
Улаанбаатар	3			43	3	
	36	**13**	**49**	**49**	**102**	**4**

Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастны улсын жагсаалтад бүртгэгдсэн 102 хүнийг үндсэн захиргаагаар ангилсан байдал:



ДҮГНЭЛТ

Соёлын биет бус өвийн тухай бодлого ба зохицуулалт зарим улс орнуудад, ялангуяа Зүүн Азийн орнуудад 1950-иад оноос эхлэсэн бөгөөд манай орны хувьд ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцид 2005 онд нэгдсэнээр Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа идэвхижсэн боловч СББӨ, өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааны ажилд учир дутагдал байсаар байгаа нь энэхүү бүртгэлээс харагдаж байна.

2020 оны байдлаар соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495 авьяас билэгт хүмүүс бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал малллах арга ухаан зэрэг ай савд хамаарч байна.

Тоон дүнгээс харахад ардын язгуур урлаг, уламжлалт гар урлалын ай саваас бусад илэрхийллүүд маш цөөн хувийг эзэлж байгаа нь тэдгээр өвийн олон төрөл зүйлс устаж үгүй болж буй, эсвэл тухайн өв болон уламжлагчийг олж илрүүлэх, таньж тогтоох судалгааны ажил хангалтгүй хийгдэж байгааг нотлон харуулж байна. Мөн тухайн аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн, бүртгэлийн ажилтны мэргэжлийн ур чадвар, тогтвор суурьшил, мөн өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааг хийх хүний нөөц, санхүү, төсвөөс шалтгаалан бүртгэлийн ажлын чанарт нөлөөлж болох юм.

Энэ удаагийн бүртгэл, судалгааны тайлангийн нэгтгэлийн хүснэгтүүд нь хоорондоо уялдаатай хийгдсэн ба тоон дүнг нэгтгэн гаргах, СББӨ-ийн албан ёсны нэр томьёог ашиглах, сум , дүүргийн тархалтын мэдээллийг гаргах зэрэг олон тоон үзүүлэлтийг нэгтгэн цаг хугацаанд нь бүрэн гүйцэд ирүүлсэн Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын сайн жишээг дурдах нь зүйтэй.

Хавсралт 1

..... аймаг/дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхан шатны нэгдсэн бүртгэл

Хүснэгт 1

№	Эзэмшсэн өвийн нэр	Хавсарсан өвийн нэр	Овог, нэр	Регистрийн дугаар	Төрсөн он	Хүйс	Яс үндэс	Үндэсэн захиргаа	Одоогийн оршин суугаа хаяг /шилжсэн тухай тэмдэглэл/	Эрхэлж буй ажил	Утасны дугаар	Бүртгэгдсэн он	Бүртгэлээс хассан шалтгаан		
													Нас барсан /он бичих/	Шилжсэн /он бичнэ/	Бусад /шалтгааныг бичнэ/
1. Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд															
1															
2															
2. Ардын язгуур урлаг															
3															
4															
3. Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам															
5															
6															
4. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл															
7															
8															
5. Уламжлалт арга ухаан															
9															
10															
6. Мал маллах арга ухаан															
11															
12															
7. Уламжлалт гар урлал															

13														
14														

Боловсруулсан: ..... /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

Хавсралт 2

Соёлын биет бус өвийн ай савын дэлгэрэнгүй тоон дүн

Хүснэгт №2

.....аймаг, нийслэл.									
№	Хамрагдсан сум, дүүргийн нэрс	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Ардын язгуур урлаг	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Уламжлалт арга ухаан	Мал маллах арга ухаан	Уламжлалт гар урлал	Дүн
1									
2									
3									
	Нийт дүн								

Боловсруулсан: ..... /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

Хавсралт 3

Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчдын баяжилтын нэгдсэн тоон дүн

Хүснэгт 3

..... аймаг, нийслэл									
№	**Хамрагдсан сум, дүүргийн нэрс**	**2010-2017 онд СӨУНБМСанд явуулсан хяналтын тоо**		**2018-2019 онд аймаг, дүүргийн БМСанд бүртгэгдсэн баяжилтын тоо**		**Бүртгэлээс хасагдсан**		**Нийт дүн**	
		Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Хасагдсан өвлөн уламжлагчийн тоо	Өвийн тоо	Өвлөн уламжлагчийн тоо
1									
2									
3									
4									
	Нийт дүн								

Боловсруулсан: ..... /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

Хавсралт 4

.... аймаг, нийслэлийн соёлын биет бус өвийн бүртгэлийн нэгдсэн тоон дүн

Хүснэгт №4

№	Ай сав	Өвийн оноосон нэр	Өвийн тоо	Өвлөн уламжлагчдын тоо	Өвийн тархалт	
					Илэрсэн сум, дүүргийн нэрс	Илэрсэн сум, дүүргийн тоо
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд					
2	Ардын язгуур урлаг					
3	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам					
4	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл					
5	Уламжлалт арга ухаан					
6	Мал маллах арга үхаан					
7	Уламжлалт гар үрлал					
	Нийт дүн					

Боловсруулсан: ..... /овог, нэр, албан тушаал/

.... оны ... сарын ... өдөр

Хавсралт 5

2019 оны соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн шинэчилсэн бүртгэлийн тайлан ирүүлсэн тухай мэдээ.

№	Аймаг, нийслэлийн нэрс	Цаасаар ирсэн /Огноо/	Цахимаар ирсэн /Огноо/	Тайлбар
1	Архангай	2020.II/13	2020.II/13	СББӨ-ийн тоо зөрүүтэй, Өвлөн уламжлагчийн мэдээлэл дутуу, БУСГ-ын мэргэжилтэнтэй холбогдож зөвлөмж өгсөн. 02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. (хүснэгт 2) БСУГ-ын мэргэжилтэн Октябрь 89002880
2	Баян-Өлгий	2020.II/14	2020.II/17	2 сарын 18-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БСУГ-ын мэргэжилтэн Ермек 994288200
3	Баянхонгор	2020.II/13	2020.III/20	Хяналтын тоо зөрүүтэй (хүснэгт 2) музейн БМСанч Эрдэнэхуяг /99039064/
4	Булган	2020.III/6	2020.III/6	Музейн БМСанч Нарантуяа 99473626 газар, БСУГ-ын мэргэжилтэн Уганчимэг 88343438
5	Говь-Алтай		2020.II/13	Тоо зөрүүтэй Музейн БМСанч Нэргүй 99933725, БСУГ-ын мэргэжилтэн Жаргалсайхан 99087762
6	Говьсүмбэр	2020.II/13	2020.II/13	Гарамсан БСУГ 99143342 тоо зөрүүтэй
7	Дархан-Уул	2020.II/7	2020.II/12	Мэдээллийг засварлах талаар зөвлөмж өгсөн. 02 сарын 17-нд мэдээллийг засварлаж ирүүлсэнч тоо зөрүүтэй Музейн БМСанч Г.Энхбаяр 99372046
8	Дорноговь	2020.II/17	2020.II/17	тоо зөрүүтэй Музейн БМСанч Уранжаргал 88617821
9	Дорнод	2020.II/14	2020.II/14	СББӨ-ийн тоо зөрүүтэй, Өвлөн уламжлагчийн мэдээлэл дутуу, БУСГ-ын мэргэжилтэн /Л.Идэрбат 99298082/-тэй холбогдож зөвлөмж өгсөн. 02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлэхээр болсон. Ирүүлээгүй.
10	Дундговь		2020.III/6	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй БСУГ-ын мэргэжилтэн Шинэбаяр 88669600, 95736969
11	Завхан	2020.II/29	2020.II/12	02 сарын 14-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Ч.Мөнхзул 92030311
12	Орхон		2020.III/4	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй, засварлах шаардлагатай. Музейн БМС Гансоёмбо 99887731, БСУГ-ын мэргэжилтэн 99808927
13	Өверхангай		2020.II/17	02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Гантулга 99902844
14	Өмнөговь	2020.II/12	2020.II/12	02 сарын 19-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч 88694404

15	Сүхбаатар	2020.II/12	2020.II/12	02 сарын 15-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БСУГ-ын газрын мэргэжилтэн Б.Золхүү 99518990
16	Сэлэнгэ	2020.II/14	2020.II/14	БСУГ-ын мэргэжилтэн Азжаргал
17	Төв	2020.II/11	2020.II/12	02 сарын 14-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. Музейн БМСанч Д.Дагмидмаа 89692129
18	Увс	2020.III/2	2020.II/20	СББӨ, өвлөн уламжлагчдын тоо зөрүүтэй, байсан тул 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр БСУГ-ын газрын мэргэжилтэнтэй холбогдож мэдээллийг засварлах талаар зөвлөмж өгсөн. 03 сарын 04-нд ирүүлсэн. Оюунцэцэг БСУГ-ын мэргэжилтэн 95254809
19	Ховд		2020.II/14	02 сарын 21-нд мэдээллийг засварлаж ирүүлсэн. БСУГ-ын мэргэжилтэн С.Алтангэрэл 99506975
20	Хөвсгөл		2020.II/20	тоо зөрүүтэй Баасансүрэн 99771162,
21	Хэнтий		2020.II/22	тоо зөрүүтэй Дэлгэрмаа 98707115
22	Нийслэл	2020.III/04	2020.II/20	тоо зөрүүтэй НСУГ-ын мэргэжилтэн Гомбосүрэн 96002773

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Улс, аймаг, байгууллагын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн баяжилт төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей, орон нутаг судлах танхим 104, орон нутгийн өмчийн бусад байгууллага 1, нийт 136 байгууллагад хийгдсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн 32 музей нийт 1109 дэсийн 1119 ширхэг, Орон нутаг судлах танхим нийтдээ 1119 дэсийн 116 ширхэг, орон нутгийн өмчийн 1 номын сан 5 дэсийн 5 ширхэг нийт 2233 дэсийн 3161 ширхэг дурсгалаар сан хөмрөгөө баяжуулсан байна.

Нэмэгдсэн үзмэрийн 11% буюу 246 дэсийн 341 ширхэг үзмэрийг улсын болон орон нутгийн төсвөөс худалдаж авсан бол үлдсэн 89 %-ийг бэлэг хандив, шилжүүлэг, судалгаа шинжилгээ, бусад арга замаар авсан байна. Үүнээс манай музейнүүд үзмэрийн шаардлага хангасан чанартай үзмэрээр сан хөмрөгөө баяжуулж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Аймгийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд 4 аймгийн 123 хувь хүний 155 дэсийн 155 ширхэг эд өлгийн зүйлийг улсын бүртгэлд авсан байна.

Түүх, соёлын дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөнд нийт 33 байгууллагын 4901 дэсийн 8704 ширхэг дурсгал хамрагдсан. Үүнээс, дотоодын үзэсгэлэнд 28 музейн 3423 дэсийн 5797 ширхэг үзмэр, гадаадын үзэсгэлэнд 4 байгууллагын 206 дэсийн 478 ширхэг үзмэр, судалгаа шинжилгээнд 10 музейн 1272 дэсийн 2066 ширхэг үзмэр, сэргээн засварлалтад 17 байгууллагын 147 дэсийн 363 ширхэг хамрагдсан байна.

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монгол банкны Эрдэнэсийн сан, Ховд их сургуулийн тайлангаас харахад санд зааврын дагуу хувийн дугаар өгөгдөөгүй, цахим бүртгэлд оруулаагүй зэрэг асуудал нийтлэг байгааг анхаарах шаардлагатай байна.

Аймаг, нийслэлийн 15 бүртгэл, мэдээллийн санд шинээр 843 үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн байна. Үл хөдлөх дурсгалын авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны

зөвшөөрөлтэй 6 байгууллагын авран хамгаалах ажлаар 6 байгууллага 522 авран хамгаалах малтлага, эрдэм шинжилгээ судалгаагаар 985 газарт судалгаа явуулсан бөгөөд нийт 1859 дурсгалт газар ажиллажээ.

Соёлын биет бус өвийн тухай бодлого ба зохицуулалт зарим улс орнуудад, ялангуяа Зүүн Азийн орнуудад 1950-иад оноос эхлэсэн бөгөөд манай орны хувьд ЮНЕСКО-гийн 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцид 2005 онд нэгдсэнээр Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа идэвхижсэн боловч СББӨ, өвлөн уламжлагчийн бүртгэл, судалгааны ажилд учир дутагдал байсаар байгаа нь энэхүү бүртгэлээс харагдаж байна.

2020 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд анхан шатны байдлаар 10495 хүн бүртгэгдсэн бөгөөд 2018-2019 онд 2446 хүн буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Анхан шатны байдлаар бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагчдын 50% нь буюу 3635 хүн Ардын язгуур урлаг, 23% нь буюу 1685 хүн Уламжлалт гар урлал, 9% нь буюу 653 хүн Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, 9% нь буюу 635 хүн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, 6% нь буюу 407 хүн Уламжлалт арга ухаан, 2% нь буюу 181 хүн Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, 2% нь буюу 141 хүн Мал малллах арга ухаан зэрэг ай савд хамаарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагч нь нийт өвлөн уламжлагчийн 1 хувийг эзэлж байна. Тус жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын 36 хүн нь үндсэн захиргаа буюу төрсөн нутагтаа амьдарч байна. Шилжилт хөдөлгөөн хийсэн нийт 49 хүний 43 нь Улаанбаатар хотруу, 2 хүн Ховд аймаг, 2 хүн Орхон аймаг, 1 хүн Сэлэнгэ аймаг, 1 хүн Ховд аймагт тус тус шилжэн суурьшсан бол 13 хүн нас барж, 4 хүний мэдээлэл илрээгүй үзүүлэлтэй байна.

Энэ удаагийн бүртгэл, судалгааны тайлангийн нэгтгэлийн хүснэгтүүд нь хоорондоо уялдаатай хийгдсэн ба тоон дүнг нэгтгэн гаргах, СББӨ-ийн албан ёсны нэр томьёог ашиглах, сум , дүүргийн тархалтын мэдээллийг гаргах зэрэг олон тоон үзүүлэлтийг нэгтгэн цаг хугацаанд нь бүрэн гүйцэд ирүүлсэн Сэлэнгэ, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын сайн жишээг дурдах нь зүйтэй юм.

УНБМСанд ирүүлсэн тайланг нягтлан үзэхэд Орхон, Булган, Хэнтий, Дундговь, Нийслэлийн соёл урлагийн газар зэрэг байгууллагууд шаардлага хангахгүй мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд: Эзэмшсэн өвийн нэр хэсэгт нэр томъёог буруу бичих, ай савын нэрээр бичих, 2 ба хэд хэдэн өвийг 1 хүнд хамаатуулж бичих, БСШУС-ын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дугаар тушаалд дурдсан өвийн нэр томъёог өөрчилж оруулах, регистрийн дугаарыг бичихгүй орхих, зөвхөн он сарыг бичих, оршин суугаа хаягын мэдээлэл дутуу, шилжсэн тухай газрын нэр зөрөх, утасны дугаар, бүртгэгдсэн он бичигдээгүй, бүртгэлээс хассан шалтгаан ойлгомжгүй, давхардуулж бичих, сум тус бүрийн мэдээлэл /тоон дүн/-ийг оруулаагүй, тоон дүн нь бусад хүснэгтээс зөрүүтэй, сум, дүүргийн тархалт бичигдээгүй, бичигдсэн сумын нэрс нь тоон дүнтэй зөрөх гэх мэт нийтлэг алдаа дутагдалыг гаргасан байна.

Тоон дүнгээс харахад Ардын язгуур урлаг, Уламжлалт гар урлалын ай саваас бусад илэрхийллүүд маш цөөн хувийг эзэлж байгаа нь тэдгээр өвийн олон төрөл зүйлс устаж үгүй болж буй, эсвэл тухайн өв болон уламжлагчийг олж илрүүлэх, таньж тогтоох судалгааны ажил хангалтгүй хийгдэж байгааг нотлон харуулж байна. Мөн тухайн аймаг, нийслэлийн соёлын биет бус өв хариуцсан мэргэжилтэн, бүртгэлийн ажилтны мэргэжлийн ур чадвар, тогтвор сууршил, мөн бүртгэл, судалгааны ажлыг хийх хүний нөөц, санхүү, төсвөөс шалтгаалан бүртгэлийн ажлын чанарт нөлөөлж болох юм.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ САНАЛ

1. Соёлын өвийг хадгалж, бүртгэж байгаа байгууллагууд бүртгэл, мэдээллийн санч болон холбогдох мэргэжилтнүүдээ бүртгэл, мэдээллийн сангийн сурталтад тогтмол хамруулж байх,

2. СББӨ, өвлөн уламжлагчийн судалгааны асуулга, мэдээллийг илүү баяжуулах зорилгоор, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 541 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягтыг шинэчлэн сайжруулах,

3. Нийслэлийн соёл, урлагийн газар, Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, Их дээд сургууль, бусад түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж байгаа байгууллагуудын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжуулах,

4. Түүх, соёлын үл хөдлөх “дурсгал”, “дурсгалт газар”-ын талаарх нэгдмэл ойлголтыг бий болгох, мэдээллийг үнэн зөв гаргах үүднээс мэргэжлийн судалгаа шинжилгээний байгууллагуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

-oOo-

ТАЙЛАН БИЧСЭН:

Ш.ЭНХТУЯА. /СӨБСГ-ын Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч/

Ж.НАСАНЖАРГАЛ /СӨБСГ-ын Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/

Г.БҮРЭНТӨГС. /СӨБСГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч/

ХЯНАСАН:

Г.ЭНХБАТ /Соёлын өвийн үндэсний төвийн захирал/

2. СӨУНБМСАНД ХАДГАЛАГДАЖ БУЙ БАРИМТЫН НӨХӨН БҮРДҮҮЛЭЛТ, ДАНСЛАХ АЖИЛ.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд 2019 оны оны цаасан суурьтай 15 ширхэг тайланг Хадгаламжийн нэгжийн хэсэгчилсэн техник боловсруулалт хийж хүлээн авсан.

- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн баримтыг данслах ажил. Санд хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт 778 дурсгалт зүйлийн бүртгэлийг тулган, нөхөн бүрдүүлэх, товьёгжуулах ажлыг гүйцэтгэж байна. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд “Түүх, соёлын Хосгүй үнэт дурсгалт зүйлийн бүртгэл”-тэй холбогдолтой 10 ширхэг хавтас хадгалагдаж байсан. Эдгээр хавтсыг товъёгтой нь тулган нөхөн бүрдүүлэлт хийсэн. Дээрх 10 хавтасны материал ямар нэгэн байдлаар дутуу байсан бөгөөд 2010 оны үзлэг тооллогоор музейнүүдээс ирсэн бүртгэлийг дугаарлан цэгцлэж 6 хавтсанд нөхөн хийснээр нийт 16 хавтас материал болсон. Үүний 10 хавтас буюу 310 дурсгалт зүйлийг хамруулсан 10 хавтасны дотоод товьёг хийгдээд байна. Үүнд:

o А.1-5 дугаар хавтаст бүртгэлийн маягт,

o Б.6-9 дүгээр хавтаст “Хосгүй үнэт дурсгалт зүйлийн гэрчилгээ”,

o В.10 дугаар хавтаст бүртгэлийн маягт

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалтын баримтын данслах ажил. Тусгай зөвшөөрөлтэй эрдэм шинжилгээний байгууллагуудын авран хамгаалах болон малтлага судалгааны 2009-2019 оны нийт 1453 тайлан, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын баримтжуулалтын 1993-2019 оны 148 тайлан, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын сэргээн засварлалтын 2012-2016 оны 10 тайлан, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны үзлэг тооллогын хобогдолтой 13 хавтаст хэрэг бүртгээд байна. 2001-2003 онуудад Засгийн газрын тогтоолоор хэрэгжүүлсэн Хуулбар 1, 2, 3 төслийн хүрээнд хийгдсэн хэв хуулбар дардасыг данслах ажлыг одоогийн байдлаар нийт 50 дурсгалын хэв хуулбарыг ялган дугаар, товч тодорхойлолтыг хийж дунслан, зориулалтын голд ороож хадгалах ажлыг хийгээд байна. RICH 3 программ дээрх мэдээллийг RICH 4 программд оруулан нийт 12 аймгийн 5895 дурсгалын бүртгэлийг RICH 4 Excel дээр хөрвүүллээ. Нийт 13 хавтаст хэрэг, 50 хэв хуулбарын нэгжийг бүрдүүлэв.

- Соёлын биет бус өвийн нөхөн бүрдүүлэлт хийж данслах ажил. Соёлын биет бус өв, - түүнийг өвлөн уламжлагчын бүртгэлтэй холбоотой аймаг, нийслэлийн 27 хадгаламжийн нэгжийн 5149 хуудас цаасан баримтын дотоод товьёгийг хийх ажлыг гүйцэтгэлээ. “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагч” шагналд нэр дэвшүүлэх ажлын хүрээнд 20 хүний материал ирснийг хадгаламжийн нэгжийн техник боловсруулалт хийх ажлыг гүйцэтгэж нийт 890 хуудас 4 хадгаламжийн нэгж болгон дотоод товьёг үйлдсэн. Соёлын биет бус өвийн холбогдолтой 25 хадгаламжийн нэгжийн 1505 хуудас цаасан баримт, аймаг, нийслэлийн 27 хадгаламжийн нэгжийн 5149 хуудас цаасан баримтын дотоод товъёгийг бүрдүүлэв. “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагч” шагналд нэр дэвшүүлэх ажлын хүрээнд 890 хуудас 4 хадгаламжийн нэгж болгон дотоод товьёг үйлдсэн. Нийт соёлын биет бус өвийн холбогдолтой 25 хадгаламжийн нэгжийн 1505 хуудас цаасан баримтны дотоод товъёг хийгдсэн болно.

3. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн баяжилт. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 тооллогын дараах баримтыг хүлээн авсан. Үүнд:

- БСШУСЯ-ны СУБЗГ-ын соёл, урлагийн салбарын бодлогын зохицуулалт,

соёлын хөдлөх өвийн асуудал хариуцсан шинжээч Б.Даваацэрэнгээс 2019 оны 10 сард төрийн өмчийн 17 байгууллагын музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн 44 дэвтэр, 21 тооллогын тайлан, цахим тээгч, 2020 оны 6 сарын 02-нд Соёл урлагийн газрын мэргэжилтэн Ч.Нацагнямаас төрийн өмчийн 3 музей, дүүргийн 2 музей, 21 аймгийн музейн нийт 132 ширхэг, Орон нутаг судлах танхимын 262 ширхэг тооллогын тайлан, 82 ширхэг тооллогын тайлан , 82 ширхэг CD, DVD. Нийтдээ 350 ширхэг Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэр, 61 ширхэг тооллогын тайлан, 287 ширхэг CD, DVD хүлээн авсан. Харин тооллогын нэгдсэн тайланг одоогоор хүлээлгэж өгөөгүй, нийт 287 ширхэг CD, DVD хүлээн авснаас 44 ширхэг нь эвдрэлтэй байсан. Энэхүү байдлаас шалтгаалж манай МТАБГазраас музейнүүдийн дата, гэрэл зургийн файлыг татан авч 616246 ширхэг 3995 GB, 126810 дэсийн 276077 ширхэг үзмэрийн дата аваад байна.

- Дурсгалт уран барилгын сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл хөмрөгийг баяжуулах зорилгоор Үндэсний төв архивын Зураг, төслийн архивын сан хөмрөгөөс улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон 18 дурсгалд холбогдох мэдээллийг цахим хувилбараар /319 хадгаламжийн нэгжийн 4979 хуудас баримт 20GB файл/ СӨУНБМСанд товьёгжуулж хүлээн авлаа.

Нийтдээ 350 ширхэг Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэр, 61 ширхэг тооллогын тайлан, 287 ширхэг CD, DVD хүлээн авсан. нийт 287 ширхэг CD, DVD хүлээн авснаас 44 ширхэг нь эвдрэлтэй байсан. Энэхүү байдлаас шалтгаалж манай МТАБГазраас музейнүүдийн дата, гэрэл зургийн файлыг татан авч 616246 ширхэг 3995 GB, 126810 дэсийн 276077 ширхэг үзмэрийн дата аваад байна.

НЭМЭЛТЭЭР:

1. “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын тулгамдсан асуудлууд” сэдэвт судалгааны ажил. Үндэсний төвийн захирлын үүрэг болгосноор тус Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа нь “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын тулгамдсан асуудлууд” сэдэвт судалгааны ажлыг 2020 оны 8 дугаар сараас эхлэн 11 дүгээр сарыг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгаа нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.2, 8.3, 13.1.8 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн зэрэглэлд хамрагдаж Засгийн газрын шийдвэрээр 1995-2019 онд Монгол Улсын “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн 778 хосгүй үнэт дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлыг үнэлж дүгнэн, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэгдсэн ба 3 бүлэг 6 дэд сэдэв, дүгнэлт, зөвлөмж, хавсралтуудаас бүрдсэн болно.

2. Дэлхийн өвийн үндэсний урьдчилсан жагсаалтад багтсан “Дорнод Монголын хээр” өвийн урьдчилсан судалгаа. Монгол Улсын үндэсний урьдчилсан жагсаалтад багтсан “Дорнод Монголын хээр”-ийг Дэлхийн өвд нэр дэвшүүлэхтэй холбогдолтой урьдчилсан судалгаанд шаардлагатай соёлын өвийн мэдээлэл, судалгааг 2020 оны 7 дугаар сард гүйцэтгэсэн. Тус судалгааны гол зорилго нь Дорнод Монголын хуурай хээрийн бүсэд байх соёлын биет болон биет бус өвийн өнөөгийн нөхцөл байдлыг өмнө хийгдсэн хээрийн судалгааны ажил, бүртгэл, мэдээлэлтэй харьцуулах, Дорнод Монголын хуурай хээрийн экосистемийг унаган байдлаар нь хамгаалахад нүүдлийн соёлын нөлөөллийг тодорхойлох байсан болно. Бэлчээр дагасан нүүдлийн мал аж ахуй, түүнд холбогдох соёлын биет бус өвийн төрөл зүйлийн оршин тогтнох байдал энэ бүс нутагт харьцангуй тогтвортой байгааг судалгааны үр дүн харуулсан хэдий ч уламжлалт мал маллагааны соёлд машин техникийн хэрэглээ нэмэгдэх, отрын нүүдэлчдийн нөлөөгөөр бэлчээрийн талбай хумигдах, уламжлалт мал аж ахуйтай зарим нэгэн соёлын биет бус өвийн төрөл зүйл өөр өвийн төрөлтэй уусах шинж тэмдэг илэрч буйг судалгааны үр дүнг харуулсан болно.

3. Шувуулахуй өвийн мэдээлэл. Монгол Улс ЮНЕСКО-гийн Хүн Төрөлхтний

Соёлын Биет Бус Өвийн Төлөөллийн жагсаалтад “Шувуулахуй” өвийг 18 улстай хамтран бүртгүүлсэн. 2020 онд нэмж 6 улс (Хорват, Киргизстан, Ирланд, Нидерланд, Польш, Словак) энэхүү өвийн жагсаалтад хамтран бүртгүүлэх хүсэлтээ илэрхийлсний дагуу, Монгол Улсад “Шувуулахуй” өвийн хадгалалт, хамгаалалтын талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хамт олны оролцоо, бүртгэл судалгааны ажил, давтамжийн талаархи мэдээлэл болон дээрхи 6 улсыг тус жагсаалтад нэмж бүртгүүлэхийг хүлээн зөвшөөрсөн “Зөвшөөрөл”-ийг бэлтгэж, Англи хэл рүү орчуулан ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисст хүргүүллээ.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны (хуучнаар) Мэдээллийн технологи, статистикийн хэлтсээс манай байгууллагад хандан соёлын өвийн албан ёсны захиргааны статистикийн мэдээллийг нэгтгэх маягт, нөхөх зааврыг боловсруулж 2020 оны 8 дугаар сард ирүүлж, хамтран ажиллах хүсэлтийн дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус өв гэсэн 3 ангиллын дагуу 7 төрлийн статистик мэдээллийг нэгтгэх маягт, маягтыг нөхөх зааврын төслийг тус тус боловсруулан Соёлын яаманд хүргүүлсэн. Үүнд:

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20 ...оны үйл ажиллагааны мэдээ /З-СӨ-1/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 17 хуудастай,
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 20 ... оны мэдээ /З-СӨ-2/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 6 хуудастай, Аймаг, нийслэлийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 20 ... оны нэгтгэл мэдээ /З-СӨ-2.1/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 16 хуудастай
- Соёлын биет бус өвийн 20 ... оны мэдээ /З-СӨ-3/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 7 хуудастай, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн 20... оны хөдөлмөр эрхлэлтийн мэдээ /З-СӨ-3-1/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 6 хуудастай, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн 20... оны боловсролын түвшний мэдээ /З-СӨ-3-2/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 6 хуудастай, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн 20.. оны насны бүлгийн мэдээ /З-СӨ-3-3/-ний маягт, маягтыг нөхөх заавар, 14 хуудастай.

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.4-р арга хэмжээ.
Соёлын биет болон биет бус өвийн дүрс бичлэг, гэрэл зургийн мэдээллийн сан бүрдүүлэх

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ДҮРС БИЧЛЭГЭЭР БАРИМТЖУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны Үр дүнгийн гэрээний Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.4-т заасны дагуу “Соёлын биет болон биет бус өвийн дүрс бичлэг, гэрэл зургийн мэдээллийн сан бүрдүүлэх” ажлын хүрээнд Монгол төрийн түүхийн музейд хадгалагдаж байгаа Засгийн газрын 2010 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан түүх, соёлын хосгүй үнэт 259 ширхэг дурсгалт зүйлийг дүрс бичлэгээр баримтжууллаа. Уг ажлыг 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр 11/01 тоот гэрээ байгуулан СӨҮТ-ийн Ерөнхий бүртгэл мэдээллийн санч Ш.Энхтуяа, дүрс бичлэгийн оператор Д.Мөнхбаатар нар Монгол төрийн түүхийн музейн бүртгэл, мэдээллийн санч Л.Цэнд, арга зүйч Эрдэм шинжилгээний ажилтан Ш.Тогтохбаяр, сан хөмрөгч О.Эрдэнэбадма нарын хамт Монгол төрийн түүхийн музейн 08 тоот өрөөнд 2020 оны 8 дугаар сарын 5, 6, 7, 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Баримтжуулалтыг дүрс бичлэгийн оператор Д.Мөнхбаатар Canon 200D, Sony α7S камераар хийсэн. Засгийн газрын тогтоолын хавсралтын 290, 291, 292, 293 дугаарт батлагдсан Чойбалсангийн бүсний арал, товч, ханцуйны тээглүүр товч, Монгол хатны богтаг малгай, Эмээлийн мод, Цагаан ханангийн агуйн булшны олдвор 4 дэсийн 15 ширхэг

Дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах үзмэрийн жагсаалт

Д/д	Үзмэрийн нэр	ЗГ-ийн тогтоолын хавсралтын дугаар
1	Чойбалсангийн бүсний арал, Товч, Ханцуйны тээглүүр товч	290
2	Монгол хатны богтаг малгай	291
3	Эмээлийн мод	292
4	Цагаан ханангийн агуйн булшны олдворууд	293
5	Зоос	294-548
Нийт 255 үзмэр		

ХУ №	Файлын хэмжээ (GB)	Хугацаа (цаг.мин.сек)
KhU290	1.31	0:06:41
KhU291	1.11	0:05:37
KhU292	1.47	0:07:07
KhU293	4.5	0:22:55
KhU294	0.141	0:00:41
KhU295	0.143	0:00:41
KhU296	0.142	0:00:40
KhU297	0.071	0:00:20
KhU298	0.144	0:00:42
KhU299	0.143	0:00:41
KhU310	0.147	0:00:41
KhU311	0.147	0:00:41
KhU312	0.148	0:00:41
KhU313	0.147	0:00:41
KhU314	0.147	0:00:41
KhU315	0.195	0:00:55
KhU316	0.163	0:00:46
KhU317	0.164	0:00:47
KhU318	0.199	0:00:56
KhU319	0.143	0:00:41
KhU330	0.145	0:00:41
KhU331	0.146	0:00:41
KhU332	0.182	0:00:51
KhU333	0.184	0:00:52
KhU334	0.146	0:00:41
KhU335	0.147	0:00:41
KhU336	0.165	0:00:46
KhU337	0.148	0:00:41
KhU338	0.164	0:00:46
KhU339	0.181	0:00:51
KhU350	0.084	0:00:44
KhU351	0.083	0:00:43
KhU352	0.144	0:00:41
KhU353	0.142	0:00:40
KhU354	0.193	0:00:54
KhU355	0.147	0:00:41
KhU356	0.149	0:00:41
KhU357	0.253	0:01:11
KhU358	0.164	0:00:46
KhU359	0.145	0:00:41

ХУ №	Файлын хэмжээ (GB)	Хугацаа (цаг.мин.сек)
KhU300	0.146	0:00:41
KhU301	0.128	0:00:36
KhU302	0.145	0:00:41
KhU303	0.143	0:00:40
KhU304	0.166	0:00:46
KhU305	0.147	0:00:41
KhU306	0.216	0:01:01
KhU307	0.148	0:00:41
KhU308	0.148	0:00:41
KhU309	0.145	0:00:41
KhU320	0.144	0:00:41
KhU321	0.18	0:00:51
KhU322	0.146	0:00:41
KhU323	0.143	0:00:41
KhU324	0.165	0:00:46
KhU325	0.148	0:00:41
KhU326	0.163	0:00:46
KhU327	0.164	0:00:46
KhU328	0.147	0:00:41
KhU329	0.167	0:00:47
KhU340	0.199	0:00:57
KhU341	0.164	0:00:46
KhU342	0.146	0:00:41
KhU343	0.163	0:00:46
KhU344	0.083	0:00:43
KhU345	0.084	0:00:44
KhU346	0.084	0:00:44
KhU347	0.084	0:00:44
KhU348	0.084	0:00:44
KhU349	0.073	0:00:38
KhU360	0.151	0:00:42
KhU361	0.148	0:00:41
KhU362	0.149	0:00:42
KhU363	0.166	0:00:46
KhU364	0.148	0:00:41
KhU365	0.147	0:00:41
KhU366	0.166	0:00:46
KhU367	0.149	0:00:41
KhU368	0.147	0:00:41
KhU369	0.15	0:00:41

KhU370	0.184	0:00:51
KhU371	0.166	0:00:46
KhU372	0.205	0:00:57
KhU373	0.166	0:00:46
KhU374	0.149	0:00:41
KhU375	0.149	0:00:41
KhU376	0.148	0:00:41
KhU377	0.147	0:00:41
KhU378	0.149	0:00:41
KhU379	0.182	0:00:51
KhU390	0.149	0:00:42
KhU391	0.148	0:00:41
KhU392	0.147	0:00:41
KhU393	0.146	0:00:41
KhU394	0.181	0:00:51
KhU395	0.146	0:00:41
KhU396	0.149	0:00:42
KhU397	0.147	0:00:41
KhU398	0.164	0:00:46
KhU399	0.147	0:00:41
KhU410	0.2	0:00:56
KhU411	0.163	0:00:46
KhU412	0.146	0:00:41
KhU413	0.164	0:00:46
KhU414	0.147	0:00:41
KhU415	0.147	0:00:41
KhU416	0.165	0:00:46
KhU417	0.162	0:00:45
KhU418	0.147	0:00:41
KhU419	0.147	0:00:41
KhU430	0.103	0:00:54
KhU431	0.084	0:00:44
KhU432	0.092	0:00:48
KhU433	0.083	0:00:43
KhU434	0.083	0:00:43
KhU435	0.103	0:00:54
KhU436	0.084	0:00:44
KhU437	0.181	0:00:51
KhU438	0.148	0:00:41
KhU439	0.146	0:00:41
KhU450	0.146	0:00:41
KhU451	0.147	0:00:41

KhU380	0.148	0:00:41
KhU381	0.183	0:00:51
KhU382	0.146	0:00:41
KhU383	0.147	0:00:41
KhU384	0.164	0:00:46
KhU385	0.145	0:00:41
KhU386	0.146	0:00:41
KhU387	0.148	0:00:41
KhU388	0.184	0:00:52
KhU389	0.148	0:00:41
KhU400	0.148	0:00:41
KhU401	0.146	0:00:41
KhU402	0.148	0:00:41
KhU403	0.146	0:00:41
KhU404	0.147	0:00:41
KhU405	0.147	0:00:41
KhU406	0.162	0:00:46
KhU407	0.145	0:00:40
KhU408	0.148	0:00:41
KhU409	0.183	0:00:51
KhU420	0.153	0:00:42
KhU421	0.106	0:00:55
KhU422	0.113	0:00:59
KhU423	0.103	0:00:54
KhU424	0.083	0:00:43
KhU425	0.084	0:00:44
KhU426	0.113	0:00:59
KhU427	0.083	0:00:43
KhU428	0.103	0:00:54
KhU429	0.103	0:00:54
KhU440	0.147	0:00:41
KhU441	0.149	0:00:41
KhU442	0.147	0:00:41
KhU443	0.147	0:00:41
KhU444	0.147	0:00:41
KhU445	0.165	0:00:46
KhU446	0.148	0:00:41
KhU447	0.18	0:00:50
KhU448	0.149	0:00:42
KhU449	0.166	0:00:47
KhU460	0.147	0:00:41
KhU461	0.149	0:00:42

KhU452	0.148	0:00:41
KhU453	0.183	0:00:51
KhU454	0.237	0:01:07
KhU455	0.165	0:00:46
KhU456	0.146	0:00:41
KhU457	0.164	0:00:46
KhU458	0.147	0:00:41
KhU459	0.146	0:00:41
KhU470	0.184	0:00:51
KhU471	0.146	0:00:41
KhU472	0.163	0:00:45
KhU473	0.163	0:00:45
KhU474	0.166	0:00:46
KhU475	0.146	0:00:41
KhU476	0.149	0:00:41
KhU477	0.146	0:00:41
KhU478	0.147	0:00:41
KhU479	0.146	0:00:41
KhU490	0.179	0:00:51
KhU491	0.146	0:00:41
KhU492	0.162	0:00:46
KhU493	0.145	0:00:41
KhU494	0.159	0:00:46
KhU495	0.145	0:00:41
KhU496	0.146	0:00:41
KhU497	0.144	0:00:40
KhU498	0.146	0:00:41
KhU499	0.145	0:00:41
KhU510	0.159	0:00:46
KhU511	0.143	0:00:41
KhU512	0.143	0:00:41
KhU513	0.147	0:00:42
KhU514	0.145	0:00:41
KhU515	0.182	0:00:52
KhU516	0.144	0:00:41
KhU517	0.145	0:00:41
KhU518	0.162	0:00:46
KhU519	0.181	0:00:52
KhU530	0.144	0:00:41
KhU531	0.142	0:00:41
KhU532	0.14	0:00:41
KhU533	0.143	0:00:41
KhU534	0.194	0:00:56
KhU535	0.177	0:00:51
KhU536	0.144	0:00:42
KhU537	0.143	0:00:41
KhU538	0.144	0:00:42
KhU539	0.143	0:00:41
	27.517	2:15:16

KhU462	0.167	0:00:47
KhU463	0.162	0:00:46
KhU464	0.147	0:00:41
KhU465	0.183	0:00:51
KhU466	0.183	0:00:51
KhU467	0.146	0:00:41
KhU468	0.162	0:00:45
KhU469	0.146	0:00:41
KhU480	0.163	0:00:46
KhU481	0.147	0:00:41
KhU482	0.147	0:00:41
KhU483	0.146	0:00:41
KhU484	0.163	0:00:46
KhU485	0.179	0:00:51
KhU486	0.144	0:00:41
KhU487	0.183	0:00:52
KhU488	0.178	0:00:51
KhU489	0.179	0:00:51
KhU500	0.143	0:00:41
KhU501	0.145	0:00:41
KhU502	0.144	0:00:41
KhU503	0.162	0:00:46
KhU504	0.143	0:00:41
KhU505	0.142	0:00:41
KhU506	0.144	0:00:41
KhU507	0.142	0:00:41
KhU508	0.141	0:00:40
KhU509	0.146	0:00:42
KhU520	0.145	0:00:41
KhU521	0.145	0:00:41
KhU522	0.192	0:00:54
KhU523	0.146	0:00:41
KhU524	0.146	0:00:41
KhU525	0.141	0:00:41
KhU526	0.156	0:00:46
KhU527	0.136	0:00:40
KhU528	0.217	0:01:02
KhU529	0.145	0:00:42
KhU540	0.145	0:00:42
KhU541	0.159	0:00:46
KhU542	0.14	0:00:40
KhU543	0.143	0:00:41
KhU544	0.14	0:00:41
KhU545	0.14	0:00:40
KhU546	0.142	0:00:41
KhU547	0.162	0:00:46
KhU548	0.178	0:00:51
	19.043	1:34:56

дурсгалыг дүрс бичлэгээс гадна гэрэл зургаар баримтжуулсан, үлдсэн 255 ширхэг Зоос тус бүрийг урд болон ар талаас нь камераа хөдөлгөөгүй зоож 40-55 секундын бичлэг хийсэн. Баримтжуулсан үзмэр бүрийн хэмжээ, хугацааг орууллаа.

Баримтжуулах ажлын эхний өдөр 2020 оны 8 дугаар сарын 5-нд 4 дэсийн 15 ширхэг үзмэр, 8 дугаар сарын 6-ны өдөр 85 дэсийн 85 ширхэг Зоос, 8 дугаар сарын 7-ны өдөр 104 дэсийн 105 ширхэг Зоос, 8 дугаар сарын 10-ны өдөр 65 дэсийн 65 ширхэг Зоос хамрагдсан. Нийт 4 өдөр түүх, соёлын хосгүй үнэт 259 ширхэг дурсгалыг 46.56 GB хэмжээтэй, 3:50:12 цагийн хугацаатай дүрс бичлэгээр баримтжууллаа. Баримтжуулсан ажлын тэмдэглэл, холбогдох баримтыг хавсаргав.








МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНЫ ТӨВ ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДЭД ХАДГАЛАГДАЖ БУЙ ТҮҮХ, СОЁЛЫН ХОСГҮЙ ҮНЭТ ҮЗМЭРИЙГ ДҮРС БИЧЛЭГЭЭР БАРИМТЖУУЛСАН АЖИЛ

Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлийн 2 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Комисс байгуулах тухай” 2020 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн А/117 тоот тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл, урлагийн газрын даргын “Гандантэгчэнлин хийдийн дурсгалт зүйлийг тоолох тухай” 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/23 тоот тушаалын хэрэгжүүлж МБШТөв Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн улсын тооллогын ажил хийгдэж байна.

Тооллогын үеийн тус хийдэд хадгалагдаж буй Засгийн газрын 1999, 2011 оны шийдвэрээр “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн 15 дурсгалт зүйлийг нэг бүрчлэн дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг гүйцэтгэсэн. Уг ажлыг СӨҮТ-ийн зураглаач Д.Мөнхбаатар гүйцэтгэсэн ба нийтдээ 4 цаг 52 мин 57 сек-ийн дүрс бичлэг хийж, СӨУНБМСанд архивлан хадгалсан. Хосгүй үнэт дурсгалуудын дүрс бичлэг хийх үед Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга Ч.Нацагням, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Соёл хяналтын улсын ахлах байцаагч Д.Отгонбаяр, Тагнуулын Ерөнхий газрын ажилтан Ч. Бат-Оюун нар байлцаж хяналт тавьж ажилласан.

Дүрс бичлэг хийгдсэн түүх, соёлын хосгүй үнэт 15 дурсгалт зүйлийн жагсаалт

№	Засгийн газрын тогтоолын дугаар	Дурсгалын нэр, Хувийн дугаар	Зураг	Дүрс бичлэгийн хугацаа
1	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 117-рт	Очирдара ГТХ2014.5394 ОД-633 370		27 мин 29 сек
2	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 118-рт	Майдар ГТХ2014.5370-1 ОД 645 373		11 мин 32 сек
3	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 119-рт	Майдар ГТХ2014.5302 ОД646 390		9 мин 8 сек

4	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 120-рт	Сосорбарам ГТХ2014.5368 ОД 631 371, 444		22 мин 40 сек
5	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 121-рт	Чойжий Жанцан Богд ГТХ2014.5299 ОД 615 378		12 мин 45 сек
6	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 122-рт	Лхамж Дүйнхор ГТХ2014.4753 ОД 415 464		24 мин 25 сек
7	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 123-рт	Очирдарь ГТХ2014.4352 ЗД 473 635		36 мин 13 сек
8	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 124-рт бичигдсэн.	Богд лам (Жавзандарната) ГТХ2013.2934 ГД762		20 мин 15 сек
9	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 125-рт	Богд ГТХ2013.2902		10 мин 39 сек
10	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 126-рт	Өндөр гэгээн ГТХ2013.2950 ГД 804 67		15 мин 13 сек
11	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 127-рт	Осоргочоо ГТХ2013.2625 ГД 867		28 мин 54 сек

12	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 128-рт	Арван нэгэн тэргүүнт Аръяабал ГТХ2013.911 НС 208 Д-5		20 мин 6 сек
13	Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 110 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 129-рт	Бурхан багш ГТХ2013.921 НС 217 Д-1		38 мин 12 сек
14	Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 214 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 608-рт	Г.Занабазарын зургаадай таяг ГТХ2014.6511		5 мин 47 сек
15	Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 214 тоот тогтоолоор батлагдсан “Түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ын 609-рт	Г.Занабазарын бойвог (гутал) ГТХ2014.6512		9 мин 39 сек
	Түүх, соёлын 15 хосгүй үнэт дурсгалт зүйлийн дүрс бичлэгийн нийт хугацаа			4 цаг 52 мин 57 сек

НЭМЭЛТЭЭР:

1. Монголын үндэсний телевиз, Өв соёлын студын найруулагч Б.Нямхүү “Гэсэр” туультой холбоотой 1783 GB баримт,

2. “Айрагны нутгаар” ТББ-аас 2019 онд ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад 2019 онд батлагдсан “Айрганы өв”-ийн талаар баримтад кино, судалгааны тайлан бүхий нийт 16.289 MB баримтаар тус тус баяжилт хийгдсэн.

3. ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв-Лимбэний битүү амьсгааг өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь төслийн хүрээнд 5 дугаар сарын 29-нөөс 9 дүгээр сарын 23-ны өдрүүдэд Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Улаанбаатар хот нийт 11 сургагч багш, шавь нарын гэрэл зураг 95 ш, 0.58 GB, дүрс бичлэг 124 ш, 108.71 GB, дуу бичлэг 54 ш, 0.15 GB бичлэг хүлээн авсан.

4. Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл” ТББ болон Монголын Үндэсний Номын Сантай хамтран хэрэгжүүлж буй “Баримтат өвийг танилцуулах веб сайт хийх” төслийн хүрээнд МҮНС-нд хадгалагдаж буй “Монгол Шунхан Данжуур”-ын гэрэлт хөшөөг 3D-ээр баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг 3D баримтжуулалтын ажлын 1.08 GB дата мэдээллийг УНБМСанд хадгалав.

5. Монголын үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрууд” төсөлд хамтран ажиллах санамж бичгийг МҮОНРТелевиз, Титанс пикчерс ХХК-тай байгуулав. Тус төслийн хүрээнд 21 аймгийн нутагт орших түүх, соёлын дурсгалт газрууд баримтат кино хэлбэрээр олон нийтэд сурталчилагдах бөгөөд одоогоор Дорнод, Хэнтий аймгийн нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын баримтат киноны зураг авалт явагдаж байна. Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дээрх ажил түр хойшлогдоод байна. 2678GB бичлэг УНБМСанд архивлав.

ДАНЖУУРЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ 3D БАРИМТЖУУЛАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл ТББ-аас хэрэгжүүлсэн “Баримтат өвийн веб сайт хийх” төсөлд Монголын үндэсний номын сан болон Соёлын өвийн үндэсний төв (СӨҮТ) хамтран оролцсон билээ. Энэхүү төслийн гол зорилго нь олон нийтэд баримтат өвийн тухай цогц мэдлэг олгох, Монгол улсаас ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази-Номхон далайн бүс нутгийн болон Олон улсын баримтат өвийн жагсаалтанд бүртгэгдсэн өвүүдийг сурталчлах, мөн тэдгээрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах явдал байв.


“Баримтат өвийн веб сайт хийх” төслийн хүрээнд өдгөө Монголын үндэсний номын санд хадгалагдаж буй ЮНЕСКО-гийн Олон улсын баримтат өвийн жагсаалтанд бүртгэгдсэн Данжуурын гэрэлт хөшөөг 3D-ээр скан хийж баримтжуулах ажлыг Соёлын өвийн үндэсний төвөөс хийж гүйцэтгэлээ.

Хөшөөг сканнердах ажлыг СӨҮТ-ийн системийн инженер П.Чинбат, зураглаач Д.Мөнхбаатар нар 202 оны 9-р сарын 16-наас 18-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ (Зураг-1). 3D баримтжуулалтыг Konica Minolta Vivid 9i 3D сканнераар хийсэн ба хөшөөний бичээс бүхий хэсгийг өндөр нарийвлалтай Tele линзээр, бусад хэсгийг дундаж нарийвчлалтай буюу Medium линзээр авав.

3D баримтжуулалтын ажлын хүрээнд нийт 3.05 GB хэмжээтэй 283 ширхэг түүхий файл (.VVD) цуглуулж хадгаллаа (Зураг-2). 3D моделийг Geomagic XOS програм хангамж ашиглан боловсруулсан ба веб сайтанд байрлуулах зорилгоор баримтжуулах үеийн цэгийн нягтагшлыг 50%-аар багасгасан болно (Зураг-3).



Зураг-1 | 3D скан хийх ажлын явц



Зураг-2 | 3D скан түүхий файлууд (Raw file)



Зураг-3 | Гэрэлт хөшөөний 3D модель

TITANS PICTURES БОЛОН СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАМТАРСАН МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ, ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУД ТӨСӨЛ

МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДОРНОД АЙМАГТ АЖИЛЛАСАН ТАЙЛАН

Тайлан бичсэн: Б.Амгаланбат /...../

Соёлын өвийн үндэсний төвийн
үл хөдлөх дурсгал хариуцсан
бүртгэл мэдээллийн санч

Улаанбаатар 2020 он

УДИРТГАЛ

Titans pictures санаачлан зохион байгуулж буй Монгол орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд төслийн хүрээнд, Соёлын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төвд хамран ажиллах санал тавьсны дагуу 2020 оны 7 сарын 27 нд хоёр тал хэлэлцэж хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Түүнчлэн санамж бичигт Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс, Titans pictures санаачлан зохион байгуулж буй төсөлд анхан шатны материал бэлдэж өгөх, Түүхэн дурсгалт газруудад буюу үл хөдлөх дурсгалуудыг газар дээр очиж биечлэн тайлбар өгөх мэргэжилтэн гаргах заалт мөн Titans pictures төслийн хүрээнд цугларсан видео бичлэг болон зураг дүрсийг Соёлын өвийн үндэсний төв хүлээлгэн өгөх, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалуулах зэрэг заалтууд тус тус багтсан байна.

Тухайн төслийн зорилго нь төв Азийн өндөрлөгт орших Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрууд болон түүх соёлын биет өвийг олон нийтэд танилцуулж сурталчлах, тэдгээрийг хайрлан хамгаалах асуудалд ард иргэдийн анхаарлыг хандуулахад оршино. Танин мэдэхүйн чиглэлийн энэ нэвтрүүлэг нь түүх, археологийн эрдэм шинжилгээ, судалгааны материалд үндэслэн түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тайлбарлахын зэрэгцээ эдгээр дурсгалууд бидний үеийг хүртэл үе дамжин ирэхдээ ямар их үнэ цэнэтэй ховор нандин олдворууд болохыг нотлох юм. Нэвтрүүлгээрээ уламжлан түүх соёлын үл хөдлөх дурсгалд хандах хандлагыг төлөвшүүлэх, залуу үеийг өнө эртний түүхтэй танилцуулж мэдлэгийн хүрээг нэмэгдүүлэх гол зорилгыг агуулсан байна.


Энэхүү төсөл нь 21 аймаг, 330 гаруй суманд байх түүх, соёл, шинжлэх ухаан, урлаг уран сайхны өндөр ач холбогдолтой түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон эрдэм шинжилгээ судалгаагаар нотлогдсон баримт олдворуудын түүхийн үнэ цэн, ач холбогдол, хувьсал өөрчлөлт, байгалийн үзэсгэлэнт газар түүнд холбогдох домог хууч яриаг ард иргэд, үзэгчдэд тодорхой мэдээлэл өгөх, соёлын өв, түүх соёлын дурсгалд хүндэтгэлтэй хандах нийгмийн төлөвшил бүрдүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой байна.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд төсөл нь манай орны бүх сумдад хэрэгжих бөгөөд 1 сумаас 3-4 түүхийн дурсгалт газрыг сонгон авч байгалийн үзэсгэлэнт 3-4 цогцолбор газруудтай холбон түүх соёлын үл хөдлөх дурсгалын тухай 30 мин баримтат нэвтрүүлэг бэлтгэх болно. Төсөл Соёлын өвийн үндэсний төв болон ШУА-ийн Археологийн хүрээлэн зэрэг холбогдох байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтран ажиллах болно.

Төслийн хүрээнд эхний ээлжинд Дорнод аймгийн 14 сумын нутагт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалаас сонгон 40 гаруй дурсгалт газрууд болон байгалийн үзэсгэлэнт цогцолбор газруудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг бодит байдал, баримт материал, эрдэмтэн судлаачдын дүгнэлт нотолгоонд тулгуурлан, газарзүйн байрлал, аялал жуулчлал, дэд бүтэцтэй уялдуулан олон нийтэд таниулах болно.

Өнөөгийн Монгол улсын 21 аймаг 330 сумын нутаг дэвсгэрээс эртний нүүдэлчин ард түмний үлдээсэн түүх, археологийн дурсгал арвин баялаг, илэрч олдон судлагдаад байгаа билээ. Тэдгээрээс Монголын зүүн хязгаарын бүс нутаг болох Дорнод аймгийн нутгаас эртний Чулуун зэвсгийн үеийн дурсгал, Хүрэл зэвсгийн үеийн дурсгал, Хүннүгийн үеийн дурсгал, Монголын үеийн дурсгал зэрэг бүхэл үед хамаарах олон тооны дурсгалууд илэрч олдон судлагдаад байгаа билээ. Монгол орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд төслийн хүрээнд Дорнод аймгийн 14 сумаас Улс аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон Аймаг, Нийслэлийн хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сонгон авч баримтад нэвтрүүлгийг газар дээр очиж хийх ажлыг 2020 оны 8 сарын 12-ноос 9 сарын 20-г хүртэл хийж гүйцэтгээд ирсэн билээ.

Дорнод аймгийн төсөлд хамрагдсан дурсгалт газрууд



1	Их бүрхантын	47° 52.429'N 118° 27.106'E
2	Шонх Таван толгойн	N47 58 15 E118 9 31
3	Хунт нуурын	47.19389N 117.92722E
4	Тамсагбулагийн	N47 14 37 E117 22 59
5	Барчигарын	N47 17 45 E115 47 57
6	Ловх /Бүрдний гол/	N46 41 17 E115 51 52
7	Алтан Очиртын	N46 52 48 E115 32 49
8	Буян Өлзийтийн	N47 57 5 E113 8 24
9	Саруул гүний	N48 2 26 E113 11 22
10	Цувраалийн	N47 53 5 E112 56 0
11	Тугийн	N47 59 35 E113 25 7
12	Норовлин уулын	N47 59 45 E113 55 43
13	Нүүлийн	N48 0 1 E113 53 27
14	Дунгалжин уулын	N48 14 35 E114 55 37
15	Сайхан булагийн	N48 14 32 E115 25 2
16	Хар эргийн	N47 59 52 E114 6 11
17	Хэрлэн барс	N48 3 19 E113 22 27
18	Чулуут хар толгойн	N48 36 25 E113 26 59
19	Салхит уулын	N48 31 12 E112 56 18
20	Ламын гэгээний	N48 16 39 E114 55 12

21	Юншээбү	N48 35 39 E115 10 54
22	Тэмээн хадны	N48 52 36 E115 5 21
23	Галын	N48 31 53 E114 9 31
24	Баян уулын	N48 35 6 E114 14 26
25	Хараат уулын	N48 30 59 E114 1 20
26	Хөцөөгийн хоолойн	N48 59 30 E114 19 1
27	Цагаанчулуутын	49 05 36 115 02 16
28	Чингисийн	N49 7 56 E114 48 18
29	Монгол цагаан нуурын	N49 53 11 E116 9 38
30	Үхэртийн	N50 2 2 E114 52 46
31	Хайлангийн	49 52 23 114 47 7
32	Бараан толгойн	N49 36 26 E113 37 16
33	Бөөний булангийн	N49 19 49 E114 9 59
34	Улзын Улаан эргийн	N49 28 47 E114 6 53
35	Норовлин уулын	N49 12 33 E113 53 27
36	Дангайн эхний	N49 20 23 E113 45 56
37	Зүүн Ханангийн	N49 10 48 E11 47 35
38	Чингисийн	48 52 33 113 08 38
39	Арслан толгойн	N48 51 26 E112 18 47
40	Эрдэнэ гүний	N48 51 16 E112 19 26

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

1.	Халхгол	Их бурхантын цогцолбор дурсгал
2.		Шонх Таван толгойн хүн чулуун хөшөө
3.	Цагаан-Овоо	Хэрлэн барс хотын туурь, суварга

ДОРНОД АЙМГИЙН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

1.	Баяндун	Дангайн эхний булш
2.		Норовлин уулын булш
3.		Тогоонтөмөр хааны хэрэм
4.		Чингисийн хэрмэн зам
5.	Баянтүмэн	Дүнгэлжин уулын бааюу
6.	Баян-Уул	Чингисийн хэрмэн зам
7.	Булган	Тугийн сүмийн туурь
8.	Гурванзагал	Хөцөөгийн хоолойн цогцолбор дурсгал
9.		Цагаанчулуутын булш
10.		Чингисийн хэрмэн зам
11.	Дашбалбар	Бараан толгойн булш
12.		Бөөний булангийн шинэ чулуун зэвсгийн суурин
13.		Чингисийн хэрмэн зам
14.	Матад	Алтан Очиртын хийдийн туурь
15.		Барчгарын хүн чулуун хөшөө
16.		Буян-Өндөрийн хүн чулуун хөшөө
17.		Ловхын хүн чулуун хөшөө
18.		Хайлаастын амны Ёндонгийн усны бичээс
19.	Сэргэлэн	Галын овооны дурсгал
20.		Паршин уулын булш
21.	Халхгол	Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн суурин
22.		Улаан гангын хэрэм
23.		Утай уулын хийдийн туурь
24.		Халхын сүмийн туурь
25.	Хөлөнбуйр	Баян Өлзийтийн хүн чулуун хөшөө
26.	Цагаан-Овоо	Зүүн дөрөө хэрэм
27.		Чулуут толгойн булш
28.	Чойбалсан	Ламын гэгээний хийдийн туурь
29.	Чулуунхороот	Монгол цагаан нуурын дурсгал
30.		Үхэртийн булш
31.		Хайлангийн булш

ДОРНОД АЙМГИЙН НУТАГТ ОРШИХ БАРИМТАД НЭВТРҮҮЛЭГ ХИЙСЭН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

№	Сум	Газрын нэр	Дурсгалын төрөл	Анх илэрүүлсэн	Холбогдох ном зохиол
1.	Халхгол	Их бурхантын	Цогцолбор дурсгал	То ван хэмээн алдаршсан Халхын Сэцэн хан аймгийн Бат-Очирын Тогтохтөр нутаг хошуу 1859-1861 он.	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
2.		Шонх Таван толгойн	Хүн чулуун хөшөө	1962 онд Н.Сэр-Оджав	Д.Баяр Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002.
3.		Тамсагбулагийн	Шинэ чулуун зэвсгийн суурин	1949 онд А.П.Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги илрүүлэн олсон байна.	Дорж Д. Неолит Восточной Монголии. УБ., 1971. Дорж Д. Тамцаг-Булагская культура и ее место в древней историй Центральной Азий // Ролькочевых народов цивилизации Центральной Азии. УБ. 1974. т. 127-131.
4.	Матад	Барчигарын	Хүн чулуун хөшөө	1962 онд археологич Н. Сэр- Оджав	Д.Баяр Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002.
5.		Ловх /бүрдний гол/	Хүн чулуун хөшөө	1962 онд археологич Н. Сэр- Оджав	Д.Баяр Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002.
6.		Алтан Очиртын	Хийдийн туурь	1858 он Лувсан, Жамбал, Аралдий нарын санаачлагаар байгуулжээ.	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
7.	Хөлөнбуйр	Буян Өлзийтийн	Хүн чулуун хөшөө	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
8.		Сарүүл гүний	Хийдийн туурь	1781 онд Саруул гүний хийдийг байгуулжээ.	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
9.		Цувраагийн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд

				бүртгэсэн	
10.	Булган	Тугийн	Сүмийн туурь	1866 он Тогтохтөр санаачилсан	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
11.		Норовлин уулын	Неолитын булш	1972 онд энэхүү дурсгалт газрыг Монгол-Зөвлөлтийн геологийн экспедицийн геологич В.П.Дергач анх илрүүсэн.	Волков В.В.. Погребение Норовлин –Уула (Монголия) //Археология Северной и Центральной Азии. Новосибирск, 1975. //Монголын археологи: хээрийн судалгааны тайлан (1928-1974). УБ., 2016. т. 262-263.
12.		Нүгний	Хийдийн туурь	1880 онд Ядамсүрэн анх байгуулжээ.	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
13.	Баянт үмэн	Дүнгэлжин уулын	Бааюу	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
14.		Баруун өлзийт	Чулуун зэвсгийн дурсгал	Монгол-Зөвлөлтийн хээрийн судалгааны анги	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
15.		Хар эргийн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
16.	Цагаан-Овоо	Хэрлэн барс	Хотын туурь, суварга	1953-1955 онд археологич Х.Пэрлээ	Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн бүтээл (Нийгмийн ухааны анги). №2. УБ., 1957. Пэрлээ Х. Монгол Ард Улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961, т. 126-127.
17.		Чулуут хар толгойн	Чулуун зэвсгийн дурсгал	1953-1955 онд археологич Х.Пэрлээ	1953-1955 оны тайлан
18.		Чулуут толгой	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд


19.	Чойбалсан	Ламын гэгээний	Хийдийн туурь	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
20.		Тайжнарын	Хурлын туурь	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
21.	Гурванзагал	Хөцөөгийн хооloйн	Цогцолбор дурсгал	Анх археологич Н.Сэр-Оджав 1962 онд дорнод аймгийн нутгаар хайгуул судалгаа хийх үедээ үзэж товч мэдээлсэн байдаг.	[Анхсанаа., Мижиддорж 2010: 389-393; Даваацэрэн нар 2010: 32-36; Мижиддорж., Анхсанаа 2009: 44-48; Наваан нар 2009: 1-53]
22.		Цагаанчулуутын	Дөрвөлжин булш	1969, 1971 онд Гурван гол, 2009-2010 онд МУИС-ын Антропологийн тэнхим Д.Түмэн	МУИС-ын 2009 сэтгүүл
23.		Чингисийн	Хэрмэн зам	Пэрлээ 1961 Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон УБ., 1961	[Пэрлээ 1961: 103-104; Монголын нууц 1976: 281; Эзэн Богд … 1992]
24.	Чулуун хороот	Үхэртийн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
25.		Хайлангийн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
26.	Дашбалбар	Бөөнийбулангийн	Шинэ чулуун зэвсгийн суурин	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
27.		Улзынэргийн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
28.		Төмөртэйтолгой	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд

		н		бүртгэсэн	
29.	Баянд ун	Шалзат толгой	Балгас	2015 он Археологийн хүрээлэн судлаач Т.Иш-Цэрэн	Малтлага судалгааны ажлын тайлан
30.		Угтамын	Хийдийн туурь	Түүхээс үзвэл Угтамын хийдийн үүсгэлийг 1870 оны үед Наваан-Осор мааранба тавьсан	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.
31.		Онхоодойн	Тахилын байгуулламж	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
32.	Баян-Уул	Өвөр эрээний	Хадны зураг	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
33.		Чингисийн	Хэрмэн зам	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
34.		Арслан толгойн	Дөрвөлжин булш	Соёлын өвийн төвөөс зохион байгуулсан тооллогоор 2008 анх бүртгэсэн	Тайлан СӨҮТ-ийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд
35.		Эрдэнэгүний	Хийдийн туурь	Архив	Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ. 2009.

ДОРНОД АЙМГИЙН НУТАГТ ОРШИХ ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУД ДЭЭР БАРИМТАТ НЭВТРҮҮЛЭГ ХИЙСЭН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ

Монгол орны үзэсгэлэнт байгаль түүхэн дурсгалт газрууд төслийн хүрээнд Дорнод аймгийн 12 сумын нутагт орших түүхэн дурсгалт газрууд дээр шинжлэх ухааны үндэслэл бүхий тайлбар хийх ажлыг Соёлын өвийн үндэсний төвөөс үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Амгаланбат, Шинжлэх ухааны Археологийн хүрээлэнгээс Дундад зууны сехторын эрхлэгч доктор Г.Энхтөр нар газар дээр нь ажилсан билээ. Түүнчлэн Дорнод аймгийн Халхгол сумын түүхэн дурсгалт газар дээр доктор Г.Энхтөр, бусад сумууд дээр Б.Амгаланбат миний бие тайлбар хийсэн билээ. Мөн дурсгалт газруудын тодорхойлолт болон байршил зүйг миний бие очсон дурсгалт газар бүр дээр шалгаж явсан билээ. Түүнчлэн доор сум тус бүрийн нэвтрүүлэг хийгдсэн түүхэн дурсгалт гурван газрын тодорхойлолт болон гэрэл зураг, нарийвчлан шалгасан GPS-ийн хамт нэгдсэн байдлаар оруулав.

Түүхэн дурсгалт газруудаар явсан маршрут



1	Их бурхантын	47° 52.429'N 118° 27.106'E
2	Шонх Таван толгойн	N47 58 15 E118 9 31
3	Хунт нуурын	47.19389N 117.92722E
4	Тамсагбулагийн	N47 14 37 E117 22 59
5	Барчигарын	N47 17 45 E115 47 57
6	Ловх/бурдний гол/	N46 41 17 E115 51 52
7	Алтан Очирлын	N46 52 48 E115 32 49
8	Буян Өлзийтийн	N47 57 5 E113 8 24
9	Сарүүл гүний	N48 2 26 E113 11 22
10	Цуараалийн	N47 53 5 E112 56 0
11	Туийн	N47 59 35 E113 25 7
12	Норовлин уулын	N47 59 45 E113 55 43
13	Нүүлийн	N48 0 1 E113 53 27
14	Дунгэлжин уулын	N48 14 35 E114 55 37
15	Сайхан булагийн	N48 14 32 E115 25 2
16	Хар эргийн	N47 59 52 E114 6 11
17	Хөрлөн барс	N48 3 19 E113 22 27
18	Чулуут хар толгойн	N48 36 25 E113 26 59
19	Салхит уулын	N48 31 12 E112 56 18
20	Ламын гэрээний	N48 16 39 E114 55 12

21	Юншэзбү	N48 35 38 E115 10 54
22	Тэмээн хадны	N48 52 36 E115 5 21
23	Галын	N48 31 53 E114 9 31
24	Баян уулын	N48 35 6 E114 14 26
25	Хараат уулын	N48 30 59 E114 1 20
26	Хөцөөгийн хоолойн	N48 59 30 E114 19 1
27	Цагаанчулуутын	49 05 36 115 02 16
28	Чингисийн	N49 7 56 E114 48 18
29	Монгол цагаан нуурын	N49 53 11 E116 9 38
30	Үхэртийн	N50 2 2 E114 52 46
31	Хайлантийн	49 52 23 114 47 7
32	Бараан толгойн	N49 36 26 E113 37 16
33	Бөөний буланпийн	N49 19 49 E114 9 59
34	Улзын Улаан эргийн	N49 28 47 E114 6 53
35	Норовлин уулын	N49 12 33 E113 53 27
36	Дангайн эхний	N49 20 23 E113 45 56
37	Зүүн Хананпийн	N49 10 48 E11 47 35
38	Чингисийн	48 52 33 113 08 38
39	Арслан толгойн	N48 51 26 E112 18 47
40	Эрдэнэ гүний	N48 51 16 E112 19 26

ХАЛХГОЛ СУМ

Их бурхантын цогцолбор. Дорнод аймгийн Халхгол сумын төв Сүмбэрээс хойш 35 км-т, Халх голын баруун эргийн тохойн налуу энгэрт оршино. Их бурхантын цогцолборыг Халхын Сэцэн хан аймгийн Илдэн Жун ван То ван хэмээх Бат-Очирын Тогтохтөр (1797-1868)-ийн санаачлага, удирдлагаар бүтээсэн бөгөөд “Их шүтээн”, “Их бурхант” хэмээн олноо алдаршжээ. То ван хийгээд Сэцэн хан аймгийн хошуу ноёд чулуугаар хэвтээ байдлаар бүтээн залахаар шийдэж аймаг, хошуу нутгийнхны хандив хөрөнгөөр зуу шахам гар урчуудыг оролцуулж 1859-1864 оны хооронд урлан бүтээсэн байна. Уг цогцолбор дурсгалын гол шүтээн Жанрайсиг (Жигжаджав) бурхны өндөр нь 30 метр (дунджаар 94 тохой, 1 тохой 32 см) өндөртэй. Бага хүрээн дотор 2х1.1 м хэмжээтэй 12 суваргыг мөн чулуу шигтгэн бүтээжээ. Энэхүү цогцолбор дурсгал нь он цагийн уртад байгалийн элдэв гамшиг, үер ус, газар хөдлөлт, түймэр, хил орчмын самуун, мөргөлдөөн, социалист нийгмийн үзэл сурталд өртөж эвдэрч сүйдэн, гулсаж ихээхэн гэмтсэн байна. Харин 1990-ээд оноос уг дурсгалыг сэргээн бүтээх санаачлага гарч онд холбогдох судалгаа шинжилгээ, малталт, сэргээн засах ажил тэнд өрнөсөн байна. Энэ ажлын хүрээнд 1995 онд ШУА-аас Их Бурхантын чулуун дурсгалыг судлан шинжлэх баг томилон ажиллуулснаар уг дурсгалын ойролцоо оршдог болон Их Бурхантын дурсгалтай холбоотой хэд хэдэн бурханы дүрс бүхий чулуун дурсгалыг олж бүртгэсэн байна. Үүний дараа Монгол улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн хүрээнд 2012-2016 онд тус дурсгалыг Соёлын өвийн үндэсний төвөөс сэргээн засварлажээ. Дурсгалын байршил 47° 52.429'N 118° 27.106'E



Шонх таван толгойн хүн чулуу. Дорнод аймгийн Халх гол сумын төвийн өмнө 7 км зайтай Шонх таван толгой нэртэй газарт хоёр хүн чулуу байсан бөгөөд нэг нь одоо Монголын Үндэсний Музейд үзмэрт хадгалагдаж байна. Цагаан өнгийн гантиг чулуугаар, түшлэгтэй исэр сандалд заларч буй эр хүний дүрсийг тун уран чадварлаг цоолборлон урласан, эвдэрч хэмхэрсэн зүйл бараг үгүй бүтэн сайнаараа байгаа нь тун онцлог юм. Зүүн гартаа урт иштэй цомбон хундага барьж баруун гараа сандлын тохойвч дээр тавин суужээ. Шанаархаг өргөн нүүр, жирэвгэр хөмсөг, жартгардуу том нүдтэй бөгөөд бөмбөгөр оройтой, зузаан хүрээтэй, оройдоо жинс, ардаа залаа бүхий дүгрэг малгай өмсч хоёр чихний араар багцалж боосон шибилгэр гэзэг унжуулжээ. Дээлийнхээ гадуур, богино ханцуйтай урт хормойтой, хоёр ташаандаа оноо бүхий хувцас давхарлан өмссөн нь ганц өргөн эмжээртэй, зөв ташуу энгэртэй ба үүний хормой дотуур өмссөн дээлийнхээс арай богино болохыг тун бодитой илэрхийлжээ. Баруун ташаандаа мөлгөр булантай, зүүн ташаандаа дөрвөлжин хэлбэртэй хавтага зүүсэн нь онооны завсраар цухуйж харагдана. Хөлдөө шовгордуу хоншоортой, нимгэвтэр ултай гутал өмссөн нь хормойн дороос цухуйж сандлын дорхи тавцанд гишгэсэн байна. Сандлын хөл хоорондоо зөрөлдсөн ба уулзвар дээр нь цэцэг хэлбэрийн тав гаргаж түшлэгийн арыг цэцгэн хээгээр чимжээ. Дурсгалын байршил 47°57'50.45"N 118° 9'17.83"E



Тамсаг булгийн суурин: Дорнод аймгийн Халх гол сумын нутагт Тамсагбулаг сумын хуучин төвөөс зүүн урагш 7 км-т эртний хатаж ширгээд тойром болсон нуурын эрэг дэнжид байрлана. Тамсагбулагийн неолитын дурсгалт газрыг анх 1949 онд А.П.Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги илрүүлэн олсон байна. 1967, 1969 онуудад МЗТСХЭ малтлага судалгааны ажил хийсэн. Тамсагбулагийн сууринд 1998 онд Монгол-Францын судалгааны хэсэг, 2012 онд Монгол-Японы хамтарсан анги тус тус судалгаа хийжээ. Тамсагбулагаас баруун зүүн тийш 2-3 км орчим үргэлжилсэн ганга гуу бүхий дэнжид неолитын үеийн чулуун зэвсгийн зүйл элбэг олдохоос гадна дэнжийн нүцгэрсэн хэсгээр ялзмаг хар хөрст соёлт давхарга ил харагдах нь эртний сууцны хана туургын ул мөр буйг тод гэрчилдэг. Дурсгалын байршил 47°14'37.00"N 117°22'59.00"E



Утай уулын хийд. Халхгол сумын төвөөс баруун тийш 120 гаруй км, хуучны Тамсаг сумын төвийн хойд талд Утай 5 уулын хийдийн туурь бий. Энэ хийдийн туурийнаас баруун тийш 2 орчим км-т хуучны Тамсагийн дивизийн барилга байшингийн үлдэгдэл байдаг. Нутаг орондоо хэцүү То ван хэмээн хүндлэгдэж байсан Тогтохтөр ван энэхүү хийдийг үндэслэсэн бөгөөд 1916 оны орчим шудрага баатар Бавуужавын халдлагад удаа дараа өртөн сүйджээ. Эдүгээ уг хийдийн байгаа газар маш олон байшин барилга, сүм хийдийн суурь, хэрэм хашааны үлдэгдэл ор мөр хараглана. Туурийн дээгүүр барилгын шавар, эдлэл, бурхан шашны холбогдолтой эд өлгийн зүйлс зэрэг олон дурсгал хөглөрч байна. Мөн цөөнгүй хүний яс харагдаж байлаа. Энэ нь 2005-2008 онд олон хүн уг хийдийн туурийг ухаж сүйтгэснээс болжээ. Дурсгалын байршил 47°14'31.29"N 117°23'1.05"E



МАТАД СУМ

БАРЧИГАРЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ: Дурсгалыг анх 1962 онд археологич Н. Сэр- Оджавын удирдсан хээрийн шинжилгээний анги Дорнод аймгийн сумдын нутгаар хайгуул хийж түүх соёлын олон арван дурсгалыг шинээр илрүүлж бүртгэн баримтжуулсны нэг нь Барчигарын хүн чулуун хөшөө юм. Барчигарын хүн чулуун хөшөө нь аймгийн төвөөс 156 км, сумын төвөөс 6 км-т оршдог. Мөн уг дурсгал нь байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалж толгой болон цээж хэсэг нь салж 3н хэсэг болдог, хувцас нь мэдэгдэхгүй, ташаандаа хавтагатай ба 13-р зууны үеийн хөшөө дурсгал хэмээн үздэг. Дурсгалын байршил 46°53'41.33"N 115°19'17.63"E



Ловхын хүн чулуу. Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдын зааг нутаг, Бүрдний гол хэмээх газарт тахилга бүхий хоёр овооны ойролцоо сул хэвтэнэ. Нутгийн ард олон хүн чулууг ”Ловх ноён ” хэмээн нэрлэж хүндлэн тахиж иржээ. Уг хүн чулууг анх 1962 онд Н.Сэр-Оджав удирдуулсан хээрийн судалгааны анги анх илрүүлж, 1981 археологич баяр давтан судалсан байна. Хүн чулууг хүрэн өнгийн хүрмэн чулуугаар үйлдсэн 125 см өндөртэй, 66 см өргөнтэй, 24 см зузаан хэмжээтэй. Хүний биеийн ерөнхий хэлбэр гаргаад нэг талд нь хүний толгойг нэлээд бодитой урлан дүрсэлжээ. Толгойд нь шовгор үзүүртэй дуулга хэлбэрийн малгай дүрсэлж чихийг тал цагираг хэлбэрээр товойлгон урласнаас өөр онц дүрслэлгүй. Нүүр царайг нэлээд бодитой сайн урласан ба хянган хамартай, өргөн нүүртэй, нэлээд том нүдтэй хүний төрх гаргажээ. Дурсгалын байршил 46°41'17.34"N 115°51'51.95"E



Алтан-Очиртын хийд. Матад сумын төвөөс зүүн урагш 25-30 орчим км, Лонходын овооны зүүн тал, Сүмийн голын урд талд, 4-р багийн байрнаас чанх урагш 3 орчим км-д Алтан Очиртын хийдийн туурь оршино. Энд хоёр хэсэг газар ойролцоогоор 30 орчим га газарт олон тооны байшин барилгын үлдэгдэл бий. Барилгуудын байрлалаас харахад 4-5 эгнээ гудамжтай байсан бололтой байна. Зүүн талыг бүлэг байшингийн туурийн ард нэг суварга байсан нь нэлээд нурсан байдалтай байх ажээ. Зарим барилгуудын гадуур тоосгон болон чулуу өрж барьсан хэрэм байна. Эндхийн туурийн дээр барилгын шавар эдлэлийн бүтэн болон хагархай хэсэг, зарим төмөр ахуйн хэрэглээний эд зүйлс хөглөрнө. Байшин барилгын суурь, довжоо, баганын суурь чулуудыг маш сайн засаж урласан байв. Хийдийн туурийг хожуу үед хүмүүс их хэмжээгээр ухаж сүйтгэсэн байна. Дурсгалын байршил 46°52'55.57"N 115°33'4.30"E



ХӨЛӨН БУЙР СУМ

Буян-Өндрийн хүн чулуу. Хөлөнбуйр сумын төвөөс зүүн тийш 16 орчим км, Хэрлэн голын урд хөвөө, Өлзийтийн хөндийн урд талд орших Баян Өлзийт уулын зүүн хойд бэлд, сумын төвөөс Булган сум орох замын дэргэд жижиг чулуун овоолгын дунд сул хэвтэх нэг хүн чулуун хөшөө байна. Энэхүү хөшөө орших газрыг зарим иргэд “Хүн чулуун хөшөөтийн толгод” гэж нэрлэдэг гэнэ. Энэ хөшөөг шаргал саарал өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар урлажээ. Хүн чулуун хөшөө нь баруун гартаа сэнжтэй аяга барьж цээжин тус газраа авсан, зүүн гараа хүйс орчимд авч бүсээ атгасан байдалтай цэх босоо, хүний цээжин хэсгийн дүрсийг гаргасан байна. Толгойн ерөнхий хэлбэр өргөн шанаатай, урт эрүүтэй, оройгоороо гурвалжин хэлбэртэй ажээ. Эрүүний хэсгийг цээжрүү нэлээд түрж орсон байдалтайгаар дүрсэлсэн байна. Нүүрэнд нүд, хамар, амны дүрслэлийг хонхойлгох товойлгох хоёр аргаар гаргажээ. Мөрний хэсгийн урд талаас эгц харахад өргөн, зузаан байдалтай харагдах авч энэ нь мөр булчингийн дүрслэл бус урлаачийн хүний биеийн ерөнхий тэгийг гаргахдаа хийсэн засвар ажээ. Баруун гарыг мөрнөөс доош нарийсган гаргаад тохойгоор нугалан цээжин тушаа байрлуулан хуруугаар бөөрөнхий ёроолтой сэнжтэй савны сэнжнээс барьсан /чимхэн барьсан/ байдалтай дүрсэлсэн байна. Дурсгалын байршил 47°57'5.10"N 113° 7'50.82"E



Саруул гүний хийд. Хөлөнбуйр сумын төвөөс зүүн хойш 30-аад км, Хэрлэн голын хойд бие, Норзонгийн овооны урд энгэрт, Дорнодын замыг дагасан холбооны утасны модны дэргэд тус хийдийн туурь оршино. Эдүгээ тус хийдийн туурь орчимд янз бүрийн хэмжээтэй 40 гаруй барилгын үлдэгдэл суурь мэдэгдэх бөгөөд түүн дээр барилгын шавар хэрэглэгдэхүүн их байна. Зарим барилгын үлдэгдэл дээгүүр Хэрлэн Барс хотын туурийн дээр байдаг тоосго, дээврийн нөмрөг, тосгуур ваар, суурь чулуудтай ижилхэн хэлбэр хийцтэй тоосго, ваарны үлдэгдэл, чулууд цөөнгүй байв. Энэ нь тус хийдийг барьж байгуулах үед Хэрлэн Барс хотын барилгын үлдэгдлээс ашигласан байж магадгүй гэсэн бодлыг төрүүлж байлаа. Хийдийн туурийн дээрх зарим барилга байшингийн гадуур намхан хэрэм байсан бололтой ул мөр мэдэгдэнэ. Мөн томоохон байшингийн урд талд шороо чулуу ашиглан хийсэн гэрийн буурь цөөнгүй байв. Хийдийн зарим туурийг хожуу үед хүмүүс ухаж сүйтгэсэн байна. Дурсгалын байршил 48° 2'17.04"N 113°10'55.79"E



Цувраа уулын булш. Хөлөнбуйр сумын төвөөс урд зүгт 5 орчим км Өгөөмөр уулын баруун хойно байрлах чулуутай уулын урд энгэрээр дугуй хэлбэртэй хэдэн булш бий. Мөн Баян уулын хойд талд цуварсан гурван толгойн нутгийн иргэд Цувраа хэмээн нэрлэх бөгөөд тухайн уулын хойд талд хүрлийн үеийн бүлэг дөрвөлжин булш болон дугуй булш оршин байна. Дурсгалын байршил 47°52'59.77"N 112°56'23.96"E




БУЛГАН СУМ

Тугийн сүмийн тууль. Булган сумын төвөөс баруун зүгт 30 орчим км, Хэрлэн голын урд хөндий, Хөлөнбуйр сумаас Булган сумруу явдаг замын урд этгээдэд Тугийн овоо гэх орой дээрээ жижиг овоотой намхан уул бий. Энэ уулын энгэрт байх барилгын туурь үлдэгдлийг нутгийнхан Тугийн сүмийн туурь гэнэ. Энд том жижиг нийлсэн 30 гаруй барилгын туурь үлдэгдэл байх бөгөөд түүний дээгүүр барилгын элдэв төрлийн шавар эдлэлүүд хөглөрөх ажээ. Мөн барилгын чулуун суурь цөөнгүй харагдана. Сүүлийн жилүүдэд элдэв багажтай улсууд ирж Тугийн сүмийн туурийг ухаж сүйтгэх явдал мэр сэр гардаг болсон гэнэ. Үүнийг батлах баримт бол барилгын туурийн дотор талд энд тэнд ухаж онгичсон нүх олон байсан явдал юм. Тугийн сүм нь дээр үеэс энэ нутгийнхны Чингис хааны үйл амьдралтай холбон ярилцаж хайрлан хүндэтгэж ирсэн онгон дагшин газар юм. Тэдний яриагаар бол “Чингис хаан Алтан улстай байлдаад буцаж явахдаа энд буудаллаж Туг ууланд хар тугаа байрлуулж байжээ. Энэ дурсгалт үйл явдалтай холбогдуулан Минжүүрдорж гэх хүн хожим нь энд сүм дуганыг барьж байгуулсан ажээ. Уг сүмд Чингис хаан түүний есөн өрлөгийн баримал байсан гэдэг” ажээ. Мөн Туг уулын ард Сэцэн ханы ноёдууд чуулган хуралдаанаа хийдэг угсраа тоонотой том Хөх гэр байсан тухай нутгийн ард иргэд ам дамжин ярилцсаар эдүгээг хүрчээ. Дурсгалын байршил 47°59'35.64"N 113°25'18.24"E



Норовлин уулын булш: Дорнод аймгийн Булган сумын нутагт Норовлин уулын баруун суганд оршино. Анх 1972 онд энэхүү дурсгалт газрыг Монгол-Зөвлөлтийн геологийн экспедицийн геологич В.П.Дергач анх илрүүлсэн. Улмаар тэр жилдээ Н.Сэр-Оджав, В.В.Волков нар малтан судалсан байна. Тухайн дурсгалт газарт 1974 онд археологич Н.Сэр-Оджав, В.В.Волков нар дахин судалгаа хийсэн боловч ганц тахилгын байгууламжаас өөр дурсгал илрүүлээгүй байна. Булшны тал хэсэг эвдэрсэн байсан ба малтлагын дүнд 1,6 м-ийн гүнд өвдгөөр нь атийлгаж, суугаа байдлаар, монгол төрхийн хүнийг оршуулсан байсан нь тогтоогдсон юм.Түүний толгой хавьд нь 1,5-2 мм голдоч бүхий 3000 орчим сондор байсан нь уг хүний дээл малгайд хадаж байсан бололтой. Мөн оршуулганд хүний нүүрний дүрс бүхий цайвар өнгийн чулуугаар хийсэн 22,5 см урт чулуун онго, 43 см урт хоёр талдаа зуулга чулуун иртэй ясан хутга, гахай, тарвага, хүдрийн соёогоор хийсэн ясан зүүлт, гахай, зарааны дүрстэй танан чимэг, дугуй ба сар хэлбэрийн гоёл чимэглэлийн зүйл, ясан бугуйвч, 10,5 см урт захыг нь ирлээгүй хос хутган ялтас, хоёр захыг нь сэлтлэн ирлэж зассан 6 ш жижиг хутган ялтас зэргийг дагалдуулан тавьсан байжээ. Норовлингийн булшны оршуулгын зан үйлтэй холбоотой бас нэг сонирхолтой зүйл бол хүнээ оршуулахын өмнө ухсан нүхэнд болон хүнээ оршуулсны дараа түүний дээр их хэмжээний улаан зосон будаг цацсан явдал юм. Энэ нь зосоор цусыг төлөөлүүлсэн ба хүний хойд насны тухай ойлголттой шууд холбоотой болно. Дурсгалын байршил 48° 0'23.01"N 113°46'33.18"E



Норовлингийн неолитын үеийн булш
Neolithic tomb of Norovlin

Нүгний хийдийн туурь. Булган сумын төвөөс баруун тийш 8 орчим км, Булган овооны баруун урд, Хэрлэн голын хөндийрүү түрж орсон бяцхан хошууг нутгийнхан Нүгний хошуу гэдэг. Дээр үед нутгийн ард иргэд энэ хошууны дээрээс Хэрлэн голын хойд эрэг дээр байх Булган овооны зүг идээ цагааны дээжээ өргөдөг байсан гэнэ. Эдүгээ энэ хошуун дээр хийдийн бололтой элдэв шавар эдлэлээр босгосон жижигхэн овоо бий. Овооны өвөрт барилгын суурийн чулуу гэмээр дөрвөлжин боржин чулуугаар тахилын ширээ байдлаар тавьсан байлаа. Эрт дээр үед энэ орчимд Нүгний хийд байсан гэнэ. Гэхдээ овооны урдуур хошууны дэвсэг дээгүүр барилгын бололтой тоосго, шавар эдлэлийн хэсгүүд хөглөрөн харагдах боловч ямар нэг байшин барилгын туурь үлдэгдэл гэхээр зүйл мэдэгдэхгүй байв. Ямар ч гэсэн өнөөгийн сумын төвийн баруун талаар эртний гэмээр байшин барилгын суурь байсныг энэ хийдийн туурь мөн эсэхийг цаашид нарийн нягтлан хэрэгтэй байна. Дурсгалын байршил 48° 0'4.94"N 114°29'37.29"E



БАЯНТҮМЭН СУМ


Дүнгэлжин уулын бааюу. Баянтүмэн сумын төвөөс зүүн зүгт 40 орчим км, аймгийн төвөөс зүүн тийш 30-аад км, Хэрлэн голын урд биед орших Дүнгэлжин хэмээх гурван хэсэг түнтгэр уулын баруун талын уулын баруун хойд хормойд хуучны нэг шатаах зуух байна. Энэ хэсэгт хэрлэн гол урагшаа тохойрсон хэсгийн баруун тал, айлын өвөлжөөнөөс 600-д метрт байрласан байдалтай байна. Бааюу дотор талын хоёр хана 4,5 орчим м урт, үүд хоймор нь 2,8 орчим м талбайтай, хагас дугуй хэлбэрийн үүдтэй, улаан хөх өнгийн тоосго өрж шавраар шавардсан ажээ. Зарим тоосго нь дутуу шаталттай учир их өгөршиж бутарсан байв. Дотор талын хананд нимгэн хар хөө наалдсан байв. Дотор тал нь бага зэрэг зууван дугуй юм. Үүдний хэсгийг нимгэн хавтгай чулуудыг зузаан шавраар шавж үйлдсэн байна. Үүдний урт 1,2 орчим м урт юм. Энэхүү бааюуг хэдэн жилийн өмнө хүмүүс ухаж сүйтгэсэн тул нарийн тодорхойлох боломж олдсонгүй. Ямар боловч энэ ховор дурсгалыг Дорнод аймгийн харьяат Шараа гэх хүн 2-3 жилийн өмнө ухсан гэж нутгийн иргэд бидэнд хэлж байсан. Тухайн үед энэ бааюунаас маш том үхрийн толгой гарсан тухай хүмүүс ам дамжин ярилцаж байсан гэх бөгөөд 2008 онд хэвлэгдсэн “Дорнодын Болор толь”-д ч иймэрхүү утгатай зүйл бичээтэй бий. Бааюуны үүднээс дутуу шатаасан шавар эдлэлийн хэсэг, шар, хөх тоосго, хээтэй тосгуур зэрэг зүйлс олдож байна. Дурсгалын байршил 48°14'34.85"N 114°55'36.93"E



Баруун Өлзийтийн неолитын буудал, суурин. Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос зүүн тийш 17 км-т Хэрлэн голын урд биед орших Баруун Өлзийт гэдэг товцогийн орчимд Монгол-Зөвлөлтийн чулуун зэвсэг судлаачид неолитын үеийн хоёр буудал, сууринг илрүүлэн олж судалжээ. Эхний суурин нь Баруун Өлзийт рүү шахаж тогтсон өндөр дэнж дээрээс олдсон. Эндээс 30 орчим үлдэц, олон тооны хусуур, хутган ялтас, хянгар, ойл, хусуур /хаш/ зэвсэг гарсан байна. Хоёр дахь суурин нь эхнийхээс нэг км орчим зайтай оршино. Тэндэх 30 м-40 м х 300м-400м талбайгаас олон тооны чулуун зэвсэг олдсоны дотор үлдэцүүд, хутган ялтас, ялтсан залтсаар хийсэн зэвсгүүд, булан хусуур, баргил залтсаар хийсэн хянгар, ирэлсэн ялтсан зуулга ир, түүнчлэн үр тариа цайруулдаг самбар чулуу олдсон байна. Баруун Өлзийтөөс зүүн тийш, голын дагууд гурван хэсэг газраас неолитын олдворууд олдсон юм. Эдгээрийн дотор зууван дугуй буюу дугуй хэлбэрийн гал голомтын ор (0,5-1,2 м голчтой 0,1-0,4 м зузаантай) бий. Заримдаа зургаа хүртлэх голомт нэг дороос хамт олдсон нь хоорондоо ойрхон зайтай байрласан байжээ. Голомтуудын дэргэдээс ихэвчлэн үлдэц, хусуур, ойл-хусуур зэвсэг, булан хусуур, залтас ялтас, хутган залтас, том, жижиг амьтдын яс олдсон байна. Мөн эндээс зүүн хажуугаар нь атийлган хэвтүүлж, нүүрийг баруун тийш хандуулан давчиг нүхэнд оршуулсан цогцос бүхий булш гарчээ. Баруун Өлзийтийн сууринаас хэд хэдэн гал голомтын ор хамт олдсон нь сонирхолтой боловч сууцны ор мөр илэрч олдоогүй тул нэг томоохон сууцанд хэд хэдэн гал голомт байв уу, эсвэл олон жижиг сууц тус бүрдээ нэг нэг гал голомттой байв уу гэдэг нь сонирхолтой юм. Дурсгалын байршил 48° 6'17.20"N 114°41'5.49"E



Хар эргийн булш. Баянтүмэн сумын төвөөс баруун зүгт 30 орчим км, Хэрлэн голын хойд хөвөө, Хар эрэг гэх газар 2 булш бий. Эдгээр булшийг ойрын үед хүмүүс ухаж сүйтгэсэн тул нарийн тодорхойлох боломжгүй байв. Зүүн хойд талын булшны хэлбэрээс харахад эдгээр булш нь намхан хашлагатай дөрвөлжин булш байсан бололтой. Мөн тухайн газарт нэгэн шинэ дурсгал үзэж тэмдэглэв. Дурсгалын байршил 48° 1'48.06"N 114° 1'50.38"E



ЦАГААН-ОВОО СУМ

Хэрлэн барс хот. Дорнод аймгийн Цагаан Овоо сумын нутаг Баруун Дөрөө нуурын зүүн урд Хэрлэн Барс хот оршино. 1953 онд тэнд хийсэн эртний судлалын хайгуулаар Хэрлэн Барс хотын хуучин үлдэгдэлтэй холбогдох хоёр хэрмийг ойролцоо нь илрүүлж олсон бөгөөд эл гурван хэрмийг хооронд нь сольж самуурахгүйн тулд судлаачид тусгайлан дугаарлаж, нутийнхны Барс хот гэж нэрлэдэг суварга бүхий их хэрэмт хотыг Барс хот-1 гэж бичиж тэмдэглэх болжээ. Барс хот-1-ийн их хэрмийн хэмжээ нь хааш хаашаа 1600-1800 м, зузаан нь 4 м, өндөр нь 1.5-2 м. Хэрмийн дотор болон зүүн талд тав, долоон давхар хоёр суваргатай байжээ. Хэрмийн баруун өмнөд хэсэгт өндөр шороон довжоон дээр чулуугаар барьсан бага хэрмийн ор бий.Тэр бага хэрмийн дотор дөрвөн барилгын суурьтай бөгөөд энэхүү бага хэрмийн орчинд 5-6 м-ийн хэмээтэй дөрвөлжин барилгын ор арав гаруй байдаг. 1953-1955 онд археологич Х.Пэрлээ Барс-1 хотын хэрмийн доторхи дөрвөн барилга, бага хэрмийн орчин тойрны жижиг барилгын суурь, мөн шохой шатааж байсан зуухны ор зэргийг малтан шинжилж олон, том бурхны сэнтий, дээврийн хөх тоосгон ваар, том жижиг хэмжээний угалзтай, угалзгүй тоосго, шавар баримал, ур хийц сайтай бурхны үлдэгдэл, бурхны баримал чимэглэлийн хэсэг, жансагийн мал адгуусны дүрс, цац, сийлбэртэй мод, яс, төмөрлөг зүйл илрүүлэн олж уг барилга нь бурхан шүтээний газар байсан болохыг тогтоосон байна. Дурсгалын байршил 48° 3'17.60"N 113°21'50.64"E



Чулуут хар толгойн чулуун зэвсгийн дурсгал. Цагаан-Овоо сумын төвөөс зүүн тийш 20 гаруй км, Чулуут хар толгойгоос хойд зүгт 1 км гаруй зайд авто замын баруун талд элстэй эргэн дэнд чулуун зэвсгийн дурсгалт газар бий. Чулуун зэвсгийн дурсгалт газраас цагаан цайвар өнгийн цахиур чулуугаар хийсэн чулуун зэвсгийн үлдэдэл олдож байлаа. Мөн чулуун зэвсгийн дурсгалт газрын урд үзүүр хэсэгт эвдэрч сүйтгэсэн, танигдахгүй болсон 3 булш бий. Тухайн дурсгалт газраас бид баримтат нэвтрүүлэг хийх гэж очих явцадаа чулуун зэвсгүүд болон саарал өнгийн өвөрмөц хээтэй ваар хөрсөн дээр ил гарсан байсныг түүвэр байдлаар авсан болно. Дурсгалын байршил 48°36'20.78"N 113°26'34.82"E



Чулуут толгойн булш. Цагаан-Овоо сумын төвөөс урагш 2-3км, Мобигийн антентай нүцгэн толгойн баруун урд орших хад чулуу ихтэй Чулуут толгойн эргэн тойронд дөрвөлжин голдуу 160 орчим булш байна. Машин замын зүүн талд байрлах 20 гаруй булшны дараас чулуудыг их хэмжээгээр авч зөөснөөс болж хэлбэр төрхийг нь нарийн тодорхойлох боломжгүй болсон байв. Харин замын баруун талаар орших булшнууд нь эрт үед тоногдсон хэдий ч хана, хашлага, хөшөө чулуудын анхны байрлал бараг хөдлөөгүй байв. Чулуут толгойн дөрвөлжин булшнуудын хамгийн том нь 7,0х6,0м хамгийн жижиг нь 2,3х3,2м орчим хэмжээтэй. Эндхийн дөрвөлжин булшны гадаад зохион байгуулалт нь ерөнхийдөө 3 хэлбэртэй юм. Чулуут толгойн булшийг өмнө нь малтан судалсан ажил байхгүй юм. Харин 1980-аад оны үед эндхийн булшны чулуудаас авч байшин барилгын суурь болон малын хашаа , хороонд ашиглаж байсан гэнэ. Ойрын жилүүдэд Чулуут толгойн булшнуудаас 2-3 булшийг ухаж сүйтэгсэн тохиолдол тааралдаж байлаа. Дурсгалын байршил 48°32'24.24"N 113°14'42.62"E



ЧОЙБАЛСАН СУМ

Ламын гэгээний хийдийн туурь. Чойбалсан сумын төвөөс баруун урагш 30-аад км, Хэрлэн голын хойд хөвөөнөө 2 хэсэг газарт Ламын Гэгээний хийдийн туурь оршино. Тухайн дурсгалын 1800 оны төгсгөл үед лам нарын саачлагаар бариж байгуулсан бөгөөд 1900 оны эхээр их хэлмэгдүүлэлтийн үед устаж үгүй болсон байна. Хийдийн туурь дэрээс хөх өнгийн тоосго болон дээврийн ваарны хагархай элбэг олдож байна. Дурсгалын байршил 48°15'6.19"N 114°53'13.21"E



Талбайн Тайж нарын хурлын тууль. Сумын төвөөс зүүн тийш 60 гаруй км, Хэрлэн голын зүүн хойд хөвөө, Сүмийн Цагаан нуурын зүүнтээ хоёр барилгын тууль бий. Үүнийг нутгийн ард иргэд “Талбайн Тайж нарын хурлын тууль” гэж нэрийдэх ажээ. Тухайн дурсгалт газар нь Гурван баян уулын баруун талд оршин байна. Дурсгалын байршил 48°36'8.87"N 115°25'41.81"E



ГУРВАНЗАГАЛ СУМ

Цагаанчулуутын булшнууд. Гурванзагал сумын төвөөс зүүн урагш 12 км зайд Цагаан чулуут хэмээх газарт олон үеийн булшнууд оршин байна. Энд 2008 онд энд 160 гаруй оршуулгын байгууламж тоологдсоны дийлэнх нь дөрвөлжин булш байснаас археологич Д.Наваан Монголын үед холбогдох нэгэн булшийг сонгон малтсан байна. Мөн 2010 оны нэмэлт тооллогоор нийт 166 булш тоологджээ. 1969, 1971 онуудад ШУА-ын түүхийн хүрээлэнгийн “Гурван голын” шинжилгээний анги анх Цагаан чулуутын оршуулгын газарт ажиллаж, дөрвөлжин булш малтан судлахын завсар цөөн монгол булш малтаж олон сонирхолтой эд өлгийн зүйлс илрүүлсэн байдаг. Мөн энд Д.Наваан Монголын үед хамаарах цөөн булш малтан судалсан ба зарим үр дүнгийн талаар нэгэн сэдэвт зохиолдоо тусгажээ. Түүний энд малтсан “Цагаан чулуут”-ийн 5,6,7,8-р булшнаас шинэ чулуун зэвсгийн үлдцүүд олдож байсан ба ихэнх нь оршуулга дэр чулуутай тохиолддог ажээ. Дурсгалын байршил 49° 5'28.56"N 115° 2'23.44"E



Хөцөөгийн хоолойн дурсгал: Дорнод аймгийн Гурванзагал сумын төвөөс баруун зүгт 60 км орчим, Хөцөөгийн хоолойн баруун дэнж дээр бүлэг дурсгал оршино. Энэхүү дурсгалт газар анх археологич Н.Сэр-Оджав 1962 онд дорнод аймгийн нутгаар хайгуул судалгаа хийх үедээ үзэж товч мэдээлсэн байдаг. Энд дөрвөлжин булш, түүний хоёр хүн чулуу, хадны зургийн дурсгал хамтдаа байдаг. Дөрвөлжин булш нь хэмжээний хувьд 540 х 480 см бөгөөд зүүн хойд талд нь 2 хүн чулууг зэрэгцүүлэн нүүрээр нь булш руу харуулан тавьсан байна. Эхний буюу хойд талын хүн чулуунд хүний нүүр, нүд, хөмсөг, хамар, ам, эрүү хацрыг мэдэгдэхүйц товойлгон дүрсэлжээ. Уг хүн чулуу 70 см өндөр, өргөн 49-52 см, зузаан 6-12 см хэмжээтэй. Харин хоёрдугаар хүн чулуу өмнөх чулуунаас зүүн урагш 1.6 м зайд оршино. Энэ хүн чулууны дүрслэл маш бүдгэрсэн байна. Хэмжээ 58 см өндөр, 46 см өргөн, 21 см зузаан байна. Энэхүү дурсгал нь Төв болон Дорнод Монголын нутгаар дөрвөлжин булшинд олонтой тохиолдох хөшөө чулууг хүн чулуу болохыг нотлох чухал хэрэглэгдэхүүн бөгөөд нэгэнтээ ууган археологич Х.Пэрлээ өөрийн “Хүн чулуун хөшөөний үүсэл хувьслыг судлах асуудалд” бүтээлдээ энэ талаар дурьдсан байдаг. Мөн энд дөрвөлжин булшны хажууд унасан байдалтай ромбо хэлбэртэй 118 см урт, 83 см өргөн чулуун дээр шулуун 2 зураасаар зам, түүний хоёр талаар дээд талд 4, доод талд 3 адууг нуруугаар нь зураас руу хандуулан сийлжээ. Энэ хадны зураг нь Монгол орны энэ төрлийн дурсгалын зүүн зах нь болох юм. Дурсгалын байршил 48°59'22.98"N 114°19'0.84"E



Лацын амны булш. Гурванзагал сумын төвөөс баруун зүгт 50 орчим км, Айраг уулын баруун үзүүр, Баян-Эрхэт овооны орчим болон Лацын амны адгийн жалгын хоёр эрэг дээр нийт 30 гаруй булш бий. Эдгээр булшны ихэнх нь дөрвөлжин хэлбэртэй байх бөгөөд 10 гаруй нь дугуй хэлбэртэй юм. Дөрвөлжин булшны хамгийн том нь 2,9х4,1м, жижиг нь 1,6х2,3м бол дугуй булшны дундаж голч нь 3,4 орчим м байлаа. Дөрвөлжин булшны хана хашлагыг энгийн чулуудыг хайрцаглан өрж суулгасан байх бөгөөд голыг нь чулуугаар дүүргэсэн байна. Бүх булшнууд эрт үед тонуулчдын гарт өртөж анхны хэлбэр төрхөө алдсан ажээ. Дугуй булшнуудын хэлбэр төрх, чулуун дээр суусан хөрсний зузаан зэргээс харахад эдгээр нь дөрвөлжин булшийг бодвол харьцангуй хожуу үед /Түрэгийн үеэс-Монголын үед/ үйлдсэн бололтой юм. Дурсгалын байршил N48 52 24 E114 34 6



Сүмийн булгийн хийдийн туурь. Гурванзагал сумын төвөөс баруун хойд зүгт 5 орчим км, Сүмийн нуурын хойд эрэг, булгийн ойролцоо 2 том барилгын туурь үлдэгдэл бий. Үүнийг нутгийнхан Сүмийнбулагийн хийдийн туурь гэдэг. Хоёр барилгын суурийг ойролцоогоор 1,5-2м өндөр шороо овоолон дагтаршуулж дээр нь нэлээд гоёмсог сүм дуган барьсан байна. Үүнийг туурийн дээр хөглөрөх барилгын паалантай чимэглэл, хээ, хуар бүхий тоосго зэргээс харж болно. Бидний ажсанаар бол энэ хоёр барилгын туурь үлдэгдэл нь хэдийгээр хийдийн туурь нэртэй боловч бүр эрт үеийн ордны туурь үлдэгдэл ч байж болох юм. Сайтар нягтлах хэрэгтэй дурсгал ажээ. Дурсгалын байршил 49° 7'55.39"N 114°48'15.75"E



ЧУЛУУНХОРООТ СУМ

Үхэр чулуутын дөрвөлжин булш. Чулуунхороот сумын төвөөс баруун хойд зүгт 90 орчим км, Үхэрт гэх том чулуутай нүцгэн уулын оройд 26 дөрвөлжин булш, 6 хөшөө чулуу байна. Булшнуудын хамгийн том нь 4,1х4,7м, хамгийн жижиг нь 2,1х2,6м байв. Дөрвөлжин булшнууд нь анхныхаа байдлыг хэдийнээ алдсан хэдий ч хэлбэр зохион байгуулалтаа хадгалан үлдсэн байна. Булшнуудыг энгийн чулуудыг хоёр талаас нь жижиг чулуугаар чигжин хайрцаган суулгаж буланд нь өндөр гонзгой чулууг босоогоор нь суулгажээ. Энэ хэлбэрийн булш Үхэртийн дөрвөлжин булшны ихэнх хувийг эзлэх бол зарим намхан хашлагатай, хөшөөгүй энгийн дөрвөлжин булш мэр сэр харагдаж байв. Хойд талд бүлэглэн орших дөрвөлжин булшны зүүн талд босгосон хөшөө чулуудын гадаргуу дээр ямар нэг тамга тэмдэг, дүрс байхгүй байна. Харин урд этгээдэд орших хадтай толгойн өвөрт хөшөөтэй нэг дөрвөлжин булш бий. Хөшөө нь булшнаас зүүн тийш 20 орчим алхмын зайд орших ба 64 см өндөр, 39 см өргөн, 27 см зузаантай юм. Хөшөөний гадаргууг маш сайн засаж тэгшилсэн байх ба булшруу харсан гадаргуу буюу баруун талд нь тал дугуй дүрсийн тэгш талыг нь дээш харуулан сийлжээ. Мөн зүүн тийш харсан гадаргуу дээр урт иштэй шанаган тамга дүрсэлсэн байв. Дурсгалын байршил 50° 01'42.69"N 114°52'27.06"E



Хайлангийн дөрвөлжин булш. Чулуунхороот сумын төвөөс баруун зүгт 80 орчим км, Хайлангийн цагаан нуурын баруун хойд дэвсэг дээр байсан 2 дөрвөлжин булш бусдаасаа хэмжээний хувьд харьцангуй том бөгөөд хашлага чулууны гадагш харсан гадаргуу дээрээ сийлмэл зурагтай юм. Хойд талын булшны баруун урд талд хашлага болгон суулгасан /хөшөө болгож суулгасан/ элсэн боржин чулууны гадагш харсан тэгш гадаргуу дээр нийт 12 амьтны сийлмэл зураг байгаагийн дотор 3 ширхэг буга, 5 ширхэг гөрөөс, 1 ширхэг үнэг, 3 ширхэг шувууны зураг байв. Энэ чулууны өндөр 135см, өргөн 81 см, зузаан 27см байв. Бугын дүрсийг хүзүүгээрээ дээш өлийсөн байдалтай /урамдаж байгаа мэт/ дүрсэлсэн бол үнэгний зургийг газраар ямар нэг зүйл үнэрлэж байгаа мэт хүзүүгээ унжуулан яваа байдлаар дүрсэлжээ. Шувуудыг цуварч суусан байдалтай дүрсэлсэн байна. Гөрөөсийг урт биетэй цэх зогсож байгаа байдлаар дүрсэлжээ. Бугын эврийг олон салаа гэсэн санаагаар гол зураасын хоёр талруу урт богино шулуун зураас татаж тоймлон дүрсэлсэн байна. Энэ зургийн зарим нэг амьтдын дүрслэл он цагийн уртад элэгдэж алга болжээ. Дурсгалын байршил 49°52'15.49"N 114°46'41.49"E



ДАШБАЛБАР СУМ

Бөөн булангийн чулуун зэвсгийн дурсгал. Дашбалбар сумын төвөөс баруун зүгт 32 орчим км, Бөөний булан хэмээх газар хоёр элсэн эрэгцэгт шинэ чулуун зэвсгийн үлдэгдэл бүхий дурсгалт газар бий. Эндээс улаан, хүрэн, ногоон, шаргал өнгийн хас чулуун, цагаан өнгийн өөхөн чулуун, саарал өнгийн хайраг, боржин чулуун элдэв чулуун зэвсгийн үлдэгдэл маш их хэмжээгээр олдож байв. Мөн олон үед холбогдох ваар савны хагархай хэсгүүд их байна. 2009 оны үл хөдлөх дурсгалын улсын тооллогын хүрээнд эндээс 120 гаруй чулуун зэвсгийн үлдэгдэл, 3 чулуун зэв, 2 чулуун нухуур, 250 гаруй ваар савны хагархай хэсэг, 1 хүрэл зэв олсон юм. Бөөний булангийн чулуун зэвсгийн дурсгалт газарт хэд хэдэн газарт гал түлж байсан том жижиг хар нүүрсний толбо бүхий газар байв. Дурсгалын байршил 49°19'56.95"N 114°10'0.93"E



Төмөртэй толгойн булш. Дашбалбар сумын төвөөс хойд зүгт 30 орчим км, Рашаан бөөрийн Төмөртэй толгойн энгэр бэл, хормойгоор 60 гаруй дөрвөлжин булш, гадаргуу дээрээ тамга тэмдэгтэй 1 хөшөө чулуу бий. Эндхийн булшны хамгийн том нь 2,8х3,1м, хамгийн жижиг нь 2,0х2,5м байв. Дөрвөлжин булшнууд эрт цагт тоногдож дараас чулууд нь эмх замбараагүй болсон хэдий ч хана хашлага чулуудын байрлал анхныхаа хэлбэр, зохион байгуулалтыг харьцангуй сайн хадгалж үлдсэн байв. Гэхдээ хашлага чулууд нь гадагш дотогш налж хазайсан байдал ихэнх дөрвөлжин булшинд тохиолдоно. Дараас чулууд гэхээр зүйл бараг мэдэгдэхгүй юм. Төмөртэй толгойн дөрвөлжин булшны гадаад зохион байгуулалт нь том хавтгай чулуудаар хана хашлага хийсэн булш нийтлэг шинжтэй юм. Булшны хашлага чулууны том жижиг өндөр нам байх нь тухайн талбайны хэмжээнээс хамаарч байсан тохиолдол цөөнгүй ажиглагдаж байлаа. Дурсгалын байршил 49°43'36.00"N 114°11'56.00"E



Улзын улаан эргийн булш. Дашбалбар сумын төвөөс баруун хойд зүгт 35 орчим км, Улз голын урд бие, Улаан эрэг гэх газар, Баяндунгаас Дашбалбар сумруу явдаг замын хажууд 10-аад дөрвөлжин булш бий. Эндхийн дөрвөлжин булшнуудын зарим нь маш их эвдрэлтэй тул хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг нь бүрэн тодорхойлж хэмжээ авах боломжгүй болсон байв. Цөөн хэдэн булшны хэрэглэгдэхүүнээс харахад энгийн бахим том чулуудыг 4 буланд нь суулгаад түүнийгээ хавтгайдуу чулуудаар хайрцаглан холбосон хэлбэртэй байна. Гэхдээ бүх булшны 4 буланд суулгасан чулууд харилцан адилгүй том жижиг байсныг дурдах хэрэгтэй. Голын дараас нь чулуу цөөтэй, газрын гадаргатай бараг нэг түвшинд байх ажээ. Эндхийн нэг дөрвөлжин булшны зүүн хойд талд /толгой талд/ 30 орчим см өндөртэй байгалийн засаагүй чулуугаар хөшөө босгосон нь эдүгээ баруун талруугаа нэлээд хазайсан байдалтай байв. Энэ хөшөө чулууны гадаргуу дээр ямар нэг тамга тэмдэг, дүрс байхгүй юм. Дурсгалын байршил 49°28'48.64"N 114° 7'16.96"E



БАЯНДУН СУМ

Угтамын хийдийн туурь. Баяндун сумын төвөөс зүүн зүгт 40 орчим км, Угтам уулын өвөр, Могойтын голын эхэнд Угтамын хийдийн туурь бий. Эдүгээ тус хийдийн туурийн дээр олон тооны байшин барилгын туурь үлдэгдэл , шинээр сэргээсэн хэрэм бүхий дуган, зүүн энгэрт жуулчны газрын байшин зэрэг байна. Мөн хийдийн туурийн дээгүүр гууль, төмөр, хөнгөн цагаан эд зүйлсийн хэсэг, шашны холбогдолтой эд зүйлийн хэсэг ч олон бий. Хийдийн туурь үлдэгдлийг хожуу үед хүмүүс их хэмжээгээр ухаж сүйтгэсэн байна. Түүхээс үзвэл Угтамын хийдийн үүсгэлийг 1870 оны үед Наваан-Осор мааранба тавьсан гэх бөгөөд ид цэцэглэлтийн үедээ буюу XX зууны эхээр Сэцэн хан аймгийн 3 том хийдийн нэгд тооцогдож байжээ. Энэ хийд Цогчин, Чойр, Жүд, Дүйнхэр, Мамба, Ламиран, Зод гэсэн 7 дацан 12 дугантай байнга суудаг 200 гаруй ламтай байсан гэнэ. Хийдийн гол шүтээн нь Гомбо бурхан байжээ. Мөн тус хийдэд Чингисийн хар туг байсан гэх бөгөөд Довчин хувилгаан гэх хүн цагаан сарын битүүнд ёслолын хувцсаа өмсөн мөргөдөг байсан гэнэ. Энэ хийд цамаараа Халхад 2-рт, багийн хийцээрээ 1-рт, хийдийн зохион байгуулалтаараа 4-рт ордог байсан гэнэ. Дурсгалын байршил 49°17'11.22"N 113°46'11.81"E



Онхоодойн тахилын байгууламж. Баяндун сумын төвөөс баруун зүгт 7 орчим км, Мэргэн хар уулын зүүн талд, Онхоодойн булгийн баруун талд хуучин гахайн фермийн зүүн хойно зүүнээсээ баруун зүгт цуварсан 3 тахилын байгууламж бий. Эдгээрийн хойд талынхыг хожуу үед тонуулчид ухаж сүйтгэжээ. Зэрэгцэн орших хоёр тахилын байгууламжийн хэмжээ 2,3х2,5м байна. Тахилын байгууламжуудад зэл чулуу болон хөшөө чулуу байхгүй юм. Хавтгайдуу чулуугаар дүүргэсэн хэлбэр энэ 3 тахилын байгууламжид нийтлэг ажиглагдана. Мөн уг уг газраас хойш 600 орчим метрт сүүл үед ухагдсан нэгэн дөрвөлжин булш бий. Дурсгалын байршил 49°13'42.78"N 113°20'58.36"E



Шалзат толгойн балгас. Баяндун сумын төвөөс зүүн хойд зүгт 30 км, Улз голын урд хөвөө, Шалз толгойн зүүн хөндийд нутгийнхны Тогоонтөмөр хааны хэрэм гэж нэрийдэх хоёр дөрвөлжин шороон хэрэм бий. Зарим хүмүүс “Хороон довын балгас” гэх нь ч бий. Эдгээр хэрмүүд хоорондоо 300-400 м зайтай оршино. Баруун хэрэм нь 40х40 орчим хэмжээтэй урдаа үүдний тасархай хэсэгтэй, 2 орчим м-ийн өргөнтэй, 0,7 орчим м өндөртэй шороо дагтаршуулж хийсэн хэрэм юм. Зүүн хэрэм нь 75х80 м хэмжээтэй урдаа үүдний тасархай хэсэгтэй, 2 орчим м-ийн өргөнтэй, 1,0м өндөртэй шороо дагтаршуулж хийсэн хэрэм юм. Хэрмийн гадуур 3-4 орчим м өрөгнтэй усан шуудууны бүдэг оромтой. Хэрмийн дотор талд нэг байшингийн үлдэгдэл байх бөгөөд түүний хэмжээ 7,0х7,0 орчим м юм. Энэ байшингийн үлдэгдэл дээгүүр барилгын дээврийн нөмөр ваар, тосгуур ваарны хагархай хэсгүүд хөглөрнө. Тухайн дурсгалт газарт Археологийн хүрээлэнгийн судлаачид 2017 онд малтлага судалгааны ажлыг хийсэн байна. Дурсгалын байршил 49°23'43.35"N 113°37'8.11"E



БАЯН-УУЛ СУМ

Өвөр эрээний хадны зураг. Баян-Уул сумын төвөөс хойд зүгт 27 км, Эрээн багийн төвийн хойд хэсэг, Өвөр эрээн ХХК-ны хашааны зүүн талд 30 орчим м, Ц. Баярбатын хашааны баруун хойд буланд, авто замын баруун захад газраас цухуйж байгаа 3 ширхэг хөх саарал өнгийн билүү чулуун дээр амьтан, хүмүүсийн дүрсийг цохиж хонхойлгон дүрслэсэн. Уг чулууд нь газар булагдсан байж байгаад бороо усанд элэгдэж ил гарсан байдалтай. Чулуудын баруун талд 15 орчим метр зайд ухагдсан 3 дөрвөлжин булш байна. Хойд талын булш нь хашлага чулуутай байсан бололтой. Дурсгалын байршил 49°16'31.00"N 112°29'23.00"E



Чингисийн хэрмэн зам. Монгол улсын нутагт “Чингисийн далан”, “Чингисийн зам”, “Чингисийн хэрэм”нэртэй нэлээд хэдэн дурсгал байдгын нэг нь Хэнтий аймгийн Баян-Адарга сумын хуучин төвийн баруун талаас эхлэн Хуурайн даваагчиглэн, Нарийн хөндийд хүрч, Сайханы араас баруунтайгуур, хөндий даган Сайнцагаан нуурын хойгуур гарч, Норовлин сумын Улзын Өндөр дов, Дорнод аймгийн Баян-Уул сумын нутаг Хэрмийн худаг зэрэг газраар дамжин улмаар Цагаан овоо, Сэргэлэн, Гурван-Загал, Чойбалсан сумдын нутгаар БНХАУ-ын нутагт ортол хэсэг хэсэг газар тасран үргэлжилсэн шороон хэрэм юм. Энэхүү хэрэмний Монголын нутагт үргэлжлэх урт нь 500 орчим км. Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Хүйтэн булагийн хоолой хэмээх газраар дайран өнгөрч улсын хилээс гаран Хятад, Орос улсын нутагт мөн тэмдэглэгдсэн байдаг. Дурсгалын байршил 48°49'6.37"N 113° 1'2.75"E



Арслан толгойн дөрвөлжин булш. Баян-Уул сумын төвөөс баруун урд зүгт 50 орчим км, Дэлбэрхэйн өндөрийн баруун талд зэрэгцэн орших хадтай шовх толгойг Арслан толгой гэдэг. Арслан толгойн өврөөр дөрвөлжин голдуу 20 гаруй булш байна. Дөрвөлжин булшны хамгийн том нь 4,5х3,3м, хамгийн жижиг нь 3,0х3,7м байлаа. Эндхийн дөрвөлжин булшний нийтлэг хэлбэр нь дөрвөлжин чулуун далан байдалтай байв. Хашлага гэж танигдахаар хавтгай чулуудын ёроолыг гадна талаас нь хэд хэдэн жижиг хавтгай чулуугаар чигжиж өгсөн тохиолдол тааралдаж байлаа. Ихэнх булшны дөрвөн буланд хана, хашлага чулуудаас бага зэрэг том чулууг хөшөө байдалтай суулгасан харагдана. Арслан толгой дөрвөлжин булшнаас 5-ийг хожуу үед хүмүүс ухаж сүйтгэжээ. Дурсгалын байршил 48°51'20.89"N 112°18'29.74"E



Эрдэнэ гүний хийдийн туурь. Баян-Уул сумын төвөөс баруун урд зүгт 50 орчим км, Дун уулын хойд хөндий Дэлбэрхэйн голын хойд бие, Дэлбэрхэйн суварганы зүүн хойно, Дэлбэрхэйн өндөрийн урд энгэрт 10 гаруй барилгын туурь бүхий Эрдэнэ гүний хийдийн туурь бий. Хийдийн туурийн дээгүүр барилгын элдэв хэрэглэгдэхүүн, мод, төмөр эдлэлийн хэсэг хаа сайгүй хөглөрөх ажээ. Хожуу үед хүмүүс хийдийн туурийн дээрх байшин барилгын үлдэгдлийг ухаж сүйтгэсэн ул мөр цөөнгүй тааралдаж байв. Урд талын Дун хан уул нь Чингис хааны түүхтэй холбоотой гэж үзлэг аж. Дурсгалын байршил 48°51'14.32"N 112°19'15.86"E



ДҮГНЭЛТ

Монгол орны үзэсгэлэнт байгаль түүхэн дурсгалт газрууд төслийн хүрээнд 1 сар гаруй хугацаанд Монгол улсын зүүн бүсийн хязгаар нутаг болох Дорнод аймгийн нутгаар явсан нь зам болон цаг хугацааны хувьд бэрхшээлтэй байсан боловч Монгол орны байгаль цаг уурын сайханд саад бэрхшээлээ умартан түүхэн дурсгалт газруудынхаа сайхныг бишрэн явсаар ирсэн нь нэвтрүүлгийн багийн хамт олны хувьд бахдам ажил болсон билээ. Түүнчлэн Дорнод аймгийн 12 сумын нутагт орших түүхэн дурсгалт газрууд дээр нэгдсэн баримтат нэвтрүүлэг хийх ажил нь урд өмнө нь манай улсад хийгдэж байгаагүй шинэ санаа билээ. Тухайн төслийн эцсийн зорилго нь Дорнод аймгийн нутагт орших түүхэн дурсгалт газруудыг олон нийтэд таниулах, сурталчлах түгээх, нийтийн хандлагыг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой билээ.

Энэхүү Дорнод аймгийн нутгаар явсан төсөл ажлын хүрээнд түүхэн дурсгалт газрын мэдээлэл, гэрэл зураг, бичлэг, агаарын зураг зэрэг олон төрлийн материал судалгааны хэрэглэгдэхүүн баримтжуулалт хийгдэж Дорнод аймгийн Улс, аймгийн хамгаалалтад орсон дурсгалуудын нэгдсэн дата бааз үүсэж буй нь хамгийн чухал ач холбогдол бүхий ажил болж байна.

ХАВСРАЛТ

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

Энэхүү Санамж бичгийг

Нэг талаас: Монгол Улсын Соёлын яамны харъяа Соёлын өвийн Үндэсний төв түүнийг төлөөлж захирал Г.Энхбат;

Нөгөө талаас: "Титанс Пикчерс" ХХК түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Т.Амар

нар дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Соёлын өвийн үндэсний төв, "Титанс Пикчерс" ХХК хамтран Монгол үндэстний түүх, соёлын үл хөдлөх дурсгалын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн санг баяжуулах, олон нийтэд таниулан сурталчлах, үндэсний агуулгатай контент бэлтгэх чиглэлээр эрх тэгш, түншлэлийн зарчимд тулгуурласан хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү Санамж бичгийг байгуулав.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

2.1 Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн түүх, соёл, урлаг, уран сайхан, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүхий л төрөл зүйлийг бүртгэн баримтжуулах, хадгалж, хамгаалах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх суурь болон бусад судалгааг хамтран зохион байгуулах, мэдээлэл солилцох тэдгээрийг дуу дүрс агуулсан бичлэг болгох,

2.2 Мэргэжлийн түвшинд судлаж, бүртгэн баримтжуулсан мэдээллийн санг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, олон нийтэд таниулан сурталчилах зорилгоор үнэдэсний агуулгатай контент боловсруулах болон холбогдох бусад асуудлаар хамтран ажиллахыг зорилго болгоно.

2.3 Санамж бичиг нь талуудын цаашдын хамтын ажиллагаанд дагаж мөрдвөл зохих үндсэн баримт бичиг болно

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

3.1 Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр", 69 дүгээр тоот тогтоолоор батлагдсан "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг гадаад дотоодод сурталчлан түгээн дэлгүүрэхэд хамтран ажиллах,

3.2 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой хадны зураг, бичээс, буган чулуун

хөшөө, хүн чулуун хөшөө, тамга тэмдэг, бичээс бүхий хөшөө, амьтны дүрст чулуун дурсгал, зураг, тамга бүхий хавтан чулуун дурсгалууд зэрэг чулуун соёлын өвийг олон нийтэд таниулах, хамгаалах, сурталчлах чиглэлээр үндэсний агуулгатай контент бэлтгэхэд хамтран ажиллах,

3:2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын холбогдолтой судалгааны болон архивын баримтад үндэслэсэн үндэсний контентийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, телевизээр олон нийтэд түгээхэд дэмжлэг үзүүлэх,

3.4 Санамж бичгийн хэрэгжих хугацаанд жил бүр хамтын ажиллагааны хүрээнд гарсан үр дүнг дүгнэн, цаашдын хамтын үйл ажиллагааг төлөвлөхийг хичээнэ.

3.5 Хамтын ажиллагаа нь харилцан ашигтай, үр дүнтэй байхад чиглэгдэнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Санамж бичигт тусгагдсан аливаа үйл ажиллагаа нь хоёр талын харилцан ойлголцол, хамтын ажиллагааны нэгдмэл зарчимд тулгуурлана,

4.2 Санамж бичгийн хүрээнд хийгдэх аливаа үйл ажиллагааг талууд богино болон урт хугацааны төлөвлөгөөнд тусгаж, харилцан уялдаатай ажиллана,

4.3 Санамж бичгийн хүрээнд гүйцэтгэх ажлыг хоёр байгууллагын удирдлагууд удирдан зохион байгуулна. Үүнд:

4.3.1 Контент бүтээх ажилд оролцуулах судлаач, мэргэжилтнүүдийг сонгох.

4.3.2 Контент бүтээх судалгааны ажилд шаардлагатай соёлын биет болон биет бус өвийн төрөл зүйлийг сонгох, мэдээллээр хангах.

4.3.3 Бэлэн болсон контентийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24.1-2, 36.1-д заасны дагуу олон нийтэд мэдээлэн сурталчлах, .

4.4 Хээрийн зураг авалтын ажил хийх тохиололд багийн бүрэлдэхүүнийг хоёр байгууллагын захирлын томилсон мэргэжилтнүүд ахална,

4.6 Талууд аливаа гүйцэтгэх үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг харилцан тохиролцоно,

Соёлын өвийн үндэсний төвийн эрх үүрэг

4.4 Санамж бичгийн хүрээнд бүртгэн баримтжуулж, олон нийтэд сурталчлахаар төлөвлөж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллээр хангах,

4.5 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг баримтжуулах, олон нийтэд сурталчлахад зөвлөгөө өгөх, тайлбарлагч, хөтөчийг санал болгох,

“Титан пикчерс” ХХК-ийн үүрэг

4.6 Соёлын өвийн үндэсний төвийн мэдээлэлд суурилан баримтжуулсан аливаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, дүрс бичлэг, боловсруулсан видео, дижитал контентийн нэг хувийг Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээлгэж өгч, хадгалуулах.

4.7 Бүтээсэн контентийг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл, телевизээр олон нийтэд түгээх ажлыг хариуцна.

ТАВ. БУСАД

5.1 Энэхүү Санамж бичиг нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 (тав) жилийн туршид хүчин төгөлдөр үйлчилнэ. Санамж бичигт талууд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Санамж бичгийн салшгүй хэсэг байна.

5.2 Хоёр тал хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд бие биедээ хүндэтгэлтэй хандаж, байгууллагын нэр хүнд, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах үүрэгтэй ба үүссэн аливаа маргааныг зөвшилцөх, харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.3 Санамж бичгийг Монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙГ ТӨЛӨӨЛЖ	“ТИТАНС ПИКЧЕРС” –ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.АМАР
.....	.....
2020 оны 07 дугаар сарын 27	2020 оны 07 дугаар сарын 27

УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗ, TITANS PICTURES, СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ БАЙГАЛЬ, ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАРИМ СУМДЫН НУТАГТ АЖИЛЛАСАН ТАЙЛАН

Тайлан бичсэн.....Г.Бүрэнтөгс
.....Б.Өнөрбаяр

УЛААНБААТАР
2020

УДИРТГАЛ

Titans pictures кино зургийн ангийн санаачлан зохион байгуулж буй “**Монгол орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд”** төслийн хүрээнд, Соёлын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төвд хамран ажиллах санал тавьсны дагуу 2020 оны 9 сарын 27 нд хоёр тал хэлэлцэж хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байна. Түүнчлэн санамж бичигт Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс, Titans pictures санаачлан зохион байгуулж буй төсөлд анхан шатны материал бэлдэж өгөх, Түүхэн дурсгалт газруудад буюу үл хөдлөх дурсгалуудыг газар дээр очиж биечлэн тайлбар өгөх мэргэжилтэн гаргах заалт мөн Titans pictures төслийн хүрээнд цугларсан видео бичлэг болон зураг дүрсийг Соёлын өвийн үндэсний төв хүлээлгэн өгөх, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалуулах зэрэг заалтууд тус тус багтсан байна. Тухайн төслийн зорилго нь төв Азийн өндөрлөгт орших Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газрууд болон түүх соёлын биет өвийг олон нийтэд танилцуулж сурталчлах, тэдгээрийг хайрлан хамгаалах асуудалд ард иргэдийн анхаарлыг хандуулахад оршино. Танин мэдэхүйн чиглэлийн энэ нэвтрүүлэг нь түүх, археологийн эрдэм шинжилгээ, судалгааны материалд үндэслэн түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тайлбарлахын зэрэгцээ эдгээр дурсгалууд бидний үеийг хүртэл үе дамжин ирэхдээ ямар их үнэ цэнэтэй ховор нандин олдворууд болохыг нотлох юм. Нэвтрүүлгээрээ уламжлан түүх соёлын үл хөдлөх дурсгалд хандах хандлагыг төлөвшүүлэх, залуу үеийг өнө эртний түүхтэй танилцуулж мэдлэгийн хүрээг нэмэгдүүлэх гол зорилгыг агуулсан байна. Энэхүү төсөл нь 21 аймаг, 330 гаруй суманд байх түүх, соёл, шинжлэх ухаан, урлаг уран сайхны өндөр ач холбогдолтой түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон эрдэм шинжилгээ судалгаагаар нотлогдсон баримт олдворуудын түүхийн үнэ цэн, ач холбогдол, хувьсал өөрчлөлт, байгалийн үзэсгэлэнт газар түүнд холбогдох домог хууч яриаг ард иргэд, үзэгчдэд тодорхой мэдээлэл өгөх, соёлын өв, түүх соёлын дурсгалд хүндэтгэлтэй хандах нийгмийн төлөвшил бүрдүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой байна. Монгол орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд төсөл нь манай орны бүх сумдад хэрэгжих бөгөөд 1 сумаас 3-4 түүхийн дурсгалт газрыг сонгон авч байгалийн үзэсгэлэнт 3-4 цогцолбор газруудтай холбон түүх соёлын үл хөдлөх дурсгалын тухай 30 мин баримтат нэвтрүүлэг бэлтгэх болно. Төсөл Соёлын өвийн үндэсний төв болон ШУАийн Археологийн хүрээлэн зэрэг холбогдох байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтран ажиллах болно. Төслийн хүрээнд хоёрдугаар ээлжинд Хэнтий аймгийн 18 сумын нутагт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалаас сонгон 40 гаруй дурсгалт газрууд болон байгалийн үзэсгэлэнт цогцолбор газруудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг бодит байдал, баримт материал, эрдэмтэн судлаачдын дүгнэлт нотолгоонд тулгуурлан, газарзүйн байрлал, аялал жуулчлал, дэд бүтэцтэй уялдуулан олон нийтэд таниулах болно. Өнөөгийн Монгол улсын 21 аймаг 330 сумын нутаг дэвсгэрээс эртний нүүдэлчин ард түмний үлдээсэн түүх, археологийн дурсгал арвин баялаг, илэрч олдон судлагдаад байгаа билээ. Тэдгээрээс Монголын зүүн хязгаарын бүс нутаг болох Дорнод аймгийн нутгаас эртний Чулуун зэвсгийн үеийн дурсгал, Хүрэл зэвсгийн үеийн дурсгал, Хүннүгийн үеийн дурсгал, Монголын үеийн дурсгал зэрэг бүхэл үед хамаарах олон тооны дурсгалууд илэрч олдон судлагдаад байгаа билээ. Монгол

орны үзэсгэлэнт байгаль, Түүхэн дурсгалт газрууд төслийн хүрээнд Хэнтий аймгийн 18 сумаас Улс аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон Аймаг, Нийслэлийн хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сонгон авч баримтад нэвтрүүлгийг газар дээр очиж хийх ажлыг 2020 оны 10 сарын 16-наас 11 сарын 13-г хүртэл хугацаанд Хэнтий аймгийн 18 сумын нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар нутгийг дүрсжүүлэн баримжуулах үеэр covid-19 цар тахал улс орон даяар гарч Улсын онцгой комисоос энэ оны 12 дугаар сарын 11-нийг хүртэл Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлж, хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан тус ажил түр зогссон болно.

УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТУЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолын хавсралт

20. Хэнтий аймаг		
1.	Батширээт	Өглөгчийн хэрэм
2.		Рашаан хадны цогцолбор дурсгал
3.	Баян-Адрага	Дуурлиг нарсны Хүннүгийн язгууртны оршуулгын газар
4.	Баянхутаг	Сэрвэн хаалганы бичээс
5.	Биндэр	Борбулагийн булш
6.	Дэлгэрхаан	Аваргын балгас
7.	Жаргалтхаан	Дуулга уулын Хүннүгийн оршуулгын газар
8.	Мөрөн	Салбар уулын бичээс
9.	Өмнөдэлгэр	Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхадын зураг, бичээс
10.		Дунд Жаргалантын цогцолбор дурсгал
11.	Хэрлэн	Гэлэн гэх хүн чулуун хөшөө
12.		Цэцэн ханы ордны цогцолбор

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ЖАГСААЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт

20. Хэнтий аймаг		
1.	Батширээт	Үзүүр цохионы хадны зураг
2.		Хажуу нуурын буган чулуун хөшөөд
3.	Батноров	Дүнгэнэдэг хадны зураг
4.		Тунсаг овооны дурсгал
5.	Баянхутаг	Баянхүрээ уулын булш
6.		Модонгийн хэрэм
7.		Сонын урд ухаагийн хүн чулуун хөшөө
8.		Ханзат хотын хэрэм
9.	Баян-Овоо	Хулгар ухаагийн хүн чулуун хөшөө
10.		Цагаан усны хоолойн хөшөө
11.	Биндэр	Бага могойн амны хадны зураг
12.	Дадал	Бор хоолойн адгийн булш
13.		Дэлүүн болдог
14.	Дархан	Ногоон уулын хадны зураг
15.		Ходойн хүн чулуун хөшөө
16.		Шавартайн чулуун зэвсгийн дурсгалт газар
17.	Дэлгэрхаан	Гүн бүрдийн дурсгал
18.		Сүжийн талын хүн чулуун хөшөө

19.		Ханангийн энгэрийн булш
20.		Хаяа худгийн дурсгал
21.	Жаргалтхаан	Баруун Жаргалантын арын хүн чулуун хөшөө
22.		Хар модон толгойн хадны зураг
23.		Цэнхэрийн голын хэрэм
24.	Мөрөн	Баруун хэрэм
25.		Зүүн хэрэм
26.		Уртын амны булш
27.		Худагтын амны хүн чулуун хөшөө
28.	Өмнөдэлгэр	Бичигт ханангийн бичээс
29.		“Удган ширээ” хэмээх дурсгал
30.	Хэрлэн	Саригийн голын хүн чулуун хөшөөд
31.		Эрдэнэ уулын бичээс
32.	Цэнхэрмандал	Цэнхэрмандалын бичээс
33.		“Чингисийн тулга” хэмээх дурсгал

ХЭНТИЙ АЙМГИЙН НУТАГТ ОРШИХ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД ДЭЭР БАРИМТАТ НЭВТРҮҮЛЭГ ХИЙСЭН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ

Титанс пикчресийн санаачилгаар, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Монгол орны үзэсгэлэн байгаль, түүх, соёлын үл хөдлөх дурсгал хийгээд сум орон нутгийн онцлогийг харуулсан баримтат кино нэвтрүүлгийн зураг авалтыг 2020 онд эхлүүлсэн бөгөөд 2020 оны 08 сараас 10 сар хүртлэх хугацаанд Дорнод аймгийн бүх сумдаар нэвтрүүлгийн зураг авалтыг хийсэн байна. 2020 оны 10 сарын 16-ны өдрөөс Хэнтий аймгийн сумдад зураг авлтын ажлыг эхлүүлсэн бөгөөд тус нэвтрүүлгийн хоёрдугаар шатанд Хэнтий аймгийн 18 сумын нутагт орших түүхэн дурсгалт газрууд дээр шинжлэх ухааны үндэслэл бүхий тайлбар хийх ажлыг Соёлын өвийн үндэсний төвөөс үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Г.Бүрэнтөгс, Дэлхийн-Өв Бурхан халдун уулын хамгаалалтын захиргааны ажилтан Б.Өнөрбаяр нар газар дээр нь ажилсан билээ. Түүнчлэн Хэнтий аймгийн

Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Биндэр, Батширээт, Баян-Адарга сумын түүхэн дурсгалт газарт Б.Өнөрбаяр, бусад сумууд дээр Г.Бүрэнтөгс миний бие тайлбар хийсэн билээ. Мөн дурсгалт газруудын тодорхойлолт болон байршил зүйг миний бие очсон дурсгалт газар бүр дээр шалгаж явсан билээ. Түүнчлэн доор сум тус бүрийн нэвтрүүлэг хийгдсэн түүхэн дурсгалт гурван газрын тодорхойлолт болон гэрэл зураг, нарийвчлан шалгасан GPS-ийн хамт нэгдсэн байдлаар оруулав.



1. Цэнхэрмандал сум 2020 оын 10 сарын 16-ны өдрөөс 10 сарын 19-ны өдрүүдэд

Тус нэвтрүүлгийн баг Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас нэврүүлгийн ажлыг эхэлсэн бөгөөд Цэнхэрмандал сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн. Тус нэвтрүүлгийн багт Б. Өнөрбаяр нь Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Нарангийн амны буган чулуун хөшөө, Цэнхэрмандалын бичээс буюу Бургастайн бичигт хад, Чингисийн тулга хэмээн нэрлэгдэх далан бүхий тахилын онгоны мэдээллийг тайлбарласан.

2. Өмнөдэлгэр сум 2020 оны 10 сарын 20-ны өдрөөс 10 сарын 22-ны өдрүүдэд

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн. Тус нэвтрүүлэгт түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар болох

Балданбэрээвэн хийд, Дунд жаргалантын буган чулуун хөшөө бүхий дурсгалт газар, Бичигт ханангийн бичээс, байгалийн үзэсгэлэнт газарт Бурхан Халдун уул, Ононгийн халуун рашаан, Балданбэрээвэн хийдийн орчмын байгалийн үзэсгэлэнт газарт зураг авалт хийсэн болно.

3. Батширээт сум 2020 оын 10 срын 22-ны өдрөөс 10 сарын 24 өдрүүдэд

Хэнтий аймгийн Батширээт сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн. Үүнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар Биндэр уулын дурсгалт газар, Рашаан хадны дурсгалт газар, Өглөгчийн хэрэм зэрэг газарт зураг авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газруудад Дайчин овоо, Хурхын хөндий биндэр овоо, Онон голын сав орчмын зураг авалтыг хийсэн.



4. Биндэр сум 2020 оны 10 сарын 25-наас 10 сарын 28-ны өдрүүдэд

Хэнтий аймгийн Биндэр сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн. Үүнд түүх, соёлын үл хөдлөх дурсгал Бор булагийн хүннүгийн оршуулгын газар, Могойн амны хадны зураг, Ламын ухаа буюу Шар хүрээ хийдийн туурь орчимд зураг авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газруудад Онон хурхын бэлчир, Бор булагийн оршуулгын газрын хойно Онон голын хойд эргийн уул орчмын домогт газар, Ламын ухаа буюу зарим судлаачид Дэлүүн болдог гэж үзэж буй уул орчмын зураглалыг хийсэн.

5. Баян-Адарга сум 2020 оны 10 сарын 28-наас 10 сарын 30-ны өдрүүдэд

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн бөгөөд зураг авалтыг Чингисийн хэрмэн зам, Буурлын агуй, Дуурлыг нарсны хүннүгийн оршуулгын газар үл хөдлөх дурсгалт газруудад зурагт авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газрууд Шуусын боом, Адарга уул, Хүслийн мод болон Хатдын өргөөний зураглалыг хийсэн.

6. Дадал сум 2020 оны 11 сарын 1-наас 11 сарын 4-ны өдрүүдэд

Хэнтий аймгийн Дадал сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн бөгөөд зураг авалтыг Дэлүүн болдог, Нүцгэн өндөр, Хар үзүүр зэрэг үл хөдлөх дурсгалт газруудад зурагт авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газрууд Цагаанчулуут, Дэгэн жигэн, Зээрэн хавцалын зураглалыг хийсэн.



7. Норовлин сум 2020 оны 11 сарын 5-наас 11 сарын 7-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Норовлин сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн бөгөөд зураг авалтыг Өлзийтийн хадны зураг, Баян Өлзийт уулын хадны зосон зургийн дурсгал, Чингисийн хэрмэн зам, Дэлүүн болдог, Нүцгэн өндөр, Хар үзүүр зэрэг үл хөдлөх дурсгалт газруудад зурагт авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газрууд Уран дөш, Шихихутагын анх олсон түүхэн газар нутаг болох газруудаар гэрэл зураг болон дүрс бичлэг хийсэн.



8. Батноров сум 2020 оны 11 сарын 8-наас 11 сарын 10-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Батноров сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн бөгөөд зураг авалтыг Дүнгэнэдэг хад, Хойд буурал уулын ямаан, Тунсаг овоо зэрэг үл хөдлөх дурсгалт газруудад зурагт авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газрууд Аав хад, Хөхүүрийн тал, Агуйт зэрэг түүхэн газар нутаг болох газруудаар гэрэл зураг болон дүрс бичлэг хийсэн.






9. Баян-Овоо сум 2020 оны 11 сарын 10-наас 11 сарын 12-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутгийн онцлог болсон байгалын үзэсгэлэнт цогцолбор газар, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зураг авалтыг хийсэн бөгөөд зураг авалтыг Ханзат хотын туурь, Чингисийн морины уяа, Тунсаг овоо зэрэг үл хөдлөх дурсгалт газруудад зурагт авалт хийсэн бол байгалийн үзэсгэлэнт газрууд Аав хад, Хөхүүрийн тал, Агуйт зэрэг түүхэн газар нутаг болох газруудаар гэрэл зураг болон дүрс бичлэг хийсэн.



ХЭНТИЙ АЙМГИЙН НУТАГТ ОРШИХ, БАРИМТАД НЭВТРҮҮЛЭГ ХИЙСЭН ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАРХАЛТЫН ЗУРАГ



ДҮГНЭЛТ


Энэхүү баримтат кино нь Монгол Орны үзэсгэлэнт байгаль, түүх, соёлын үл хөдлөх дургсалын талаар хийгдэх бөгөөд Монгол улсын 21 аймаг 330 сумыг хамрах бөгөөд Титанс пикчерсээс зохион байгуулж байгаа уг баримтат кино нэвтрүүлгийн зураг авалт 2020 оны 10 сараас Хэнтий аймагт хийгдэж эхэлсэн билээ. Дэлхийн өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт хамаарах Өмнөдэлгэр сум, Батширээт сум хамрагдаж байгаа нь дэлхийн өв, түүний урьдчилсан цагсаалтанд орсон түүх, соёлын дурсгалт газруудыг олон нийтэд танилцуулах, сурталчилах ажлыг хийх нэгэн хэлбэр болж өгсөн юм. Дээрх ажлын хүрээнд Буган чулуун хөшөө бүхий цогцолбор газар, Балдан бэрээвэн хийд, Биндэр уул, Рашаан хад, Өглөгчийн хэрэм зэрэг дурсгалын талаар мэдээлэл өгч ажилласан. Титанс пикчерсээс хийж буй энэхүү нэвтрүүлэг нь 2021 оноос олон нийтэд цацагдаж эхэлнэ. Түүнчлэн Хэнтий аймгийн 18 сумын нутагт орших түүхэн дурсгалт газрууд дээр нэгдсэн баримтат нэвтрүүлэг хийх ажил нь урд өмнө нь манай улсад хийгдэж байгаагүй шинэ санаа билээ. Хэнтий аймгийн нутгаар явсан төсөл ажлын хүрээнд түүхэн дурсгалт газрын мэдээлэл, гэрэл зураг, бичлэг, агаарын зураг зэрэг олон төрлийн материал судалгааны хэрэглэгдэхүүн баримтжуулалт хийгдэж Дорнод аймгийн Улс, аймгийн хамгаалалтад орсон дурсгалуудын нэгдсэн дата бааз үүсэж буй нь хамгийн чухал ач холбогдол бүхий ажил болж байна.


Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.5-р арга хэмжээ. Соёлын өвийн мэдээллийн сангийн цахим сүлжээ байгуулан ажиллах, байгууллага, олон нийтэд, мэдээллийг түгээх.

1. Windows 7 үйлдлийн систем шинэчлэл хийхээ больсонтой холбогдуулан Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн Register болон RCH2.0 программ бүхий музейн компьютеруудыг шат дараалалтай Win10 үйлдлийн системруу шилжүүлэн программуудыг хэвийн ажиллагаанд оруулахаар ажиллаж байна. Жилийн эцэст давхардсан тоогоор байдлаар нийт 34 музейн компьютерын үйлдлийн системд шинэчлэл хийн, программуудын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн www.register.mongoluv.mn нэгдсэн цахим системийг бий болголоо. Дээрх нэгдсэн системд улс, аймгийн музей болон сумдын орон нутаг судлах танхимд хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг агуулсан болно. Тус систем нь эрх бүхий байгууллагуудыг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн.








www.register.mongoluv.mn сайтын харагдах байдал

3. Соёлын өвийн УНБМСангийн цахим санг боловсрогуй болгох зорилгоор СӨУНБМСанд Archive программыг зохиолгож, дотоод ажлын хэрэглээндээ ашиглахад бэлэн болгоод байгаа ба ирэх оноос хэрэгжүүлж эхлэх болно.



Archive программын харагдах байдал

4. Говь-Алтай аймгийн Боловсрол соёл, урлагийн газраар дамжуулан тус аймгийн сумдын Соёлын төвүүдэд соёлын өвийн бүртгэл, мэдээлийн чиглэлээр ашиглах техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага, үзүүлэлтүүд болон соёлын биет ба биет бус өвийг хариуцан ажиллах ажилтны ажлын байрны тодорхойлолт зэрэг арга зүйн зөвлөмжүүдийг цахим байдлаар хүргүүлэн эхний удаад бэлтгэн ажил хийгдсэн. Дэлхий нийтэд тархсан Covid-19 цар тахлын хорио цээрийн дэглэм нөхцөл байдлаас хамааран Говь-Алтай аймгийн сумдад соёлын өвийн цахим программын сургалт зохион байгуулах ажил хийгдээгүй болно.

5. Соёлын өвийн УНБМСанд бүртгүүлэх хүсэлт гаргасан 7 байгууллагын 13 газарт Соёлын өвийн бүртгэлийн Улсын код шинээр олгож, Register бүртгэлийн программд Админ эрхийг нээсэн ба шифрлэсэн Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэр өглөө. Үүнд,

1. Чингис хааны музей 1125 ЧХМ (1125 CHM)
2. Дархан-Уул аймгийн Орхон сумын ОНСТанхимд 4504 ОНС
3. Дундговь аймгийн Дэрэн сумын ОНСТанхимд 4822 ОНС
4. Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын ОНСТанхимд 4834 ОНС
5. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын ОНСТанхимд 4840 ОНС
6. Дундговь аймгийн Гурвансайхан сумын ОНСТанхимд 4813 ОНС
7. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын ОНСТанхимд 4207 ОНС
8. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын ОНСТанхимд 6704 ОНС
9. Хөвсгөл аймгийн Рашаант сумын ОНСТанхимд 6725 ОНС
10. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ОНСТанхимд 6722 ОНС
11. Өвөрхангай аймгийн Ганданпунцоглин хийдэд 6201 ГПХ
12. Завхан аймгийн Дөрвөлжин сумын ОНСТанхимд 8116 ОНС
13. Завхан аймгийн Завханмандал сумын ОНСТанхимд 8119 ОНС

6. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд байгаа соёлын биет болон биет бус өвийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, танилцуулах, сурталчлах, холбогдох байгууллагыг мэдээллээр

хангах, өмчийн хэлбэр үл харгалзан соёлын өвийг бүртгэх, бүртгэлээр хяналт тавих хувилбараар соёл урлаг, соёлын өвийн салбарын төрийн үйлчилгээг олон нийтэд цахим хэлбэрээр хүргэх, хамтран ажиллах механизм бий болгох зорилго бүхий соёлын өвийн цахим мэдээллийн нэгдсэн системийн (E-SOYLIIN OV) танилцуулга, бүтэц, загварын төсөл боловсруулан, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2020 оны 01/324 тоот албан бичгээр хүргүүлсэн.

“Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх цахим Соёлын өв (E-SOYLIIN OV) мэдээллийн нэгдсэн системийн бүтэц, загвар танилцуулгын санал

ЗОРИЛГО

Монгол Улсын хэмжээнд байгаа соёлын биет болон биет бус өвийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, танилцуулах, сурталчлах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, өмчийн хэлбэр үл харгалзан соёлын өвийг бүртгэх, бүртгэлээр хяналт тавих хувилбараар соёл урлаг, соёлын өвийн салбарын төрийн үйлчилгээг олон нийтэд цахим хэлбэрээр хүргэх, хамтран ажиллах механизм бий болгох.

Зорилгын хүрээнд дараах 3 зорилт, 10 үйлчилгээний төрлийг мэдээллийн санд байршуулна.

ЗОРИЛТ

<u>Нэгдүгээр зорилт. Олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдлэг олгох, соёлын өвийг танилцуулах, сурталчлах үйлчилгээ</u>

Үйлчилгээ 1.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл буюу музейн үзмэр, эд өлгийн зүйлсийн мэдээллээр хангах сан

Энэ зорилтын хүрээнд улсын 10, эрдэм шинжилгээний хүрээлэн 2, их дээд сургуулийн 3, байгууллагын дэргэдэх 2, үндэсний номын сан 1, Эрдэнэсийн сан 1, аймаг, орон нутаг, нийслэлийн 24, сум дүүрэг, орон нутаг сурталчлах танхимын 261, шашны 3 нийт 307 байгууллагын сан хөмрөгөөс онцлон танилцуулах тодорхой тооны (100 орчим) шилдэг, үнэт үзмэрийн мэдээлэл болон улс, аймаг, байгууллагын эзэмшил, өмчлөлд хадгалагдаж буй 26 байгууллагын түүх, соёлын хосгүй үнэт дурсгал (778 дурсгал)-ын мэдээллийг товч танилцуулга, гэрэл зургийн хамт мэдээлнэ.

Үйлчилгээ 1.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал буюу хадны зураг бичээс, буган чулуу, хүн чулуу, эртний булш хиргисүүр, хот суурин зэргийн мэдээллээр хангах сан

Энэ зорилтын хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан зэрэглэл ангиллын дагуу улсын (185 дурсгал) болон аймаг нийслэлийн (630 дурсгал) хамгаалалтын зэрэглэлд хамаарах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, сум дүүргийн хамгаалалтын зэрэглэлд хамаарах дурсгалууд, Монгол Улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн 3 дурсгалт газрыг тус тус хамруулах ба засаг захирганы нэгж, төрөл зүйлээр ангилан хуваах, товч танилцуулга, гэрэл зургийн хамт мэдээлнэ.

Үйлчилгээ 1.3. Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч хүмүүсийн мэдээллээр хангах сан

Эх хэл аман уламжлалын илэрхийлэл, ардын язгуур урлаг, уламжлалт арга, ухаан, мэдлэг, гар урлал зэрэг соёлын биет бус өв (7 ай сав, 362 өв), соёлын биет бус өвийг ур чадварын өндөр өвлөн уламжлагч шилдэг хүн (102 хүн), Монгол Улсаас ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн 15 өвийн мэдээллийг угсаатны бүлэг, аймаг орон нутгийн засаг захиргаа, биет бус өвийн төрөл зүйлээр төрөлжүүлэн товч танилцуулга, гэрэл зургийн хамт мэдээлнэ.

Үйлчилгээ 1.4. “Дэлхийн дурсамж” буюу Баримтат өвийн мэдээллээр хангах сан

Энэ зорилтын хүрээнд Монго Улсаас ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” буюу Баримтат өвийн жагсаалтад орсон бүс нутгийн болон Олон улсын бүртгэлд бүртгэгсэн 6 дурсгалт зүйлийг товч танилцуулга, Монгол Улсын үндэсний жагсаалтад бүртгэгдсэн 108 өвийн жагсаалтыг мөн товч танилцуулга гэрэл зургийн хамт мэдээлнэ.

Хоёрдугаар зорилт. Төрийн болон судалгааны байгууллагыг мэдээллээр хангах үйлчилгээ

Үйлчилгээ 2.1. Төрийн болон судалгааны байгууллагыг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллээр хангах

Энэ зорилтын хүрээнд цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналт, хил гааль болон шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад зориулан улсын 10, эрдэм шинжилгээний хүрээлэн 2, их дээд сургуулийн 3, байгууллагын дэргэдэх 2, үндэсний номын сан 1, Эрдэнэсийн сан 1, аймаг, орон нутаг, нийслэлийн 24, сум дүүрэг, орон нутаг сурталчлах танхимын 261, шашны 3 нийт 307 байгууллагын товч танилцуулга, 2018-2019 оны улсын тооллогоор бүртгэгдсэн 126716 дэсийн 176003 ширхэг дурсгалын дүн мэдээ болон түүх, соёлыг хосгүй үнэт дурсгал (778 дурсгал)-ын мэдээлийг Засгийн газрын товч танилцуулга, гэрэл зура бүхий мэдээллээр хангана. Мэдээллийг Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан өгөгдлийн хүрээнд танилцуулна.

№	Байгууллага	Улсын тооллогод хамрагдсан байгууллагуудын тоо	Өмчийн хэлбэрээр
1	Улсын музей	10	Төрийн өмчийн (19)
2	Эрдэм шинжилгээний хүрээлэн	2	
3	Их, дээд сургуулийн дэргэдэх музей	3	
4	Байгууллагын дэргэдэх музей	2	
5	Үндэсний номын сангийн ховор номын фонд	1	
6	Монголбанкны Эрдэнэсийн сангийн музей	1	
7	Аймаг, орон нутаг, нийслэлийн музей	24	Орон нутгийн өмчийн (285)
8	Сум, дүүргийн Орон нутаг сурталчлах танхим	261	
10	Бурханы шашны сум хийд	3	Шашны өмчит (3)
	Нийт	307	

(Хүснэгт 1)

Мөн энэ хүрээнд хууль хяналтын байгууллагад тусгайлан зориулж алдагдсан, эрэн сурвалжилж байгаа, солигдсон, гэмт хэрэгт холбогдоон шалгагдаж байгаа зэрэг нэмэлт өгөгдөл бүхий эх сурвалжаар хангаж болно.

Үйлчилгээ 2.2. Төрийн болон судалгааны байгууллагыг түүх, соёлын үл хөдлөх дурсгал, дурсгалт газрын мэдээллээр хангах

Энэ зорилтын хүрээнд 2015 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг тооллогоор 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийт 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалын мэдээлэл, хамгаалалтын бүс тогтоосон, тусгай хэрэгцээнд авч хамгаалсан, кадастрын бүртгэлд бүртгэгдсэн, уул уурхай, зам, дэд бүтцийн хайгуул, ашиглалтын талбайд орсон зэрэг байгаль, нийгмийн хүчин зүйлийн нөлөөлд өртсөн дүн мэдээ бүхий дурсгалын талаарх мэдээллээр хангана.

Мөн палеонтологи, археологийн эрдэм шинжилгээ болон авран хамгаалах малтлага судалгааны талаарх дүн мэдээг хамруулна.

Хууль хяналтын байгууллагад тусгайлан зориулж алдагдсан, эрэн сурвалжилж байгаа, тоногдсон, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа зэрэг нэмэлт өгөгдөл бүхий эх сурвалжаар хангаж болно.

Үйлчилгээ 2.3. Төрийн болон судалгааны байгууллагыг соёлын биет бус, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хүний мэдээллээр хангах

Энэ зорилтын хүрээнд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлд бүртгэгдсэн 10450 хүний мэдээллийг угсаатны бүлэг, аймаг орон нутгийн засаг захиргаа, биет бус өвийн төрөл зүйлээр төрөлжүүлэн товч танилцуулга, гэрэл зургийн хамт мэдээлнэ. Мөн өвийн өвлөгдөл гээгдэл, өвийн оршин буй байдал зэргийг үнэлсэн тоон мэдээ баримт зэргээр хангаж болно. Соёлын биет бус өв, угсаатны зүйн чиглэлээр судалгаа хийдэг байгууллагын судалсан, судлах шаардладагтай өвийн нэгдсэн мэдээлэл

орж болно.

Гурав. Соёлын өвийн бүртгэл судалгааны чиглэлээр иргэдийн мэдээллийг хүлээн авах үйлчилгээ

Үйлчилгээ 3.1. Иргэний өөрийн санаачилгаар хувийн өмчлөлд хадгалагдаж буй эртний эдлэл, соёлын өвд хамаарах дурсгалт зүйлийг бүртгэх үйлчилгээ

Энэ зорилтын хүрээнд хувь хүн, байгууллага өөрсдийн өмчлөлд хадгадагдаж буй эртний эдлэл, дурсгалт зүйлээ хэрхэн бүртгэж баталгаажуулах тухай зааварчилгааны мэдээллийг системтэйгээр загварчлан танилцуулна.

Үйлчилгээ 3.2. Иргэнээс хээр хөдөө орших түүх, соёлыг үл хөдлөх дурсгалтай холбоотой мэдээллийг авах үйлчилгээ

Энэ зорилтын хүрээнд иргэн шинээр илрүүлсэн, олсон, өөрийн мэдэх болон дурсгалт газрыг хууль бусаар ухаж тонож, байгаа, хөшөө чулууг хулгайлах, авч явж байгаа зэрэг хээр хөдөө орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг орон нутаг болон аймаг улсын холбогдох байгууллага, цагдаа, тагнуул зэрэг хууль хяналтын байгуулага, судалгааны байгууллагад иргэнийхээ эрх үүргийн дагуу хэрхэн мэдээлэхийг системтэйгээр загварчлан танилцуулна.

Үйлчилгээ 3.3. Иргэнээс соёлын биет бус өв, түүнийг өөрөө өвлөн уламжлан эзэмшиж байгааг талаарх мэдээллийг авах үйлчилгээ

Энэ зорилтын хүрээнд иргэн, гэр бүл, хамт олон, угсаатны бүлэг зэрэг талууд эцэг өвгөдөөс уламжлан хадгалж авч үлдсэн соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийн мэдээллийг хэрхэн аймаг орон нутаг, төрийн болон судалгааны байгууллагад хэрхэн мэдэгдэж бүртгүүлэх талаар системтэйгээр загварчлан танилцуулна.

ЦАХИМ САНГИЙН СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Мэдээллийн санд байршигдах мэдээллийг ашиглах хэрэглэгчийг:

- Олон нийтэд зориулсан нээлттэй мэдээлэл буюу мэдээлэл нь хязгаартай үйлчлүүлэгч,
- Тусгай хэрэгцээний байгууллага, этгээдэд мэдээллийг судалгааны түвшинд дэлгэрэнгүй хэлбэрээр хангах, хэрэглэгч үүсгэн нэвтрэх эрхтэй үйлчлүүлэгч гэж 2 ангилна.

Үйлчлүүлэгчдэд соёлын өвийн холбогдох мэдээллээр Соёлын өвийг хамгаалах хуулийн хүрээнд өвийг хадгалж, эзэмшиж, харъяалж буй буй байгууллага, хуулийн этгээд нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бүртгэл, судалгааны байгууллагын зөвшөөрлөөр ханган ажиллана.

Цахим сангийн мэдээллийг удирдлагын түвшинд хариуцагч байгууллага нь Соёлын яам, түүнээс эрх олгосон байгууллага байна.


Мэдээллийг ашиглах арга хэлбэр нь “веб”-д суурилсан онлайн систем технологитой байна.

Мэдээллийн ашиглалт ба аюулгүй байдал: Системд бүртгэлтэй хэрэглэгчид соёлын өвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах ба хэрэглэгчийн системд хийсэн хайлт болон бусад мэдээллүүд түүх үүсгэн хадгалагдана.


Цахим мэдээлэл санг боловсруулах, мэдээллийг дамжуулах бүтцийн зураглалыг хавсаргав.

Төслийн саналыг боловсруулсан:
Соёлын өвийн үндэсний төв

Цахим соёлын өвийн удирдлагын системийн ерөнхий бүтэц




Цахим мэдээллийн сангийн агуулга ба цахим порталын үйл ажиллагааны бүдүүвч



Цахим соёлын өвийн удирдлагын системийн схемчилсэн загвар /СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН САНАЛ/ Хуудас 3/3

Соёлын өвийн цахим мэдээллийн санг бүрдүүлэгч талууд




Цахим соёлын өвийн удирдлагын системийн схемчилсэн загвар /СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН САНАЛ/ Хуудас 3/3

Олон нийтэд зориулсан цахим контент /Жишээ/


ВЕБ ПОРТАЛ

Наадмыг үгтан гарч буй "Монгол дээл" үзэсгэлэн



Мобайл апликейшн

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын навигацын систем бүхий AR контент



7. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Орон зайн суурь өгөгдлийн системд (https://nsdi.gov.mn/) соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа 2015 оны түүх, соёлын үл хөдлөх үзлэг тооллогын мэдээллийг байршуулан, холбогдох байгууллагууд хэрэглэгчийн эрхээр нэвтрэх GIS-д суурилсан WEBMAP-ийн эхний хувилбарыг боловсруулаад байна.

8. Covid-19 цар тахлаас шалтгаалан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан олон нийтэд соёлын өвийн мэдээллийг түгээх зорилгоор байгууллагын веб сайтад “Танин мэдэхүй” дэд цэс нэмсэн ба доторх агуулгыг удирдах админ удирлагын хэсгийг мөн боловсруулж холбогдох тохиргоог серверт хийсэн. Энэхүү булангаар соёлын өвийн танин мэдэхүйн 4 удаагийн мэдээлэл дамжуулагдсан болно.

9. Монгол Улсад коронавируст (COVID19) цар тахал бүртгэгдэж, уг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүх нийтийн бэлэн байдалд шилжин хорио цээрийн дэглэм тогтоосон үед Соёлын яамнаас гаргасан цахимаар ажиллах төлөвлөгөөний дагуу Соёлын өвийн үндэсний төв 19 ажлыг төлөвлөн www.ncch.gov.mn веб сайт болон https://www.facebook.com/ncch.gov хуудсаар дамжуулан олон нийтийн цахим орчинд "ЦАХИМ ОРЧИНД СОЁЛ ТҮГЭЭЕ, БИ ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН" аяныг дэмжин нийт 19 ажлыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 127977 хүнд хүргэсэн байна.

КОВИД-19 ЦАР ТАХАЛЫН ҮЕИЙН БҮХ НИЙТИЙН ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ ХУГАЦААНД СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЦАХИМААР АЖИЛЛАСАН ТАЙЛАН

Монгол Улсад коронавируст (COVID19) цар тахал бүртгэгдэж, уг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүх нийтийн бэлэн байдалд шилжин хорио цээрийн дэглэм тогтоосон үед Соёлын яамнаас гаргасан цахимаар ажиллах төлөвлөгөөний дагуу Соёлын өвийн үндэсний төв 19 ажлыг төлөвлөн www.ncch.gov.mn веб сайт болон https://www.facebook.com/ncch.gov хуудсаар дамжуулан олон нийтийн сошиал орчинд “ЦАХИМ ЕРТӨНЦӨД СОЁЛ ТҮГЭЭЕ, БИ ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН” аяныг дэмжин нийт 19 ажлыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 127977 хүнд хүргэсэн байна. Үүнд:

Цахим хуудас:

- Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс 32014 хүнд,
- Улс аймгийн хамгаалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал 41622 хүнд,
- “ЮНЕСКО-гийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-д бүртгэгдсэн өв. 43715 хүнд,
- “Цахим орчинд соёл түгээе Би хариуцлагатай иргэн” уриалагын төлөвлөгөөнд ороогүй бусад соёлын өвийн мэдээлэл 10626 хүнд

Телевизийн контент:

МҮОНРТ:

- “Монгол өв соёлын гайхамшиг” нэвтрүүлгийн эхний дугаар “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” нэвтрүүлэг
- “Монгол өв соёлын гайхамшиг” нэвтрүүлгийн хоёр дахь дугаар “Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс,тоглоом наадгай,уриа дуудлага” нэвтрүүлэг
- “Өв эрдэнэ” богино хэмжээний 6 цуврал контент (өдөр 3 удаа)

Соён гэгээрүүлэгч:


- “Монгол уртын дуу тоглох уламлалт арга Лимбэний битүү амьсгааг өвлүүлэх нь” нэвтрүүлэг (2 цуврал) телевизийн нэвтрүүлэг

зэргийг тус тус олон нийтэд хүргэв. / нүүр хуудасны хандалтын статистикийг хавсаргав./

Соёлын өвийн үндэсний төвийн нүүр хуудсаар өдөр бүрийн хандалтын тоо



Соёлын өвийн үндэсний төвийн нүүр хуудсаар нийт үзсэн хандалтын тоо:



Соёлын Өвийн Үндэсний Төв
Published by Purevsuren Chinbaa ·
December 8, 2020 at 1:21 PM ·

Соёлын яамнаас уриалж буй "Цахим орчинд соёл түгээе Би хариуцлагатай иргэн" цуврал:

ТАВАН ТОЛГОЙН ХҮН ЧУЛУУ ХӨРГҮҮД
Сүхбаатар аймгийн Онгон сумын төвөөс баруун урагш 40 км орчим зайд, Таван толгой хэмээх газарт, толгодын дунд тахилын байгууламж бүхий XIII-XIV зууны үеийн хоёр хүн чулуун хөрөг оршино.
Хөргүүдийг цагаан өнгийн гантиг чулуугаар хийсэн ба зөв энгэртэй, өргөн эмжээр бүхий ташуу захтай, ар далан дээгүүр үүлэн дунд нисэж яваа лууны дүрстэй, мөн хормой дээгүүр өвд... See More



22,566
People Reached

2,206
Engagements

Boost Unavailable

You and 206 others 8 Comments 118 Shares

Like Comment Share

Most Relevant

Comment as Соёлын Өвийн Үндэсний Төв

View comments

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.2.6-р арга хэмжээ.Улаанбаатар хотод байрлах улсын музейн гадаад, дотоод орчны хадгалалт хамгаалалт ба соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд арга зүйн зөвлөгөө өгөх.

Тайлант хугацаанд 7 музейд музейн гадаад, дотоод орчны хадгалалт хамгаалалт ба соёлын өвийн БМСангийн бүрдүүлэлтэд арга зүйгээр хангахаар төлөвлөсөн боловч цар тахлын хорио цээрийн дэглэмээс шалтгаалан Чойжинламын сүм музейд чийгшил дулааны орчны судалгаа, Монголын уран зургийн галерейд сан хөмрөгийн орчны судалгаа, Дүрслэх урлагийн музей, Монголын үндэсний музейд тус тус ажиллав. Үүнд:

1. Монголын уран зургийн галерейн сан хөмрөгт хадгалагдаж буй тоос, шороо болон бусад хүчин зүйлээс хамгаалах зорилгоор хийгдсэн гадаргуу хэсэгтэй гялгар уутан хучлагатай 52 ширхэг уран зурагт хадгалалт хамгаалалтын эрсдэлийн дүн шинжилгээг хийлээ. Байгаль, цаг агаарын харьцангуй тогтвортой үе буюу өвөл цагт халаалт эхэлсэн үеийг сонгож 2019 оны 12 сарын 25-ны өдрөөс, 2020 оны 1 сарын 15-ны өдрийг хүртэлх 21 хоногийн хугацаанд тухайн зураг хадгалагдаж буй сан хөмрөгт дулаан чийгшилийн хэмжилтийг хийж ажиглалт явуулж зөвлөмж хүргүүлсэн.

2. Чойжин ламын сүм музей хадгалалт хамгаалалтын орчны судалгааг 2 удаа байгуулж ажиллалаа.

- Тус сүм музейн барилга халаалтгүй учир гадны чийгшил халуун дулааны нөлөөлөлд шууд ордог, ялангуяа нимгэн мод, чулуун ханатай, ханын хэсгүүдэд байрлах үзмэр болон хорго нь халуун хүйтний хэлбэлзэлд харьцангуй олон давтамжтай орж хөлрөө үүссэнээр үзмэр болон байгууламжийн тоос шороотой урвалд орж хөгц мөөгөнцөр үүсэх эрсдэл өндөр байгааг танин мэдүүлж урьдчилан сэргийлэх аргазүйгээр хангаж ажилласан.

- Музейн хашаанд байх хөх тоосгон шалны хүрээ тоосго хэсгийг бүрсэн шилэн таг нь газрын хөрсний чийгшил дулааны нөлөөгөөр халуун хүйтний улиралд цан үүсч хөлрөлт явагдсанаар тоосгонд тогтмол чийг өгч үндсэн хатуулагт нөлөөлж бутарч гэмтэх эрсдэл өндөр байгаа болон шилэн таг болох ил музейн технологийн аргазүй стандарт бус байгааг орчны судалгаагаар тодорхойлж өгсөн.

3. Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгийн нэг хэсэгт үзмэрийн хадгалалтын орчны судалгаа мөн чийгшил, дулааны хэмжилтэд нарийвчилсан багажаар 2020 оны 3 дугаар сарын 27-оос 4 дүгээр сарын 3-н хүртэл 7 хоногийн хугацаатай нарийвчилсан хэлбэлзлийг тогтоож, хүрээлэн буй орчны дулаан чийгшлийн эрсдлийг тодорхойлохоор 1 цагийн давтамжтай 150 удаагийн хэмжилт хийж, үзмэрийн хадгалалтын орчин нөхцөлийн судалгааг хийсэн.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай А/129 дүгээр тушаалаар тус Үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д Нарантуяа нь 2020 оны 6 дугаар сарын 12-ноос 29-ний өдрүүдэд Монголын Үндэсний музейн үйл ажиллагаан хяналт үнэлгээ дүн шинжилгээ хийх шалгалтын Ажлын хэсэгт ажилласан. Тус “Ажлын хэсгийн ажиллах удирдамж”, “Үндэслэл, зорилго”-д заасан Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Соёлын өвийг зөөж тээвэрлэх журам”, Засгийн газрын 2018 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”, БСШУ-ны сайдын 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/335 дугаар тушаалаар батлагдсан “Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар”, Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS2006:5643 стандартын 7.4 дүгээр зүйл, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга бөгөөд Ажлын хэсгийн ахлагчийн баталсан “Хийх ажлын төлөвлөгөө”-ний 7 дугаарт тус тус тусгагдсны дагуу “Музейн сан хөмрөгийг бүртгэх баримтжуулах заавар, өмч хөрөнгийн ашиглалт, түүний аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт, зарцуулалтын талаар” тус музейн 2019 он, 2020 оны эхний хагас жилийн үзмэр, эд өлгийн зүйлийн шилжилт хөдөлгөөний зохион байгуулалттай холбогдолтой бүртгэл, баримт материалуудад хяналт шинжилгээ хийж дүгнэлт гарган, Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.


МУЗЕЙН САН ХӨМРӨГИЙН ЭРСДЭЛ БА ОРЧНЫ СУДАЛГАА

ДУМ-н даавуу зөөлөн эдлэлийн сан хөмрөг №114-т хийсэн чийгшил дулааны хэмжилт, хөгц мөөгөнцрийн нян бактерийг устгаж ариутгасан ажлын тайлан

Музейн үзмэр эд өлгийн зүйлийг хадгалан хамгаалах зорилгоор шинжлэх ухаанд суурилсан багажид дүн шинжилгээн арга зүйгээр материал судлал, гэмтлийн төвшинг тодорхойлж хадгалалт хамгаалалт, бэхжүүлэлт сэргээн засварын ажилбар хийх шаардлагатай байдаг. Хадгалалт хамгаалалт, сэргээн засах ажилбар дууссаны дараах эд өлгийн зүйлүүдийг музейн сан хөмрөг, үзүүлэнгийн танхим, хоргонд тухайн эд өлгийн материалын онцлог шинжид таарсан хүрээлэн буй орчны тогтвортой орчин бүрдүүлж хадгалах нь хамгийн чухал асуудал юм. Энэхүү хүрээлэн буй орчны суурь судалгааны хүрээнд хүрээлэн буй орчноос эд өлгийн зүйлд эрсдэл учруулдаг олон хүчин зүйлийн нэг төрөл болох дулаан чийгшлийг үзмэр хадгалагдаж буй музейн сан хөмрөгийн хөгц мөөгөнцөр үүссэн хэсэгт 2020 оны 3 дугаар сарын 27-оос 4 дүгээр сарын 3-н хүртэл нарийвчилсан хэлбэлзлийг тогтоож, хүрээлэн буй орчны дулаан чийгшлийн эрсдэлийг тодорхойлохоор 1 цагийн давтамжтай 165 удаагийн хэмжилт хийж, сан хөмрөгийн хөгц үүссэн хэсэгт хадгалалтын орчин нөхцөлийн судалгааг хийсэн. Материал харгалзахгүй орчны нөлөөлөл бага байх нь олдворт хамгийн таатай орчин бүрдүүлдэг бөгөөд энэхүү чийгшлийн хэмжилтийн үр дүнд хэлбэлзэл харьцангуй өндөр, чийгшил 44.2-20.3% / TR-72wf багажаар/, дулаан хэмжилтийн үр дүнд хэлбэлзэл харьцангуй бага 21.1-17.5 /TR-72wf багажаар/ байсан. Энэ удаагийн дулаан чийгшлийн эрсдэлийг тодорхойлох судалгааг музейд 3 сард хийсэн бөгөөд хадгалалт хамгаалалтын стандартад тохирохуйц дулаан чийгшлийн харьцангуй тогтворгүй, чийгшлийн хувьд 20-с дээш хэлбэлзэлтэй үр дүн гарсан нь цаашид чийгшлээс хамааралтай хөгц мөөгөнцөр үүсэх өндөр магадлалтай байна. Манай орон шиг эрс тэрс уур амьсгалтай нөхцөлд 12 сар бүрийн нарийвчилсан дулаан чийгшлийн хэмжилт хийж, цаашид хэлбэлзлийг харьцуулсан суурь судалгааг хийх зайлшгүй шаардлагатай байна.

2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Сан хөмрөг №114 өрөөний цонхны тавцан хааж тавьсан фанер нь 110х55 см хэмжээтэй газарт мөөгөнцрийн хамгийн анхны хэлбэр болох хөх өнгийн мөөгөнцөр үүссэн байсныг мэдэж 2008 оны Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгийн журмын 1.2-т мөн Монгол улсын стандарт MNS 5643: 2006, 3.1 заасны дагуу музейн захиргаанд амаар болон зураг авч баримтжуулан мэдэгдсэний дагуу дараах арга хэмжээг авав. Сан хөмрөгийн дулааны хэлбэлзэл нимгэн ханын гаднын хүйтэн сэрүүн нөхцөл нөлөөлснөөр бага зэрэг хөлрөө үүсч, органик нэгдэл, нян бактери, бохирдол тоос шороог хөдөлгөөнд оруулж чийгшлээс хамааралтай хөгц мөөгөнцөр үүсэх эрсдэл учруулсан байна. Манай музейн даавуу зөөлөн эдлэлийн сан хөмрөгт чийгшлээс хамаарах хөгц мөөгөнцөр үүссэн байсныг зориулалтын материал, ариутгагч шингэн, багаж хэрэгслээр цэвэрлэгээ хийж хөгц мөөгөнцөрт устгал хийж ариутгасан. Энэ удаа СӨҮТ-ийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газартай хамтран 3 удаагийн нарийвчилсан хуурай цэвэрлэгээ хийж “ Ecomuar wiper” буюу алкил диаминоэтил, глицин гидрохлорид CHNO,ClH, метанол CH3OH, пропилийн спирт CH3CH2OH, целлюлоз полипропилений нийлмэл материал ашигласан даавуун арчлага болон этанол C2H5OH спиртийг ашиглан хөгц мөөгөнцөр, тоос шороог 3-5 удаагын давтамжтай чийгтэй цэвэрлэгээ хийж хөгц үүссэн ханын хэсгийн нян бакьтерийг ариутгаж гүн бохирдлыг цэвэрлэсэн. Цаашид хадгалалт хамгаалалтын стандарт горимд хадгалан хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиглалт судалгааг СӨҮТ-ийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газартай хамтран явуулж байна.

Анхны байдал



Хөгц үүссэн байдал

Хөгц үүссэн шалтгаан- Музейн сан хөмрөгт эд өлгийн зүйлийг хадгалахад хадгалалтын нарийн горим шаарддаг бөгөөд цаг хугацааны туршид гарах эрсдэлийг харгалзан, тогтвортой орчин бүрдүүлж урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай хийдэг. Зөөлөн эдлэлийн сан хөмрөг №114-ийн хуучин цонх байсан хэсэгт тавцанг нь ашиглаж бүртгэлд ороогүй хайрцагтай үзмэрүүдийг байрлуулсан хэсэгт хөгц үүссэн. Гадна цонхны нимгэн хананаас (хөрсөн доороос) чийг авч, сан хөмрөгийн дотоод дулааны нөлөөллөөр дотогшоогоо цан цохиж хөлрөө үүссэнээр нян бактери болон тоос шорооноос үүссэн чийгшлээс хамааралтай хөгц гэж үзэж байгаа бөгөөд, агааржуулалтын систем байхгүй, халаалтын систем нь хуучны том паар учир их халдаг, ямар нэгэн тохиргоо байхгүй зэрэг шалтгаалсан болно.

Сан хөмрөг №114 хийгдсэн ажлууд.

1.Сан хөмрөг №114 хувьд бол хуучин цонх байсан газрыг гаднаас нь битүүлж, дотроос нь мөн фанер тавьж будсан.Цонхны тавцан байсан газрыг ашиглаж түүн дээр хайрцагтай бүртгэлд ороогүй судруудыг олон давхарлан тавьж ханатай нь хөндий биш наалдуулсны улмаас байшингийн доод ёроолоос, мөн гаднаас нь чийг татаж хөх өнгийн хөгц үүссэн байна. Энэ нь барилга нь хуучирч муудсан, доороосоо чийгтэй байгаа нь харагдаж байна. Хөгцийг эхний ээлжид хусаж арилган, доош нь унагаагаад дараа нь хуурай алчуураар, дараа нь чийгтэй ариутгалын бодистой алчуураар өнгөн хэсгийг нь арилгасан.

2. 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Захирлын зөвшөөрлөөр Соёлын өвийн үндэсний төвийн ерөнхий технологич М.Оюунтулга, Бүртгэл мэдээллийн санч П.Баасанцэрэн, Сэргээн засварлагч Р.Чинзориг, миний бие (4хүний бүрэлдэхүүнтэй) сан хөмрөг №114- д орж нөхцөл байдалтай танилцаж, заавар зөвлөгөө өгөв.

Соёлын өвийн үндэсний ерөнхий технологич М.Оюунтулга:

Хөгц нь хүний биед ашигтай ашиггүй хортой хоргүй гэсэн олон төрлөөр оршдог. Цэнхэр хөгц нь байгальд хамгийн өргөн тархацтай аспергиллус төрлийн хөгц юм.

Хөгц мөөгөнцөр нь хүчил төрөгч, хоол тэжээл, дулаан чийгшил, органик бодис гэх мэт нөхцөлөөс ургаж үүсдэг. Цэнхэр хөгц нь хар хөгцтэй адил өдөр тутмын амьдралд танил болсон хөгцүүдийн нэг юм. Агаарт байнгын хөвдөг хүний биед хор хөнөөл багатай хэдий ч улаан хөгцийн үүслийн гол шалтгаан болдог учир хортой хөгцийн төрөлд хувирдаг гэсэн үг юм. Тиймээс органик нэгдэл хадгалагдаж буй сан хөмрөгийн хувьд хөгц үүссэн тохиолдолд хурдан хугацаанд устгал хийхгүй бол органик эд өлгийн зүйлд халдан үүссэнээр материалыг бүтцийн гэмтэлд оруулж гэмтээх гол хүчин зүйл нь болдог.

3.2020.03.27- ны өдөр 11 цаг 50 минутад цэвэрлэх ажиллагаа эхлэв. Ажлын багт СӨҮТ-ийн ерөнхий технологич М.Оюунтулга Ph.D, ДУМ-н сан хөмрөгч Б.Оюунчимэг, судлаач сэргээн засварлагч Р.Чинзориг нар оролцов.

Хөгц үүссэн хэсгийг эхлээд хуурай цэвэрлэгээ хийв.

- Шпателаар хөгцийг хусаж арилгаж дараа нь хуурай даавуугаар арчина.
- Этанолын 100 % уусмалыг цэвэр хөвөн даавуунд шингээж хүчтэй даралтаар 2 дахин арчиж, дараа нь хуурай цэвэр даавуугаар арчина.
- Түүний дараагаар хүйтэн сэнсээр үлээлгэж, нойтон цэвэрлэгээ хийсэн хэсгийг хатаана.
- Дараа нь ECOMUAR WIPER- Япон улсын Экаригаас гаргадаг соёлын биет өвийн хөгц мөөгөнцрийн ариутгал устгалд ашигладаг нойтон сальфеткан алчууураар бигнүүр тавьж дэвтээсний дараа арчиж хөгцийн устгалыг хийсэн. Тус алчуур нь зөвхөн соёлын биет өв болон үзмэр эд өлгийн зүйлд хэрэглэдэг зориулалттай. Хөгц бактерийг бүрэн устгах чадвартай, гүн бохирдлыг арилгадаг үйлчилгээтэй юм. Спиртийн шингэний найрлага ашиглаж байгаа учир гадаргуугийн массыг сийрэгжүүлж гүн хэсэгт үүссэн хөгцийг устгалд оруулдаг. Үүний дараа дахин хүйтэн сэнсээр үлээлгэж хэсэг хугацааны дараа дээрх үйлдлүүдийг дахин хийснээр энэ удаагийн ажилбараа дуусгасан. Тус ханын хөгцтэй хэсгийг бүрэн ариутгаж хөгцөнд устгал хийж цэвэрлэсэн хэдийч чийгшил дулааны битүүмжлэл багатай тогтворгүй орчин үргэлжилсээр байвал цаашид хөгц дахин үүсэх боломжийг бүрдүүлнэ.

Цаашид авах арга хэмжээ.

СӨҮТ-ийн ерөнхий технологич М.Оюунтулгын зөвлөснөөр хана цонхны тавцан хоёрын хоорондын ханыг зузаалж, битүүмжлэлийг сайжруулж тоос шороо ханын завсар орохыг хязгаарлаж чийгшил, дулаан хүйтний хэлбэлзлийг багасгаж ханын хэсэгт үүсэх хөлрөөг зогсоосноор чийгшлээс үүсэх хөгц мөөгөнцрийг зогсоох боломжтой болно.

Хавсралт 1



Зураг 1: Этанол



Зураг 2: Устгалын бодис



Зураг 4: Сэнсээр хатааж буй байдал



Зураг 5: Чийгтэй цэвэрлэгээ



Зураг 6: Уусмалаар арчиж буй байдал



Зураг 7: Хөгц мөөгөнцөрийг цэвэрлэсэн байдал

Хавсралт 2

7	ГТХ2013.2180	Авид, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
8	ГТХ2013.2181	Манал, Цүтгамал	1	Утаа, тортог болсон.
9	ГТХ2013.2182	Гүнгэрвааны чимэг үнжлага,	1	Утаа, тортог болсон.
10	ГТХ2013.2183	Цэлха намсум,Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
11	ГТХ2013.2184	Очирваань, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
12	ГТХ2013.2185	Жидор, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
13	ГТХ2013.2186	Дамдин, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
14	ГТХ2013.2187	Богд лам, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
15	ГТХ2013.2188	Ногоон дара эх, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
16	ГТХ2013.2189	Зуу, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
17	ГТХ2013.2190	Адиша гэгээн, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
18	ГТХ2013.2191.1-21	Хорин нэгэн дара эх, Шавар, бүтэн баримал	21	Утаа, тортог болсон.
19	ГТХ2013.2192	Богд лам, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
20	ГТХ2013.2193.1-2	Бурхан багшийн 2 шавь, Цүтгамал	2	Утаа, тортог болсон.
21	ГТХ2013.2194	Мял богд, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
22	ГТХ2013.2195	Жигжид, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
23	ГТХ2013.2196	Дэмчиг, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
24	ГТХ2013.2197	Гонгор, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
25	ГТХ2013.2198	Жовужи Атиша гэгээн, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
26	ГТХ2013.2199	Майдар, Танка	1	Утаа, тортог болсон.
27	ГТХ2013.2200	Ламын бясалгал, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
28	ГТХ2013.2201	Жигжид, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
29	ГТХ2013.2202	Сэндом, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
30	ГТХ2013.2203	Сандуй,Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
31	ГТХ2013.2204	Дувчин, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
32	ГТХ2013.2205	Цэлха Намсум, Шавар, хагас ингэмэл	1	Утаа, тортог болсон.
33	ГТХ2013.2206	Жамсран, Танка	1	Утаа, тортог болсон.
34	ГТХ2013.2207.1-2	Ансон гүндэл Жанрайсэг, Шавар, бүтэн баримал	2	Утаа, тортог болсон.
35	ГТХ2013.2208	Манзушир, Танка	1	Утаа, тортог болсон.
36	ГТХ2013.2209.1-2	Манал, Цагаан дара эх, Танка	2	Утаа, тортог болсон.
37	ГТХ2013.2210	Чоён сун ван Манзушир, Танка	1	Утаа, тортог болсон.
38	ГТХ2013.2211	Цагаан дара эх, Танка	1	Утаа, тортог болсон.
39	ГТХ2013.2212	Сэндом,Танка	1	Утаа, тортог болсон.
40	ГТХ2013.2213	Бурхан багш 2 шавьтайгаа, Танка	1	Утаа, тортог болсон.
41	ГТХ2013.2214	Манзушир, Танка	1	Утаа, тортог болсон.
42	ГТХ2013.2215	Жигжид, Танка	1	Утаа, тортог болсон.
43	ГТХ2013.2216	Дувчин, Танка	1	Утаа, тортог болсон.
44	ГТХ2013.2217	Тогтума (Бурхан багш), Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
45	ГТХ2013.2218	Жигжид, Шавар, бүтэн баримал	1	Утаа, тортог болсон.
46	ГТХ2013.2219	Аюуш, Зээгт наамал	1	Утаа, тортог болсон.
47	ГТХ2013.2220	Жигжид, Мод	1	Утаа, тортог болсон.
48	ГТХ2013.2221	Жавзан Чойжийжанцан, Танка	1	Утаа тортог болсон. /хүрээ торго хуучин их урагдалттай/
49	ГТХ2013.2222	Жанрайсэг. Танка	1	Галд бүрэн шатсан.
	Нийт	49 дэсийн 73 ширхэг бурхан шүтээнээс:		
		Галд өртөж утаа тортог болсон 48 дэсийн 72 ширхэг бурхан шүтээн,		
		Галд бүрэн шатсан 1 дэсийн 1 ширхэг танка зураг.		

Гүйцэтгэлийн зорилт №3.1.4. Соёлын өвийг сурталчлах

Эрх зүйн акт:

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйл, Соёлын өвийн боловсрол

2. Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм 2.1.1 Соёлын өвийг бүртгэн мэдээлэх чиг үүрэг

Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 3.1.4.1-р арга хэмжээ. Соёлын өвийг сурталчлах, мэдлэг олгох.

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын Олон улсын ангилал. 1972 онд НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци”-д “Соёлын өв” гэдэг ойлголтод:

- Хөшөө дурсгалууд: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдворууд, бичээс, агуй болон цогцолбор дурсгалууд,
- Уран барилгын чуулган: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж уран барилгуудын цогцолбор,
- Түүхийн дурсгалт газрууд: хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатан судлалын хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг оруулдаг.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын Монгол Улсын ангилал. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.3-д “түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг хэлнэ хэмээн томьёолсон бөгөөд мөн хуулийн 5.1-д дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

5.1.1.эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;

5.1.2.эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;

5.1.3.чулуун зэвсгийн олдворт газар;

5.1.4.хадны зураг, бичээс;

5.1.5.булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;

5.1.6.эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;

5.1.7.хөшөө дурсгал;

5.1.8.эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9.тахилгат газар;

5.1.10.түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11.бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал хэмээн заажээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах анхны эрх зүйн баримт бичиг. 1921 онд байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгийн дүрэмд “дэлхий дахины улсын бичиг судрын сан ба музей үзмэрийн зүйлийг хураах ... монгол үндэстэнд холбогдох бичигтэй хөшөө, чулуун зураг зүйлүүдийг хамгаална” гэж заасан байдаг нь төрөөс соёлын өвийн талаар баримтлах эрхзүйн бичиг баримтын эхлэл байв.

Засгийн газрын 1924 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар “Хуучны

зүйлийг сахин хамгаалах тухай дүрэм”-ийг баталсан нь орчин цагийн Монголын соёлын өв тэр дундаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалах анхны эрх зүйн баримт бичиг болжээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтад авсан тогтоол шийдвэрүүд. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 79 дүгээр хурлын тогтоолоор “Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг шинэчлэн баталж, “Монгол Улсын хязгаар дотор буй хуучны бүх дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө мөн” хэмээн заагаад тогтоолын 2 дугаар хавсралтад нэр бүхий 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалтад, 16 дурсгалыг улсын хамгаалалтад анх удаа оруулав. Үүнээс хойш улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг 5 удаа тус тус шинэчлэн баталжээ. Үүнд:

- БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1971 оны 420 дугаар тогтоолоор “БНМАУ-ын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ыг баталж, улсын хамгаалалтад 21 дурсгал, орон нутгийн хамгаалалтад 106 дурсгал,
- Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор 93 дурсгалыг улсын хамгаалалтад, 287 дурсгалыг аймгийн хамгаалалтад,
- Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор 120 дурсгалыг улсын хамгаалалтад, 233 дурсгалыг аймгийн хамгаалалтад,
- Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор 175 дурсгалыг улсын хамгаалалтад, 275 дурсгалыг аймгийн хамгаалалтад,
- Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор 185 дурсгалыг улсын хамгаалалтад тус тус баталсан байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамгаалалтын бүс тогтоосон тухай: 1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийн 16.6 дахь заалтад “Эртний хот, суурины үлдэгдэл, байшин барилга, цогцолбор зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн сүр барааг хадгалах зорилгоор эргэн тойронд нь 0.1-3 км-ийн хамгаалалтын бүсийг Засгийн газар тогтоож болно” гэж заажээ. Энэхүү заалтын дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол, улсын хамгаалалтын зэрэглэл зэргийг харгалзан үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоож эхэлжээ.

Хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд: Засгийн газрын 1997 оны 241 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Монголын эртний нийслэл Хархорум хотын тууриин хамгаалалтын бүсийг 9.69 км.кв талбайтай байхаар тогтоосон нь анхны хамгаалалтын бүс тогтоосон дурсгал болсон юм. 2001 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болгон шинэчлэн

№	Тогтоолын он сар	Тогтоолын дугаар	Тоо	Дурсгалын нэр	Хэмжээ
1	1997 оны 12 дугаар сарын 15-ны өдөр	241	1	Монголын эртний нийслэл Хархорум хотын тууриь	9,69 ам дөрвөлжин км
2	2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр	96	1	Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүм	58,0 га,
			2	Богд хааны Ногоон ордон	5,7 га,
			3	Чойжин ламын сүм	2,0 га
			4	Дамбадаржаа хийд	10,5 га
			5	Гэр хэлбэрт модон дугануудбуюу Дашчойлин хийд	1,7 га
			6	Чин ван Ханддоржийн байшин	0,5 га
3	2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр	71	1	Билгэ хаан хөшөө	20.8 кв.км
			2	Культегиний хөшөө	
			3	Хар балгасын тууриь	39.8 кв.км
			4	Төвхөн хийд	4.5 кв.км
			5	Тоньюкукийн дурсгал	65.58 кв.км
4	2003 оны 8 дугаар сарын 27-ны өдөр	190	1	Уушгийн өврийн буган чулууны цогцолбор	42,0 га,
			2	Аваргын балгас	1230 га
			3	Манзуширын хийдийн тууриь	15,6 га
			4	Дарь-Эхийн сүмийн 2 чулуун багана	0,07 га

5	2004 оны 5 дугаар сарын 26-ны өдөр	126	1	Хархорин сумын нутаг дэвсгэрт оршдог Барүүн хүрээ хийд, түүрь	220 га
			2	Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт оршдог Хөгнө тарнийн дээд, доод хийдийн түүрь	42.9 га
6	2004 оны 12 дугаар сарын 1-ний өдөр	230	1	Алтан-Өлгий дэх оршуулгын газар	
7	2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр	70	1	Цогт тайжийн цагаан байшингийн балгас, Бичигт хөшөө болон Хар Бухын балгасын хамгаалалтын бүсийг	920 га, 1080 га
8	2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр	123	1	Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт	121967 га
9	2011 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр	271	1	Баяннуур сумын Майхан уулын энгэрт орших эртний нүүдэлчний язгууртны бүнхант булш	700 га
10	2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр	135	1	Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт орших Эргэлийн зоон палеонтологийн дурсгалт газар	
			2	Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт орших Өнгөтийн цогцолбор дурсгал	
			3	Дэлгэрхаан сумын нутаг дэвсгэрт орших Их Хөшөөтийн цогцолбор дурсгал	
			4	Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дэвсгэрт орших Өглөгчийн хэрэм	
			5	Хэнтий аймгийн Рашаан хад, Үзүүр цохионы цогцолбор дурсгал.	
			6	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг дэвсгэрт орших Балдан	
				Бэрээвэн хийд, түүний орчмын хадны зургийн дурсгал	
			7	Хэнтий аймгийн Дунд Жаргалантын цогцолбор дурсгал	
			8	Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт орших Цэцэн ханы ордны цогцолбор	
			9	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт орших “Өндөр хоршоо” хэмээх түүхт барилга (Дүрслэх урлагийн музей)	
			10	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших Ардын Намын Төв Хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан түүхт барилгын (Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей)	
11	2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр	104	1	Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигтийн ам, Батсүмбэр сумын нутаг Ноён уулын Зурамт, Хужиртын ам,	133.6 га
			2	Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Балгасын талд орших Хүннүгийн язгууртны дурсгалт цогцолбор газар	
12	2013 оны 12 дүгээр сарын 14-ний өдөр	414	1	Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг дахь Шар цавын үлэг гүрвэлийн мөр бүхий дурсгалт газар	408 га
			2	Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дахь Сүйхэнтийн чулуужсан мод бүхий дурсгалт газар	892 га

баталсан бөгөөд уг хуулийн 17.6, 17.7, 17.8 заалтад түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүс тогтоож байх тухай асуудал хэвээр тусгагдаж, талбайн хэмжээг тогтоосон заалтыг хассан байна. Засгийн газар “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн холбогдох заалтыг үндэслэн 1997-2013 онд Монгол Улсын Засгийн газрын 12 удаагийн тогтоолоор 36 дурсгалт газрын хамгаалалтын бүсийг тогтоожээ (хүснэгт 1).

1.ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР

Чулуун зэвсгийн дурсгалт газарт

Түүхэн тодорхой үед хүмүүс аж төрж байсныг гэрчлэх чулуун зэвсэг, түүнийг хийхэд үлдсэн чулууны үлдэгдэл, хоол хүнсний үлдэгдэл болон бусад хүмүүсийн хэрэглэж байсан эд зүйлсийн ул мөр бүхий олдвортой дурсгалт газрыг хамруулдаг. Эдүгээ манай улсын нутгаас чулуун зэвсгийн бууц суурины үлдэгдэл илэрч тэмдэглэгдсэний хамгийн эртнийх нь Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Ярх уул, Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших Цахиуртын хөндий зэрэг дурсгалт газар хамаардаг. Хамгийн эртний хүний ясны олдвор нь Хэнтий аймгийн Норовлин сумын Салхит гэдэг дурсгалаас илэрсэн эртний хүний гавлын ясны үлдэгдэл бөгөөд энэ олдворын он цагийг 30-40 мянган жилийн өмнөх үед холбогдохыг судлаачид тогтоосон байна. Мөн өнөөгийн монгол нутгаас илэрч олдсон нийт 1259 чулуун зэвсгийн дурсгалт газар бүртгэгдсэн ба тархацаар нь авч үзэхэд БӨ, БХ, ДГ, ГС, СҮ, БУ, ӨМ, ХЭ, ГА, ТӨ, УБ зэрэг бүс нутгуудаар өргөн тархсан ба ДО, ХӨ, ӨВ, ХО, ДУ, СЭ, УВ, АР, ЗА аймгуудын нутгаар харьцангуй бага тархалттай болно.

Доод палеолит нь (3,3 саяас 100 мянган жилийн өмнө)-ын үед тодорхой хэлбэр дүрстэй багаж зэвсэг хийж сурсанаас гадна хайрган зэвсэг, гилбэр мэс голчлон үйлддэг байв. Хайрган зэвсгийн гол төлөөлөгч бол чоппер, чоппинг бөгөөд зөвхөн ир хэсгийг хагалж бэлтгэдэг байжээ. Энэ үеийн дурсгалт газруудад Нарийн гол, Уран хайрхан - (Баянхонгор аймгийн Өлзийт сум), Оцон мааньт – (Өмнөговь аймгийн Баян-Овоо сум), Цахиурт (Дорноговь аймгийн Даланжаргалан сум) зэрэг орно.

Дунд палеолит нь (100-40 мянган жилийн өмнө) цуулалтын Леваллуагийн арга боловсорч гүйцсэн үе хэмээн судлаачид үздэг. Байгаль дээр орших цул чулууны гадрыг цохилтын аргаар цуулж авч улмаар чулууны төв рүү чиглүүлэн тал талаас нь холтчин цохих аргаар цуулалтын гадаргууг бэлтгэдэг байжээ. Үүний үндсэнд хурц үзүүртэй гурвалжин хэлбэрийн урт цуулдас гардаг бөгөөд ийм цуулдсыг дахин ашиглаж жадны үзүүр болгон хэрэглэдэг болов. Энэ үеийн дурсгалт газруудын жишээ: Орхон - 1;7 – (Өвөрхангай аймгийн Хархорин сум), Арц Богд – (Өвөрхангай аймгийн Богд сум), Орог нуур, 1,2 (Баянхонгор аймгийн Богд сум) зэрэг болно.

Дээд палеолит нь (40-12 мянган жилийн өмнө) чулууг цуулан авч ир гарган холтчин ирлэх болсон үе юм. Цоолтуур, үзүүр мэс, бичил хусуур, жижиг сүх зэрэг зэвсэг шинээр буй болж, огтлох цоолох зэрэг үйлд зориулсан хөнгөн багаж зэвсэг мод болон ясан бариултай болжээ. Үүний зэрэгцээ арслан зааны дал, соёо, бугын эврээр жад, шөвөг хийж, чулуу, амьтны яс болон тэмээн хяруулын өндөгний хальс ашиглан гоёл чимэглэлийн зүйлс урлах болжээ. Энэ үеийн онцлогтой газруудад Мойлтын ам - (Өвөрхангай аймаг, Хархорин сум), Ханзат - (Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум), Төлбөрийн голын төлбөр 1-29 - (Булган аймгийн Хутаг-Өндөр сум) зэрэг орно.

Энэ үе бол асар удаан жил үргэлжилсэн хүн төрлөхтний түүхэн хувьслын үе бөгөөд дэлхий дээр орших ан амьтан, ургамлын аймагт хүртэл өөрчлөлт орж, доод палеолитын үеэс эхлэн галыг ашиглах болжээ. (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл:

Цэрэндагва Я. Палеолитын үндэс. УБ., 2017. 10-16-р тал

Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Очирхуяг Ц. Монголын археологи. УБ., 2002. 37-15-р тал “Хааны Эзэнт гүрэн, монгол”. тусгай үзэсгэлэнгийн каталоги. УБ., 2018. 27-р тал

Цогтбаатар Б. Монголын чулуун зэвсэг. Монголын археологийн өв. Боть I. УБ., 2016.

Лхагвасүрэн Х., Балжинням Б., Энхтайван Ц. Дэлхий дахинаах монголчуудын түүх, соёлын өв. Тэргүүн боть. УБ., 2018. 138, 147-р тал

Энхбат Г., Батсуурь Ж. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгаа. УБ., 2020

Мезолит (12000-8000 жилийн өмнө)

Палеолитын үеэс неолитод шилжих шилжилтийн үеийг мезолит буюу дунд чулуун зэвсгийн үе хэмээн нэрлэдэг. Энэ үеийн түүхэнд бичигдсэн дэвшилтэт онцлог нь эртний хүмүүс газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэлийг анх тавьсан ба багаж зэвсгийн үйлдвэрлэлийн түүхэнд мөн дэвшил гарсан нь нум сумыг сэдэж зохиосон үе юм. Үүнийг даган төрөл бүрийн чулуун ялтсаар хийсэн сумны зэвнүүд нумтай харилцан хөгжих болжээ. Манай улсын нутаг дэвсгэрээс олдсон мезолитын үеийн гол төлөөлөл: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг Чихэн агуй, Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Хэрээ уул, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад зэрэг болно (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Очирхуяг Ц. Монголын археологи. УБ., 2002. 68-69-р тал

Цогтбаатар Б. Монголын чулуун зэвсэг. Монголын археологийн өв. Боть I. УБ., 2016. 200-201-р тал

Неолит (8000-5000 жилийн өмнө)

Төмөрлөг зэвсэгт шилжих хүртэлх үеийг судлаачид неолитын үе буюу шинэ чулуун зэвсгийн үе хэмээн нэрлэдэг. Энэ үеийн гол дэвшил нь байгалийн тухайлсан чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, засах, ховил гаргах, нэвт нүхлэх аргуудыг сэдэж олсонд оршино. Мөн анх гар аргаар ахуйн зориулалттай сав суулга, багаж зэвсэг, чулуун гоёл зүүсгэл хийж эхэлсэн байна. Манай улсын нутаг дэвсгэрээс илэрсэн неолитын үеийн гол төлөөлөл болох дурсгал: Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн суурин, Булган сумын Норовлин уулын оршуулгаас гарсан чулуун онго, 3000 орчим сувсан зүүлт, гахай, тарвага, хүдрийн соёогоор хийсэн зүүлт, гахай, зарааны дүрстэй танан чимэг зэрэг баялаг олдворууд гарсан нь энэ үеийг бүрэн илэрхийлэх дурсгалууд болж түүхэнд тэмдэглэгдсэн байна. (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Дорж Д. Неолит восточной Монголии. УБ. 1971. 28-32-р тал, 39-54-р тал.

Цогтбаатар Б. Монголын чулуун зэвсэг. Монголын археологийн өв. Боть I. УБ., 2016. 222-223-р тал

Агуй, оромж, түр сууц

Эртний хүмүүс байгаль цаг уурын тааламжгүй нөлөө болон араатан амьтдын дайралтаас биеэ хамгаалах зорилгоор хадны агуй, нөмөр нөөлөг бүхий байгалийн тогтоц бүхий газарт орж хорогддог байжээ. Энэ нь эртний хүмүүсийн оюун ухаан хөгжихийн хэрээр амьдралын нэг салшгүй хэсэг болж улмаар орон сууц үүсэх үндэс болсон ажээ. Эртний хүмүүсийн болон хожуу үеийн хүний оршин сууж байсан хадны агуй хонгил, нүхэн сууц зэргийн оршин байх газар нутаг нь байгалийн тогтцыг дагахаас гадна тухайн бүс нутгийн ан амьтан, үр жимсний бүрэлдэхүүн, усны хангамж, аюулгүй орчин зэрэг хүний хэрэгцээний бүх зүйлсийг харгалзан үзэж сонгосон байдаг. Хожуу үед хүмүүсийн оршин сууж байсан хадны агуй хонгилтой холбоотой олон арван үлгэр, домог, хууч яриа, хөдөө орон нутгаар элбэг байдаг бөгөөд энэ нь шашин мөргөлийн зан үйл, эрдэм чадалтай бөө, лам нарын намтар цадигтай холбоотой байх нь элбэг байдаг (Б.Даваацэрэн).

Ашигласан ном бүтээл

Г.Энхбат., Г.Анхсанаа., Ред: Б.Цогтбаатар. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах. УБ., 2017

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал // Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

2.ХАДНААХ ЗУРАГ, БИЧГИЙН ДУРСГАЛ

Хаднаах зураг

Байгалийн тогтцоороо байгаа хад чулууны толигор гадаргуу дээр хүн, мал, амьтан болон бусад зүйлсийн зургийг тусгай багаж зэвсэг ашиглан сийлж зурсан хаднаах зургуудыг сийлмэл зургийн төрөлд хамруулдаг бол эрт үедээ тусгай найрлага бүхий зос, бэх, шороон будаг ашиглан зурсан зургуудыг “Зосон зургийн дурсгал” хэмээн нэрлэж, үндсэн 2 хэсэгт ангилдаг байна. Эдгээр аргуудаар бүтээгдсэн дурсгалуудаас хамгийн түгээмэл нь тухайн дүрсэлж буй зүйл (хүн, мал, ан амьтан, эсвэл бичээсийн хувьд тухайн үсэг)-ээ нийт талбайгаар нь хонхойлон цохих, сийлэх аргаар бүтээгдсэн байдаг. Харин зос болон хар, улаан өнгийн бэхээр бүтээгдсэн дурсгал нийт дурсгалтай харьцуулахад харьцангуй цөөн хувийг эзэлдэг. Эдүгээ Монгол Улсын нутгаас зосон зургийн 195 дурсгал, сийлмэл зургийн 500 гаруй дурсгалт газар илэрсэн. Хадаах зураг дээд палеолитын үеэс дэлхий дахинаа байгалийн хад чулуунаа зурагдан үлдсэн бөгөөд 80 орчим хувь нь Төв Азийн өндөрлөг өнөөгийн монгол нутагт хоцрон үлджээ. Үүнээс хамгийн алдартай нь Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн агуйн зосон зургийн дурсгал болох тэмээн хяруул, арслан заан, одос үхэр зэрэг нь монгол нутагт эрт цагт байгаад сөнөж үгүй болсон амьтад тул уг зургууд нь дээд палеолитын үед холбогдохыг нь давхар нотолж байна. Мөн Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хадны сийлмэл зурагт савагт хирсийг бодитоор сийлж үлдээсэн нь ховор бөгөөд ийм төрлийн хаднаах зураг дахин олдоогүй байна. Өнөөгийн монгол нутгаас илэрч олдсон нийт хаднаах зургийн нягтралын гол төвлөрлүүд нь БӨ, ХО, БУ, ӨМ аймгуудын нутгаар өргөн тархалттай болно (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал // Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. УБ., 2008. 79-р тал.

Хааны Эзэнт гүрэн монгол. УБ., 2018. 52-р тал

Н.Батболд. Монголын хадны зураг. Монголын археологийн өв. Боть IV. УБ., 2016. 18, 68-р тал

Энхбат Г., Батсуурь Ж. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгаа. УБ., 2020

Лхагвасүрэн Х., Балжинням Б., Энхтайван Ц. Дэлхий дахинаах монголчуудын түүх, соёлын өв. Тэргүүн боть. УБ., 2018. 71-р тал

Тамга, тэмдэг

Монголчууд тамга, тэмдэг, бичиг үсэг хэрэглэж хад чулууны толигор гадаргуунд түүхэн үйл, хэрэг явдлын тухай бичиж сийлсэн байдаг. Тамга, тэмдэг үүссэн нь хүн төрөлхтний бүдүүлэг үеэс овгийн байгууллын харилцаанд шилжих түүхэн үйл явцаас улбаатай. Овгууд шинээр салбарлах тутам овгийн хуучин үндсэн тамганы дүрсэнд нэмэлт зүүлт хийж үүсгэмэл тамга нэмэгдэхийн хамт шинэ үндсэн тамга ч гаргаж, овгийн нийт тамга олширч, олон овгийн “их хуралдай”, цуглаанд ирэгчид байгалийн өвөрмөц онцлог, сүрлэг хад цохионд овгийн тамгаа сийлж үлдээх, нийт олноор хэрэглэх ус бэлчээрийг эзэмших эдлэх эрхээ бататган хад чулуунд нэгэн дор овгийн тамгаа сийлэн үлдээдэг байжээ. Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр уулын Рашаан хадны хавтан чулууг академич Х.Пэрлээгийн судалсан ба тамга, тэмдгийг тоолж зүүн талын тэгш гадаргуу дээр 180 гаруй, ар талдаа 40-өөд, сэрвээн дээрээ 50-иад нийтдээ 270-аад тамга, тэмдэг дүрс байсныг олж тогтоосон байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал // Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

Даваацэрэн Б., Цогтбаатар Б., Анхсанаа Г. Тахилгат Биндэр уул орчмын түүх,

соёлын үл хөдлөх дурсгал. УБ., 2019. 48-р тал

Н.Батболд. Монголын хадны зураг. Монголын археологийн өв. Боть IV. УБ., 224-р тал

Түрэг бичиг

Түрэгийн соёлын хамгийн гайхамшигт ололт бол “Орхон-Енисейн бичиг” хэмээн алдаршсан 38 үсэг бүхий авианы бичгийг зохион хэрэглэж, төр улсынхаа түүхийг тэмдэглэн бичиж үлдээсэн явдал билээ. Түрэгүүд хэдийгээр Нангиад мэт эртний өндөр хөгжилт улс оронтой хөрш зэргэлдээ нутаглаж соёлын ололт амжилтаас нь багагүй зүйл авч хэрэглэсэн боловч хятадын дүрс үсгийг авсангүй, харин нүүдэлчдийн ахуй орчин, хэл соёлын өвөрмөц онцлогт яв цав нийцэж оюуны хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангахуйц өөрийн бичиг үсгийг зохион хэрэглэж байжээ. Түрэг улс мандан хөгжиж, мөхөж буурч байсан, төр улсаа дахин сэргээсэн, бусад ард түмэнтэй дайтаж, найрамдаж явсан тухай болон эх нутаг, нүүдэлчдийн мөнхийн шүтлэг бөө мөргөлийн тухай зэрэг олон сэдвээр түүхчлэн бичсэн байдаг. Түрэгийн руни бичгийн дурсгал нь тусгайлан зассан пайлуур гэрэлт хөшөөнөөс гадна байгалийн хаднаа сийлж үлдээдэг байсан ба өдгөө 100 гаруй дурсгал бүртгэгдсэн байна. Үүнээс гадна барилгын хананы шаваас, дээврийн ваар, зоосон мөнгө, судар номын баринтагийн тээг чулуун дээр бичсэн зэргээр олдож байна. Энэ үеийг төлөөлөх археологийн хамгийн алдартай дурсгалд Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө Цайдамд орших Түрэгийн үеийн Культегин, Билгэ хааны бичигт хөшөө, Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Тоньюкукын бичигт хөшөө бүхий цогцолбор дурсгалууд хамаарна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 177 тал

Г.Энхбат, Г.Анхсанаа, Ред: Цогтбаатар Б. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах. УБ., 2017. 18-р тал

Баттулга Ц. Алтай нутаг дахь руни бичгийн судалгааны товч тойм // Acta mongolica, Tom. II, (208),

Уйгурын бичиг

Уйгур улсын үед мааний шашны судар ном унших, эх (уйгур) хэлнээ орчуулан буулгах зайлшгүй шаардлага гарч руни бичиг нь үйс, цаас тэргүүтэн дээр бичих, ном судар орчуулан буулгахад тэр бүр бичгийн шаардлагыг төгс хангаж чадаагүйд шинэ үсэг зохиох, тэрхүү хэрэгцээг ном бичигт мэргэшсэн согдуудын туслалцааг авч согд үсэгт суурилсан уйгур цагаан толгой, уйгур бичгийг зохиожээ хэмээн эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Монгол нутагт уйгуруудын үлдээсэн бичгийн дурсгалыг руни, согд, уйгур үсгийн хэмээн гурав ангилж болох бөгөөд дотор нь гэрэлт хөшөөний, хад чулууны гэж хуваана. Гэрэлт хөшөөнд Моюнчур, Тариатын буюу Тэрхийн гэрэлт хөшөө, Тэс, Хар балгасын бичээс, харин хад чулуунд бичигдэн үлдсэн дурсгалд Ар Ханан, Хангидай хад, Гурвалжин уул, Гурванмандал, Бага Ойгор, Хөл Асгат, Сэврэй, Их бичигт, Долоодойн хөшөөний бичээсүүд багтдаг. Моюнчур, Хар балгас, Тариат, Тэсийн гэрэлт хөшөөдийн бичээст Уйгурын хаант улсын эхэн үеийн хэрэг явдлыг тэмдэглэсэн нь түүхэн сурвалж болохоос гадна үсэг бичиг, соёл, хэл аялгууны чухал баримт болж байна.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 179-180 тал

Хятан бичиг

Хятан нарыг VIII зуунаас дүрс бичигтэй болж хэрэг явдал тэмдэглэх болсон гэж сурвалжид өгүүлсэн байдаг. Тэд түүхэндээ Их, бага хэмээх хоёр зүйлийн бичиг зохион хэрэглэж байжээ. Хятан бичгийн дурсгалыг 1927 оноос олон тоогоор илрүүлэн судалж

ирсэн боловч хараахан бүрэн тайлагдаагүй байна. Энэ үеийн бичээс чулуун хөшөө, хүрэл толь, зоос, шавар тоосго, элдэв пайз, шаазан сав суулгын ёроол, хадан дээр үлдээсэн нь тохиолддог байна. Манай оронд хятан нарт холбогдох бичиг үсгийн дурсгал хад чулуунаа сийлж үлдээсэн байдлаар хэдэн газраас олдоод байгаа нь: Архангай аймгийн Их Тамир сумын Тайхар чулуу, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Бүлээний Овоо, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Мөрөн сумын Салбарын уулын Ханан хад зэрэг болно. Түүнээс гадна Булган аймгийн Дашинчилэн сумын Чин толгойн балгаснаас хятан бичигтэй дээврийн ваар олдсоныг ууган археологч Х.Пэрлээ тусгайлан хэвлүүлж байжээ. Мөн Хятаны их бичээсийг Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Еншөөв багийн нутаг Бүлээний Овоо хэмээх говь нутгийн намхан толгой дээр, овооноос зүүн урагш 20-иод м зайд нанхиад үсэг мэт сийлмэл бичээстэй хөшөө байхыг 1950-иад оны үед судлаачид үзэж гэрэл зургийг нь авч байсан гэх ба эрдэмтэн О.Намнандорж 1960-аас 1980-аад оны дунд үе хүртэл хээрийн шинжилгээний ажлаар явахдаа олж тодорхойлолт хийж бүртгэсэн гэдэг. Харин 2009 оны намар Соёлын Өвийн Төвийн мэргэжилтнүүд Бүлээний Овооны гэрэлт хөшөөг бүртгэн баримтжуулж 2010 онд гэрэл зураг, товч тайлбарыг нийтлүүлсэн байна. 2010 оны намар Монгол-японы хамтарсан “Бичээс” төслийнхөн Бүлээний овооны гэрэлт хөшөөг үзэж гэрэл зураг, цаасан хэв аван баримтжуулахын хамт хөшөөний бичээсийг хятан их үсгээр бичсэн болохыг тогтоосон байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Жанчив Ё. Уйгуржин монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд //Corpus scriptorum, Tomus II, УБ., 2005

Даваацэрэн Б. Бүлээний овооны гэрэлт хөшөөг авран хамгаалсан тухай // Соёлын өвийн мэдээ, мэдээлэл. №5. УБ., 2011, т. 32-34.

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007.

Монгол бичиг

Дундад эртний монголчууд нэгдсэн төр улсаа байгуулахдаа уйгуржин монгол бичгийг төрийн бичиг болгон хэрэглэж байсан бөгөөд улмаар Монголын Эзэнт гүрний үед дөрвөлжин бичгийг зохиож улс гүрэн даяар албан хэрэгт хэрэглэх тухай Хубилай хааны зарлиг бичигт тэмдэглэгдсэн байдаг. Монгол нутагт хадгалагдаж үлдсэн эртний судлалын дурсгалууд дотор Чингисийн чулууны бичээс, Хархорумын I, II монгол бичээс, Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээс, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бичигтийн голын Хадан хошууны бичээс, дундад зууны хожуу үед холбогдох Хэсэг байшингийн бичээс, Цогт тайжийн Дуутын хар чулууны бичээс зэргийг дурдаж болох юм. Үүнээс хамгийн алдартай нь Чингисийн чулууны бичээс бөгөөд уг бичээсний утга нь “Буха Сочихай” хэмээх газар 1224 оны өвөл Чингис хаан Хорезмыг байлдан эзэлсэн дайны дүнг батлан Их хурилдай хуралдаж, их найр наадам хийхэд Хавт Хасарын хүү Есүнгэ ноён 335 алд газар байрлуулсан байг гойд мэргэн онож шалгарсан тухай түүхэн явдлыг тусган бичиж үлдээснээрээ онцлогтой байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 182-186 тал

Тод бичиг

Зая Бандид Намхайжамц 1648 онд монгол бичгийг засварлан тодорхой болгосон тод бичгээ зохиожээ. Тод бичиг хэмээн нэрлэсний учир нь монгол бичгийг тодорхой нарийн болгосныг өгүүлж буй юм. Монгол бичиг монгол хэлний нутаг нутгийн олон аялгуунд сэлгэн хэлэгддэг авиаг нэг дүрсээр тэмдэглэсэн байдаг. Харин тод үсгийг Зая Бандид анх зохиохдоо нийт монгол хэлтэнд зориулсан боловч бүх монголчуудад дэлгэрч чадалгүй зөвхөн ойрадын бичиг болон хувирсан нь өмнө өгүүлсэнчлэн олон аялгуу

дундын шинжтэй монгол бичгийг тодорхой нэг аялгуунд ойртуулснаас шалтгаалжээ. Мөн тод бичиг нь монгол бичиг шиг хурдан бичихэд төвөгтэй, нарийн зурлага олонтой байсан нь бас нөлөөлжээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт тод үсгээр хад чулуунд тэмдэглэн үлдээсэн дурсгал цөөн боловч тэдгээрийн заримыг дурдвал, Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Тайхар чулуу, Ховд аймгийн Шар сүмийн гэрэлт хөшөө, Баян-Өлгий аймгийн Алтай сумын Ёл хадны бичээс зэрэг хамаарч байна.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 191-192 тал

Дөрвөлжин бичиг

Монголын Эзэнт гүрний үед Пагва лам Лодойжалцан Хубилай хааны зарлигаар Монгол дөрвөлжин үсгийг зохиож дуусмагц 1269 онд улс гүрэн даяар албан хэрэгт хэрэглэх тухай Хубилай хааны зарлиг гарчээ. Уг зарлиг нь “Би санаваас үсгээр үгийг бичмүй. Үгээр хэргийг тэмдэглэмүй. Энэ нь эрт ба өдгөөгийн нэвтэрхий хууль болой. Манай улс умард газар тулгар байгуулсан тул суртал нь хэмжээтэй, эртнийг эрхлэх тул дүрэм тогтоол үүсгэж завдсангүй. Аливаа хэрэглэх үсэг бичиг нь хятадын хичээнгүйлэх ба жич холхи олон улсын дүрмийг хянаваас тус тусдаа үсэг буй амуй. Өдгөө бичгийн засаг улмаар хөгжих үсэг бичгийг тогтоох нь дутуу, бүрдээгүй тул ийнхүү тусгайлан Улсын багш Пагвад тушааж...” монголын шинэ үсгийг үүсгэн зохиолгожээ. Одоо олдоод байгаа дөрвөлжин бичгийн дурсгалын зүйлс дотор тамга тэмдэг, зоос, пайз, гэрэлт хөшөө, хад чулуу, мод, цаас, даавуу тэргүүтэнд монголоос гадна хятад, төвд, санскрит, түрэг хэлээр бичсэн дурсгалууд байдаг. Монгол нутгаас олж илрүүлээд буй дөрвөлжин бичгийн дурсгалуудад: Хүйтэний голын бичээс, Ховд аймгийн Ямаат Улаан уулнаас олдсон судар, Хархорумаас олдсон Аюуширидара хааны Сангийн яамны эрхэлсэн түшмэлийн тамганы бичиг, Тайхар чулууны бичээс, Хэнтий аймгийн Рашаан хадны бичээсүүд болно.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 186-188 тал

Жанчив Ё. Дөрвөлжин үсгийн монгол дурсгал. УБ., 2002 .

Жанчив Ё. Уйгуржин монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд, //Corpus scriptorum, Tomus II, Улаанбаатар. УБ., 2002 .

Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ., 2001.

Манж бичиг

Монгол улсын нутаг дахь манж бичээснүүдийг бичсэн зориулалтаар нь авч үзвэл Чин улсын төрөөс сүм хийдэд зориулан байгуулсан гэрэлт хөшөөний соёрхол бичээс, цэрэг дайн, албаны хэргээр аялан явсан хүмүүсийн тэмдэглэл бичээс гэж ангилан үзэж болно. Сүм хийдэд зориулан байгуулсан гэрэлт хөшөөний соёрхол бичээст Амарбаясгалант (1736-1937), Дамбадаржаалин (1765), Шар сүмийн гэрэлт хөшөөний бичээс (1767) зэрэг нь багтах бөгөөд эдгээр гэрэлт хөшөөний бичээснүүдэд манжийн цэргийн байгуулсан ялалт, гавьяа, тухайн сүм хийдийг хэний зарлигаар хэдийд үйлдсэн, сүм барих газрыг хэрхэн сонгосон, хэдий хугацаанд хэчнээн хөрөнгө мөнгө зарцуулсан зэргийг тодорхой өгүүлсэн байдаг билээ. Цэрэг дайн, албаны хэргээр аялан явсан хүмүүсийн тэмдэглэл бичээст Тайхар чулууны I, II манж бичээс, Хотын булан, Бичигт чулууны манж бичээс зэргийг хамруулдаг байна.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть

32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 195 тал

Согд бичиг

Монгол нутагт согд үсгийн дурсгал харьцангуй цөөн бөгөөд харьцангуй бага судлагдсан бичиг юм. Өнөөгийн монгол нутгаас олдсон согд бичгийн дурсгалд Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Баянцагааны голын баруун хөвөөнөөс 1956 онд археологич Ц.Доржсүрэн хүүхэд хөхүүлж буй чонын дүрстэй сүрлэг хөшөө, Архангай аймгийн Хотонт сумын нутагт, Хархориноос баруун хойш 45 км-т орших Хар балгаснаас руни, согд, нангиад гурван зүйл үсгээр бичсэн гайхамшигт хөшөө, Өмнөговь аймгийн Сэврэйн бичээс зэрэг дурсгалуудыг дурдаж болно.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 178-179 тал

Араб, перс бичиг

Монголын дундад зууны түүхэнд холбогдох араб, перс бичгийн цөөн дурсгалууд олдсоныг дурдвал: Хэнтий аймгийн Батширээт сумын нутгаас академич Х.Пэрлээ Рашаан хадны их барсгар толионд хар бэхээр татлан бичсэн 5 мөр араб бичээс илрүүлэн олж нийтлүүлжээ. Мөн Монголын эртний нийслэл Хархорумаас араб бичээс бүхий нэгэн зоос олджээ. Үүнийг Монгол-Германы Хархорум Экспедицийн малтлагын үеэр хотын төв хэсгээс илрүүлсэн байна. Араб үсгээр “Хархорум” хэмээн бичсэн, уг зоосыг 1237-1238 он буюу Өгэдэй хааны үед цутгажээ хэмээн орчуулагдсан ба монголын эзэнт гүрний түүхийн нууцлаг баримт болж буйгаараа монголын түүх судлалд маш чухал ач холбогдолтой олдвор болон тэмдэглэгдсэн байна. Перс бичээсийн тухайд монголын эртний нийслэл Хархорумд байсан, одоо Эрдэнэзуугийн хэрмийн дотор буй перс бичээс бүхий гэрэлт хөшөөний бичгийг тайлж уншихад Аллахыг магтан дуулж, Хархорум хотод лалын сүм барьж байгуулахад туслалцаа үзүүлсэн хүмүүсийн нэрийг дурдаж, хижрагийн 742 он буюу нийтийн он тооллын 1341 онд босгосныг тэмдэглэсэн тухай онц сонирхолтой баримтыг түрэг судлаач Б.Аззаяа монгол улсын нутгаас олдсон араб, перс бичээсний талаарх тойм бичиж “Чингисийн цадиг” сурвалжийн судалгаа хэмээх номдоо оруулан анх удаа бичсэн нь монгол нутгаас олдсон араб, перс бичгийн төлөөлөл болж тэмдэглэгдсэнээрээ онцлогтой.

Ашигласан ном бүтээл

Аззаяа Б. “Däftär-i Čingiz-nāmä” сурвалжийн судалгаа. //Corpus scriptorum, Tomus V. – УБ., 2006.

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 188-189 тал

Төвд бичиг

Монголын нийт нутгаас түвэд хэл бичгээрх дурсгал их хэмжээгээр олддог. Ерөнхийд нь судар ном буюу цаас тэргүүтний, хад чулуу болон гэрэлт хөшөөний гэж ангилан үзэж болох юм. Хад чулуунаа сийлэн үлдээсэн төвд үсэг бичгийн дурсгалууд асар олон бөгөөд тэдгээрийн тоог гаргахад олон жилийн уйгагүй их хөдөлмөр шаардагдах нь мэдээж. Тиймээс хад чулуун болон гэрэлт хөшөөний дурсгалуудаас цөөн хэдийг төлөөлүүлэн дурдвал: Цогтын цагаан байшин, Амарбаясгалант, Дамбадаржаалин хийд, Шар сүмийн гэрэлт хөшөөний бичээс, Бичигт шургуулга, Тайхар чулуу, Их Бага бичигтийн бичээс зэргийг багтаж байна.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 191 тал

Хятад бичиг

Хятад үсгээр тэмдэглэн бичсэн хуучин бичээс манай нутгаас нилээд олдсоныг гэрэлт хөшөө, хад чулуу, тамга тэмдэгийн гэж ангилна. Тухайлбал, Култегин, Билгэ хааны гэрэлт хөшөөний нангиад бичээс, Хар балгасны бичээс, Хархорумын гэрэлт хөшөө,

Мөнх хааны гэрэлт хөшөө, Хотонтын хөшөөний бичээс, Хархорумаас шинээр олдсон бичээсүүд, Тооно уулын бичээс, Хөгшин тээлийн хөшөөний бичээс, Амарбаясгалант, Дамбадаржаалин хийдийн, Шар сүмийн гэрэлт хөшөөний бичээс зэргийг дурдаж болно. Хад чулуунаа сийлэн үлдээсэн дурсгал гэвэл, Тайхар чулуу, Зүүн билүү, Сөдөтийн цагаан чулуу, Замын нуурын хадны бичээс, Бичигт шургуулга, Бичигт хошууны бичээс, Амар хиагийн бичээс, Хавцлын Адаг, Залаатын ам, Сэрвэн хаалганы бичээс, харин тамга тэмдгийн зүйлд Хархорум хотыг судлан шинжлэх явцад олдсон тамганы бичээсүүд хамаардаг.

Ашигласан ном бүтээл

Баярхүү Н. Эртний бичээс судлалын тойм. Монголын Археологийн Шинжлэх Ухаан. Боть 32. Монгол Улсын Шинжлэх Ухаан 108 боть. УБ., 2007. 189 тал

3. БУЛШ ОРШУУЛГЫН ДУРСГАЛ

Неолитын булш (12,000-4,000 жилийн өмнө)

Шинэ чулуун зэвсгийн үед холбогдох неолитын булш өнөөгийн монгол нутагт цөөн тоогоор судлагдсан. Энэ үеийн оршуулгын зан үйлийн онцлог нь хүнээ оршуулахын өмнө ухсан нүхэнд болон оршуулсны дараа түүний дээр их хэмжээний улаан зосон будаг цацаж оршуулдаг байна. Энэ үеийг төлөөлөх археологийн дурсгал Дорнод монголд байдгийн дотор Хэрлэн голын зүүн эрэгт орших Овоотын суурин, Булган сумын нутагт Норовлин уулын булшнаас илэрсэн 3000 орчим сувс, хоёр талдаа зуулга чулуун иртэй ясан хутга, хүний нүүрний дүрст чулуун онго зэрэг баялаг эд өлгийн зүйлс орно. Мөн 2015 онд Улаанбаатарын Их сургуулийн судалгааны багийн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутагт илрүүлэн малтан судалсан неолитын булш нь монголын түүхэнд 40 гаруй жил илрэн олдоогүй онцлог хэрэглэгдэхүүн ба зуулга ир бүхий хутганууд, нэхмэлийн зүү, сувсан зүүлт олон тоогоор олдсон бөгөөд оршуулгын нүхэнд улаан зос цацсан зэргээрээ неолитын булш болсон.

Ашигласан ном зохиол

Волков В.В. Погребение Норовлин -Уула (Монголия) //Археология Северной и Центральной Азии. Новосибирск, 1975.

Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Эрдэнэбаатар Д., Галбадрах Б. Монголын археологи. Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн 2015 оны зуны Эгийн голын Усан Цахилгаан Станцын талбайд явуулсан авран хамгаалах судалгаа. УБ., 2015. 146-149 тал

Шоргоолжин булш

Энэ үеийн дурсгал өнөөгийн Монгол нутаг болон Байгал нуурын сав, Өвөрмонголын зарим нутгаар тархсан байдаг. Уг булшны онцлог нь ихэвчлэн өргөрөгийн дагуу тогтсон байдалтай байдаг ба урд болон хойд хэсгээрээ бага зэрэг хотойж хавиргалан шигтгэн суулгасан хашлага чулуутай байна. Энэ үеийг төлөөлөх археологийн дурсгалууд: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын Улаан зуух, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань Хар уулын булш зэрэг болно. Шоргоолжин булш түүнтэй ижилсэх дурсгалууд нь он цагийн хувьд хүрэл зэвсгийн дунд үе буюу НТӨ II мянганд хамаардаг болохын судлаачид тогтоожээ.

Ашигласан ном зохиол

Амартүвшин Ч., Батболд Н., Эрэгзэн Г., Батдалай Б. Чандмань Хар уулын археологийн дурсгал I. УБ., 2015.

Хатанбаатар Д., Эрдэнэ М., Анхсанаа Г., Ванчигдаш Ч. Дорнод Монголын хүрлийн үеийн дурсгал // Ancient bronze age and hiong-nu cultures in mongolia. УБ., 2011.

Хиргисүүр

Уг дурсгал нь чулуун овгор дараас түүний гадуур байх дөрвөлжин болон дугариг хүрээ, түүнийг тойрсон жижиг, том хэлбэр хэмжээтэй чулуун дагуул байгууламжуудаас

бүрдэнэ. Энэ дурсгал Оросын Алтай, Тува, Умард, Баруун хойд Монголоос Өмнөд Буриад, Дорнод Монгол хүртэл өргөн уудам нутагт тархжээ. Эдүгээ манай улсын нутгаас 1000 гаруй хиргисүүрийн дурсгал илэрч бүртгэгджээ. Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед (МЭӨ 1600-800/700 он) холбогдуулан авч үздэг бөгөөд хэмжээний хувьд харилцан адилгүй зарим газарт 100 гаруй м голчтой тохиолдоно. Одоогийн байдлаар манай орны нутаг дэвсгэрт 14 аймгийн 30 сумын 67 газарт малтан судалсан 121 дурсгалын мэдээлэл нэгтгэгдээд байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Очирхуяг Ц. Монголын археологи. УБ., 2002. 37-15-р тал

Очир А., Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрэгзэн Г., Гантулга Ж., Түмэн Д., Баярсайхан Ж., Эрдэнэболд Л, Өлзийбаяр С., Эрдэнэбат У. Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. УБ., 2020. 52-р тал

Дөрвөлжин булш

Өнөөгийн монгол орны төвийн болон зүүн зүгийн нутгаар өргөн тархсан дөрвөлжин хэлбэртэй эртний булшийг судалгааны бүтээлүүдэд Дөрвөлжин булш хэмээн нэрлэдэг. Энэ дурсгалын тархац баруун тийш Алтайн уулс, умард зүгт Байгал далай, өмнө зүгт говиор хязгаарлагдаж байна. Уг дурсгалыг XIX зууны 80-аад оноос өнөөг хүртэл олон үеийн судлаачид судалжээ. Дөрвөлжин булш зохион байгуулалтын хувьд хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ толгойг нь зүүн зүг хандуулан дээш харуулж, тэнэгэр байдалтайгаар оршуулж, том зузаан хавтгай чулуудаар дарж таглан шороогоор булаад, дээр нь хавтгай чулууг эгнүүлэн босгож дөрвөлжин хэлбэр гарган, гадна талын хаяаг нь жижиг чулуугаар манаж бэхэлсэн байдаг. Уг дурсгалыг малтахад ваар савны хагархай, шавар, чулуугаар хийсэн сувс, хүрэл, ясан эдлэлүүд гарахаас гадна хосгүй ховор сонирхолтой олдвор ч цөөнгүй олджээ. Үүнээс хамгийн алдартай дурсгал нь археологич Д.Эрдэнэбаатарын Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Асгатын дөрвөлжин булшнаас олдсон хүрэл морь бөгөөд монгол нутагт малтан шинжилсэн хүрэл зэвсгийн үеийн археологийн дурсгалуудаас одоо хэр нь олдоогүй байна. Одоогийн байдлаар 400 гаруй дөрвөлжин булшийг малтан судалжээ (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном бүтээл

Чингис хааны өв. УБ., 2012. 46-р тал

Эрдэнэбаатар Д. Асгатын дөрвөлжин булш. SA, Tom. XIII, Fasc. 56 – УБ., 1992.

Пазырык булш

Өнөөгийн Монгол, Орос, Хятад, Казахстаны Алтайд МЭӨ VI-II зуунд холбогдох Пазырыкийн соёл өргөн тархсан байдаг. Мөнх цэвдэгт Алтайн нуруунд амьдарч байсан нүүдэлчдийн дурсгалыг Оросын нутагт XIX зуунаас судалж эхэлсэн бөгөөд анхны малтлага хийсэн “Пазырык” хэмээх газрынх нь нэрээр нэрийджээ. Пазырык булшны онцлог нь уг соёлыг тээгч нүүдэлчдийн булшийг ертөнцийн зүгээр урдаас хойш чигтэйгээр нэг эгнээнд цуврууллан, овгор дугуй дараастайгаар хийдэг бөгөөд баруун талд нь тахилгын байгууламж, зүүн талд нь хамгийн том булшинд зэл чулуу босгодгоороо онцлогтой. Энэ үеийн олон дурсгал өнөөгийн монгол нутгаас олдсоноос хамгийн сонирхолтой нь 2006 онд дэлхийн 10 шилдэг нээлтийн нэгээр зүй ёсоор нэрлэгдсэн Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Улаан даваа, Олон гүүрийн голоос илэрсэн дурсгал юм. Энэхүү Олон гүүрийн гол-10 булшнаас урьд өмнө Монголд судлагдсан эртний булшнаас туйлын ховор эд өлгийн зүйлс илэрсэн. Үүнд тарваганы арьсан дээл, морь, бугын сийлмэл модон чимэглэл бүхий шувууны дүрстэй өндөр малгай, богино өмд, урт түрийтэй арьсан гутал зэргийг өмссөн хүний хүзүүнд Скифийн амьтны загварт урлагийн аргаар хийсэн архирч буй чонын дүртэй модон зүүлт зүүлгэсэн ба дээлийг нь бүсэлж байсан бололтой 2 буландаа уяа уях зориулалт бүхий дөрвөн нүхтэй бүсний сийлбэртэй модон даруулга гарсан нь нэн сонирхолтой болно. Өдгөө Монгол улсын

нутагт малтан судалсан Пазырыкийн булшны тоо 42 болсоныг судлаачид тогтоожээ (Г.Бүрэнтөгс)

Ашигласан ном зохиол

Молодин В.И., Парцингер Х., Цэвээндорж Д. Замерзшие погребальные комплексы пазырыкской культуры на южных склонах Сайлюгема (Монгольский Алтай). М., 2012.

Төрбат Ц., Батсүх Д., Жискар П.Х. Монгол Алтайд Пазырыкийн булшийг анх удаа малтан судласан тухай // Studia archaeologica. Tom. III (XXIII), Fasc. 3. УБ., 2005, т. 32-53.

Батсүх Д. Монголын пазырыкийн булшнууд. Монгол Алтайн мөнх цэвдгийн булш. Монголын Пазырыкийн соёл. Төрбат Ц., Цэвээндорж Д. (Ред.). Үзэсгэлэнгийн каталоги. УБ., 2016.

Хүннү булш

Хүннүчүүд зүүн тийш Манжуурын талаас баруун тийш Тэнгэр уул, өмнө зүгт Цагаан хэрмээс хойд зүгт Байгал нуур хүрсэн өргөн уудам газар нутгийг эрхшээлдээ авч захирч байв. Хүннүгийн үеийн булш оршуулга нь Шаньюй буюу язгууртны хийгээд жирийн иргэдийн хэмээн 2 төрөл байна. Өдгөө манай улсын нутагт 600 орчим Хүннүгийн булшийг малтан судалжээ. XX зууны 20-иод онд одоогийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт Ноён хэмээх уулнаас асар том булшнуудыг малтсанаар Хүннүгийн Шаньюйн оршуулгын байгууламжийн тухай шинжлэх ухааны томоохон нээлт хийсэн. Монгол нутгаас илэрч олдоод буй язгууртны оршуулгад Ноён уул, Гол мод, Гол мод-2, Дуурлиг нарс, Бор булагийн ам, Тахилтын хотгор зэрэг дурсгалт газрууд тэмдэглэгджээ. Хүннүгийн язгууртны болон жирийн иргэдийн булшнаас түүхэн үнэ цэн агуулсан эд өлгийн зүйлс илэрдгээс хамгийн алдартай нь Хараагийн Ноён уулын 6-р булшнаас гарсан олдворууд билээ. Тухайлбал эсгий ширдэг, торгон хатгамал хөшигний чимэглэл, хээ нь анхаарлыг ихэд татдаг. Энэ эмжээрийн дотор талаар сарлаг, буга, дэлтэй боловч сүүл ба биеийн байдал бартай адил араатан, мөн чих толгой нь араатан мэт далавч, сүүлтэй амтнуудыг ноцолдож буй байдлаар зохиомжилсон нь хүмүүсийн сонирхлыг ихэд татсаар ирсэн. Өнөөгийн байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт Хүннүгийн 330 орчим оршуулгын дурсгалт газар, бүрэн бус тоогоор 10 000 гаруй булш бүртгэгджээ (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Очир А., Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрэгзэн Г., Гантулга Ж., Түмэн Д., Баярсайхан Ж., Эрдэнэболд Л., Өлзийбаяр С., Эрдэнэбат У. Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. УБ., 2020. 121-124-р тал

Эрдэнэбаатар Д., Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Батболд Н., Галбадрах Б.,

Маратхаан А. Балгасан тал дахь Гол мод 2-ын Хүннүгийн язгууртны булшны судалгаа.УБ., 2015.

Монголын Үндэсний Музейн тайлбар. УБ., 2019.

Түрэг булш

Эртний нүүдэлчдийн оршуулгын үндсэн хэлбэрийн нэг бол нас барсан хүнийг газарт нүх ухаж булшлан оршуулах ёс юм. Тэгвэл олон зүйлийн булш оршуулгаас зан үйлийн хувьд бусдаас ялгарах нэг өвөрмөц хэлбэр нь эртний түрэгийн үеийн “Морьтой оршуулга” юм. Түрэг булшны онцлог нь үндсэн хэлбэр нь ерөнхийдөө дугуй, зууван дугуй хэлбэртэй, овгор харагдах боловч төв хэсэгтээ чулуу цөөн ба бага зэрэг хотгор байдалтай, мөн ихэнх тохиолдолд дараасны төв хэсэгт булшны нүхийг тойруулан тусгайлан хийсэн дугуй болон дөрвөлжин хүрээтэй байдаг. Одоогоор малтан судлаад байгаа VI-X зууны 200 гаруй морьтой оршуулгаас 100 орчмыг нь Саян-Алтай буюу ОХУ-ын Алтай, Тува, Алтайн хязгаарын нутагт, үлдсэнийг нь Монгол, Шинжаан, Дундад Азид малтан судалжээ. Монгол улсын нутаг дэвсгэрээс Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум, Сыргаль-2 дурсгалын 5-р булш, Увс аймгийн Бөхмөрөн сум, Шанаган Хэвийн 2-1

булшнаас тус тус сонирхолтой эд өлгийн зүйлс илэрч байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Талын морьтон дайчдын өв соёл. УБ., 2014. 31-р тал

Баярхүү Н. Монгол нутаг дахь морьтой оршуулгын судалгаа (VI-X зуун). Руни бичгийг тайлж уншсаны 122 жилийн ойд зориулсан “Эртний түрэгийн түүх, соёл” Олон Улсын Эрдэм Шинжилгээний хурал. УБ., 2015.

Уйгур булш

Уйгур булш нь анх “Дөрвөлжин” хэмээх дурсгалаар танигдаж судалгааны эргэлтэд орсон бөгөөд онцлогын тухайд гадаад зохион байгуулалтаараа байгалийн шороог дэлдэж үйлдсэн, дөрвөлжин хэлбэртэй намхан шороон хэрэмтэй, хэрмийн үүд зүүн тийш харсан байх ба хэрмийн гадуур ус зайлуулах татаал сувагтай байдаг байна. Энэ үеийн хамгийн онцлог дурсгал нь Хулихын ам, Хиргист хоолой, Харанхуй жалга, Өгөөмөрийн уйгур булшийг дурдахаас гадна Архангай аймгийн Хашаат сумын нутаг Өвөрхавцалын 3-р дөрвөлжний тоосгон бунхант язгууртны булш юм. Энэхүү дурсгалаас илэрсэн шавар арслан нь догшин түрэмгий, хурц нүдтэй, нарийн ур хийцээрээ ялгардаг аж. Харин уйгурын жирийн ард иргэдийн булш оршуулгыг малтан судалсан нь харьцангуй цөөн боловч Казахстан, Тува болон Монголын нутгаас илрүүлэн судалсаар байгаа билээ. Тэдгээр нь Түрэг булшны нэгэн адил морь дагалдуулсан оршуулгууд байдаг бөгөөд булшнаас илэрч буй олдвор хэрэглэгдэхүүнээр нь Уйгурын үед холбогдуулан үздэг ажээ. Уйгурчуудын бунхант булшууд нь Орхон голын хөндий, уг гол цутгасан жижиг голуудын хөндийд голлон байрлажээ. Одоогийн байдлаар дээрх газруудаас 50 орчим бунхант булш байгааг судлаачид тогтоожээ (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Очир А., Эрдэнэболд Л., Одбаатар Ц., Анхбаяр Б. Уйгурын бунхант булш. Archaeological studies. 2008. Tom.(VI), XXVI, Fasc.17, pp328-368

Одбаатар Ц. Уйгурын үеийн археологийн дурсгалууд. /Талын дайчдын өв соёл/ үзэсгэлэнгийн каталоги. УБ.,2014 он, тал 45-53

Энхтүвшин Б., Тала, Очир А., Чэн Ёнжи (Ред.). Монгол-Хятадын хамтарсан судалгаа

II. Монгол улсын Архангай аймгийн Хотонт сумын Өвөрхавцалын амны 3-р Дөрвөлжингийн малтлага судалгаа. УБ., 2008.

Очир А., Одбаатар Ц., Эрдэнэболд Л., Анхбаяр Б. Монгол улсын нутаг дахь Уйгурчуудын археологийн дурсгал. УБ., 2019. 232-р тал

Өлзийбаяр С. Өгөөмөрийн уйгур булш. Түүхийн судлал Т. XXXYII, f. 3. УБ., 2007 тал 26-32

Хятан булш

Монгол Улсад Хятаны булшийг анх 1940 онд Төв аймгийн Сэргэлэн сумын Авдарын уул хавьд малтсан хэмээн үздэг. Хятан булшны онцлогын тухайд гадаад зохион байгуулалтын хувьд Хятаны жирийн иргэдийн булшийг үйлдэхдээ хавтгай чулуугаар өрлөг хийж балбал чулуу болон хөшөө босгодог байна. Дотоод зохион байгуулалтын хувьд газарт дөрвөлжин хэлбэр гарган ухаж булшны нүх хийгээд мод, чулуугаар нүхний дотор талд өрж тэгш өнцөгт хэлбэр гаргах, эсвэл модон авс хийж хүнээ баруун хойд зүгт толгойг хандуулан тавиад чулуу, банз зэргээр таг хийж оршуулдаг байжээ. Хятаны хэмээн үзэж буй эгэл иргэдийн булшийг цөөн тоогоор малтан судалсан байдлаас үзэхэд оршуулгын зан үйл, хойлгын эд зүйлс нь Өвөр Байгалд олддог дундад зууны булшуудаас гардаг эд зүйлстэй адил байхын зэрэгцээ тухайн үеийн Түрэг ба Уйгурын дурсгалаас ялгаатай байгаа нь уг булшийг үлдээгсэд НТ I мянган жилийн сүүл, II мянган жилийн эхэн үед байсан, Хятаны соёлын нөлөөг нэлээд хэмжээгээр хүлээн авсан нүүдэлчин монгол аймгийнхны дурсгал гэж үзэх боломжийг олгож байна. Харин Хятаны үед холбогдох нүүдэлчдийн оршуулгын дурсгалд Баянхонгор аймгийн Дугуй Цахирын

хадны оршуулга, Ховд аймгийн Булган сумын Баян-Өндөрийн хадны оршуулга зэргийг судалгаанд хамруулжээ (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Сэр-Оджав Н. Эртний түрэгүүд (VI-VIII зуун). УБ., 1970, т. 31.

Ивлиев А.Л. Центральная Азия и соседние территории в средние века. Погребения Киданей. Новосибирск, 1990, т. 42.

Баяр Д. Дундад зууны эхэн үе ба хятан нарын булш // Монголын археологийн шинжлэх ухаан. Боть №32. Ботийн редактор Д.Цэвээндорж, У.Эрдэнэбат. УБ., 2007, т. 133-138.

Крадин Н.Н., Ивлиев А.Л., Очир А., Васютин С.А., Данилов С.В., Никитин Ю.Г.,Эрдэнэболд

Л. Киданьский город-Чинтолгой балгас. М., 2011.

Монгол булш

Дундад зууны монголчуудын язгууртны оршуулга манай улсын нутгаас олдоогүй байна. Монгол булшны онцлогын тухайд газрын хөрсөн дээр чулуугаар цагариглан өрж хийсэн овоолгоор танигддаг бөгөөд жирийн иргэдийн булш нь газрын гүнд маш гүехэн тавьдаг. Харин зарим булшинд гүн нүх малтаж гурван давхар төмөр бүслүүртэй модон авсанд хийн, толгойг голдуу умар зүг хандуулан тавьсан нь илэрсэн. Манай улсын нутагт нийт 80 орчим газарт 600 гаруй Дундад зууны үеийн монгол булш малтан шинжилсэн мэдээ бий. Үүнээс хамгийн алдартай дурсгалд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Хориг уул, Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой зэрэг газруудад малтан судалсан дурсгалууд юм. Хамгийн алдартай нь Хэнтий аймаг, Хэрлэнбаян-Улаан сум, Бухын хошууны малтлага судалгаанаас илэрсэн зөрүү энгэртэй Монголын эзэнт гүрний үеийн язгууртан эрэгтэй хүний дээл юм. Энэхүү дээл нь XIII зууны үеийн Монголын эдийн соёлын судалгааны чухал эх сурвалж ба ташуу захтай, урт нарийн ханцуйтай, бэлхүүсээрээ жигд хуниастай, дэрвэгэр хормойтой. Нимгэн пансан торгон гадартай. Эвэр угалзан хээг хоргой торгоор хайчлан, захаар нь алтан утсаар зээг даруулан дээлийн энгэр, зах, ханцуй, хормойн хэсгийг чимэглэсэн нь Монголын Эзэнт гүрний язгууртны хувцас хэрэглэгдэхүүнийг бүрэн илэрхийлдгээрээ онцлогтой (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Эртний монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд. УБ., 1956.

Төрбат Ц., Батсүх Д. Таван толгойн монгол язгууртны булшнууд. // Монгол-Францын археологийн нээлтүүд, хорин жилийн хамтын ажиллагаа. Үзэсгэлэнгийн каталог. УБ., 2015, тал 139-169.

Эрдэнэбат У., Төрбат Ц. Онгон нутгийн өв соёл. УБ., 2011.

Баярсайхан Ж нар. Монгол Америкийн хамтарсан “Умард монгол” археологийн төслийн 2019 оны хээрийн судалгааны ажлын тайлан. УБ., 2019.

Эрдэнэбат У. Чингис хааны өв. УБ., 2012.

Монголын Үндэсний музейн тайлбар. УБ., 2019.

Хадны оршуулга

Хадны оршуулга нь өнөөгийн Монгол, Енисей, Чулым, Абакан, Эрхүү муж болон Өвөр Байгал, Уулын Алтай зэрэг бүс нутгуудад олдож малтан судлагджээ. Хадны оршуулгын онцлогын тухайд ихэвчлэн уулын дунд болон орой хэсгийн алсын бараа үзэгдэх хараатай газрын энгэр хаднаа хөмөглөсөн байдлаар илэрдэг. Хадны оршуулгыг байгалийн бэлэн агуй хонгил, хадны хөмөг, ангал, нүх сүвийг ашиглан үйлдэх тул дотор нь орж л үзэхгүй бол шууд гадна талаас нь энд оршуулга байна гэж танигдах шинж тэмдэг үгүй байдаг. Өнөөгийн монгол нутгаас олдсон хамгийн сонирхолтой дурсгал нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Арцат дэлийн хадны оршуулга, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Үзүүр гялан, Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Дугуй Цахирын

хадны оршуулга, Ховд аймгийн Мянгад сумын Урд улаан үнээт зэрэг дурсгалаас гарсан олдвор хэрэглэгдэхүүн нь монгол нутгаас олдсон хадны оршуулгыг үлдээгч ард түмний эдийн сурвалжийн томоохон төлөөлөл болсон. Үүнээс хамгийн сонирхолтой нь Ховд аймгийн Мөнххайрхан сумын Үзүүр гялан хэмээх газраас 2016 онд илэрсэн оршуулга нь Монгол Алтайн уулсын бүсэд малтан судалсан хадны оршуулгын нэгэн төлөөлөл бөгөөд оршуулгын эзнийг дагуулан адуу тавьснаараа урьд өмнө нь малтан судалсан хадны оршуулгуудаас онцлогтой. Өдгөө монгол нутгаас 120 гаруй хадны оршуулга илэрсэн ба зарим булшинд археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийгдсээр байгаа болно (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Эрдэнэбат У., Амартүвшин Ч. Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун) // Studia archaeologica. Tom. XXVII. УБ., 2009.

Хүрэлсүх С. Хадны оршуулгын судалгааны зарим асуудал. УБ., 2002.

Бүрэнтөгс Г., Мягмарсүрэн Б. Монголын археологи. Үзүүр Гялангийн хадны оршуулга. УБ, 2016.

Мөнхбаяр Ч., Пүрэвдорж Г., Бямбасүрэн Х., Сүхбаатар Б. Монголын археологи. Үзүүр гялан, Цахир, Тошинтын хадны оршуулгын малтлага судалгааны урьдчилсан үр дүн. УБ, 2016

4. ТАХИЛЫН ОНГОН, БАЛ БАЛ ЧУЛУУ

Тахилын онгон, бал бал чулуу

Түүхэн тодорхой цаг үед гэрэлт хөшөө болон тахилын сүм, тойрон хүрээлсэн хэрэм далан, олон хүн, адгуус амьтны чулуун баримал бүхий цогцолбор юм. Тахилын онгон Монгол орны төв нутаг Орхон, Туулын сав газраар төвлөрөн байрладаг хэдий ч хамгийн зүүн зах нь Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг дахь Донгойн ширээн тахилын онгон хэмээн бүртгэгдсэн. Бал бал чулуу нь тахилын онгоны зүүн талд тусгайлан босгосон чулуун хөшөө бөгөөд тооны хувьд хамгийн багадаа 3 байх ба үүнээс дээш хэдэн арав, бүр хэдэн зуу хүртэл тоотойгоор зүүн урд зүгт цуварсан байдалтайгаар үргэлжилж төгсгөл нь зүүн хойш эргэж дуусдаг байна. Үүнийг монголчууд малын зэлтэй адилтган “зэл чулуу” гэж нэрлэдэг тул судалгааны бүтээлд “балбал”, “зэл чулуу” гэж хоёр янзаар бичиж тэмдэглэсэн байдаг. Түрэгийн үед нас барагсаддаа зориулж байгуулсан тахилын онгонд босгосон байдаг боловч үүнээс өмнө хүрэл зэвсгийн үеийн тахилгын хашлаганд бал бал чулуу байх ба мөн түрүү төмөр зэвсгийн үед буюу Алтайн нуруугаар амьдарч байсан Пазырыкчуудын булшинд мөн ийм бал бал чулуу босгодог байна (Г.Бүрэнтөгс).

Ашигласан ном зохиол

Төрбат Ц. “Сэргэ” эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент // Studia ethnologica. Tom. XII, Fasc. 14. УБ., 1999.

Баттулга Ц. Монголын руни бичгийн бага дурсгалуудын судалгаа. Докторын зэрэг горилсон бүтээл, УБ., 1999.

Баярхүү Н. Морьтой булшны оршуулгын зүг чиг (VI-X зуун). “X. International Turkic Culture, Art and Protection of Cultural Heritage Symposium/Art Activity”.Олон Улсын Эрдэм Шинжилгээний Хурлын илтгэл. УБ., 2016.

Баяр Д. Монгол нутаг дахь хүн чулуун хөшөө // Түүхийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. Мэргэжил:05.03.08.00 (археологи). УБ., 2001

Шивээ

Түүхэн тодорхой цаг үед цэргийн бэхлэлт болгон барьж байгуулсан барилга байшин, хэрмийн үлдэгдлийг хэлнэ. Ихэвчлэн уулын хяр, аараг толгод дээр байгуулсан байдаг. Зориулалт нь дайсны давшилтыг таслах, няцааж түүнд их хэмжээний хохирол учруулан эзэлсэн байраа тогтоон барих зорилгоор хийдэг байна (Г.Бүрэнтөгс).

5.БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛ

Суурьшлын ул мөр бүхий газар

Тодорхой түүхэн үед хүмүүс удаан хугацаагаар тогтвортой амьдарч байсан ул мөр үлдээсэн газрыг хэлдэг. Суурьшлын ул мөр бүхий газраас элдэв төрлийн чулуун зэвсэг, үр тарианы үлдэгдэл, мал амьтны яс, гал түлж байсан ор мөр зэрэг хүн амьдарч байсан илэрхийлэл болсон зүйлс илэрч олддог (Г.Анхсанаа).

Эртний хот, суурины үлдэгдэл

Төв Азийн нүүдэлчид тэр дундаа Монгол нутагт төрт улсаа байгуулж асан ард түмэн тодорхой цаг хугацаанд нэг газарт төвлөрөн суухдаа хот хэрэм байгуулан сууж байсныг манай орны хөдөө орон нутгаар дайралдах хэмжээний хувьд харилцан адилгүй олон тооны эртний хотын үлдэгдлүүд гэрчилнэ. Эдүгээ манай улсын нутгаас 300 гаруй эртний хот суурины үлдэгдэл илэрч тэмдэглэгдсэний хамгийн эртнийх нь Хүннүгийн үед хамаардаг байна. Үүнээс хойш Уйгур, Хятан, Монгол, Манжийн үед холбогдох хот суурины үлдэгдлүүд болно (Г.Анхсанаа).

Хүннүгийн хот, суурины үлдэгдэл

Манай улсын нутаг дэвсгэрээс Хүннүгийн үед хамаарах Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Өндөр дов, Хүрээт дов, Цэнхэрийн голын хэрэм, Баруун Дөрөөгийн хэрэм, Шувуутайн голын хэрэм, Дов дэрсний хотын туурь, Баянбулагийн туурь, Мангасын хүрээ, Сайрын балгас, Талын гурван хэрэм, Бороогийн суурин, Эгийн голын Баянголын суурин, Овоотын баруун хавцлын балгас зэрэг 20 гаруй хот, суурины үлдэгдэл илэрч олдоод байна. Мөн Хүннүгийн хот суурин манай улсын нутаг дэвсгэрээс гадна Өвөр Байгалаас хятадын цагаан хэрэм хүртэлх өргөн уудам нутагт тохиолддог. Энэ үеийн хот, суурины үлдэгдлийг судлаачид үүрэг зориулалтаар нь, - Хүн улсын шаньюйн орд харш - Хүн улсад дагаж ирсэн хятад жанжин нарын бэхлэлт-хот суурин, - Хүн улсын худалдаа, тариалан, гар үйлдвэрийн суурин хэмээн ангилж үзсэн нөгөө хэсэг нь Сэлэнгэ мөрний дагуу гар үйлдвэрлэл, газар тариалан эрхлэгчдийн суурин, Хэрлэн голын дагуу тахилгын газрууд, Өвөр Монголын нутгаар цэргийн бэхлэлт хэрмүүд тархсан байдаг хэмээн бичжээ.

Мөн түүнчлэн дээрх ангиллыг илүү дэлгэрүүлэн 1.Түр зуурын бэхлэлт хэрэм (цэрэг дайны болон засаг захиргааны зориулалттай), 2.Шашин мөргөлийн суурин, 3.Хилийн бэхлэлт цайз, 4.Гар урчууд, газар тариаланчдын суурин гэж хуваасан байдаг.

Хүннүгийн хот суурины судалгаагаар нүүдлийн соёл иргэншил, түүнд суурин иргэншил хэрхэн нөлөөлснийг төсөөлж болох бөгөөд энэ үеэс эхлэн дараа үеийн нүүдэлчдийн хот суурин төлөвлөлтийн цаашдын хөгжилд зохих хувь нэмэр болсон ба нүүдлийн аж ахуй эрхлэн хөтлөх хэв шинжид тохирсон төв суурин газар, тухайн үеийн нийгмийн харилцаа зэрэг түүхийн үндсэн сэдвийг тодруулахаас гадна үйлдвэрлэл, худалдаа наймаа, гадаад харилцаа гэх мэт олон асуудалд хариулт өгөх чухал дурсгал юм (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон УБ., 1961

Батсайхан З. Хүннү (Археологи, угсаатны зүй, түүх). УБ., 2002

Төрбат Ц., Гантогтох Г. Хүннүгийн хот суурины судалгааны асуудалд // Acta historica. Tom. XI, Fasc. 3. УБ., 2010

Төрбат Ц. Хот суурин // Хүннүгийн толь бичиг. УБ., 2011

Уйгурын хот, суурины үлдэгдэл

Өнөөгийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршиж байсан эртний хүчирхэг төр улсуудын нэг бол Уйгурын хаант улс (744/45-840 он) юм. Уйгурын хаант улсын үед холбогдуулан үздэг хот суурин, тахилын онгон, гэрэл хөшөө, булш оршуулга, хүн чулуун хөшөө зэрэг хэд хэдэн төрлийн дурсгалууд манай улсын нутаг дэвсгэрт байдаг. Эдгээрээс нэлээд сайн судлагдсан төрөл нь хот суурин юм. Нийт судалгааны эргэлтэд

орсон 20 гаруй хот суурин болон малтлага судалгаа хийгдсэн хот, суурины бүтэц зохион байгуулалтаас ажиглахад хэдэн төрөлд хувааж үзэж болохоор байгааг судлаачид тэмдэглэсэн байна. Үүнд,

- Улс төрийн төв том хотууд
- Ноёдын өргөө (өвөлжөө, зуслан)
- Газар тариалангийн суурин газар
- Тахилга шүтээний байгууламж гэх мэт үүрэг зориулалт, хот байгуулалтаар нь хэд ангилжээ.

Ерөнхийдөө Уйгарын бэхлэлтийн хамгийн чухал онцлог шинж нь хананы дагуу болон булангийн цамхгууд, цайзын дөрвөлжин хэлбэрийн зохион байгуулалт, аль нэгэн ханын төв хэсэгт хаалгатай байх зэрэг болно. Төв Азийн дундад зууны байлдааны бэхлэлтийн хувьд ховор тохиолддог онцлог нь хэрмийн хананы буланд барьсан бастион, форт, цитадель зэрэг юм. Хана дагуу сумны тусгалын хэмжээнд байрласан цонж, бастион, форт, цитадель зэрэг нь удаан хугацааны хориглолт хийх боломжийг нэмэгдүүлсэн байна. Энэ бүгд нь Орду-Балык буюу зэрэг Уйгурын цайзыг Төв Ази дахь дундад зууны үеийн хамгийн боловсронгуй цэрэг-инженерийн байгууламж мөн гэж судлаачид дүгнэсэн байдаг (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Худяков Ю.С. Памятники уйгурской культуры в Монголии // Центральная Азия и соседние территории в средние века. Новосибирск, 1990

Энхтөр А. Уйгурын хотын хэв шинж онцлог (Цагаан сүмийн балгасны жишээн дээр) // Актуальные вопросы археологии и этнологии Центральной Азии. Материалы II международной научной конференции, посвящённой 80-летию д.и.н., проф. П.Б. Коновалова (г. Улан-Удэ, 4-6 декабря 2017 г.) Улан-Удэ: БНЦ СО РАН. 2017

Монголын эртний хот суурин. Монголын археологийн өв цуврал. X боть. Эрхлэн хэвлүүлсэн:

Г.Эрэгзэн, Л.Эрдэнэболд. УБ., 2020

Хятаны хот, суурины үлдэгдэл

Хятанчууд X зууны хоёрдугаар хагасаас Орхон, Хэрлэнгийн сав газрын олон аймгуудыг “урвах, дагах нь хязгааргүй” гэж тэднийг дарангуйлан захирах бодлого явуулж цэргийн зориулалттай бэхлэлт хэрмүүдийг барьж эхэлжээ. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт Хятаны үеийн хорь орчим хот суурин мэдэгдээд байна. Одоогоор Туул голын хөндийд буй Хатан хот буюу Чэнь-жоу, Хар Бухын балгас, Хэрмэн Дэнж, Хэрлэн голын хөндийд буй Зүүн ба Баруун хэрэм, Барс хот-1 зэргийг харьцангуй сайн судлаад буй. Эдгээрээс гадна Талын Улаан балгас, Дэрсэн хэрэм, Эмгэнтийн хэрэм, Цагаан хэрэм, Өглөгчийн хэрэм зэрэг Хятаны хот суурины туурь бий. Эдгээр хотуудын байрлал нь зүүнээс баруун тийш чиглэсэн байдалтай байдаг ба бас нэгэн ялгах гол онцлог нь бэхлэлтийн шинж чанартай давхар хаалга буюу сонор хаалгатай байдаг (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон УБ., 1961

Очир А., Энхтөр А., Эрдэнэболд Л. Харбухын балгас ба Туул голын сав дахь хятаны үеийн хот суурингууд. УБ., 2005

Энхтөр А. Монгол улсын нутаг дахь Хятаны археологийн судалгаа // Хятаны өв соёл (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). УБ., 2014

Монголын үеийн хот, суурины үлдэгдэл

XIII зуунд монголчууд дэлхийн түүхэнд хамгийн том эзэнт гүрнийг байгуулсан юм. Монголчуудын байлдан дагууллын үр дүнд олон үндэстэн угсаатнууд нэгэн их гүрний доор нэгджээ. Эзэнт гүрний нийслэл хот Хархорумыг Орхоны хөндийд байгуулсан нь цэцэглэн хөгжиж, өрнө дорныг холбосон, улс төр, эдийн засаг, соёл, шашны том төв

болж байлаа.

Энэ үед хамаарах археологийн дурсгалууд монгол улсад олон байгаагаас бичиг үсгийн дурсгал, хүн чулуун хөшөө, булш, хот сууринууд харьцангуй сайн судлагдсан байна.

Тухайн үеийн хот суурины томоохон дурсгалуудад одоогийн монгол орны нутагт орших Хар хул хааны балгас, Аваргын балгас, Дойтын толгой, Шаазан хот, Халтарын балгас, Тахил усны суурин, хил залгаа нутагт орших Хархираа, Шанд зэрэг олон хотууд тухайн үед байж байсан нь монголчуудын барилга архитектурын хөгжлийг харуулах чухал дурсгалууд болох юм (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон УБ., 1961

Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Очирхуяг Д. Монголын археологи.УБ. 2002

Цэвээндорж Д., Баяр Д., Эрдэнэбат У. Монголын эртний хот суурины судалгаа. Монголын археологийн шинжлэх ухаан. Боть №32. Ботийн редактор Д.Цэвээндорж, У.Эрдэнэбат. УБ., 2007

Манжийн үеийн хот, суурины үлдэгдэл

XVI-XVII зууны үе буюу Чин гүрний үед холбогдох хот суурины судалгаа харьцангуй бага хийгдсэн хэмээн үзэж болно. Энэ үед хэдийгээр Монголчууд Чин гүрний эрхшээлд орсон боловч хот орон байгуулах ажил тасалдалгүй үргэлжилсээр байсан юм. Тухайлбал, Д.Майдарын Монголын хот тосгоны гурван зураг (эрт, дундад үе, XX зууны эхэн). Улаанбаатар, 1970 бүтээлд Манжийн үеийн цайз ба худалдааны хотууд хэмээх хэсэгт 130 гаруй суурин газрын нэрс оруулсан байдаг билээ. Мөн энэ үеийн хот түүхийг тодруулах гол арга нь сурвалжийн мэдээнд дулдуйдан явагдсаар ирсэн юм. Тэр дундаа энэ үед олноор байгуулагдсан хүрээ хийдийн түүхийг архивын баримт хэрэглэгдэхүүнд түшиглэн тодруулах ажил багагүй хийгдсээр байна. Эдгээр сурвалж, бичгийн мэдээ сэлтийг археологийн судалгаагаар батлах нэг боломж нь тухайн үеийн хот сууринуудыг малтан судлах явдал юм. Анхлан археологич Н.Сэр-Оджав Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Байдраг голын эрэгт орших “Хотын булан” малтан шинжилсэн байна. Сүүлийн жилүүдэд Завхан аймгийн Тэс сумын Сүм толгой, Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших Сүм хөх бүрд, Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Цогтын цагаан балгас зэрэг энэ үеийн дурсгалуудыг малтан шинжлэх ажил идэвхтэй хийгдэж байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Очир А., Одбаатар Ц., Хотгойдын дээдсийн нэгэн суурины тухай. // Бүтээлийн эмхэтгэл. УБ., 2012

Пэрлээ Х. Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961

Сэр-Оджав Н. Манжийн цэргийн хот. // Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. УБ., 2003

Ширэндэв Б. Цэргийн цайз «Тамир» хотод холбогдох үйл явдлууд (18 дугаар зууны үе) // ШУАМ №4. УБ., 1967

Чулуун С., Энхтуул Ч. “XVII зууны Монголын хотууд” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч дүнгээс // Монголын археологи – 2018 (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). УБ., 2019

Хэрмэн зам

Манай улсын зарим аймгийн нутагт, тодруулбал Ховд, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Төв, Өвөрхангай аймгуудын нутгаар олон зуун километр урт үргэлжилсэн эртний их суваг, далан, хэрмийн ор суурь, үлдэц одоо болтол тод хадгалагдан үлдсэн байдаг. Эртний тэдгээр байгууламжийг нутгийн ардууд Сартуулын суваг, Сартагтайн шуудуу, “Чингисийн далан”, “Чин¬гисийн зам”, “Чингисийн хэрэм” Гүнжийн зам, Илжгэн

чихт хааны хэрэм гэх зэргээр нэрлэж гарал үүсэлтэй нь холбон янз бүрийн домог ярьдаг боловч ерөнхийд нь “Хэрмэн зам” хэмээн нэрэлдэг бөгөөд физик газарзүйн болон байр зүйн зурагт “Чингисийн далан” (вал Чингис хана) гэж тэмдэглэдэг байна. Хэрмэн замыг байгуулахдаа их төлөв суваг малтаж түүнээс гарсан шороогоор далан байгуулсан байх ба харин говийн аймгийн нутаг дахь даланг шороотой газар шороогоор, загтай газар загаар, чулуу элбэгтэй газар чулуугаар барьдаг. Мөн энэхүү байгууламжийн бас нэг онцлог нь голчлон өмнө талд дөрвөлжин, цөөн тохиолдолд дугуй хэлбэртэй шороон хэрэмүүд 15-35 км зайтай байгуулсан байдаг. Тус дурсгалын үүрэг зориулалт, он цагийн талаар өдгөө болтол нэгдсэн саналд хүрээгүй байгаа боловч Монгол нутагт оршиж байсан улс гүрнүүдийн хил хязгаар, худалдааны зам хэмээн үзэх хандалга давамгайлдаг (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон УБ., 1961

Баасан Түү. Чингисийн далан гэж юу вэ? УБ., 2006

Шуудуу

Ус урсах зориулалт бүхий хиймэл буюу ерийн тогтсон нарийвтар сувгийг шуудуу гэнэ. Эрт үед газар тариалан эрхэлж байгаа талбай руу ус гүйлгэх зорилгоор урт, эсвэл хот балгад, тахил тайлгын онгоныг хамгаалах үүднээс хэрэмний 4 талаар тус бүр зориуд шуудуу татдаг байжээ. Тухайлбал, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт орших Дугшихын сууринд эрт цагт эрхэлж байсан тариаланг услах шуудууг 30 орчим км-ийн зайд орших Аврахын булгаас татаж байсан баримт бий (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Пэрлээ Х. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь талын нутгаар эртний судлалын хайгуул хийсэн нь. “Эртний судлал, угсаатны зүйн бүтээл”. Tom. 2, fasc. 4. УБ., 1963

Сүм хийдийн туурь

Бурханы шашны хурал номын үйл ажиллагаа явуулж байсан болон мөргөл, хүндэтгэлийн үүргийг гүйцэтгэж байгаад хожим нь эвдэрч сүйдсэн, эргэж сэргээн засварлагдсан томоохон суварга, сүм хийд, түүний туурь үлдэгдлүүд нь монголчуудын сүсэг бишрэлийн илэрхийллийн томоохон жишээ болохын хувьд оюуны болон эдийн соёлын үнэт дурсгал болдог. Монголд бурханы шашин дэлгэрсэн үеэс хойш олон тооны сүм хийд барьж байгуулан хурал номын үйл ажиллагаа явуулж байсан ба сүм хийдийг даган хүмүүсийн төвлөрөл бий болж байв. Монгол Улсын нутагт 1930-аад оны сүүлийн их хэлмэгдүүлэлтээс өмнө 1000 гаруй сүм хийд хурал номын үйл ажиллагаа явуулж байсан гэсэн албан бус тоо баримт байдаг. Эдгээр сүм хийд, томоохон суваргуудыг 1937-1940 оны хооронд зориудаар эвдэн сүйтгэсэн бөгөөд цөөхөн хэдэн тооны сүм хийдийг зориулалтаар нь өөрчлөн ашиглахаар авч үлдсэн байдаг. Хөдөө орон нутагт байгаа сүм хийд, суваргын үлдэгдлүүдээс барилгын тоосго шавар болон модон материалууд, шавар бурхдын үлдэгдлүүд, ахуйн хэрэглээний сав суулга зэрэг зүйлс олддог байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ., 2009

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах. Эмхэтгэсэн Г.Энхбат, Г.Анхсанаа, Ред: Б.Цогтбаатар. УБ., 2017

Суварга

Бурханы шашны шүтээн урлагийн нэг төрөл суварга нь архитектурын жижиг байгууламж мөн билээ. Суварга гэдгийг “Энэтхэгийн одон орон домог зүйд: Тэнгэр хааны нутагласан “Мөр уул”-ыг дүрсэлсэн дугуй, дөрвөлжин хэлбэртэй байгууламж хэмээн үзсэнээр ирсэн бөгөөд ариун санваартан бурхадыг “сахиуслан хамгаалах орон”, ”түүхт үйл явдалд зориулж” тухайн газарт барьж байгуулдаг барилга аж. Түүнийг

Буддын шашинт орнуудад чоддон, дагоба, пагода, суварга, таа стуга гэх мэтээр нэрлэн тэмдэглэсээр иржээ.” гэсэн байна.

Суваргыг Энэтхэг орноо Бурхан багшийг ертөнцөөс ангжирхад шавь нар нь биеийг чандарласанд хайлаагүй үлдсэн эд (яс, шүд гэх мэт)-ийг хадгалахаар үүдэж анх үүссэн архитектурын жижиг байгууламж бөгөөд энэ чанараараа суварга нь нэгд: Булш бунхныг буюу Бурхан багшийн төлөөлөл болгож, хоёрт: ариун сүм, шүтээн гэсэн ухагдахуунуудаар улс бүрд хөгжиж иржээ.

Суварга дотроо маш олон төрөл ялгамжтай бөгөөд жишээ нь бидний сайн мэдэх найман суварга, үүнээс гадна Хэрүгэ бээр их догшидыг номхотгохын цагт үхээрийн найман оронд найман мамын шид бүтээж гарахуйд алдаршсан найман суварга, Брадигабудын суварга, Шарваганы суварга, Давхарлагатай байшин суварга, Зарлиг увдисын суварга гэх мэт олон төрөл анги байх ажээ.

Мөн үүнээс гадна зохиомж, хийц төлөвлөлтөөс нь хамааруулж:

• Олон буюу богино саравчийн суварга,

• Цамхаг хэлбэрийн суварга. Үүнийг бас Махаболи буюу Лхантай суварга гэж нэрлэдэг,

• Дагоба суварга гэж ангилсан нь бий (Б. Адъяа).

Түүхэн барилга, байгууламж (Historic buildings) - Архитектурын түүхэнд чухал ач холбогдолтой, архитектурын чухал шинж чанарыг агуулсан, эсвэл орон нутгийн соёл, нийгмийн хөгжилд түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн барилгууд (In Getty Research - Art & Architecture Thesaurus Online)-ыг хамруулахаас гадна түүхэн үйл явдал, үйл ажиллагаа, эсвэл хүнтэй холбоотой чухал ач холбогдол бүхий барилга болон хүний үйл ажиллагааны аливаа хэлбэрийг агуулах, хамгаалах зориулалтаар баригдсан байгууламжуудыг хамруулдаг байна.

Уран барилга (Архитектур-architecture) хэмээхийг «Архитектур» гэсэн нэр томьёоноос эхэлж тайлбарлах нь зүйтэй. Архитектур хэмээх нэр хэрхэн гарч ирснийг эрдэмтэд: Латин хэлний «Архитектус»- Architectus гэдэг үг, Оросоор архитектур хэмээн дуудагдах болжээ. Харин Латин хэлний «Архитектус» гэдэг нь эртний Грек хэлээрх арки буюу барилга удирдаж бариулагч (талбайн даамал), тектон буюу барилга барьдаг урчууд (барилгачин) гэсэн хоёр үгнээс гаралтай гэж тайлсан байна.

Ийнхүү үүссэн "Архитектур" гэдэг үгийг Монгол хэлэнд "Уран барилга" хэмээн буулгаж, энэ агуулгаар ойлгох болсон ба Ж.Бадраа агсан үүнийг бас “Цогцлоох урлаг” гэж урлагийн талаас нь нэрлэсэн бий.

"Архитектур" үүнийг хамгийн товчоор «ашиглалт, бат бөх, гоо үзэмж» гэсэн агуулгатай, эсвэл уран барилга урлалын ухаан, үйл ажилбарыг нэрлэсэн нэр гэх зэргээр тайлбарласан байдаг бол Финландын нэрт архитектор Албер Альто «Архитектур гэдэг ойлголтод хотоос эхлээд хаалганы бариул хүртэлх бүтээл бүхэлдээ багтана» гэсэн нь бий. Ер нь Уран барилга гэдэг нь "Тухайн бүс нутагт амьдран суух үндэстэн ястны гоо зүйн таашаалыг илэрхийлж, байгаль цаг уурын нөхцөлд зохицуулсан, ахуй амьдралын олон талын хэрэгцээг хангахуйц эзлэхүүн, төлөвлөлттэй байхын хамт эдэлгээний удаан хугацааг давахаар техник, технологийн хөгжил дэвшилд тулгуурласан найдвартай бат бөх материаллаг хүрээлэл бүхий орон зай үүсгэн, олон хүний хөдөлмөрөөр бүтээгдсэн, хүн төрөлхтний эрхлэн буй нэгэн төрөл өвөрмөц урлаг" гэжээ (Б. Адъяа).

Уран баримал - Ямарваа юмны дүр төрхийг уран сайхны зохиомж оруулж, гурван хэмжээсээр сийлэх, цутгах, барих зэргээр үйлдэж, бүтээх дүрслэх урлагийн нэгэн төрлийг хэлнэ. Уран баримлыг судлаачид овор дүрсэлбэрт (пластик арт) урлагийн төрөл гэж үзэх нь бий (Б. Адъяа).

Сүм бол бурханы шашны хувраг, шавь нарын ном хурах бясалгал хийх газар

бөгөөд “олны хүрээлэн”, “бурханы гэр” гэсэн утгатай санскрит үг. Гэвч монгол хэлэнд сүм дуган хэмээн хоршин нэрлэдэг. Сүм дуган бол гол төлөв хурал ном хурах газар боловч бурханы сүм дуган, тахилын сүм, шарилын сүм, маанийн дуган, ярнайн дуган, “догшдын дуган”, шарилын дуган гэх мэт олон янзын зориулалттай дуган байжээ. Сүм нь ерөнхийдөө хурал хурах, бурхан шүтээн залан байрлуулдаг газар боловч дотроо бас нарийн зааг ялгаатай бөгөөд зарим нь хувь хүн буюу өндөр мяндаг зэрэгтэй хутагт хувилгаад номын багш нарын орд өргөө эсвэл тэдний бүтээлээ туурвих урлах зориулалттай байжээ (А.Намуун).

Хийд монгол хэлний тайлбар тольд “аглаг хий зайд хот айл, тосгон сууринаас саахалт айлын зайтай байгуулсан сүм хийдийн ерөнхий нэр. Шашны шавь нар сууж, бурхан тахих, хуралд суух, ном бясалгал хийх орон” гэж бичсэн бий. Хүрээ хийд, сүм хий гэж хоршоо үгээр хэлэлцдэг (Б. Адъяа).

Сүрлэг чимэглэлийн урлаг (Monumental) - Хүний биеийн харьцаанаас үл шалтгаалж аугаа сүрлэг зохиомж хэлбэр өвөрмөц, төрөл бүрийн арга барил материалаар бүтээсэн, дүрслэх урлагийн нэгэн төрөл, урлагийн бүтээл юм. Үүнийг “...Манументаль урлагийн бүтээл нь сүрлэг, овор хэмжээ том байдаг ба дотор утга агуулга, хэмжээ, ерөнхийлөл, зохиомжоороо өөр хоорондоо ялгаатай, байшин барилгын дотор, гадна хананд зурсан зураг, шигтгэмэл, чимэглэл, хотын гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэнд босгосон хөшөө, баримал гэх мэт олон төрөл зүйлтэй.” гэж тайлбарласан бий.

Манайд энэ урлагийн төрөл XIX зууны үеэс хөгжиж байсныг Зүүн хүрээнд бүтээсэн 50 тохой (16 м орчим) өндөр алтадсан Майдар бурхан 1911-1913 он олны өргөлөөр бүтээсэн Мэгжид Жанрайсаг бурхадаас мэдэж болно.Үүнээс гадна нэн эртний үед бүтээгдсэн биет соёлоос өв (буган хөшөө чулуу мэт)-ийн дурсгалуудыг хамааруулж болно. Сүүлийн үед төрийн шагналт уран барималч Ц.Амгалан нарын босгосон Халх голын Ялалтын хөшөө, ахмад архитектор А.Хишигт нарын бүтээсэн Зайсан толгой дахь Монгол-Зөвлөлтийн дайчдын дурсгалын сүрлэг хөшөө зэргийг нэрлэж болно (Б. Адъяа).

6.ХӨШӨӨ ДУРСГАЛ

Буган чулуун хөшөө

Буган чулуун хөшөө тархсан бүс нутгийн хойд зах нь Байгал нуур, өмнөд зах нь Монголын их элсэн говийн ар хэсэг, зүүн зах нь Хэнтий аймаг, баруун зах нь Эльба мөрөн хүрэх бөгөөд тархалтын төв, гарал үүслийн цэм нь мөн болохын хувьд нийт бүртгэгдсэн хөшөөний 90 гаруй хувь буюу 1200 орчим нь өнөөгийн Монгол улсын нутагт байна. Буган хөшөөг НТӨ II мянган жилийн дунд үеэс Төмрийн түрүү үеийг дуустал буюу НТӨ III зуун хүртэлх хугацаанд бүтээж байсан гэж эрдэмтэд үздэг. Буган хөшөөг үлдээгчид нь байгалийн хад чулуунаас тусгай бэлдэц гонзгой чулууг цуулан авч, газраас дээш харагдах хэсгийн дөрвөн талыг нь тусгайлан засаж, ээмэг буюу дугуй сүйх, хүзүүний зүүлт, бугын дүрс болон зарим тохиолдолд адуу, гахай, бар зэрэг амьтдын дүрс, толь, бамбай, бүс зэр зэвсэг зарим тохиолдолд хөшөөний орой хэсэгт титэм (малгай) зэргийг сийлсэн босоо чулуун хөшөө юм. Буган хөшөөнд дайчин эрийн зэвсэг болох чинжаал, хутга, билүү, байлдааны зээтүү, нум сум, саадаг, хоромсого, жад, бамбай, гох дэгээ, гүйвэр дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бугын дүрсний оронд буюу завсар зайд адуу, ирвэс, янгир, зээр, зэрлэг гахай зэрэг амьтад дүрсэлсэн нь ч тохиолдоно. Буган хөшөөн дээрх дүрслэлийн онцлог, тархсан газар нутгийн хүрээнд нь тулгуурлан хийсэн дараах гурван ангиллыг баримталж байна. Үүнд:

1. Монгол-Өвөр Байгалын хэлбэр буюу бугын загварчилсан дүрст хөшөө,
2. Саян-Алтайн хэлбэр буюу буга болон бусад амьтын бодит дүрст хөшөө,
3. Евразийн хэлбэр буюу амьтны дүрслэлгүй хөшөө.

Буган хөшөө голдуу 1-4 м гаруй өндөр, 20-50 см зузаан, 30-100 см өргөн хэмжээтэй

байх бөгөөд түүнийг үйлдэхдээ цоолбор, сийлбэр, уран баримлын аргуудыг хэрэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн нийгмийн тодорхой бүлэг хүмүүст буюу овог, аймгийн толгойлогч-язгууртан хүмүүст зориулан бүтээсэн дурсгалын хөшөө болох нь тодорхой бөгөөд түүнд дүрслэгдсэн дүрслэл, тахилгын байгууламжийн зан үйлд эртний нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл хийгээд бөө мөргөлийн үзэл санаа гүн шингээсэй байдгаараа онцлогтой (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Волков В.В. Оленные камни Монголии. УБ.: Изд-во АН МНР, 1981

Баярсайхан Ж. Монголын умард нутгийн буган хөшөөд. УБ., 2017

Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Монголын археологийн өв цуврал. VIII-IX боть. Эрхлэн хэвлүүлсэн: Ц.Төрбат. УБ., 2018

Лхагвасүрэн Х., Балжинням Б., Энхтайван Ц. Дэлхий дахинаах монголчуудын түүх, соёлын өв. Тэргүүн боть. УБ., 2018. 335-р тал

Хүн чулуу

Монголын эртний түүхийн дурсгалын нэг үндсэн хэсэг нь хүн чулуун хөшөө юм. Хүн чулууг түүхэн тодорхой цаг үед зан үйл, шүтлэг бишрэл, тэмдэглэлт үйл явдалд зориулан хүний царай төрх, бие галбирыг дүрслэн урласан түүх, урлагийн үнэ цэн бүхий нийт дурсгалуудыг хамруулан үздэг. Манай улсад явуулсан археологийн шинжилгээгээр өдгөө хүрэл, түрэг, уйгур, хятаны үед хамаарах хүн чулуун хөшөөдийг илрүүлэн судалгааны хүрээнд оруулаад байна. Өнөөгийн монгол нутагт нийт 1240 хүн чулуу бүртгэгдсэн ба ЗА, ГА, БХ, АР, ӨВ, БУ, ТӨ, ХЭ, ДО, Сүхбаатар аймагт олон байхаас гадна говийн гурван аймагт маш цөөн тоотой буй. Хүн чулуун хөшөөг урлан босгох нь тэнгэрт халин одсон өндөр өвөг дээдсийнхээ алдар гавьяаг үеийн үед мөнхжүүлэн шүтэн тахил тайлгын шинжтэй, нүүдэлчдийн бөө мөргөлийн шүтлэг бишрэлийн нэгэн хэсэг болох ажээ. Хүн чулууг бүтээхдээ уг хүний амьд ахуйн дүр төрхийг аль болох үнэн зөв дүрслэхийг зорьж, өмсөж эдэлж байсан хувцас хэрэглэлийг нь байсан байдлаар нь цоолборлон урладаг байжээ. Тиймээс хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн дүр төрх, эдийн соёлын шинж чанар, нийгмийн харилцааны тусгал болохоос гадна түүхийг сэргээн судлахад чухал ач холбогдолтой сурвалж болдог байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Өлзийбаяр С. Монгол улсын эртний түүх. Монгол улсын шинжлэх ухаан. Боть 27. УБ., 2009

Монголын хүн чулуу. Монголын археологийн өв цуврал. V боть. Эрхлэн хэвлүүлсэн: Ч.Амартүвшин, Б.Бадма-Оюу. УБ., 2016

Лхагвасүрэн Х., Балжинням Б., Энхтайван Ц. Дэлхий дахинаах монголчуудын түүх, соёлын өв. Тэргүүн боть. УБ., 2018. 138, 147-р тал\

Хүрлийн үеийн хүн чулуун хөшөө

Сүүлийн жилүүдэд манай улсын Алтайн бүс нутгаас хүрлийн үед холбогдох хүн хөшөөд шинээр олдсоор байгаа билээ. Тодруулбал, Ховд аймгийн Булган сумын нутаг Ягшийн хөдөө, Аавын Хөх Уул, Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутаг Шататын бэлчир, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Согоогийн голын Багалзуурын хүн чулуун хөшөөд орно. Судлаачдын тэмдэглэснээр “Төмөрлөг зэвсгийн эхэн үеийн хүн чулуу урлах тогтсон хийц загвар, дүрслэлтэй байсан нь хөгжлийн эртний үедээ хавтгай чулуугаар хүнийг дүрсэлж гаргах юм уу эсвэл хөвөөлөн сийлэн сууж буй байдалтай эр хүний хагас дүр буюу цээжин биеийг нэгэн ижил хөрөг баримал байдлаар уралдаг байжээ. Эдгээр хүн чулуунд ихэнх тохиолдолд хүзүүний зүүлт, бүс, ташуур болон зэр зэвсэг болох “скиф” хэв маягийн байлдааны зээтүү, хоромсого, илд, дуулга, цээжний хос халхавч бүхий дугуй царайтай, мэдэгдэх төдий богино хүзүүтэй, заримдаа хүүхэн хараагүй нүдтэй, зарим тохиолдолд нуман хэлбэрт живэртэй, булчинлаг цээжтэй, тодорхой загварчилж гаргасан далтай, эрхий хуруугаа гозойлгож бусад хуруугаа

сарвайлгасан гартай нүцгэн хүнийг дүрсэлсэн байдаг аж.

Эртний нүүдэлчин овог аймгуудын үлдээсэн ийм хөшөө эсвэл хүн чулуу хүрлийн үеэс Евразийн бүс нутагт тархсан ба ялангуяа манай орны баруун хязгаар Монгол Алтайтай хөрш зэргэлдээ Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны Алтай аймгийн нутагт нэлээд тоогоор илэрсэн байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Анхсанаа Г., Нэргүй О. Алтайн нуруунаас олдсон эртний хүн чулуун хөшөө // Nomadic Heritage Studies Museum Nationale Mongoli. Нүүдэлчдийн өв судлал. Tom XVII. Fasc. 1. Улаанбаатар, 2016

Ковалев А.А., Древнейшие статуи Чемурчека и прилегающих территорий. СПб. 2012

Төрбат Ц., Батбаяр Т. Монгол Алтайгаас илрүүлсэн түрүү төмөрлөгийн үеийн хүн чулуут цогцолбор // Studia Archaeologica. Tom. (IX) XXIX, fasc 8. Улаанбаатар, 2010

Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө

Түрэгийн үеийн хүн чулууд нь манай улсын баруун хязгаараас төв хэсэг рүү өргөн тархсан түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болон оршин байна. Түүнчлэн өнөөгийн байдлаар нийт 600 орчим хүн чулууд илэрч олдон судлагдаад байна. Хүн чулууд нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тухайн үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ төвшнийг илтгэн харуулдаг байна. Хүн чулуу нь загвар зохиомж хийгээд бүтээсэн ур чадварын хувьд харилцан адилгүй бөгөөд зарим хүн чулууг үйлдэхдээ ердийн хавтгай чулуунд хүний нүүр, бие эрхтэн болон эд юмсыг тойм төдий хонхойлгон сийлж гаргасан байна. Ийм хүн чулуу ихэвчлэн “эгэл жирийн” хэмээх багахан байгууламжийн бүрэлдэхүүнд байдаг. Тэгвэл хаад язгууртны дурсгалд зориулсан нарийн зохион байгуулалттай, сүрлэг том тахилын онгоны бүрэлдэхүүнд оруулж тавьсан хүн чулууд нь тун уран нарийн, бодит дүрслэлтэй байдгаараа ялгардаг. Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөнд малгай, гэзэг үс, дээл, бүс, гутал, гоёл чимэг, зэр зэвсэг зэрэг зүйлсийг дүрсэлдэг байна. Иймээс хүн чулуунд дүрсэлсэн эд зүйлс нь тухайн үеийн ёс заншил, эдийн соёлын онцлог, хүмүүсийн дүр төрх зэргийг сэргээн тодруулах нэн үнэ цэнтэй сурвалж болох юм (Б.Амгаланбат).

Ашигласан ном зохиол

Баяр Д. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. Улаанбаатар, 1997

Баяр Д., Эрдэнэбаатар Д. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. Улаанбаатар, 1999

Уйгурын үеийн хүн чулуун хөшөө

Монголын баруун бүсийн нутгаас дэргэдээ тахилын хашлага, амьтны дүрст хөшөө, зэл чулуугүй хоёр гараар хэвлийн өмнө сав барьсан, босоо дүрстэйгээс гадна хоёр чихэвчийг нь дээш сөхсөн дүгрэг малгайтай, олон унжлага зүүлт бүхий бүстэй хүн чулуун хөшөө цөөн тоогоор олдсон нь хийц дүрслэлээрээ Түрэгийн хэмээх хүн чулуун хөшөөнөөс ялгаатай бөгөөд манай судлаачид зэргэлдээ орших Тувагийн нутгаас олдсон VIII-X зууны үед холбогдох зарим хүн чулуудтай харьцуулан үзээд уйгурын үед холбогдуулан үзжээ. Ийм дүрслэлтэй хүн чулуун хөшөө одоогоор Монгол Улсын нутаг дэвсгэрээс судлаачдын баттай олж тогтоосноор найм илэрч олдсоноос Туватай залгаа Баян-Өлгий аймгийн нутагт 7, Увс аймгийн нутагт 2, Архангай аймгийн нутагт 1 тус тус оршиж байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Сэр-Оджав Н. Монголын эртний түүх. УБ., 1977

Баяр Д., Эрдэнэбаатар Д. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. Улаанбаатар, 1999

Очир А., Батболд Г. Бөхмөрөний Уйгур хүн чулуу // Nomadic studies. Bulletin №17, Ulaanbaatar 2010

Хятаны үеийн хүн чулуун хөшөө

Булган аймгийн Ингэт толгойн сангийн аж ахуйн төвөөс зүүн тийш 1 км орчим зайтай Ингэт толгой хэмээх жижиг толгойн өвөрт нэгэн хүн чулуу байдгийг нутгийнхан ард олон “Далха Вандад” хэмээн нэрлэн тахисаар иржээ. Энэхүү хүн чулууны хэмжээ болон хэлбэр хийц, өмсгөл зүүлт нэн өвөрмөц, Монгол нутагт элбэг тархсан VI-VIII зууны Түрэгийн, VIII-IX зууны Уйгарын, XIII-XIV зууны Монголын хүн чулуудаас эрс ялгаатай байгааг харьцуулалт хийж Алс Дорнод, Уссури хязгаараас эртний Зөрчидийн соёлд холбогдох хүн чулуудтай төстэй учир нэгэн үе Монгол нутагт ноёрхлоо тогтоож байсан Хятан нарын соёлын дурсгал хэмээн судлаачид үзсэн байна (Г.Анхсанаа).

Ашигласан ном зохиол

Баяр Д. 1990 онд Булган, Сэлэнгэ, Төв аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний ангийн тайлан. ТХГБС. УБ., 1990

Баяр Д. Ингэт толгойн хүн чулуу // Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах). УБ., 1999

Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуун хөрөг

Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулууд нь манай улсын зүүн урд хэсэг буюу Дорнод Монголын бүс нутагт төвлөн тархсан бөгөөд өнөөгийн байдлаар 85 хүн чулууд илэрч судлагдаад байна.Тэдгээр хүн чулууд дүрслэл болон ур хийц зэрэг зүйлээрээ өөрийн гэсэн онцлог шинжийг агуулна. Хүн чулуудыг түшлэгтэй сандалд суусан байдлаар баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэг, эсвэл өвдөг дээрээ тавин сандал дээр суугаа байдлаар урласан байдаг. Харин хүн чулуудын хэв загвар, зохиомжийн онцлог шинжүүдийг нарийвчлан авч үзвэл эр хүний хөрөг дүрсээс гадна эмэгтэй хүнийг дүрсэлсэн хөшөө байх бөгөөд тэдгээр нь дээл хувцас, эд хэрэглэл болон бие бялдрын ерөнхий төрхөөр хоорондоо эрс ялгаатай ажээ. Дундад эртний чулуунд дүрсэлсэн эд өлгийн соёлын холбогдолтой зүйлс буюу гэзэг үс, малгай, дээл, бүс, гутал, хундага сав, хавтага, хутга, гоёлын ба шүтлэгийн зүйлс, сандал суудал зэргийн хэлбэр хийц маяг нь тун сонирхолтой бөгөөд ер нь хүн чулуунд дүрсэлсэн эдгээр зүйлс нь тухайн ард түмний зан заншил, угсаа гарлыг тогтооход чухал үүрэгтэй билээ. Сүүлийн үеийн судалгаагаар ур хийц болон дүрслэл сайтай хүн чулууд, археологийн олдвор, түүхийн сурвалж зэргээс үндэслэгдэн Юань улсын үед үйлдэгдсэн нь тодорхой болоод байна. Уг хүн чулууд нь монголчуудын түүхэнд холбогдох эд өлгийн болон утга соёлын дурсгал төдийгүй манай өвөг дээдсийн уран ухаан, уйгагүй хөдөлмөрөөр бүтсэн урлагийн бүтээл болохын хувьд Монголын эртний дүрслэх урлагийн алтан санд зүй ёсны байр суурь эзлэх нь дамжиггүй бөгөөд бидний хамгийн эхэнд эрхэмлэн нандигнан дээдлэх дурсгал мөн билээ (Б.Амгаланбат).

Ашигласан ном зохиол

Баяр Д. Монголчуудын чулуун хөрөг XIII-XIV зуун. УБ., 2002

Баяр Д. Дорнод монголын хүн чулуудыг бүтээсэн цаг үе, хийц дүрслэлийн асуудалд. // Journal of Eurasian Studies. Volume III., Issue 2./ April June 2011

Викторова Л.Л. Монголы: Происхождение народа и истоки культуры. Москва, 1980

Какакевич В.А. Намогильные статуи в Дариганге. Материалы МОНК. Вып. 5. Ленинград. 1930

Лүндэв Г., Болорбат Ц., Одсүрэн Д., Сэрхийн далангийн нэгэн хүн чулуун хөргийн тухай. // Studia Archaeologica. Tom XXXII, Fasc.18. УБ., 2012

Амгаланбат Б. Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуудын дүрслэл, он цагийн зарим асуудал. (Магистрын дипломын ажил). УБ, 2019

Тамга тэмдэгтэй хөшөө чулуу

Монголын эртний судлалын нэгэн төлөөлөл болох их бие дээрээ эртний тамга, тэмдгийн зүйл агуулсан хөшөө чулуу монгол нутагт элбэг. Ихэвчлэн байгалийн гонзгой

чулууг гурав болон дөрвөн тал гарган засаж улмаар чулууны гадаргуу хэсэгт эртний овгийн тамга, өмчийн тамга, элдэв дүр дүрслэл, үйл явдлыг сийлж үлдээсэн байдаг. Хэдийгээр энэхүү дурсгалыг өнөө цагт дагнан суурь судалгааг хийгээгүй боловч хавсарга хэлбэрээр сүүлийн жилүүдэд судалгааны эргэлтэд хамрагдаж байна (Г.Бүрэнтөгс).

Гэрэлт хөшөө

Байгалийн чулууг тусгайлан засаж хээр хүрээгээр чимэглэн дээр нь тухайн үед өрнөсөн элдэв хэрэг, үйл явдлыг бичиж тэмдэглэсэн хөшөө чулууг археологийн утга зохиолд гэрэлт хөшөө хэмээдэг. Манай орны түүхийн олон үед хамаарах үйл явдлыг тэмдэглэн бичсэн үлдээсэн гэрэлт хөшөөн цөөнгүй бий. Тухайлбал, Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Хөшөө цайдамын Күл тегин, Билгэ хаан, Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Тоньюкук, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Мөнх хааны дурсгалд зориулсан гэрэлт хөшөөдийг дурдаж болно (Г.Анхсанаа).

Амьтны дүрслэлтэй хөшөө

Манай улсын эртний чулуун дурсгалуудын дотор амьтны дүрсийг бодит эсвэл өвөрмөц байдлаар урласан хөшөөд элбэг. Эдгээр хөшөө нь голчлон түрэг, уйгурын үеийн тахил тайлгын байгууламжийн бүрдэл хэсэг болсон чулуун хонь, арслан, яст мэлхий, заримдаа сүм хийдийн чимэглэл болох бич, нохой зэргийн дүрслэл байдаг (Г.Анхсанаа).

Цулгуй хөшөө

Манай орны баруун болон говийн бүсийн нутгаар ямар нэг хэлбэрт оруулаагүй, дээр нь элдэв зураг дүрслэл, бичиг үсэг сийлээгүй байгалийн чулууг ашиглан ганц нэгээс хэдэн арваар нь хөшөө босгосон байдаг. Ийм цулгуй хөшөөний он цаг, зориулалтын талаар харилцан адилгүй санал дэвшүүлдэг байна. Тухайлбал, зарим судлаачид хүрлийн үед хамааруулан үздэг бол зарим судлаачид түрэгийн хаант улсын үед холбогдуулан үзээд тахил тайлгатай холбоотой зан үйлийг илэрхийдэг байсан бололтой хэмээн тайлбарладаг (Г.Анхсанаа).

7.ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УЛ МӨР БҮХИЙ ДУРСГАЛТ ГАЗАР

Төмөрлөг олборлож, боловсруулж байсан газар

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн төмөрлөг олборлож байсан уурхай болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Төв Азийн өргөн уудам нутаг дээр эдүгээгээс 5 мянга гаруй жилийн тэртээ аж төрж байсан хүмүүс хүрлийг гарган авч амьдрал ахуйдаа хэрэглэж эхэлжээ. Эртний хүмүүс хүрлийн агууламжтай хүдрийг уулын салхи ихтэй онги хөтөл дээр овоолон салхин талаас нь илч ихтэй мод, нүүрсний галаар хөөлгөн гарган авдаг. Үүнийг Монголын түүхэнд “Бух дарах арга” хэмээдэг. Манай ард түмэн төмөрлөгийн агууламжтай орд газрыг таньж мэдэн агуулагдах баялгийнх нь нэрээр нэрлэж ирсэн түүхэн уламжлалтай билээ. Тухайлбал Эрдэнэт, Оюу толгой, Төмөртэй, Зэст, Оюут, Эрдэнэхайрхан гэх мэт нэртэй газар орноос баялаг агууламжтай орд газрууд илэрдэг.

Ийм дурсгалт газар ихэвчлэн хөрсөн дороо төмөрлөгийн агууламжтай уулархаг газраар тохиолддог байна. Манай орны баруун, төв, өмнөд бүс нутгуудаас ийм төрлийн дурсгалт газар илэрч олдоод байгаагаас дурдвал Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгойн эртний зэсийн уурхай гэх мэт газруудыг нэрлэж болно.

Төмөрлөг олборлож байсан эртний уурхайн болон түүнийг боловсруулж байсныг гэрчлэх ул мөр бүхий дурсгалт газрууд нь ихэвчлэн төмөрлөгийн агууламжтай орд газруудтай давхцан оршдог учир уул, уурхайн зориулалтаар ашиглах газарт орж устгагдах аюултай байдгийг дурдах хэрэгтэй (Б.Даваацэрэн).

Ашигласан ном зохиол

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал // Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар

Тодорхой түүхэн цаг үед хүмүүсийн шавраар ахуйн хэрэгцээний сав суулга, барилгын хэрэглэгдэхүүн зэрэг эд зүйлс хийж байсан болон хийсэн зүйлсээ шатаан боловсруулж байсан ул мөр бүхий дурсгалт газрууд хамаарна. Энэ төрлийн дурсгалт газар манай оронд олон биш илэрч мэдэгдээд байгаа боловч бидний өвөг дээдсийн түүх, соёл, аж ахуйн хөгжлийн талаар үнэтэй мэдээлэл агуулсан байдаг онцлогтой.

Шавар бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан газар нь ихэвчлэн шатаах зуух хэлбэрээр илэрч мэдэгддэг ба тэндээс шатаасан болон түүхий барилгын дээврийн тосгуур, нөмрөг, нүүр, вааруудын үлдэгдэл, тоосго, шавар ваар, сав суулганы хагархай хэсгүүд зэрэг олддог байна. Судлаачид хүрэл зэвсгийн түрүү үеэс буюу одоогоос 5-4 мянган жилийн тэртээгээс шавар сав суулгаа шатааж бэхжүүлэх арга технологийг Төв Азийн нүүдэлчин ард түмнүүд эзэмшсэн хэмээн тэмдэглэсэн байдаг. Шавар бүтээгдэхүүний шаварлагийн найрлага, хэлбэр хийц, бат бөх байдал зэрэг нь тухайн бүтээгдэхүүний цаг хугацааг тодруулах баримт болохоос гадна ямар ард түмний хийж бүтээсэн дурсгал болохыг гэрчлэх баримт болдог байна.

Энэ төрлийн дурсгалт газрууд нь хамрах газар нутгийн хувьд их талбай эзэлдэггүй бөгөөд ихэвчлэн хот хэрмийн ойролцоо, томоохон гол мөрний шаварлаг хөрсийг даган байрладаг. Гэхдээ энэ төрлийн дурсгалт газруудын ашиглалтын байдал нь цаг зуурын шинжтэй байх нь их байдаг. Их Монгол улсын нийслэл Хархорум хотын үлдэгдлийг малтан шинжлэх явцад барилгын материал шатааж байсан зуух илэрч олдсон бөгөөд энэ нь байнгын үйл ажиллагаатай байсан байна (Б.Даваацэрэн).

Ашигласан ном зохиол

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал // Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

Газар тариалан эрхэлж байсан газар

Түүхэн тодорхой цаг үед хүмүүсийн газар хагалж, суваг шуудуу татах зэргээр тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газар нутаг хамаарна. Манай орны газар нутаг дээр эрт цагаас аж төрж ирсэн нүүдэлчин түмэн мал аж ахуй голлон эрхлэхийн зэрэгцээ газар тариаланг томоохон гол мөрний сав дагуух үржил шим бүхий газраар тариалан эрхэлж байсан нь сурвалжийн болон археологийн хэрэглэгдэхүүнээр гэрчлэгддэг. Судлаачид Төв Азийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн үеэс буюу эдүгээгээс тав гаруй мянган жилийн тэртээгээс зээтүүт тариалангийн эх үүсвэр тавигдсан гэж үздэг байна. Гэвч эх газрын эрс тэрс уур амьсгалтай монгол нутагт газар тариалан эрчтэй хөгжиж чадаагүй ажээ.

Хүмүүсийн газар тариалан эрхэлж байсныг гэрчлэх ул мөр бүхий газрын хөрс нь тодорхой нэгэн цагт хүний гараар шулуун тууш хэдэн зуун мөр гарган хөндөгдсөн байдаг учир таньж мэдэхэд хялбар байдаг. Зарим тариан талбай руу томоохон гол мөрнөөс суваг шуудуу татаж усжуулсан байдаг. Манай оронд тохиолдож байгаа эртний хүмүүсийн тариа тарьж байсан талбайнууд нь ихэвчлэн Орхон, Сэлэнгэ, Туул, Хэрлэн, Онон, Ховд, Буянт зэрэг томоохон гол мөрний ай саваар байдаг. Гэхдээ эдгээр тариан талбайнууд нь бүгдээрээ нэг цаг үед холбогдохгүй учир хэлбэр хэмжээ, ил мэдэгдэх шинж зэргээрээ харилцан адилгүй. Жишээлбэл эртний шинж бүхий тариан талбайнууд нь хөрсөн дээрх ихэд баларсан мөрний шинжээрээ танигддаг бол хожуу үед холбогдох хагалсан тариан талбай нь харьцангуй дээрх шинж нь тод байдаг.

Тариалан эрхэлж байсан газарт томоохон гол мөрнөөс суваг шуудуугаар дамжуулан ус татаж тариалангийн талбайгаа усжуулж байсан ул мөр их байдаг (Б.Даваацэрэн).

Ашигласан ном зохиол

Энхбат Г., Даваацэрэн Б. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал //

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. УБ., 2008

8. ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР

8.1. Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд
8.2. Палеозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд
8.3. Мезозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд
8.4. Кайнозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд

Монгол улс эртний амьтан ургамлын олдворын нөөц баялаг болон судалгааны үр дүнгээр олон улсын төвшинд бодитой байр суурь эзлэн нэр хүнд нь байнга өссөөр байна . Палеонтологийн дурсгалт газрыг түүхэн хөгжлийн он дараалаар, хронометрийн аргаар эртнийхээс хожуу үе рүү шатлан ангилж судалдаг. Хроностратиграф (аливаа хурдас чулуулгийг нас, тэдгээрийн цаг хугацааны харьцааг судалдаг стратиграфийн салбар) -ийн аргаар геологийн цаг хугацааг Эон, Эрин, Галав, Галчин, Зуун, Хрон гэсэн нэгжүүдэд хувааж олдворт газруудыг энэхүү аргаар системчлэн ангилж байна.

8.1. Кембрийн өмнөх цаг үе буюу архей протерозойн эриний олдворт газрууд

Амьд биет анх үүссэн 3,5 тэрбум жилийн өмнөөс 542 орчим сая жилийн өмнөх цаг үед хамаарах давхраалаг хурдас Монгол орноос өргөн тархацтай илэрдэг бөгөөд амьд биет агуулсан хамгийн эртний хурдас Ханхөхий нуруунаас олдсон нь 2 тэрбум орчим жилийн настай байна. Энэ цаг үед хамаарах нуур, тэнгисийн орчинд дасан зохицон амьдарч байсан ургамал, амьтны үлдэгдэл хэсэг бүхий олдворт газрууд Монгол нутгийн умард мужид арвин, өмнөд хэсэгт хомс тархалттай байна. Строматолит, микрофоссил, сфероморфид, услаг ургамал, зөөлөн биетэн, мөрт малтмал, микробиота, археоциат, трилобит, хиолит зэрэг голлон олддог.

8.2. Палеозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд

Палеозойн (эрт төрмөл) эрин одоогоос 541 орчим сая жилийн өмнөөс эхэлж, 290 орчим сая жил үргэлжлээд, одоогоос 251 орчим сая жилийн өмнө дууссан гэж үздэг . Эх газрын орчинд дасан зохицсон эртний ургамал, амьтны үлдвэр энэ эринээс эхлэн олддог. Олдворт газрууд нь геологийн насаараа Кембри, Ордовик, Селур, Девон, Карбон, Перм гэсэн түүхэн хөгжлийн дарааллаар 6 галавт хуваагдана.

8.2.1 Кембрийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 541 орчим сая жил, дээд хил зааг 458.4 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 55.6 орчим сая жил. Араг ястай буюу сараалжин амьтад олноороо үүсэж амьдрах болсон.

8.2.2 Ордовикийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 485.4 орчим сая жил, дээд хил зааг 443.8 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 41.6 орчим сая жил. Тэнгисийн сээр нуруугүйтэн амьтад, толгой хөлтөн, шүр, хөвд биетэн, мөр хөлтөн, зэрэг болон анхны эрүүгүй загас, доод ургамал, дун, хясаа илэрдэг.

8.2.3 Селурийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 443.8 орчим сая жил, дээд хил зааг 419.2 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 24.6 орчим сая жил. Граптолит, дөрвөн цацрагт шүр табулят, өргөст арьстан, нугалуур хөлтөн, толгой хөлтөн моллюск, трилобит, хөвд биетэн, аварга хавч, эрүүгүй загас, эгэл шивэрс ургамал олддог.

8.2.4 Девоны цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 419.2 орчим сая жил, дээд хил зааг 358.9 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 60.3 орчим сая жил. Тэнгисийн гаралтай хурдаснаас дөрвөн цацрагт шүр табулят, аммонит, өдөт

сэрвээт, хоёр амьсгалтан, царвуу сэрвээт яслаг загас, мөгөөрст загас, нугалуур хөлтөн, хос хавтаст моллюск, трилобит, хөвд биетэн, далайн сараана, бамбайхай, аварга хавч, хөх ногоон болон хаарын замаг, нематофит илэрдэг. Эх газрын хурдаснаас псилофит, эгэл шивэрс, ойм хэлбэртэн, нүцгэн үрт болон анхны үет ургамлууд элбэг олдоно.

8.2.5 Карбоны цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 358.9 орчим сая жил, дээд хил зааг 298.9 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 60 орчим сая жил. Тэнгисийн гаралтай хурдаснаас дөрвөн цацрагт шүр табулят, мөр хөлтөн, далайн зараа, далайн сараана, шилбэт өргөст арьстан, гониатит бүлгийн аммонит, хэвэл хөлтөн моллюск, эртний загас, харин эх газрын анхны сээр нуруутан болох хоёр нутагтан могой хэлбэрт хуягт толгойт- стегоцефал, мөн аварга шавж, ургамлаас ойм хэлбэртэн, лецидофит зэрэг модлог болон шилмүүст ургамлын үлдвэр эх газрын хурдаснаас илэрдэг .

8.2.6 Пермийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 298.9 орчим сая жил, дээд хил зааг 252.17 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 46.73 орчим сая жил. Тэнгисийн гаралтай хурдаснаас фораминифера, дөрвөн цацрагт шүр табулят, мөр хөлтөн, далайн зараа, далайн сараана, аммонит-цератит, хэвэл хөлтөн моллюск, ялтаслаг заламгайт моллюск, хөвд биетэн, хос хавтастан, харин эх газрын анхны сээр нуруутан хуягт толгойт- стегоцефал, рептил, өвсөн тэжээлт котизавр, мөгөөрст хадарган загас, ургамлаас ойм хэлбэртэн, цикад, гинко, зэрэг модлог болон шилмүүст ургамлын үлдвэр эх газрын хурдаснаас илэрдэг.

8.3. Мезозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд

Мезозойн (дунд төрмөл) эрин одоогоос 252 орчим сая жилийн өмнөөс эхэлж, 186 орчим сая жил үргэлжлээд, одоогоос 66 орчим сая жилийн өмнө дууссан гэж үздэг. Триас, Юра, Цэрдийн гэсэн түүхэн хөгжлийн 3 галавт хуваж үздэг.

8.3.1 Триасийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 252.17 орчим сая жил, дээд хил зааг 201.3 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 50.87 орчим сая жил. Тэнгисийн гаралтай хурдаснаас хэвэл хөлтөн моллюск, далайн сараана, толгой хөлтөн моллюск, гастропод, харин эх газрын нөхцөлд анхны белемнит үүсэж улмаар матар, яслаг загас, мөн түүнчлэн хэвлээр явагчид, аварга рептили, плезиозавр, ихтиозавр, анхны өндөглөгч болон уутат хөхтөн амьтан бий болсон. Ургамлаас ойм хэлбэртэн, цикадофит, гинко, шилмүүст модны төрөл зүйлийн үлдвэр эх газрын хурдаснаас илэрдэг.

8.3.2 Юрийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 201.3 орчим сая жил, дээд хил зааг 145 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 56.3 орчим сая жил. Хэвэл хөлтөн, далайн сараана, ялтаслаг заламгайт моллюск, аммонит, хэвлээр явагчид, ихтиозавр, гүрвэл сүүлт шувуу, гүрвэл аарцагт үлэг гүрвэл, стегозавр, мэлхий олддог. Ургамлаас ойм хэлбэртэн, цикадофит, гинко, шилмүүст модны төрөл зүйлийн үлдвэр эх газрын хурдаснаас илэрдэг.

8.3.3 Цэрдийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 145 орчим сая жил, дээд хил зааг 66 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 79 орчим сая жил. Ялтаслаг заламгайт моллюск, далайн зараа, аммонит, хэвлээр явагчид, дэвүүр сүүлт шүдэт шувуу, гүрвэл аарцагт үлэг гүрвэл, шувуу аарцагт үлэг гүрвэл, анхны амьдаар төрөгч ихэст хөхтөн, яст мэлхийн олдвор олддог. Ургамлаас ойм хэлбэртэн, цикадофит, гинко, шилмүүст модны төрөл зүйл, бүрхүүл үртэн, цэцэгт ургамал эх газрын хурдаснаас илэрдэг.

8.4. Кайнозойн эриний ургамал, амьтны олдворт газрууд

Кайнозойн (хожуу төрмөл) эрин одоогоос 66 орчим сая жилийн өмнөөс эхлэн үргэлжилж байна.

8.4.1 Палеогений цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 66 орчим сая жил, дээд хил зааг 23 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 43 орчим сая жил. Олон төрлийн зөөлөн биетэн, яслаг загас, хэвлээр явагчид, хоёр нутагтан, маш олон төрлийн хөхтөн амьтны олдвор олддог. Ургамлаас бүрхүүл үртэн, нүцгэн үртэн ургамал ихээр олддог.

8.4.2 Неогений цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 23 орчим сая жил, дээд хил зааг 2.58 орчим сая жил, үргэлжлэх хугацаа 20 орчим сая жил. Энэ цаг үеийн хурдаснаас хос хавтаст моллюск, далайн зараа, хөхтөн амьтнаас хошуутан, буга, тэмээ, гиппарион, адуу, зээр, хирс, мэрэгчид, дэвүүрт шувуу олддог.

8.4.3 Дөрөвдөгчийн цаг үед хамаарах олдворт газруудын геологийн насны доод хил зааг 2.58 орчим сая жилээс одоог хүртэл үргэлжилж байна. Энэ цаг үед хүн үүссэн, цаг агаар олон дахин огцом өөрчлөгдсөн. Орчин цагийн ургамал, амьтан бүрэлдэн бий болсон .

Ашигласан ном зохиол

Барсболд Р., Бямба Ж. Монголын геологи ба ашигт малтмал. II боть. Палеонтологи. УБ., 2011

Бямба Ж., Энхбаатар Б. Стратиграфийн үндэс. УБ., 2017

Доржнамжаа Д. нар Монгол орны регионал стратиграфи. УБ., 2017

Доржнамжаа Д., Цогтбаатар Х. Палеонтологи, геологийн түгээмэл нэр томьёоны тайлбар толь. УБ., 2019

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад. Гарын авлага. УБ., 2008

Benton M.J. Vertebrate paleontology. Oxford. 2005

УЛСЫН ХАМГААЛАЛТАД БАЙХ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ

Архангай аймаг
1. Луу гүний хүрээний цогчин дуган
2. Худгийн толгойн Хүннүгийн оршуулгын газар
3. Цацын дэнжийн цогцолбор дурсгал
4. Алтан сандал уулын цогцолбор дурсгал
5. Баянцагааны хөндийн буган чулуун хөшөөд
6. Тайхар чулуу
7. Талын гурван хэрэм
8. Балгасан тал (Гол мод-2)-ын Хүннүгийн язгуартны оршуулгын газар
9. Их Жаргалантын цогцолбор дурсгал
10. Дадгын өвөлжөөний хүн чулуун хөшөөд
11. Хөшөө Цайдмын цогцолбор дурсгал
12. Баянголын амны “Дөрвөлжингүүд” гэх булш
13. Дойтын толгойн туурь
14. Хар балгас
15. Булган уулын бурхадын зураг
16. Зая гэгээний хийдийн цогцолбор
17. Гол модны Хүннүгийн язгуартны оршуулгын газар
18. Хархул хааны балгас

ЛУУ ГҮНИЙ ХҮРЭЭНИЙ ЦОГЧИН ДУГАН, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Архангай аймгийн Батцэнгэл сумын төвд орших Луу гүний хүрээний Цогчин дуган нь хуучны Сайн Ноён хан аймгийн Лу гүн хэмээн олноо алдаршсан Лувсанхайдавын хошууны нутагт харьялагдах Тарвачэнболин хийдийн төв барилга юм. Цогчин дуганг 1751-1800 он хүртэл хооронд барьж дуусан үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Тус хийдийн Цогчин дуган буддын сүм хийдийн барилгын өвөрмөц архитектуртай юм. Луу гүний хүрээ нь 1937 онд сүм хийд хаагдахад 170 гаруй ламтай байсан гэж архивын материалд тэмдэглэжээ. Уг барилгыг 2013 онд Нутгийн иргэдийн оролцоотойгоор сэргээн засварласан байна.

ХУДГИЙН ТОЛГОЙН ХҮННҮГИЙН ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Батцэнгэл сумын төвөөс 30 км орчим зайд, Худгийн Толгой хэмээх газарт Хүннүгийн үед холбогдох 306 булш бүхий оршуулгын газар байна. Дурсгалыг 1980-1982 онд Монгол-Зөвлөлтийн хүрэл ба төмөр зэвсгийн дурсгал судлах анги, 1987 онд Монгол-Унгарын археологийн шинжилгээний анги тус тус малтан судалжээ. 1987 онд малтсан хоёрдугаар булшнаас ар талдаа 16 үсэгтэй цац хүрэл толь олдсон бөгөөд энэ нь хүннүгийн үеийн булшнаас гарсан анхны бүтэн толь юм.

ЦАЦЫН ДЭНЖИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Их Тамир сумын төвөөс 10 км Хойд Тамирын голын ар дэнж Цацын эрэг гэдэг газарт 14 буган хөшөө, тахилын цогцолбор бүхий дурсгал

байна. Буган хөшөөдийн ихэнхийг анхны байрлалаас хөдөлгөж, дөрвөлжин булш зэрэг өөр дурсгалд ашигласан байна. Эдгээр хөшөөд нь бугын хийсвэр дүрслэлтэй ба цагираг ээмэг, чинжаал, дэгээ, нум, сум бүс зэрэг нийтлэг дүрслэлүүдтэй.

АЛТАН САНДАЛ УУЛЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Их тамир сумын нутаг Хойд тамир голын хөндийд сумын төвөөс баруун зүгт 15 км зайд тэгш оройтой уулыг Алтан сандал гэж нэрлэнэ. Энэ уулаас баруун хойш 1 км зайд жижиг довцог дээр дугуй болон дөрвөлжин хүрээтэй хоёр хиргисүүр, дөрвөлжин булш 8 байх ба энэхүү цогцолборт дөрвөлжин булшинд авч ашигласан 7 буган хөшөө бий. Эндэхийн нэгэн буган хөшөөнөө том толгойтой, соотон чихтэй гурван адууг уран нарийн сийлсэн байдаг.

БАЯНЦАГААНЫ ХӨНДИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Архангай аймгийн Их Тамир сумын төвөөс зүүн хойш 20 гаруй км зайд Баянцагааны хөндийд түүхийн олон үед холбогдох булш, хиргисүүр, буган хөшөө, дөрвөлжин булш, Түрэгийн үеийн тахилын онгон зэрэг дурсгалууд бий. Энэ хөндийгөөс харьцангуй бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн нийт 18 буган хөшөө одоогоор бүртгэгджээ. Эдгээрийн ихэнх нь бугын хийсвэр дүрслэлтэй хөшөөд бөгөөд нэгэн хөшөөнөө бугаас гадна аргал, янгир зэрэг амьтдыг сийлжээ.

ТАЙХАР ЧУЛУУ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол/2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Ихтамир сумын нутагт Цэцэрлэг хотоос 22 км зайд, Хойд Тамир голын захад байрлах Тайхар чулуу нь 18 м өндөр бөгөөд боржин чулуунаас бүтсэн цохио юм. Тайхар чулуун дээр түүхийн олон үед холбогдох зос, сийлмэл зураг дүрс, тамга тэмдэг, руни, монгол, хятад, уйгур, согд, төвд зэрэг олон хэлээр бичсэн 150 гаруй бичгийн дурсгал бий. Бичээснүүд дотроос хамгийн олон нь 70 орчим тоотой Монгол бичиг юм. Тайхар чулууны түрэг бичээс нь улаан, хар өнгийн зосоор эртний түрэг үсгийн бичмэл хэлбэрийг хадгалан үлдсэнээрээ онцлог.

ТАЛЫН ГУРВАН ХЭРЭМ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Архангай аймгийн Өгийнуур сумын төвөөс баруун хойд зүгт 21 км орчим зайд, Хэрмэн тал хэмээх газар уг дурсгал оршино. Тухайн дурсгалыг XIX зууны сүүлчээр Оросын эрдэмтэн Д.Клеменц олж үзээд Хэрэйд (аймаг)-д холбогдох хот хэмээн тодорхойлсон байна. Харин дурсгалыг 2014 онд Нүүдлийн соёл иргэншлийг судлах Олон улсын хүрээлэн “Монгол Улсын нутаг дахь эртний нүүдэлчдийн археологийн хайгуул, судалгаа” төслийн хүрээнд НТӨ 170-НТ 10 оны хооронд Хүннү нарт холбогдохыг дээжийн шинжилгээ болон сурвалжийн мэдээнд тулгуурлан тогтоожээ. Дурсгалт газар нь Булган аймгийн Баяннуур сумын Улаан хэрэм, Архангай аймгийн Батцэнгэл сумын Халзан голын зүүн биед буй байгууламж, Бор азаргын хэрэм зэрэгтэй гадаад зохион байгуулалтаараа адил байна.

БАЛГАСАН ТАЛ (ГОЛ МОД-2)-ЫН ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвөөс

зүүн хойш 60 км зайд Хануйн голын хөндийтэй нийлэх Гол модны аманд, Балгасан тал хэмээн газарт Хүннүгийн 450 гаруй булштай язгуартны бүлэг оршуулгын газар оршин байна. Булшнууд баруунаас зүүн тийш цуварсан байдалтай бөгөөд 2.2 км урт, 1.3 км өргөн талбайг эзэлнэ. Булшны гадаад зохион байгуулалт нь чулууг ашиглан дөрвөлжин хэлбэрээр өрсөн, өмнө талд залгуулан байгуулсан урт үүдэвчтэй. Дурсгалыг 2001 онд Монгол-Америкийн хамтарсан “Хануйн хөндий” төслийн хээрийн шинжилгээний анги хайгуулын явцад илрүүлж, булшнуудын байрлал зүйн дэвсгэр зургийг үйлджээ. 2002-2011 оны хооронд Улаанбаатарын Их сургуулийн судлаачид тус оршуулгын газрын хамгийн том хэмжээтэй болох 1-р булш болон түүний дагуул 30 булшийг малтан шинжлэх ажлыг хийж, олон төрлийн хосгүй үнэт олдвор нээн илрүүлжээ.

ИХ ЖАРГАЛАНТЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвөөс зүүн хойш 46 км орчим зайд, Жаргалантын ам хэмээх газар олон тооны тахилгын байгууламж, буган хөшөөд, хиргисүүр, дөрвөлжин хэлбэрийн булш бүхий цогцолбор дурсгал бий. Эрт үед эдгээр тахилгын байгууламж дунд босгосон буган хөшөөдийг хожим дөрвөлжин булшны хана, дараасанд олноор нь авч ашигласан байсныг судлаачид тогтоожээ.

Энд анхны байрлалаас нь хөдөлгөөгүй гурван том буган хөшөөнөөс гадна гурван дөрвөлжин булшинд ашигласан 22 буган хөшөөг малтан илрүүлсэн байсныг 2009 онд тахилгын байгууламжууд дунд буцаан сэргээн босгожээ. Буган хөшөөдийн дундаж өндөр нь 160-170см, зузаан нь 15-20см хэмжээтэй бөгөөд шаргал өнгийн боржин болон хар хөх өнгийн занар чулуу ашиглан хийжээ. Жаргалантын амны 3-р хөшөө 389х68х48см хэмжээтэй, 5 тонн орчим жинтэй төдийгүй буган хөшөөний соёлд хамгийн олон буюу 68 бугыг нэгэн хөшөөнөө дүрсэлснээрээ нэн чухал дурсгалт газар юм.

ДАДГЫН ӨВӨЛЖӨӨНИЙ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Тариат сумын төвөөс баруун зүгт 24 км орчим зайд, Тэрх багийн нутаг Дадгын булаг гэдэг газар Түрэгийн үеийн 2 ширхэг хүн чулуун хөшөө, тахилын онгон бий. Хөшөөдийг цайвар сарал өнгийн боржин чулуугаар урлажээ. Тухайн хүн чулууд нь хадгалалтын хувьд бүтэн үлдсэн ба түрэгийн үеийн эдийн соёлын судалгаа болох зүүлт чимэглэл, хувцас урлал, зэр зэвсэг зэргийг судлахад чухал үнэн цэнтэй дурсгал юм.

ХӨШӨӨ ЦАЙДМЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн хурлын 2 дугаар зүйл/1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө цайдам хэмээх газарт Түрэгийн Билгэ хаан, түүний дүү төрийн нэрт зүтгэлтэн Кул-тегин жанжин нарт зориулсан тахилын онгоны цогцолбор дурсгал байна. 1889 онд Оросын эрдэмтэн Н.М Ядринцев Орхон голын хөндийд хөндийд орших аварга том хөшөөдийг нутгийн ардын тусламжтайгаар илрүүлж, шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна. Монгол Туркийн хамтарсан судалагааны баг “Монгол дахь Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах, судлах сэргээн засварлах” төслийн хүрээнд тахилын онгоныг малтан судалж, 4000 гаруй үнэ цэн бүхий олдор, эд өлгийн зүйлс илрүүлжээ. 2010 онд дурсгалт газрыг хамгаалах, судлах, сурталчлах үүрэг бүхий Хөшөө Цайдам музейг дурсгалт газар түшиглэн байгуулсан юм. Энэхүү дурсгалт газар нь 2004 онд Дэлхийн өвд соёлын ангиллаар Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд багтжээ.

БАЯНГОЛЫН АМНЫ “ДӨРВӨЛЖИНГҮҮД” ГЭХ БУЛШ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Хотонт сумын нутагт, Орхон голын хойно, Дунд Хутаг уулын арын салбар уулуудаас хойш буусан амнуудад өвөрмөц зохион байгуулалт бүхий сонин дурсгалууд байсныг 1998 онд илрүүлэн олсон юм. Сүүлийн үеийн судалгаагаар энэхүү дурсгалт газар нь Уйгарын үед холбогдох, бунхант булш болохыг тогтоожээ.

ДОЙТЫН ТОЛГОЙН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Хотонт сумын төвөөс зүүн хойд зүгт 20 орчим км зайд Шорвог, Хунт, Дойт, Цагаан, Цэцэг нууруудын дунд холын бараа сайн харагдах Дойтын толгойн оройд энэхүү дурсгал оршино. Дойтын толгойн эртний хотын туурийг Өгөдэй хааны “Гэгэ-чаган орд” мөн болов уу гэж монгол, японы археологчид үзсэн байна. Юан Улсын судрын Тайзугийн бүлэгт “Өгөдэй 9-р он, улаан тахиа /1237/ жилийн зун Цэцэг цагаан нуурт авалжээ. Зуны дөрвөн сард Саолин /суурин/ хотыг цогцлоод Гэгэ-чаган харш байгуулжээ” хэмээгээд уг ордон нь Хархориноос умар зүг 70-аад /40км/ ли зайтай байрладаг гэжээ. Энэхүү дурсгалт газар нь 2004 онд Дэлхийн өвд соёлын ангиллаар Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд багтжээ.

ХАР БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хотонт сумаас зүүн хойд зүгт 16 км орчим зайд, Орхон голын баруун хөндийд Уйгарын Эзэнт гүрний нийслэл Ордубалуйк буюу нутгийн ардууд Хар балгас хэмээн нэрлэдэг эртний хотын туурь бий. Хар балгасын барилга байгууламж бүхий суурин эдэлбэр газар нь 32 кв, км талбайг эзлэн оршино. Эртний судлалын бичиг судрын мэдээнд, Хар балгас нь Уйгарын хааны төрийн өргөө, төрийн яам, гар үйлдвэр, худалдааны хороод, шашны сүм, бэхэлсэн цайз хэрмээс бүрдэх их хот байсан талаар дурджээ. Энэхүү дурсгалт газар нь 2004 онд Дэлхийн өвд соёлын ангиллаар Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд багтжээ.

БУЛГАН УУЛЫН БУРХАДЫН ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Архангай аймгийн төвийн хойморт орших Булган хэмээх хангайн үзэсгэлэнт сүрлэг уулыг 1965 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 17 дугаар зарлигаар дархалжээ. Хангайн гол их ноён нуруунаас салбарлан зүүн хойш чиглэж , Хойд, Урд Тамир голын хоорондуур, усны хагалбар болон үргэлжилсээр хоёр Тамирын бэлчир хүрч шувтарсан 130-140 км урт Сүмт-хан Өндрийн нурууны дорнот хэсэгт Булган уул оршдог. Булган уулын энгэр хаднаа Богд Зонхов тэргүүтэй, Жанрайсэг, Жанцав, Дармаринчен, Хайдав Гэлэгбалсан, Ловон Бадамжунай, Авид бурхадын хөргийг өнгө ялган будаж дүрслэн бүтээсэн нь одоо хэр тодоор үлдсэнээс гадна уйгуржин монгол, төвд зэрэг бичиг үсгээр хад чулуунд нь сийлсэн бичгийн дурсгалууд байна.

ЗАЯ ГЭГЭЭНИЙ ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын

тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Эрдэнэбулган сум, аймгийн төвийн хойд Булган уулын урд бэлд энэхүү дурсгалт газар оршино. Зая бандида Лувсанпэрэнлэй 1679 оны өвөл Төвөдөөс нутагтаа ирээд бурханы шашныг дэлгэрүүлэх, сүм хийд байгуулах, ном бүтээл туурвих ажлыг эхэлж, 1631 онд суурь нь тавигдсан Заяын хийдэд Гүнрэг, Агва, Чойр, Жанрайсэг, Ханцан гэсэн 5 дацанг байгуулж, байнгын хуралтай болгон Манжийн хаанаас ”Гандангэжайлин” буюу “Төгс баясгалант буяныг дэлгэрүүлэгч” нэрийг авч өргөжүүлснээр Заяын хүрээ байгуулагджээ.

Заяын хүрээний төлөвлөлт нь уулын өвөр талын бага зэргийн налуу энгэрт уламжлалт “хүрээ” төлөвлөлтийн дагуу урагшаа задгай, бүх барилгын үүдийг урд зүг рүү харуулж, төвд нь Зая бандида Лувсанпэрэнлэйн Лавран ордон, ордны хэрмийн баруун хойдхон талд Цогчин дуганг байгуулж, хоёр гол байгууламжийн ар тал болон баруун, зүүн талаар бусад сүм дуган дацанг төлөвлөсөн байжээ.

Эдүгээ Заяын гэгээний хийдийн цогцолбор гэдэгт аймгийн музей байрлаж буй Гүдэн сүм болон Баруун, зүүн Сэмчун, Цогчин дуганы үлдэгдэл, шашин номын хурлын үйл ажиллагаатай Сандуй хувилгааны дуган зэрэг нь багтаж байна.

ГОЛ МОДНЫ ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт, Хангайн нурууны салбар болох Бөхөн шар уул ар бэлд Хүннүгийн 492 булштай язгууртны бүлэг оршуулгын газар оршино. Оршуулгын газрын дийлэнх булш нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн язгууртны булшнууд ажээ. Гол модны дурсгалт газрыг Ц.Доржсүрэн 1956 онд хайгуулын явцад илрүүлж, тухайн жилдээ 26 дагуул жижиг булш малтан судалсан байна. Хожим Монгол-Францын хамтарсан шинжилгээний анги 2000-2005 оны хооронд ажилласан бөгөөд малтлага судалгаа хийсэн булшнууд эрт цагт тоногдож сүйтгэгдсэн байсан хэдий ч хүннү нарын оршуулгын зан үйл, аж ахуй, соёл, гадаад харилцааны түүхийг нэхэн тодруулахад чухал ач холбогдолтой олон арван шинэ хэрэглэгдэхүүн илэрч олджээ. Тэдгээрээс 20-р булшнаас адууны толгой, бугын биетэй, салаа туурайтай, духан дээрээ ганц эвэр бүхий “бэлгэт гөрөөс” хэмээн нэрлэдэг домгийн амьтны дүрстэй эмээлийн хударга, хөмөлдрөгийн алт шармал мөнгөн чимэг илэрсэн байдаг. Тухайн дурсгал нь хангайн бүсийн нутагт орших хүнүүгийн язгууртны томоохон оршуулгын газрын нэг билээ.

ХАРХУЛ ХААНЫ БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Эрдэнэмандал сумаас урд зүгт 7 км орчим зайд, Алаг уул багийн нутаг Хануйн голын урд хөндий Тойром нуурын хойд талд сүүл толгойн зүүн хормойд Хар хул хааны балгас нэртэй хотын туурь бий. Хэрэм нь дөрвөн талдаа хаалгатай хаалга тус бүрийн 2 талд харуулын цонж өндөрлөгтэй, хэрмийн 4 буланд харуул цонжтой хэрмийн гадуур суваг шуудуутай хэрмэн дотор том жижиг 10 орчим барилга байгууламжын дөрвөлжин хэмтэй суурь байна. Хэрмийн дотор хойд хэсэгт голлон хамгийн том барилга байгууламжын суурь бий. Суурыг дөрвөлжин хэлбэртэй шар шавар шороог дэлдэж гадуур нь хавтгай дөрвөлжин боржин чулуу тоосгоор олон давхар өнгөлөн өрсөн байна. Хэрмийн дотор талд тоосго, барилгын ваарны хагархай элбэг байна. Тухайн дурсгалыг судлаачид XIII-XIV зууны үед холбогдуулжээ.

Баян-Өлгий аймаг
1. Цагаан Хөшөөтийн хүн чулуун хөшөө
2. Бугат Эрээн Харганатын хөшөө
3. Хөлцөөтийн хадны зураг
4. Ногооннуур сумын төвд орших хүн чулуун хөшөө
5. Ямаат Улаан уулын хүн чулуун хөшөө
6. Даяннуур орчмын хүн чулуун хөшөө
7. Бага Ойгорын хадны зураг
8. Хар ямаатын голын хүн чулуун хөшөө
9. Арал толгойн хадны зураг
10. Билүүтийн хадны зураг
11. Могойтын рашааны хүн чулуун хөшөө
12. Цагаан голын цогцолбор дурсгал
13. Шивээт Хайрханы хадны зураг

ЦАГААН ХӨШӨӨТИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын төвөөс зүүн урагш 13 км орчим зайд, Ховд голын баруун эргийн дэнж дээр Уйгурын үед холбогдох нэгэн чулуун хөшөө байна. Уг хүн чулуу нь чихэвчийг нь дээш сөхсөн дүгэргэн малгайтай, дугуйрсан хөмсөг, шулуун урт хамар зэргийн үргэлжилсэн товгор байдлаар дүрсэлжээ. Баруун талынх нь нүд холцорч бүдгэрсэн, зүүн талынх нь нүднээс үзэхэд уртавтар зууван, давхар хүрээ гарган зовхийг нь тодруулсан зураастай. Үзүүр нь ялгүй дээш эргэсэн нум хэлбэрийн живэр сахалтай, ам, уруулыг нэлээд бодитой дүрсэлсэн байна. Хоёр чихийг нь тал агираг хэлбэрээр дүрсэлсэн бөгөөд ээмэггүй юм. Мөн хоёр гараа тохойгоороо нугалан дэрвэгэрдүү амсартай урт хүзүүтэй, цүлхэн бөөртэй, тэгш суурьтай ваар савыг хоёр бөөрнөөс нь шахаж барьсан бөгөөд хуруунуудыг тодорхой сайн дүрсэлжээ. Дээлийн энгэр заам, ханцуйн зураас мэдэгдэхгүй боловч товруун чимэггүй нарийвтар бүс бүсэлж, хоёр ташаандаа нэжгээд дүгрэг хавтага унжуулсан нь доороо нарийн унжуулгатай. Түүнчлэн бүснээс баруун талдаа гурав, зүүн талдаа хоёр шулуун унжлага унжуулснаас гадна зүүн ташаанд хавтаганы хойгуур махир үзүүртэй мөн нэг уртавтар зүйл унжуулжээ.

ЭРЭЭН ХАРГАНАТЫН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Бугат сумын төвөөс зүүн урагш 9 км зайд, Хар хатуугийн голын баруун эрэг, Нохой хуцдаг уулын баруун бэлд, Эрээн харганат хэмээх газарт түрэгийн үеийн руни бичгт хөшөө оршин байна. Хөшөөний дөрвөн талыг нь тэгш зассан гялгар хар чулуугаар хийсэн энэ хөшөөний нүүрэн талын дунд хэсэгт газраас дээш 80 см өндөрт 17 үсэг тэмдэгт бүхий руни бичээс сийлжээ. Бичээсийг Ц.Баттулга Монгол хэлнээ “Гүнж /ийг/ илгээсэн хүн нь өшив” хэмээн орчуулжээ. Тэрээр эртний нүүдэлчдийн дунд хөрш зэргэлдээх овог аймаг, улс оронтой найрамдалт харилцаатай байхын бэлгэдэл болгон хаад язгууртан нар ураг барилдах ёс түгээмэл байсан ба Түрэгийн нэгэн язгууртан гүнжээ тийнхүү илгээх зуур хүргэгчдээс нэг нь өш санаж хөнөөснийг тэмдэглэсэн бололтой гэжээ. Бичээсний он цагийг Түрэг улс Тан улсын эрхшээлд байсан үе буюу 630 оноос хойш бичигдсэн хэмээн үздэг.

ХӨЛЦӨӨТИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий

аймгийн Буянт сумын нутаг, Цэнгэл хайрханы оргилын баруун биеэс эх авч зүүн урагшаа урсах Хойд Хөлцөөтийн голын хөндий мөнх цастай өндөр уулаар хүрээлэгдсэн хавцал, хад чулуу ихтэй бөгөөд голын эрэг рүү шахаж тогтсон хүрэн өнгийн хад цохионоо олон тооны зураг сийлжээ. Хадны зургуудыг ихэвчлэн уулын хормойд тогтсон хадархаг толгойн энгэр талын хаданд, голд түрж тогтсон голын эрэг, голын хоёр талын дэнжийн унамал хаднууд дээр сийлсэн байна. Харьцангуй жижиг талбайд олон дүрс сийлэх, хуучин дүрсийг сэргээж байсан ул ором, эртний зургийн дээрээс дарж давхардуулан сийлсэн байгаа нь уг газарт хадны зургийг түүхийн урт хугацааны туршид тасралтгүй урлаж ирснийг гэрчилнэ. Хойд Хөлцөөтийн хаднаа амьтдын дүрсийг бүх талбайгаар нь хонхойлгон эсхүл гадаад тэгийг хөвөөлөн цохиж гаргасан, мөн нарийн үзүүртэй багажаар сийлсэн зураг ч бий. Хойд Хөлцөөтийн хадны зурагт янгир, аргаль, буга, үхэр зэрэг амьтдын дүрсийг олон янзын арга барил, хэв маягаар дүрсэлсэн байна.

НОГООННУУР СУМЫН ТӨВД ОРШИХ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын төвд хоёр хүн чулуу байдаг бөгөөд тэдгээрийг сумын төвөөс урагш орших Ямаат Улаан орчмоос авч ирсэн гэдэг. Нэг дэх хүн чулууг нь цайвар саарал өнгийн боржингоор босоо хүний дүрс оруулан урласан. Цээжинд хувцасны зах гаргаагүй бөгөөд хоёр гараа тохойгоор нугалан гэдэсний өмнө шулуун хүзүүтэй тэгш ёроолтой цүндгэр ваарыг хоёр бөөрнөөс нь дэмнэн барьжээ. Бүс болон зэвсэг зүүлт байхгүй. Хоёр дахь хүн чулууг улбар шар өнгийн боржингоор босоо хүний дүрс гарган хийжээ. Толгойд нь хавтгай оройтой, урдаас нь харахад бортого хэлбэртэй малгай өмсгөжээ. Цээжинд нь доош унжсан хоёр хөх гаргасан нь эмэгтэй хүний дүрс болохыг гэрчилнэ. Хоёр гараа тохойгоор нугалан цээжний өмнө ямар нэгэн сав барьж байсан бололтой бөгөөд чулууны гадарга гэмтсэнээс уг савын хэлбэр, гарын хуруу мэдэгдэхгүй болжээ.

ЯМААТ УЛААН УУЛЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ногооннуур сумын төвөөс урд зүгт орших Ямаат улаан уулын эргэн тойронд нийтдээ 100 гаруй булш, 50 орчим хиргисүүр, тахилгын онгон, хүн чулууд бүхий бүлэг дурсгал бий.

ДАЯННУУР ОРЧМЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Даян нуурын эрэгт VI-VIII зууны үед оршин тогтнож байсан эртний Түрэгийн үед холбогдох нэгэн хүн чулуун хөшөө байдгийг нутгийнхан “Даян баатрын хөшөө” хэмээн нэрлэдэг. Энэ хөшөөнд хүний толгой их биеийг дүрсэлсэн боловч гар, хөлийг дүрслээгүй байна. Тэгэхдээ малгай, ээмэг бүхий чих, нүд хөмсөг, хамар, ам, живэр сахал, хацрын төвгөр зэргийг нарийн гаргажээ. Их биед нь мөрөвч, бүс хувцасны эмжээр чимэглэл болон хүзүүнд нь сахиус бололтой дэвж буй шувуу хэлбэрийн зүйлийг зүүлт болгосон байна. Судлаачид энэхүү хүн чулуун хөшөөнд дүрсэлсэн сахиусны хэлбэрийг VI-VIII зууны эртний түрэг угсааны аймгуудын дунд “христос” шашин дэлгэрч байсантай холбон тайлбарладаг.

БАГА ОЙГОРЫН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол

Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Бага Ойгор, Цагаан салаа голын савд олон тооны хадны зураг оршино. Алтай Таван Богдын зүүн сугаас эх авч урсах Цагаан Салаа, Бага Ойгорын голын хөндийд Монгол-Америк-Оросын хамтарсан хадны зураг судлах анги 1995-2000 онд ажиллаж 15 км орчим талбайд тархсан, арван мянга гаруй хадны зургийн зохиомжийг илрүүлэн олж судалжээ. Хадны зургийг голын хөндийн том жижиг төрөл бүрийн хаданд цоолборлосон зурсан байдаг. Хадны зургийн нэгэн зохиомжид ганц хоёроос эхлээд нэг зуу гаруй зургийг тоймлож дүрсэлсэн байх ба дунд ч нь 10-30 зурагтай байдаг байна. Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зургийн хамгийн эртнийх нь палеолитын үед хамаарах арслан заан, үхрийн толгой зэргийг дүрсэлсэн цөөн тооны зураг байдаг. Зургийн үндсэн хэсэг болох арваад мянган зохиомж нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед хамаарах юм. Харин дундад зууны үед хамаарах цөөн тооны зураг бас байна. Бага ойгорын хадны зургийн дурсгалт газар нь нь 2011онд Дэлхийн өвд соёлын дурсгалт газрын ангиллаар бүртгэгдсэн Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газрын нэг хэсэг юм.

ХАР ЯМААТЫН ГОЛЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Хар Ямаатын голын хөндийд эртний Түрэгийн үед холбогдох нэгэн хүн чулуу бий. Уг хүн чулууг нимгэн хавтгай чулуудыг ирмэглэн суулгаж үйлдсэн дөрвөлжин хашлаганы зүүн талд нүүрээрээ зүүн урагш хандсан байдалтай газарт зоолттой байрлана. Хүн чулуунаас зүүн урагш балбал чулууг зэллүүлэн зоосон байна. Хүн чулууг цайвар судалтай хөх өнгийн нимгэвтэр хавтгай занар чулуугаар хүнийг уран нарийн дүрслэлтэйгээр урлажээ. Баруун гараа хагас нугалан хэвлийн өмнө дэрвэгэрдүү амсар, цүлхэн бөөр, бөөрөнхий ёроолтой жижиг ваар барьж зүүн гараар цээжний өмнө махир үзүүртэй чинжаал хутгыг үзүүрээр нь дээш харуулан атгажээ. Хөшөөний хамгийн сонирхолтой дүрслэл нь бүсэлхийнээс нь дооших хэсэгт буй эмээл хазаартай хоёр морийг цулбуураас нь хөтлөн сөхөрч суусан хоёр хүний дүрс юм. Морины нуруунд эмээлийн бүүрэг тодорхой мэдэгдэх бөгөөд морьд нь жижгэвтэр толгойтой, зэгзгэр урт хөлтэй, газар шүргэсэн урт сүүлтэй ажээ.

АРАЛ ТОЛГОЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Монгол Алтайн нурууны ноён оргил Алтай Таван Богд уулын өвөр бэлээс эх авсан Хар салаагийн гол, Рашааны гол хэмээх хоёр голын хооронд тогтсон намхан толгойг Арал толгой гэнэ. Арал толгойн өвөр болон орой хэсгийн хэвтээ хаднаа олон тооны амьтдын зургийг хонхойлон цохиж сийлсэн байх бөгөөд ихэнх хэсэг нь буюу 90 орчим хувь нь зэрлэг ан амьтан ба ан агнууртай холбоотой байхад зөвхөн 7 орчим хувь нь мал, мал аж ахуйтай холбоотой байна. Иймээс Арал толгойн хадны зураг үндсэндээ эртний анчдын бүтээсэн дурсгал болох нь илэрхий юм. Тус газрын хадны зургийн хамгийн эртнийх нь томоор дүрсэлсэн тэмээн хяруул, адууны дүрс бүхий зохиомжууд, буга, үхрийн зураг бөгөөд зарим зургийг зориуд гүйцээлгүй дутуу орхисон байна. Арал толгойн хадны зургийн дурсгалт газар нь 2011онд Дэлхийн өвд соёлын дурсгалт газрын ангиллаар бүртгэгдсэн Монгол Алтайн нурууны хадны зургийн дурсгалт газрын нэг хэсэг юм.

БИЛҮҮТИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын

нутаг Хотон нуурын хойд хөвөөнд оршино. Энэхүү дурсгалт газрыг Далан түргэний хос толгойн ч гэж нэрлэдэг. Судалгааны үр дүнд хооронд холгүй орших хоёр толгойн 700 гаруй хаднаа 7000 гаруй зураг, дүрслэл байгаа нь тогтоогджээ. Дүр дүрслэл талаас авч үзвэл янгир хамгийн олон дүрслэгдсэн байна. Мөн буга, аргаль, үхэр, адууны дүрслэл голлоно. Амьтдын дүрсээс харахад шүтлэгийн шинж тэмдэг бүхий зураг дүрслэл байгаа нь хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн ертөцийг үзэх үзэл, зан заншил, шүтлэг бишрэл, бэлгэдэл зүйн асуудлыг тодруулахад чухал нөлөөтэй юм. Амьтан шүтлэгийн зэрэгцээгээр ан агнуурын гол тусгал болсон олон тооны зурагтай. Ан агнуурт хүрэл болон төмөр зэвсгийн үед нум сум, жад голлон хэрэглэж ганцаар болон хоёр гурваараа, мөн олуулаа зээглэн агнах хэлбэр давамгайлж байсныг тодорхой зохиомжуудаас харж болно. Энд буй хадны зургууд нь неолит, хүрэл зэвсэг, төмөр зэвсгийн түрүү үе, дундад эртний улсуудын үед холбогдоно.

МОГОЙТЫН РАШААНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Могойтын голын хөндийд буй бүлэг археологийн дурсгалууд дотор гурван хүн чулуун хөшөө Могойтын рашааны дэргэд байна. Хөшөөнд хүний нүүрний төрх гарган засч, нүд, хөмсөг, хамар, ам зэргийг гаргаж дүрсэлсэн ба дүрслэлийн нийтлэг шинжээрээ түрэгийн үед холаогдоно.

ЦАГААН ГОЛЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Цагаан голын цогцолбор дурсгал нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын төвөөс чанх баруун хойш 6,5 км-т Цагаан голын хойд дэнж дээр хоёр буган хөшөө байрлана. Энэ хоёр хөшөөний онцлог нь 1-р буган хөшөө нь ногоон туяатай хөх саарал өнгийн нимгэн хавтгай урт чулуугаар хийсэн. Өргөн талын оройн хэсгийн хоёр талд цагираг гарган сийлсэн байна. Харин 2-р буган хөшөө нь гонзгой урт нүүртэй, шулуун жирэвгэр хөмсгийн уулзвараас доош хамрыг шууд үргэлжлүүлэн товгор шулуунаар гаргасан нь бусад буган хөшөөдөөс хүний нүүрний хэв дүрсэлсэн хэв шинжээрээ онцлог байна. Ийнхүү хүний нүүр гарган хийсвэр байдлаар дүрсэлсэн хөшөөг ихэнх судлаачид хүрэл зэвсгийн үед холбон үздэг байна.

ШИВЭЭТ ХАЙРХАНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан хадны зургийн цогцолбор нь Хар салаа, Цагаан салаа голуудын хөндийд, Хар салаа голын зүүн эргээр тарсан хадны нурангийн хошуурсан хэсгүүдээр байрлана. Хадны зургийн цаг хугацааны хувьд авч үзвэл, зургуудыг Монголын Алтайн эртний оршин суугчид хүрлийн түрүү үеэс эртний Түрэгийн үе хүртэлх түүхийн урт удаан хугацаанд бүтээжээ. Зарим нэгэн газар төвлөрсөн зургуудын дийлэнхийг хүрэл ба төмрийн түрүү үед зурсныг онцлох хэрэгтэй. Эдгээр зургуудын ихэнх дээр янгир, буга агнаж байгаа анчид, дайн байлдаан хийж байгаа хүмүүс, элдэв домгийн амьтад дүрслэгдсэнээс гадна зарим нэгэн буга, үхэр, араатнуудын их бие, эвэр дээр төрөл бүрийн тамга сийлсэн байна. Шивээт хайрханы хадны зургийн дурсгалт газар нь 2011 онд Дэлхийн өвд соёлын ангиллаар Бага Ойгор, Арал толгойн хадны зургийн хамтаар бүртгэгджээ.

Баянхонгор аймаг

1. Бичигтийн амны хадны зураг

2. Зоог Зуухын Чулуун Зэвсгийн Бууц
3. Лигийн цагаан агуй
4. Тай нуурын гэрэлт хөшөө
5. Дундмандал, адагмандал уулын хадны зураг, бичээс
6. Бурхант хясааны бурхадын хөрөг, бичээс
7. Чин сүжигт номун хааны хийдийн цогцолбор,
8. Замын хашаатын хадны зураг
9. Их булган уулын чулуун зэвсгийн суурин, хиргисүүр
10. Уран хайрханы чулуун зэвсгийн бууц
11. Хачин ламын сүм
12. Шатар чулууны цогцолбор дурсгал

БИЧИГТИЙН АМНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Их Баян уулын Бичигтийн аманд орших хадны сийлмэл зураг. Эндэхийн хаднаа эртний хүмүүс хүн, амьтан, тамга тэмдэг зэрэг олон зуун зургийг цоолборлон, сийлж үлдээжээ. Янгир, бугыг анчид ганц нэгээрээ буюу хэсэг бүлгээрээ нум сумаар харван намнаж буй байдлыг үзүүлсэн сэдэвтэй зураг олон байгаа нь тэр үеийн хүний амьдралд ан агнуур хэчнээн чухал байсныг харуулах чухал баримт юм. Мөн эндэхийн хаданд чоно, ирвэс, шилүүс зэрэг араатан амьтад аргаль, янгир, буга зэрэг амьтдыг элдэж хөөсөн, тойрч бүслээд барьж идэхийг завдан буй байдлыг дүрсэлсэн нь олон тохиолдоно. Тухайн хадны зургууд неолитын үеэс эхлэн зурагдсан хэмээн судлаачид үзсэн байна.

ЗООГ ЗУУХЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН БУУЦ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Зоог зуух гэдэг газар нь неолитын үеийн чулуун зэвсгүүдийн хамт зэс, зэсийн хүдрийн хайлшны олдвор бүхий газар билээ. Зоог зуухын сууринаас неолит, энеолитийн үед хүн удаан хугацаагаар амьдарч байсны баримт болох 30 гаруй гал голомтын ор, 4000 гаруй эд өлгийн зүйлс, түүний дотор чулуун зэвсэг, шавар ваарын хагархай, зэс хайлуулж байсан жижиг чулуугаар барьсан хоёр зуух, зэсийн хайлш, загийн нүүрс зэрэг илэрсэн байна.

ЛИГИЙН ЦАГААН АГУЙ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт оршино. Энэ агуйг анх 1987 онд Монгол- Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн үеийн дурсгал судлах анги олж илрүүлэн 1988-1989 онуудад малтан судлах ажлыг гүйцэтгэжээ. 1995-2000 оны хооронд Монгол-Орос-Америкийн хамтарсан археологийн экспедиц малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ. Малталт судалгааны үр дүнд Монгол болон Төв Азийн энэхүү бүс нутагт дөрөвдэгч галавын сүүл үед урин зөөлөн уур амьсгалтай байсан болохыг тогтоон, Монгол орны нутаг дээр хүн амьдарч эхэлсэн 500 мянган жилийн тооллыг даруй 200 мянган жилээр урагш нь ахиулж, Төв Азид, тэр дотроо плейстоцений үед үүсэн тогтсон “Эртний нууруудын хөндий”-д хүн дэлхийн чулуун зэвсгийн сонгодог онолоор ОЛДУВАЙН үед буюу манай тооллын өмнөх 700 мянган жилийн тэртээгээс суурьшин амьдарч байжээ хэмээн үзэх үндэслэлийг өгчээ.

ТАЙ НУРУУНЫ ГЭРЭЛТ ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг Тай нуруунд Түрэгийн үеийн бичээс болон овог аймгийн тамгатай хөшөө чулуун шивээний урд талд оршино. Хөшөөний орой хэсэн болон нүүрэн талын дээд хэсэгт руни бичиг сийлсэн бөгөөд түүний талд 33 төрлийн овог аймгийн тамгыг дүрсэлсэн байна.

ДУНДМАНДАЛ, АДАГМАНДАЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус утс батлагдсан. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын төвөөс зүүн хойш 40 км орчим зайд, баруун хойноос зүүн урагш цувран тогтсон, тэгш тогтоцтой гурван уулыг Гурван Мандал хэмээнэ. Уг газарт хадны зураг болон Түрэгийн руни бичээс бүхий дурсгалтай. Хадны зургуудын дотор буга, согоо, янгир зэрэг ан амьтан, адуу, тэмээ, нохой зэргийн мал адгуус, түүнчлэн нум сумаар зэвсэглэсэн хүмүүс ан гөрөө хийж буй байдал, адгуус амьтныг гаршуулан сургаж буй сэдэв байхаас гадна нум сум, байлдааны сүх, тэрэг, эртний олон овог аймгийн тамгыг дүрсэлсэн нь нэн их бөгөөд тэдгээрийн дотор онгин, сэрээ, хайрлага, чагтан болон янгир тамгууд байна. Эдгээр дүрсүүдийн дотор буган хөшөөнд хийсвэрлэн дүрсэлдэгтэй адил шувуу мэт урт нарийн хошуутай, зоон дээрээ хошуурсан овгор бүхий бугын дүрс, хоёр дугуйтай ганц урт аралтай тэрэгний дүрс зэрэг дүрсүүд байна.

БУРХАНТ ХЯСААНЫ БУРХАДЫН ХӨРӨГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймаг Галуут сумын нутагт орших Чин сүжигт номун ханы хүрээнээс зүүн тийш, Цагаан туруутын голын хойд эрэгт ханан хаданд сийлэн урласан олон тооны бурхадын хөрөг оршин байна. Тухайн дурсгал нь Чин сүжигт номун ханы хүрээний түүхтэй салшгүй холбоотой байна.

ЧИН СҮЖИГТ НОМУН ХАНЫ ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Чин Сүжигт номун хан Лувсанноровшарав 1751 онд одоогийн Баянхонгор аймгийн Галуут сумын Цагаан туруут гол Ханхарын өвөрт Чогчин дуганыг цогцлоож Чин Сүжигт номун хан хутагтын хүрээг байгуулсан түүхтэй. Эрдэнэ ноён цорж, Чин Сүжигт Номун хан хутагт хэмээн түүний цолоор нутгийн ард Чин сүжигт номун ханы хийд гэж хэлж заншсан байдаг. Тэрээр Халхын 13 тамгатай хутагтын нэг болно. Чин сүжигт номун хан нь Энэтхэг, Төвөдөөс гарвалтай гүр дууг Монголд уламжлуулан хөгжүүлсэн ба тухайн хийдийн ая дан бусад хийдээс нэлээд ялгавартай, хийдэд 130 гаруй нэр төрлийн ном хурдаг, цам майдар эргэх ёс шашны уншлага нь ч ихээхэн өвөрмөц байжээ.

ЗАМЫН ХАШААТЫН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших Хангайн нурууны салбар уулсын хамгийн урд хэсэгт байрлах Хашаат хэмээх уулын оройгоор цуварсан дэл хадны цохиогоор энэхүү дурсгал тархжээ. Уг дурсгалыг үйлдсэн газрын ерөнхий байршил нь нар, салхины нөлөөнд өртөмтгий бөгөөд олон жилийн турш уг дурсгал бүдгэрэн баларчээ. Эндэх хадны зургийг дүрслэхдээ нэлэнхийд нь буюу их биеийн хүрээг цохиж, эсвэл хурц үзүүртэй зүйлээр

сараачин зуржээ. Уг хадны зурагт буга, янгир, ан амьтан, адуу, нохой болон нум сумаар зэвсэглэсэн дайчдыг ан гөрөө хийж буй байдлаар дүрсэлснээрээ онцлогтой.

ИХ БУЛГАН УУЛЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУУРИН, ХИРГИСҮҮР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших энэхүү дурсгалт газрын чулуун зэвсгийн дурсгалыг Түйн голын хөндийн дунд урсгалын дагуу 1985-1986 оны хооронд Монгол Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги илрүүлэн олжээ. Энэхүү газар нь дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн шатнаас эхлэн дээд палеолитын төгсгөл хүртэлх үеийн чулуун зэвсгийн чухал илэрц бүхий олдворт газар юм. Мөн Булган уулын тахилгат овоо болон овооны зүүн баруун талд эртний булш хиргисүүрүүдэй.

УРАН ХАЙРХАНЫ ЧУЛУУН ЗЭВСГИЙН БУУЦ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг, Нарийн голын зүүн эргээс Монгол Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн археологичид 1986 онд палеолитын доод, дунд дээд шатанд холбогдох 52 бууц, суурин, дархны газрыг илрүүлэн 2783 ширхэг чулуун зэвсэг түүвэрлэн олжээ. Тэдгээр суурингйн долоо нь доод палеолитын үед холбогдохын зэрэгцээ тав нь дархны газар юм. Нарийн голын бүлэг дурсгалаас хамгийн эрт үед холбогдох дурсгал нь Уранхайрхан уулын орчим дахь Нарийн голын 17 дугаар суурин болно. Чулуун зэвсгийн байдлаас харахад арга зүйн болоод хэв шинжийн хувьд хайрган зэвсгийн уламжлалыг илэрхийлдэг. Нарийн голын доод палеолитын дурсгалыг судалсан судлаачид бусад газар нутгаас олдсон ижил төрлийн эдлэлүүдтэй харьцуулан холбогдох он цагийг 850000 жилээр тогтоожээ. Тухайн дурсгал нь Монголын чулуун зэвсгийн хамгийн эртний он цаг юм.

ХАЧИН ЛАМЫН СҮМ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын төвд Хачин ламын сүм байрлана. Тус сүм 1775 оноос 1983 он хүртэл шашны үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд хар модон банзан хашаатай, сүмийн хаалгыг баруун талд хийсэн нь зарим сүм барилгыг Шамбалын орон руу харуулж барьдаг нэгэн ёс уламжлалтай холбоотой. Сүм хоёр давхар, урд талын хаалгаар нь ордог, доод давхар нь өвлийн сууц бөгөөд дотроо хоёр өрөөтэй, гадна талаас нь галлаж ханзыг халаадаг байжээ.

ШАТАР ЧУЛУУНЫ ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Шатар чулууны дурсгалт газар нь түүхийн олон үед хамаарах хиргисүүр, зэл чулуу, дөрвөлжин булш, буган хөшөө, эртний Түрэгийн тахилгын онгон зэрэг дурсгалаас бүрдэнэ. Эдгээрийн дотор хамгийн эрт цагт хамаарах зэс чулууны үеийн гурван булш Түйн голын эрэгт ойр дэнж дээр байрлаж байжээ. 1971, 1975 онуудад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици малтан судалсан. Тухайн газарт олон үеийн дурсгал нэгэн оршин байдгаараа онцлогтой.

Булган аймаг

1. Шивээт улааны цогцолбор дурсгал
2. Майхан уулын Шороон бумбагар
3. Бичигтийн гарамны хадны зураг
4. Харбухын балгас
5. Цогтын Цагаан байшин, гэрэлт хөшөө
6. Чин толгойн балгас
7. Хөл Асгатын цогцолбор дурсгал
8. Сайхан Байширын усны буган чулуун хөшөөд
9. Моюунчурын гэрэлт хөшөө
10. Ингэт толгойн хүн чулуун хөшөө
11. Бийбулагийн балгас
12. Төлбөрийн голын чулуун зэвсгийн суурин

ШИВЭЭТ УЛААНЫ ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Баян-Агт сумын төвөөс 25 км зайд, Хануй, Хүнүй хоёр голын цутгалангийн харалдаа голын хойд талд орших Шивээт улаан гэдэг жижиг толгойн орой дээр байдаг. Шивээт Улааны дурсгалыг анх 1912 онд Финляндын эрдэмтэн Густав Иохан фон Рамстедт олж илрүүлэн дэлхийн эрдэмтдийн сонорт хүргэжээ. Уг дурсгал Түрэгийн сүүл үед хамаарах Элтерес цолтой Кутулук хааны дурсгал юм. Энд чулуун өрлөг бүхий байгуудамжийн хамт хүн чулуу 9, чулуун арслан 4, чулуун хонь 4 байна. Хүн чулуунууд нь шовх зах бүхий дээл өмссөн байдалтай, захын ар талд жижиг дөрвөлжин унжлагатай байдаг. Нэг хүн чулуу нь баруун ташаандаа хавтага зүүж, хоёр гартаа бумба барьсан, өөр нэг нь сэлэм атгасан баруун гараа элгэндээ авч, зүүн гараараа сэлэмний хуйн дээд хэсгээс барьсан байдалтай байдаг.

МАЙХАН УУЛЫН ШОРООН БУМБАГАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Баяннуур сумын төвөөс зүүн хойш 14 км зайд, Баян Улаан уулын зүүн хойно, Майхан уулын урд энгэрт оршино. Нутгийнхан Шороон Бумбагар хэмээн нэрлэдэг бөгөөд булшин дээр шороог зууван дугуй конус хэлбэрээр дэлдэж дарсан дараастай юм. Бунханы өндөр нь 4,2 м, суурийн голч 50 м, уг булшны хэрэм нь 200 х 180 м. Бунхант булшны нийт урт нь 42 метр. Бунхны хана болон бунхны үүдэвчний ханыг нимгэн шавраар доторлож дээр нь зураг зурсан байна. Уг булшнаас нийт 500 гаруй үнэ цэнтэй эд зүйлс илэрчээ. Дурсгалыг малтан судласан судалгааны баг дурсгалыг VII зууны хоёрдугаар хагас орчимд хамаарна хэмээн он цагийг тогтоожээ. Энэхүү дурсгал нь Монгол нутаг дахь анхны ханын зураг бүхий бүтэн малтагдаж судалагдсан бунхан юм.

БИЧИГТИЙН ГАРАМНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Булган аймгийн Бугат сумаас баруун хойш 45 км орчим зайд, Алтаадын голын баруун талд орших, Бичигтийн гарам хэмээх ханан хаднаа зосон зургийн бүлэг дурсгал бий. Тус зосон зураг нь эзлэх талбайн хэмжээ, зургийн тоо, өгүүлэмж, дүрслэлийн хувьд өмнө илэрч мэдэгдсэн зосон зургийн дурсгалыг бодвол ихээхэн баялагт тооцогдох бөгөөд 250 гаруй метр урт үргэлжлэх, эгц урагш харсан цавчим ханан хадны ёроолоор хоёр хэсэг газарт бөөн байдалтай оршино. Бичигтийн гармын хадны зосон зурагт хүн, шувуу, адуу, үхэр, буга, нохой, дөрвөлжин болон зууван хүрээтэй цэгүүд дүрсэлснээс хамгийн олон тоотой зурагдсан дүрс нь хүн юм. Энд нийт 56 хүн дүрсэлсний дийлэнх нь бүтэн дүрслэлтэй бол үлдсэн цөөн хэдийн хөлийн дүрслэл бүдгэрч арилсан. Зурагт

тэдгээр хүмүүсийн толгой, бие, гар, хөлийг энгийн тойм байдалтай дүрслэн үзүүлсэн ба хүмүүсийг гараа алдлан хөлөө алцайн зогсож буй байдлаар ганц нэгээр нь, эсвэл эгнээ үүсгэн гар гараас хөтлөлцсөн буйгаар дүрсэлжээ.

ХАРБУХЫН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Дашинчилэн сумын төвөөс баруун зүгт 12 км зайд, Хар бухын голын өмнө хөвөөнд, Хадаасан толгойн зүүн хойно орших эртний хотын туурийг Хар бухын буюу Хадаасангийн балгас гэдэг. Туурийг анх XIX зууны үед илрүүлэн олсон ба 1934, 1948-1949 онуудад хайгуул судалгаа, 1970 онд бага хэмжээний малтлага хийжээ. Уг хотын туурь түүхийн хоёр өөр цаг үед холбогдох бөгөөд эхнийх нь X-XI зууны Кидан улсын үе болно. Энэхүү балгасын Киданы үед холбож үзэх гол үндэслэл нь Чин толгойн балгаснаас олдсон Кидан бичээст дээврийн ваартай яг ижил хэлбэр маягийн ваар олдсон явдал юм. Хожим XVII зууны эхэн хагаст эртний энэ хотын хэрэм дотор дан чулуугаар хийсэн барилга байгууламжуудыг барьжээ. Энэ нь тус тусдаа бат бэх хэрэмтэй хэдэн том барилга дуган байсан бөгөөд барилгын чулууны өрлөг бэхэлгээ зэрэг нь XVII зууны үеийн Монголын бусад шивээ бэхлэлтэд нийтлэг ажиглагддаг бөгөөд барилгын хэв загвар нь Төвд барилгын хийц маягийг илэрхийлдэг.

ЦОГТЫН ЦАГААН БАЙШИН, ГЭРЭЛТ ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/ -оор тус тус батлагдсан. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Халхын Цогт хун тайжийн үед байгуулсан барилгын үлдэгдэл байдаг. Байшинг довцог толгойн орой дээр барьсан бөгөөд дуган хэлбэртэй дээврийн ваартай байжээ. Энэ байшинг хуучин барилгын суурь дээр барьж, хэрмийн доод хэсгийг чулуугаар өрж, дээш нь тоосгоор босгожээ. Эргэн тойронд нь барилгын үлдэц олон байгаа нь түүнийг тойрон нэлээд олон хүн ам оршин сууж байсныг гэрчилнэ. Цогтын цагаан байшинг 1933-1934 онд Оросын эрдэмтэн Д.Д.Букинич бага сага малталт хийсэн ба хожим энэ орчмоос эрдэмтэн Х.Пэрлээ XY-XIY зууны үед холбогдох үйсэн дээр бичсэн Монгол хуулийн эмхэтгэлийг олжээ. Цагаан байшингийн баруун талд Цогт тайж, эх Чин Тайху хатны хамт 1601-1617 оны хооронд буюу 17 жилийн хугацаанд зургаан сүм байгуулсныг өгүүлсэн саарал боржин чулуун бичигт хөшөө байдаг.

ЧИН ТОЛГОЙН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт нутгийнхан “Чин толгой” гэдэг эртний хотын туурь бий. Энд эртний гэрэлт хөшөөний суурь хоёр том чулуун мэлхий байх бөгөөд олдсон зарим дээврийн ваар нь Кидан бичигтэй байжээ. 1890-ээд оны үед монголоор жуулчилж явсан Оросын жуулчин А.Позднеев Чинтолгойн балгасыг үзэж, түүний хэмжээ болон, хэлбэр хийцийн талаар товч мэдээллийг хэвлүүлсэн. Энэ хотын туурь нь 1260 х 680 м хэмжээтэй, бараг зөв тэгш өнцөгт хэлбэртэй. Хойноосоо урагш өмнө зүг сунаж тогтсон, тал бүрээс нь нар тусаж байхаар бодож барьсан зохиомжтой. Хэрмийг нь шороо дагтаршуулан барьжээ. Хэрмийн хойд талын шороон даланд 6, өмнөд

талд 6, баруун, зүүн талын шороон даланд тус бүр 10 харуулын цамхаг байжээ. Тэднийг балгасны 4 өнцөг дээр байгаатай нь нийлүүлж тооцвол нийт 36 цонжтой. Хэрмийг гадуур нь тойруулсан шуудуутай байжээ.

ХӨЛ АСГАТЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол/2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Могод сумын нутаг Асгатын хөндийд Түрэгийн үеийн тахилын онгон оршино. Энэ дурсгал дөрвөн хавтан чулуу ирмэглэн суулгаж үйлдсэн, өргөргийн дагуу байрлалтай хоёр хашлагаас бүрдэнэ. Зүүн тийш хандсан хашлаганы дотор талын гадаргад зэрэгцэн сууж байгаа гурван хүний дүрсийг товойлгон сийлжээ. Дунд талын хүнийг эгц урдаас нь харуулж завилан суугаа, захын хоёр хүнийг ташуу байдалтай, сөхрөн сууж байгаагаар дүрсэлжээ. Гурвуул гозгор оройтой, түрэгийн хөшөө дурсгалд элбэг тохиолддог малгайтай, баруун гартаа ваар сав барьсан байна. Эдгээрийн доогуур хээ угалз бүхий өргөн тууш зурвас дүрсэлсэн нь тэр гурван хүн хивсэн дээр сууж буйг цохон харуулсан санаа бололтой. Зурагт хавтангийн зүүн дээд өнцөгт янгир тамга, түүний дээр сууж байгаа шонхор шувууны дүрс, дээгүүр нь нэг мөр руни бичиг сийлжээ. Энэхүү дурсгал нь Түрэгийн үеийн тахилын онгоны өвөрмөц хэлбэр юм.

БАЙШИРЫН УСНЫ БУГАН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших энэхүү дурсгал нь Хайрхан уулын урд хөндий дагасан Байширын бүрд хэмээх газар бий. Энэхүү буган хөшөөг дөрвөлжин булшны хашлага чулуу болгон дахин ашигласан бололтой. Нийтдээ 9 буган хөшөө байгаагаас зарим хөшөөд он удаан жил газрын хөрснөө шигдсэн байдалтай байна.

МОЮУНЧУРЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Сайхан сумын Хиргисийн хөндий гэдэг газарт Могойн Шинэ усны онгон буюу Моюн-Чурт зориулсан гэрэлт хөшөө оршино. Уг дурсгал нь гадууpаа намхан шороон далан, гүехэн сувагтай зүүн зүг харсан жижиг үүдтэй дундаа чулуун овоолго бүхий дурсгал юм. Дурсгалын өмнө талд хоёр хэсэг болж хугарсан хөшөө чулуу, мэлхийн дүрст чулуун суурь түүний дэргэд хоёр хэсэг хуваагдсан руни бичгээр бичсэн дурсгал бий. Энэ чулууны бичээс нь түүх, хэл соёлын хосгүй дурсгалын нэг бөгөөд энэ хөшөөний урт 3.8 м, мэлхий чулуун дээр суурилуулан босгожээ. Хөшөөний нүүрэн талд 1-12, баруун талд 13-23, хойд талд 25-39, зүүн талд нь 40-44 мөрийг тус тус сийлжээ. Нэг мөрөнд дунджаар 150 орчим үсэг зурлагатай юм. Судлаачид уг хөшөөнд ойролцоогоор 6750 орчим үсэг зурлага байсан бөгөөд 1750 орчим нь баларсан гэж үздэг. Энэ хөшөөг Уйгур улсын хоёр дахь хаан Моюн-Чур /Баян чур/-т зориулан босгожээ. Моюн-Чур нь Уйгур улсыг байгуулж улмаар хаанд өргөмжлөгсдөн Пэйлогийн хүү бөгөөд 747-759 оны хооронд хаан ширээнд суухдаа тэнэрээс заяат төр засагч мэдэлтэй хаан гэж алдаршжээ. Хөшөөний бичээст 744-750 оны хоорондох түүхэн үйл явдлыг газар усны нэрийн хамт бичсэнээрээ чухал ач холбогдолтой.

ИНГЭТ ТОЛГОЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Ингэт толгойн сангийн аж ахуйн төвөөс зүүн тийш 1 км орчим зайд, Ингэт толгой хэмээх жижиг толгойн өвөрт нэгэн хүн чулуу байна. Хүн чулууг бүдүүн ширхэгтэй шаргал өнгийн боржин чулуугаар үйлдсэн, өндөр 220 см, мөрний өргөн 70 см, цээжний зузаан 30 см хэмжээтэй, босоо хүний бүтэн сийлмэл хөрөг. Дээл нь маш өргөн нэлмэгэр ханцуйтай бөгөөд нугалсан гараас доош газарт шүргэсэн хормойтой, хормойноос дооших хэсгийг газарт зооход зориулж нарийсган, хөлийг дүрслээгүй аж. Энэхүү хүн чулууны хэмжээ болон хэлбэр хийц, өмсгөл зүүлт нэн өвөрмөц, Монгол нутагт элбэг тархсан VI-VIII зууны Түрэгийн, VIII-IX зууны Уйгарын, XIII-XIV зууны Монголын хүн чулуудаас эрс ялгаатай байгааг харьцуулалт хийж Алс Дорнод, Уссури хязгаараас эртний Зөрчидийн соёлд холбогдох хүн чулуудтай төстэй учир нэгэн үе Монгол нутагт ноёрхлоо тогтоож байсан Кидан нарын соёлын дурсгал хэмээн судлаачид үзсэн байна.

БИЙБУЛАГИЙН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/,Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын төвөөс баруун тийш 13 км зайд, Сэлэнгэ мөрний хойд хөвөөнд, эртний балгасны туурь байдаг нь Уйгур улсын соёл, шашны нэгэн томоохон төв Байбалык хотын ор үлдэц юм. Нутгийн ард олон эрт цагаас энэ хотын туурийг Бийбулагийн балгас хэмээн нэрлэсээр ирсэн нь даруй эртний нэрээ хадгалан үлдсэн гайхамшигт жишээ болно. Эл хотыг үүсгэн байгуулсан тухай “Сэлэнгийн чулуу” хэмээн алдаршсан Могойн Шинэ Усны хөшөө буюу Моюнчур хааны гэрэлт хөшөөнд өгүүлжээ. Энд нийт гурван хэрэм буйн үндсэн хэсэг нь баруун болон хойт талдаа шавар дагтаршуулан дэлдэж хийсэн өндөр ханатай дөрвөлжин том хэрэм юм.

ТӨЛБӨРИЙН ГОЛЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУУРИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багийн нутагт оршино. Их Төлбөрийн голын чулуун зэвсгийн дурсгалыг анх 1975 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн судалгааны анги илрүүлэн олсон ба 2002 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны экспедиц нарийвчилсан хайгуул хийж чулуун зэвсгийн үеийн 14 бууц сууриныг олж илрүүлжээ. 2004-2015 онуудад Монгол-Оросын хамтарсан судалгааны анги Төлбөрийн голын 4, 15, 16, 21-р сууринуудад малтлага судалгааны ажлыг гүйцэтгэжээ. Төлбөрийн голын олон дурсгалаас 4, 15, 21-р сууринд суурин малтлагыг хийж тухайн бүс нутгийн палеолитын хөгжлийн чиг хандлага чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хөгжлийг бүрэн тодорхойлжээ. Дээд палеолитын эхэн үеэс хүмүүс Төлбөрийн голд суурьшиж эхэлсэн нь батлагдаж байгаа бөгөөд чулуун зэвсэг үйлдвэрлэх өвөрмөц арга технологитой байсны дээр ясан зэвсгийн үйлдвэрлэл ч амжилттай хөгжиж байсныг тогтоожээ.

Говь-Алтай аймаг
1. Шар тээгийн палеонтологийн дурсгалт газар
2. Бичигтийн бууцны хадны зураг, бичээс
3. Гурван эрээн нуурын палеонтологийн дурсгалт газар
4. Сүмийн дэнжийн цогцолбор дурсгал
5. Тоосготын хүн чулуун хөшөө
6. Шататын бэлчирийн цогцолбор дурсгал
7. Цагаан голын хадны зураг

8. Хиргист хоолойн булшнууд

ШАР ТЭЭГИЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Алтай сумын Урт багийн нутагт Шар тээг хэмээх палеонтологийн дурсгалт газар нэлэнхийдээ шар өнгийн шаварлаг бүхий хөрстэй, зарим хэсгийн хөрсний элэгдлийн улмаас эрэг гарсан ба тэр хэсэгт улаан шаварлаг өнгийн хөрс ил харагдаж байгаа, энэ орчимд эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл байдаг. Тухайн дурсгалт газар нь Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын бүсэд багтдаг. Шар тээгийн палеонтологийн дурсгалт газар Дунд- Хожуу Юра (J2-3), Түрүү Цэрд (K1)-ийн цаг үед хамаарах ба хавчаахай, шавж, дун, хясаа, замаг, яст мэлхий, матар зэргийн чулуужсан яс олддог.

БИЧИГТИЙН БУУЦНЫ ХАДНЫ ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол/2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Бигэр сумын төвөөс 17 км зайд, Бичигтийн хавцлын төв хэсэгт ёроолоосоо орой хүртэл хадны зурагтай хэд хэдэн өндөр хадтай 3 хэсэг газарт хадны зураг бичээс байна. Нэгдүгээр хэсэг буюу Бичигт хад-1 нь хавцлын тэхий гүнд, хоёрдугаар хэсэг Бичигт хад-2 нь дараагийн уулын хаданд, Бичигт хад-3 нь хоёр дахь хадны зургаас 100 орчим метрийн зайд орших ууланд бий. Эндхийн хадны зургуудаас хамгийн сонирхолтой нь ан амьтдыг хашиж, хөөж, отож, агнаж /үргээлгэ/ буй байдлыг харуулсан хэсгүүд юм. Мөн энд дөрвөн хэсэг эртний түрэг бичээс бий. Үүнийг Бигэрийн түрэг бичээс ч гэдэг.

ГУРВАН ЭРЭЭН НУУРЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Дарви сумын Жавхлант багийн нутагт орших Гурван эрээний нуур орчимд 10 га газар хамрах энэхүү палеонтологийн дурсгалт газар оршино. Эндээс ихэвчлэн шавж, ургамлын чулуужмал болон үлэг гүрвэлээс завропод, теропод олдоно. Гурван эрээний нуруу палеонтологийн дурсгалт газар Дунд-Хожуу Юра (J2-3), Түрүү Цэрд (K1)-ийн цаг үед хамаарна.

СҮМИЙН ДЭНЖИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Жаргалант сумын төвөөс баруун урагш 20 км орчим зайд, Сүмийн дэн /дэнж/ хэмээх газарт түрэгийн үеийн хүн чулуу, хашлагаас бүрдсэн таван хүн чулуун хөшөө бүхий тахилын цогцолбор бий. Эдгээр нь Хасагт хайрхан уулаас хойш, Жаргалант, Үй өндөр зэрэг уулс, Улаан толгой хэмээх намхан ухаа толгод бүхий хөндийгөөр хүрээлэгдсэн хойноос урагш налуу өргөн дэнжийн баруун захаар өмнөөс хойш цувран байрлажээ.

ТООСГОТЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Жаргалант сумын төвөөс баруун урагш 20 гаруй км зайд, Тоосгон дэн буюу Дэлийн үзүүр хэмээх газарт Түрэгийн үеийн 3 хүн чулуу, тахилын

онгон бүхий цогцолбор дурсгал бий.

ШАТАТЫН БЭЛЧИРИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Тонхил сумын Соёмбо багийн нутаг Урд хулд, Шататын бэлчир хэмээх газарт Түрэгийн үеийн хөшөө чулуу, хашлага бүхий тахилын онгон зэрэг олон тооны хөшөө чулуун бүлэг дурсгал нэг дор оршиж байгаа бүс нутгийн онцлог шинжийг агуулсан дурсгал юм.

ЦАГААН ГОЛЫН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Халиун сумын нутагт оршино. Дурсгалт газар нь аймгийн төвөөс Цээл сум уруу явах замд байх ба Цагаан голын хавцалын зүүн хойшоо харсан хадны налуу хэсэг дээр морь, буга, шувуу, жад барьсан хүн амьтны зурагтай, мөн 20 гаруй тамга тэмдэг дүрслэлтэй, нэг доор олон дүр дүрслэлийг харуулснаараа нэлээд онцлогтой дурсгал юм. Тухайн дурсгалыг 1900-ээд онд археологич Ц.Доржсүрэн анх нээн олж судлан, дараа нь Зөвлөлтийн судлаач В.В.Волков, Э.А.Новгородова нар нягтлан судалжээ.

ХИРГИСТ ХООЛОЙН БУЛШНУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Говь-Алтай аймгийн Цогт сумын төвөөс зүүн хойш чиглэсэн нарийн хоолойг Хиргист хоолой гэнэ. 1986 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Хүннүгийн дурсгал судлах анги энэ орчмоос эртний 100 орчим булш буйг илрүүлэн олж нэлээдийг малтан шинжилжээ. Эдгээр булш нь урд өмнө манай орны болон хөрш зэргэлдээ Буриадын нутагт малтан шинжилсэн хүннү нарын жирийн иргэдийн булштай хэлбэр төрхөөрөө ижил юм. Хиргист хоолойн булш нь Алтайн нурууны өвөр биеэс анх удаа олдож буй хүннү нарын томоохон бүлэг булш бөгөөд хүннү нарын үндсэн нутаг болох Монгол орны археологийн дурсгалын тархалтын хүрээг улам тэлж байгаагаараа онцлог.

Дархан-Уул аймаг

1. Хүйтэний голын хадны зураг, бичээс

ХҮЙТЭНИЙ ГОЛЫН ХАДНЫ ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дархан хотоос зүүн хойд зүгт 70 гаруй км зайд, Хүйтэний голын Бичигт хошуу хэмээх газарт, Хүйтэний гол руу зүүн талаасаа түрж шахсан өндөр хадан хошууны гол руугаа хандсан үзүүрийн ханан хадны хөмөгт буй эдгээр дурсгалт бичээснүүд бий. Монгол бичээс нь өндөр 36 см, өргөн 21 см талбай эзэлсэн бөгөөд хар өнгийн бэхээр бичигджээ. Бичээсний ерөнхий утгыг тоймловол: Мөнх тэнгэрийн хүчинд хааны суу дор нэгэн үйл явдлыг дурсан хаданд бичиж, хүр “дурсгал” болгон бэлгэдэж тахиа жилийн есөн сарын шинийн наймнаа уг бичээсийг үйлдсэн мэт байна. Мөн уг бичээсний дэргэд 7 мөр босоо дөрвөлжин бичиг байгаа нь басхүү мөнх тэнгэрийн хүчинд хааны сууд хэмээн эхэлж байна. Монгол бичээс шиг хар бэхээр бичигдсэн эл дөрвөлжин бичгийн дурсгал үлэмж элэгдэж баларсан тул утга нь мөнөө бүрэн тайлагдаагүй байна. Хүйтэний голын арван хоёр мөр монгол бичиг нь XIII-XIV зууны монгол бичгийн дурсгал мөн бол долоон

мөр босоо дөрвөлжин бичиг нь монгол нутгаас маш ховор олддог дөрвөлжин үсгийн бичээсийн ховор нандин дурсгал юм.

Дорноговь аймаг
1. Олон байшинтын туурь
2. Хэсэг байшинтын туурь
3. Сүйхэнтийн палеонтологийн дурсгалт газар
4. Эргилийн зоон палеонтологийн дурсгалт газар

ОЛОН БАЙШИНТЫН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорноговь аймгийн Их хэт сумын нутаг, Бүсийн чулууны ард Олон байшин гэдэг гадна талаараа хэрэмгүй эртний хотын энэ туйрд 50 гаруй орон байшингийн нурсан үлдэгдэл бий. Зарим барилга нь хэлбэр байдлаараа Хэсэг байшингийнхтай тун адилхан боловч тойрсон хэрэм байхгүйгээрээ ялгагдана. Барилгын суурийг боржин чулуугаар өрж дээр нь тоосгон хана хийсэн, өрлөгийн хэлбэр мөн л хэсэг байшингийнхтай ижил, хэвтээ болон ташуу өрлөг хосолсон байжээ. "Хэсэг байшин", "Олон байшин" хоёр нь нэгэн цаг үед байгуулагдсан бөгөөд Сайн хун тайж хэмээгч нь Хэсэг байшингийн хөшөөнд нэр гардаг үзэмчний Эрдэнэ хун тайж Дэгэлэй /Дэгэд/ мөн болох нь лавтай бөгөөд тэрбээр албат ардаа дагуулан энд ирж нутаглаж байгаад XVII зууны сүүлийн хагаст манжид эзлэгдэн уугуул нутагтаа буцах үед эзгүйрэн үлдэж улмаар эвдэрсэн байна.

ХЭСЭГ БАЙШИНТЫН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорноговь аймгийн Их Хэт сумын нутаг Бүсийн чулуу хэмээх сунаж тогтсон их байц хадны өвөрт дундад эртний Монголын уран барилгын нэгэн дурсгалын туурь үлдэгдэл бийг "Хэсэг байшин" гэдэг. Энэхүү дурсгалт газрыг Оросын эрдэмтэн Палладий Кафаров 1847 онд үзэж тэмдэглэсэн бөгөөд 1923 онд Судар бичгийн хүрээлэнгийн томилолтоор В.А.Казакевич, их зохиолч Д.Нацагдорж нар тэнд байсан Монгол бичээст хөшөөний бичээсийг хуулбарлан авч дурсгалын тойм зургийг үйлджээ. Уг дурсгалын төв барилга нь дөрвөлжин хэлбэртэй, чулуу өрж цогцолсон хэрэмтэй, ханын чулуун өрлөг нь хэвтээ ба ташуу хоёр янзын байрлалтай. Төв барилгын гурван талаар нь өөр бусад орон барилгын ор үлдэгдэл хүрээлж байсны дотор хэд хэдэн суварга байжээ. Гол барилгаас урагш, хөшөө чулууны суурь болох боржин чулуун яст мэлхий газарт хагас булаастай байсныг шинжээчид малтан гаргасан ба дэргэдээс нь 11 хэсэг болж хагарсан Монгол бичээст хөшөө илрүүлж олсон байна.

СҮЙХЭНТИЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорноговь аймгийн Мандах. сумын Сүйхэнтийн палеонтологийн дурсгалт газар Хожуу Юра (J3)-ийн цаг үед хамаарна. Чулуужсан мод ихээр хадгалагдан үлдсэн гаар нутаг юм..

ЭРГИЛИЙН ЗООН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эргилийн зоо палеонтологийн дурсгалт газар нь

Хожуу Еоцен (E2-3 ez)-ын цаг үед хамаарна. Эртний хөхтөн амьтнаас махан идэштэн, бронтотер, ренотер мөн түүнчлэн яст мэлхий олддог.

Дорнод аймаг
1. Их бурхантын цогцолбор дурсгал
2. Шонх Таван толгойн хүн чулуун хөшөө
3. Хэрлэн барс хотын туурь, суварга

ИХ БУРХАНТЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорнод аймгийн Халхгол сумын төв Сүмбэрээс хойш 35 км зайд, Халх голын баруун эргийн тохойн 35 хэмийн налуу энгэрт оршино. Халхын Сэцэн хан аймгийн Илдэн Жун ван Бат-Очирын Тогтохтөрийн /То-Ван/ /1797-1868/ санаачилга, удирдлагаар 1859-1864 онд бүтээсэн энэ дурсгал “Их шүтээн”, “Их бурхант” хэмээн олноо алдаршжээ. Найман аюулаас аврагч Жанрайсиг /Жигжиджав/ бурхны дүр эл шүтээнийг То ван болон Сэцэн хан аймгийн хошуу ноёд ихэс дээдэс чулуугаар хэвтээ байдлаар бүтээн залахаар шийдэж аймаг, хошуу нутгийнхны хандив хөрөнгөөр зуу шахам гар урчуудыг оролцуулж урлан бүтээсэн байна. 90 тохой буюу 30 метр уг бурхныг их, бага хоёр хүрээн дотор цогцлуулжээ. Том хүрээ нь 220х97 м бөгөөд үүний дотор талд дунджаар165х110 см хэмжээтэй 20 ланз үсгийг хэвтээ байдлаар шигтгэж, бага хүрээн дотор 200х110 см орчим 12 ширхэг суврага болон Их бурхныг тойруулан чулуугаар урласан 20 гаруй жижиг бурхны дүр бүтээсний нилээд нь өдгөө хүртэл хадгалагдан үлджээ.

ШОНХ ТАВАН ТОЛГОЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорнод аймгийн Халх гол сумын төвөөс өмнө зүгт 7 км зайд, Шонх таван толгой хэмээх газарт XII-XIV зууны үеийн хоёр хүн чулуу байсан бөгөөд нэг нь одоо Монголын Үндэсний Музейд үзмэрт хадгалагдаж байна. Цагаан өнгийн гантиг чулуугаар, түшлэгтэй исэр сандалд заларч буй эр хүний дүрсийг тун уран чадварлаг цоолборлон урласан, эвдэрч хэмхэрсэн зүйл бараг үгүй бүтэн сайнаараа байгаа нь тун онцлог юм. Зүүн гартаа урт иштэй цомбон хундага барьж баруун гараа сандлын тохойвч дээр тавин суужээ. Зузаан хүрээтэй, оройдоо жинс, ардаа залаа бүхий дүгрэг малгай өмсөж хоёр чихний араар багцалж боосон шивилгэр гээгэг унжуулжээ. Баруун ташаандаа мөлгөр булантай, зүүн ташаандаа дөрвөлжин хэлбэртэй хавтага зүүсэн нь онооны завсраар цухуйж харагдана. Хөлдөө шовгордуу хоншоортой, нимгэвтэр ултай гутал өмссөн нь хормойн дороос цухуйж сандлын доорх тавцанд гишгэсэн байна. Сандлын хөл хоорондоо зөрөлдсөн ба уулзвар дээр нь цэцэг хэлбэрийн тав гаргаж түшлэгийн арыг цэцгэн хээгээр чимжээ. Дурсгалд хүний зүс царай, бие бялдрын хэмжээ харьцааг нарийн сайн илэрхийлж уран чадварлаг дүрслэжээ. Энэхүү хүн чулуу нь Монголын түүх, соёл, шинжлэх ухаан, дүрслэх урлагийн томоохон төлөөл болно.

ХЭРЛЭН БАРС ХОТЫН ТУУРЬ, СУВАРГА, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Баруун Дөрөө нуурын

зүүн урд Хэрлэн Барс хот оршино. Дурсгалыг 1953 онд эртний судлалын хайгуулаар Хэрлэн Барс хотын хуучин үлдэгдэлтэй холбогдох хоёр хэрмийг ойролцоо нь илрүүлж олсон байна. 1953-1955 онд археологич Х.Пэрлээ Барс-1 хотын хэрмийн доторх дөрвөн барилга, бага хэрмийн орчин тойрны жижиг барилгын суурь, мөн шохой шатааж байсан зуухны ор зэргийг малтан шинжилж олон, том бурхны сэнтий, дээврийн хөх тоосгон ваар, том жижиг хэмжээний угалзтай, угалзгүй тоосго, шавар баримал, ур хийц сайтай бурхны үлдэгдэл, бурхны баримал чимэглэлийн хэсэг, жансагийн мал адгуусны дүрс, цац, сийлбэртэй мод, яс, төмөрлөг зүйл илрүүлэн олж уг барилга нь бурхан шүтээний газар байсан болохыг тогтоосон байна. Монгол нутаг дахь Хятаны үеийн хот суурины томоохон дурсгалын нэг юм.

Дундговь аймаг
1. Сүм Хөхбүрдийн балгас
2. Хүрэн духын палеонтологийн дурсгалт газар
3. Ярх уулын чулуун зэвсгийн үеийн бууц
4. Дэл уулын хадны зураг, бичээс
5. Сангийн далай хийдийн Цогчин дуган
6. Үнстийн хийдийн Цогчин дуган

СҮМ ХӨХБҮРДИЙН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт байх Хөх бүрд хэмээх нуур оршино. Нуурын дунд талын жижиг арал дээр XYI-XYII зууны үед баригдсан чулуун барилгын туурь байдаг. Туурийг тойрон 4 хэсэг чулуун өрлөг байна. Барилгын урдуур 40 метр урт давхар чулуун хэрэм байжээ. Энэ чулуун байгуумжид хэрэглэсэн чулууны ижил нь өмнө зүгт 200 гаруй км алсад байгаа бөгөөд тэндээс тэмээн хөсгөөр тээж ирсэн гэж таамагладаг. Тухайн дурсгалыг сонгосон газрын байршил болон барилгын ханын өрлөг ихэд онцлогтой.

ХҮРЭН ДУХЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дундговь аймгийн Баянжаргалан сумын Хүрэн духын палеонтологийн дурсгалт газар нь Түрүү цэрд (K1)-ийн цаг үед хамаарна. Дун, шавж, шанаганцар, усны махан идэшт мөлхөгч, үлэг гүрвэлээс игуанадонтид, харпимимус, пситтакозавр олддог.

ЯРХ УУЛЫН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕИЙН БУУЦ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Ярх уулын орчим нь доод палеолитын үед холбогдох чулуун зэвсгийн дурсгалт газар юм. Эндээс хасын хольцтой шаргал өнгийн цахиурын төрлийн чулуугаар хийсэн олон төрлийн чулуун зэвсгүүд дундаас гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүдийн хийсэн арга барил, хэв шинжээрээ Өмнөд Ази, Европ, Африкын доод палеолитын ашелийн үед өргөн тархсан гилбэр ба үзүүр мэсэн зэвсгүүдтэй ижил байна. Ярхын дурсгалыг олж судалснаар гилбэр зэвсэг хийж эзэмшигчдийн нутгийн хил хязгаар нэлээд хэмжээгээр тэлэгдэж сонгодог гилбэр зэвсэгтэн гэж нэрлэгддэг Африк, Баруун европ, Бага Ази, өмнөд Энэтхэгтэй нэгэн адил Төв Азийн нутаг, түүний дотор Монгол орон багтах нь эргэлзээгүй болсон билээ

хэмээн ахмад үеийн археологичид дүгнэсэн юм. Монгол орны палеолитын хөгжлийн зүй тогтлыг харуулж чадахуйц Ярхын дурсгалын нэг онцлог нь гилбэр ба үзүүр мэсэн зэвсэг үйлдэгчид нь өрнө зүгийн доод палеолитын үеийн хүний нэг адил чулууг засаж, түүгээр хоёр талаас нь засаж ирлэсэн зэвсэг хийх өөрийн тогтсон арга барилтай байжээ хэмээн эрдэмтэд тогтоожээ.

ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг сумын төвөөс баруун урд зүгт 80 км орчим зайд орших, 30 орчим км сунасан хар хүрэн, улаан хүрэн өнгийн босоо хуудаслаг чулуун гадаргуу бүхий намхан уулыг Дэл уул хэмээнэ. Дэл уул нь хадны зургаар нэн баялгийн зэрэгцээ Руни, Монгол, Түвд, Хятад бичээс, дөрвөлжин булш, зэл чулуу, хийдийн туурь зэрэг хэдэн төрлийн дурсгалууд зэрэгцэн оршдог. Дэл уулын хадны зураг тархалтын хувьд жигд хэдий ч дотор нь Баруун зүүн билүүн, Хамар ус, Элст хөтөл, Гучин хоёр хүнт, Өлзийтийн хуудас хэмээн бүлэглэж болно. Мөн “Гучин хоёр хүнт” хэмээх газар орших хөшөө бүхий дөрвөлжин булшны хашлага дээр ямар нэгэн зан үйл гүйцэтгэж буй бололтой ар араасаа цуварсан, гэзэг үсийг тод харуулсан олон хүн болон буга, согоо, тоодог шувуу зэргийг дүрслэн сийлсэн байдаг нь энэ төрлийн дурсгалд түгээмэл бус тохиолддог сонирхолтой дүрслэл юм.

САНГИЙН ДАЛАЙ ХИЙДИЙН ЦОГЧИН ДУГАН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Угтаал сангийн далай хийдийн цогчин дуган нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын төвд оршдог бөгөөд хийдийг 1810 онд байгуулж, Буддын шашныг мандуулж, түмэн амьтныг амар тайван байлгах зорилгоор Цогчин дуганыг 1918-1919 онд барьжээ. Цогчин дуганыг бариулсны дараа VIII Богд Жавзандамба өргөж, түүний айлтгаснаар Жапүтэй /айлтгалтай/ сүм хэмээн Дамбадаржаалин /шашныг бадруулагч/ гэж нэр хайрласан байна. Сангийн далай хийдийн Цогчин дуган нь 10 сүм дугантай, 300 лам хурдаг, цам тоглодог гол дуган байжээ. Цогчин дуганг бариулах хөрөнгө мөнгийг Даншуур жасаас буюу өглөгийн эздийн өргөл бадрын мөнгөөр бариулж, барилгын мод, шавар шохойг нутгаас нь бэлтгэн хөх тоосго, хөх ваар, чимэглэлийг хийсэн байна. Сангийн далай хийдийн дугануудаас Цогчин дуган нь бараг бүтэн үлдсэн бөгөөд Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газраас 1987 онд хэмжилт судалгаа хийж, сэргээн засварлах зураг төслийг боловсруулан 1990-1991 онд сэргээн засварласан байна. 1991 оноос буддын шашны хурал номын үйл ажиллагаа эхэлсэн байна.

ҮНСТИЙН ХИЙДИЙН ЦОГЧИН ДУГАН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Дундговь аймгийн Цагаан-Овоо багийн төвөөс 5 км зайд оршино. Хийдийг 1800 оны сүүл 1910-аад оны үед барьж байгуулсан бөгөөд тус хийдийг барих газар дээр үед галд шатсан барилгын ор байсан учраас Үнстийн хийд гэж нэрлэсэн байна. Хийдэд Таантрын шүтлэгтэй, Дэмчиг, Дуйнхор дацантай, Цогчин, Ламиран, Майдарын сүм, Дарь эхийн сүм, Маналын сүм, Чойрын сүм, Дордовын сүм бүхий 320 гаруй лам хувраг шавилан суудаг байжээ. Үнстийн хийд нь монгол үндэсний сүмийн барилгын төрх төлөвийг хадгалж үлдсэнээр үнэ цэнтэйгээс гадна монголын суурин орон сууцны төлөвлөлтийг хадгалж чадсанаараа хөдөө орон нутаг дахь бусад хийдүүдээс онцлог.

Завхан аймаг
1. Мөнгөт хясааны хүн чулуун хөшөө
2. Хөх хошууны боомын булшнууд
3. Янживын шилийн хүн чулуун хөшөөд
4. Дааган дэлийн цогцолбор дурсгал
5. Хөшөөтийн амны хүн чулуун хөшөө
6. Яруугийн голын хүн чулуун хөшөөд

МӨНГӨТ ХЯСААНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Алдархаан сумын нутаг, Улиастай хотоос зүүн урагш 30 орчим км зайд, Мөнгөт хясаа хэмээх уулын өвөрт орших хөшөөг Мөнгөт хясааны хөшөө хэмээн. Хөшөөг цагаан саарал өнгөтэй урт гонзгой боржин чулууны дөрвөн талыг нь тэгшлэн засаад хавтгай өргөн нэг талд нь дөрвөн хүний дүрсийг нарийн зураасаар хонхойлон зурж урласан байна. Хөшөөний өндөр 205 см, өргөн нь дээгүүрээ 58 см, доогууураа 70 см, зузаан нь дээгүүрээ 14 см, доогууураа 53 см. Зураг дүрс бүхий өргөн талаар нь зүүн тийш харуулан босгожээ. Хөшөөн дээр дүрсэлсэн хүмүүсийн гэзэг, үс сахал, дээл хувцас зэргийг харахад VI-VIII зууны үеийн Түрэгийн үед холбогдох дурсгал юм.

ХӨХ ХОШУУНЫ БООМЫН БУЛШНУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Баянтэс сумын нутаг Хөх булгийн дээд үзүүрийн зүүн биеэр олон тооны том, жижиг хиргисүүр, тахилын байгууламжууд нэг дор оршино. Эдгээр хиргисүүрүүд голдоо чулуун овоолго бүхий дараас чулуутай. Гадна хүрээний ойролцоо олон жижиг тахилын байгууламжтай байна.

ЯНЖИВЫН ШИЛИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Цэцэн-Уул сумын төвөөс баруун урагш 30 км зайд, Янживын шил хэмээх газарт Түрэгийн үед холбогдох 3 хүн чулуу бий. Тухайн хүн чулууд хойд талдаа дөрвөлжин тахилын байгууламжтай байна. Түрэгийн үеийн хүн чулууг ихэвчлэн хүний ерөнхий дүрс оруулан товгор баримлын байдалтай урладаг бол эдгээр хүн чулууг чулууны хавтгай нүүрэн талд хүний дүрсийг нь хурц үзүүртэй багажаар зурж сийлэхаргаар урласнаараа их өвөрмөц сонин содон юм.

ДААГАН ДЭЛИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Шилүүстэй сумын нутаг, Дааган дэл уулын ар талд Цэцэрлэгийн голын адагт олон арван тахилгын байгууламж дунд босгосон 8 буган хөшөө бүхий нэгэн цогцолбор дурсгал бий. Судалгаа шинжилгээний ном зохиолд “Дааган дэл”-ийн гэдэг нэрээр танил болсон дурсгал юм. Дааган дэлийн буган хөшөөд нь анхны байдлаа алдаагүй харьцангуй бүтэн хадгалагдан үлдсэн маш цөөн тооны дурсгалт газрын нэг болно. Эдгээр хөшөөд нь ихэнх нь бугын хийсвэр дүрслэлтэй боловч зарим хөшөөнд адуу дүрсэлсэн байдаг. Мөн соёо сондор, хүзүүний зүүлт, бөгтөр мөртэй хутга,

товруу чимэгтэй бүс, ханан хээтэй бүс зэргийг уран нарийн сийлжээ.

ХӨШӨӨТИЙН АМНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Алдархаан сумын нутаг, Хөшөөтийн амнаа онцгой уран хийцтэй түрэгийн үед холбогдох нэгэн хүн чулуу бий. Энэ хүн чулууг ногоовтор туяатай цайвар өнгийн гантиг чулуугаар нарийн урлажээ. Толгойн оройг гэдрэг налуу, хамар, хөмсгийг товгор төрхтэйгөөр гаргасан бөгөөд живэр сахлыг тод томруун гаргажээ. Энэхүү хүн чулуунд буруу энгэртэй дээл өмсгөн урласан ба баруун гартаа хундага барьж харин зүүн гарт нь сэлэм агсан бүсэндээ хавтага зүүсэн байдалтай дүрсэлжээ.

ЯРУУГИЙН ГОЛЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Завхан аймгийн Яруу сумын төвийн өмнө, Яруугийн голын урд биеэр нэлээд тооны хүн чулуунууд дөрвөн тусдаа газар байрлана. Хүн чулууд нь цагаан өнгийн шохойлог чулуугаар хийсэн бөгөөд бүгд баруун гартаа жижиг аяга барьсан, зүүн гараа ташаандаа зүүсэн илдний бариул дээр тавьсан байдалтай. Толгойн орой мөлгөр бөөрөнхий, хамар, хөмсгийг нэг үргэлж товгор зураасаар гаргасан ба махирласан живэр сахалтай, чихэндээ цагариган сэнж, бөөрөнхий унжлага бүхий ээмэг зүүжээ. Дээлийн энгэр заам гаргаагүй, дөрвөлжин ялтсан чимэгтэй бүс бүсэлж өмнөө жишүү бариултай жижиг хутга хөндлөн зүүгээд зүүн ташаандаа махир илд агсжээ. Баруун ташаандаа тал дүгрэг хавтага, билүү бололтой богино шулуун эдлэлийн хамт унжуулжээ. Хүн чулуудад чулуун хашлага болон өмнөөс нь зүүн урагш чиглэсэн зэл чулууны үлдэгдэлтэй. Яруугийн голын хүн чулуу он цагийн хувьд Түрэгийн үед холбогдоно.

Орхон аймаг

1. Айрагийн гозгорын оршуулгын газар

АЙРАГИЙН ГОЗГОРЫН ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Орхон аймгийн Жаргалант сумын нутаг Айрагийн гозгор хэмээх газарт бүлэг оршуулгын газарт оршин байна. Тухайн дурсгалыг анх 2008 онд илрүүлсэн бөгөөд 2014-2019 оны хооронд Монголын Үндэсний музейн судлаачид 100 гаруй булшнаас 23 булшийг малтан судлажээ. Энэхүү дурсгал нь он цагийн үед НТ I зууны дунд үеэс НТ III зууны үед холбогдож байгаа нь Хүннүгийн эзэнт гүрний сүүлчээс Сяньбийн хаант улсын үетэй давхцаж байна. Айрагийн гозгорт малтан судалсан булшны оршуулгын байгууламж, зан үйл, гарсан олдвор хэрэглэгдэхүүн, хүний ясанд хийгдсэн судалгааны үр дүнг үзвэл Өвөр Монголын нутагт малтан шинжилсэн Сяньби нарын оршуулгатай ижил төстэй байдал ажиглагддаг.

Өвөрхангай аймаг

1. Андай сайр, Шанд гол, Таацын гол, Татал голын палеонтологийн дурсгалт газрууд
2. Төвхөн хийд
3. Өөшийн нуруу, Хөөвөрийн палеонтологийн дурсгалт газар
4. Онгийн голын цогцолбор дурсгал
5. Хөгшин тээлийн балгас
6. Гүмбийн дэнжийн буган чулуун хөшөө

7. Зараа толгойн зураг, бичээс
8. Мойлтын амны чулуун зэвсгийн бууц
9. Мэлхий толгойн туурь, мэлхий чулуу
10. Ханджамцын суварга
11. Хархорум хотын туурь, чулуун яст мэлхий
12. Шанхын хийдийн дуганууд
13. Эрдэнэ зуу хийдийн цогцолбор

АНДАЙ САЙР, ШАНД ГОЛ, ТААЦЫН ГОЛ, ТАТАЛ ГОЛЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Андай сайр, Шанд гол, Таацын гол, Татал голын палеонтологийн дурсгалт газрууд Олигоцен, Шанд голын цаг үе (E3 sg)-д хамаарна. Эртний хөхтөн амьтан олдоно.

ТӨВХӨН ХИЙД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын төвөөс зүүн хойш 20 гаруй км зайд Төвхөн ширээт хэмээх уулын оройн хаданд Төвхөн хийд оршдог. 1648 онд I Богд Занабазар арав гаруй настай байхдаа энэхүү байгалийн өвөрмөц тогтоцтой газрыг үзэж 1651 оны үед нямбалан сууж номын бясалгал хийх чулуун туурга ханатай жижиг байшин бариулсан байна. 1688 оны Галдан бошготын самуун дайн эхэлснээс хойш тэр бүтээлийн сүмийг ашиглаагүй учир бүр мартагдахад хүрснийг 1773 оноос хийд болгон хурал номын ажлыг сэргээж, түүнээс хойш Төвхөн хийд хэмээн нэрлэгдэх болсон.

ӨӨШИЙН НУРУУ, ХӨӨВӨРИЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын Өөшийн нуруу, Хөөвөрийн палеонтологийн дурсгалт газар Түрүү цэрд (K1)-ийн цаг үед хамаарна. Ургамал, шавж, моллюск, гүрвэл, үлэг гүрвэлээс анкилозаврид, пситтакозавр, мезозойн хөхтөн олдоно.

ОНГИЙН ГОЛЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг, сумын төвөөс урагш 17 км зайтай Мааньт уулын өвөр хормойд Түрэгийн нэгэн томоохон цогцолбор дурсгал байдаг. Судлаач эрдэмтэд оршин буй газрынх нь нэрээр Онгийн голын, Мааньтын гэх мэтчилэн олон янзаар нэрлэж бичсээр иржээ. Хөшөөний бичээсийг тайлан уншсан эрдэмтийн судалгаанаас үзэхэд уг дурсгалыг Түрэгийн Ильтерес хаан, Ильбилгэ хатан хоёрт зориулан босгожээ. Эндэх хүн чулуудын хийц загвараас түрэг угсаатны тахил шүтээний байгууламжийг цогцлон барихад дагаж мөрдөх зан үйл, дүрслэн хийсэн хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, зэрэг дэв, албан тушаалын ялгааг тодруулан нягтлах боломжтой.

ХӨГШИН ТЭЭЛИЙН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг Хангайн нурууны

баруун өмнөд үзүүр Хан Хөгшин ууланд оршино. Хөгшин тээлийн балгас буюу Хубилайн цэргийн хот нь Хан Хөгшин уулын зүүн суга Их модны ам, Бага модны амны гурван хэсэг газар барьсан том хэрэм, Их модны амны адгийн Цагаан толгойн өвөрт буй нутгийнхан “Дарь эхийн сүм” хэмээн нэрлэдэг барилгын үлдэц зэргээс бүрддэг. Судлаачид энэхүү хотын туурийг Хубилай, Ариг бөх хоёрын Монголын хаан ширээ булаалдсан XIII зууны хоёрдугаар хагасын түүхэн үед буюу 1275-1278 онд байгуулсан хэмээн үзжээ.

ГҮМБИЙН ДЭНЖИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс баруун зүгт 10 км орчим орших Орхон голын хойно орших жижиг дэнжийг Гүмбийн дэнж хэмээн нэрлэнэ. Тус газарт саарал өнгийн чулуугаар үйлдсэн бугын хийсвэр дүрслэлтэй нэгэн хөшөө бий. Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байрладаг.

ЗАРАА ТОЛГОЙН ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс баруун тийш Зараа хэмээх хадтай хошууны өвөрт уг дурсгал оршино. Энэхүү хаднаа хүний хөрөг, 4 мөр хятад бичээсийг тод дүрсэлсэн бөгөөд эдгээрийн зүүн дээд талд хүний хамар нүд гэмээр дүрс тод дүрслэгджээ. Хүний нүүрний төрх, малгай, гурвалжин энгэртэй хувцас, сахал, гар зэргийн дүрслэл нэлээд тодорхой харагдаж байна.

МОЙЛТЫН АМНЫ ЧУЛУУН ЗЭВСГИЙН БУУЦ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс баруун хойно 1 км зайд Орхон голын хойд эрэгт Мойлтын аманд орших хуучин чулуун зэвсгийн үеийн энэ бууц сууриг Анх 1949 онд археологич А.П. Окладниковоор удирдуулсан түүх угсаатны зүйн шинжилгээний хамтарсан экспедицийнхэн илрүүлж олсон ба 1960, 1961, 1964, 1969 онд А.П.Окладников,А.П. Деревянко , Д.Дорж, Д.Цэвээндорж нарын удирдсан шинжилгээний ангийнхан малтан судалжээ. Уг сууринги соёлт давхаргын зузаан нь 1.5-2 м бөгөөд малтлагын явцад дээд палеолитын түрүү үеэс эхлэн мезолит ба неолитын эхэн үеийг дэс дараалан хамарсан дөрвөн соёлт давхарга илэрчээ. 2004 онд Орхоны хөндийн соёлын дурсгалт газар Дэлхийн өвд бүртгэгдэхэд энэхүү дурсгалт газар нь чухал түлхэц болсон билээ.

МЭЛХИЙ ТОЛГОЙН ТУУРЬ, МЭЛХИЙ ЧУЛУУ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвөөс урагш 1 км орчим зайд Мэлхийт толгойн оройд оршино. Хотын туурь нь 106х78 метр хэмжээтэй тэгш өнцөгт хэлбэрийн шавар хэрмэн далангаар хүрээлэгдсэн бөгөөд түүний дотор талд тус тусдаа далантай зэрэгцээ байрлах 2 барилгын ортой. Зүүн талын далангийн голд боржин чулуун яст мэлхийг байрлуулсан байна. Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байрладаг.

ХАНДЖАМЦЫН СУВАРГА, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорум сум Эрдэнэзуу хийдийн баруун хойд хэсэгт 1674 онд Өндөр гэгээний эх Ханджамцад зориулж босгосон суварга оршин байна. Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт

газрын хамгаалалтын бүсэд байрладаг.

ХАРХОРУМ ХОТЫН ТУУРЬ, ЧУЛУУН ЯСТ МЭЛХИЙ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Монголын эртний нийслэл Хархорум хотын туурь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт оршдог. Хархорум хотын суурь тавигдсан нь VIII зуунаас эхэлсэн бөгөөд түүнийг “Тайгал Шивээ” хэмээн нэрлэж байв. XIII зууны үед Чингис хаан улсынхаа нийслэлийг Орхон гол, Хар Хүрэмт уул хоёрын завсар төвлөрүүлэхээр шийдсэн ба түүний хүү Өгөдэй хааны үед 1235 оноос хотыг өргөтгөн бариулж эхэлжээ. Хархорум хотын туурийн төв хэсэгт саарал өнгийн боржин чулуугаар хийсэн, дунджаар 2.6 метр урт, 1 метр өндөр, 1.2 метр өргөн бөгөөд жин нь 10 тонн орчим чулуун мэлхий оршин байна. Түүхийн сурвалж бичгийн мэдээ, аялан жуулчлагсадын замын тэмдэглэлд Хархорум хот Монголын их гүрний засаг захиргаа, худалдаа, гар үйлдвэр, соёлын төв байсан, өрнө дорнын олон орныг холбосон эдийн засаг, соёлын чухал зангилаа газар болж байсан тухай дурджээ. 2004 онд Орхоны хөндийн соёлын дурсгалт газар Дэлхийн өвд бүртгэгдэхэд Хархорум хотын туурь нь чухал түлхэц болсон билээ.

ШАНХЫН ХИЙДИЙН ДУГАНУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Түшээт хан аймгийн Түшээт ханы хошуу буюу одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Шанх багийн төвөөс зүүн урагш 3-4 км зайд Шанх уулын өмнө Харзын голын баруун дэнж дээр анх энэхүү хүрээ хийд байгуулагджээ. Тус хүрээг Өндөргэгээн Занабазарын /1635-1723/ арван гурван сүүдэр дээр буюу Эеэр Засагчийн тавдугаар /1647/ оны гал гахай жил байгуулжээ. Анх 1654 онд Номын их хүрээ Орхон голын хөндийгөөс Хэнтий уулын өвөр тийш нүүхэд өндөр гэгээн Занабазар төрсөн дүү сайван Билбидоржид Номын Их Хүрээний үндсэн хэсэг, түүхийн олон үнэт дурсгал, сурвалжийг үлдээн нүүсэн гэдэг. Баруун талд үлдэж хоцорсон хийд ард түмний дунд “Баруун хүрээ”, Шанх уулын өвөр талд суурьших болсноос “Шанхын хүрээ” гэж нэрлэгддэг байна. Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байрладаг.

ЭРДЭНЭ ЗУУ ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Эрдэнэ зуу хийдийг 1580 онд Автай сайн хан, дүү Түмэнхэн ноёны хамт III Далай ламтай уулзаж өөрийн нутагт сүм хийд байгуулахаар амласанд III Далай лам Хархорум хотын хуучин нэгэн сүмийг сэргэхийг зөвлөсний дагуу 1585 онд эртний Тахай балгасан дахь сүмийг сэргээн босгож дуусгасан нь одоогийн Эрдэнэ зуу хийдийн Гол зуу сүм юм.

Гадууpаа 108 суварга бүхий 400х400 метрийн хэмжээтэй, дөрвөн талдаа асар хаалгатай хэрмэн дотор байдаг монголын анхны буддын энэ хийд 1792 онд 62 сүм, 500-аад барилгатай байснаас өдгөө 18 сүм дуган үлджээ. Эрдэнэ зуу хийдийг цогцлон босгож байсан эхний үед шарын шашны ёс горим төдий л гүн нэвтрэн дэлгэрээгүй байсны учир хийдийн ерөнхий төлөвлөлтийг шийдвэрлэхдээ монголчуудын уламжлан баримталсаар байсан ертөнцийн чиг зүгийг хүндэтгэх билэгдлийн дагуу шийдвэрлэсэн ба уламжлалт

хот байгуулалтын дагуу баригдсан цорын ганц хийд гэж үздэг.

Өмнөговь аймаг

1. Баянзаг, Төгрөгийн ширээ, Авдрант, Алаг тээгийн палеонтологийн дурсгалт газар
2. Баянзагийн чулуун зэвсгийн дурсгалт газар
3. Цахиуртын хөндий чулуун зэвсгийн дархны газар
4. Хэрмийн цав, Цагаан хошуу, Бүгийн цав, Гурилын цав, Алтан-Уул, Нэмэгт, Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газар
5. Могойн дэлийн палеонтологийн дурсгалт газар
6. Шар цавын палеонтологийн дурсгалт газар
7. Бичигтийн хадны зураг
8. Байшин цав, Хуурай цав, Үрэлбэ, Амтгайн палеонтологийн дурсгалт газрууд
9. Дэмчигийн хийд, Эрээтийн хийд, Цогзолын хийдийн туурь
10. Жавхлант хайрханы хадны зураг
11. Алгуй-Улаан цавын палеонтологийн дурсгалт газар

БАЯНЗАГ, ТӨГРӨГИЙН ШИРЭЭ, АВДРАНТ, АЛАГ ТЭЭГИЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Төгрөгийн ширээ, Авдрант, Алаг тээгийн палеонтологийн газрууд. Хожуу Цэрд, Жодохтийн цаг үе (K2 dg)-д хамаарна. Гүрвэл, шувуу, үлэг гүрвэлээс протоцератопс, велоцератопс, шувууяа, анкилозаврид, орнитомимид, үлэг гүрвэлийн өндөг олдоно.

БАЯНЗАГИЙН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Баянзагийн суурин нь Өмнөговь аймгийн Булган сумын нутагт буюу Говийн Алтайн уулсын өмнөд төгсгөл, Гурвансайхны нуруу орох замд оршино. Эндээс олон мянган чулуун зэвсгийн дурсгал болон ваарны хагархай олдсоноос хамгийн сонирхолтой нь археологийн ухаанд “говийн үлдэц” нэрээр орсон үлдцэн хусуур юм. Зэвсгийн төрөлд сумны зэв, зуулга ирт эдлэл, хутган ялтас, хусуур зонхилох хувийг эзлэх бөгөөд жадны үзүүр буюу гилбэр хэлбэрт зэвсэг ч тааралдана. Мөн эндээс мезолит, боловсрон неолитын үеийн ваар сав шавар ваар савны хагархай ихээр олддог ба дээд палеолитын үеэс шавраар ваар сав хийх оролдлого бий болж, үйлдвэрлэдэг болсныг гэрчилж байна. Баянзагийн суурин нь шинэ чулуун зэвсгийн үед холбогдоно.

ЦАХИУРТЫН ХӨНДИЙ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДАРХНЫ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998, №235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өвөрхангай аймгийн Богд, Өмнөговь аймгийн Булган сумдын нутгийн заагт оршино. Энэ сууриныг 1995 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан “Монголын чулуун зэвсгийн үе” төслийн хээрийн шинжилгээний ажлын үеэр хийгдсэн хайгуулын явцад анх олж илрүүлжээ. Ойролцоогоор 20 км2 талбай эзлэх энэ суурин нь газрын хөрсөн дээрээ хуучин чулуун зэвсгийн доод шатнаас эхлэн шинэ чулуун зэвсгийн эхэн үеийг хамарсан хэдэн зуун мянган чулуун зэвсгийн дурсгалыг агуулдаг. Он цагийн хамаарлын хувьд асар урт хугацааг хамарсан, өргөн уудам талбайг эзлэн оршсон чулуун зэвсгийн ийм суурин Монгол, Төв Ази төдийгүй дэлхийд маш ховор тохиолддог.

ХЭРМИЙН ЦАВ, ЦАГААН ХОШУУ, БҮГИЙН ЦАВ, ГУРИЛЫН ЦАВ, АЛТАН-УУЛ, НЭМЭГТ, УХАА ТОЛГОДЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хэрмийн цав, Цагаан хошуу, Бүгийн цав, Гурилын цав, Алтан-Уул, Нэмэгт, Ухаа толгодын палеонтологийн дурсгалт газар Хожуу Цэрд, Нэмэгтийн цаг үе (K2 nm)-д хамаарна. Олон төрлийн ургамал, чулуужсан мод, моллюск, матар, гүрвэл, яст мэлхий, олон төрөл, зүйлийн үлэг гүрвэл, үлэг гүрвэлийн мөр олддог.

МОГОЙН ДЭЛИЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Өмнөговь аймгийн Манлай сумын Могойн дэлийн палеонтологийн дурсгалт газар Түрүү цэрд (K1)-ийн цаг үед хамаарна. Ургамал, шавж, моллюск, остракод, загас олдоно.

ШАР ЦАВЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Өмнөговь аймгийн Манлай сумын Шар цавын палеонтологийн дурсгалт газар Хожуу Цэрд, Баян ширээгийн цаг үе (K2 bs)-д хамаарна. Чулуужсан мод, моллюск, үлэг гүрвэлээс завропод, авимимус, үлэг гүрвэлийн мөр.

БИЧИГТИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998, №235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Номгон сумаас урагш 140 км-т Бичигтийн ус хэмээх гар худгийн баруун гар талд орших жижгэвтэр уулын хаднаа сийлмэл зургийн дурсгал бий. Эндэхийн зургийн бүтэц зөвхөн хүний толгойн дүрсээс бүрдэх бөгөөд ганц хоёрхон буга ба үхрийг хүмүүсийн хамт зурсан нь нэн сонирхолтой. Энд нэг хүнийг толгой дээрээ гурван шовх оройтой малгай мэт зүйлс өмссөн, том бүлтгэр нүдтэй зэргээр нүүрийг тод гаргахын хамт элдэв хэрчлээс гаргаснаас гадна эрүүнд нь урт нарийхан сахал бас дүрсэлжээ. Мөн нэг төрлийн дүрсэлсэн зургууд олон давхарлаж зурагдсан нь бөө мөргөлийн болон тахилга шүтлэгтэй холбоотой бололтой.

БАЙШИН ЦАВ, ХУУРАЙ ЦАВ, ҮРЭЛБЭ, АМТГАЙН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Байшин цав, Хуурай цав, Үрэлбэ, Амтгайн палеонтологийн дурсгалт газрууд Хожуу Цэрд, Баян ширээгийн цаг үе (K2 bs)-д хамаарна. Дун, хясаа, ургамал, яст мэлхий, үлэг гүрвэлээс анкилозаврид, орнитомимид, завропод, теропод, тираннозаврид, гадрозаврид, үлэг гүрвэлийн өндөг олдоно.

ДЭМЧИГИЙН ХИЙД, ЭРЭЭТИЙН ХИЙД, ЦОГЗОЛЫН ХИЙДИЙН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших энэхүү гурван хийдийг Говийн догшин ноён нутагт Данзанравжаа байгуулжээ. “Галбын гурван хийд” хэмээн нэрлэгдэх эдгээр хийдийг 1830-1836 оны хооронд барьж байгуулсан бөгөөд хоорондоо 5-6 километр зайтай.

ЖАВХЛАНТ ХАЙРХАНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Жавхлант хайрханы оройн хэсгийн хаднаа хүн, амьтдын дүрсийг цоолборлосон хадны зургийн 200 гаруй зохиомж байна. Ихэнх зургууд хадны үндсэн өнгөнөөс ялгагдах төдий байгаа нь харьцангуй эрт үед бүтээгдсэн хэмээн судлаачид үзсэн байдаг. Мөн зарим эртний гэмээр балархай зургууд дээр хожимхон өөр зургууд давхардуулан зурсан тохиолдлууд цөөнгүй байдаг байна. Уг хадны зургийн дурсгалт газарт хүнийг өвөрмөц хэлбэрээр үйл хөдлөл хийж байгаагаар дүрсэлсэн байдаг ба хүний дүрслэл хамгийн олон тоотой буюу 171 ширхэг байна. Нэгэн хаданд дөрвөн хүнийг бие бие рүүгээ толгойгоороо хандсан байдалтайгаар дүрсэлсний гурвыг нь гурван хуруутай гараа тохойгоор нь дээш өргөн хөлөө алцайн тэнгэр өөд наминчлан зогсож буй байдалтай дүрсэлсний зэрэгцээ толгойд нь урт соновтор маягийн зүйлийг гарган үзүүлсэн эндэхийн хадны зургийн өвөрмөц онцлогийг илтгэн харуулж байгаа төдийгүй Жавхлант хайрхан уулын хадны зургууд сүсэг бишрэлийн зан үйлийн үр дүнд бүтээгдсэн хэмээн тодорхойлон дүгнэх саналыг судлаачид дурдаад ихэвчлэн тэнгэр өөд залбиран наминчлан буй хүний зураг голлох байр суурийг эзэлж байгаад тулгуурлан он цагийг неолит, энеолит үеэс эхлэн хүрэл зэвсгийн сүүл үед холбогдуулан авч үзжээ.

АЛГУЙ-УЛААН ЦАВЫН ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт орших Алгуй-Улаан цавын палеонтологийн дурсгалт газар Түрүү Цэрд, Хөхтээгийн цаг үе (K1 hh)-д хамаарна. Яст мэлхийн хуяг, үлэг гүрвэлийн яс, өндөг, үүр олдоно.

Сүхбаатар аймаг
1. Алтан овооны хүн чулуун хөшөөд
2. Ламтын хүн чулуун хөшөөд
3. Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөд
4. Устай бургастайн чулуун зэвсгийн бууц
5. Сөдөтийн цагаан чулууны бичээс
6. Таван толгойн цогцолбор дурсгал
7. Шивээтийн хүн чулуун хөшөөд

АЛТАН ОВООНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвийн зүүн хойно дөрвөн хүн чулуун хөшөө бий. Эдгээрийг нутгийн ард олон “ноён, хатан, хүү, бэр” хөрөг хэмээн нэрлэж хадаг тавин идээ, цагааныхаа дээжийг өргөж хүндэлсээр иржээ. Энэхүү дурсгалт газар нь XIII-XIV зууны монголчуудын бүтээсэн дурсгал болох нь нэгэнт тогтоогджээ. Энэхүү дөрвөн хөргийг өөр өөр төрлийн, өнгө зүс ялгаатай чулуугаар харилцан адилгүй ур чадвар гарган хийсэн боловч ерөнхий хэлбэр байдал дүрсэлж гаргасан хувцас, эд хэрэглэл нь нэгэн цаг үе, нэг соёлын хүрээнд хамаарахыг илтгэнэ.

ЛАМТЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн урагш 40 гаруй км зайд, Ламт хэмээх уулын зүүн

хормойд, Ламтын заставын баруун урд талд Монголын XIII-XIV зууны үеийн гурван хүн чулууд оршин байна. Хүн чулуудыг баруун гартаа урт иштэй цөмбөн хундага барьж, зүүн гараа өвдөг дээр тавин түшлэгтэй сандал дээр суужсан, Нарийн ханцуйтай урт дээлийн гадуур богино ханцуйтай, мөн урт хормой бүхий хувцас давхарлан өмссөн байдалтай урласан байна.

ХӨРГИЙН ХӨНДИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 45 км зайд Хөргийн хөндий хэмээх хойноос урагш тогтсон нарийн хөндийн хойд хэсэгт баруун хойноос зүүн тийшээ цуварсан байдалтай 7 хүн чулуу оршин байснаас Сүхбаатар аймгийн музейд 2 хүн чулууг зөөж байрлуулсан байна. Энэхүү уг газарт одоо нийт 6 хүн чулууд оршин байна. Хүн чулуудыг галт уулын саарал хүрмэн чулуугаар үйлдсэн бөгөөд баруун урд байрлах хүн чулууг бүдүүн ширхэгтэй боржин чулуугаар үйлджээ. Хүн чулуудын дүрслэлийн арга барил ихэд өвөрмөц бөгөөд 4 хүн чулууг тодорхой нүцгэн, эр бэлгийн эрхтэнг тодорхой гаргаж өгсөн байна. Хөшөөдийн ерөнхий загвар, тэдгээрийн байрлуулж тавьсан байгууламж, дүрсэлж гаргасан хувцас, эд юмс зэрэг нь дурдсан хөргүүд нэгэн цаг үед бүтээгдсэн, түүх соёл, угсаатны хувьд нэг л соёлын хүрээнд багтах XIII-XIV зууны монголчуудад хамаарах зүйл болох нь тодорхой.

УСТАЙ БУРГАСТАЙН ЧУЛУУН ЗЭВСГИЙН БУУЦ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших Устай бургастай хэмээх газар орших шинэ чулуун зэвсгийн үед холбогдох бууц сууриныг 1961 онд археологич А.П.Окладников, Н.Сэр-Оджав, Д.Дорж нар олж илрүүлсэн байна. Энэ дурсгалын онцлог нь газрын хөрсөн дээр чулуун зэвсэг, багаж ил тархсан байдалтай олддог. Олдвор хэрэглэгдэхүүнд бэлдэц, үлдэц, цөөн тооны зэвсгийн зүйлсээс гадна олон тооны залтас, ялтас зэрэг олдсон байдаг. Дурсгалаас олдсон зэвсэг багажийн зүйлс нь хийсэн материалын хувьд олон төрөл байгаа хэдий ч он цагийн хувьд мезолитын төгсгөл неолитын эхэн үед холбогдоно.

СӨДӨТИЙН ЦАГААН ЧУЛУУНЫ БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Наран сумын төвөөс зүүн урд зүгт 30 км зайд, Сөдөт хэмээх газарт цагаан өөхөн чулууны гадаргуу дээр 3 хэсэг газар Хятад ханзаар бичсэн эртний бичээс бий. Чулуун дээрх бичээсийн зарим үсгийг нэлээд томоор сийлсэн харагдана. Эдгээр бичээсийг тайлж уншсан судлаачдын бичсэнээс үзвэл дээрх бичээсийг 1409 онд Мин улсын үед, 1696 онд Манжийн үед Монгол улсын нутагт болсон хоёр томоохон үйл явдалтай холбогдуулан сийлж үлдээсэн ажээ.

ТАВАН ТОЛГОЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Онгон сумын төвөөс баруун урагш 30 гаруй км зайтай Таван толгой хэмээх намхавтар ухаа толгодын дунд хоёр хөрөг хүн чулуу бий. Энэ

хоёр хөрөг нь хийц, дүрслэл, бүтээсэн ур чадварын хувьд нийт Монгол нутагт буй хүн чулуунуудын дотор нэн онцгой бөгөөд ерөөс Төв Азийн хүн чулуу бүтээх урлагийн оргил хэмээн үзэж болох юм. Эдгээр хөргүүдийг цагаан болон хөх өнгийн гантиг чулуугаар түшлэгтэй, зөрүүлсэн хөлтэй исэр сандалд залран сууж буй байдлаар урлажээ. Дээлийн энгэр, ар далан дээгүүр үүлэн дунд нисэж яваа луугийн дүрсийг маш уран чадварлаг сийлэн дүрсэлжээ. Хормойн дороос мухар хоншоортой, уллагаа бүхий гутлын хамар цухуйх ба хөлөөр сандлын доорх тавцанг гишгэжээ. Эдгээрийн нэн онцлог нэгэн шинж нь, залран суусан исэр сандлын түшлэгийг барын арьсаар бүрхэж, тэр тусмаа нэг нь барын толгой дээр гишгэсэн дүрслэлтэй байгаа нь ертөнц дахиныг донсолгосон алтан ургийн их хаадын хэн нэгэн нэр бүхий төлөөлөгчийг дүрсэлсэн болохыг илтгэнэ.

ШИВЭЭТИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сүхбаатар аймгийн Онгон сумын төвөөс өмнө зүгт 40 гаруй км зайд Шивээт хэмээх намхавтар ухаагийн зүүн урд энгэрт XIII-XIV зууны үеийн ур хийц сайтай 3 хүн чулууд оршин байна.

Сэлэнгэ аймаг
1. Ардын намын Төв хороо, Түр Засгийн газар байрлаж байсан байшин
2. Амарбаясгалант хийдийн цогцолбор

АРДЫН НАМЫН ТӨВ ХОРОО, ТҮР ЗАСГИЙН ГАЗАР БАЙРЛАЖ БАЙСАН БАЙШИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төв, 1дүгээр багийн нутаг дэвсгэр дээр байрладаг. Энэхүү байшинд 1921 онд Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн Газар байрлаж байжээ.

АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Манжийн төрөөс Ар Монголд шарын шашныг хүчтэй дэлгэрүүлэх зорилгын дүнд байгуулсан хийд тус хийд нь Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу буюу одоогийн Сэлэнгэ аймгийн Баруун Бүрэн сумын нутаг Бүрэнхан уулын өвөрт Ивэн голын хөвөөнд оршино. Уг хийдийг Манжийн Найралт төвийн 5-р он буюу 1727 оноос байгуулж эхлэн 1737 онд барьж дуусгажээ. Амарбаясгалант хийд нь хийц, загвар, үзэмжийн хувьд дорнын уран барилгын хэв загварыг өөртөө шингээсэн чуулбар байв. Амарбаясгалант хийдийг байгалийн үзэсгэлэнт байдалтай хослуулан бүтээсэн бөгөөд Монголын шарын шашны тэргүүн өндөр гэгээн Занабазарт зориулагдсан ариун дагшин шүтээн, Монголын түүх, соёлын хосгүй нандин дурсгалын нэг юм.

Төв аймаг
1. Өнгөтийн цогцолбор дурсгал
2. Морин толгойн булшнууд
3. Ноён уулын Хүннүгийн язгуурtны оршуулгын газар
4. Гуа дов
5. Гашуун балгастайн гэрэлт хөшөө

6. Хүүхэн хонгорын хүн чулуун хөшөөд
7. Чихэртийн зоон хүннүгийн оршуулгын газар
8. Бороогийн суурин
9. Дуутын хар чулууны бичээс
10. Их хөшөөтийн цогцолбор дурсгал
11. Манзуширын хийдийн туурь, бурхадын зураг
12. Бүрхийн дөрвөлжин
13. Сарьдагийн хийдийн туурь
14. Тэрэлжийн дөрвөлжин
15. Уянгын үзүүрийн хадны зураг
16. Гүнжийн сүмийн үлдэгдэл
17. Тоньюкукын цогцолбор дурсгал

ӨНГӨТИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Туул голын хойд хөндийн Өнгөт уулын бэлд Түрэгийн үеийн томоохон тахилын онгон байна. Өнгөтийн цогцолбор нь 55х38м хэмжээтэй шороон далангаар хүрээлэгдсэн, далан дотор 30 гаруй хүн чулуу, томоохон хээтэй хавтангууд байна. Шороон далангийн зүүн талаас энэ хоёр хүн чулуутай ижил чиглэлээр балбал, зэл чулуудыг зүүн тийш цувруулан зоосон нь хоёр км гаруй үргэлжлэх ба чулууны тоо нь 550 гаруйд хүрдэг. Өнгөтийн дурсал нь Монгол болоод Төв Азид судлан шинжилсэн хүн чулуут цоцгобор дурсгал дотроос хамгийн олон хүн чулуутайгаараа онцлог.

МОРИН ТОЛГОЙН БУЛШНУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгойн энгэрт нэг доор 120 дөрвөлжин булш, 3 буган хөшөө, тэдгээрийн зүүн талд зэргэлдээ 24 хүннү булш байна. Хүннү булшнаас илэрсэн хамгийн сонирхолтой олдвор бол Хэл хуур билээ. Энэхүү хэл хуур нь энэ төрлийн хөгжмийн зэмсгийн одоогоор мэдэгдэж буй хамгийн эртнийх ч байж болох агаад лавтай 2000 гаруй жилийн тэртээ холбогдох юм.

НОЁН УУЛЫН ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ноён уул нь Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын заагт оршино. Уулын баруун талын Сүжигт, өмнөд талын Журамт, зүүн талын Хужирт гэсэн 3 аманд нийт 230 орчим Хүннү булш бий. Дурсгалт газрын ихэнх булш газрын өнгөн хөрсөн дээр ил цухуйх дөрвөлжин хэлбэрийн гол байгууламж, түүний өмнө талд залгуулан байгуулсан урт гонзгой үүдэвчтэй Хүннүгийн язгуртны булшнууд юм. Ноён уулын дурсгалт газраас Хүннүгийн үед холбогдох ширмэл ширдэг, хувцас, эдлэл хэрэглэл, алт мөнгөн эдлэл зэрэг ховор нандин олдворууд ихээр олддог.

ГУА ДОВ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Баянжаргалан сумын нутаг Хэрлэн мөрний баруун талд, сумын төвөөс зүүн хойш 28 км зайд Гуа дов хэмээх эртний хотын туурь оршин байна. Судалгааны үр дүнд Гуа дов нь 180х200 м хэмжээтэй дөрвөлжин хэлбэрийн зэрэгцээ олон модон багана бүхий вааран дээвэртэй саравчит хашаагаар хүрээлүүлсэн, тэрхүү хашааны 4 тал бүрийн дунд хэсэгт 2 давхар вааран дээвэртэй сүрлэг том хаалгатай, хашааны баруун хойд хэсгийг эзлүүлэн байгуулсан 40х30 м хэмжээтэй 1 том барилга, түүний зүүн хойд талд залгаа байдалтай урт гонзгой хэлбэрийн барилгатай, хашааны зүүн өмнөд буланд хүний гараар бүтсэн цөөрөмтэй, хэд хэдэн том барилгатай байсан хэмээн үзэж холбогдох он цагийг НТӨ II зууны сүүлийн хагасаас НТӨ I зууны дунд үед буюу Хүннү гүрний үед холбогдоно хэмээн үзжээ.

ГАШУУН БАЛГАСТАЙН ГЭРЭЛТ ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Баянцагаан сумын төвөөс хойд зүгт 45 км зайд 1-р багийн нутаг, Тарлан балгастай хэмээх газарт орших тахилын онгон, хөшөө чулуу. Хар саарал өнгийн боржин чулуун нийт 5 хөшөө чулуутай.

ХҮҮХЭН ХОНГОРЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Баянцагаан сумын төвөөс зүүн хойш 30 гаруй км зайд, Хүүхэн хонгор уулын өвөр бэлд чулуун байгууламжийн дунд гадаад төрх байдал нэлээд элэгдсэн XIII-XIV зууны үеийн хоёр хүн чулууд оршин байна. Тухайн дурсгал нь төвийн бүсэд хосоороо оршин буй XIII-XIV зууны үеийн хүн чулууд билээ.

ЧИХЭРТИЙН ЗООН ХҮННҮГИЙН ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор батлагдсан. Төв аймгийн Баянцагаан сумын нутагт, сумын төвөөс өмнө зүгт 12 км зайд Чихэртийн зоо хэмээх газарт Хүннүгийн бүлэг оршуулгын газар оршино. Дурсгалт газрыг анх 2013 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид археологийн авран хамгаалах хайгуул судалгааны үед 287 булш илрүүлж бүртгэсэн байна. Тухайн дурсгат газарт хүннүгийн жирийн иргэдийн гэх дугуй цагирган дараатай хамгийн том булш байгаа нь онцлог юм. .

БОРООГИЙН СУУРИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Бор нуур сумын төвөөс хойд зүгт 40 км зайд 3-р багийн нутаг, Борнуурын сангийн аж ахуйгаас хойш 30 км зайтай Цагаан чулуут хэмээх Бороо гол руу харсан амны адагт Бороогийн алтны уурхайн хуучин төв байдаг бөгөөд тэнд дэрс, халгай ургасан дов, хонхор ихтэй хэсэг газраас янз бүрийн хээтэй шавар ваар савны хагархай, малын яс зэрэг зүйл ихээр олдож байсныг археологич Ц.Доржсүрэн 1966 онд үзэж он цагийн хувьд Хүннү улсын үед холбогдох хот суурин газар болохыг тогтоосон байна. Уг дурсгал нь төвийн бүсийн нутагт орших Хүннүгийн үеийн томоохон хот суурины нэг юм.

ДУУТЫН ХАР ЧУЛУУНЫ БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл

хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутагт, Халхын Баарай хошуучын хүү Цогт 1621 оны намар Хангай ханы Цэцэрлэгийн ууланд авлаж яваад, өндөр уулан дээр гарч нэгэн шүлэг цээжээр зохиосныг хамт явсан эрх хиа гэгч бичиж авч дараа нь 1624 оны хаврын тэргүүн сарын арван найманд Дайчин хиа, Гүенбаатар хоёр тэр шүлгийг одоогийн Дуутын хар чулуу хэмээх хаднаа сийлэн бичиж үлдээсэн нь өдгөө тэнд бий. Монгол бичгийн долоон бадаг, 28 мөр шүлэгтэй уг бичээс нь Монгол бичгийн томоохон дурсгалын нэг юм.

ИХ ХӨШӨӨТИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Их хөшөөт хэмээх газарт энэхүү дурсгал нь Түрэг улсын үед холбогдоно. Энэхүү гэрэлт хөшөөг Кул-чур хэмээх ноёнд зориулан зориулан босгосон гэж үздэг. Гэрэлт хөшөөн дэх бичээс нь Кул чурын аян дайн, хувцас хэрэглэл, хурдан морь хийгээд аян дайн хийсэн газар орны тухай өгүүлдэг тул түүхийн асар их үн цэнтэй бичгийн дурсгал юм.

МАНЗУШИРЫН ХИЙДИЙН ТУУРЬ, БУРХАДЫН ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Манжийн хаадын шүтээн Манзуширын хувилгаан нь анх Энэтхэг оронд гарсан бөгөөд түүнээс хойш Төвдөд хэдэн удаа, Монголд таван удаа тодорч байжээ. Анхны Манзушир хувилгаан Навааанжамбалцанг залан ирж 1733 онд Богд хан уулын өвөрт Төвд хэлбэртэй анхны сүмийг барьж эхлэн 1747 онд дуусгажээ. Өдгөө Манзуширын хийдийн Хангал, Өрөнхан, Цогчин, Богдын Шар хүрээ, Өвгөн Лаврин, Эргэдэг Майдар, Сувраган сүм, Сэрүүн Лаврин, Мамба, Цанид, Бадам ёго, Жүд, Мангал зэрэг сум дуганы буйр, туурь л үлджээ. Хийдийг орчин тойрны байгальтай нь хослуулан уран сайхнаар зохицуулж байгуулсан байжээ. Сэрүүн лавринг сэргээн засварлан Төв аймгийн музейн салбар шашны музей болгожээ.

БҮРХИЙН ДӨРВӨЛЖИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Хэрлэн голын цутгал зүүн Бүрх голын баруун хөвөөнд оршдог эртний дөрвөлжин хэрмийн орыг нутгийнхан нь бөө, удган хоёрын суусан газар “Хараалчийн хэрэм” хэмээн домоглож нэрлэдэг. Бүрхийн дөрвөлжин бол дөрвөн тал шороон хэрмийн ор юм. Таван удаагийн малтлага судагаагаар барилгын дээврийн ваарны хагархай, хээтэй дөрвөлжин тоосго олдсон бөгөөд үүгээр нь Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин зэрэг Хүннүгийн үеийн хэрэмтэй нэг цаг үеийнх гэж эрдэмтэд үздэг.

САРЬДАГИЙН ХИЙДИЙН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Мөнгөнморьт сумын төвөөс зүүн хойд зүгт Сарьдаг ууланд оршино. Түүхийн сурвалжид тэмдэглэснээр, Халхын Өндөр Гэгээн Занабазар өргөөгөө улам өргөтгөж шарын шашны төв болгох зорилгоор 1654 онд

Хэнтий уулын өвөрт Рибогэжайганданшадублин гэдэг хийд байгуулж эхэлсэн бөгөөд 1680 оны зун үндсэнд нь барьж дуусгасан байна. 1687 оноос Халх, Ойрадын дайн болж, Галдан бошигт Халхын нутгийн гүнд цөмрөн Хэрлэн гол, Хэнтий уул хүртэл давшихдаа Өндөр гэгээний байгуулсан уг хийдийг эвдлэн сүйтгэсэн байна. Улаанбаатар хот анх 1639 онд Хутагтын өргөө нэртэйгээр эх суурь нь тавигдаж 150 шахам нүүдэллэн 1778 онд одоогийн байгаа газраа суурьшсан түүхтэй. Тийнхүү нүүж суурьшиж байсан дурсгалт газруудын нэг нь Сарьдгийн хийд юм.

ТЭРЭЛЖИЙН ДӨРВӨЛЖИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Мөнгөнморьт сумын төвөөс зүүн хойш 25 км зайд, Мөнхжаргалан уулын дэвсэгт, Тэрэлж голын зүүн эрэгт эртний хотын туурь бий. Барилгын тосгуур ваар, нөмрөг ваар, хээтэй тоосго зэрэг олдвор хэрэглэгдэхүүн нь Гуа довоос олдсон олдворуудтай адил байсан байна. Малтлагын үр дүнд үндэслэж Х.Пэрлээ энд хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ.

УЯНГЫН ҮЗҮҮРИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Өндөр ширээт сумын төвөөс баруун хойш 21 км орчим зайд баруун урдаас зүүн хойшоо их, бага хоёр хэсэг үелж дэллэсэн их хадыг Уянгын үзүүр гэх бөгөөд энэ дэллэсэн хадны бараг чулуу бүхэн дээр хадны зураг сийлсэн байна. Уянгын үзүүрийн хадны зурагт амьтдыг дүрсэлсэн байдлыг ажиглахад энгийн хялбарчлан тоймлох арга зонхилох хандлагатай боловч ерөнхийдөө бодит байдлаар дүрслэхдээ бүх талбайгаар нь цохиж хонхойлгох аргаар урлажээ. Уянгын үзүүрийн хадны зургийг судлаачид дүрслэл, урласан арга зэрэгт нь тулгуурлан он цагийн хувьд хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе (МЭӨ Ш-МЭӨ I мянган жилийн тэргүүн хагас)-д холбогдоно хэмээн үзсэн байдаг.

ГҮНЖИЙН СҮМИЙН ҮЛДЭГДЭЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Хэнтийн нурууны салбар уул Баян уулын өвөр хормой Хөх чулууны голын эхэнд Гүнжийн сүм хэмээх дурсгал ошин байна. 1697 онд Түшээт хан Чахундоржийн ач хүү Дондовдорж Манжийн хааны гүнжийг хатнаа богон авч олон жил ханилан суужээ. Хожим хатныг нас барахад Манжийн хааны зарлигаар сүм барьж, сүмийн хөлөмжид шарилыг нь оршуулж, Гүнжийн сүм хэмээн нэрлэх болжээ. Гүнжийн сүм нь 18 дугаар зууны үеийн Монголын уран барилгын хийгээд эд, оюуны соёлын чухад дурсгалд тооцогдоно.

ТОНЬЮКУКЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/-, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Эртний Түрэгийн хаант улсын гурван хааны зөвлөх байсан мэргэн

сайд Тоньюкукт зориулан босгосон нэгэн дурсгал Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Баян цогт уулын баруун хойно оршино. Гэрэлт хөшөө нь 62 мөр бичээстэй бөгөөд тухайн үеийн Түрэгийн нийгмийн байдлыг Тоньюкукийн намтартай холбогдуулан бичсэн агуулгатай юм. Энэхүү цогцолборт хүн чулуу, гэрэлт хөшөө, тахилын чулуун байгууламж, амьтны дүрст хөшөө чулуу зэрэг олон дурсгалууд багтана.

Увс аймаг
1. Бор нурганы хүн чулуун хөшөөд
2. Зураагийн улаан хадны зураг
3. Дунд Турагийн хад үзүүрийн хадны зураг
4. Можоогийн хадны зураг
5. Халхайтын дэнжийн цогцолбор дурсгал
6. Да лам Цэрэнчимэдийн гэрэлт хөшөө

БОР НУРГАНЫ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Увс аймгийн Давст сумын нутаг Бор нурганы (Хүүхдийн овооны) орой дээр хоёр хүн чулуу бий. Үүний нэг нь газарт босоо зоолттой, зогсож буй хүний дүрстэй. Гонзгой чулууны зөвхөн нэг талыг засаж янзлан хүний дүрс оруулан хийжээ. Дээд тал нь шовх үзүүртэй тул гозгор малгайтай мэт харагдана. Эвдэрч хэмхрээгүй бүтнээрээ бөгөөд хийц төдий л нарийн бус, гэвч нүүр, нүд ам, хамрын дүрс маш тодорхой. Хоёр гараа хэвлийн өмнө нийлүүлэн сав барьсан, түүнээс доош хоёр хөлийн дүрс гаргажээ. Цээжинд хоёр хөх дүрсэлснээс үзэхэд эмэгтэй хүний ажээ. Хоёр дахь хөшөө нь яг дээрхтэй зэрэгцэн босоо зоолттой байсан нь хугаран унажээ. Энэ хөшөөний толигор хавтгай өргөн талд хүний нүүр, толгой болон гэдсээ тэвэрсэн хоёр гар, хүйс, хөл зэргийг сараачин зурж дүрсэлжээ. Эдгээр дурсгалын холбогдох он цаг болон түүх, соёлын хамаарлыг тодорхойлох шинж тэмдэггүй ч хийц дүрслэлийн зарим онцлогийг харахад түрэгийн дурсгал бололтой гэж судлаачид үздэг.

ЗУРААГИЙН УЛААН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Увс аймгийн Зүүнхангай сумын нутагт сумын төвөөс хойш 14 км зайд, Зураагийн хошууны өвөрт, Зураагийн Улаан орших хэмээх том улаан хаданд байдаг. Энд нийт таван хэсэг газарт эртний хүмүүс улаан зосоор зураг зурж үлдээжээ. Хадны зургийн дүрслэлд төрөл бүрийн тамга тэмдгийн дүрс хийгээд бүжиг мэт үйл хөдлөл, хөдөлгөөн хийж хүмүүсийг дүрслэн үзүүлсэн нь сонирхолтой.

ДУНД ТУРАГИЙН ХАД ҮЗҮҮРИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Увс аймгийн Сагил сумын нутагт Монгол, Оросын хилийн заагаас 5 км орчим зайд оршино. Хад үзүүрийн өмнөд ба баруун урд талын хаданд янгир, буга, үхэр, адуу, чоно, хүн зэргийн зуу гаруй дүрсийг хонхойлон цохиж сийлсэн бөгөөд дүрслэлийн арга барил төдийгүй он цагийн хувьд өөр өөр үед холбогдох ажээ. Эдгээр олон зургаас харьцангуй эрт чулуун зэвсгийн үед хамаарах цөөн зураг тод ялгардаг. Тэдгээр зураг нь биеийн ерөнхий тэгийг хонхойлон цохиж бодит байдлаар дүрсэлсэн босоо эвэр, хоёр салаа омруу (хөөлүүр), эр хүйсийг цохон үзүүлсэн том үхэр, том бугын дүрс юм.

МОЖООГИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол

Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Увс аймгийн Сагил сумын нутагт энэхүү дурсгалт газар оршино. Эндэхийн хаданд аргаль, янгир, тэмээ, нохой, үхэр хүн зэргийг ганц нэг ба хэсэг бүлгээр сийлсэн олон зуун зургийн дүрслэл бий. Эндэх хадны зургуудын дотор хамгийн томд орох баруун тийш харсан тэгш талбай бүхий хэвтээ хаданд арав гаруй үхрийг голдуу данхар том эвэртэй, эр хүйстэй байдлаар дүрслэхдээ бас зарим үхрийн хэвлий цээжний доогуур “үржлийг бэлгэдсэн” дугуй хонхор цохиж гаргасан нь палеолитын үеийн дүрслэлийн арга барилыг санагдуулна. Уг дүрслэлээс үзэхэд эл зураг зурагдах үед үхрийг гэршүүлсэн үе болохыг үзүүлэхийн сацуу нум сумыг хүн мезолитын үеэс эхлэн хийж хэрэглэж ирсэн цаг үеийг давхар нотолж байна. “Үржлийг” билэгдсэн тэмдэг бүхий палеолитын үеийн уламжлалт дүрслэлийн арга барил, нум сумаар зэрлэг үхэр агнаж байгаа мезолитын үеийн ан агнуур, үхрийг гэршүүлсэн неолитын аж ахуйн сэдвүүд дээрх зурагт хамт нэг дор тусгагдсан нь уг хадны зургийг мезолитын сүүлч, неолитын эхэн үед холбогдуулан авч үзэх боломжийг судлаачдад олгожээ.

ХАЛХАЙТЫН ДЭНЖИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Увс аймгийн Тариалан сумын төвөөс баруун урд зүгт 16 км орчим зайд Хархираа голын хойд биед Халхайтын дэнж хэмээх газар олон тооны булш, хиргисүүр, хөшөө чулуу зэрэг олон үеийн дурсгал бүхий цогцолбор дурсгал бий. Энд түрэгийн үеийн хоёр хүн чулууд байх бөгөөд хийц дүрслэл уран нарийн дүрслэлтэй байна.

ДА ЛАМ ЦЭРЭНЧИМЭДИЙН ГЭРЭЛТ ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Монгол Улсын Дотоод явдлын яамны Тэргүүн сайд, Чин сүжигт Да лам Цэрэнчимэдийн дурсгалд зориулж босгосон хөшөө Увс аймгийн Хяргас сумын нутагт бий. Монголчууд Манжийн олон жилийн дарлалаас гарч, тусгаар тогтнолоо эргүүлэн олох их тэмцлийг манлайлагчдын нэг нь Дал лам Цэрэнчимэд юм.

Ховд аймаг
1. Гурван цэнхэрийн агуйн хадны зураг
2. Ишгэн толгойн хадны зураг
3. Тахилтын хотгорын Хүннүгийн язгуурtны булш
4. Улаан толгойн бичээс
5. Баянзүрхийн цогцолбор дурсгал
6. Ямаан усны хадны зураг
7. Сөртийн хөшөө чулуу
8. Халиуны хөтлийн хүн чулуун хөшөө
9. Цамбагаравын хадны зураг

ГУРВАН ЦЭНХЭРИЙН АГУЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Манхан сумын төвөөс зүүн урагш 25 км зайд Хойд Цэнхэрийн агуйн хөмөг доторх мөргөцгийн тааз хананд олон янзын тэмдэг дүрс, ан амьтдыг бие биен дээр нь давхардуулан зурсан зосон болон сийлмэл зургууд бий. Тэмээн хяруул, бух, янгир, арслан заан зэрэг олон амьтдын дүрсийг агуйн

мухрын зэрэгцээ нэг том буланд шаваралдуулан зуржээ. Энэ хэсэгт тэмээн хяруулын дээгүүр нэг эгнээ олон толбо гаргаж зурсан байдаг. Агуйн 8 м өргөн 10 м урт хонгилын хананд хоёр бөхтэй тэмээг нэгэн товгор дээр зогсож хоншоороо цааш харуулан их биеэрээ хажуу тийш харж байгаагаар дүрсэлжээ. Хойд Цэнхэрийн агуйн зургийн үндсэн хэсэг нь дээд палеолитийн үед холбогдох боловч хожуу үеийн цөөн зураг бас бий. Хадны зургийг судлаачид дээд палеолитын үед (20.000-15.000 жилийн өмнө) холбогдоно гэж тогтоожээ.

ИШГЭН ТОЛГОЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгой хэмээх газарт Дээд палеолитын үед холбогдох хадны бүлэг дурсгал оршин байна. Ишгэн толгойн хаднаа үхэр, адуу, буга, янгир, тэмээ зэрэг амьтдын дүрсийг хадны толион дээр гол төлөв ганц нэгээр урласан байх бөгөөд зургийн сийлсэн өнгө хадны байгалийн өнгөнөөс бараг ялгарахгүй болж зөвхөн гараар тэмтрэхэд сийлмэл зурагтай болох нь мэдэгддэг. Ишгэн толгойн хадны ихэнх зураг түүний хойт талд өөрөөр хэлбэл салхин талд нь зонхилон зурагдсан онцлогтой. Монгол орон түүний хөрш зэргэлдээ нутгаас урьд өмнө чулуун зэвсгийн үед холбогдох барын зураг олдож мэдэгдээгүй бөгөөд харин Ишгэн толгойн хаднаа дурдсан зэрлэг амьтдын хамт цөөн тоогоор барыг дүрсэлсэн нь сонирхолтой юм. Манай оронд палеолитын үед бар нутаглаж байснаас түүнийг үзсэн, мэддэг төдийгүй хад цохионоо дүрслэн үлдээжээ.

ТАХИЛТЫН ХОТГОРЫН ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ БУЛШ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун өмнө зүгт 20 км орчим зайд, Цэнхэрийн голын хөндийд Хүннүгийн оршуулгын дурсгалт газар оршино. Булшнууд нь үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай том, цагариг хэлбэрийн дунд болон жижиг булшнууд юм. Нийт 130 орчим булш бүртгэжээ. Тахилтын хотгорын булшнууд нь бүтэц зохион байгуулалтын хувьд Монголын төв болон зүүн бүс нутагт малтлага хийсэн Ноён уул, Гол мод, Дуурлиг нарс зэрэг Хүннүгийн язгууртны булшнуудтай төстэй боловч хэмжээний хувьд харьцангуй жижиг юм.

УЛААН ТОЛГОЙН БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Мөнххайрхан сумын төвөөс баруун тийш 20 гаруй км зайд Долоон нуурын Улаан толгойн зүүн урд боржин чулуун хаданд гурван хэсэг бичээс буй. Уг гурван бичээсний хоёр нь уйгуржин монгол хэлбэртэй боловч эдүгээгийн монголоор уншиж үл болох ба нэгнийх нь дээд талд христос шашны загалмай тэмдгийн хэлбэртэй дүрс буй нь сонирхолтой бөгөөд дундад эртний монголын хэрэйд, найман зэрэг аймгуудын дунд христийн шашны урсгал нэвтэрч байсан мэдээ баримттай ч холбон үзэж болох талтай. Эл дурсгал нь XIII зууны үеийн зам харилцаа хийгээд Юань улсын түүхийг судлахад чухал мэдээ баримт болдог байна.

БАЯНЗҮРХИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Мөст сумын нутаг, Бодончийн голын дээд бие,

Мухар Давын амнаас дээш холгүй орших зүрх хэлбэрийн хар хүрэн уулыг Баянзүрх гэж нэрлэх бөгөөд тус газарт 4 буган хөшөө оршино. Онцлог дүрслэл гэвэл нэг хөшөөний бүх талыг тойруулан сийлсэн буганууды эвэргүйгээр буюу “согоо” дүрсэлсэн байгаа нь нэн сонирхолтой. Учир нь буган хөшөөнд угалзарсан эвэртэй бугыг хөшөөг тойруулан сийлдэг ба эвэргүй согоо дүрслэх тохиолдол нэлээд ховор байдаг. Мөн тэгш өнцөгт хэлбэрийн бамбай дүрсэлсэн байх ба үүнээс гадна бас нэгэн онцлог дүрслэл бол гэзэг үс дүрсэлсэн хөшөө ихээхэн өвөрмөц юм. Энд Евразийн хэлбэрийн нэгэн хөшөөний ар тал руу багцалж боосон бололтой гэзэг унжуулж дүрсэлсэн нь сонирхолтой төдийгүй маш ховор тохиолдол болно.

ЯМААН УСНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Үенч сумын нутагт орших Ямаан усны хавцал нь жижиг горхи урсдаг хадтай нарийн хавцал юм. Уг хавцлын дунд хэсэгт орших Ханан хаднаа олон тооны хадны зурагтай. Эндэхийн хаданд гол төлөв янгир, буга, зээр, бөхөн, адуу, тэмээ, чоно зэрэг амьтдыг янз бүрийн байдлаар дүрсэлжээ. Мөн ханан хадны баруун дээд буланд дөрвөн моринд хөллөсөн хоёр дугуйтай сүйх тэргийг хажуугаас нь харсан байдлаар дүрсэлсэн ба сүйх тэргэнд нэгэн хүн сууж яваагийн зөвхөн цээжин хэсгийг, тэрэгний өмнө хойно тус бүр морь унасан хоёр хүн байна. Сүйх тэрэгнүүдийн дугуйг найман хигээстэйгээр зурсан нь тодорхой харагдана. Энэ сүйх тэрэгний зургийг Хангийн үеийн булшны ханын зурагтай ижил төстэй байдлаар нь судлаачид Хүннүгийн үед холбогдуулан үздэг. Мөн хүннү булшнаас гарсан үйсэн савны тагна дээрх мухлагт тэрэгний зургууд нь Ямаан ус, Дэл уулын тэрэгний зургуудыг Хүннүгийн үед холбогдохыг баталсан олдвор хэрэглэгдэхүүн болсон юм.

СӨРТИЙН ХӨШӨӨ ЧУЛУУ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Сөртийн хөшөө чулууд нь Ховд аймгийн Ховд сумын төвөөс баруун урагш 6 км зайд байрладаг. Энд нийт 8 хөшөө чулуу бий. Сөртийн хөшөө чулууд нь МЭӨ IY-YIII зууны үед холбогдоно. Хөшөө чулуунуудыг саарал болон хар саарал өнгө бүхий боржин чулуугаар үйлдэж, баруун зүгээс зүүн тийш чиглэлтэйгээр нэг шугамд зэрэгцүүлэн босгосон байна. Энэхүү дурсгалт газар нь нутгийн өвөрмөц соёлыг агуулсан түүх, соёлын чухал дурсгалт газарт юм.

ХАЛИУНЫ ХӨТЛИЙН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Цэцэг сумын нутаг Халиуны хөтөл хэмээх газарт Түрэгийн үеийн тахилын онгон, хүн чулуу оршин байна. Тахилын онгон нь хашлага чулуу болон хүн чулуу, 17 ш зэл чулуудаас бүрдэнэ. Хүн чулуу нь баруун гараа цээжин хэсэгт байрлуулж, зүүн гарыг гэдэс хэсэгт байрлуулан хутга атгуулсан байна.

ЦАМБАГАРАВЫН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Цамбагарав уулын Хар дэлийн бууц хэмээх газар түүхийн олон үед холбогдох зураг дүрслэл нэлээд буйн дотор хурц үзүүртэй багажаар зурж сийлсэн

цэрэг эрсийн зураг онц сонирхолтой. Хадны дээд хэсэгт дорно зүг хойно хойноосоо цуварч яваа хоёр хуягт морин цэрэг, тэдгээрийн доохно талд өөдөөс нь сөрж яваа нэгэн хуягт морин цэрэг, түүний ард нумаар зэвсэглэсэн дуулгатай явган цэргийг дүрсэлжээ. Цэрэг эрсийн заримыг өвч хуягтай , заримыг хуяггүй, өргөн мөртэй, нарийхан бэлхүүстэй, морьдыг өвч хуягтай дүрсэлсэн байна. Эдгээр зургийг судлаачид Жужаны үе буюу IV-VI зуунд холбогдуулдаг.

Хөвсгөл аймаг
1. Эрхэлийн Улаантолгойн цогцолбор дурсгал
2. Эрчүү хотын туурь
3. Монгорцог, Хөнгөрцөгийн хадны зураг
4. Уушигийн өврийн цогцолбор дурсгал
5. Бартад бригадын цогцолбор дурсгал
6. Зуны голын цогцолбор дурсгал
7. Бор хужирын буган чулуун хөшөөд
8. Хөшөөтийн цогцолбор дурсгал

ЭРХЭЛИЙН УЛААНТОЛГОЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн төвөөс 35 км зайд орших Эрхэл нуурын баруун талд Улаан толгой уулын бэлд таван ширхэг буган хөшөө, тахилгын байгууламжийн хамт оршино. Эдгээр хөшөөд бүгд бугын хийсвэр дүрслэлтэй бөгөөд нэгдүгээр буган хөшөөнд бугаас гадна адуу, бар зэрэг амьтдыг дүрсэлжээ. Ойр орчим нь дөрвөлжин болон дугуй хүрээтэй нэлээд хэдэн хиргисүүр бий. Эдгээр буган хөшөөний урдаасаа хоёр дахь нь 3.84 см өндөр бөгөөд монголын хамгийн өндөр буган хөшөө гэдгээрээ алдартай.

ЭРЧҮҮ ХОТЫН ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэр мөрний хойд хөвөө Алтан гадас уулын арханд Мөнх хааны хөшөө, орд харшийн үлдэгдэл эвдэрхий балгас бий. Хааш хаашаа 100 гаруй метр урт шороон далан түүний гол дунд 30 метр орчим хэмжээний дөрвөлжин хэлбэртэй томоохон орон барилгын суурь, дэрсэн дунд баганын суурь зургаан том засмал дөрвөлжин боржин болон углуургатай хүрэн боржин чулуу хэд хэд цухуйж ажиглагддаг. Балгаснаас урагш 40 м орчим зайтай овгор дэрсэн дотроос цухуйж байсан хавтгай хөх чулууг түшлэг гэдэг байсан нь Мөнх хааны Монгол, Хятад бичигтэй хөшөө байжээ. Тус туурийг 1953 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс томилон илгээсэн О.Намнандорж ахлагчтай орон нутаг судлах аяллынхан анх илрүүлэн олж судлан XIII зууны үед холбогдохыг түүхэн эш баримтад тулгуурлан тодорхойлсон байна.

МОНГОРЦОГ, ХӨНГӨРЦӨГИЙН ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын төвөөс 45 км зайд гурван талаараа уулс, голоор хүрээлэгдсэн Бичигт булан хэмээх газар бий. Голын доод дэнжид эрэг рүү түрж орсон хаднаа улаан зосоор зурсан зосон зургийн дурсгалтай. Уг хаднаа хүн, янгир, шувуу, нохой зэргийг тоймлон зурснаас гадна дөрвөлжин хүрээн дотор арваад цэг зурсан нь судлаачдын анхаарлыг татсаар иржээ. Мөн хадны доод талаар нэг гартаа саваа мод барьж нөгөө гараа хажууд байгаа морь руу сунгасан байдалтай хүн, хоёр талаас нь нум сумаар зэвсэглэсэн дайчин, ямар нэгэн овгийн тамга, хэрээс тэмдэг, цуварч зогссон дөрвөн амьтан, тэгш өнцөгт хүрээн доторх цэгүүдийг тус бүр тоймлон зуржээ. Монгол

орны зарим аймгийн нутгаас олддог зосон зурагтай сэдэв, зохиомж, агуулга, зурсан хэв шинж нь адил байгаа нь эртний зосон зургийн томоохон төлөөллийн нэг болохыг батлан харуулж байна.

УУШИГИЙН ӨВРИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт Дэлгэр мөрний хойд бие, уужим хөндийд орших хиргисүүр, буган хөшөө бүхий дурсгал нь Монгол нутаг дахь томоохон цогцолбор дурсгалуудын нэгд зүй ёсоор тооцогдоно. Хамгийн сүүлийн үийн мэдээллээр нийт 23 хөшөөний бүтэн болон хугархай хэсгүүд бүртгэгджээ. Уушигийн өвөрийн буган хөшөөдийн олонх нь бугын хийсвэр дүрслэлтэй бөгөөд зарим хөшөөнд бугаас гадна янгир, бар ирвэс мэт амьтдыг дүрсэлсэн байна. Эндэхийн 14 дүгээр буган хөшөөнд хүний толгой, нүүрний хэсгийг уран тод дүрслэн үлдээсэн нь буган хөшөөний соёлд хамгийн онцлог сийлбэртэй хөшөөнд тооцогдоно. Мөн 8 дугаар буган хөшөөнд гүйвэр хэмээх эртний зэр зэвсгийн нэгэн төрлийг сийлснээрээ онцлог юм.

БАРТАД БРИГАДЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг 3 дугаар багийн төвийн ойролцоох Хөшөөтийн ам хэмээх газарт зургаан буган хөшөө, тахилгын байгууламжуудын дунд оршин байна. Эдгээр хөшөөд нь бүгд бугын хийсвэр дүрслэлтэй бөгөөд нэгэн хөшөөнд аргалын толгой бүхий тольттой чинжаал дүрсэлсэн нь нэн ховор дүрслэл болно. Анхны хэв шинжээ харьцангуй бүрэн бүтэн хадгалж, цогцолбор байдлаараа буй цөөн тооны дурсгалт газрын нэг юм. Мөн тухайн газарт булш хиргисүүрүүд олон байна.

ЗУНЫ ГОЛЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Зуны голын хөндийд хоёр хэсэг газарт олон хиргисүүр, буган хөшөө бүхий цогцолбор дурсгал бий. Энэ дурсгалт газар 10 буган хөшөө байх бөгөөд ихэнх нь бугын хийсвэр дүрслэлтэй боловч 2009 онд археологич Ж.Баярсайханы илрүүлэн олсон 10 дугаар буган хөшөөнд бугаас гадна шувуу, мэлхий, гахай, согооноос гадна адуу мэт сүүлтэй, үхэр мэт биетэй хоёр амьтан, соотон чихтэй, хурц шүд, хумстай, цоохор биетэй хоёр араатан зэрэг олон төрлийн домгийн амьтад сийлсэн байсан нь одоогоор олдоод буй цорын ганц буган хөшөө юм.

БОР ХУЖИРЫН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын нутаг Бор хужирын голын зүүн талын өндөр эрэг дээр хоёр эгнээгээр хойноос урагш цуварсан 9 буган хөшөөг В.В.Волков анх бүртгэн тодорхойлж, Агарын суурин хэмээх нэрээр хэвлүүлжээ. 2008 онд “Буган хөшөө” төслийн хүрээнд дахин бүртгэн ойролцоох 3 газарт орших 15 хөшөөг дахин баримтжуулж, 4 тахилгын байгууламжийг малтан судалжээ. Эндэхийн 3 дугаар буган хөшөөний оройг өвөрмөц хэлбэрээр засч, дээд хэсэгт нь хүний нүүр дүрсэлснээрээ онцлог юм.

ХӨШӨӨТИЙН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутаг Хөшөөт хэмээх газарт буган хөшөөний цогцолбор дурсгал оршин байна. Энд нийт 11 ш буган хөшөө тахилын байгууламжийн хамт оршин байна. Мөн тухайн газарт булш хиргисүүрүүд олон тоотой тархсан байна.

Хэнтий аймаг
1. Өглөгчийн хэрэм
2. Рашаан хадны цогцолбор дурсгал
3. Дуурлиг нарсны Хүннүгийн язгууртны оршуулгын газар
4. Сэрвэн хаалганы бичээс
5. Борбулагийн булш
6. Аваргын балгас
7. Дуулга уулын Хүннүгийн оршуулгын газар
8. Салбар уулын бичээс
9. Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхадын зураг, бичээс
10. Дунд Жаргалантын цогцолбор дурсгал
11. Гэлэн гэх хүн чулуун хөшөө
12. Цэцэн ханы ордны цогцолбор

ӨГЛӨГЧИЙН ХЭРЭМ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Батширээт сумын төвөөс баруун урагш 40 орчим км зайд энэхүү дурсгалт газар байрлана. Хэрмийн урд хэсэг шороонд дарагдсан байдалтай зарим хэсгээрээ нурсан боловч ихэнх чулуун өрлөг хэвээрээ байна. Хэрмийн дотор ямар нэг барилгын ор мөр, туурь байхгүй боловч Киданы үеийн ваарын хагархай, сумны төмөр зэв зэрэг зүйлс түүвэр байдлаар олддог байна. Судлаачид дурсгалт газрыг Киданы үед холбогдох бэхлэлтийн хэрэм хэмээн тодорхойлжээ.

РАШААН ХАДНЫ ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр уулын зүүн урд хормойд палеолитын үеэс дундад зууныг хүртэлх түүхийн олон үеийг хамарсан Рашаан хадны цогцолбор дурсгалт газар оршино. Рашаан хадны палеолитын үеийн зураг түүхийн хожуу үед холбогдох бусад зургаас дүрсэлсэн амьтан, дүрслэлийн арга барилаараа өвөрмөц юм. Үүнд, арслан заан, савгат хирс хожуу үеийн зургуудаас хэмжээгээрээ том төдийгүй, амьтдын дүрсний гадаад хүрээг харьцангуй өргөн гарган дүрсэлж, түүний ерөнхий төрхийг гаргахыг хичээсэн байдал ажиглагддаг. Рашаан хаднаа эртний 7 төрлийн нийт 61 бичээсийг бичээсийг сийлэн үлдээжээ.

ДУУРЛИГ НАРСНЫ ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Баян-Адрага сумын нутаг Дуурлиг нарс хэмээх газарт Хүннүгийн язгууртны булшнууд байна. Энд нийт 299

булш тоолж бүртгэснээс дийлэнх нь үүдэвч бүхий язгуартны булшнууд ажээ. Дуурлиг нарсны булшнууд нь Хүннү гүрний зүүн жигүүрийн ихэс язгуартны оршуулга болох нь судалгаагаар батлагдаж байна.

СЭРВЭН ХААЛГАНЫ БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг Хэрлэн голын урд хөндийд орших зэрэгцсэн хадтай гурван шовх уулыг Сэрвэн хаалга хэмээн нэрийднэ. Энэ уулын баруун талын шовх өндрийн энгэрт хоорондоо 10-аад м-ийн зайтай орших 2 том боржин хадны наран зүгт харсан тэгш гадаргуу дээр эртний нанхиад, зөрчид хоёр бичээс бий. Дээрх бичээс нь 1196 онд Алтан улсын цэргийн жанжин Вангин Чинсан, Татарын Мэгүжин сүүлттэй байлдахад Тэмүүжин эртний өсөөт татаруудыг даралцахад хүч хавсарсан Улз голын байлдааны талаар өгүүлсэн Их Монгол улс байгуулах үеийн түүхийн чухал сурвалж юм.

БОРБУЛАГИЙН БУЛШ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23 №235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Биндэр сумын төвөөс зүүн урагш 20 гаруй км зайд Онон голын урд бие, Цармын талбай хэмээх уужим хөндийд, Борбулагийн амны адгаар олон үед холбогдох 120 гаруй булш байна.

АВАРГЫН БАЛГАС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт, Аваргын голын хойд хөвөөнд, Рашаан дэрсний ухаа хэмээх толгодын дээр эртний нэгэн хотын үлдэгдэл бий. Судлан үзэхэд хотын барилгуудын гадуур нь хүрээлсэн ерөнхий хэрэм байхгүй, нийтдээ 4,5 км талбай эзэлнэ. Хотын үлдэгдэл нь нийтдээ дөрвөн хэсгээс бүрэлдэх бөгөөд эдгээр нь гар урлал, тариалангийн хороолол, шүтээний сүм, тусгай хана хэрмүүд болон орд харшийн барилга юм. Гар урлал тариалангийн хороолол нь сууринги йн зүүн хэсэгт, барилга бүхий гурван гудамж, бусад эмх замбараагүй барилгын үлдэгдлүүдээс бүрдэнэ. Энд 13 хэрэмт барилгын үлдэгдэл мэдэгдэнэ. Энэхүү дурсгат газар нь Монголын их хааны хаан сууринд суух төв болж байсан домогт Хэрлэнгийн Хөдөө арлын төв юм.

ДУУЛГА УУЛЫН ХҮННҮГИЙН ОРШУУЛГЫН ГАЗАР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын төвөөс зүүн урагш 27 км зайд орших бөмбөгөр оройтой уулыг Дуулга гэнэ. Энэ уулын өврөөс баруун урагш хандсан жижгэвтэр ам, түүний хойд налууг дагаад хүннүгийн 142 булш бий Дуулга уулын булшийг анх 1969 онд Гурван голын шинжилгээний анги илрүүлж таван булш малтан судлажээ. Дуулга уулын 2 дугаар булшнаас гарсан ваарand хурдан эргэх оньсон хүрд дээр хийхэд үлддэг олон хөндлөн зураас байгаа нь тухайн үед ваар үйлдвэрлэлд гарсан техникийн хөгжлийг харуулсан тодорхой дэвшил хэмээн судлаачид үздэг.

САЛБАР УУЛЫН БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт Салбар

хэмээх уул оршдог. Салбарын Бичигт ханангийн бичээс их бага хоёр хэсгээс бүрддэг. Их бичээс нь уншигч хүний баруун гар талд, бага бичээс нь солгой гар талд тус тусдаа сийлэгджээ. Ажиглан үзвэл, бага бичээс нь их бичээсний тэтгэсэн он сар нь шиг сэтгэгдэл төрүүлдэг. Эрдэмтэн Х.Пэрлээ Салбарын Бичигт Ханангийн бичээс, болон тамган дүрс зэргийг судлаад Х.Т-ын Х-ХІ зууны Кидан улсын их бичигтэй холбон үзжээ.

БАЛДАН БЭРЭЭВЭН ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, БУРХАДЫН ЗУРАГ, БИЧЭЭС, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт энэхүү дурсгалт газар оршино. 1784 онд Дайчин жонон ван Гомбожавын үед үндэс шав нь тавигдсан гэж үздэг ба 8000 ламын данстай халх монголын зүүн талын жигүүрийн шашин номын зонхилох төв байжээ. Бэрээвэн хийд их хөвч тайга бүхий уулын энгэрт байрласан учир барилгууд нь чулуу мод голчилсон хийцтэй, хад чулуунд эдлгэн хаданд бурхадын дүрс болон соёмбо сийлсэн нь одоог хүртэл хадгалагдан үлджээ.

ДУНД ЖАРГАЛАНТЫН ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Дунд Жаргалантын голд буган хөшөөд дөрвөлжин булш бүхий цогцолбор дурсгал байна. Дунд Жаргалантын буган хөшөөд нь бүгд бугын хийсвэр дүрслэлтэй хөшөөдийн ангилалд багтана. 1 дүгээр хөшөөнд хүний нүүрний дүрслэлийг товойлгон жижиг нүд, том хамар, амтайгаар сийлж үлдээсэн нь хүний нүүрний дүрслэлтэй цөөн тооны буган хөшөөний нэг юм. Мөн эл дурсгалт газар нь буган хөшөөний соёлын тархалтын хамгийн зүүн захад оршиж буй цорын ганц цогцолбор болно.

ГЭЛЭН ГЭХ ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт Чингис хотын нисэх буудлаас баруун урагш 2-3 км зайтай тэгш талд галт уулын хүрмэн чулуугаар хийсэн нэг хүн чулууг нутгийн иргэд Гэлэн хөшөө хэмээн нэрлэж заншжээ. Энэхүү хөшөө нь Монголын үеийн хүн чулуун дурсгал болох нь болох нь нүүр царай, хувцас хэрэглэл зэрэг хэв шинж, дүрслэлээс нь мэдэгдэнэ.

ЦЭЦЭН ХАНЫ ОРДНЫ ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Хэнтий аймгийн төв Чингис хаан хотод Сэцэн ханы ордон оршино. Эдүгээ тус ордны барилгын бүрэлдэхүүнд хятад загвартай 5 байшин үлдсэн бөгөөд дотор нь аймгийн угсаатны зүйн музей үйл ажиллагаа явуулдаг байна.

Улаанбаатар хот

1. Гандантэгчэнлин хийдийн цогцолбор
2. Ардын намын Төв хороо, Ардын Засгийн газар түр байрлаж байсан байшин
3. Гачууртын амны хадны зураг
4. Дарь-Эхийн сүмийн чулуун багана, гол сүм
5. Дамбадаржаа хийдийн цогцолбор
6. Дашчойлин хийдийн гэр хэлбэрт модон дуганууд

7. Чин ван Ханддоржийн байшин
8. Чойжин ламын сүмийн цогцолбор
9. Туулын Хар түнийн ордны туурь
10. Богд хааны ногоон ордны цогцолбор
11. Их тэнгэрийн амны хадны зураг
12. Анхны “Өндөр хоршоо”-ны 2 давхар байшин
13. Гэсэр сүмийн цогцолбор

ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Их хүрээний зүүн хэсгийг Зүүн хүрээ, баруун хэсгийг Гандан буюу Гандантэгчилэн гэж нэрлэдэг байжээ. Гандантэгчилэн хийд буюу Төгс Баясгалант их хүлгэн хийдийн анхны сүмийг 1809 онд Далхын дэнж дээр Шар сүм нэртэйгээр байгуулагдсан түүхтэй. Гандантэгчинлэн хийдийн уран барилгууд нь монгол, монгол-хятад, хятад-төвд хэлбэр маягтай. Монголын бурхны шашны томоохон төв Гандантэгчинлэн хийд нь Монголын ард түмний шүтлэг бишрэл, оюуны голомт болон хөгжиж байна.

АРДЫН НАМЫН ТӨВ ХОРОО, АРДЫН ЗАСГИЙН ГАЗАР ТҮР БАЙРЛАЖ БАЙСАН БАЙШИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрлах ба өдгөө тус байшинд Улаанбаатар хотын музей үйл ажиллагаа явуулж байна. Музейн байшингийн хойд талын хананд саарал гантиг чулуун дээр “Ардын түр Засгийн газар 1921 оны 7 дугаар сард эхэнд байрлаж байв”, мөн “Их жолоодогч Д.Сүхбаатар 1921 оны 7 дугаар сард энд ажиллаж байв” гэсэн бичигтэй.

ГАЧУУРТЫН АМНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын төвөөс зүүн тийш 25 км орчим зайд Гачууртын ам хэмээх газарт хадны зосон зураг оршино. Хясааны хамгийн баруун захад орших толигор хаданд дотроо хэдэн толботой дугуй хүрээ, дээрээс доош, баруунаас зүүн тийш тоонолжлон хоёр зураасаар дөрөв хуваасан жижиг дугуй хүрээ, дотроо хэдэн толботой дөрвөлжин хашлагыг эгнүүлэн дүрслээд доор нь нохой хөтөлсөн хоёр хүн зуржээ. Түүний зүүн доор нэлээд зайтай гурван хүн, гурван толбо дүрсэлсэн байна. Хамгийн дээд талд зурагтай хадны төв хэсгийн том хавтгай хаднаа зэрэгцээ хоёр замаар нэг нэг адуу хөтөлсөн хоёр хүн, урд талын хүний дэргэд гурван толбо дүрсэлсэн байна. Замын доод талд мөн хоёр адуу гурван хүн, нисэж яваа хоёр бүргэд дүрсэлжээ. Бүхэлд нь ихэд тоймлон дүрсэлсэн эдгээр зургийг он цагийн хувьд хүрлийн үед холбогдоно гэж судлаачид үздэг.

ДАРЬ-ЭХИЙН СҮМИЙН ЧУЛУУН БАГАНА, ГОЛ СҮМ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт Дарь эхийн сүмийн үлдэгдэл бий. Их хүрээний хүн ардын амьдралын хэрэгцээг хангах арилжаа худалдааг өргөжүүлэх зорилгоор хятад худалдаачдын төвлөн суурьших Наймаа хотыг байгуулж Элбэг Амгалант гацаа, Амгаланбаатар хот гэх мэтээр нэрлэж байжээ. Наймаа хотод 7

сүм байсны нэг нь Дарь эхийн сүм юм. Дарь эхийн сүмийн урд боржин чулуугаар хийсэн маш уран сийлбэртэй 11 метр өндөр хоёр чулуун багана бий.

ДАМБАДАРЖАА ХИЙДИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатр хотын хойно, баруун зүүн Сэлбэ голын уулзварт халхын анхны гурван хийдийн нэг Дамбадаржаа хийд оршино. Хоёрдугаар Богд Жавзандамба хутагтын дурсгалд зориулан Манжийн эзэн хааны зарлигаар 1761-1765 онд энэ хийдийг байгуулжээ. Манжийн хааны зарлигийг тэмдэглэж монгол, төвд, манж, хятад дөрвөн хэлээр чулуун дээр сийлбэрлэсэн бмчээс бүхий гэрэлт хөшөөг эндэх Түүхийн сүмд байршуулсан байна.

ДАШЧОЙЛИН ХИЙДИЙН ГЭР ХЭЛБЭРТ МОДОН ДУГАНУУД, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Монголын уламжлалт уран барилгын дурсгалын нэг нь гэр хэлбэрт модон дуган бөгөөд түүний төлөөлөл нь хуучин Их Хүрээний арван дацан 30 аймгийн сүм дуганаас үлдсэн Эрхэм Тойны, Вангаа, Эх дагины аймгийн гэр дуганууд юм.

Улаанбаатар хот дахь гэр хэлбэрт модон дуганаас үлдсэн дуганууудын хамгийн том нь Эх дагины аймгийн дуган бөгөөд өдгөө эдгээр дуганд Дашчлойлон хийд бурханы шашны үйл ажиллагаа явуулж байна. Энэ дуганууудыг барихад монголчуудын хамгийн түгээмэл сууц-гэрийн үндсэн хийц, зохиомжийг үндэслэн түүний орон зай, бүтээцийг өргөжүүлэн бүтээлчээр зохион төлөвлөсөн байдаг.

ЧИН ВАН ХАНДДОРЖИЙН БАЙШИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрлах тус байшин нь Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, Гадаад яамны Тэргүүн сайд чин ван Ханддоржийн амьдрал, үйл ажиллагаатай холбогдоно.

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын төв хэсэгт байрлах энэхүү сүмийг VIII Богд Жавзандамба хутагт өөрийн дүү Чойжин лам Лувсанхайдавт зориулж 1904-1908 онд барьж байгуулжээ. Чойжин ламын сүм нь монголын хүрээ хийдүүдийн дотор уран барилгын үзэсгэлэнт байдлаараа болон уран зураг, уран баримал, өнгө будаг, гадаад дотоод чимэглэлийн хувьд хамгийн гоё сайхан сүмийн нэгд зүй ёсоор орно.

ТУУЛЫН ХАР ТҮНИЙН ОРДНЫ ТУУРЬ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тустус батлагдсан. Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэг Сонгинохайрхан уулын урд өвөрт, Туул гол, Бөхөг Түргэний голын бэлчирт нэгэн хотын туурийг “Туулын Хар Түнийн орд” хэмээдэг бий. Судлаачид

XII зууны эцэс XIII зууны эхэнд Монгол нутагт байсан Хэрэйд аймгийн толгойлогч ван хан Тоорил сууж байсан ордон хэмээн үздэг.

БОГД ХААНЫ НОГООН ОРДНЫ ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлын 2 дугаар зүйл /1941,№79/, Бүгд Найрамдах Монгол Ард улсын Сайд нарын зөвлөлийн тогтоол /1971.12.28,№420/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Монголын төр, шашныг хослон баригч VIII Богд Жавзандамба Туул голын хөвөөнд Ногоон ордны уран барилгын цогцолбор Шаравпэлжээлин буюу Билгийг хөгжүүлэн бадруулагч сүмийг 1893 оноос эхлэн барьж 1906 онд дуусгажээ. Оросын III Николай хаанаас VIII Богд Жибзундамбад бэлэглэсэн барилгын зураг төслөөр 1905 онд өвлийн ордон хэмээх Европ маягийн хоёр давхар цагаан байшинг барьжээ. Богд хааны Ногоон ордны байгууламж төлөвлөлтийн хувьд гол тэнхлэг дээр “Цогчин дуган” буюу гол сүм орших бөгөөд тэнхлэгийн дагуу тэгш байрлалаар урдаас хойш сүм, дугануудыг зориулалтаар нь эрэмбэ дараатай байруулдаг ёсыг баримталжээ.

ИХ ТЭНГЭРИЙН АМНЫ ХАДНЫ ЗУРАГ, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын өмнө Богд хан уулын Их тэнгэрийн амны зүүн үзүүрийн хойшоо харсан хадан хясаан дээр улаан зосон болон хар бэхээр зурсан зураг, монгол, түвд бичээс бүхий дурсгал бий. Эндхийн зосон зураг нь өргөн зураасаар том дөрвөлжин хашлага, түүний дотор олон дугуй толбо, хашлаганы дээд талд хошуугаа хажуу тийш харуулан халин нисэж буй бүргэд шувуу, хашлаганы зүүн талд хөтлөлцөж зогссон хүний тойм зураг доор нь амьтан дүрсэлдэг хүрэл зэвсгийн үеийн зосон зургийн нэг төлөөлөл юм. Зосон зургуудын ойролцоо хар бэхээр “Мөнх хөх тэнгэр” гэсэн үг бүхий монгол бичээс мөн урт хормой, өргөн ханцуйтай дээлтэй, бүдүүн түрийтэй, ээтэн хоншоортой монгол гуталтай эмэгтэйг эгц урдаас нь дүрсэлсэн байх бөгөөд түүний дугариг царай, онигордуу нүдэй дүрсэлжээ. Энэ эмэгтэйг богтог малгайтай дүрсэлсэн нь XIII зууны үеийн зураг болохыг илтгэж байна.

АНХНЫ “ӨНДӨР ХОРШОО”-НЫ 2 ДАВХАР БАЙШИН, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт байрлах тус барилгыг 1913-1914 онд Оросын худалдаачин худалдааны зориулалтаар бариулсан нь тухайн үеийн хамгийн том байшингуудын нэг байжээ. Тус байшинг 1921 он хүртэл орос худалдааны төв, банк, орос цэргийн штабын зориулалтаар ашигдаж байгаад 1930 онд байшинг өргөтгөн Харилцан туслалцах хоршооны төв дэлгүүр болгосон нь Өндөр хоршоо хэмээн алдаршжээ. 1961 оноос Урчуудын Эвлэлийн Хороо, 1965 оноос өнөөг хүртэл Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей байрлаж байна.

ГЭСЭР СҮМИЙН ЦОГЦОЛБОР, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1994.12.28,№233/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1998.12.23,№235/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2008.05.14,№175/, Монгол Улсын Засгийн газрын тогтоол /2020.01.08,№13/-оор тус тус батлагдсан. Улаанбаатар хотын Тасганы овооны урд байрлах энэхүү сүмийг 1919-1920 онд байгуулжээ. Гэсэр сүмийн барилга хятад хийцийн төрөлд хамаарах бөгөөд эдүгээ Гандантэгчилэн хийдийн харьяа Бадма Ёга дацан буюу шашны дунд сургууль байрлан үйл ажиллагаа явуулж байна.

2. Тус Үндэсний төвөөс эрхлэн гаргадаг "Соёлын өвийн мэдээ, мэдээлэл" сэтгүүлийн агуулгыг урьдчилсан байдлаар:

- Соёлын биет ба биет бус өвийн бүртгэл баримтжуулалт,
- Сэргээн засварлалт чиглэлээр хийгдсэн ажлын тухай,
- Соёлын өвийн танин мэдэхүй гэсэн чиглэлээр сэтгүүлийн төлөвлөсөн.


Дэлхий нийтэд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал дэгдсэнээс болж сэтгүүл хэвлэх санхүүжилт зогссон тул дээрх ажил хийгдээгүй.

3. Эрхэлж гаргасан ном, хэвлэл:


- Шороон бумбагарын бунхант булшны хадгалалт /Монгол Улсад илэрч олдсон анхны ханын зураг бүхий бунхант булш/ ном Монгол-Англи-Франц хэлээр хэвлүүлсэн. Шороон бумбагарын бунхант булшны ханын зурагны брошур Монгол-Англи хэлээр хэвлүүлсэн.
- Архитектурын өвийн хадгалалт хамгаалалтын гарын авлага,
- Гэрэл зураг авах аргачлал гарын авлага,
- Соёлын өвийг хамгаалах эрх зүйн холбогдох баримт бичгүүд шинэчилсэн гарын авлага
- "Чулуун соёлын өв"-ийг сурталчилах чиглэлээр Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хийсэн ажлын тайлан брошур,
- ЗГХА Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвөөс ШУА-ын Археологийн хүрээлэн, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг ТББ-тай хамтран Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нар зориулсан гарын авлага,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого явуулах гарын авлага болох "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгаа" номыг тус тус хэвлүүллээ.




"ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ"
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
www.ncch@gov.mn


"ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР


Түүх, соёлын үл хөдлөх
дурсгалд сөрөг нөлөөт хүчин
зүйлсийн учруулах эрсдэлийн
үнэлгээний судалгаа
Улаанбаатар 2020


Шороон Бумба
хадгалал
Preserving
Shoroon Bumba
The First Painted Tomb
Discovered in Mongolia
Préservation de
Shoroon Bumbagar
Le Premier Tombeau Peint
Découvert en Mongolie

НЭМЭЛТЭЭР:

1. Уулзалт, арга хэмжээ, үзэсгэлэн:

- Саудын Арабын Вант Улсын Рияд хотод байрлах Олон улсын тэмээний холбоо (International Camel Organization) байгууллагын Удирдах газраас ирүүлсэн урилгын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2020 оны А/17 тоот тушаалаар Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат 2020 оны 01 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд наадам, хурлын үйл ажиллагаанд оролцлоо. Арабын Вант Улсын Рияд хотын ойролцоо Абдулазиз хааны нэрэмжит Тэмээний Наадам, Тэмээний Клуб ТББ-ын зохион байгуулалт дор Олон улсын тэмээний холбоо (International Camel Organization) байгууллагын захирлуудын уулзалт, Олон улсын Тэмээн полоны гишүүдийн уулзалт зэрэг арга хэмжээнийн үеэр ОХУ-ын баруун өмнөд хэсэг, БНХАУ-ын Шинжаан Уйгурын өөртөө засах бүс нутаг, Казахстан, Киргиз, Узбекистан зэрэг улсуудтай хамтран судалгааны ажлыг зохион байгуулах, Монгол 2 бөхт тэмээтэй холбоотой соёлыг сурталчилж, 2 бөхт тэмээн соёлыг хамгаалах судлах бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санал санаачлага гаргасан.

- Япон улсын Ойта хотын түүхийн музей, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургууль, Хархорум музейтэй хамтран “Хархорум 800” үзэсгэлэнг Япон улсын талтай хамтран зохион байгуулж, 13-р зууны эртний нийслэл Хархорум хотын түүх соёлыг Япон улсад сурталчлан танин мэдүүлэх тусгай үзэсгэлэнг 1 сарын хугацаатай зохион байгуулсан.

- Уламжлалт тоглоом, наадгайн Олон улсын зөвлөлтэй хийсэн цахим уулзалт. Уламжлалт тоглоом, наадгайн Олон улсын зөвлөл, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний Комисс хамтран зохион байгуулсан цахим уулзалтад ЗГХА- Соёл, урлагийн газар, ЗГТА Биеийн тамир, спортын улсын хороотой хамтран оролцож, “Уламжлалт тоглоом наадгайн үндэсний зөвлөл” байгуулах асуудлаар байр сууриа илэрхийлсэн.

- Чулуун соёлын өв” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд гарах тусгай үзэсгэлэнд зориулсан 32 “Хүнт” дөрвөлжин булшны танилцуулга, Можоогийн хадны зураг, Бужаагийн хадны зураг, Их сарын нумчин хадны зураг, Буган хөшөөний танилцуулга, Хадны зургийн танилцуулга тус бүрийн мэдээллийг бичиж, 5 үл хөдлөх дурсгалын гар зургийг Coreldraw программ дээр зурж бэлэн болгосон. Дэлхий нийтэд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал дэгдсэнээс болж тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

2. Телевизийн нэвтрүүлэг, ярилцлага:

- Соёлын өвийн үндэсний төв “Монголын үндэсний хүүхдийн кино академи” ТББ-тай хамтран “Цэц” өв соёлын хүүхдийн уралдаант танин мэдэхүйн нэвтрүүлэгийг 2020 оны 4-р сарын 4-нөөс 6-р сарын 1-нийг хүртэл бэлтгэн, UBS TV-ийн эфирээр 14 цуврал нэвтрүүлгийг хүргэлээ. Хүүхэд бүрийн сурч мэдэх мэдэх ёстой үндэсний өв соёл болон зан заншил, монгол аж ахуйтай холбоотой энэхүү нэвтрүүлгийг дэлхий даяар тархаж буй “Covid-19” вирусын тархалттай холбоотойгоор сурагчдыг гэртээ байх хугацаанд цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжийг олгох, өв соёлын талаар танин мэдэхүйн мэдээлэл олгох зорилготойгоор хийсэн ба уг нэвтрүүлэг 7 хоногт 2 дугаар, сард 8 дугаар гарсан бөгөөд давтан нэвтрүүлж байна.

- Соёлын өвийн үндэсний төв, МҮОНТВ, Нийслэлийн соёл урлагийн газар,Монголын аялал жуулчлалын холбоо хамтран бүтээсэн "Монгол өв соёлын гайхамшиг" 7 дугаар бүхий цуврал нэвтрүүлгийн эхний дугаар "Эх хэл,аман уламжлал, илэрхийллүүд" нэвтрүүлэг 2020 оны 11 сарын 16-ны Монгол бахархлын өдөр-Эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр 09:00 цагт МҮОНТВ-ээр эфирт цацагдан Монгол Улсын Соёлын биет бус өвийн нэгэн төрөл зүйлийг олон нийтэд сурталчлав. Нэвтрүүлгийн хоёрдахь дугаар "Уламжлалт баяр наадам,зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага" айн нэвтрүүлэг 2020 оны 11-р сарын 21-ний өдөр МҮОНТВ-ээр эфирт цацагдсан. Хөл

хорионы улмаас уг нэвтрүүлгийн зураг авалт хойшлогдсон бөгөөд одоо III,IV дугаар нэвтрүүлгийн зураг авалтыг хийж эфирт цацахад бэлэн болгоод байна. Энэхүү цуврал нэвтрүүлгийн нийт 7 дугаарын зохиолыг Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл мэдээллийн санч Ц.Жаргалсайхан бичиж бэлтгэсэн болно.

- Монголын радиогийн “Voice of Mongolia” дэлхийн 5 улсын хэл дээр цацагддаг нэвтрүүлэгт “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл” өвийг ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтөний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлсэн тухай ярилцлага, мэдээллийг англи хэл дээр өгсөн.

- МҮОНТВ-ийн “Монгол өв соёл” нэвтрүүлгийн үндэсний их баяр наадмын өдөрт зориулсан 3 цуврал тусгай дугаарт Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдлийн судалгаа, түүх, соёлын хосгүй үнэт дурсгал, хосгүй үнэт дурсгалын шалгуур үзүүлэлт, түүх, соёлын үл хөдлөх дурсгал, чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр, соёлын биет бус өв, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, органик эдлэлийн хадгалалт хамгаалалт ба өнгө будгийн сэргээн засвар, анхан шатны суурь судалгаа хийх аргазүй ба ач холбогдол, чулуун дурсгалын хэв, хуулбар, хадгалалт хамгаалалт сэдвээр тус тус Захирал Г.Энхбат, ЕБМСанч Ш.Энхтуяа, СӨАХГ-ын дарга Г.Анхсанаа, Бүртгэл, мэдээллийн санч Ж.Насанжаргал, Ц.Цолмон, СБӨСЗГ-ын дарга М.Оюунтулга, Ерөнхий сэргээн засварлагч Д.Нямдорж нар оролцож соёлын өвийг олон нийтэд сурталчиллаа.

4. Судалгааны өгүүлэл, илтгэл:

- Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаа Дундговь аймгийн музейгээс зохион байгуулсан “Дундговь судлал” цахим эрдэм шинжилгээний бага хуралд “Их газрын чулуу дурсгалт газарт хийсэн соёлын өвийн бүртгэл, судалгаа” сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцсон, ОУ-ын хянан магадлан итгэмжлэгдсэн CELL сэтгүүлийн 2020 оны 11 сарын дугаарт Зүүн Евразийн тал нутаг дахь генетикийн 6000 жилийн түүх сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд хамтран зохиогчоор оролцов (https://www.scima-gojr.com/journalrank.php?category=1307).

- Австрийн Венийн Хэрэглээний урлагийн Их сургуулийн хадгалалт хамгаалалтын хүрээлэнтэй 2016 оноос хойш хамтран Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Их хөшөөтийн цогцолбор дурсгалын хадгалалт хамгаалалт, судалгааны ажлын үр дүнг эмхэтгэн “Stone congress” ОУ-ын Чулуун өвийн хадгалалт хамгаалалтын хурлын эмхэтгэлд тус төвийн захирал Г.Энхбат, мэргэжилтэн Ц.Цолмон нар “Монгол дахь чулуун соёлын өв: Их хөшөөтийн дурсгалд хийсэн нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа” өгүүллийг хэвлүүлсэн.

- Тус үндэсний төвийн Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга М.Оюунтулга Монголын үндэсний музейгээс эрхлэн гаргаж буй Айрагийн гозгорын судалгаа, Музей судлал сэтгүүл, ШУА-ийн Түүх, угсаатны зүй хүрээлэнгээс эрхлэн гаргаж буй Сарьдагийн хийд судалгааны тайлан ном, ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан Чандмань хар уулын дурсгал судалгааны эмхэтгэлд тус тус соёлын бие өвийн хадгалалт хамгаалалт сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн.

- Эрдэнэ Зуу музейн захиргааны хүсэлтийн дагуу тус Үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа нь тус музейгээс эрхлэн хэвлүүлэх гэж буй “Их шүтээний орон Эрдэнэ Зуу” номын эх бэлтгэх ажлын хэсэгт ажиллаж:

- “Уншигчдад зориулах үг” номын агуулга, бүтцийн талаарх тайлбар өгүүлэл, “Эрдэнэ Зуу музей”-н танилцуулга өгүүлэл, “Их шүтээнүүдийн тухайд” уг номонд орж буй бүтээлүүдийн талаарх судалгааны өгүүлэл, “Үгийн тайлбар” номонд бичигдсэн бурхны шашны холбогдолтой үгсийн тайлбар, “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн тус музейн хосгүй үнэт үзмэрийн жагсаалт зэргийг тус тус бичиж бэлтгэн тус номын редакцид хүлээлгэн өгсөн. Энэхүү ном бэлтгэх ажлын хүрээнд Засгийн газрын шийдвэрээр түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан “Шагш Жанрайсиг”, “Доржсэмбэ”, “Дэмчиггарав”, “Юм Сэргиймаа”, “Жийцэгмаа”, “Бурхан багш

16 архад, 4 махранзын хамт” зэрэг 6 хосгүй үнэт үзмэрийн нэр ташаарч бүртгэгдсэнийг холбогдох ном, баримттай тулган, харьцуулан судалсны үндсэн дээр засаж залруулах ажлыг гүйцэтгэв.

- Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын бүртгэл, мэдээллийн санч Г.Бүрэнтөгс Монголын Үндэсний Музейн “Нүүдэлчдийн өв” сэтгүүлийн №21 дугаарт “Цагаан Асгын өврийн нуруунд шинээр бүртгэсэн хадны зургийн судалгаа” сэдвээр өгүүлэл, Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын бүртгэл, мэдээллийн санч Б.Амгаланбат Монголын XIII-XIV зууны үеийн хүн чулуудын бүртгэл судалгааг шинэчилж дата бааз үүсгэж, Өвөр Монголын нутагт орших XIII-XIV зууны үеийн хүн чулууд хэмээх сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэв.

- Дэлхийн өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Ц.Цолмон ОХУ-ын Соёлын яамнаас зохион байгуулсан “Бүжгийн дэглэлт, боловсрол, судалгааны өнөөгийн асуудлууд” ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд “Угсаатны бүжиг дэх улс төрийн нөлөө: Ёохор бүжгийн жишээн дээр” сэдэвт илтгэл цахимаар хэлэлцүүлсэн.

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№3.2.1 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

Гүйцэтгэлийн зорилт №3.2.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах

3.2.1.1 Үндэсний төвийн орон тоо, бүтцийг боловсронгуй болгох;

- Тус үндэсний төвийн шинэ байр ашиглалтанд орсоноор ажлын ачаалал, чиг үүрэг нэмэгдэхтэй холбогдуулан одоо байгаа 35 орон тоон дээр шаардлагатай орон тоо, ажилтан, мэргэжилтний саналыг Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл” зэргийг үндэслэл болгон 53 төрлийн 83 хүн бүхий орон тоо, цалингийн санг агуулсан санал боловсруулж, төсвийн төсөлд тусгасан.

№	Харьяалах газар	Албан тушаал	Тоо
1	Захиргаа, удирдлагын газар	Захирал	1
2		Дэд захирал	1
3		Захиргаа, удирдлагын газрын дарга	1
4		Ерөнхий нягтлан бодогч	1
5		Нягтлан бодогч	1
6		Нярав	1
7		Дотоод хяналт, аудитын ажилтан	1
8		Төсвийн байгууллагын мэргэжилтэн	1
9		Гадаад харилцаа олон нийт хариуцсан мэргэжилтэн	1
10		Хүний нөөцийн мэргэжилтэн	1
11		Бичиг хэргийн ажилтан	1
12		Архивын ажилтан	1
13		Нарийн бичиг	1
14		Номын санч	+-
15		Жижүүр	4
16		Үйлчлэгч	2
17		Сантехникч	1
18		Цахилгаанчин	1
Бүгд			**21**
19	Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар	Газрын дарга	1
20		Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч	1
21		Эрдэм шинжилгээний ажилтан /Түүх, үгсаатны зүйч/	2
22		Эрдэм шинжилгээний ажилтан /Археологич/	2
23		Шинжээч	3
24		Бүртгэл, мэдээллийн санч /үл хөдлөх дурсгал/	2
25		Бүртгэл, мэдээллийн санч /Хөдлөх дурсгал /	2
26		Бүртгэл, мэдээллийн санч /Биет бус өв/	3
27		Арга зүйч	1
Бүгд			**17**
28		Газрын дарга	1

29	**Соёлын өвийг авран хамгаалах газар**	Дэлхийн өв хариуцсан бүртгэл мэдээллийн санч	1
30		Эрдэм шинжилгээний ажилтан	3
31		Уран барилга, архитектурын зураг төслийн мэргэжилтэн	2
32		Газар зүйн мэдээллийн инженер	2
Бүгд			**9**
33	**Соёлын өвийг сэргээн засварлах газар**	Газрын дарга	1
34		Ерөнхий технологич	1
35		Ерөнхий сэргээн засварлагч	1
36		Лабораторын эрхлэгч	1
37		Сэргээн засварлагч /Археологийн олдвор/	2
38		Сэргээн засварлагч /Даавуу зөөлөн эдлэл/	4
39		Сэргээн засварлагч /Металл эдлэл/	2
40		Сэргээн засварлагч /Модон эдлэл /	2
41		Сэргээн засварлагч /Уран баримал /	2
42		Сэргээн засварлагч /Уран зураг /	2
43		Сэргээн засварлагч /Монгол зураг /	2
44		Чулуун өв сэргээн засварлагч, судлаач	2
45		Химич	1
46		Лаборант	1
47		Сан хөмрөгч	1
48		Судлаач	1
Бүгд			**26**
49	**Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар**	Газрын дарга	1
50		Сүлжээний инженер	1
51		Систем хөгжүүлэлтийн инженер	1
52		Программист	1
53		Аюулгүй байдлын инженер	1
54		Найруулагч	1
55		Дуу, дүрсний инженер	1
56		Зураглаач	2
57		Гэрэл зурагчин	1
Бүгд			**10**
Нийт орон тоо			**83**

- Шинэ орон тоо болон сул орон тооны сонгон шалгаруулалтыг үнэгүй зар цахим хуудас, байгууллагын цахим хуудас дээр байршуулж ажилласан. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн программд журмын дагуу мэдээллийг тухай бүр шинэчилж хэвшсэн.

- Энэ онд Төрийн албаны манлайлал сэдвийн дагуу дараах агуулгатай 2 удаагийн сургалт зохион явуулсан.

1. Төрийн албан хаагчийн манлайлал, Хувь хүний зан чанарын манлайлал, манлайлагчийн харилцааны ур чадвар /аюулгүйн тойрог үүсгэх, итгэлцэл бий болгох/, баг хамт олныг бүрдүүлэх ур чадвар, бусдыг ойлгож мэдэх чадвар, урам зориг өгч урамшуулах, чиглүүлэн сургах ажил үүрэг хуваарилах, асуудал зөрчлийг шийдвэрлэх талаар;

2. Хүний нөөц, удирдлагуудад зориулсан сургалт, Хүний нөөцийн орчин үеийн хандлага, авьяасыг ашиглах, ажлыг таниж мэдэх, албан тушаалын зорилго, гүйцэтгэх үндсэн үүрэг, албан тушаалын онцлог, хувь хүнийг таниж мэдэх, сонгож авах, ажилтанд нөлөөлөх, идэвхижүүлэх, үнэлэх, хөгжүүлэх, ажилтныг ажлаас чөлөөлөх тухай.

3.2.1.2 Ажилтнуудын мэдлэг боловсролоо дээшлүүлэх, ахисан шатанд суралцах ур чадвараа ахиулах сонирхлыг дэмжиж боломж нөхцөлөөр хангах, зохих сургалтад хамруулах;

- Төрийн албаны манлайлал сэдвийн хүрээнд ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор 4 удаагийн сургалтыг Азийн сангийн мастер багш Т.Оюундарийг урьж зохион байгуулав. Сургалт дараах сэдэв, агуулгыг хамарч зохион байгуулагдсан.

1. Төрийн албан хаагчийн ёс зүй, түүний үнэт зүйлс, тулгуур зарчмууд, үүрэг хариуцлага, Төрийн удирдах албан тушаалтны ёс зүй, нөлөөлөл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

2. Төрийн албан хаагчийн хандлага, харилцаа, Төрийн албан хаагч ба хувь хүн, төрийн албан хаагчийн ажлын байранд бүрдүүлэх гадаад төрх, төрийн албан хаагчийн хандлага, харилцааны стандарт, олон нийтийн хэрэгсэлтэй харилцах тухай, нууц хадгалах, хариуцлага хүлээх;

3. Төрийн албан хэрэг хөтлөлт, Баримт бичгийн стандартын тухай, баримт бичгийн нэр төрлүүд, бүрдлүүдийг зөв үйлдэх, хэвлэмэл хуудастай ажиллах арга зүй;

4. Зөрчил стрессийг удирдах, Байгууллага дахь зөрөлдөөнийг оношлох, зөрөлдөөнийг удирдах, тохирох стратегийг боловсруулах, стессийн тухай, зайлсхийх, тэмцэх, чөлөөлөгдөх аргууд.

- Түүнчлэн Япон улсын Ойта мужийн түүхийн музейтэй хамтран музейн тогтвортой орчны судалгаа болон материал судлал, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, бодис хэрэглэгдэхүүн, багаж техниктэй ажиллах онол практикийн сургалтыг Ойта мужийн түүхийн музейг түшиглэн зохион байгуулсан. Тус сургалтад Соёлын биет өвийг сэргээн засварлах газрын дарга М.Оюунтулга, Сэргээн засварлагч С.Даваадарь нар оролцсон. Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яам, Америкийн Монгол судлалын төвийн дэмжлэгтэйгээр АНУ-ын Нью-Иорк хотод зохион байгуулагдсан “Монголын яаралтай хамгаалах шаардлагатай бөс даавуун цуглуулга ба өв уламжлалыг хадгалж хамгаалах” төслийн 28 хоногийн сургалтад Сэргээн засварлагч Э.Батжаргал хамрагдсан. 2020 онд 1 ажилтан докторантурт элсэн суралцсан.









№ 3.2.2 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

Гүйцэтгэлийн зорилт №3.2.2.Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт нийтээр хүлээх үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт

3.2.2.1. Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын хэрэгжилт дээр хяналт хийх;

2020 оны 03 сард, Захиргаа, удирдлагын газрын дарга О.Мэндсайхан, Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга Г.Анхсанаагаар ахлуулсан байгууллагын Ёс зүйн зөвлөл болон Дотоод хяналт, аудитын нэгж газар тус бүр дээр хяналт шалгалт явуулсан.10-р сард Захиргаа, удирдлагын газрын дарга, хяналт шалгалтын нэгжийн дарга О.Мэндсайхан, Ерөнхий бүртгэл мэдээллийн санч, хяналт шалгалтын нэгжийн нарийн бичгийн дарга Ш.Энхтуяагаар ахлуулсан байгууллагын Хяналт, шалгалт, дотоод аудитын нэгж газар тус бүр дээр хяналт шалгалт явуулж үйл ажиллагааг дүгнэсэн.

Төлөвлөөгөөнд 2020 оны 11 сарын 20-ны өдөр жилийн ажлын хяналт шалгалт явуулах байсан боловч Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хэрэгжээгүй. Соёлын яамнаас явуулж буй цахим хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан журам, Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төвөөс гарсан дүрэм журам Хөдөлмөрийн дотоод журам, Орон тооны бус зөвлөл, нэгжүүдийн дотоод журмыг байнгын мөрдлөг болгон ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, сахилга дэг журмын хэрэгжилт тус тус хангадсан. Нийт 2 удаагийн хяналт шалгалт хийгдсэн.



Батлав: О.Мэндсайхан

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	сарууд								
		3	4	5	6	7	8	9	10	11
1	СӨҮНБСанд 2019 оны тайланг хүлээн авах график гаргах									
2	Ажилтан, албан хаагчдаас 2019 оны болон өмнөх онуудын тайланг ХН техник боловсруулалт хийж хүлээн авах									
3	СӨҮНБСангийн 2019 оноос өмнөх нөхөн бүрдүүлэлтийн ажил									
4	СӨҮНБСанг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах									
5	СӨҮНБСангийн баримтуудыг данслах ажлыг зохион байгуулах									
6	Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах									
7	Нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэл ажлыг хангах									

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020-03-16 № / Улаанбаатар хот

Хурал Соёлын өвийн үндэсний төвийн 203 тоот өрөөнд 9.30-11.00 цагт боллоо.

ХУРЛЫН ИРЦ:

О.Мэндсайхан -	Захиргаа удирдлагын газрын дарга захирал, хяналт шалгалтын нэгжийн дара
Ш.Энхтуяа -	Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч, хяналт шалгалтын нэгжийн нарийн бичгийн дара
Д.Нямдорж -	Ерөнхий сэргээн засварлагч, хяналт шалгалтын нэгжийн гишүүн
Д.Нарантуяа -	Соёлын өвийн бүртгэл, судалганы газрын дарга, хяналт шалгалтын нэгжийн гишүүн
Г.Анхсанаа -	Соёлын өвийг авран хамгаалах газрын дарга, хяналт шалгалтын нэгжийн гишүүн

ХЭЛЭЛЦСЭН нь:

2020 онд хийх дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагаа

СОНССОН нь:

О.Мэндсайхан: Байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийн бүрэлдэхүүнд 2019-нд өөрчлөлт орсныг та бүхэн мэдэж байгаа шинэ бүрэлдэхүүнээр нэгжийн дарга би, нарийн бичгийн дарга өмнө дотоод хяналтын нэгжийн дарга байсан Энхтуяа эгч, 3 гишүүн нь газрын дарга нэр байгаа.

2019 онд улсын хэмжээгээр архивын шалгалт явагдахтай холбогдуулан архивын дүрэм, зааврын хэрэгжилтийн байдалд түлхий анхаарал хандуулж бүх ажилтнуудыг архивын мэдлэг олгох сургалтад хамруулсан. Энхтуяа эгч 30 хоногийн сургалтад суусан, ирээд мөн сургалт явуулсан. Үүний үр дүнд манайх ерөнхийдөө баримт бичиг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй болсон байх гэж бодож байгаа.

2020 оны хувьд дэлхий нийтийг хамарсан халдварт өвчин гарсантай холбогдуулан манай улсын хэмжээгээр бүх байгууллагууд "тусгай горим"-оор ажиллах болсон ба манайх ч бас тусгай комисс байгуулж, богиносон цагаар ажиллах дэглэмд орсон байгаа. Энэхүү нөхцөл байдалдаа тохируулан манай нэгж 2020 онд 2 чиглэлд анхааран ажиллах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Нэгд. Бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд, Хоёрт. Нүүлгэн шилжүүлэх ажиллагаа

Ш.Энхтуяа: Сангийн баримтууд нилээн цэгцгүй байгаа, байгаа байдлаас харахад 2014 он хүртэл Соёлын биет бус өвийн мэдээллийг Мөнхзул хариуцаж гайгүй цэгцтэй явж ирсэн байна. Үүнээс хойшх 5,6 жилийн хувьд бүртгэлийн ажил хаягдсан гэж болно. Энэ бол зөвхөн биет бус өвийн хувьд. Энэ мэт асуудал байгаа

байгаа. Үүнд анхаарал хандуулах нь зөв. Нүүлгэж шилжүүлэлтийн ажил бол энэ оны хамгийн том чухал ажил, бид анхаарал хандуулахаас өөр арга байхгүй.

Д.Нарантуяа: Ерөнхий бүртгэл, мэдээллийн санчтай болоод 2 жил гаруй болж байна. Энэ хугацаанд сангийн ажилд дэвшил гарсан байдал харагдахгүй л байгаа. Одоо манайхан бүргд Бүртгэл, мэдээллийн санч л болсон биз дээ. Ажлаа хийх хэрэгтэй. Нүүлгэлтийн ажлын хэсэг байгуулагдах байлгүй дээ.

Г.Анхсанаа: Мэндээ даргын хэлж байгаа энэ 2 чиглэлд манай дотоод хяналт анхаарлаа хандуулж ажиллах нь зөвөө. Короноогоор болоод багасгасан цагаар ажиллаж байгаа учир хүн бүр дор дороо санд өгөх ажлуудаа цэгцлэх зав гарч байна нэг талдаа.

Д.Нямдорж: Нүүлгэж шилжүүлэх ажлыг одооноос л хийж байх нь зөв ялангуяа манай сэргээн засварлагчид материал дагалдах хэрэгсэл маш ихтэй. Энэ 2 чиглэлдээ анхаарал хандуулж ажиллая оо. Төлөвлөгөө гаргах уу.

О.Мэндсайхан: За за. Тэгвэл Энхтуяа эгч бүртгэл, мэдээллийн сангийн ажлын сайжруулах төлөвлөгөө гаргаад танилцуулаарай. Нүүлгэж шилжүүлэх ажлын төлөвлөгөөг манай захиргаанаас гаргая. Тэгээд та нарт тараана аа.

Ш.Энхтуяа: За гэхдээ, дотоод хяналт үндсэн чиг үүрэг бол байгууллагын үр дүнгийн гэрээний биелэлт, удирдлагын үүрэг даалгаврыг биелүүлэх дэмжлэг, хяналт тавих мөн байгууллагын хөрөнгийн ашиглалтад хяналт тавих зэрэг ажлыг хэрэгжүүлэх ёстойг журамдаа тусгасан байдаг юм байна лээ.

О.Мэндсайхан: Ер нь бидний өмнө тулгамдсан гол асуудал бол дэлхий нийтийг хамарсан шар тахалыг эсэн мэнд давах. Үүнд хүн бүр өөрийн үүргээ ухамсарлах ёстойг сануулж байгаарай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. 2020 ОНЫ ДОТООД ХЯНАЛТЫГ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ ТАНИЛЦУУЛАХ

ТЭМДЭГЛЭЛ БИЧСЭН: ЕРӨНХИЙ БҮРТГЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН САНЧ ..... Ш.ЭНХТУЯА

ТАНИЛЦСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА ..... О.МЭНДСАЙХАН

3.2.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байранд хийсэн шинжилгээ, зохих байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэнд шалгалт хийх;

